

СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ

№1

Улаанбаатар хот
2020 он

СУДАЛГААНЫ ТОВХИМОЛ №1

Энэхүү судалгааны ажилд дурдагдсан санал, дүгнэлт нь зөвхөн хувь судлаачдын байр суурийг илэрхийлэх бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО, 2020



ӨМНӨХ ҮГ

Эрхэм уншигч Таны амар амгаланг айлтгая!

Санхүүгийн зохицуулах хороо үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойг тохиолдуулан хийгдсэн судалгааны ажлуудаас анх удаагаа судалгааны товхимлыг бэлтгэн нийтлүүлж буй нь судалгаанаас гарсан үр дүн, дүгнэлтийг уншигч Тантай хуваалцах зорилготой билээ.

Олон улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналтын талаар шийдвэр гаргахдаа судалгаа, шинжилгээг үндэслэсэн урт хугацааны хөгжлийн гарцаа тодорхойлдог.

Иймд Санхүүгийн зохицуулах хороо нь олон улсын шилдэг туршлага, стандартыг хяналт зохицуулалтдаа нэвтрүүлэх, судалгаа, шинжилгээний үндсэн дээр шийдвэр гаргах,

нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, системийн эрсдэлийг урьдчилан тооцсон урт хугацааны хөгжлийн стратеги бий болгох зорилгоор зах зээлийн судалгаа, хөгжлийн нэгдсэн бодлогын бүтцийг бий болгосон юм.

Энэхүү товхимолд Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн жилүүдэд хийж гүйцэтгэсэн судалгааны ажлуудаас нэгтгэн хүргэж байгаа бөгөөд товхимолд орсон судалгаанууд нь санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоо, коронавирус цар тахлын нөлөө, санхүүгийн зах зээл дэх технологи, тэдгээрийн төрөл зохицуулалт, санхүүгийн зах зээлийн реформ, үнэт цаасны зах зээл дэх тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлага, санхүүгийн хүртээмжийг үнэлэх түүвэр судалгаа, жижиг дунд үйлдвэрлэл ба түүний санхүүжилт зэрэг сэдвүүдийг багтаасан болно.

Судлаачид, мэргэжилтнүүдийн хийсэн судалгааны санал, дүгнэлт нь Санхүүгийн зохицуулах хорооны албан ёсны байр суурийг заавал илэрхийлэх албагүй бөгөөд судалгааны санал дүгнэлтийг бодлогын шийдвэр гаргахад үндэслэл, харгалзах хүчин зүйлс болгон авч үздэгээрээ давуу талтай юм.

Энэхүү судалгааны товхимлыг анх удаагаа гаргаж байгаа тул алдаа, дутагдал байхыг үгүйсгэхгүй бөгөөд Та судалгааны талаарх санал, дүгнэлтээ Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлбэл бид талархаж, үнэтэй саналыг нь дараагийн судалгааны ажилдаа тусгах болно.

Эцэст нь оюун ухаанаа уралдуулан тулгамдаж буй чухал асуудлуудыг хөндөн бие даасан, шинэлэг арга, техникээр хийх боломжуудаа дайчлан ажилласан Санхүүгийн зохицуулах хорооны албан хаагчиддаа болон хамтран ажилласан судлаач нартаа талархсанаа илэрхийлье.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

АГУУЛГА

ШИНЭ КОРОНА ВИРУС (COVID-19)-ИЙН УЛМААС САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮҮСЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ	13
САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО	45
ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ШИЛДЭГ ТУРШЛАГА	83
МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ: ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ	101
САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТЕХНОЛОГИ, ТЭДГЭЭРИЙН ТӨРӨЛ, ЗОХИЦУУЛАЛТ	131
ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ БА ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА	159
АВСТРАЛИ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН РЕФОРМ	183
МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮВЭР СУДАЛГАА	269
БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС	313

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1.	Дэлхийн гол индексүүдийн төлөв	23
Хүснэгт 1.2.	Гадаад болон дотоод орчны шинжилгээ	26
Хүснэгт 1.3.	ХЗХ–дын зээлийн мэдээ, тэрбум төгрөгөөр	29
Хүснэгт 1.4.	ХЗХ–дын хадгаламжийн мэдээ, тэрбум төгрөгөөр	29
Хүснэгт 1.5.	Корона вирусийн цар тахал, эдийн засгийн хүндрэлийн нөлөөг бууруулах шийдэл	36
Хүснэгт 1.6.	Иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх зөвлөмж	37
Хүснэгт 2.1.	Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэр	48
Хүснэгт 2.2.	Институционал зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал	49
Хүснэгт 2.3.	Функционал зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал	52
Хүснэгт 2.4.	Нэгдсэн зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал.....	54
Хүснэгт 2.5.	Хосолмол зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал.....	57
Хүснэгт 2.6.	Санхүүгийн хямралын дараагаар санхүүгийн салбарын зохицуулалтын загваруудад гарсан өөрчлөлт	60
Хүснэгт 2.7.	Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэрүүд, бүс нутгаар	61
Хүснэгт 2.8.	Европын холбооны улсуудын санхүүгийн нэгдлийн банк, даатгалын салбарт эзлэх хувь	62
Хүснэгт 2.9.	Улс орнуудын нэгдсэн зохицуулалтын загварт шилжих болсон шалтгаан	64
Хүснэгт 2.10.	Санхүүгийн нэгдлүүд	72
Хүснэгт 3.1.	Хөрөнгө оруулалтыг дэмжсэн олон улсын туршлага	94
Хүснэгт 3.2.	Ил тод байдлыг нэмэгдүүлсэн олон улсын туршлага	95
Хүснэгт 3.3.	Хөрөнгө оруулагчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгосон олон улсын туршлага	96
Хүснэгт 3.4.	Засаглалыг бэхжүүлсэн олон улсын туршлага	97
Хүснэгт 3.5.	Чадавхыг бэхжүүлсэн олон улсын туршлага	98
Хүснэгт 4.1.	Зээлийн эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээ	114
Хүснэгт 4.2.	Зээлийн нийлүүлэлтийн тэгшитгэлийн үнэлгээ	116
Хүснэгт 4.3.	SWOT шинжилгээ	118
Хүснэгт 4.4.	Зээлийн эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээ (Дамми)	127
Хүснэгт 4.5.	Хувьсагчдын дэлгэрэнгүй тайлбар, тоон мэдээллийн эх үүсвэр	128

Хүснэгт 5.1.	Зээлийн платформын үйл ажиллагаа явуулж буй финтек компаниудын жишээ.....	140
Хүснэгт 6.1.	ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын интервенц	164
Хүснэгт 6.2.	ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн цогц бодлогыг амжилттай хэрэгжүүлж буй улсууд	168
Хүснэгт 6.3.	ЖДҮ–ийн санхүүжилтийн уламжлалт хэлбэр ба шинэ үеийн хэлбэрийн харьцуулалт	177
Хүснэгт 7.1.	Австралийн ДНБ, салбараар.....	186
Хүснэгт 7.2.	Төрийн салбарын реформ	188
Хүснэгт 7.3.	Корпорацчилалын баримтлах нөхцөл	199
Хүснэгт 7.4.	1980 болон 1990–ээд оны бүтцийн өөрчлөлтүүд	202
Хүснэгт 7.5.	Инфляцийн түвшин, 1975–1996	210
Хүснэгт 7.6.	Инфляцийн түвшин, 1990–1994	212
Хүснэгт 7.7.	Засгийн газрын санхүүжилттэй сангууд	217
Хүснэгт 7.8.	Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өөрчлөлт	220
Хүснэгт 7.9.	Голлох үйл явдал 1986–2007 он	224
Хүснэгт 7.10.	Австралийн санхүүгийн системийн үзүүлэлтүүд (ДНБ–д харьцуулсан харьцаа).....	235
Хүснэгт 7.11.	Хөдөө аж ахуйн маркетингийн зохицуулалтын шинэчлэлүүд	239
Хүснэгт 7.12.	Netback арга.....	256
Хүснэгт 8.1.	Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, хот хөдөөгөөр	281
Хүснэгт 8.2.	Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, хүйсээр	282
Хүснэгт 8.3.	Хадгаламж хийх, зээл авахад хамгийн өргөн үйлчлүүлдэг байгууллагууд	295
Хүснэгт 8.4.	Үнэлгээний үр дүн.....	305
Хүснэгт 8.5.	Хүртээмжийн индикатор	306
Хүснэгт 8.6.	Хүртээмжийн GPM индикатор	306
Хүснэгт 8.7.	Хүртээмжийн ангилал	306
Хүснэгт 8.8.	Дансны төрөл, шалтгаан.....	306
Хүснэгт 8.9.	Бичиг баримт	308
Хүснэгт 8.10.	Дансны хэрэглээ	308
Хүснэгт 8.11.	Даатгал	309
Хүснэгт 8.12.	Орлогын эх үүсвэр.....	309
Хүснэгт 9.1.	Хувьсагчдын хураангуй статистик.....	322
Хүснэгт 9.2.	Шинжилгээний үр дүн	324

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.1. Шинэ корона вирусийн 2020 оны I улиралд дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, Дойче банкны тооцооллоор.....	21
Зураг 1.2. ББСБ–ын зээлийн үзүүлэлт, салбарын ангиллаар.....	27
Зураг 1.3. Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь.....	28
Зураг 1.4. Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр.....	30
Зураг 1.5. Топ–20 индекс.....	30
Зураг 1.6. MSE–А индекс.....	31
Зураг 1.7. MSE–В индекс.....	31
Зураг 1.8. Үйлдвэрлэл болон уул уурхайн компаниудын ханш.....	31
Зураг 1.9. 2020 оны 1, 2 дугаар сарын хувьцааны арилжааны дүн, арилжаа явагдсан өдрөөр, сая төгрөгөөр.....	31
Зураг 1.10. Хувьцааны арилжааны дүн, сараар, сая төгрөгөөр.....	31
Зураг 2.1. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалт.....	70
Зураг 2.2. Санхүүгийн нэгдлүүдийн санхүүгийн зах зээлд эзлэх хувь, салбар тус бүрээр....	72
Зураг 3.1. НҮБ–ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд.....	86
Зураг 3.2. Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлж буй арилжаа эрхлэх байгууллагын тойм	87
Зураг 3.3. SSE–д бүртгэлтэй гишүүд.....	87
Зураг 3.4. Ногоон бондод оруулсан хөрөнгө оруулалт /их наяд ам.доллар/.....	88
Зураг 3.5. ESG индекс болон уламжлалт зах зээлийн индексийн өгөөж /хувиар/.....	88
Зураг 3. 6. SDG–ийг дэмжих арга хэмжээ.....	91
Зураг 4.1. Банкуудаас иргэдэд олгосон зээлийн жилийн өсөлт.....	105
Зураг 4.2. Өрхийн өр, орлогын харьцаа.....	105
Зураг 4.3. Банкуудаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хугацаа.....	106
Зураг 4.4. Хэрэглээний зээлийн үлдэгдэлтэй иргэдийн өр, орлогын харьцаа.....	106
Зураг 4.5. Банкуудаас иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээл.....	106
Зураг 4.6. Банкны зээлийн шалгуурын индекс, хэрэглээний зээлийн өсөлт.....	106
Зураг 4.7. Иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээл.....	107
Зураг 4.8. Зээлийн дансны тоо.....	107
Зураг 4.9. Иргэдэд шинээр олгосон зээл, өсөлт.....	107
Зураг 4.10. ББСБ–аас иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээлийн бүтэц.....	107
Зураг 4.11. ББСБ–ын пассивын бүтэц.....	108


Зураг 4.12. ББСБ–ын ХНХ болон зээлийн үлдэгдлийн өсөлт	108
Зураг 4.13. ББСБ–уудын нийт зээлийн үлдэгдэл, хугацааны ангиллаар.....	108
Зураг 4.14. ББСБ–ын зээлдэгчдийн өр, орлогын харьцаа.....	108
Зураг 4.15. Зээлдэгчдийн тоо (ББСБ, давхардсан тоогоор)	109
Зураг 4.16. Зээлийн дүн, ББСБ	109
Зураг 4.17. ББСБ чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	119
Зураг 4.18. ББСБ–ын зээлийн эрсдэлийн сан.....	119
Зураг 4.19. Гар утсаар зээл авч буй иргэдийн нийт зээлдэгчдэд эзлэх хувь	120
Зураг 4.20. Гар утсаар олгосон зээлийн эзлэх хувь	120
Зураг 4.21. Иргэдийн зээлийн санхүүжилтийн төрлүүд.....	122
Зураг 5.1. Финтект оруулсан капитал хөрөнгө оруулалт ба нийт хэлцлийн тоо	134
Зураг 5.2. Финтекийн хэрэглээний түвшин	136
Зураг 5.3. Санхүүгийн зах зээл дээрх финтек ашиглалтын хувь	136
Зураг 5.4. Уламжлалт P2P зээлийн загвар.....	138
Зураг 5.5. Нотари зээлийн загвар	138
Зураг 5.6. Зээлийн баталгаат загвар.....	139
Зураг 5.7. Балансын загвар	139
Зураг 5.8. Дэлхийн хэмжээнд нийт ПэйТек компанийн хөрөнгө оруулалт /сая ам.доллараар/	140
Зураг 5.9. Гар утсаар хийгдэж буй төлбөр тооцооны хэмжээ /сая ам.доллараар/	142
Зураг 5.10. Иншүртек хөрөнгө оруулалтын хандлага (2012–2018).....	149
Зураг 6.1. ЖДҮ–ийн санхүүжилтэд ашиглагддаг санхүүгийн арга хэрэгслүүд.....	162
Зураг 6.2. ЖДҮ эрхлэгчдийн тоо	172
Зураг 6.3. Санхүүжилтийн орчин.....	173
Зураг 7.1. ДНБ–ий өсөлт	187
Зураг 7.2. Нэг хүнд ногдох ДНБ	187
Зураг 7.3. Аж үйлдвэрийн тусламжийн хорооны бүтэц.....	193
Зураг 7.4. Аж үйлдвэрийн хорооны бүтэц, 1995 он.....	194
Зураг 7.5. Ажилчдын тоо	195
Зураг 7.6. Бүтээмжийн хорооны зохион байгуулалтын бүтэц.....	196
Зураг 7.7. Австралийн төрийн өмчийн хувьчлал салбараар.....	198
Зураг 7.8. Нийт хүчин зүйлсийн бүтээмжийн өсөлт, 1980–1990 ба 1990–2000 он.....	203
Зураг 7.9. Аж ахуйн нэгжийн хэлцэлд хамрагдсан ажилчдын нийт ажилчдад эзлэх хувь....	205

Зураг 7.10. Австралийн хөдөлмөрийн бүтээмж ба ажилгүйдлийн түвшин.....	206
Зураг 7.11. 1990–2003 он хоорондын дэд бүтцийн салбарууд дахь ажилчдын тоо /мянган ажилчин/.....	206
Зураг 7.12. Австрали болон OECD–ийн орнуудын ажиллах хүчний оролцоо	207
Зураг 7.13. KLEMS Олон хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт.....	207
Зураг 7.14. Инфляцийн түвшин.....	208
Зураг 7.15. Хүүгийн түвшин.....	208
Зураг 7.16. Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ–д эзлэх хувь	209
Зураг 7.17. Австралийн засгийн газрын төсвийн тэнцэл, ДНБ–д эзлэх хувиар, 1980–2005 он	215
Зураг 7.18. ДНБ–д эзлэх засгийн газрын зардлын хувь, 1998–2015 он	215
Зураг 7.19. Засгийн газрын зардалд салбаруудын зардлын эзлэх хувь, 1972–2005 он	216
Зураг 7.20. ДНБ–д эзлэх Засгийн газрын нийт өр, 1908–2008 он	217
Зураг 7.21. Гадаадын цэвэр өр төлбөр ба төлбөрийн тэнцэл	218
Зураг 7.22. Австралийн төрийн сектор дахь гадаад цэвэр өр төлбөр	218
Зураг 7.23. Татварын орлогын задаргаа /1980–2015/.....	219
Зураг 7.24. Аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь /1980–2017/	220
Зураг 7.25. Татвар ногдуулах орлого ба татварын хувь /1980–2008/.....	221
Зураг 7.26. Бараа үйлчилгээний татварын нийт орлогод эзэлж буй хэмжээ.....	222
Зураг 7.27. Хадгаламж, хөрөнгө оруулалт, ДНБ–д эзлэх хувиар.....	223
Зураг 7.28. Үндэсний нийт хадгаламж, сектороор	223
Зураг 7.29. Австралийн дотоодын зээлийн өсөлт	227
Зураг 7.30. Австралийн нэрлэсэн болон бодит валютын ханшийн түвшин	228
Зураг 7.31. Австралийн албан бус секторт эзлэх нийт болон цэвэр мөнгөн хөрөнгийн урсгал, ДНБ–д эзлэх хувиар	229
Зураг 7.32. Хүүгийн түвшин ба валютын ханшийн хэлбэлзэл, 6 сарын гулгасан дундаж, сарын абсолют өөрчлөлтөөр	230
Зураг 7.33. Австралийн зээлийн нэрлэсэн ДНБ–д эзлэх хувиар	231
Зураг 7.34. Банкны ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөж	232
Зураг 7.35. Австралийн нийт зээлийн бүтэц, санхүүжилт олгож буй байгууллагаар, тэрбум ам.доллар.....	235
Зураг 7.36. Баруун Австралийн рояалти татварын хувь	254

Зураг 8.1. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж.....	275
Зураг 8.2. 1000 хүнд ногдох арилжааны банкны данс.....	276
Зураг 8.3. Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд, 2017	276
Зураг 8.4. Санхүүгийн хүртээмж, бүсээр.....	277
Зураг 8.5. Санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр.....	277
Зураг 8.6. Санхүүгийн хүртээмж, ажил эрхлэлтээр (%).....	278
Зураг 8.7. Санхүүгийн хүртээмж, сууцны төрлөөр	278
Зураг 8.8. МУ–ын санхүүгийн хүртээмж, хүйсээр	278
Зураг 8.9. Орлогын эх үүсвэр, хүйсээр (%).....	279
Зураг 8.10. Санхүүгийн хүртээмж, орлогоор	279
Зураг 8.11. Логистик загварын үнэлгээний үр дүн.....	280
Зураг 8.12. Банканд дансгүй иргэд, хүйс болон орлогын бүлгээр	281
Зураг 8.13. Банканд дансгүй иргэд, нас болон эдийн засгийн идэвхээр (АХО)	281
Зураг 8.14. Данс эзэмшихгүй байгаа шалтгаан.....	282
Зураг 8.15. Банкны салбарт очиход зарцуулдаг зардал болон хугацаа, бүсээр.....	282
Зураг 8.16. АТМ очиход зарцуулдаг зардал болон хугацаа, бүсээр.....	283
Зураг 8.17. Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, сууцны төрлөөр.....	284
Зураг 8.18. Хадгаламж хийх болон банкны үйлчилгээ авдаг давтамж.....	285
Зураг 8.19. Хадгаламж хийх давтамж орлогын эх үүсвэрээр	285
Зураг 8.20. Банкны үйлчилгээ авах давтамж орлогын эх үүсвэрээр.....	286
Зураг 8.21. Орлогын эх үүсвэр ба сууцны нөхцөл	286
Зураг 8.22. Банкаар өдөр бүр/долоо хоногт 1–2 удаа үйлчлүүлдэг иргэдийн хувь.....	287
Зураг 8.23. Банкаар өдөр бүр/долоо хоног тутам үйлчлүүлдэг хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувь.....	287
Зураг 8.24. Дансны төрөл, хот хөдөө болон хүйсээр.....	288
Зураг 8.25. Данс нээлгэсэн шалтгаан, хот хөдөө, хүйсээр.....	289
Зураг 8.26. Хоёр ба түүнээс дээш тооны данс эзэмшиж буй байдал, бүлгээр	289
Зураг 8.27. Эзэмшиж буй дансны тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар.....	290
Зураг 8.28. Мөнгөө хадгалах хамгийн найдвартай, эрсдэл багатай арга.....	291
Зураг 8.29. Өнгөрсөн 12 сарын хугацаанд хуримтлал хийсэн хэрэглэгчид, бүлгээр.....	292
Зураг 8.30. Хуримтлал хийсэн эсэх, орлогын бүлгээр	292
Зураг 8.31. Хуримтлал хийсэн эсэх, бүсээр	293
Зураг 8.32. Хуримтлалдаа мөнгө хийсэн сүүлийн хугацаа	293
Зураг 8.33. Хуримтлал хийсэн шалтгаан.....	294
Зураг 8.34. Иргэдийн зээл авсан байдал.....	295
Зураг 8.35. Иргэдийн авсан зээлийн бүтэц, олгосон байгууллагаар.....	295

Зураг 8.36. Зээл олгосон байгууллагуудаар, хот хөдөөд.....	296
Зураг 8.37. Зээл авсан байдал, бүлгээр.....	296
Зураг 8.38. Иргэдийн зээл авсан байдал, бүсээр.....	297
Зураг 8.39. Иргэдийн зээл авсан байдал, орлогын бүлгээр.....	297
Зураг 8.40. Мобайл болон интернет банкны хэрэглээ бүсээр.....	298
Зураг 8.41. Мобайл болон интернет банкны хэрэглээ, хүйс, байршил, сууцны нөхцөлөөр.....	299
Зураг 8.42. Мобайл болон интернет банкны хэрэглээ, орлогын бүлгээр.....	299
Зураг 8.43. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх.....	300
Зураг 8.44. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр.....	301
Зураг 8.45. Хамгийн хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн даатгалууд.....	301
Зураг 8.46. Хамгийн хэрэгцээтэй даатгал, бүлгээр.....	302
Зураг 8.47. Даатгалд хамрагддаггүй шалтгаан.....	303
Зураг 8.48. Сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгаан, бүлгээр.....	304
Зураг 9.1. Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо.....	318
Зураг 9.2. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн өсөлт.....	318
Зураг 9.3. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж хүү.....	319
Зураг 9.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаа.....	319
Зураг 9.5. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн өгөөж.....	320
Зураг 9.6. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтэц.....	320





ШИНЭ КОРОНА ВИРУС (COVID-19)-ИЙН УЛМААС САНХҮҮГИЙН САЛБАРТ ҮҮСЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХАД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2020 он

Гүйцэтгэсэн: Н.Нарантуяа¹, Б.Батчимэг², А.Бадамсүрэн³, А.Мөнгөнсаран⁴, Б.Батболд⁵, Б.Тэргэл⁶, А.Нинжин⁷, Б.Дөлгөөн⁸, О.Бямбасүрэн⁹, Ч.Билгүүн¹⁰, Д.Лхагвасүрэн¹¹

1 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, nanantuya@frc.mn

2 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

3 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, badamsuren@frc.mn

4 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, mingunsaran@frc.mn

5 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн, batbold_b@frc.mn

6 СЭХ-ны Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн, tergel@frc.mn

7 СЭХ-ны Үнэт цаасны газрын референт, ninjin@frc.mn

8 СЭХ-ны Үнэт цаасны газрын мэргэжилтэн, dulguun_b@frc.mn

9 СЭХ-ны Даатгалын газрын мэргэжилтэн, byambasuren@frc.mn

10 СЭХ-ны Даатгалын газрын гэрээт ажилтан, bilguun_ch@frc.mn

11 СЭХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн, lkhagvasuren_d@frc.mn

ХУРААНГУЙ

2020 оны эхээр улс орон даяар тархаж эхэлсэн шинэ төрлийн корона вирус нь дэлхийн хүн амын эрүүл мэнд, улс орны эдийн засагт томоохон эрсдэлийг үүсгэсэн. Дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлийг 2009 оны хямралаас хойших хамгийн том уналт, бууралт хүлээж байна хэмээн олон улсын шинжээчид таамаглаж эхэлсэн бөгөөд улс орнууд халдварын тархалтыг зогсоох үүднээс хөл хорио тогтоосноор эдийн засаг, бизнесийн олон салбарын үйл ажиллагаа тасалдаж эхлээд байна. Энэхүү судалгааны зорилго нь шинэ корона вирус (Ковид-19)-ийн улмаас Монгол Улсын санхүүгийн зах зээлд үүсэж болох эрсдэлийг шуурхай илрүүлэх, урьдчилан сэргийлэх бодлогын санал боловсруулахад оршино.

Халдварт өвчин тохиолдож байсан улс орнуудыг тодорхойлж, тэдгээрийн хямралыг даван гарсан, хямралын дараа түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байдал, эхний хоёр сарын байдлаарх корона вирус ихээр тархаж буй улс орнуудын эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, түүний эсрэг шуурхай авч хэрэгжүүлж буй бодлогын хэрэгслүүдийг судалсан.

Корона вирусийн дам нөлөөгөөр Монгол Улсын санхүүгийн зах зээлд үүсэж буй нөхцөл байдлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэх саналыг энэхүү судалгааны ажлаар боловсрууллаа.

Жич: Энэхүү судалгааны ажил нь корона вирусийн тархалтын эрчимжих эхэн үед боловсруулагдсан буюу судалгаанд ашиглагдсан мэдээлэл нь өвчлөл эхэлж байх үеийн мэдээлэлд суурилсан болно.

Түлхүүр үгс: санхүүгийн зах зээлийн эрсдэл, эдийн засгийн хүндрэл, корона вирус, хөл хорио

JEL ангилал: G20, G28

НЭГ. УДИРТГАЛ

2019 оны 12 дугаар сард Бүгд Найрамдах Хятад Ард Улс (БНХАУ)-ын Хубэй мужийн Ухань хотод “Шинэ төрлийн корона вирусээс үүсэлтэй уушгины хатгалгаа” өвчин анх илэрч, халдварлах нөлөө ихтэйн улмаас хүмүүсийн шилжих хөдөлгөөнөөр дамжин дэлхийн бусад улс орнуудад 2020 оны 1 дүгээр сараас эхлэн хурдтай тархан цар тахлын хэмжээнд хүрээд байгаа билээ. Дэлхийн хэмжээнд хамарсан халдварт өвчлөлүүд нь дан ганц иргэдийн эрүүл мэнд, амь насанд аюул учруулаад зогсохгүй улс орнуудын эдийн засгийн үйл ажиллагаанд эрсдэл учруулах нөлөөтэй юм.

Цар тахлын нөлөөгөөр бизнес эрхлэгч, үйлдвэрлэгч, аж ахуйн нэгж (ААН)-үүдийн үйл ажиллагааны тасралтгүй байдал доголдох, зах зээлийн бүтээмж буурах, ажилгүйдлийн түвшин өсөх зэрэг эрсдэлүүд үүсэж байдаг. Түүнчлэн эдийн засаг, зах зээлийн орчныг даган санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал алдагдах, хөрөнгийн хөрвөх чадвар буурах, системийн хэмжээний эрсдэлүүд тохион удаан хугацаанд үргэлжлэх хямралыг өдөөх боломжтой юм. Шинэ төрлийн корона вирусийн дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд үзүүлэх нөлөө өндөр байгаа бөгөөд дэлхийн хоёр дугаар дайны дараагаар тохиосон их хямрал, 2009 онд тохиосон санхүүгийн зах зээлийн хямрал зэрэг томоохон хямралуудаас ч илүү гүнзгий нөлөөтэй байж болзошгүй талаар олон улсын судлаачид, эдийн засагчид таамаглал, тооцооллыг дэвшүүлээд байна.

Вирусийн тархалтаас шалтгаалсан энэхүү хямралаас ард иргэдийнхээ амь нас болон ирээдүйн амьдралын чанар аль алиныг нь хамгаалах томоохон сорилт бодлого гаргагчдын өмнө тулгараад буй энэхүү үед Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны зохицуулалтын салбарууд болох хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодын хувьд үзүүлж буй нөлөөг цаг тухай бүр үнэлэх, дэлхийн бусад улс орнууд эдийн засаг, санхүүгийн зах зээлээ хамгаалах чиглэлд бодлогын ямар байр суурьтай оролцож буйг судлах, өвчлөлөөс үүдэн зохицуулалтын салбаруудад үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд, тэдгээрийн хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү судалгааны ажилд халдварт өвчлөл болон онцгой нөхцөл байдлын үед улс орнууд тохиосон хямралыг хэрхэн даван туулж байсан талаарх туршлага манай улсын санхүүгийн зах зээлд халдварт өвчлөлийн үзүүлж буй нөлөө, дөрөвдүгээр бүлэгт үүсээд буй сөрөг нөлөөллөөс зах зээлийн оролцогчдыг хамгаалах чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг тусгасан. Мөн халдварт өвчлөлийн үеэр зах зээлийн оролцогчид, бизнесийн байгууллагуудад үйл ажиллагаандаа мөрдөх зөвлөмжийг боловсруулан хавсаргасан болно.

ХОЁР. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮЕД ХЯМРАЛЫГ ДАВАН ТУУЛСАН УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

Улс орон бүр өөрсдийн онцлогт тохируулан халдварт өвчин гарсан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, бэлэн байдлын стратеги, төлөвлөгөөг боловсруулдаг бөгөөд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахын тулд эрх бүхий байгууллагууд хэрхэн уялдаа холбоотой ажиллаж, ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тус стратегиудад тусгажээ. Мөн зарим улс орнуудын хувьд халдварт өвчин гарсан үед мөрдөгдөх зөвхөн санхүүгийн байгууллагуудад зориулсан бизнесийн тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг урьдчилан боловсруулсан байдаг. Үүнээс гадна, улс орнууд системийн нөлөө бүхий санхүүгийн байгууллагууддаа бэлэн байдлын үнэлгээг гарган эрсдэлээс урьдчилан сэргийлдэг. Тухайлбал Америкийн Нэгдсэн Улс (АНУ)–ын Холбооны нөөцийн банк халдварт өвчний үед санхүүгийн байгууллагуудад тогтвортой үйл ажиллагаа явуулах чадамж буй эсэхийг тодорхойлох зорилгоор бэлэн байдлын үнэлгээг томоохон 15 банкны хүрээнд гаргасан. Мөн үндэсний хэмжээнд төдийгүй бизнесийн байгууллагууд эдийн засгийн огцом савлагааны үеэр ашиглах эрсдэлийн санг байгуулдаг жишиг олон улсад түгээмэл байна.

Шинэ корона вирус гарсантай холбоотойгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ

Корона вирус гарсантай холбоотойгоор дэлхий дахинд улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг яаравчлан хэрэгжүүлж байна.

(БНХАУ): БНХАУ–ын эрх баригчид корона вирус гарсантай холбоотойгоор эдийн засгийн уналтаас үүдэх сөрөг нөлөөллийг бууруулах, бизнесийн байгууллагуудыг дэмжиж ажиллах нарийвчилсан төлөвлөгөөг гаргасан.

2020 оны 01 дүгээр сарын 27–ны өдөр БНХАУ–ын Банк, даатгалын зохицуулах хороо (CBIRC) “Банк, даатгалын салбарын санхүүгийн үйлчилгээг бэхжүүлэх, корона вирусээс урьдчилан сэргийлэх, үр дүнтэй хяналт тавих чиглэлээр хамтран ажиллах тухай мэдэгдэл” гаргав. Тус мэдэгдэлд бүх банк, даатгалын байгууллагууд дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ хэмээн тусгажээ. Үүнд:

- Шинэ корона вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хянах ажилд холбогдох хэлтэс, орон нутгийн засаг захиргаад бүх хүчээ дайчлан тусалж, хамтран ажиллах;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлэх ногоон суваг нээх;
- Өвчнөөр өвчилсөн бүсүүдэд үзүүлэх дэмжлэгийг өргөжүүлэх шаардлагатай бөгөөд санхүүгийн үйлчилгээний төлбөр хураамжийг бууруулах, чөлөөлөх, процедурыг хялбаршуулах;
- Өвчин эмгэгийн улмаас орлогын эх үүсвэрээ түр алдсан хүн амд зээлийн бодлогын талаар зохих давуу эрх олгох, орон сууцны ипотекийн зээл, зээлийн карт болон бусад хувийн зээлийн зохицуулалт, зээлийн хугацааг оновчтойгоор сунгах;
- Корона вирустэй холбоотой даатгалын нэхэмжлэл гаргасан хэрэглэгчдэд давуу эрх олгож, нөхөн төлбөрийг бүрэн олгох;
- Ажилтнуудын өвчний үзлэгийг сайжруулах, Автомат теллер машин (АТМ)–ы ариутгал, цэвэрлэгээг тогтмол хийж, үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн үйлчилгээний газруудын эрүүл ахуй, өвчнөөс урьдчилан сэргийлэх менежментийг сайжруулах, ажилчид, үйлчлүүлэгчдийн төвлөрлийг бууруулах зэрэг болно.

Мөн БНХАУ-ын Сангийн яамнаас иргэд, бизнесийн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэхээ нийтэд мэдээлсэн бөгөөд БНХАУ-ын Төв банк өвчний улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжүүдийн зээлийн хүүг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх амлалт өгсөн. Тус улсын эрх баригчид муж, хот тус бүрийн хэмжээнд дараах бодлогын арга хэмжээг авч эхлээд байна.

БНХАУ-ын экспортын төв хот болох Гуандон дахь банк болон даатгалын зохицуулагч байгууллага халдварт өвчний улмаас үйл ажиллагаа нь доголдсон бөөний болон жижиглэн худалдаа, хүргэлт, аялал жуулчлалын салбарын компаниудыг дэмжин ажиллахаа зарласан. Гуандон хот дахь банк болон бусад санхүүгийн байгууллагууд бизнес эрхлэгчдэд туслах үүднээс зээл төлөлтийн хугацааг хойшлуулах, зээлийн хүүг бууруулах зэрэг арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байгаа талаар зохицуулагч байгууллагаас мэдэгджээ. Мөн зохицуулагч байгууллагын зүгээс зээл олгох бусад сувгуудыг бий болгож, байгууллагуудад зээл олгох үйл явцыг хялбаршуулах шийдвэр гаргасан.

Бээжин дэх зохицуулагч байгууллага тус өвчний улмаас үйл ажиллагаа нь доголдсон компаниудыг дэмжих үүднээс банкууд зээлийн хүүгээ бууруулж, мөн хүнд нөхцөлд орсон бизнесүүдийн чанаргүй зээлийг худалдаж авахыг актив удирдлагын компаниудад мэдэгдэв.

Шанхай хотын Хүний нөөц, нийгмийн хамгааллын товчооноос 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр корона вирусийн өвчнөөс үүдэн үйл ажиллагаа доголдсон аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн дарамтыг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг мэдэгдлээ. Тус арга хэмжээнүүд нь ажилгүйдлийн даатгалын хураамжийг буцаан олгох, нийгмийн даатгалын сангийн тохируулгын хугацааг хойшлуулах, нийгмийн даатгалын төлбөрийн хугацааг сунгах зэрэг юм.

Сүжоу мужийн захиргаа жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ)-д олгох зээлийг нэмэгдүүлэх, санхүүжилтийн зардлыг бууруулахыг банкуудад уриалж, ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн 50 хувийг буцаан олгохыг амлаж, үйл ажиллагаа нь ноцтой доголдсон аж ахуйн нэгжүүдийн даатгалын төлбөрийн хугацааг зургаан сараар сунгах шийдвэр гаргажээ. Төрийн өмчийг бизнесийн зориулалтаар түрээсэлдэг ЖДҮ-ийн хувьд нэг сарын түрээс төлөхөөс чөлөөлөх бөгөөд хоёр дахь сарын түрээснээс 50 хувиар хөнгөлнө. Нэн шаардлагатай аж ахуйн нэгжүүд үл хөдлөх хөрөнгийн албан татвараас чөлөөлөгдөх мөн татвар төлөх хугацааг 3 сараас дээшгүй хугацаагаар хойшлуулах боломжтойг тогтоожээ.

Түүнчлэн корона вирусийн дэгдэлт нь БНХАУ-ын иргэдийн хувьд даатгалын мэдлэгийг дээшлүүлж, тухайн улсын амьдралын даатгалын салбарын урт хугацааны хөгжилд эерэг нөлөө үзүүлж болзошгүй юм. Дэлхийн амьдралын даатгалын хоёр дахь том зах зээлийн хувьд БНХАУ-д өсөлтийн боломж өндөр хэвээр байгаа бөгөөд даатгалын компаниуд технологийн дэвшлийг ашиглан бодлогоо алсаас хүргэхийг эрэлхийлж байна.

Бүгд Найрамдах Солонгос Улс /БНСУ/: БНСУ-ын Засгийн газраас 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх ажлыг эхлүүлсэн ба нийт 379.6 тэрбум воныг шинэ зээл болон баталгаанд олгосон бол корона вирусийн дэгдэлтийн улмаас бизнест нөлөө үзүүлж буй жижиг, дунд бизнес эрхлэгчид, жижиглэн худалдаачид, хувиараа бизнес эрхлэгчдэд зориулан нэмэлт 607.4 тэрбум воны зээл болон баталгааг олгосон.

Жижиг бизнес эрхлэгчдийн хувьд БНСУ-ын Аж үйлдвэрийн банк болон бүс нутгийн зээлийн баталгааны сангаар дамжуулан бага хүүтэй зээл, баталгааны дэмжлэг зэрэг санхүүжилтийг авах боломжтой бөгөөд БНСУ-ын Аж үйлдвэрийн банкны хэт бага буюу үндсэн хүүтэй зээлд хамрагдах хөрөнгийг 1.7 их наяд воноос 4.2 их наяд вон болгон нэмэгдүүлэх, бүс нутгийн зээлийн батлан даалтын сангийн баталгааны дэмжлэгийн зориулалттай хөрөнгийг 16.7 их наяд воноос 17.2 их наяд

вон болгон нэмэгдүүлэх шийдвэрийг тус тус гаргасан.

Түр зуурын хөрвөх чадварын асуудалтай тулгараад байгаа жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд барьцаалагдсан анхдагч бондын үүрэг (P-CBO) болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулсан Засгийн газрын санхүүжилтийн хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн дэмжлэг авах боломжтой ба P-CBO-ийн олголтыг 1.7 их наяд воноос 2.2 их наяд вон болгон нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжихэд чиглэсэн санхүүжилтийн хөтөлбөрийн (аж үйлдвэрийн бүтцийг хөгжүүлэхэд 3 их наяд вон, байгууламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд 4 триллион вон) хэрэгжилтийг хангах ажлууд хийгдэнэ.

Түүнчлэн корона вирусийн тархалтаас шалтгаалан бизнесээ санхүүжүүлэхэд асуудалтай тулгарч байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн зээлийн хугацааг хамгийн багадаа зургаан сар болон нөхцөл байдал буурах хүртэл сунгах, хамгийн ихдээ 100 саяас 500 сая хүртэлх хэмжээний дунджаар 1–1.5 хувийн хүүтэй хөнгөлөлттэй нөхцөл бүхий бизнесийн зээл олгох бодлогыг баримтлан ажиллаж байна.

Сингапур Улс: Сингапурын Худалдаа аж үйлдвэрийн яамны дэргэдэх хуулийн зөвлөх төрийн байгууллага болох “Энтерпрайз Сингапур” нь бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг боловсруулах гарын авлага гаргасан. Тус гарын авлагад корона вирустэй холбоотой бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хянах менежерийг томилох зөвлөмжийг өгчээ. Мөн ахлах менежерүүдээс гадна харилцаа холбоо, хүний нөөц, үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудын залгамж халааг төлөвлөхийн ач холбогдлыг тус гарын авлагад ихээхэн онцлов. Үүнээс гадна, онцгой нөхцөл байдалд ажиллах багийг байгуулж, тэдгээрийн боловсон хүчнийг бүх цаг үед тусгаарлахыг бизнесийн байгууллагуудад зөвлөжээ.

Сингапурын хувийн даатгалын компани “Aia” нь өөрийн 1.4 сая даатгуулагчдадаа корона вирусийн даатгалд үнэгүй хамруулах болсноо мэдэгдсэн. Харин шинэ даатгуулагчид 2020 оны 02 дугаар сарын 17–ноос 7 дугаар сарын 31–ний өдрийн хооронд үнэгүй хамрагдах боломжтой. Даатгалын үйлчлэл хугацаа нь 2020 оны 12 дугаар сарыг дуустал байх бөгөөд энэхүү тусгай нөхцөл нь эмнэлэгт хэвтэх нэг удаагийн төлбөр болох \$1000–ын, корона вирусийн өвчний улмаас нас барсан тохиолдолд \$25000–ын нөхөн төлбөр олгохоор заажээ. Энэ арга хэмжээ нь тус компанийн нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагын хүрээнд хийж буй ажил ажээ.

Хонконг Улс: Хонконг Улсын зохицуулагч байгууллагууд орон сууцны болон кредит картын зээлээ төлөхөд бэрхшээлтэй байгаа иргэдэд онцгой анхаарал хандуулж ажиллах талаар санхүүгийн байгууллагуудад зориулсан удирдамж гаргасан. Мөн тус улсын эрх баригчид ЖДҮ эрхлэгчдэд бага хүүтэй зээл олгох, вирусийн эсрэг тэмцэх амны хаалт үйлдвэрлэдэг болон бусад эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг компаниудад шинээр данс нээх үйл ажиллагааг эрчимжүүлэх, санхүүгийн үйлчилгээний шимтгэлээс чөлөөлөх үйл ажиллагааг хэрэгжүүлэх юм.

Бослого үймээн, корона вирусийн тархалтын улмаас хүнд байдалд орсон эдийн засгаа аврахын тулд Хонконг Улсын засаг захиргаа 18–аас дээш насны иргэн бүрт \$1200 тараах бөгөөд нийт 120 тэрбум Хонконг доллар (\$15.4 тэрбум) зарцуулагдана. Энэхүү тэтгэмжид Хонконгийн байнгын оршин суугч 7 сая орчим хүн хамрагдахаар болжээ. 2019 оны 3 дугаар улирлаас эхэлсэн санхүүгийн хямралын улмаас тус хот сүүлийн 15 жилийн хугацаанд анх удаа төсвийн алдагдалд орсныг сангийн сайд Пол Чан мэдэгдсэн байна. Нөхцөл байдал цаашид улам муудаж, 2021 оны санхүүгийн жил дуусахад Хонконгийн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 4.8 хувиар буурах төлөвтэй байгааг тэрээр анхааруулжээ. Бэлэн мөнгө тараахаас гадна Хонконгийн эрх баригчид татвараас хөнгөлөх, бага орлоготой иргэдийн орон сууцны нэг сарын түрээсийн төлбөрийг чөлөөлөх, амьжиргааны түвшин

доогуур 200,000 өрхөд нэг удаагийн тэтгэмж олгохоор болжээ.

Вьетнам Улс: Вьетнам Улсын Төлөвлөлт, хөрөнгө оруулалтын яамнаас Засгийн газарт хүргүүлсэн мэдэгдэлд Төв банк ЖДҮ эрхлэгчид, халдварт өвчнөөс үүдэн үйл ажиллагаа доголдсон тариаланч, аж ахуй эрхлэгчдэд олгох зээлийн хүүг бууруулах, зээл эргэн төлөлтийн хугацааг сунгах зэрэг зээл олголтыг дэмжих үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх шаардлагатай талаар дурджээ. Мөн Сангийн яам зарим доголдсон бизнесүүдийн татвар төлөлт болон газрын түрээсийн төлбөрийг хойшлуулах, татварыг бууруулах асуудлыг авч үзэх талаар мэдэгдсэн.

Их Британи Улс: Их Британи Улсын санхүүгийн зохицуулагч байгууллагууд 2006 онд зургаан долоо хоногийн хугацаанд зах зээлийг бүхэлд нь хамарсан тахал тархахад санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах үүднээс ямар арга хэмжээ авч ажиллах, одоогийн мөрдөгдөж буй зарчмыг хэрхэн сайжруулах тал дээр хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулж байв. Тус уулзалтын үр дүнд дараах санаачилгуудыг гарган, хэрэгжүүлсэн.

- 2007 онд Их Британийн Засгийн газраас “Томуу, томуу төст өвчин, тахлын үеийн хариу арга хэмжээ авах үндэсний хэмжээний стратеги”-ийг баталсан;
- Бэлэн мөнгөний гүйлгээ хийдэг байгууллагууд тахал өвчний үед баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулсан;
- Томуу, тахал өвчний үед банкны хэвийн үйл ажиллагааг хангахын тулд жижиглэн худалдааны банкууд зарчимд суурилсан тогтолцоог бий болгосон. Тус тогтолцооны хүрээнд дараах зарчмуудыг баримталсан. Үүнд:
 - ажилтнуудыг аюулаас хамгаалах;
 - Засгийн газрын үндсэн чиглэлтэй уялдаж ажиллах;
 - хамтын ажиллагааны хүрээг идэвхжүүлэх;
 - зарчмуудыг сурталчлах.

Эдгээр зарчмуудыг Санхүүгийн зохицуулагч байгууллага, Сангийн яам болон Төв банк нь баталсан бөгөөд Их Британийн бусад санхүүгийн байгууллагуудад өргөн хүрээнд хүлээн зөвшөөрүүлэх талаас нь түгээн дэлгэрүүлэх ажил хийгдсэн.

- Санхүүгийн байгууллагууд болох Лондоны хөрөнгийн бирж, Лондоны төлбөр тооцооны төв онцгой нөхцөл байдалд ажиллах төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж илүү боловсронгуй болгосон;
- Салбарын хэмжээг хамарсан асуудлыг шийдэх, мөн гишүүнчлэлээр дамжуулан туршлага солилцох үүднээс даатгалын компаниуд Даатгагчдын холбооны удирдлага дор бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хангах холбоог байгуулсан;
- Алслагдсан байршлаас ажиллах баг нь өөр өөр байршлаас ажиллах эрсдэлийг тооцоолох үүднээс байгуулагдсан бөгөөд гол саад бэрхшээлүүдийн талаар удирдамж гаргасан.

Эдийн засгийн хямралын үед улс орнуудын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Халдварт өвчлөлийн үр нөлөөгөөр дотоодын эдийн засаг, санхүүгийн салбарт хямрал тохиох өндөр эрсдэл бий тул санхүүгийн салбараа хямралаас хохирол багатай гаргах, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг тогтвортой байлгах зэрэг нь хамгийн чухал юм.

2009 онд тохиосон санхүүгийн зах зээлийн хямралын үеэр дэлхийн олон орны төв банкууд уламжлалт

болон уламжлалт бус хямралын эсрэг бодлогуудыг хослуулан хэрэгжүүлж ажилласан. Энэ үед авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ нь санхүүгийн салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих замаар зээлийн тасалдлын эрсдэлийг бууруулах, гадаад валютын хөрвөх чадварыг тогтвортой байлгах, валютын своп хэлцэл хийх замаар ханшийн эрсдэлийг багасгах, ажлын байрыг тогтвортой хадгалах зэрэг байжээ.

Олон Улсын Валютын Сан (ОУВС)–гийн хийсэн судалгаагаар хямралын үед БНХАУ, Нигери, Унгар зэрэг орнуудын төв банкууд дотоодын зээлийн нөхцөл шаардлагыг зөөлрүүлэхэд, Чили, Израйл, Филиппин, Оросын Холбооны Улс, Мексик, БНСУ зэрэг улсуудын төв банкууд банкны салбарын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд анхаарч байжээ. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих бодлогынхоо хүрээнд банкуудын чанаргүй активыг худалдан авах, зээл олгох, санхүүгийн эх үүсвэр байршуулах, мөнгөний зах зээлийн арилжаанд хүлээн зөвшөөрөгддөг барьцаа хөрөнгийн жагсаалтыг шинэчилж өргөжүүлэх зэрэг олон арга хэрэглэжээ. Харин Турк, Филиппин, Израиль, Чили, Энэтхэг, Унгар, Индонез, Серби, БНСУ, Мексик зэрэг улсуудын төв банкууд Засгийн газартайгаа хамтран хямралын эрсдэлийг зөөлрүүлэхэд анхаарчээ. Энэ хүрээнд төв банк хооронд болон төв банкаас дотоодын банкуудтай валютын своп хэлцэл хийх замаар гадаад валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, гадаад валютын захад оролцох буюу интервенц хийх замаар ханшийн огцом савлагааг зөөлрүүлэх зэрэг арга хэрэглэсэн.

Үүнээс гадна дотоодын арилжааны банкууддаа гадаадын зах зээлээс валютын эх үүсвэр зээлэхэд бодлогын дэмжлэг үзүүлэх, гадаад валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг бууруулах гэх мэт цаг үеийн арга хэмжээ авч байжээ. Үүний үр дүнд банк санхүүгийн салбар төдийгүй бодит эдийн засагт учирсан эрсдэлийг бууруулж, учирч болзошгүй хохирлыг тойрч гарсан улсууд олон байна. Хямралыг зөөлрүүлж ажлын байраа хадгалахыг хичээсний үр дүнд эдийн засаг тогтвортой тэлэх суурийг бүрдүүлж чадсан гэж ОУВС–гаас дүгнэсэн.

ОУВС–гийн судалгаанаас үзэхэд улс орнуудын төв банкуудын ихэнх нь Засгийн газартайгаа хамтарч бодлогын арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэн, эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлт огцом буурах, банкны салбарт зээлийн гэнэтийн тасалдал гүнзгийрэх, банк санхүүгийн салбар системийн шинжтэй эрсдэлтэй учрах, хөдөлмөрийн зах зээлд маш олон тооны ажлын байр хоромхон зуур алга болж ажилгүйдэл огцом нэмэгдэх, эдийн засаг уналтад орох эрсдэлээс сэргийлж чаджээ. Харин зарим улс орны төв банкууд хямралын үед тулгарч мэдэх аюулыг зөөлрүүлэх бодлого хэрэгжүүлээгүй, хямарсны дараа засах оролдлого хийсэн нь улс орны эдийн засгийг уналт руу түлхсэн байна.


ГУРАВ. ШИНЭ КОРОНА ВИРУСИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЭХ ДАМ НӨЛӨӨ

Макро эдийн засагт үзүүлж буй нөлөө

Олон улсын түвшинд: 2019 оны байдлаар дэлхийн нийт ДНБ-ий 24.8 хувийг АНУ, 16.3 хувийг БНХАУ, 5.9 хувийг Япон Улс, 4.5 хувийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ), 3.4 хувийг Энэтхэг Улс, 45.1 хувийг бусад улс орнууд тус тус эзэлж байгаа бөгөөд БНХАУ нь дэлхийн 2 дахь том эдийн засагтай улс юм. Мөн 2019 онд БНХАУ дэлхийн нийт үйлдвэрлэлийн 33 хувийг дангаар бүрдүүлсэн байна. Эдгээр статистик мэдээллээс харахад БНХАУ нь дэлхийн эдийн засагт ихээр нөлөөлдөг бөгөөд шинэ корона вирусийн дэгдэлт дан ганц БНХАУ-аас гадна дэлхийн эдийн засагт томоохон сорилт болж байна. Дэлхийн банкны 2020 оны 6 дугаар сард гаргасан Дэлхийн эдийн засгийн ирээдүйн хандлагын тайланд 2019 оны сүүлээс эхлэн хөгжсөн орнуудын эдийн засаг 7 хувиар, хөгжиж буй орнуудынх 2.5 хувиар агших төлөвтэйг дурджээ. Харин БНХАУ-ын эдийн засаг 1 хувиар өсөхөөр байгаа ба энэ нь сүүлийн 40 гаруй жилийн хугацаанд хамгийн багаар өсөх таамаглалтай байгааг онцолжээ.

Олон улсын шинжээчдийн 2020 оны эхэн үед таамаглаж байснаар шинэ корона вирусийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө 2002 онд дэгдэж байсан CAPC (SARS) вирусээс илүү хүчтэй байж болзошгүй юм. Учир нь БНХАУ-ын эдийн засаг 2002 оноос хойш 4 дахин томорч бусад улс орнуудтай явуулж буй хамтын ажиллагаа, гадаад харилцаа нь илүү өргөжсөн байна. Хятадын эдийн засгийн энэхүү бууралт зүүн өмнөд Азийн улсуудад хамгийн их нөлөө үзүүлнэ гэж олон улсын шинжээчид таамаглаж байна. Тухайлбал Япон, БНСУ зэрэг улс орнуудын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, тэр дундаа дэвшилтэт технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд БНХАУ хамгийн том нийлүүлэгч тул эдгээр улсуудын эдийн засгийн үзүүлэлтэд хамгийн их нөлөө үзүүлэхээр хүлээгдэж байна. Харин АНУ болон БНХАУ хооронд өрнөсөн худалдааны дайнтай холбоотойгоор АНУ-ын эдийн засагт корона вирусийн үзүүлэх нөлөө харьцангуй бага хэмээн шинжээчид таамаглажээ.

Зураг 1.1. Шинэ корона вирусийн 2020 оны I улиралд дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө, Дойче банкны тооцооллоор



Эх сурвалж: *Financial Times*

Шинэ корона вирусийн улмаас хамгийн их өртөх БНХАУ–ын эдийн засгийн салбарууд:

– Аж үйлдвэрийн салбар

Корона вирусийн тархалтын нөлөө хамгийн хүчтэй тусаж буй салбар нь аж үйлдвэрийн салбар тэр дундаа электрон бараа, тоног төхөөрөмж, автомашины үйлдвэрлэл байна. БНХАУ нь дэлхийн электрон тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийн хамгийн том оролцогчдын нэг бөгөөд дэлхийн хэмжээнд хийгдсэн электрон бүтээгдэхүүний бүрдэл хэсгийн экспортын нийт 30 хувийг дангаараа нийлүүлдэг. Мөн өвчин тархсан Ухань хот нь автомашин үйлдвэрлэлийн төв хот бөгөөд уг бүсэд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүд зогссоноор тус салбар хүчтэй нөлөөнд автаад байна.

Аж үйлдвэрийн салбарын уналттай холбоотойгоор банкны зээлийн чанар муудах эрсдэл үүссэн бөгөөд БНХАУ–ын Төв банк зогсонги байдалд орсон аж үйлдвэрийн салбараа унахаас хамгаалах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд зориулан үүсгэсэн сангаа вирусийн халдварын үеэр ашиглаж эхэлсэн.

– Эрдэс бүтээгдэхүүний зах зээл

Корона вирусээс шалтгаалан Хятадын эдийн засагт үүсээд буй нөхцөл байдал нь дэлхийн эрдэс бүтээгдэхүүний салбарт мөн хүчтэй нөлөө үзүүлж байна. Учир нь БНХАУ эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн хамгийн том импортлогч улс тул үүссэн нөхцөл байдал, аж үйлдвэрийн салбарын зогсолт нь эрдэс бүтээгдэхүүний салбарт сөрөг нөлөө үзүүллээ. Мөн БНХАУ–ын дотоод эдийн засгийн энэхүү хүндрэлээс шалтгаалан өвчлөлийн дараагаар БНХАУ үйл ажиллагааг нь зогсоогоод байсан нүүрсний үйлдвэрүүдээ сэргээн дотоодын эдийн засгаа дэмжихээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь цаашид эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн импорт буурахад нөлөө үзүүлэх магадлалтай.

– Аялал жуулчлалын салбар

БНХАУ–ын уламжлалт баяр цагаан сартай холбоотойгоор дотоодын аялал жуулчлал, түүнийг дагасан олон мянган захиалгууд цуцлагдсан. Үүнээс гадна БНХАУ нь дэлхийн аялал жуулчлалын салбарын томоохон оролцогчдын нэг бөгөөд 2018 оны 9 дүгээр сараас 2019 оны 9 дүгээр сар хүртэлх нэг жилийн хугацаанд БНХАУ–ын ард иргэд нийт 173.0 сая гаруй удаагийн жуулчлалаар 0.3 орчим их наяд долларыг аялал жуулчлалын салбарт зарцуулсан байна.

БНХАУ–ын эдийн засаг 2020 оны эхний улиралд халдварын тархалтын улмаас өрхийн хэрэглээ буурсан, санхүүгийн бус үйлчилгээний салбарын үйл ажиллагаа зогссоноос улбаатай огцом унасан. Харин 2 дугаар улирлаас тогтоосон хорио цээрээ сулруулснаар эдийн засаг нь аажмаар хэвийн байдал руугаа шилжсэн. Түүнчлэн Засгийн газраас санхүүжилтийн хомсдол, гадаад эрэлтийн бууралтыг нөхөхөөр ДНБ–ийхээ 2.8 хувьтай тэнцэх хэмжээний хөрвөх чадварыг сайжруулах, татвараас чөлөөлөх, эрүүл мэнд, татаас олгох зэрэг мөнгөний болон сангийн бодлого хэрэгжүүлсэн.

Манай улсын хувьд: Засгийн газрын шийдвэрийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 11–нээс эхлэн 3 дугаар сарын 02–ны өдөр хүртэл буюу ойролцоогоор гурван долоо хоногийн хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн, Бичигт, Булган боомтын нүүрсний экспортыг бүрэн зогсоолоо. Энэ нь түүхий эдийн үнэ унавал экспортын бүтээгдэхүүнээс ихэнх орлогоо бүрдүүлдэг манай улсын хувьд хүндхэн цохилт болох юм. Монгол Улсын нийт экспортын 60 хувь нь зэс болон нүүрсний экспорт эзэлдэг. Өнгөрсөн оны хоёрдугаар сард Монгол Улс 1.9 сая тонн нүүрс экспортолж, 163.4 сая ам.долларын экспортын орлого олжээ. Ийнхүү өмнөх жилийнхтэй адилтган тооцвол Засгийн газрын хоригийн улмаас Монгол Улс нүүрсний экспортоос олох 163.4 сая ам.долларын орлогоо алдахаар байна.

Мөн 2019 оны байдлаар манай улсын нийт экспортын 93.8 хувь, импортын 41.8 хувийг БНХАУ дангаараа бүрдүүлж байгаа бөгөөд БНХАУ–д үүсээд буй уг нөхцөл байдал удаан үргэлжилбэл гадаад

худалдааны нөхцөл түүгээр дамжин дотоодын эдийн засаг, үйлдвэрлэлийн салбар уналтад орох магадлалтай.

Санхүүгийн зах зээлд үзүүлж буй нөлөө

Олон улсын түвшинд: Корона вирусийн улс орнуудын макро эдийн засагт үзүүлж буй нөлөө хөрөнгийн зах зээл дээр мөн ажиглагдан корона вирусийн айдас дунд хувьцааны үнэ санхүүгийн хямралаас хойших түүхэн доод түвшиндээ хүрлээ. 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар БНХАУ-ын Си Эс Ай индекс 13 жилийн хугацаанд анх удаа уналаа. Мөн эрдэс баялгийн болон аж үйлдвэрийн салбарын бууралтаас шалтгаалан Япон, Шанхай, Хонконг зэрэг томоохон хөрөнгийн зах зээлүүдэд уналт, савлагаа үүсэж эхлээд байсан бол үүнээс хойш сар хүрэхгүй хугацааны дараа хувьцааны зах зээлийн голлох индексүүдийн нэг болох S&P 500 индекс 13 хувийн уналтыг үзүүлсэн нь 2008 оны хямралаас хойш үзүүлсэн хамгийн их бууралт боллоо. 2008 оны 10 дугаар сард S&P 500 индексийн үнэ 18 хувь унасан юм. Түүнчлэн Европт Их Британийн FTSE100 индекс 11 хувь, ХБНГУ-ын DAX индекс 12 хувь буурсан бол, Азид Nikkei-225 индекс 10 хувь, БНСУ-ын KOSPI индекс 8 хувь, Шанхайн Shanghai Composite индекс 8 хувийн бууралтыг тус тус үзүүлээд байна.

Хүснэгт 1. 1. Дэлхийн гол индексүүдийн төлөв

№	Индекс	2020.02.24 – 2020.02.28	2020.09.23– 2020.09.30
1	S&P 500 in United States	13% ↓	3.9%
2	Dow Jones in United States	14% ↓	3.8%
3	FTSE 100 in Britain	11% ↓	0.6% ↓
4	DAX in Germany	12% ↓	0.9%
5	KOSPI in South Korea	8% ↓	0.2% ↓
6	Hang Seng Index in Hong Kong	4% ↓	1.2%
7	Nikkei 225 in Japan	10% ↓	0.7% ↓

Эх сурвалж: www.marketwatch.com

Корона вирусийн тархалтаас шалтгаалан эдийн засаг, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал муудна гэсэн айдаст таамаглалаар хөрөнгө оруулагчид эзэмшиж буй хувьцаагаа худалдах хандлага ажиглагдаж байгаа юм. Зах зээлийн энэхүү нөхцөл байдалд уялдуулан АНУ-ын Холбооны нөөцийн банкны дарга Жероми Паувел “Корона вирусийн тархалтын нөхцөл байдал дордвол зохицуулагч байгууллагын хувьд эдийн засгийг дэмжих зохих арга хэмжээг авах болно” гэж хөрөнгө оруулагчдыг тайвшруулсан мэдэгдэл хийлээ.

Хөрөнгийн менежментийн “Гүггенхайм Инвестмэнт” компанийн шинжээч Скот Майнерд мөн Холбооны нөөцийн банкт хамтарч ажиллаж байгаа бөгөөд Уол Стрийтийн хамгийн чухал ажиллагаа болох хөрөнгө оруулалтын хөдөлгөөн удаашрах, царцахыг анхааралтай ажиглаж байгаа гэж мэдэгдлээ. Хэрэв нөхцөл байдал дордвол Холбооны нөөцийн банк хөрөнгө оруулагчдыг хөнгөлөлттэй үнийн нөхцөл санал болгож хөрөнгө оруулалтыг дэмжих, зах зээлийн арилжааг идэвхтэй хэвээр хадгалах чиглэлээр шахах болно гэж мэдэгдсэн байна.

Бизнес эрхлэгчид, үйлдвэрлэгчдийн үйл ажиллагаа зогссоноос шалтгаалан бизнесийн байгууллагуудын зээлийн эргэн төлөлт муудаж эхэлсэн бөгөөд Эс Энд Пи-гийн таамаглаж буйгаар БНХАУ-ын банкны салбарын муу зээлийн нийт хөрөнгөд эзлэх дүн 2 хувиас 6.3 болж өсөх боломжтой бөгөөд уг үзүүлэлт нь БНХАУ-ын банкны салбарт сүүлийн 20 жилийн туршид тохиож байгаагүй үзэгдэл юм.

Корона вирусийн цар тахал улс орнуудад хурдацтай тархаж, тархалтыг удаашруулах зорилгоор олон нийтийн газар цугларахыг хориглож, ажилтнуудыг гэрээсээ ажиллуулах болсон, зарим улс орон хил

гаалиа хаасан зэрэг шалтгаанаас хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлийн талаарх тодорхойгүй байдал болон нөхцөл байдал муудна гэсэн айдас үүсэж хувьцааны үнэ бууран олон улсын зах зээлийн голлох индексүүд огцом унасан. Хөрөнгийн зах зээлийн уг уналт 2020 оны 5 дугаар сараас улс орнуудын тогтоосон хорио цээр буурсантай холбоотой эргэн сэргэсэн. 2020 оны 9 дүгээр сарын байдлаар хөрөнгийн зах зээлийн голлох индексүүд хэвийн хэмжээнд хэлбэлзэж байгаа хэдий ч корона вирусийн улмаас тодорхойгүй байдал одоог хүртэл үргэлжилж байна. Хөрөнгө оруулагчид цар тахлын нөхцөл байдлын улмаас найдвартай хөрөнгө оруулалтын хэрэгслийг сонгох болсноор бондын эрэлт өсөв. Мөн хөрөнгө оруулагчдын хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотой шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг эрэлхийлэх болсон.

Корона вирус нь бизнесийн хэд хэдэн чиглэлд даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэх магадлал өндөртэй байна. Бусад тахал өвчний адил корона вирус нь иргэдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй аялал жуулчлал, бизнесийн үйл ажиллагаа зогсоход хүргэж байна. Улмаар эрүүл мэнд, амь насны даатгал болон бизнесийн үйл ажиллагааны нөхөн төлбөрийн зардал нэмэгдэж болзошгүй юм. Даатгалын бодлогын мөн чанар нь урьдчилан тооцоолоогүй, үл мэдэгдэх эрсдэлээс даатгуулагчийг хамгаалдаг боловч тохиолдох нь мэдэгдэж байсан нөхцөл байдлаас хэрэглэгчийг хамгаалахгүй. Одоогийн байдлаар энэ талаар даатгагчдын нэгдсэн хандлага, үзэл гэж байдаггүй. Зарим даатгагчид корона вирусийг ийм нөхцөл байдал үүсгэхийг мэдэж байсан, мэдэх боломжтой нөхцөл байдал гэж үзсэн бол зарим нь эсрэг байр суурьтай байна. Корона вирусийн дэгдэлтийн өнөөгийн нөхцөлд даатгалын хамрах хүрээ хараахан тодорхойлогдоогүй байгаа юм. Энэ нь зарим талаараа БНХАУ–ын эрүүл мэндийн үндэсний комиссоос корона вирусийг В ангиллын халдварт өвчин гэж ангилдагтай холбоотой. Хятадын ихэнх хувийн даатгалын компаниуд В ангиллын халдварт өвчнөөс хамгаалах үйлчилгээ үзүүлдэггүй. Гэсэн хэдий ч зарим даатгагчид даатгалын гэрээний хасалтын заалтыг түдгэлзүүлж, өртгийн тодорхой хэсгийг сайн сайхан байдал, нийгмийн хариуцлагын хүрээнд нөхөн төлөх шийдвэрийг гаргаж байна. Даатгалын зах зээлд халдварт өвчлөлөөс шалтгаалан тодорхой бус байдал үүсээд буй хэдий ч даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх боломж мөн харагдаж байгаа юм. БНХАУ–ын иргэд эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний ач холбогдлыг ойлгох, хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагдалтаа нэмэгдүүлэх хандлагатай байна. Энэ нь БНХАУ дахь хувийн эрүүл мэндийн даатгагчдад өсөлтийн томоохон боломж байгааг харуулж байна.

Корона вирусийн макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар бидний таамаглаж байгаагаар тархалт ихэнх салбарт дундаас урт хугацааны хязгаарлагдмал нөлөө үзүүлэх бөгөөд тэдгээрийн өсөлтийн хандлага үндсээрээ өөрчлөгдөхгүй. Эдийн засгийн өсөлтөд хамгийн их хувь нэмэр оруулдаг хэрэглээний салбар хамгийн их хохирол амсах салбар байх болно. Энэ оны эхний хагаст нийтийн хоолны газар, жижиглэн худалдаа, аялал жуулчлалын үйлчилгээний борлуулалт буурсан. Гэсэн хэдий ч, цахим худалдаа ихээхэн хувь эзэлдэг өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, ялангуяа өдөр тутмын хэрэгцээ, хэрэглээний орчин тогтворжсон дарууд амархан сэргэж чаддаг. Нөгөө талаас корона вирус нь шинжлэх ухаан, анагаах ухааны үйлчилгээний салбаруудад сорилт болж тус салбаруудад хөгжих боломжийг авчирч байна. Вирусийн тархалттай холбоотой эмнэлгийн хэрэгсэл, эмийн хомсдол үүсэж эхэлсэн тул халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эмнэлгийн үйлчилгээний тогтолцоог сайжруулах зэрэг асуудлыг улам боловсронгуй болгож, эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хөрөнгө оруулалт татаж болно. Корона вирусийн халдварын үед бүх салбарт технологийн дэвшлийг аль болох ашиглах нь чухал байна. Ялангуяа онлайн боловсрол, онлайн үзвэр үйлчилгээ, гэрээсээ ажиллахад технологи ашигласнаар корона вирусийн тархалтын эсрэг чухал арга хэмжээ болж, зарим үйл ажиллагааг хэвийн явуулах боломж олгож байна.

Манай улсын хувьд: Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил харьцангуй сул, идэвхжил бага байгаагаас шалтгаалан зах зээлийн үзүүлэлтүүд аливаа томоохон өөрчлөлтийг мэдрэх мэдрэмж багатай. 2020 оны 02 дугаар сарын байдлаар хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүдийн хувьд өвчлөлөөс шалтгаалсан бууралт, огцом өөрчлөлт ажиглагдаагүй байна. Гэхдээ УИХ болон Засгийн газрын шийдвэрээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн зорилтот зах зээл нь БНХАУ тул олон улсын зах зээл, тэр дундаа Хонконгийн хөрөнгийн бирж дээр IPO хийх төлөвлөгөөтэй байсан. БНХАУ дахь вирусийн тархалт их байгаа тул Хонконгийн хөрөнгийн захад уналт ажиглагдсан, мөн тухайн зах зээлд шинээр гарч байгаа IPO цуцлагдах, аливаа байдлаар IPO-ийн үйл явц удааширснаар “Эрдэнэс таван толгой” ХК-ийн хувьцааг олон нийтэд худалдахад сөрөг нөлөө үзүүлэхээр байна.

Харин даатгалын салбарын хувьд өвчлөл нэгэнт нэвтрэн даатгалтай иргэд, аж ахуйн нэгж хохирсон тохиолдолд тэдгээрийн нөхөн төлбөрийг олгохтой холбоотой зардлыг гаргах боломжтой. Гэхдээ өвчлөл гарсан улс орнуудад корона вирусийн өвчлөлөөс үүдсэн хохирлыг гэнэтийн хүчин зүйл эсхүл хасагдах нөхцөлд оруулан тооцож нөхөн төлбөрийн зардлыг багасгах, эсхүл нийгмийн хариуцлагын хүрээнд тодорхой хэмжээний нөхөн төлбөрийг олгох зэргээр арга хэмжээ авч буй тохиолдлууд байна.

БНХАУ-ын экспортын хэмжээ буурсантай холбоотой манай улсын түүхий эдийн экспорт буюу уул уурхайн гаралтай бараа, түүхий эдийн нийлүүлэлт багасна, мөн өвчлөлөөс шалтгаалсан хөл хорионы улмаас бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа доголдоно гэж үзвэл арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж, зээлийн хоршоодоос авсан зээл, мөн бондын хаалттай хэлбэрээр санхүүжилт татсан аж ахуйн нэгжүүдийн хувьд зээлийн үндсэн төлбөр болон хүү хугацаандаа эргэн төлөгдөх чадвар буурч, улмаар бизнесийн болон хэрэглээний зээл чанаргүйдэх, санхүүгийн зах зээл энэхүү дам нөлөөллийн улмаас эрсдэлд орохоор байна. Өөрөөр хэлбэл, санхүүгийн байгууллагаас зээл авсан аж ахуйн нэгж болон иргэдийн орлого олох суваг зогсох нь мөнгөн хуримтлалгүй байх үетэй давхцвал зээл, хүүгийн эргэн төлөлт саарснаар чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх сөрөг талтай.

Халдварт өвчин гарснаар үүсээд буй эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан санхүүгийн салбарт учрах эрсдэлийг даван туулах, тогтвортой байдлыг хангахад ямар төрлийн аюул, боломж, давуу, сул тал үүсэж болохыг таамаглан доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. 2. Гадаад болон дотоод орчны шинжилгээ


	ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ	БОЛОМЖ	АЮУЛ ЗАНАЛ
Макро эдийн засгийн түвшинд	<ul style="list-style-type: none"> * 2017 оноос хойш эдийн засгийн өсөлт сайжирсан; * Дотоод хэрэгцээг бүрэн хангах мал аж ахуйн нөөц ихтэй; * Алтны нөөц сайжирсан. 	<ul style="list-style-type: none"> * Эдийн засгийн гадаад хүчин зүйлээс хамаарах эмзэг байдал өндөр; * Хямралын үед ашиглах нөөц сан хомс, улсын өрийн түвшин өндөр. 	<ul style="list-style-type: none"> * Газрын тосны үнийн бууралт; * Хөрөнгө оруулагчид хөрөнгийнхөө үнэ цэнийг тогтвортой хадгалахын тулд алтанд хөрөнгө оруулалт хийж буйтай холбоотой, алтны үнийн өсөлт. 	<ul style="list-style-type: none"> * Эрдэс бүтээгдэхүүний зах зээлийн экспортын бууралт; * Хөдөлмөрийн зах зээлд хүлээгдэж буй эрсдэл, ажилгүйдлийн түвшин, ажилчдын бүтээмж буурах асуудал; * Эдийн засгийн өсөлт удаашрах, зорилтот түвшинд хүрэхгүй байх, эдийн засагт гарсан өөрчлөлтийг улс төрийн нөлөөнд автуулж, буруугаар ашиглах; * БНХАУ–д хөл хорио тогтоож, худалдаа наймаа буурсан энэ үед манай улсын БНХАУ руу гаргадаг экспорт буурах.
Зохицуулалтын орчноос	<ul style="list-style-type: none"> * СЗХ нь олон нийт болон зохицуулалтын байгууллагуудыг онцгой нөхцөл байдлыг даван туулах, уриалахад чиглэл өгөн хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага. 	<ul style="list-style-type: none"> * Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагуудын уялдаа холбоотой ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах урьдчилсан стратеги, төлөвлөгөө байхгүй; * Системийн хэмжээний эрсдэлийг удирдах нэгдсэн хяналт шалгалтын систем бүрдээгүй. 	<ul style="list-style-type: none"> * Амьдралын даатгалыг сурталчлах боломж; * Зохицуулалтын үйл ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэх, цаашид технологиор дамжуулан төрийн үйлчилгээний хүнд суртлыг бууруулах. 	<ul style="list-style-type: none"> * Зохистой зохицуулалтыг хэрэгжүүлж чадаагүйн улмаас зохицуулалттай байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоож, зах зээлээс гарах; * Хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хохирч, зах зээлд итгэх итгэл буурах; * Бизнесийн үйл ажиллагааны тасалдал, эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд буурах.
Зохицуулалттай байгууллагын түвшинд	<ul style="list-style-type: none"> * Мэргэжлийн холбоодтой өөрийгөө зохицуулах байгууллагын хүрээнд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажилладаг. 	<ul style="list-style-type: none"> * Санхүүгийн байгууллагууд өвчин гарсан тохиолдолд баримталж ажиллах ёс зүйн дүрэмгүй; * Хямралыг даван туулах бэлэн байдлын төлөвлөгөөгүй; * Зээл олгоход тавигдах шаардлага өндөр. 	<ul style="list-style-type: none"> * Санхүүгийн хүртээмж нэмэгдэх буюу зарим төрлийн санхүүгийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэх; * Санхүүгийн байгууллагууд технологийн дэвшлийг үйлчилгээндээ нэвтрүүлэх, бүтээгдэхүүнээ илүү сайн таниулж, хэрэглээнд нэвтрүүлэх. 	<ul style="list-style-type: none"> * Санхүүгийн байгууллагаас зээл авсан аж ахуйн нэгж болон иргэдийн орлого олох суваг зогсох нь мөнгөн хуримтлалгүй байх үетэй давхацвал зээл, хүүгийн эргэн төлөлт саарснаар чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэх; * Ажилтнууд өвчин тусах эсхүл ажлын байрны цагийг уян хатан болгосноор ажиллах хүчин хомсдох, ажлын бүтээмж буурах, хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний чанар муудах; * Бэлэн мөнгө их хэмжээгээр буцаан татах, ингэснээр банк санхүүгийн байгууллагууд эрсдэлд орох; * Зарим төрлийн даатгалын бүтээгдэхүүний хураамжийн орлого буурах, нөхөн төлбөрийн зардал нэмэгдэх.

Олон нийт	* Засгийн газрын шийдвэрийг богино хугацаанд даган мөрдөх цөөн хүн амтай.	* Ард иргэд ташаа мэдээлэлд түргэн автдаг.	* Иргэдийн санхүүгийн сахилга бат сайжрах; * Бизнесийн байгууллагууд, иргэд нөөц сан, хуримтлал, даатгалын бүтээгдэхүүний ач холбогдлыг ойлгох, гэнэтийн эрсдэлийг удирдахад суралцах.	* Халдварт өвчний тархалтаас шалтгаалан эрүүл мэндийн аюулгүй байдалд өндөр эрсдэл үүсэх, эмчилгээний зардал нэмэгдэх, бүтээмж буурах; * Иргэдийн орлого тасалдах, амьжиргааны түвшин буурах; * Зах зээл дэх санхүүжилтийн эх үүсвэр буурах улмаар жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гарааны бизнесүүдийн үйл ажиллагаанд хүндрэл учрах.
------------------	---	--	---	--

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-уудын салбар: 2019 оны байдлаар ББСБ-ууд нийт 1.8 их наяд төгрөгийн зээл олгосон ба үүнээс иргэдэд олгосон зээл 71 хувийг бүрдүүлжээ. Харин ББСБ-аас уул уурхайн салбарын зориулалттай зээлийн эхний болон эцсийн үлдэгдэл, олгосон болон төлөгдсөн зээлийн 4 хүрэхгүй хувийг эзэлжээ. Банкны салбарын зээлийн хувьд уул уурхайн салбарын зориулалттай зээл 10 гаруй хувьтай байна.


Зураг 1.2. ББСБ-ын зээлийн үзүүлэлт, салбарын ангиллаар



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт зээлийн үлдэгдлийг зээлийн зориулалтаар нь ангилан харвал хамгийн их буюу 57.8 хувийг хэрэглээний зээл, 17.1 хувийг бөөний болон жижиглэн худалдааны зориулалт бүхий зээл, 10.4 хувийг барилгын зориулалттай зээл, 3.9 хувийг уул уурхай, олборлолтын зориулалттай зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

Зураг 1.3. Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2019 оны жилийн эцсийн байдлаар зээлийн жигнэсэн дундаж хүү 3.0 хувь байна. ББСБ–ын зээлийн үлдэгдэл оны эцэст 1.2 их наяд төгрөгт хүрснээс зээлийн 87.9 хувь нь хэвийн, 3.6 хувь нь хугацаа хэтэрсэн, 8.5 хувь нь чанаргүй зээл байна.

2019 оны жилийн эцсийн байдлаар ББСБ–ын салбарын нийт зээлд эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ 3.6 хувь байсан бол 2020 оны 01 дүгээр улирлын байдлаар 4.0 хувьд хүрч 0.4 пунктээр нэмэгдсэн байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ 2019 оны жилийн эцсээс 0.1 пунктээр буурч 8.4 хувьд хүрэв.

Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)–дын салбар: Дэлхийн хадгаламж, зээлийн хоршоодын холбооноос¹ 2020 оны 02 дугаар сарын 28–ны өдөр Базелийн хороо Банкны системийн эрсдэл, хяналт шалгалтын санаачилгууд болон Базел III–ын хэрэгжилтийн талаар ярилцах үедээ корона вирусийн санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх нөлөөллийн талаар хэлэлцсэн байна. Ингэхдээ уг вирусийн хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдлыг харгалзан сонор сэрэмжтэй байхыг банкууд болон хянан шалгагч байгууллагуудад уриалж, ийм цохилтыг даван туулахад хил дамнан мэдээлэл солилцох, хамтран ажиллах нь үр дүнтэй болохыг чухалчлав.

ХЗХ–дын хувьд 2014–2018 онуудын дундаж зардлын бүтцийг гаргавал нийт зардал дунджаар 23.3 тэрбум төгрөг бөгөөд үүнээс орлогын албан татварын зардал 2.2 хувийг, боловсон хүчний зардал 19.0 хувь, зохицуулалтын үйлчилгээний хөлс 0.1 хувийг бүрдүүлж байна. Хувь хүний орлогын албан татварын болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын төлбөр нийт зардлын 3.3 хувийг бүрдүүлж байна. Харин хүүгийн зардал 62.1 хувийг эзэлсэн нь зээлийн хүү төлөгдөхгүй нөхцөлд ХЗХ–ны гишүүн, хадгаламж эзэмшигчдэд хохирол учрахаар байна. Давагдашгүй хүчин зүйл тохиолдохоор байгаа энэ нөхцөлд ХЗХ–д бүх гишүүдийн хурлаараа хадгаламж болон зээлийн хүүгээ дахин тохирох боломжтой.

ХЗХ–д нь санхүүгийн тайлан болон хадгаламж, зээлийн статистик мэдээллийг улирлын давтамжтайгаар СЗХ–нд тайлагнадаг бөгөөд корона вирусийн халдвар нь ХЗХ–дын үйл ажиллагаанд үзүүлж буй эсэхийг тандах зорилгоор салбартаа хамгийн их хөрөнгөтэй хоршоодоос зээлийн эргэн төлөлт, хадгаламж, түүний буцаан таталтад өөрчлөлт орж байгаа эсэхийг Топ 20 ХЗХ–доос агуулгын хэлбэрээр 2020 оны 02 дугаар сард тодрууллаа.

Тус 20 ХЗХ–ны хөрөнгийн хэмжээ салбарын нийт активын 81.7 хувийг эзэлдэг. Судалгаанд хамрагдсан хоршоодын 89 хувь нь одоогийн байдлаар өөрчлөлт мэдрэгдээгүй, 11 хувь нь жижиглэнгийн худалдаа

1 WOCU

эрхлэгчид зээлээ сунгуулах тухай хүсэлт ирүүлсэн гэж хариуллаа. Эдгээр ХЗХ–ны зээл олголт, эргэн төлөлтийн мэдээллийг өмнөх саруудтай нь харьцуулж үзэхэд зээл олголт, эргэн төлөлт саарсан үзэгдэл ажиглагдаагүй бөгөөд 02 дугаар сард тохиосон олгосон зээлийн бууралт нь улирлын шинж чанартай тул үүнийг онцгой өөрчлөлт гэж авч үзэхээргүй байна.

Хүснэгт 1.3. ХЗХ–дын зээлийн мэдээ, тэрбум төгрөгөөр

№	Хугацаа	Зээлийн эхний үлдэгдэл	Олгосон зээл	Төлөгдсөн зээл	Зээлийн эцсийн үлдэгдэл
1	2019.10 сар	115.7	40.1	36.9	118.9
2	2019.11 сар	121.6	41.6	39.9	123.2
3	2019.12 сар	124.1	45.2	55.1	114.1
4	2020.1 сар	105.6	41.3	25.2	121.5
5	2020.2 сар	114.8	30.0	28.6	116.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Харин ХЗХ–дын хадгаламж татан төвлөрүүлэлт, буцаан олголтын мэдээллийг өмнөх саруудтай нь харьцуулж үзэхэд хадгаламж эзэмшигчид хадгаламжаа сүүлийн саруудад их хэмжээгээр татсан үзэгдэл ажиглагдаагүй байна.

Хүснэгт 1.4. ХЗХ–дын хадгаламжийн мэдээ, тэрбум төгрөгөөр


№	Хугацаа	Хадгаламжийн эхний үлдэгдэл	Татан төвлөрүүлсэн хадгаламж	Буцаан олгосон хадгаламж	Хадгаламжийн эцсийн үлдэгдэл
1	2019.10 сар	106.7	5.9	5.7	106.9
2	2019.11 сар	106.9	5.1	6.7	105.3
3	2019.12 сар	105.3	7.1	4.2	108.2
4	2020.1 сар	108.2	14.8	13.3	109.7
5	2020.2 сар	109.7	5.3	2.4	112.6

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөрөнгийн зах зээл: Аливаа улсын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг илэрхийлэгч гол үзүүлэлтүүд нь зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ) болон индекс байдаг. Эдгээр үзүүлэлтүүд шинэ корона вирусийн талаар мэдээлэл олон нийтэд цацагдаж эхэлснээс хойших хоёр сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдсөн, зах зээлд нөлөө үзүүлсэн эсэхийг харуулах статистик мэдээллүүдийг авч үзье.

Монголын хөрөнгийн биржийн зах зээлийн үнэлгээ 2019 оны жилийн эцсийн байдлаар 2.69 их наяд төгрөг байсан бол 2020 он гарснаас хойш 2 сарын хугацаанд буюу 2020 оны 02 дугаар сарын 28–ны өдрийн байдлаар 2.75 их наяд төгрөг хүрсэн нь 2.1 хувиар өссөн үзүүлэлт юм. 2019 оны 3 дугаар сарын 10–ны өдөр буюу Монгол Улсад корона вирусийн анхны тохиолдол илрэх үеийн зах зээлийн үнэлгээ 2.71 их наяд төгрөг болж 1.5 хувиар буурсан нь сүүлийн 7 хоногт ЗЗҮ–ний тренд доошлох хандлагатай болсон.


Зураг 1. 4. Зах зээлийн үнэлгээ, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Монголын хөрөнгийн бирж дээр ТОП–20, MSE–A, MSE–B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргаж байна. Зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компаниас бүрдэж буй ТОП–20 индексийн сүүлийн хоёр сарын хугацааны трендийг ажиглавал буурсан байдалтай байгаа бөгөөд 2019 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад 1.2 хувиар буураад байна.


Зураг 1. 5. Топ–20 индекс




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Мөн Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьд тооцон гаргаж буй MSE–A болон MSE–B индексүүдийн тренд мөн адил буурсан үзүүлэлттэй бөгөөд 2019 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулахад тус тус 0.5 болон 0.3 хувиар буурсан байна.

Зураг 1. 6. MSE-A индекс




Зураг 1. 7. MSE-B индекс



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Хэдийгээр зах зээлийн үнэлгээ өнгөрсөн хоёр сарын хугацаанд өссөн үзүүлэлттэй байгаа хэдий ч голлох индексийн үзүүлэлтүүд буурах хандлагатай байна. Гэвч үүнийг шинэ корона вирусийн нөлөөгөөр үүссэн бууралт гэж шууд тодорхойлох боломжгүй байна. ТОП-20 индексэд орсон үйл ажиллагаа нь экспорт, импортоос хамаарал өндөртэй үйлдвэрлэл болон уул уурхайн компаниудын хаалтын ханш дараах байдалтай байна.


Зураг 1. 8. Үйлдвэрлэл болон уул уурхайн компаниудын ханш




Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Хувьцааны арилжааны дүнг 2020 оны эхний хоёр сарын байдлаар харвал буурсан ч энэхүү хандлага нь 2019 оноос хойш үргэлжилсэн байгааг дараах зургаас харж болно.

Зураг 1. 9. 2020 оны 1, 2 дугаар сарын хувьцааны арилжааны дүн, арилжаа явагдсан өдрөөр, сая төгрөгөөр



Зураг 1. 10. Хувьцааны арилжааны дүн, сараар, сая төгрөгөөр



Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК

Дээрх үзүүлэлтүүдээс харахад хөрөнгийн зах зээлд 2020 оны 3 дугаар сарын дунд үе хүртэл огцом өөрчлөлт гараагүй байгаа бөгөөд Монгол Улсын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын хувьцаа нь хувьцаа эзэмшигчдийн төвлөрөл өндөртэй, хоёрдогч зах зээлд арилжаалагддаг хувьцааны хэмжээ бага, хөрөнгийн зах зээлийн хөрөнгө оруулагчдын тоо цөөн бөгөөд идэвх сул байдаг зэргээс улбаалан хөрөнгийн зах зээл нь аливаа эерэг болон сөрөг мэдээнд мэдрэг бус байна.

Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон индекс 2020 оны 3 дугаар сарын сүүл үеэс буурсан ба цаашид шинэ корона вирусийн идэвхжил өндөр хэвээр удаан үргэлжилбэл гадаад болон дотоод эдийн засгийн нөхцөл байдлаас хамааралтайгаар хувьцаат компаниудын үйл ажиллагаа, ашиг, орлого зэрэгт нөлөөлж Монгол Улсын хөрөнгийн зах зээлд сөрөг үр дагавар үзүүлэх магадлалтай байна.

Даатгалын салбарын нөхцөл байдал: Корона вирусийн тархалтын улмаас улс орон бүр тус вирустэй тэмцэх өөрсдийн бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд манай улсын хувьд хорио цээрийн арга хэмжээг аваад байгаа нь аж ахуйн нэгжүүд болон хувиараа бизнес эрхлэгчдийн бизнес тасалдах, орлого буурах зэрэг санхүүгийн хүндрэлүүд үүсэх эрсдэлийг бий болгож байна. Үүнээс шалтгаалан даатгалын 5 төрлийн бүтээгдэхүүний эрэлт буурахаар ажиглагдаж байна. Үүнд, санхүүгийн, гэнэтийн осол, эмчилгээний, ачааны, зээлийн болон итгэлцлийн даатгал зэрэг хамаарна.

Даатгалын компаниудын Санхүүгийн зохицуулах хороонд нийлүүлдэг тоон мэдээлэл нь улирлын санхүүгийн тайлан байдаг бөгөөд 2019 оны жилийн эцсийн тоон мэдээллээс корона вирусийн улмаас даатгалын салбарт гарч буй өөрчлөлтийг мэдэх боломжгүй тул улс орнуудад нүүрлээд буй вирусийн тархалт, түүний эсрэг авч буй хориг арга хэмжээтэй холбоотой даатгалын компаниудад үүсэж буй хүндрэл бэрхшээлийн талаар санал, асуулга авахад даатгалын бүтээгдэхүүний борлуулалт, хураамжийн болон нөхөн төлбөр буурч байгааг онцлон хэллээ. Даатгалын бүтээгдэхүүний борлуулалт буурахад Засгийн газраас хорио цээр тогтоосон тул иргэд даатгалын компанийг зорин ирж бүтээгдэхүүн худалдан авах нь буурсан, мөн зарим даатгалын компаниуд ажилчдаа цахимаар ажиллуулж байгаа, олон нийтэд даатгалын бүтээгдэхүүнийг таниулах ажлыг хийх боломжгүй болсон, банк болон санхүүгийн байгууллагуудын ажиллах цагийн хуваарь богиноссон нь нөлөөлсөн. Мөн хаврын улиралд сум бүрээр явж малын индексжүүлсэн даатгалд малчдыг хамруулах эсэх нь тодорхойгүй, 3 дугаар сарын авто оношилгооны үеэр жолоочийн даатгалын борлуулалт хийх боломжгүй болсон байна.

Үүнээс улбаатай даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ мөн буурсан нь ажиглагдав. Харин бизнесийн байгууллагуудын хувьд орлого буурснаас хураамжийн орлогын төлбөрийг хойшлуулах хүсэлтийг ирүүлэх болсноор хураамжийн орлогын хэмжээ буурсан байна.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАДГАЛАХ ШИЙДЭЛ

Шинэ төрлийн корона вирус өвчлөлийн тархалт, дэлхийн эдийн засгийн хүндрэлээс үүдэн манай улсын эдийн засаг, банк санхүүгийн салбарт хүндрэл үүсэхэд банкнаас бусад санхүүгийн зах зээлд хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг дараах байдлаар боловсрууллаа.

Гэрээний давагдашгүй хүчин зүйл гэсэн нөхцөлийн дагуу зээлийн эргэн төлөлтийн асуудлыг шийдвэрлэх

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6–д “давагдашгүй хүчин зүйлийг гэрчлэх” гэж заасны дагуу давагдашгүй хүчин зүйлийг Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас гэрчилж баталгаа өгөх хуулийн зохицуулалттай байна. Дээрх хуулийн зохицуулалтын дагуу Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимаас баталсан “Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл² болон хүнд нөхцөл байдлын³ баталгаа гаргах журам”–д гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл болон хүнд нөхцөл байдал гэдэгт юуг ойлгох болон хэрхэн баталгаа гаргахтай холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй дараах саад тотгор тохиолдсоны улмаас талууд гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйд хүрэхийг ойлгоно. Үүнд:

- Зарласан болон зарлаагүй дайн, зэвсэгт мөргөлдөөн, бослого, гадаадын түрэмгийлэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаа, хувьсгал;
- Байгалийн бүх төрлийн гамшиг /хүчтэй салхи шуурга, хар салхи, газар хөдлөлт, хүчтэй давлагаа, үер, цас зуд, аянга цахилгаан, гал түймэр гэх мэт/;
- Тэсрэлт, дэлбэрэлт, машин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн эвдрэл, цахилгааны ноцтой гэмтэл;
- Бүх төрлийн хязгаар хориг, хариуцлагаас чөлөөлөгдөх хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт, ажил хаялт гэх мэт;
- Төрийн албан тушаалтны хуулийн дагуух болон хууль бус үйлдэл, эс үйлдэл, эрх зүйн акт, тушаал, захирамж, ажлын байр татан буугдах, эд хөрөнгө дайчлан хураах, нийгэмчлэх гэж тус тус гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлыг тодорхойлсон байна.

Гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлыг тодорхойлсон журмын 1.2.4–т заасан “бүх төрлийн хязгаар хориг, хариуцлагаас хүсэлтэй талын аж ахуйн нэгжид тохиолдсон ажил зогсолт ажил хаялт” гэж заасан тохиолдолд БНХАУ болон бусад улс оронд гарсан корона вирусийн улмаас Монгол Улсын Засгийн газраас БНХАУ–тай хиллэдэг бүх хилийн боомтыг хаах шийдвэр гаргасан. Уг шийдвэртэй холбоотойгоор БНХАУ–аас бараа, таваараа импортолдог эсхүл БНХАУ–д бараа, таваар экспортолдог иргэн, хуулийн этгээд мөн БНХАУ–аас жижиглэнгийн болон бөөний импортын худалдаа эрхэлдэг этгээдүүдийн хувьд тус бизнес хориг хязгаарт орсон учир гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж үзэх үндэслэлтэй. Мөн Монгол Улсын хувьд Иргэний хуулийн 101.7, 220, 221, 255.1, 319.2, 321.3, 352.5.3, 356, 374.3, 384.2, 393.7, 419.2, 427.2, 799.2, 500.2 дугаар зүйлүүдэд гэнэтийн болон

2 Force Majeure

3 Hardship

давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас үүсэх хариуцлага, үр дагаврын талаар зохицуулдаг.

Корона вирусийн тархалттай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас олон нийтийн арга хэмжээ явуулахыг болон зарим төрлийн үйл ажиллагааг шөнийн 22:00 цагаас хойш ажиллахыг хориглосон шийдвэрийг гаргасан бөгөөд үүнийг дээрх бизнесийг эрхэлдэг иргэн, хуулийн этгээдийн хувьд ч гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэж үзэх нөхцөлтэй.

Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болж, түүнийг нотолсноор тухайн тал гэрээний үүргээ биелүүлээгүй хариуцлагаас чөлөөлөгдөнө гэсэн үг биш. Учир нь давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол гэрээний үүргийг бүхэлд нь дуусгавар болгох нөхцөлгүй. Баталгаа гаргуулснаар зөвхөн давагдашгүй хүчин зүйл бий болсноос дуусах хүртэл, дууссаны дараа үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай тогтоосон хугацаа өнгөртөл үүргийн гүйцэтгэл түр хойшлогдож болохоор байна.

Төрийн эрх бүхий байгууллагаас корона вирусийн халдвараас сэргийлж улс орон даяар хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хороо хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6–д “тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх” гэж заасны дагуу Хорооны зохицуулалттай этгээд үйлчлүүлэгч хооронд байгуулсан гэрээндээ талууд нь давагдашгүй хүчин зүйлийн хүрээ, түүний үр дагавар зэргийн талаар тусгасан тохиолдолд урьдчилан шийдвэрлэх боломжтой.

2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1–т “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн” гэж заасны дагуу СЗХ–ноос цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан гэнэтийн буюу давагдашгүй нөхцөл байдал бий болсонтой холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжүүдэд гэрээ байгуулах тохиолдолд нөхцөл байдалтай уялдуулан гэнэтийн буюу давагдашгүй нөхцөл байдлыг тодорхойлох, одоо мөрдөж байгаа гэрээгээ шинэчлэх зэрэг нийгмийн хариуцлагаа ухамсарлахыг уриалах боломжтой.

Актив ангиллын журамд өөрчлөлт оруулах, ББСБ, ХЗХ–дыг зээлийн үйлчилгээтэй холбоотой шимтгэл, хураамжаа бууруулахыг уриалах

Корона вирусийн тархалт, хөл хориог даган бизнесийн байгууллагуудын үйл ажиллагаа тасалдах, өрх, аж ахуйн нэгжийн орлого буурах, түүнийг даган банк, санхүүгийн байгууллагуудаас авсан зээлээ хугацаанд нь төлж чадахгүйд хүрэх, салбарын чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэн, зээлийн эрсдэлийн сангийн зардал өсөх зэрэг эрсдэлүүд хүлээгдэж байна. ББСБ, ХЗХ–д нь СЗХ–ноос баталсан активыг ангилах журмыг мөрдөн олгосон зээлийг чанараар нь ангилан бүртгэдэг. Тус журамд өөрчлөлт оруулан зээлийн эргэн төлөлт хугацаандаа хийгдээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн зээл, чанаргүй зээлд тооцох хугацааг сунгаснаар иргэд, аж ахуйн нэгжийн хувьд төлбөрийн дарамтыг түр хугацаагаар хойшлуулах, эрсдэлтэй зээлдэгч болон зээлийн мэдээллийн санд бүртгэгдэх, санхүүгийн байгууллагуудын зээлийн эрсдэлийн сангийн зардал өсөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой юм.

Түүнчлэн ББСБ, ХЗХ–д нь үйлчлүүлэгчидтэй зээлийн гэрээ байгуулан үйлчилгээний үнэ болох хүү, шимтгэлийн түвшнийг тогтоодог бөгөөд СЗХ–ны зүгээс уг харилцаанд хөндлөнгөөс оролцох боломжгүй юм. Гэсэн хэдий ч аж ахуйн нэгж, иргэдийн орлого буурах өндөр эрсдэл үүссэн энэ цаг үед санхүүгийн байгууллагуудын нийгмийн хариуцлагаа ухамсарлан үйлчилгээний шимтгэл, хураамж, хүүгийн алдангийг бууруулахыг уриалах боломжтой.

Зохицуулалтын байгууллагын зүгээс авах татвар, шимтгэлийг бууруулах, ББСБ–уудын хувь нийлүүлсэн хөрөнгө (ХНХ)–ийг нэмэгдүүлэх шаардлагыг түр хугацаагаар хойшлуулах

Хууль эрх зүйн орчны хүрээнд санхүүгийн байгууллагууд зохицуулагч болон Засгийн газрын харьяа байгууллагуудад дараах зардлуудыг төлдөг. Үүнд:

- Хувь хүний орлогын албан татвар – Татварын ерөнхий газар;
- Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл – Нийгмийн даатгалын ерөнхий газар;
- Зохицуулалтын үйлчилгээний хураамж – Санхүүгийн зохицуулах хороо;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар – Татварын ерөнхий газар;

Байгууллагын төлөх хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ)–ын зардал ББСБ–ын хувьд нийт зардлын 4.1 хувийг, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл нийт зардлын 2.5 хувийг тус тус эзэлж байна. Байгууллагын ажилчидтай холбоотой төсөвт төвлөрүүлэх татварын зардал нь нийт зардлын 6.6 хувийг эзэлж байна.

Мөчлөгийн ажилгүйдлийг бий болгохгүйн тулд байгууллагын ажиллагсадтай холбоотой төсөвт төвлөрүүлэх татварын зардлыг хойшлуулан, хэмнэсэн зардлыг бусад зардалд зарцуулах боломжийг олгож өгснөөр байгууллагад ажлын байрны цомхтгол хийж, ажилгүйдлийг нэмэгдүүлэхээс сэргийлэх хөшүүргийг өгөх боломжтой юм.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.5–д заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Хороо нь 2019 оны 211 дүгээр тогтоолоор “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”–ыг шинэчлэн баталсан. Журмын дагуу зохицуулалт үйлчилгээний хөлсийг хувь тооцож төвлөрүүлэх, тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх, тухай бүр тогтоосон хэмжээгээр төвлөрүүлэх гэсэн гурван хэлбэрт ангилдаг. Үүнээс жил бүр төвлөрүүлэх хөлсийг 4 дүгээр сарын 01–ний өдрийн дотор зохицуулалттай этгээдүүд төлөх үүрэгтэй. Иймээс СЗХ давагдашгүй хүчин зүйл тохиолдож болохоор байгаа өнөө үед зохицуулалттай этгээдүүдийг төлбөрийн дарамтаас хөнгөлж, уг хөлсийг төлөх хугацааг эдийн засгийн нөхцөл байдал хэвийн байдалд орох хүртэл хойшлуулах шийдвэрийг хуралдаанаараа гаргаж болно. Түүнчлэн ББСБ–уудад тавигдсан хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх хугацааг түр хугацаагаар хойшлуулах боломжтой.

Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед ашиглах бэлэн байдлын стратеги төлөвлөгөө боловсруулах, нөөц сан байгуулах

Улс орнуудын туршлагаас харахад халдварт өвчин гарсан үед санхүүгийн байгууллагууд бизнесийн тогтвортой, тасралтгүй үйл ажиллагааг хангах төлөвлөгөөг урьдчилан боловсруулсан байдаг. Үүнээс гадна, АНУ–ын туршлагаас харахад Холбооны нөөцийн банк халдварт өвчний үед санхүүгийн байгууллагууд тогтвортой үйл ажиллагаа явуулах бэлэн байдлыг томоохон 15 банкны хүрээнд үнэлэн гаргасан байна. Мөн үндэсний хэмжээнд болон бизнесийн байгууллагууд эдийн засгийн огцом

савлагааны үеэр ашиглах эрсдэлийн санг байгуулах шаардлагатай байдаг.

2008 оны дэлхийн эдийн засаг хямарснаас хойш Базелийн хорооноос “Базел аккорд III” –ийг шинэчлэн гаргасан. Хямрал нүүрлэх үед улс орнуудын Засгийн газар татвар төлөгчдийн мөнгөөр хохирлыг барагдуулдаг нь эдийн засагт ихээхэн алдагдлыг учруулдаг тул шинэчлэн гаргасан стандартад санхүүгийн зах зээл дэх байгууллагуудыг урьдчилан байгуулсан сангуудаар өөрсдийнхөө хохирлыг нөхөн төлдөг байхаар шийдвэрлэсэн.

Иймээс Базелийн хорооноос хямралын үед хохирлыг даван туулах 5 төрлийн санг 2019 он гэхэд байгуулахыг зөвлөсөн. Үүнд:

- Мөчлөг сөрсөн хөрөнгийн нөөцийг⁴ системийн эрсдэл тохиолдох үед нийт зээлийн өсөлтийн эрсдэлийг тогтворжуулах зорилгоор;
- Системийн эрсдэлийн нөөц⁵;
- Хөрөнгө хамгаалах нөөцийг⁶ хөрөнгийн нэмэлт давхарга бий болгохоор нийт эрсдэлээр жигнэсэн хөрөнгийн 2.5 хувиар;
- Системийн ач холбогдолтой байгууллагуудын нөөцийг⁷ бүрдүүлэх зэрэг болно.

Иймд хямрал тохиолдох үед бэлэн байхын тулд санхүүгийн байгууллагууд урьдчилан сан байгуулж өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах нь чухал болоод байна.

Манай улсад нүүрлэж болох хямралын сөрөг нөлөөг хамгийн бага түвшинд хадгалахад богино хугацаанд авч хэрэгжүүлэх шийдэл, цаашид улс, ААН-үүдийн түвшинд хямралд бэлэн байж, тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангах үүднээс дунд, урт хугацаанд хямралыг даван туулах стратеги боловсруулж, сан байгуулах нэгдсэн санал, мөн иргэд, ААН-үүдэд хүргэх зөвлөмжийг гаргалаа.

Хүснэгт 1. 5. Корона вирусийн цар тахал, эдийн засгийн хүндрэлийн нөлөөг бууруулах шийдэл

Хугацаа	Шийдэл
Богино	<ul style="list-style-type: none"> • Зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэх хугацааг сунгах; • “Активыг ангилах, активын эрсдэлийн санг байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангилалд түр хугацаанд өөрчлөлт оруулах; • Зээлийн хүүг боломжит түвшин хүртэл нь бууруулахыг уриалах;
Дунд	<ul style="list-style-type: none"> • Санхүүгийн байгууллагууд өвчин гарсан тохиолдолд баримталж ажиллах ёс зүйн дүрмийг боловсруулахыг шаардах, тэдгээрийг хянах; • Иргэдийг урт хугацааны хуримтлалтай болохыг уриалах;
Урт	<ul style="list-style-type: none"> • Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бэлэн байдлын стратегийг боловсруулах; • Хямралыг даван туулах нөөц сан байгуулах; • Нэгдсэн хяналт шалгалтын системийг нэвтрүүлэх; • Санхүүгийн байгууллагууд халдварт өвчний үед бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулж чадах бэлэн байдал хангагдсан эсэх эрсдэлийг үнэлэх;

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

4 countercyclical capital buffer
 5 systemic risk buffer
 6 capital conservation buffer
 7 systemically important institutions buffer

Хүснэгт 1. 6. Иргэд, аж ахуйн нэгжүүдэд хүргэх зөвлөмж

Зорилтот бүлэг	Зөвлөмж
ААН	<ul style="list-style-type: none"> • Зээл авахад тавигддаг шаардлага стандартуудыг хамгийн доод түвшинд байлгахыг уриалах; • Зээлийн хүүг бууруулах, зээл эргэн төлөлтийн хугацааг сунгахыг уриалах; • Зээлийн хүүгийн хэмжээг бууруулсан ч давагдашгүй хүчин зүйлийн улмаас зээлийн эргэн төлөлт, хүү хугацаандаа төлөгдөхгүй болсон үед гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож, хугацааг хойшлуулахыг уриалах; • Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоодод зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг танахыг уриалах; • Халдварт өвчний үеэр алсаас ажиллах боломж, ажилласнаар гарах эрсдэлийг тооцоолохыг уриалах;
Төр	<ul style="list-style-type: none"> • Зохицуулалтын байгууллагууд хямралын үед нягт, харилцан уялдаатай хамтран ажиллах; • Эрх баригчид санхүүгийн болон санхүүгийн бус байгууллагуудад чиглэсэн зах зээлийн талаар авч байгаа арга хэмжээний талаар олон нийтийг мэдээллээр хангах; • Олон улсын зохицуулагч байгууллагууд болон зах зээлийн оролцогчидтой хамтран ажиллах; • Зах зээлд оролцогчдоос үйл ажиллагааны тасалдлын хэмжээ болон бусад оролцогчдоос нөлөөлж болзошгүй бизнесийн тасралтгүй арга хэмжээний талаар мэдээлэл авах;
Иргэд	<ul style="list-style-type: none"> • Ташаа мэдээлэлд автахгүй байх, зөвхөн найдвартай эх сурвалжийн мэдээлэлд итгэж, судалгаа шинжилгээтэй хандах талаар зөвлөмж өгөх. Дараах эх сурвалжуудаас найдвартай, үнэн зөв мэдээллийг авах боломжтой: www.frc.mn; www.mongolbank.mn; www.mof.gov.mn; www.dicom.mn; Хувийн санхүүгээ удирдах, 6–7 сарын хувийн санхүүгээ төсөвлөх, www.sankhuugiiinbolovsrol.mn цахим хуудаснаас мэдээлэл авах; Амьдралын даатгал, эрүүл мэндийн даатгалд даатгуулахыг уриалах.

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

2020 оны эхээр тархсан шинэ төрлийн корона вирус, түүний халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орнуудын хэрэгжүүлж буй хорио цээрийн бодлого нь дэлхийн эдийн засагт нийлүүлэлт болон эрэлт талын шокийг үүсгэн олон улсын санхүүгийн зах зээлийн үзүүлэлтүүд огцом уналтад өртөөд байна. Халдварт өвчнөөс үүдэлтэй энэ удаагийн хямралыг 2009 оны санхүүгийн хямралаас ч илүү гүнзгий байж болзошгүй гэж эдийн засагч, судлаачид таамаглаж байна.

Халдварт өвчний тархалт, хөл хорионоос шалтгаалан манай улсын санхүүгийн салбарт үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хямралын эсрэг улс орнуудын хэрэгжүүлж буй арга хэмжээнээс суралцах, хүлээгдэж буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодлогын саналыг боловсруулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэлээ. Халдварт өвчин тархаад нэг сар гаруй хугацаа өнгөрч, олон улсын санхүүгийн зах зээлүүдэд сөрөг нөлөө гарч эхэлсэн хэдий ч манай улсын санхүүгийн зах зээлийн хувьд вирусийн тархалтаас шалтгаалсан бууралт ажиглагдахгүй байна. Үүнд зах зээлийн суурь хүчин зүйлс болон цаг хугацааны хоцрогдол мөн нөлөөлж байж болох юм.

Судалгааны үр дүнд Санхүүгийн зохицуулах хорооноос шууд хэрэгжүүлж болох дараах арга хэмжээний саналыг боловсрууллаа. Үүнд:

- o Банк бус санхүүгийн байгууллагуудыг зээлийн хүүгээ одоогийн хүүгийн орлогоос зээлийн хүүгийн зардал, зайлшгүй гарах зардал болон алдагдсан боломжийн зардал, зээлийн эрсдэлийн зардлыг хассан зөрүүгээр зээлийн хүүгийн шимтгэлийг бууруулахыг мэргэжлийн холбоодтой хамтран уриалах;
- o Зээлийн хүүгийн хэмжээг бууруулсан ч давагдашгүй хүчин зүйлийн улмаас зээлийн эргэн төлөлт, хүү хугацаандаа төлөгдөхгүй болсон үед гэрээ байгуулагч талууд харилцан тохиролцож, хугацааг хойшлуулах;
- o “Активыг ангилах, активын эрсдэлийн санг байгуулж, зарцуулах журам”-ын зээлийн ангилалд түр хугацаанд өөрчлөлт оруулах;
- o Банк бус санхүүгийн байгууллага болон хадгаламж, зээлийн хоршоодод зайлшгүй гарах зардлаас бусад зардлыг танахыг уриалах;
- o Зохицуулалтын байгууллагуудаас “жил бүр төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлс”-ийг төлөх хугацааг хойшлуулах;
- o Хадгаламж зээлийн хоршоодыг бүх гишүүдийнхээ хурлаараа зээл болон хадгаламжийн хүүгийн хувьдаа өөрчлөлт оруулахыг уриалах;
- o Хорооноос ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэрийг хойшлуулах;
- o Үнэт цаас гаргаж буй компани үнэт цаасаа олон нийтэд сурталчлах ажиллагааг олон хүн цуглуулахгүйгээр цахим байдлаар хийж, үнэт цаасны танилцуулгаа танилцуулах чиглэлд технологийн шийдлийг ашиглах талаар андреррайтерд зөвлөх, шаардлагатай гэж үзвэл гадаадын хөрөнгө оруулагчид үнэт цаасны дансаа цахимаар нээх, номинал дансаар дамжуулан харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг хийх нөхцөлийг бүрдүүлэх чиглэлд анхаарал хандуулан ажиллах;
- o Хувьцаа эзэмшигчид ногдол ашгаа авахдаа брокерын компанидаа мөнгө хүсэх өргөдлөө өөрийн биеэр очин гаргаж дансаа баталгаажуулж байгааг, харин үнэт цаасны дансгүй иргэд дансаа мөн

адил брокерын компани дээр очих байдлаар нээлгэж байгааг хялбарчлах, цаг хугацаа хэмнэсэн, чирэгдэл учруулахгүйгээр зохион байгуулах талаар “ҮЦТХТ” ХХК, МҮЦАЭХ болон бусад үнэт цаасны компаниудтай хамтран ажиллах;

- o Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэлбэрээр хуралдуулах, ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах чиглэлийг барьж ажиллахыг хувьцаат компаниудад зөвлөх, ингэхдээ цахимаар хурал хийхэд санал хураах, санал тоолох ажиллагаанд элдэв сонирхлын зөрчил үүсэх, хууль бус үйлдэл гаргахгүй байх асуудлаар тодорхой чиглэлүүдийг зөвлөмжид тусгах;
- o Үнэт цаасны дараа төлбөр тооцооны Т+2 горим, төлбөрийн эсрэг нийлүүлэлт зарчим нэвтрүүлэх төлөвлөгөөний дагуу олон нийтийг хамарсан ажлуудыг хийж гүйцэтгэхдээ нэг дор бүх үнэт цаасны компаниудын төлөөллийг цуглуулахаас татгалзаж харин хэсэгчилсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг дэд бүтцийн байгууллагууд болон МҮЦАЭХ–нд чиглэл болгох, төлөвлөгөөний гүйцэтгэлд байнгын хяналт тавьж ажиллах;
- o Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлс тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, бэлэн байдлын стратегийг боловсруулах, хямралыг даван туулах сан байгуулах.

ЗУРГАА. ХАВСРАЛТ

Санхүүгийн зохицуулах хорооноос зохицуулалтын байгууллагуудад хүргэх зөвлөмж

Шинэ төрлийн корона вирус (Ковид-19)-ийн халдвар эрчимтэй тархаад буй энэхүү үед Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын байгууллагууд та бүхэн халдварт өвчний эрсдэлээс албан хаагчдаа хамгаалан, халдварт өвчин, хорио цээрийн улмаас зах зээлд үүсээд буй хүндрэлийг даван гарах нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулан чанд мөрдөж ажиллахыг зөвлөн “Харвардын бизнесийн тойм”, АНУ-ын “Халдварт өвчлөлийг хянах, урьдчилан сэргийлэх төв”-өөс гаргасан халдварт өвчлөлийн үед бизнес, санхүүгийн байгууллагууд үйл ажиллагаандаа дагаж мөрдөх зөвлөмжийг та бүхэнд хүргүүлж байна.

Бизнесийн үйл ажиллагааг нарийн төлөвлөх

- ✓ Бэлэн байдлын болон хариу арга хэмжээ авах төлөвлөгөөг боловсруулан түүнийг хариуцан хэрэгжүүлэх ажилтныг бэлтгэж, томилох, төлөвлөгөөг турших, тогтмол сайжруулан, мөрдөж ажиллах, түүнчлэн ажиллагсдын цалин, хангамжийг тасалдуулахгүй байх;
- ✓ Хэрэглэгчид, үйлчлүүлэгчдэд үзүүлэх үйлчилгээг тасралтгүй байлгах үүднээс бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хүргэх суваг тус бүрээр эрэлтийг таамаглан, байгууллагын санхүүгийн төлөвлөгөөг шинэчлэн мөрдөж ажиллах;
- ✓ Онцгой нөхцөл байдлаас шалтгаалан эрсдэлд орох хамгийн өндөр магадлалтай бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагааг тодорхойлон тэдгээрийн эмзэг байдлыг үнэлэн учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хамгийн бага зардлаар даван гарах төлөвлөгөөг боловсруулж мөрдөж ажиллах, мөн халдварт өвчин тархан, хорио цээрийн дэглэмд шилжсэнээс шалтгаалан бизнесийн үйл ажиллагаа нь доголдон, орлогын эх үүсвэр нь тасалдаж буй үйлчлүүлэгчдийг тодорхойлон тэдэнд хүргэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний бодлогодоо анхаарал хандуулах;
- ✓ Өвчлөлийн тархалт, цар хүрээ, түүний нийгэм, эдийн засагт учруулж буй хохирол, төрийн эрх бүхий байгууллагуудаас гаргаж буй шийдвэрийн талаарх мэдээллийг албан ёсны эх сурвалжаас цаг алдалгүй, тогтмол авч бизнесийн үйл ажиллагаагаа төлөвлөх;
- ✓ Яаралтай, шуурхай нөхцөл байдал үүссэн үед холбоо тогтоох дэд бүтцийг бүрдүүлэн, шаардлагатай холбоо барих мэдээллийг бүртгэлжүүлэн, тогтмол шинэчлэн ажиллах;

Үйлчлүүлэгчид болон ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах

- ✓ Олноор цуглах арга хэмжээ, аливаа хурал, зөвлөгөөн, үйл ажиллагааг хойшлуулах, теле хурал зохион байгуулах, ажиллагсдыг зайнаас ажиллуулах бодлогыг баримтлах, ажлын цагаа уян хатан болгох, шаардлагатай тохиолдолд боломжит хэлбэрээр цалин, мөнгөн тэтгэмжээр туслалцаа үзүүлэх;
- ✓ Харилцагчид, хөрөнгө оруулагчид, үйлчлүүлэгчидтэй интернет, гар утас ашиглан зайнаас холбогдож ажиллах боломжийг бүрдүүлэх, зайнаас харилцаж буй тохиолдолд үйл ажиллагааны мэдээллийн урсгалыг сайжруулах, харилцагчдад тогтмол мэдээлэл хүргүүлэх;
- ✓ Ажиллагсдыг хүн олноор цугласан, эрсдэл өндөртэй бүс нутгаар аль болох зорчуулахгүй байх, нийтийн тээвэр ашигладаг ажиллагсдадаа байгууллагын тээврийн хэрэгслээр үйлчлэх, эрсдэл өндөртэй бүс нутгаас ирсэн ажиллагсдад түр чөлөө олгон тусгаарлах;

- ✓ Ажиллагсдын дунд өвчний шинж тэмдэг илэрсэн, ажлын байран дээр эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн үед шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах;
- ✓ Ажлын байрны эрүүл орчныг чанд сахин, ажиллагсдыг шаардлагатай ариутгагч бодис, амны хаалт, үнэн зөв мэдээллээр тогтмол хангах, эрүүл мэндийн болон бусад заавар, зөвлөмжийг цаг тухайд нь хүргүүлэх, тэдгээрийн сэтгэл зүйн эрүүл мэндэд анхаарал хандуулах, хяналт тавих;
- ✓ Ажиллагсад, үйлчлүүлэгчид, харилцагчдын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, тэдгээрт шаардлагатай эх үүсвэрийг тасалдуулахгүй байх тал дээр анхаарал хандуулах;
- ✓ Бэлэн мөнгөний гүйлгээ, бэлэн мөнгөөр хийгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээнээс татгалзах;

Нийгмийн хариуцлагаа ухамсарлан олон нийтийн сайн сайхан байдалд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

- ✓ Өөрийн байгууллагад хэрэгжүүлж буй арга хэмжээ, сайн туршлагын талаар бусадтай хуваалцах, олон нийтэд мэдээлэх, уриалах;
- ✓ Төрийн эрх бүхий байгууллагууд, шийдвэр гаргах түвшний байгууллагуудтай нягт хамтран ажиллах, тэдгээрийн шаардсан мэдээ, мэдээллийг шуурхай, үнэн зөв гарган өгөх, хүндрэлийг даван гарахад бүх талуудын оролцоо чухал гэдгийг ухамсарлан, нийгмийн хариуцлагатайгаар хүчин чармайлт гарган ажиллах;
- ✓ Өвчлөлийн эрсдэл, түүнээс үүдэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр өндөр хүчин чармайлт гарган ажиллаж буй байгууллагууд, албан хаагчдад туслалцаа үзүүлэх, нийгмийн хариуцлагын хүрээнд санхүүгийн болон бусад хэлбэрийн тусламжийг үзүүлэх, тэдгээрт шаардлагатай үйлчилгээг цаг алдалгүй, шуурхай хүргэх.

ДОЛОО. ЭХ СУРВАЛЖ

Bank of England, FSA, HM Treasury, Market wide pandemic exercise 2006 progress report, May 2008

Bank of England, FSA, HM Treasury, Overview of financial sector pandemic flu planning

Chad Bray and Enoch Yiu, Hong Kong banks to offer relief on mortgages, credit cards, corporate loans as coronavirus outbreak weighs on economy [мэдээ]. (2020.02.06) <https://www.scmp.com/business/banking-finance/article/3049396/hong-kong-banks-offer-relief-mortgages-credit-cards>

Chinese regions unveil credit support for virus-hit firms [мэдээ]. (2020.01.31) <https://www.aljazeera.com/ajimpact/chinese-regions-unveil-credit-support-virus-hit-firms-200131152444861.html>

Hong Kong offers cash handouts to ease coronavirus impact [мэдээ]. <https://www.ft.com/content/e170894c-5866-11ea-a528-dd0f971febbc>

Liu, HaiYue, et al. "The COVID-19 outbreak and affected countries stock markets response." International Journal of Environmental Research and Public Health 17.8 (2020): 2800.

Travel Insurance Coverage & Coronavirus Trip Cancellations Explained [мэдээ]. (2020.02.28) <https://www.schengenvisa.info.com/news/travel-insurance-coverage-coronavirus-trip-cancellations-explained/>

Vietnam needs stimulus package to alleviate coronavirus impact, ministry says [мэдээ]. (2020.02.12) <https://www.reuters.com/article/us-china-health-vietnam/vietnam-needs-stimulus-package-to-alleviate-coronavirus-impact-ministry-says-idUSKBN2061DX>

World bank, Global economic prospects (June 2020) <https://www.worldbank.org/en/publication/global-economic-prospects>

Zoey Zhang, As Coronavirus Hampers Business Activity, China Seeks to Ease Financial Pressure [мэдээ]. (2020.02.05) <https://www.china-briefing.com/news/china-ease-financial-pressure-businesses-coronavirus-outbreak/>

Иргэний хууль

Монголын хөрөнгийн бирж www.mse.mn

Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль





САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХЯНАЛТ, ЗОХИЦУУЛАЛТЫН ТОГТОЛЦОО

2020 он

Гүйцэтгэсэн: Б.Батчимэг¹, Б.Батболд², Н.Нарантуяа³,
А.Бадамсүрэн⁴, Б.Тэргэл⁵

¹ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn
² Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн, batbold_b@frc.mn
³ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, narantuya@frc.mn
⁴ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, badamsuren@frc.mn
⁵ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн, tergel@frc.mn

ХУРААНГУЙ

1990–ээд оны эхээр хөгжсөн зах зээлтэй Улсуудад санхүүгийн нэгдлийг зохицуулах, зохицуулалтын арга хэрэгслээ өөрчлөх болсон. Монгол Улсын хувьд 2011 оноос хойш санхүүгийн нэгдлүүд бий болж, зохицуулалтын сул орон зай үүссэн, санхүүгийн нэгдлийг хянах нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх асуудал тулгарсан. Иймээс өнөөдрийн зохицуулалтын арга хэрэгслийг тодорхойлж, цаашид оновчтой тогтолцоо руу шилжих хэрэгцээ үүссэнийг энэхүү судалгааны ажлаараа тодорхойлохыг зорьсон.

Улс орнуудын санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоог нийтлэг байдлаар 4 төрөлд хуваадаг бөгөөд үүнд салбар бүрийг бие даасан байгууллагууд зохицуулдаг уламжлалт хэлбэр болох функционал болон институционал хэлбэр, мөн санхүүгийн бүхий л салбарыг нэгтгэн зохицуулж, хянадаг нэгдсэн болон хосолмол гэсэн хэлбэрүүд хамаарч байна. Санхүүгийн зах зээл, бизнесийн орчны хурдтай өөрчлөлтийн нөлөөгөөр санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа өөр хоорондоо өндөр хамааралтай болж, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн байгууллагууд, цаашлаад санхүүгийн салбарыг зааглан зохицуулах улам бүр төвөгтэй болж байгаа тул улс орнууд зохицуулалт, хяналтын тогтолцоогоо уламжлалт хэлбэрээс нэгдсэн хэлбэр рүү шилжүүлэх хандлага ажиглагдаж байна. Эдийн засаг, санхүүгийн зах зээл нь харьцангуй жижиг, банкны салбар давамгайлсан бүтэцтэй, санхүүгийн нэгдэл компаниудын зах зээлд эзлэх хувь хэмжээ өндөр буюу төвлөрөл ихтэй улсуудын хувьд нэгдсэн зохицуулалтын хэлбэрийг түлхүү сонгож байна.

Мөн банк, санхүүгийн байгууллага улам бүр өргөжин тэдгээрийг хянаж, зохицуулахад хүндрэл үүссэн, санхүүгийн нэгдэл компаниуд олноор байгуулагдаж системийн эрсдэл нэмэгдсэн зэрэг голлох шалтгаануудын улмаас нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоонд шилжих хандлага сүүлийн 30 орчим жилийн хугацаанд ажиглагдаж байна. Нэгдсэн зохицуулалтын тогтолцоонд шилжсэн улс орнуудын хувьд мөнгөний бодлогын бие даасан байдлыг хамгаалах үүднээс санхүүгийн салбарын зохицуулалтын үүргийг төв банканд бус тусдаа бие даасан байгууллагад хуваарилсан жишээ олон байгаа юм. Мөн санхүүгийн салбарын бодлогыг хэрэгжүүлэх, тогтвортой байдлыг хангахад дан ганц санхүүгийн зохицуулагч байгууллагаас гадна төв банкны үүрэг оролцоо өндөр болохыг судлаачид, бодлого гаргагчид онцолж байна.

Түлхүүр үгс: санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын хэлбэр, зохистой бодлого, зохистой хяналт, банк, хөрөнгө, даатгалын зах зээл, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, бизнесийн үйл ажиллагааны хяналт;

JEL ангилал: G18, N20, O2

НЭГ. УДИРТГАЛ

Дэлхийн санхүүгийн зах зээлд томоохон хэмжээний өөрчлөлт, шинэчлэлтүүд явагдан банк, даатгал, хөрөнгийн зах зээлд оролцогч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа өөр хоорондоо өндөр хамааралтай болохоос гадна хил хязгаар, эдийн засгийн секторын хувьд ч тэлэн санхүүгийн нэгдэл, групп компаниуд олноор бий болж байна. Түүнчлэн санхүүгийн зах зээлд гарч буй инновац, технологийн дэвшлийн нөлөөгөөр олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч эхэлснээр тус салбар дахь бизнесийн үйл ажиллагаа ихээхэн нарийн бас төвөгтэй болж эхэлсэн. Өөрөөр хэлбэл арилжааны банкууд зөвхөн хадгаламж татаж зээл олгодог, хөрөнгийн зах зээлийн оролцогч компаниуд цөөн тооны хувьцаат компаниудтай зах зээлд брокер, дилерийн үйлчилгээ үзүүлдэг, даатгалын компаниуд хөрөнгийн эсхүл амь насны даатгал зэрэг цөөн тооны бүтээгдэхүүн нийлүүлдэг байсан үе ард хоцорчээ.

Зах зээлийн энэхүү чиг хандлагыг даган бодлого гаргагчдын хувьд мөн хяналт, зохицуулалтын тогтолцоогоо өөрчлөх, шинээр гарч буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, санхүүгийн нэгдэл компаниудын үйл ажиллагааг үр ашигтайгаар хянан, зохицуулах хэрэгцээ, шаардлага үүсэж байгаа юм. Маш олон санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, даатгал, хөрөнгийн зах зээл, банкны зах зээлийн үйлчилгээний шинжийг агуулан, олон санхүүгийн байгууллагууд эдгээр зах зээл дээр нэгэн зэрэг үйл ажиллагаа явуулж буй хэдий ч тус тусдаа зохицуулалтын дор өөр өөр бизнес загвараар үйл ажиллагаа явуулах тохиолдлууд ихсэж байна. Энэ нь бизнес эрхлэгчдэд зохицуулалтын давхардал, тодорхой бус байдал, хүнд суртал үүсгэж байгаа бол зах зээл, салбарын хэмжээнд зохицуулалтын сул орон зайг бий болгон системийн хэмжээний эрсдэл, бүтцийн үр ашиггүй байдал нэмэгдэх зэрэг эрсдэлийг үүсгэж байгаа юм.

Тийм ч учраас санхүүгийн зохицуулагч байгууллагууд бизнесийн шинэ төрлийн үйлчилгээ, зах зээлийн шинэ хэв шинжид тохируулан зохицуулалт, хяналтын арга хэлбэртээ шинэчлэлт оруулах, мөн хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог сайжруулах, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөн мөрдөгддөг стандартуудыг хэрэгжүүлж эхлэх шаардлагатай бөгөөд салбарын үйл ажиллагаа зохицуулалтын шаардлагаас үүдэн нэгээс нөгөөд шилжин салбарын тогтвортой байдалд аюул учруулах өндөр эрсдэлтэй тул зах зээлийг бүхэлд нь хамарсан өөрчлөлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэх хэрэгцээ үүсэж байна.

Энэхүү судалгааны ажил нь санхүүгийн зах зээлийн хурдтай өөрчлөлтийг даган бусад улс орнуудын санхүүгийн зохицуулалтын арга хэлбэр хаашаа шилжиж байгаа, түүний орчин үеийн чиг хандлага ямар байгааг болон манай улсын санхүүгийн зах зээлд тохирох зохицуулалтын хэлбэр болон санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчинд үүсээд буй нэгдсэн хяналт, зохицуулалтын хэрэгцээ, шаардлага түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэрийг судлах зорилготой юм. Мөн Монгол Улсын санхүүгийн зах зээлийн зохицуулалтын өнөөгийн хэлбэр, үүсээд буй асуудлууд болон нэгдсэн хяналт, зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг дараагийн бүлгүүдэд дурдах бол олон улсад мөрдөгддөг нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоо, амжилттай туршлагауд, санал дүгнэлтээр энэхүү судалгааны ажил нь бүрдэнэ.

ХОЁР. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ДӨРВӨН ХЭЛБЭР

Одоогоор улс орнуудад ашиглагдаж буй санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэр нь дараах 4 үндсэн ангилалд хуваагдаж байна. Үүнд: (1) Институционал хэлбэр, (2) Функционал хэлбэр, (3) Нэгдсэн хэлбэр, (4) Хосолмол хэлбэр. Цэвэр нэг төрлийн хэлбэрээр зохицуулагдаж буй жишээ одоогоор дэлхий дээр байхгүй байгаа бөгөөд зохицуулалтын аль хэлбэр, загварт харьяалагдаж буй болохыг нь яг таг тодорхойлж чадахгүй санхүүгийн зах зээлүүд ч мөн олон байна. Хэдийгээр зохицуулалтын аль нэг хэлбэр нь тухайн улсын санхүүгийн зах зээлд давамгайлж буй ч бусад хэлбэрийн шинж чанарыг тусгах байдлаар ашиглагддаг аж. Түүнчлэн улс орон бүрийн улс төр, эдийн засаг, түүх, соёл, дотоодын бизнесийн хэлбэр, бүтэц ялгаатай тул зөвхөн энэ загвар нь л илүү үр ашигтай, илүү сайн гэж тодорхойлох боломжгүй юм. Судалгааны ажлын энэхүү бүлэгт зохицуулалтын уг 4 хэлбэрийн онцлог шинж чанар, давуу, сул талыг дурдах бөгөөд эдгээр хэлбэрт харьяалагдаж буй зарим улсуудын жишээг мөн товч дурдана.

Хүснэгт 2.1. Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэр

ИНСТИТУЦИОНАЛ ХЭЛБЭР /Institutional Approach/	ФУНКЦИОНАЛ ХЭЛБЭР /Functional Approach/	НЭГДСЭН ХЭЛБЭР /Integrated Approach/	ХОСОЛМОЛ ХЭЛБЭР /Twin Peak Approach/
<ul style="list-style-type: none"> * Санхүүгийн зохицуулалтын уламжлалт загвар; * Зах зээлд оролцогч байгууллагуудын хуулийн статуст үндэслэн тухайн байгууллагын бизнесийн үйл ажиллагаа, тогтвортой байдал хэрхэн хаана зохицуулагдах нь тодорхойлогддог; * Хуулийн статус нь ялгаатай байдгаас шалтгаалан ижил төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ эрхэлдэг санхүүгийн байгууллагуудыг өөр, өөр байгууллагууд зохицуулах тохиолдол байдаг. 	<ul style="list-style-type: none"> * Зах зээлд оролцогчийг хуулийн статусаар нь бус бизнесийн үйл ажиллагааны төрлөөс нь хамааруулан зохицуулдаг; * Бизнесийн үйл ажиллагааны төрөл тус бүр нь тусдаа зохицуулагч байгууллагатай. 	<ul style="list-style-type: none"> * Сүүлийн жилүүдэд илүү түгээмэл ашиглагдаж эхлээд буй зохицуулалтын загвар; * Бүхий л төрлийн санхүүгийн үйлчилгээ, санхүүгийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаа болон аюулгүй, найдвартай байдалд нэгдсэн нэг зохицуулагч байгууллага хяналт тавьж, зохицуулдаг. 	<ul style="list-style-type: none"> * Зохицуулалтын чиг үүрэг нь хоёр тусдаа зохицуулалтын байгууллагуудад харьяалагддаг зохицуулалтын загвар; * Нэг зохицуулалтын байгууллага нь салбарын тогтвортой байдалд анхаарал хандуулан зохицуулалт хийдэг бол нөгөөх нь санхүүгийн зах зээлд оролцогчдын бизнесийн үйл ажиллагаа, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлд илүү анхааран хяналт, зохицуулалт хийдэг.

Институционал хэлбэр /Institutional Approach/

Институционал хэлбэр нь санхүүгийн хяналт, зохицуулалтын сонгодог хэлбэрүүдийн нэг бөгөөд тус хэлбэрийг хуулийн этгээдэд тулгуурласан аргачлал гэж мөн нэрлэдэг. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагыг хэрхэн яаж зохицуулах нь тухайн байгууллагын хуулийн статусаас хамаардаг аргачлал юм. Мөн тухайн аж ахуйн нэгжийн үзүүлэх боломжтой зөвшөөрөгдөх үйл ажиллагааг хуулийн хүрээгээр тодорхойлж өгдөг бөгөөд зохицуулагч байгууллага нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалан үйл ажиллагаанд нь нэмэлтээр зөвшөөрөл олгох тохиолдол түгээмэл байдаг. Түүнчлэн өөр өөр хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь ижил төстэй үйлчилгээ эрхэлж буй хэдий ч өөр өөр зохицуулагч байгууллагуудын дор үйл ажиллагаа явуулах шаардлага уг зохицуулалтын хэлбэрт үүсдэг. Тухайн санхүүгийн салбарын ялгаа, заагийн хүрээнд тухайн байгууллагын үйл ажиллагаа,

чиг үүргийг хянан, бизнесийн үйл ажиллагааг нарийн чанд зохицуулдаг зохицуулагч байгууллагыг бий болгодог. Энэхүү чиг хандлагыг дэмжих гол аргумент бол мэдлэг чадвар юм. Тухайн салбарын хүрээнд мэргэшсэн зохицуулагч байгууллагууд салбарын талаар илүү мэдлэгтэй байдаг бөгөөд мэдлэгээ ашиглан илүү гүнзгий туршлага хуримтлуулдаг байна. Энэ тогтолцоо нь энгийн бөгөөд хоорондоо уялдаа холбоотой. Байгууллагын хууль эрх зүйн статус нь ямар зохицуулагч байгууллагаар зохицуулагдах эсэхийг тодорхой зааж өгдөг бөгөөд тухайн зохицуулагч өөрийн гэсэн өвөрмөц арга барил, техник, практикт суурилдаг. Иймд зохицуулагчдын бүрэн эрх тодорхой заагдсан байдаг учир институционал зохицуулагчид илүү үр дүнтэй байдаг гэж үздэг.

Хүснэгт 2. 2. Институционал зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> - Санхүүгийн зохицуулагч байгууллага бүр өөрийн чиг үүргийн хүрээнд тухайн нэг салбарт төвлөрч ажилладаг бөгөөд салбарыг зохицуулахад гүнзгий мэргэшсэн байдаг. Санхүүгийн системийг бүхэлд нь хамарч буй асуудлуудыг илүү сайн хянаж, шуурхай бодлогын арга хэмжээ авах боломжийг олгодог; - Санхүүгийн зохицуулагч байгууллага бүр өөрийн төсөвтэй байдаг бөгөөд нарийн тодорхойлогдсон чиг үүргийн хүрээнд зарцуулагддаг; - Хэрэгжүүлэх үйл ажиллагаа болон тавьсан зорилго нэгдсэн зохицуулагчтай харьцуулахад харьцангуй цөөн учир нэг салбарт чиглэсэн зохицуулагч байгууллага нь тухайн салбараа хянахад илүү хялбар. 	<ul style="list-style-type: none"> - Зарим салбар олон зохицуулагч байгууллагад харьяалагдаж, зарим нь зохицуулалтгүй үлдэх магадлалтай; - Зохицуулагч байгууллагууд санхүүгийн системийн талаар цогц, нэгдсэн ойлголтгүй байдаг; - Зохицуулагч байгууллага болгон тусдаа дэд бүтэцтэй байдаг (оффисын барилга, мэдээлэл технологийн систем гэх мэт); - Үр дүнтэй хамтын ажиллагаа, зохицуулалтын механизм дутагдалтай байдаг бөгөөд энэ нь хяналт зохицуулалтын тогтолцоонд үр ашиггүй байдлыг үүсгэдэг; - Зохицуулагчид хоорондын уялдаа холбоог хангах нь өндөр зардалтай байдаг; - Санхүүгийн байгууллагууд зохицуулалт хамгийн багатай эсхүл өртөг багатай салбарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулснаар зохицуулалтын цоорхой үүсэх магадлалтай.

Энэхүү тогтолцоо нь зөвхөн тухайн байгууллага нэг төрлийн санхүүгийн үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд тохиромжтой. Санхүүгийн зах зээл хөгжихийн хэрээр байгууллагууд хууль, эрх зүйн тодорхой нэг статуст хамаарахаа больж, төрөл бүрийн үйлчилгээг үзүүлэх болсон. Институционал санхүүгийн хяналт шалгалтын тогтолцоо нь санхүүгийн зах зээлийн хөгжил нэгдмэл болох тусам дараах маргаануудыг дагуулдаг. Үүнд:

- Тухайн зохицуулагч байгууллагын хүрээнд бий болсон дотоод соёл, зохицуулалтын арга барил, туршлага, мэдлэг зэргээс хамаарч институционал тогтолцоо нь ерөнхий хяналт зохицуулалтын үр нөлөөтэй байдлыг сулруулах магадлалтай. Иймд зохицуулагч байгууллагуудын тогтолцоог шинэчлэх нь зардал ихтэйгээс гадна, тухайн зохицуулагч байгууллагын хамт олны туршлага, нэгдсэн мэдээ, мэдээлэл алдагдах эрсдэлтэй. Нөгөө талаар, нэгдсэн нэг байгууллага хяналт, зохицуулалтын үүргийг гүйцэтгэснээр зохицуулалт илүү үр дүнтэй байдаг гэж үздэг байна.
- Олон зохицуулагч байгууллагатай байх нь олон нийтийн дунд төөрөгдлийг дагуулдаг бөгөөд тодорхой асуудлуудыг шийдэхэд ямар зохицуулагч байгууллага хариуцаж, шийдвэрлэх нь тодорхойгүй байдаг.
- Олон зохицуулагчтай зах зээлд зохицуулалтын цоорхой гарах мөн ижил төрлийн бизнес эрхэлдэг

- ялгаатай байгууллагуудын хооронд харилцан уялдаагүй зохицуулалт бий болох эрсдэл үүсдэг.
- Зохицуулалттай этгээдүүдэд шаардлагагүй зохицуулалтын давхардал болон нэмэлт зардлыг бий болгох магадлалтай.
 - Зөрчилдөөнийг шийдвэрлэхэд гарах гүйлгээний зардал зохицуулагч хоорондын хүрээнд бага байна уу эсхүл зохицуулагчийн дотоодод үүссэн зөрчилдөөний хүрээнд бага байна уу гэдэг нь маргаантай асуудал хэвээр байна.
 - Байгууллагууд томоохон групп компаниудын хэлбэрт харьяалагдах болсноор бизнесийн үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй болж ирдэг. Мөн банк уу, банк бус санхүүгийн байгууллага уу эсхүл даатгалын компани уу гэдгийг тогтоох боломжгүй болдог. Иймд хэт энгийн бүтэцтэй институционал тогтолцоо нь санхүүгийн групп компаниудыг зохицуулахад тохиромжгүй байдаг.
 - Зохицуулагчид шаардлага сулруулснаар санхүүгийн байгууллагуудыг зохицуулах өрсөлдөөн үүсэх эрсдэлтэй. Энэ нь ихэвчлэн хил дамнасан зохицуулалтын цоорхойг үүсгэх буюу байгууллагууд зохицуулалтын шаардлага багатай улсад компани нүүлгэн шилжүүлж тухайн улсад бүртгэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулах боломжтой болдог.
 - Санхүүгийн групп компаниудын тоо нэмэгдэх тусам зохицуулалтын давхардал мөн цоорхой үүсэх эрсдэл дагуулдаг. Ингэснээр зохицуулагчдын зорилго, үүрэг хариуцлагын тодорхой байдал алдагдаж, зохицуулагч хоорондын маргаан гарах хандлагатай байдаг. Зохицуулагчид үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэхгүй байх, эсхүл зохицуулалтаа бууруулах зэргээр тухайн зах зээлийг зохицуулалтгүй орхих эрсдэл үүсдэг.

Олон улсын туршлага

Бүгд Найрамдах Хятад Ард Улс /БНХАУ/

БНХАУ нь институционал хандлагыг ашиглахдаа функционал хандлагын зарим элементийг хослуулан ашигладаг бөгөөд сүүлийн үед улс орнууд нэгдсэн эсвэл хосолмол хэлбэрт шилжиж байгаа бол БНХАУ–ын хувьд эсрэг байр суурьтай байна. БНХАУ–ын санхүүгийн бүх хяналт, зохицуулалт нь БНХАУ–ын төв банк болох Ардын банкны хяналтад байдаг байсан бол сүүлийн 25 жилд институционал хэлбэрт шилжиж банк, үнэт цаас, даатгалын салбар тус бүр өөр зохицуулагчтай болсон байна. 1998 оноос эхлэн БНХАУ–ын Үнэт цаасны зохицуулалтын хороо (CSRC) нь үнэт цаасны зах зээлийн зохицуулалт, хяналтын байгууллагаар ажиллаж байна. Тус байгууллага нь хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, үнэт цаасны компаниуд болон хөрөнгийн зах зээлийг хянах бөгөөд жижиг болон дунд түвшний хөрөнгө оруулагчдын эрхийг хамгаалах асуудлыг чухалчлан авч үздэг байна. 1998 онд мөн БНХАУ–ын Даатгалын зохицуулалтын хороо (CIRC) байгуулагдаж, 2003 онд банкны салбарын зохицуулалт, хяналтын чиг үүргийг БНХАУ–ын Ардын банкнаас Хятадын банкны зохицуулалтын хороо (CBRC)–нд шилжүүлсэн байна. БНХАУ–ын Банкны зохицуулалтын хорооны хяналт дор арилжааны банкууд, санхүү хөрөнгө удирдлагын компаниуд, итгэлцэл болон хөрөнгө оруулалтын компаниуд болон бусад хадгаламжийн байгууллагууд байдаг. Тус байгууллага нь банкны тусгай зөвшөөрөл олгох, зохистой шалгуурыг тогтоох, дүрэм журмыг батлах, хяналт шалгалт хийх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Харин төв банк болох БНХАУ–ын Ардын банкны үүрэг нь санхүүгийн тогтвортой байдлыг хангах болон мөнгөний бодлогыг гаргаж, хэрэгжүүлэхээр хязгаарлагджээ. Гэсэн хэдий ч бодлого гаргах түвшин дэх үүргийн хувьд Төв банкны ерөнхийлөгч нь БНХАУ–ын дээд эрхт байгууллага болох Бүх Хятадын

ардын төлөөлөгчдийн их хурлын гишүүн учир санхүүгийн салбарын ерөнхий чиглэлд үзүүлэх нөлөө нь төв банкны хувьд тодорхой хэмжээнд байдаг гэж ойлгож болно.

Санхүүгийн зах зээлд гарч байгаа дэвшлүүдийн улмаас санхүүгийн байгууллагуудын ялгаатай байдал багасаж байгаа нь БНХАУ–ын институционал хандлагын хувьд асуудал үүсгээд байгаа юм. Санхүүгийн байгууллагууд өөрсдийн үндсэн үйл ажиллагаанаас өөр төрлийн бүтээгдэхүүн санал болговол зохицуулалтын давхардал эсхүл цоорхой үүсэх асуудал үүснэ. Жишээ нь даатгалын компаниуд банкны салбарынх шиг бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлдэг болбол тухайн бүтээгдэхүүн Даатгалын зохицуулалтын хорооны зохицуулалтад байх уу, Банкны зохицуулалтын хорооны зохицуулалтад байх уу гэдэг нь эргэлзээтэй болж эхэлнэ. Иймэрхүү байдлаар банк, даатгал, үнэт цаасны компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлүүд ижилхэн болох тусам зохицуулалтын асуудал үүссээр байна.

Мексик Улс

Институционал хандлагыг санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтад ашигладаг өөр нэг улс нь Мексик Улс бөгөөд тус улс энэхүү зохицуулалт, хяналтын хандлагыг “silo” хандлага гэж нэрлэдэг. Үндэсний банк, үнэт цаасны хороо (CNBV), Үндэсний даатгал, бондын байгууллагын хороо (CNSF), болон Тэтгэврийн хадгаламжийн системийн үндэсний хороо (CONSAR) гэсэн Засгийн газрын харьяа гурван агентлагууд санхүүгийн байгууллагуудыг зохицуулж, хянадаг. Санхүүгийн нэгдэл компаниудын хувьд нэгдсэн зохицуулалт эсвэл тэргүүлэх хяналтын байгууллага байдаггүй. Эдгээрээс гадна хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор Санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчдийг эрх ашгийг хамгаалах хороо (CONDUSEF) болон хадгаламжийн даатгалын зохицуулагч болох Хадгаламжийн даатгалын агентлаг (IPAB) гэсэн зохицуулагч байгууллагууд байдаг.

Үндэсний банк, Үнэт цаасны хороо нь гол хяналтын байгууллага бөгөөд банк болон брокерын компаниудыг зохицуулдаг. Банкууд болон брокерын компаниуд нийлж санхүүгийн нэгдлүүдийг үүсгэж байсан нь 1995 онд банкны болон үнэт цаасны зохицуулалтын хороод нэгдэн тус байгууллагыг үүсгэсэн түүхтэй. Тус байгууллагын үндсэн чиг үүрэг нь даатгал, бондын компани болон тэтгэврийн сангуудаас бусад бүх санхүүгийн байгууллагын аюулгүй, тогтвортой байдлыг хангах юм. Байгууллагын удирдах зөвлөл нь Сангийн яам, Мексикийн төв банк, Үндэсний даатгал болон бондын хороо, Тэтгэврийн хадгаламжийн системийн үндэсний хороо зэрэг Засгийн газрын бусад байгууллагын төлөөллүүдээс бүрддэг. Мексикийн төв банк нь санхүүгийн байгууллагуудыг шууд зохицуулах эрхгүй боловч хэрэв одоогийн зохицуулалт хангалтгүй гэж үзсэн тохиолдолд зохицуулах эрх олгогдох боломжтой байдаг. Мексикийн төв банк нь үндэсний мөнгөн тэмдэгтээр хангах, үнийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн системийн хөгжлийн тогтвортой байдлыг дэмжих, төлбөр тооцооны системийн зохистой байдлыг хангах гэсэн дөрвөн үндсэн зорилттой байдаг. Мөн банкуудын “хамгийн сүүлийн зээлдүүлэгч” буюу “lender of last resort”–ийн үүргийг гүйцэтгэдэг. 1990–ээд оны дунд үеэс эхлэн зохицуулалтын бүтцийн асуудал маргаантай хэвээр байгаа бөгөөд банк болон үнэт цаасны хороодыг нэгтгэсний дараа ч гэсэн хяналтын бүх хороод байгууллагыг нэгтгэх асуудал яригдаж байсан. Харин өнөөгийн байдлаар бүтцийн шинэчлэлийн асуудал нь байгууллагуудыг нэгтгэхээсээ илүүтэйгээр одоогийн байгаа загварын үр ашгийг сайжруулан, иргэдийнхээ санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэх хандлагатай байна.

Функционал хэлбэр /Functional Approach/

Санхүүгийн хяналт, зохицуулалтын функционал хандлагын хүрээнд санхүүгийн байгууллагуудыг хуулиар олгосон статусынх нь хүрээнд бус эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаанд нь суурилан зохицуулдаг. Энэ нь тухайн байгууллагын үйл ажиллагаа нь төрлөөсөө шалтгаалан тус тусын зохицуулагч байгууллагатай байна гэсэн үг юм. Тухайлбал аливаа нэг аж ахуйн нэгж үнэт цаасны, банкны, даатгалын зэрэг өөр өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг бол тус бүрийн салбарын зохицуулагч байгууллагын дор үйл ажиллагаагаа явуулдаг. Энэхүү загвар нь институционал загвартай төстэй бөгөөд тийм ч утгаараа давуу болон сул талууд нь бараг ижилхэн. Энэ загвар нь санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг дээр төвлөрдөг бөгөөд чиг үүрэг болгоныг зохицуулах байгууллагатай байхыг шаарддаг. Тухайлбал амьдралын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага болгоныг ямар төрлийн байгууллага гэдгээс үл хамааран нэг зохицуулагч байгууллага хянана. Санхүүгийн байгууллагын хууль эрх зүйн байдлаас үл хамааран олон төрлийн үйл ажиллагаа явуулдаг эсвэл олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг бол олон тооны зохицуулагчийн хяналтад байна. Хяналтын байгууллага болгон зөвхөн хариуцсан салбарынхаа тогтвортой байдлыг хангах болон бизнесийн үйл ажиллагааны хяналтыг тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Институционал загварыг ашигладаг ихэнх улсуудад энэхүү загварыг хослуулж, дийлэнх тохиолдолд функционал загвар нь нэмэлт байдлаар байдаг. Функционал загварыг санхүүгийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааны хяналтад, институционал загварыг тэдгээрийн аюулгүй болон тогтвортой байдлыг хангах зорилгоор хяналтын системдээ ашигладаг. Энэхүү холимог загварыг Их Британи Улс нэгдсэн загварт шилжихээсээ өмнө буюу 1997 он хүртэл ашиглаж байсан.

Хүснэгт 2.3. Функционал зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> – Байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны төрлөөс хамааран зохицуулдаг тул цөөн төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг тохиолдолд зохицуулалт үр дүнтэй байна; – Санхүүгийн хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, бизнесийн үйл ажиллагааны хяналтыг (CoV) хэрэгжүүлэхэд илүү хялбар; – Санхүүгийн байгууллагууд бүтэц, чиг үүрэгтээ өөрчлөлт оруулах боломж бүхий уян хатан хяналтын тогтолцоо. 	<ul style="list-style-type: none"> – Нэг салбар дахь үйл ажиллагааны хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр ялгаатай олон тооны зохицуулагч байх нь тодорхой хэсгийг хамарсан дүрэм журмын давхцал эсвэл зохицуулалтын цоорхой зэргийг үүсгэх магадлалтай; – Олон зохицуулагчтай байснаар санхүүгийн байгууллагуудын дүрэм журмын нийцэл (комплайнс) болон тайлагналын үйл ажиллагаа нэмэгдэнэ; – Санхүүгийн салбарыг бүхлээр нь хянах боломжгүй байдал үүсэх бөгөөд зохистой хяналтыг хэрэгжүүлэхэд тохиромжгүй.

Институционал болон функционал загварын ялгаа

Тодорхой хүрээнд бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлдэг санхүүгийн байгууллагуудын зохицуулалтыг шийдэж өгснөөрөө функционал загвар нь ялгаатай. Бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож байгаа байгууллагаас нь эхлээд түүнийг зуучилж байгаа байгууллага хүртэл зохицуулалтад хамрагдана. Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хувьд тус компани мөн арилжаа хийж буй брокер болон тус үйл ажиллагаатай холбоотой бүхий л байгууллага тогтсон стандарт бүхий зохицуулалтад орно. Ингэснээр институционал загварыг бодвол нарийн төвөгтэй, цогц зах зээлийг илүү сайн хянаж,

зохицуулдаг. Цаашлаад санхүүгийн үйл ажиллагааны хяналтын системд тус загварыг нэвтрүүлснээр бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл бүрт хэрэглэгч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах арга замыг бүрдүүлсэн.

Институционал загвар болон функционал загварын хоорондын ялгаа нь санхүүгийн байгууллага өөрсдийн салбарт тодорхой чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг үед мэдэгдэхгүй ч тэд нэгдэж санхүүгийн нэгдлийг үүсгэх үед ялгаа нь илүү ажиглагдана. Өөрөөр хэлбэл энэхүү загвар нь төлбөрийн чадварын болон системийн эрсдэлийг бий болгож байдаг. Функционал загварын хяналт нь голцуу хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалахад чиглэсэн байдаг нь энэхүү загвараар зохистой хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэдэг. Санхүүгийн зах зээлд доголдол үүсэхэд байгууллагын явуулж буй үйл ажиллагаанаас илүүтэйгээр байгууллага өөрөө эрсдэлд ордог учраас зөвхөн энэ загварыг ашиглах нь учир дутагдалтай байдаг.

Олон улсын туршлага

Итали Улс

Италийн санхүүгийн зохицуулалт нь функционал бүтэцтэй бөгөөд банк, хөрөнгө оруулалт, хөрөнгийн удирдлага, даатгал гэсэн үндсэн дөрвөн үйл ажиллагааны хүрээнд байдаг. Эдгээр нь тус бүр өөрийн гэсэн зохицуулалт, хууль эрх зүйн орчинтой.

Италийн Төв банк нь банкуудын хяналт, зохицуулалтын байгууллага бөгөөд мөн Европын Төв банкны системийн гишүүн тул мөнгөний бодлогын үүргээ ч давхар хэрэгжүүлдэг. Мөн Италийн Төв банк нь улсынхаа санхүүгийн байгууллагуудын тогтвортой болон аюулгүй байдлыг хангах зорилготой зохистой хяналт, зохицуулалтын байгууллага юм. Банкны салбарын зохицуулалтаас гадна санхүүгийн системийн тогтвортой, өрсөлдөөнтэй болон үр ашигтай байдлыг хангах чиг үүрэгтэй.

Байгууллагууд болон хөрөнгийн биржийн хороо (CONSOB) нь үнэт цаасны зах зээл болон хөрөнгө оруулалтын үйлчилгээний зохицуулалтыг хариуцдаг төрийн байгууллага юм. Үнэт цаасны зах зээлийн оролцогчдын ил тод байдал болон бизнесийн үйл ажиллагааг хянах, бүртгэлтэй компаниудын үнэн зөв, бүрэн мэдээллийг олон нийтэд ил болгох, олон нийтээс хөрөнгө оруулалт татах зорилго бүхий үнэт цаас гаргагчийн проспектус буюу үнэт цаасны танилцуулгыг хянаж шалгах, аудитын байгууллагаас гаргасан зохицуулалтын нийцлийг хангах зэрэг чиг үүрэгтэй. Эдгээрээс гадна дотоод мэдээллийг ашиглан үнэт цаасны арилжаанд оролцох, зах зээлийг урвуулан ашиглах зэрэгтэй холбоотой хяналт шалгалтыг мөн хийдэг. Ерөнхийдөө тус байгууллага нь үйл ажиллагааны хяналтад чиглэсэн бөгөөд энэ утгаараа Италийн санхүүгийн салбарын загвар нь хосолмол загварын элементүүдийг агуулдаг.

Италийн даатгалын салбарын зохицуулагч нь Даатгалын салбарын зохицуулах газар (ISVAP) ба даатгалын байгууллагуудын үйл ажиллагааг хянах болон зохицуулах үүрэгтэйгээс гадна санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүднээс бүхий л төрлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэй байдаг. Даатгал болон давхар даатгалын үйл ажиллагааны зохистой хяналтыг хэрэгжүүлээд зогсохгүй даатгалын зах зээлийн бүрэн бүтэн байдал болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг гэсэн утгаараа Даатгалын салбарын зохицуулах газар нь даатгалын салбарын зохистой болон бизнесийн үйл ажиллагааны хяналтын функционал зохицуулагч юм.

2004 оноос хойш Италийн санхүүгийн хяналтын системд бүтцийн өөрчлөлт хийх хэрэгтэй эсэх талаар маргаантай байгаа бөгөөд хяналтын байгууллагын тоог бууруулан илүү үр ашигтай байх хяналтын байгууллагатай болох саналууд гарсан байна. Ялангуяа Италийн Төв банк болон Хөрөнгийн биржийн хорооноос бусад байгууллагын чиг үүргийг энэ хоёр байгууллагад хуваарилах хэрэгтэй гэсэн саналыг

их гаргах болсон байна. Энэ тохиолдолд Италийн санхүүгийн хяналтын загвар нь хосолмол загвар луу илүү дөхнө гэсэн үг юм.

Франц Улс

Франц Улсын санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын загварын хувьд функционал хандлагатай гэж үздэг хэдий ч Итали Улстай харьцуулахад үйл ажиллагааны хуваарилалтыг илүү хийсэн байдгаараа хосолмол хандлагад дөхсөн гэж үздэг.

Санхүүгийн зохицуулалтын системийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлэх зорилгоор 2003 онд Францын санхүүгийн үйлчилгээний хяналтыг шинэчилсэн байна. Санхүүгийн хяналтын бүтэц нь ерөнхийдөө шинэчлэгдэж, илүү хялбарчлагдсан ч бусад орнуудыг бодоход олон функционал хэлбэрийн зохицуулалтын байгууллагатай хэвээр үлджээ.

Банк болон хөрөнгө оруулалтын компаниудын зохистой хяналтыг Францын Төв банкны ерөнхийлөгчийн удирдах Банкны зөвлөл хариуцдаг. Банкны зөвлөл болон Санхүүгийн зах зээлийн газрын чиг үүрэг нь харгалзан зохистой хяналт болон бизнесийн үйл ажиллагааны хяналтыг хариуцдагаараа Италийн Төв банк болон Хөрөнгийн биржийн хорооны үйл ажиллагаатай юм.

Нэгдсэн хэлбэр /Integrated Approach/

Нэгдсэн зохицуулалтын чиг хандлагын хүрээнд бүх санхүүгийн салбарууд нэгдсэн нэг зохицуулагчийн дор үйл ажиллагаагаа явуулдаг байна. Энэ чиг хандлага нь өөрөөр “FSA загвар” гэж хэлэгддэг бөгөөд Их Британийн Санхүүгийн зохицуулагч байгууллагаас гаралтай юм.

Тухайн улсын санхүүгийн салбарын тогтолцооны онцлогт үндэслэн хяналт шалгалтын системийг цогцлоох нь үр дүнтэй аргачлал гэж зарим судлаачид (Абрамс, Тайлор М, 2000) үзэж байна. Хэрэв улс орны санхүүгийн системд банкууд олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хязгаарлалт багатайгаар олон нийтэд хүргэдэг бол нэгдсэн санхүүгийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх нь зохистой байдаг.

Сүүлийн жилүүдэд зах зээл хөгжихийн хэрээр санхүүгийн салбарыг тусдаа зохицуулагч байгууллагуудаар зохицуулах нь улам нарийн төвөгтэй болж байна. Тухайлбал, олон улсад даатгалын компаниуд хадгаламжтай төстэй бүтээгдэхүүн санал болгодог. Түүнчлэн зээлийн дериватив гэх шинэ төрлийн үнэт цаасны бүтээгдэхүүнүүд нь даатгалын бүтээгдэхүүний олон шинж чанарыг өөртөө агуулдаг байна. Цаашилбал, уламжлалт зээлийн бүтээгдэхүүн болон арилжааны болон орон сууцны зээл, зээлийн картын авлага зэргийг үнэт цаасжуулах, мөн эдгээр бүтээгдэхүүнүүдийг багцлах, эрсдэлийг арилжаалах нь хувьцаа, өр болон зээл хоорондын ялгааг сулруулж байдаг.

Хүснэгт 2. 4. Нэгдсэн зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> – Санхүүгийн групп байгууллагуудыг нэгдсэн байдлаар хянан зохицуулах боломжтой; – Санхүүгийн системийг бүхэлд нь хамарч буй асуудлуудыг илүү сайн хянаж, шуурхай бодлогын арга хэмжээ авах боломжийг олгодог; – Зохицуулагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх давуу талтай; 	<ul style="list-style-type: none"> – Шилжилтийн цаг үед нэгдсэн зохицуулалт нь хяналт шалгалтын үр ашгийг бууруулах хандлагатай байдаг; – Үнэт цаас, банк болон даатгалын салбарын өвөрмөц шинж чанарыг үл анзаарснаар хяналт шалгалтын үр нөлөөг бууруулах эрсдэлтэй;

<ul style="list-style-type: none"> – Нөөцийг үр ашигтай зарцуулах мөн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх боломжтой; – Зохицуулалтын цоорхойг арилгаж, санхүүгийн системийг бүхэлд нь нэгдсэн зохицуулалтаар зохицуулдаг. 	<ul style="list-style-type: none"> – Агентлаг хооронд шуурхай мэдээлэл солилцох, хамтран ажиллах бусад тогтолцоо байдаг тул заавал нэгдсэн зохицуулалтад шилжих албагүй.
---	---

Олон улсын туршлага

Их Британи Улс

Нэгдсэн загварыг хэрэгжүүлсэн гол төлөөлөгч улс нь Их Британи юм. 1990–ээд оны үед томоохон санхүүгийн байгууллагууд олон төрлийн санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн нэгдэл компаниуд болж, Их Британи төдийгүй бусад улс орнуудад үйл ажиллагаагаа явуулах болсон нь өмнө байсан институционал хандлагыг халж, нэгдсэн хэлбэрийг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болсон. Ингэснээр 1997 онд Их Британийн санхүүгийн салбарын зохицуулалтын хэлбэрт томоохон өөрчлөлт гарч анхны нэгдсэн зохицуулалтын байгууллага болох Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага (FSA) үүссэн байна. Их Британи Улсын банк, даатгал, үнэт цаас гээд санхүүгийн бараг бүх салбарын зохицуулалтыг зохистой болон бизнесийн үйл ажиллагааны түвшинд хянах бөгөөд санхүүгийн оролцогчдын итгэлийг нэмэгдүүлэх, олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон санхүүгийн гэмт хэргийг багасгах гэсэн үндсэн дөрвөн зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг.

Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага нь зохицуулалтыг хялбарчилсан учраас хамгийн үр ашигтай болон үр дүнтэй зохицуулалтын байгууллага гэдгээс гадна “principles of good regulation” буюу сайн зохицуулалтын зарчмуудыг хэрэгжүүлдэг гэдгээрээ олонд танигдсан. Энэхүү зарчмууд нь үр ашигтай байдал, удирдлагын үүрэг хариуцлага, инновац, олон улсын санхүүгийн үйлчилгээний шинж, чанар, өрсөлдөөн зэрэг ойлголтууд дээр үндэслэсэн зарчмууд юм.

Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага нь мөн хяналт, шалгалт явуулах, хууль сахиулах, мөн прокурорын үйл ажиллагаа явуулах эрхтэй байдаг. Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллагын хараа хяналтад байдаггүй санхүүгийн зохицуулалтын гол хэсэг нь байгууллагуудын тайлагнал болон засаглал бөгөөд үүнийг Санхүүгийн тайлагналын зөвлөл (FRC) хариуцан ажилладаг байна.

1997 онд Их Британийн Төв банкыг зөвхөн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх байгууллагаар томилсон бөгөөд банкуудыг шууд хяналтад байлгах нь Төв банкны эрх мэдлийг нэмэгдүүлэх тул банкны шууд хяналтын эрхийг төв банкнаас тусгаарласан байна. Ингэснээр мөнгөний бодлогын болон зохицуулалтаас үүсэх ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлсэн гэж үзэж болно. Их Британи Улсын Сангийн яам болох “Her Majesty’s Treasury” нь санхүүгийн зохицуулалтын хууль, эрх зүйн орчныг тодорхойлох, мөн “хамгийн сүүлчийн зээлдүүлэгч”-ийн эрхийг Төв банк нь хэрэгжүүлэх эсэхийг шийддэг байна.

Их Британи Улс нь 2013 онд нэгдсэн хяналт, зохицуулалтын хэлбэрээс хосолмол хэлбэрт шилжсэн бөгөөд санхүүгийн байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааны хяналтыг Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага, санхүүгийн салбарын зохистой хяналтыг Зохистой зохицуулалтын хороо хэрэгжүүлдэг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)

ХБНГУ нь Их Британи Улстай адилхан нэгдсэн хэлбэрийн зохицуулалттай хэдий ч ялгаатай хэд хэдэн шинжийг агуулдаг. Тус улсын санхүүгийн салбарын зохицуулалтын хэлбэр 2002 он хүртэл банк, үнэт цаас, даатгалын компаниудыг зохицуулах тусдаа байгууллагууд бүхий институционал хэлбэртэй байсан. 2001 онд ХБНГУ-ын Засгийн газар ХБНГУ-ын төв банк болох Бундес банкны бүтцийг шинэчлэхээр болсон бөгөөд үүнийхээ хажуугаар санхүүгийн зах зээл дэх санхүүгийн хяналт зохицуулалтын институционал загвараа шинэчлэхээр болсон байна. Санхүүгийн салбаруудыг нэгтгэсний дараа санхүүгийн үйлчилгээний хоорондын ялгаа багассан, улмаар бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт, зохицуулалтын давхцал бий болсноор BaFin буюу Санхүүгийн зохицуулагч байгууллага нь үүссэн. Гэсэн хэдий ч ХБНГУ-ын Төв банк хэд хэдэн хяналтын чухал үүргийг хариуцсан хэвээр үлдсэн бөгөөд ингэснээр санхүүгийн салбарын зохицуулалтыг Санхүүгийн зохицуулагч байгууллага болон ХБНГУ-ын Төв банк хамтран хэрэгжүүлэхээр болсон байна.

Санхүүгийн зохицуулагч байгууллага нь банк, үнэт цаас, даатгалын салбаруудаа хариуцан хянадаг бөгөөд эдгээр салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын аюулгүй, тогтвортой байдлын хяналтыг мөн хариуцдаг. Зах зээлийн хяналтын явцад Санхүүгийн зохицуулагч байгууллага нь зах зээлд оролцогч байгууллагуудад мэргэжлийн стандарт тогтоож өгснөөр хөрөнгө оруулагчдын итгэлийг хадгалахыг зорьдог байна. Мөн хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үүднээс тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай холбоотой асуудлыг хариуцан ажилладаг.

Төв банкны ерөнхий үүргүүдээс гадна банкны салбарын зарим хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрхтэйгээрээ Германы төв банк онцлогтой. Ажил үүргийн давхцал үүсгэхгүйн тулд Төв банк болон Санхүүгийн зохицуулагч байгууллагын хооронд өдөр тутмын хяналтын үйл ажиллагааны үүргүүдийг нь зааж өгсөн харилцан ойлголцлын санамж бичиг байдаг. Энэхүү санамж бичгээр бол Төв банк нь банкны хяналтыг хэрэгжүүлэгч гол байгууллага гэж заасан байна. Бундес банк нь санхүүгийн салбар дахь томоохон асуудлын талаар эдийн засгийн бодлоготой холбоотойгоор Засгийн газарт зөвлөгчийн үүргийг гүйцэтгэх ба хямралын менежментийн чиглэлийг давхар хариуцдаг.

Их Британи Улсаас ялгаатай нь даатгалын салбарын хяналт нь засгийн газар болон мужуудын хооронд хуваарилагдсан байна. Санхүүгийн зохицуулагч байгууллага нь ХБНГУ-д үйл ажиллагаа явуулж буй хувийн даатгалын байгууллагуудын хяналт, мөн муж дамнан үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд, улсын эдийн засагт том нөлөө бүхий даатгалын компаниудын хяналтыг хариуцдаг. Харин муж болгоны зохицуулах байгууллагууд нь муж дотор үйл ажиллагаагаа явуулдаг даатгалын компаниуд болон эдийн засагт харьцангуй бага нөлөөтэй байгууллагуудын хяналтыг хэрэгжүүлдэг.

ХБНГУ-ын хувийн хөрөнгийн биржийн хяналтын байгууллага нь мужуудын хөрөнгийн биржүүдийн хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Тус байгууллага нь хөрөнгийн зах зээлийн арилжааны тэр дундаа үнэ тогтох үйл ажиллагааг хянадгаас гадна өөр нэгэн чиг үүрэг нь цахим арилжааны системд хяналт тавих юм.

Төв банк болон Санхүүгийн зохицуулагч байгууллагын чиг үүрэг, мөн зохицуулалтын загварт нэмэлт сайжруулалт оруулах шаардлага бий гэсэн асуудал сүүлийн үеүдэд яригдах болсон. Бундес банкны банкны салбарын хяналт дахь оролцоотой байдал нь Их Британи Улсын санхүүгийн салбарын зохицуулалтын загвараас ялгаатай. Иймээс ХБНГУ-ын зохицуулалтын загвар нь яг ч цэвэр нэгдсэн загвар биш харин холимог төрлийн нэгдсэн зохицуулалт юм.

Хосолмол хэлбэр

Энэхүү чиг хандлагын хүрээнд зохицуулалтын чиг үүрэг 2 зохицуулагчийн хүрээнд хуваагддаг бөгөөд нэг нь салбарын тогтвортой байдал талаас, нөгөө нь зах зээлд оролцогчдын бизнесийн үйл ажиллагаа талаас нь анхаарч санхүүгийн салбарыг хянаж зохицуулдаг байна.

Хүснэгт 2. 5. Хосолмол зохицуулалтын хэлбэрийн давуу болон сул тал

ДАВУУ ТАЛ	СУЛ ТАЛ
<ul style="list-style-type: none"> – Санхүүгийн байгууллагын зохистой үйл ажиллагаа болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлаар үүссэн сонирхлын зөрчил буурах нөлөөтэй; – Зохицуулагч байгууллагууд өөр өөрийн чиглэлээр мэргэшсэн байдаг бөгөөд тэдгээрийн дор хаяж нэг зохицуулагч нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тал дээр мэргэшсэн байдаг; – Холбогдох чиглэлийн хүрээнд зах зээлийг бүхэлд нь хамран зохицуулах боломжтой; – Зохистой үйл ажиллагааны хяналт болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд төсөв төлөвлөгдөнө; – Зохистой үйл ажиллагаа болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд гарсан асуудал тухайн чиглэлийн зохицуулагчдад хамаардаг. 	<ul style="list-style-type: none"> – Хамтын ажиллагаа, уялдаа холбоогүй байдал нь хяналтыг хэрэгжүүлэх болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад саад тотгор учруулах боломжтой; – Төсөв, улс төрийн дэмжлэгийн төлөө тэмцэх нь хяналт зохицуулалтын үр өгөөжийг бууруулж, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг сулруулж болзошгүй.

Хосолмол зохицуулалтын хэлбэрийн сул талыг нөхөх арга хэмжээ

Хэрэв зохицуулагч байгууллагуудын хооронд ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд түүнийг шийдвэрлэх механизм байх ёстой байдаг. Тухайлбал Их Британийн Санхүүгийн үйлчилгээ, зах зээлийн тухай хуульд зааснаар хэрэв (i) Их Британийн санхүүгийн системийн тогтвортой байдалд сөрөг нөлөөтэй; (ii) Зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулагч байгууллагууд дампуурах улмаар Их Британийн санхүүгийн системд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлууд үүсэх эрсдэлтэй гэж Зохистой зохицуулалтын байгууллага (PRA)–аас үзсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулагч байгууллага эрх мэдлээ хэрэгжүүлэхгүй байх үүрэгтэй бөгөөд эрх мэдлээ заасан хэлбэрээр хэрэгжүүлэхгүй байх тал дээр Зохистой зохицуулалтын байгууллагаас чиглэл өгч ажилладаг.

Зохицуулагч байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааны дутагдалтай талыг байгууллага хоорондын харилцан тохиролцоонд үндэслэн шийдвэрлэх боломжтой. Тухайлбал, Малайзын төв банк болон Үнэт цаасны хороо нь байгууллага хоорондын үр дүнтэй хамтын ажиллагааг хангах хүрээнд харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан.

Зохицуулагч байгууллага бүрийн төсөв тусдаа төлөвлөгддөг ч энэ нь бүх агентлагуудад хангалттай төсөв хуваарилагдсан гэсэн үг биш юм. Бодит байдал дээр зохистой үйл ажиллагааг хариуцсан зохицуулагч байгууллага нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагатай харьцуулахад төсвийн илүүдэлтэй байдаг.

Практикт аливаа асуудлыг шийдэх, хариуцаж ажиллах үүргийг аль зохицуулагч байгууллага нь хүлээхийг тодорхойлох нь амаргүй. Энэхүү асуудал нь ялангуяа бизнесийн зохистой үйл ажиллагаа болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлууд харилцан уялдаатай байх тохиолдолд үүсдэг. Тухайлбал, санхүүгийн хэрэглэгчдээс хууль бус төлбөр хураамж авч байгаа тохиолдол нь нэг талаараа санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг зөрчиж байгаа боловч нөгөө талаар зах зээлийн хөрвөх чадварыг бууруулж байдаг.

Олон улсын туршлага

Австрали Улс

1997 онд санхүүгийн үйлчилгээний зохицуулалтын системд хийсэн дүн шинжилгээнээс хойш Австрали Улс санхүүгийн салбарын зохистой зохицуулалт болон бизнесийн үйл ажиллагааны зохицуулалтыг салгаж хосолмол загварыг ашиглаж эхэлсэн.

Австралийн зохистой зохицуулалтын газар (APRA) нь банк, хадгаламж зээлийн хоршоод, даатгалын компаниуд, тэтгэврийн сангууд зэрэг хадгаламжийн байгууллагуудын зохицуулалтын этгээд бөгөөд төв банкнаас тусдаа бие даасан байгууллага юм. Австралийн зохистой зохицуулалтын газар нь зохицуулалтад буй байгууллагуудын зохистой хяналтыг хариуцан ажилладаг бөгөөд тэдгээрийн аюулгүй, тогтвортой ажиллагаанд нь хяналт тавьдаг. Үйл ажиллагааны доголдолтой байгаа компаниудтай холбоотой асуудлыг Австралийн төв банктай хамтран шийддэг ба шаардлагатай тохиолдолд төв банкнаас хөрвөх чадварын туслалцааг ч үзүүлдэг байна. Австралийн зохистой зохицуулалтын газар нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах төв байгууллага юм.

ASIC буюу Австралийн үнэт цаас, хөрөнгө оруулалтын хороо нь бүх салбарын хувьд зах зээлийн бүрэн бүтэн байдал, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах бизнесийн үйл ажиллагааны хяналтыг хариуцсан зохицуулагч байгууллага юм. Зохистой хяналтын байгууллага биш учраас зохицуулалтын зөвлөмж, үйл ажиллагааны кодексыг зэргийг гаргадаг.

Австралийн төв банк нь мөн санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал, бодлогын хүү, төлбөрийн системийн хяналтыг хариуцах бөгөөд тусгай зөвшөөрөлтэй этгээдүүд үйл ажиллагаагаа санхүүгийн тогтвортой байдлын шалгууруудын дагуу явуулж буй эсэхийг хянах үүрэгтэй.

Нидерланд Улс

Нидерланд нь санхүүгийн зах зээлийн зохицуулалтын загвартаа мөн хосолмол загварыг ашигладаг бөгөөд Австрали улсаас ялгаатай нь Нидерландын төв банк (DNB) нь санхүүгийн салбаруудын системийн эрсдэл болон зохистой хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг байна.

AFM буюу Нидерландын санхүүгийн зах зээлийн зохицуулалтын газар нь бүх санхүүгийн байгууллагын бизнесийн үйл ажиллагааны зохицуулалтыг хэрэгжүүлэх бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахын тулд зах зээлийн ил тод байдлыг хангах зорилготой. Энэхүү зорилгоос гадна зах зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, зах зээлийн үр ашигтай, шударга байдлыг хангах, олон нийтийн зах зээлд итгэх итгэлийг сайжруулах гэсэн гурван зорилтыг тавин ажилладаг байгууллага юм. Нидерландын төв банк болон Санхүүгийн зохицуулагч байгууллага аль аль нь хууль сахиулах эрх бүхий байгууллага болно.

1990–ээд оны эцсээр Нидерланд нь санхүүгийн зах зээлийн хяналтын институционал загвартай байсан бөгөөд зохицуулагч байгууллагууд банк, даатгал, үнэт цаасны салбараар хуваагдсан байсан. Санхүүгийн байгууллагууд нэгдэж, олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлж бүтээгдэхүүний шугам олширч байсан нь энэхүү загварыг халж, хосолмол загварыг ашиглахад хүргэсэн байна.

Нидерландын Сангийн яам нь санхүүгийн байгууллагуудын “хамгийн сүүлчийн зээлдүүлэгч” болдог бөгөөд харин төв банк нь хямралын менежментийг хариуцан ажилладаг. Одоогийн байдлаар Санхүүгийн зохицуулагч байгууллага нь хямралын зохицуулалтад оролцдоггүй боловч цаашдаа харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хандлагатай байна.

ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

Одоогоор дэлхий нийтэд ашиглагдаж буй үндсэн 4 хэлбэрийн зохицуулалтын загварын аль нэгийг нь хамгийн сайн хэмээн тодорхойлоогүй байгаа хэдий ч санхүүгийн зах зээл дэх технологийн дэвшлийн нөлөө, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөлжилт, дэлгэрэлт болон санхүүгийн нэгдэл компаниудын өсөлтөөс шалтгаалан зохицуулалтын хэлбэр, чиг хандлага салбар бүр тус тусын зохицуулалт бүхий уламжлалт хандлагаас шилжин нэгдсэн нэг зохицуулалт бүхий загваруудад шилжиж байна. Ингэхдээ санхүүгийн байгууллагын бизнесийн үйл ажиллагаанд тавигдах хяналт, зохицуулалт болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиглэл бүхий бодлогын зохицуулалт аль алиныг нь нэг институтэд төвлөрүүлсэн “Нэгдсэн” зохицуулалт эсхүл дээрх 2 чиг үүргийг хоёр тусдаа институтэд хуваарилсан “Хосолмол” загваруудыг сонгож байна.

Санхүүгийн зохицуулалт, хяналтын хэлбэрт анх функционал болон институционал хэлбэр зонхилдог байсан. Өөрөөр хэлбэл санхүүгийн зах зээлд оролцогч байгууллагуудыг салбараар нь хуваан зохицуулах хандлага давамгайлдаг бөгөөд банк, даатгал, үнэт цаас гэсэн санхүүгийн 3 үндсэн салбарыг өөр өөр байгууллага хянаж, зохицуулдаг байсан.

Энэхүү загварын давуу тал нь салбар бүрийн хүрээнд илүү сайн хянаж, тухайн зохицуулалтынхаа хүрээнд үйл ажиллагаагаа явуулж буй эсэхийг хянах боломжтой байсан хэдий ч санхүүгийн байгууллагууд өөр хоорондоо төдийлөн холбогдож эхлээгүй байсан үед хөгжиж байсан загвар юм.

Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, хяналтын хэлбэрт гарсан анхны томоохон өөрчлөлт нь интегрэйтэд буюу нэгдсэн зохицуулалтын загвар анх гарч ирэхээс эхлэлтэй. Уг загвар нь санхүүгийн бүхий л оролцогчдын хяналт, зохицуулалтыг нэг байгууллагад төвлөрүүлэх загвар юм. Санхүүгийн нэгдэл компаниуд үүсэн бий болж, тэдгээрийг үр ашигтай хянаж зохицуулах шаардлага бий болсноор тус зохицуулалтын хэлбэр гарч ирсэн түүхтэй. Хамгийн анхны санхүүгийн салбарын нэгдсэн ганц зохицуулагч байгууллага Сингапур Улсад 1984 онд үүсэж бий болсон бол дараа нь Норвеги (1986), Дани (1988), Швед (1991) зэрэг Скандинавын орнууд авч хэрэгжүүлснээр дэлгэрсэн байна. Гэхдээ энэхүү загвар луу 1997 онд дэлхийн санхүүгийн зах зээлийн төвүүдийн нэг болох Их Британи Улсад FSA буюу Санхүүгийн үйлчилгээний зохицуулагч байгууллага шилжсэнээр алдартай болсон.

Санхүүгийн хяналтын дараагийн томоохон урсгал нь хосолмол загвар бөгөөд 1997 онд Австрали Улс санхүүгийн салбартаа хэрэгжүүлснээр бий болсон. Энэхүү загвар нь санхүүгийн салбаруудын хяналтыг нэг байгууллагад төвлөрүүлдгээрээ нэгдсэн загвартай төстэй хэдий ч зохицуулалтын чиг үүргийг 2 тусдаа байгууллагад хуваарилан хэрэгжүүлдгээрээ онцлог юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн салбарын зохистой бодлого, тогтвортой байдлыг дэмжих чиг үүрэг бүхий нэг байгууллага салбарын оролцогч байгууллагуудын бизнесийн үйл ажиллагаанд хяналт, зохицуулалт тавьдаг нэг байгууллага байна гэсэн үг юм. Санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадварыг хянах болон хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах гэсэн хоёр төрлийн үйл ажиллагаанаас үүсдэг ашиг сонирхлын зөрчилдөөнийг шийдэж өгснөөрөө энэхүү загвар давуу талтай.

Хямралын дараах санхүүгийн зохицуулалтын хэлбэрүүд

Санхүүгийн зах зээлийн хямралын дараагаар улс орнууд салбарын зохицуулалтын хэлбэрээ өөрчлөх хандлага ажиглагдаж эхэлсэн бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын байгууллагаас хийсэн судалгаанд хамрагдсан 79 улсын 11 нь зохицуулалт, хяналтын загвараа өөрчилсөн байна.

Хямралын өмнө нийт 79 улсын 46 нь функционал болон институционал хяналт, зохицуулалтын тогтолцоонд хамаарагддаг байсан бол үүнээс 3 нь санхүүгийн зохицуулагч байгууллагад төвлөрсөн нэгдсэн зохицуулалт, 1 нь төв банканд төвлөрсөн нэгдсэн зохицуулалт, 1 нь хосолмол зохицуулалт, 2 нь 2 агент бүхий хэсэгчлэн нэгтгэсэн зохицуулалтад шилжсэн байна.

Өөрөөр хэлбэл судалгаанд хамруулсан 79 улсын 11 нь санхүүгийн зохицуулалтын хэлбэрээ хямралын дараагаар өөрчилсөн бөгөөд үүний дийлэнх нь буюу 7 нь функционал болон институционал хандлагаас өөрчлөгдөн бусад хэлбэр рүү шилжсэн байна. Харин уг 7-гийн 5 нь банк, даатгал, хөрөнгийн зах зээлийн хяналт, зохицуулалтыг нэг дор төвлөрүүлсэн буюу салбар бүрээр тусдаа зохицуулдаг байсан хэлбэрийг өөрчилжээ.

Хүснэгт 2. 6. Санхүүгийн хямралын дараагаар санхүүгийн салбарын зохицуулалтын загваруудад гарсан өөрчлөлт

Санхүүгийн салбарын зохицуулалтын загваруудад гарсан өөрчлөлтүүд							
Өмнөх	Одоо	Одоогийн байдал					Өмнөх нийт
		Функционал болон Институционал	Төв банканд төвлөрсөн нэгдсэн зохицуулалт	Санхүүгийн зохицуулагч байгууллагад төвлөрсөн нэгдсэн зохицуулалт	Хосолмол зохицуулалт	2 агент бүхий хэсэгчлэн нэгтгэсэн зохицуулалт	
Функционал болон Институционал		39	1	3	1	2	46
Төв банканд төвлөрсөн нэгдсэн зохицуулалт		0	6	0	0	0	6
Санхүүгийн зохицуулагч байгууллагад төвлөрсөн нэгдсэн зохицуулалт		0	2	11	2	0	15
Хосолмол зохицуулалт		0	0	0	5	0	5
2 агент бүхий хэсэгчлэн нэгтгэсэн зохицуулалт		0	0	0	0	7	7
Одоогийн нийт		39	9	14	8	9	79
Нийт өөрчлөлт				11			

Эх сурвалж: Financial Stability Institute

Дээрх судалгаанд хамрагдсан 79 улсын санхүүгийн зохицуулалтын хэлбэрийг бүс нутгаар нь ангилан харвал 2017 оны байдлаар дараах дүр зурагтай байна. Эдгээр улсуудын 30 орчим хувь нь

нэгдсэн зохицуулалтын хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд Европын улсууд илүү түлхүү ашиглах хандлагатай байна. Харин нэгдсэн зохицуулалт дундаа санхүүгийн зохицуулагч тусдаа байгууллагад төвлөрсөн хэлбэр нь илүү түгээмэл байгаа нь харагдаж байна. Мөн 10 хувь нь хосолмол хэлбэрийн зохицуулалтын загварыг ашиглаж байгаа бөгөөд Их Британи, Австрали зэрэг санхүүгийн зах зээлийн хөгжлөөр тэргүүлэгч улсууд багтаж байна. Уламжлалт хэлбэрийн институционал болон функционал хэлбэрийн зохицуулалттай улс орнууд 50 орчим хувийг эзэлж буй бөгөөд Африк, Ази Номхон далайн орнууд, Ойрхи Дорнодын улс орнууд тус хэлбэрийн зохицуулалтыг ихээр ашиглаж байна.

Хүснэгт 2.7. Санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэрүүд, бүс нутгаар

Санхүүгийн хяналтын загварууд, бүс нутгаар												
	Африк		Америк		Ази, Номхон далайн		Европ		Ойрхи Дорнод		Нийт	
Функционал болон институционал	9	100%	9	52%	7	50%	10	30%	4	66%	39	50%
Төв банканд төвлөрсөн нэгдсэн зохицуулалт	0	0%	1	6%	2	14%	5	15%	1	17%	9	11%
Санхүүгийн зохицуулагч байгууллагад төвлөрсөн нэгдсэн зохицуулалт	0	0%	1	6%	2	14%	11	33%	0	0%	14	18%
2 агент бүхий хэсэгчлэн нэгтгэсэн зохицуулалт	0	0%	3	18%	1	8%	4	12%	1	17%	9	11%
Хосолмол зохицуулалт	0	0%	3	18%	2	14%	3	10%	0	0%	8	10%
	9	100%	17	100%	14	100%	33	100%	6	100%	79	100%

Эх сурвалж: Financial Stability Institute

Санхүүгийн зохицуулалтын хэлбэрт нөлөөлж буй хүчин зүйлс

Улс орнуудын хувьд санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэр нь санхүүгийн зах зээлийн онцлогоос хамааран ялгаатай байна. Санхүүгийн зах зээлд салбаруудын эзлэх хувь нь төдийлөн зөрүүгүй улс орнуудын хувьд институционал эсхүл функционал зохицуулалтын хэлбэрийг ашиглаж байгаа бол банкны салбар давамгайлсан бүтэцтэй жижиг зах зээл бүхий улсуудын хувьд нэгдсэн зохицуулалт, хяналтын загварыг сонгож байгаа нь түлхүү ажиглагдаж байна.

Эдийн засгийн хэмжээ нь мөн санхүүгийн салбарын зохицуулалтын хэлбэрт нөлөөтэй байх хандлага ажиглагдаж байгаа бөгөөд эдийн засгийн хэмжээ бага байх тусам нэгдсэн зохицуулалтын загварыг ашиглах төлөвтэй байна. Учир нь санхүүгийн хяналт зохицуулалтыг нэг дор төвлөрүүлэх нь эдийн засгийн хувьд илүү зардал багатай, өгөөж өндөртэй юм. Нөгөө талаас санхүүгийн салбар, хяналт, шалгалтын чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин жижиг улсуудын хувьд харьцангуй цөөн байх тул тэдгээрийг нэг зохицуулалтын байгууллагад төвлөрүүлэн ажиллах нь илүү үр ашигтай байдаг байна.

Харин улс орнуудын хуулийн системийг харгалзан үзвэл ХБНГУ болон Скандинавын хууль зүйн системтэй ижил төстэй “Иргэний хууль” суурь бүхий системтэй бол зохицуулалтын нэгдсэн тогтолцоотой байх хандлага ажиглагдаж байна.

Сүүлийн 20 жилийн хугацаанд Европын холбооны ихэнх улсын санхүүгийн салбарын зохицуулалтын хэлбэр өөрчлөгдсөөр байгаа бөгөөд ихэнх улс нь банк, даатгал, үнэт цаасны зах зээлийг хариуцсан тусдаа байгууллага бүхий загвартай байсан бол тус бүс нутгийн санхүүгийн салбарт гарч буй өөрчлөлтүүд энэхүү бүтэц хуучирч байгааг харуулж байгаа юм. Санхүүгийн салбарууд өөр хоорондоо улам бүр холбоо хамааралтай болон хөрвөж байгаа бөгөөд банкууд зээл гаргах, хадгаламж татах зэрэг үйл ажиллагаатай давхар хөрөнгө оруулалтын сан, андеррайтер зэрэг үнэт цаасны салбарын үйл ажиллагааг эрхэлж байна. Банк болон даатгалын компаниуд санхүүгийн нэгдэл болоод зогсохгүй санхүүгийн бүтээгдэхүүнүүд хүртэл бие биеэ орлохуйц болсоор байна. Санхүүгийн салбаруудыг зааглах зураас бүдгэрэхийн зэрэгцээ салбар дагнасан хяналтын загварууд гарч ирж байгаа юм.

Санхүүгийн нэгдэл буюу банк, даатгал зэрэг санхүүгийн байгууллагуудын нэгдэл нь Европын банк болон даатгалын салбарын гуравны нэгийг нь бүрдүүлж байна. Нэгдсэн хяналттай байх нь эдгээр нэгдлийг хянах хамгийн зохистой хэлбэр болно хэмээн бодлого гаргагчид үзэх болжээ.

Дараах хүснэгтэд санхүүгийн нэгдлүүд Европын холбооны томоохон улсуудын банк болон даатгалын салбарт эзлэх хувь болон хяналтын загварын хэлбэрийг харууллаа. Хүснэгтээс харахад Европ тивийн томоохон эдийн засаг бүхий улс орнуудын дийлэнх нь санхүүгийн салбарын хяналтыг ямар нэгэн байдлаар нэгтгэсэн байна. Харин эдгээр сонгосон улсаас зөвхөн нэг улс нь функционал хэлбэрийн байгаа нь Испани Улс бөгөөд тус улсын банк даатгалын санхүүгийн нэгдлүүдийн салбартаа эзлэх хувь нь харгалзан 4, 3 хувь байгаа бөгөөд бусад улстайгаа харьцуулахад хамаагүй бага байна.

Хүснэгт 2. 8. Европын холбооны улсуудын санхүүгийн нэгдлийн банк, даатгалын салбарт эзлэх хувь

Улс	Банк	Даатгал	Загвар
	2015	2015	2015
Австри	24%	37%	Нэгдсэн + төв банкны оролцоотой
Бельги	40%	22%	Хосолмол
Дани	43%	17%	Нэгдсэн
Финланд	19%	82%	Нэгдсэн + төв банкны оролцоотой
Франц	88%	22%	Хосолмол
Герман	27%	28%	Нэгдсэн + төв банкны оролцоотой
Итали	19%	47%	Хосолмол
Мальта	15%	0%	Нэгдсэн
Нидерланд	17%	59%	Хосолмол
Испани	4%	3%	Функционал
Швед	45%	27%	Нэгдсэн
Их Британи	10%	17%	Хосолмол

Нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоонд шилжих шалтгаан

Дэлхийн банкнаас 2003 онд гаргасан санхүүгийн зохицуулалтын хэлбэрийн түүвэр судалгааны үр дүнгээс харахад 2002 оны эцэст дэлхийн нийт орнуудын дор хаяж 46 нь ямар нэгэн хэлбэрээр санхүүгийн зохицуулалтын нэгдсэн болон хэсэгчилсэн байдлаар нэгдсэн зохицуулалтын загварыг ашиглаж байжээ. Зохицуулалтын нэгдсэн загварыг ашиглаж буй улсуудын хувьд нэг хяналт, зохицуулалтын байгууллагатай байснаар санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүхий л байгууллагын эрсдэлийг хянаж, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангаж ажиллах боломжтой гэж үздэг. Хяналтыг нэгтгэснээр байгууллага тус бүрд тулгарч буй эрсдэлээс гадна санхүүгийн нэгдэл, цаашлаад санхүүгийн системд тулгарах эрсдэлүүдээс урьдчилан сэргийлж чадна гэж үзсэн байна. Үүнээс гадна хяналтын систем нь нэг байгууллагад төвлөрсөн байх нь зохицуулалтын асуудал үүсэхэд хариуцлага хүлээх байгууллага нь тодорхой байдаг. Мөн санхүүгийн нэгдэл групп компаниудыг хянахад илүү хялбар юм.

Зарим судлаачдын үзэж байгаагаар зохицуулагч, хяналтын байгууллагууд нь салбарын оролцогч байгууллагатайгаа ижил бүтэцтэй байх нь үр дүнтэй гэж үздэг. Хэрвээ аливаа улсын санхүүгийн салбар нь “universal banking” буюу банкууд нь санхүүгийн төрөл бүрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх хандлагатай болж байгаа бол нэгдсэн хяналтыг нэвтрүүлэх нь санхүүгийн салбар болгоныг хянах олон тооны хяналтын байгууллага байхаас илүү үр дүнтэй.

Түүнчлэн санхүүгийн салбарын бүтээгдэхүүнүүд бие биенээ орлох эсвэл төстэй шинж чанартай болж байгаа нь зохицуулалтын байгууллагууд тэдгээрийг банк, даатгал, үнэт цаасны салбарын бүтээгдэхүүн гэж ангилахад төвөгтэй болгодог. Жишээ нь даатгалын компаниуд хугацаатай хадгаламжтай төстэй бүтээгдэхүүн, үйлчилгээтэй. Үнэт цаасны компаниудын гаргаж болох зээлийн дериватив нь даатгалын хэд хэдэн шинжийг агуулсан байх гэх мэт. Эдгээр салбарын бүтээгдэхүүний ялгаа багасгах тусам эдгээр бүтээгдэхүүнтэй холбоотой эрсдэлийг удирдах, хянах боломжууд нь салбар тус бүрийн хяналтын байгууллагуудад хүндрэл учруулдаг ба хяналтын байгууллагууд өөрийн хариуцаж буй салбараас гадуурх хяналтыг хийх шаардлагыг үүсгэдэг.

Зах зээл дэх төрийн оролцоог багасгах, чөлөөт эдийн засгийг хөгжүүлэх, салбарт технологийн дэвшил гарах зэрэг томоохон өөрчлөлтүүдийн улмаас санхүүгийн байгууллагууд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх шаардлагаар дотоодын болон гадаадын бусад байгууллагатай нэгдэж улмаар санхүүгийн нэгдлийн тоо өсөх болсон. Санхүүгийн нэгдлийн тоо нэмэгдэж байгаа нь салбар тус бүрийн хяналтын байгууллагад учирч буй өөр нэгэн асуудал юм. Санхүүгийн байгууллагууд томорч, илүү цогц хэлбэртэй болж байгаагаас гадна ихэнх салбарт үйл ажиллагаагаа явуулж байгаа нь томоохон эрсдэлийг дагуулдаг. Иймээс дээрх асуудлуудыг нэгдсэн зохицуулалтын загварыг нэвтрүүлснээр шийдэх боломжтой гэж үздэг.

Үүнээс гадна энэхүү загварыг нэвтрүүлснээр хяналтын олон байгууллагатай үед үүсдэг (1) зохицуулалтын дүрэм, журам, хуулийн цоорхойг ашиглах; (2) байгууллагуудын хооронд зохицуулалт хяналтын зөрүү үүсэх; (3) санхүүгийн хяналтын байгууллагуудын хоорондын харилцаа, уялдаа холбооны сул байдал; (4) хариуцлага хүлээх байдал сул байх зэрэг асуудлуудыг шийдэх боломжтой.

Дээрх давуу талуудтай холбоотойгоор төвлөрсөн хяналтын нэг байгууллагын хэлбэрт шилжсэн 15 улсын хяналтын байгууллагаас авсан судалгааны үр дүнг дараах хүснэгтэд харуулья.

Хүснэгт 2. 9. Улс орнуудын нэгдсэн зохицуулалтын загварт шилжих болсон шалтгаан

Нэгдсэн загварт шилжих болсон шалтгаан			
№	Шалтгаан	Тоо	Хувиар
1	“Universal banking” хэлбэрт шилжиж буй санхүүгийн салбарын хяналтыг сайжруулах	14	93%
2	Өргөжилтийн үр өгөөжийг нэмэгдүүлэх	12	80%
3	Хяналтын байгууллагуудын хоорондох харилцаа, уялдаа, холбооны сул байдлыг сайжруулах	4	27%
4	Санхүүгийн байгууллагуудын хяналт, зохицуулалтын зөрүүг арилгах, хариуцлага хүлээх нэг байгууллагатай байх	3	20%
5	Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын бүтцийг шинэчлэх, сайжруулах	3	20%
6	Санхүүгийн салбарын зохицуулалт, хяналтад тулгарч буй бусад саад бэрхшээлийг давах үүднээс	2	13%

Эх сурвалж: Дэлхийн банк

Судалгаанд хамрагдсан улс: Австрали, Канад, Дани, Эстони, Унгар, Исланд, БНСУ, Латви, Люксембург, Мальта, Мексик, Норвеги, Сингапур, Швед, Их Британи

Судалгаанд хамрагдсан бараг бүх улс санхүүгийн нэгдлийн тоо нэмэгдэж байгаа мөн банк, үнэт цаас, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээнүүдийн хоорондын ялгаа багассаар байгаатай холбон тэдгээрийг хянах шаардлагаар зохицуулалтын нэгдсэн загварт шилжих болсон гэж хариулсан байна.

Санхүүгийн хяналт, зохицуулалтын нэгдсэн хэлбэрт шилжихэд үүсэх боломж, бэрхшээл

Банк, үнэт цаас болон даатгалын бүтээгдэхүүн хоорондын ялгаа тодорхойгүй байснаар зохицуулагчид эдгээр бүтээгдэхүүнүүдийн эрсдэлийг үр дүнтэй хянаж чадах эсэх нь тус тусдаа зохицуулагч байгууллага бүхий санхүүгийн хяналтын тогтолцоотой улсуудын хувьд эргэлзээтэй болж эхэлдэг.

Санхүүгийн групп компаниудын тоо нэмэгдэж байгаа нь улс орны зохицуулагч байгууллагуудад томоохон бэрхшээлийг учруулж байна. Учир нь санхүүгийн байгууллагууд илүү том мөн нарийн төвөгтэй болж ирэхийн зэрэгцээ санхүүгийн системийн ихэнх салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нь эрсдэлийг хянахад илүү хүндрэл үүсгэсэн.

Дээр дурдсан бэрхшээлүүдэд хариу арга хэмжээ авахын тулд бүхий л санхүүгийн салбарт оролцогсдыг хамарсан нэгдсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх нь санхүүгийн салбар хоорондын эрсдэлийг удирдах мөн системийн тогтвортой байдалд учирч болзошгүй аюулд хариу арга хэмжээ авах тал дээр олон зохицуулагчтай байхаас илүү үр дүнтэй байхыг нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог санал болгогчид үзэж байна. Санхүүгийн системийн хяналт шалгалтыг нэгдсэн нэг байгууллагад төвлөрүүлснээр зохицуулагч байгууллага дараах зүйлсийг гүйцэтгэх боломжтой. Үүнд:

- Ялгаатай санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн салбарууд хоорондоо эрсдэлээ шилжүүлэх үйл явцыг илүү ойлгох, хянах;
- Зах зээл, эдийн засгийн тогтворгүй байдал, цахим худалдааны хөгжил дэвшил, хүн ам зүйн өөрчлөлт, инфляцын түвшин буурах зэрэг санхүүгийн системд нөлөөлөх зах зээлийг бүхэлд нь хамарсан болон салбарын хэмжээний асуудлуудын бүхий л салбарт үзүүлэх бодит болон боломжит нөлөөллийг илүү сайн судлах;

- Санхүүгийн групп компаниудын салбар хоорондын бизнесийн үйл ажиллагааг илүү сайн ойлгох;
- Санхүүгийн групп компаниуд болон түүний харьяа аж ахуйн нэгжүүдэд учрах эрсдэлийг шийдвэрлэх бодлогын арга хэмжээг боловсруулахад дөхөм байх;
- Санхүүгийн байгууллагын хэлбэрээс үл хамааран санхүүгийн ижил төстэй бүтээгдэхүүн үйлчилгээг хянах үр дүнтэй аргачлалыг боловсруулах зэрэг болно.

Үүнээс гадна, олон зохицуулагч байгууллагуудаар зохицуулагдах үед гарч байдаг зарим саад тогторыг бууруулдагаараа нэгдсэн хяналт, зохицуулалтын систем нь олон зохицуулагчтай системээсээ давуу байдаг. Тухайлбал:

- Хяналт, зохицуулалтын тодорхой бус байдал;
- Хяналт, зохицуулалтын цоорхой;
- Санхүүгийн зохицуулагч байгууллагууд хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагаа сул байх;
- Зохицуулагч байгууллагуудын хяналт, зохицуулалт сул байх зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоо нь илүү үр дүнтэй байдаг.

Нэгдсэн зохицуулагчид өөрт байгаа мэдээлэл, нөөц бололцоогоо илүү хурдан, үр дүнтэй байдлаар ашиглах боломжтой. Түүнчлэн нэгдсэн зохицуулагч нь хяналт зохицуулалтын асуудлаар хандах цорын ганц байгууллага нь болдог учраас хяналт, шалгалтын цоорхой үүсэхээс урьдчилан сэргийлэх үүрэг хүлээдэг.

Мөн санхүүгийн зохицуулагч байгууллагуудыг нэгтгэснээр зардлыг багасгаж бүтээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Цаашлаад боловсон хүчнийг нэгтгэснээр удирдлагын зүгээс хамгийн сайн хүмүүсийг хамгийн хэрэгцээтэй нөхцөлд ажиллуулах нь үр ашгийг дээшлүүлэх боломжтой. Үүний зэрэгцээ санхүүгийн байгууллагуудын зохицуулагч байгууллагуудад тайлагнах мэдээллийн хэмжээг бууруулах боломжтой.

Өөр өөр зохицуулагч байгууллагуудыг нэгтгэх үйл явц зөв зохион байгуулагдаагүй тохиолдолд туршлагатай боловсон хүчнийг авч үлдэж чадахгүй байх, бусад ажилтнуудын цаашид ажиллах урам зоригийг мохоох эрсдэлтэй байдаг. Түүнээс гадна, нэгдсэн том зохицуулагч нь хэт хүнд сурталтай байвал хариу үйлдэл үзүүлэх үйл явц удаашрах аюултай.

Шинээр бий болсон нэгдсэн хяналт, зохицуулалтын систем нь санхүүгийн салбарын уялдаа холбоог хангасан дүрэм журмын тогтолцоог боловсруулж чадаагүй тохиолдолд үр ашигтай хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжгүй болох эрсдэлтэй. Зохицуулалтын цоорхойг арилгахын тулд банк, үнэт цаас болон даатгалын зохицуулагч хоорондын уялдаа холбоог хангах нь зүйтэй боловч, салбар тус бүрийн онцлог шинж чанарыг таних нь чухал. Нэгдсэн хяналт, зохицуулалтын систем нь санхүүгийн зохицуулалтын чанарыг бүрэн хангах тогтолцоог боловсруулж чаддаггүй. Тухайлбал, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах болон банкны системийн тогтвортой байдлыг хангах үүрэг бүхий банкныг зохицуулагч байгууллага нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоонд давамгайлах үүрэг гүйцэтгэж буй тохиолдолд үнэт цаасны салбарыг зохицуулахад бэлэн бус байх хандлагатай. Мөн буурай хөгжилтэй хөрөнгийн зах зээлтэй улсын тус зах зээл хөгжих хангалттай уян хатан нөхцөл бүрдэхгүй байх сул талтай.

Нэгдсэн хяналт, зохицуулалтын бас нэгэн сул тал бол зарим улс орнууд тус системийг хэрэгжүүлэхэд бэлтгэгдээгүй байдаг. Хэрэв тусдаа зохицуулагчдын хүрээнд санхүүгийн зохицуулалт сул байдаг тохиолдолд нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоо мөн сул байх хандлагатай.

Өөр өөр зохицуулагчид хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой улс орнуудын хувьд нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоог хэрэгжүүлэх нь хамгийн оновчтой шийдвэр биш байж болох юм. Эдгээр зорилгод хүрэх өөр үр дүнтэй аргууд байдгийн нэг нь тусгай хороог байгуулах явдал. Уг хороо нь зохицуулагчдын бодлого боловсруулагчдаас бүрдэх бөгөөд тогтмол хугацаанд уулзаж холбогдох мэдээ мэдээллийг солилцдог байна. Үүнээс гадна үр дүнтэй хамтын ажиллагаа нь харилцан ойлголцлын санамж бичиг байгуулснаар хэрэгжих боломжтой. Зарим тохиолдолд санхүүгийн групп байгууллага дампуурах зэрэг асуудлыг шийдвэрлэхэд 2 болон түүнээс дээш зохицуулагч оролцож байгаа тохиолдолд аль нэг зохицуулагчийг “тэргүүлэх” үүрэгтэй оролцох боломжийг зарим улс орны хууль эрх зүйн орчны хүрээнд олгодог байна. Эцэст нь зохицуулагч байгууллагуудыг нэгтгэн нэгдсэн зохицуулагч байгууллагыг байгуулах нь эдийн засгийн үр ашигтай байдлыг бий болгохгүй.

Санхүүгийн хяналт зохицуулалт дахь төв банкны оролцоо

1990–ээд оны дунд үеэс эхлэн санхүүгийн системд бүтцийн өөрчлөлт тохиож салбарын хяналт, зохицуулалт нь зах зээлтэйгээ уялдах зорилгоор санхүүгийн салбараар эсхүл бизнесийн үйл ажиллагааны төрлөөр хуваагдаж байснаа болин нэгдэж, нийлэх хандлага ажиглагдаж эхэлсэн. Уг асуудалтай зэрэгцэн санхүүгийн салбарын хяналт, зохицуулалт дахь төв банкны оролцооны талаар маргаан үүсэх болсон.

Улс орнууд санхүүгийн салбарын хяналтыг төв банканд олгосноор эдийн засаг болон санхүүгийн салбарын бодлогыг нэг байгууллагад хариуцуулан эрх мэдлийн хэт их төвлөрөл үүсэж болзошгүй хэмээн үзэж төв банкаас санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын үүргийг салгаж эхэлсэн. Melesky болон Podriera нарын 2012 онд гаргасан судалгаагаар 1999–2010 оны хооронд санхүүгийн зах зээл нь хөгжсөн улс орнуудын хяналт, зохицуулалт дахь төв банкны оролцоог багасгаж, хяналт, зохицуулалтын бие даасан бүтцийг бий болгох тохиолдол нь бүх зохицуулалтыг дан ганц төв банкандаа төвлөрүүлснээс их байжээ.

Харин санхүүгийн зах зээлийн хямралын дараагаар зохицуулалт, хяналтын тогтолцоонд гарсан доголдлыг засах зорилгоор санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх үүргийг төв банканд олгох хувилбарыг илүүд үзэж эхэлсэн байна. Мөн макро зохистой хяналт, бодлогын эрх мэдлийг шууд төв банканд эсхүл төв банк, санхүүгийн зохицуулагч байгууллага, Засгийн газрын хамтарсан зөвлөлд олгох хувилбарууд ч мөн гарч эхэлсэн.

Санхүүгийн зохицуулалтын хэлбэрээс гадна санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалт, бодлого үйл ажиллагаанд төв банкны оролцооны түвшин нэлээдгүй маргаан үүсгэдэг бөгөөд санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын бүхий л эрх мэдлийг төв банканд олгосон эсхүл уг чиг үүргийг санхүүгийн зохицуулагч бие даасан байгууллагад хуваарилсан зэрэг олон жишээ байдаг бөгөөд уг 2 хэлбэрийн аль нь илүү тохиромжтой хувилбар болох тал дээр судлаач, бодлого гаргагчид санал нэгдээгүй байна. Өөрөөр хэлбэл төв банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэг дээрээ санхүүгийн байгууллагуудын хянах үүргийг авах нь зөв үү эсхүл уг чиг үүргийг бие даасан санхүүгийн зохицуулагч байгууллагад шилжүүлэх нь зөв үү гэдэг нь ихээхэн чухал юм. Судалгааны ажлын энэхүү хэсэгт санхүүгийн салбарын хяналт зохицуулалтыг төв банканд төвлөрүүлснээр үүдэх давуу, сул тал болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангахад төв банкны үүрэг, оролцоог товч авч үзнэ.

Төв банк санхүүгийн хяналт, зохицуулалтын үүргийг хэрэгжүүлэхийг дэмжсэн аргумент

Арилжааны банкууд зөвхөн төлбөрийн системийн оролцогч гэсэн үүргээс гадна макро эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон үүргийг гүйцэтгэдэг зах зээлийн термометр юм. Макро эдийн засгийн хүндрэлүүд нь банкны системийн хөрвөх чадвар, төлбөрийн чадварт нөлөөлдөг бол банкны үйл ажиллагааны хүрээнд хүүгийн түвшин тодорхойлогдож, эдийн засгийн мөнгөн урсгал, оролцогч талуудын зээлийн санхүүжилтийг шийдвэрлэж байдаг учраас банкны салбар санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал хоёр нь нягт уялдаа холбоотой юм. Тийм учраас төв банк нь санхүүгийн зах зээлийг тэр дундаа арилжааны банкуудыг хянаж, зохицуулах нь зүйтэй гэж үздэг бөгөөд банкны зохицуулалтыг төв банкнаас тусдаа гаргаснаар макро эдийн засгийн тогтвортой байдалд хариуцлага хүлээдэггүй байгууллага уг салбарыг зохицуулах эсхүл эдийн засгийн бодлого тодорхойлогч нь банкны салбарын талаар нарийн мэдээлэл авч чадахгүй байх эрсдэл үүсдэг байна.

Мөнгөний бодлогын шилжих механизмд арилжааны банкууд чухал үүрэг, оролцоотойгоос гадна төв банк нь арилжааны банкуудын богино хугацааны санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, банкны хөрвөх чадварыг хангах зорилгоор интервенц хийх зэрэг арилжааны банкны төлбөрийн чадвар, хөрөнгийн чанарт шууд болон шууд бус байдлаар нөлөөлөх олон үйл ажиллагаа явуулдаг. Харин арилжааны банкууд нь санхүүгийн зах зээлд өндөр хувь эзэлдэг, санхүүгийн нэгдэл, групп компаниуд нь арилжааны банканд суурилдаг зах зээлийн хувьд банкны салбарын тогтвортой байдлыг хангах нь санхүүгийн салбарын тогтвортой байдалд чухал үүрэгтэй. Тийм ч учраас төв банк нь системийн өндөр ач холбогдол бүхий арилжааны банкуудын үйл ажиллагааны талаар илүү сайн мэдээлэлтэй байж чадсанаар эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг илүү сайн хангаж чадна гэж үздэг учир төв банканд салбарын хяналт, зохицуулалтын үүргийг өгөх хэрэгтэй гэж үздэг.

Санхүүгийн зохицуулагч байгууллага санхүүгийн хяналт, зохицуулалтын үүргийг хэрэгжүүлэхийг дэмжсэн аргумент

Төв банкны үндсэн үүрэг нь үнийн тогтвортой байдлыг хангах байдаг бөгөөд төв банкнаас хэрэгжүүлдэг мөнгөний бодлогын бие даасан байдал нь санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын үүргийг төв банкнаас салгах хамгийн том шалтгаан юм.

Төв банк нь арилжааны банкуудыг хянаж, зохицуулдаг байх тохиолдолд банкуудын хөрвөх чадвар болон төлбөрийн чадварыг хангах зорилгод нь банкируудын нөлөө орох, улмаар банкуудын үйл ажиллагааны тогтвортой байдалд хэт их анхаарал хандуулснаар мөнгөний бодлогын нөлөө сулрах, макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх чиг үүргээсээ илүүтэйгээр арилжааны банкуудыг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаа их явуулах эрсдэл үүсдэг. Улмаар банкуудын үйл ажиллагааг муудсан үед нь бодлогын хэрэгслийг ашиглан хүчээр хамгаалах бодлого хэрэгжүүлсэн тохиолдолд хямралыг улам бүр гүнзгийрүүлэх, түүнээс үүдэх зардлыг нэмэгдүүлэх өндөр эрсдэлтэй юм.

Хэдийгээр хяналт, зохицуулалтын эрхгүй төв банкны хувьд арилжааны банкуудын төлбөрийн чадварыг хангах үйл ажиллагаанд нь доголдол үүсэж болзошгүй хэдий ч мөнгөний бодлогын бие даасан байдал нь илүү чухал бөгөөд банкны системийн хүндрэл нь төв банкнаас арилжааны банкны төлбөрийн чадварыг хангах зорилгоор хэрэгжүүлдэг бодлого, үйл ажиллагаа суларснаас бус тухайн байгууллагын хөрөнгийн чанар, ил тод, шударга бус үйл ажиллагаанаас ихээхэн хамаардаг гэж төв банканд зохицуулалтын чиг үүргийг өгөх үзлийг эсэргүүцэгчид үздэг.

Түүнчлэн арилжааны банкуудын санхүүгийн нөхцөл байдалд шууд нөлөөтэй учраас төв банк нь мөнгөний бодлого хэрэгжүүлэх, бодлогын хүүгээ тогтоохдоо эдийн засгийн бодлого, нөхцөл байдлаас

илүүтэйгээр арилжааны банкуудын үйл ажиллагаанд хэт өндөр анхаарал хандуулан мөнгөний бодлогоо бие даан хэрэгжүүлэхэд саад учирдаг байна.

Мөн төв банк нь санхүүгийн зах зээлийн зохицуулалт хяналтыг нэг дор авснаар эрх мэдлийн хэт их төвлөрөл үүсэх бөгөөд санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал зөвхөн нэг байгууллагаас ихээхэн хамааралтай болсноор улс төрчид болон бизнесменүүдийн нөлөөнд амархан автах мөнгөний бодлого, хяналт, зохицуулалтын үүргийг давхар хэрэгжүүлснээр бодлогын болон шалгалтын үйл ажиллагааны үр ашигтай байдал сулардаг. Тухайлбал, Freytag болон Masciandro нарын судалгаагаар санхүүгийн салбарын хяналт, шалгалтын тогтолцоонд төв банк хэдий чинээ нөлөө ихтэй байна төдий чинээ уг зохицуулалтын хүч, үр ашигт байдал сулрах хандлагатай байна гэсэн дүгнэлтэд хүрчээ. Мөн Дэлхийн банк болон Олон Улсын Валютын Сангийн 2005 оны судалгаагаар ижил дүгнэлт гарсан ба хэрвээ нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоо үүссэн тохиолдолд тэр нь төв банкнаас тусдаа байгууллага байх хандлага их байна гэжээ.

Санхүүгийн зохицуулагч байгууллага, бодлого гаргагчдын хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулалт, хяналтын аль ч хэлбэрийн тогтолцоотой байсан гэсэн салбарын зохицуулагчид, бодлого гаргагчдын хамтын ажиллагаа, мэдээллийн чөлөөтэй урсгал чухал ач холбогдолтой юм. Хэдийгээр бодлого гаргагчид зохицуулалтын байгууллагуудын хамтын ажиллагааны ач холбогдлыг мэддэг хэдий ч тэдгээрийг хангаж ажиллах, бодит амьдрал дээр үр дүнтэй хэрэгжүүлэх нь санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын бас нэгэн том сорилт юм.

Санхүүгийн зах зээлийн хөгжлөөр тэргүүлэгч улс болох АНУ нь Холбооны нөөцийн банк (Federal Reserve), Үнэт цаасны хороо (SEC), Сангийн яам (Treasury), Таваарын фьючерс арилжааны хороо (CFTC) зэрэг санхүүгийн салбарын зохицуулагчид, бодлого гаргагчдын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг (President's Working Group) 1987 оны хувьцааны зах зээлийн хямралын дараагаар байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг нь санхүүгийн зах зээлийн зохицуулалтын асуудлыг шийдвэрлэх, бодлого гаргахад хамтран ажилладаг. Үйл ажиллагааны цар хүрээ нь санхүүгийн зах зээлийн системийн эрсдэлийг бууруулах, зах зээлийн уялдаа холбоог хангах, хэрэглэгч, хөрөнгө оруулагчдыг хамгаалах болон хөрөнгийн зах зээлийн үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн үндсэн 4 чиглэлийг хамардаг. Мөн санхүүгийн зохицуулагч байгууллагууд нь тус тусын үүрэгт илүү анхаарал хандуулан зах зээл, эдийн засгийг бүхэлд нь хамруулан бодлогоо тодорхойлох тал дээр сул тал ажиглагддаг тул уг зохицуулалт, бодлогын орон зайг нөхөх зорилгоор АНУ-ын зохицуулалтын байгууллагууд өөр хоорондоо харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан ажиллах тохиолдол их байдаг.

Хонконг Улсад мөн Төв банк (HKMA), Үнэт цаас фьючерсийн хороо (SFC), Даатгалын хороо (OCI), Хонконгийн тэтгэврийн сан (MFSA) зэрэг байгууллагууд зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, мэдээллийн солилцоо болон харилцан туслалцааг нэмэгдүүлэх зорилгоор харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулан ажилладаг. Мөн тус улсад 2 төрлийн дээд хэмжээний зөвлөл ажилладаг бөгөөд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл нь банк, үнэт цаас, деривативын зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиглэлд, Санхүүгийн зохицуулагчдын зөвлөл нь зохицуулагч байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлд ажилладаг.

Испани, Франц, Мексик зэрэг улсуудын хувьд мөн адил Төв банк, Санхүүгийн зохицуулагч байгууллага, Сангийн яамны хамтарсан зөвлөл ажилладаг бөгөөд зохицуулалт, хяналтын байгууллагууд тус бүрийн шийдвэр гаргах эрх бүхий зөвлөлд мөн бусад байгууллагуудын төлөөллийг оролцуулах байдлаар үйл ажиллагаа явуулдаг байна.

Харин санхүүгийн салбар нь нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоо бүхий Их Британи Улсын хувьд санхүүгийн салбарын бодлого, зохицуулалт, хяналт шалгалтын үйл ажиллагааг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх нь хавьгүй амар хэдий ч санхүүгийн хямрал болон эдийн засгийн уналтын үеүдэд Төв банктайгаа нягт хамтран ажиллах шаардлага зайлшгүй тулгардаг.

Хяналт, зохицуулалтын тогтолцоо нь нэгдсэн хэлбэрийн байх нь санхүүгийн салбарт хяналт тавих, бодлого гаргахад илүү амар болох хэдий ч аль ч зохицуулалтын хэлбэрийг ашигладаг байлаа гэсэн Төв банк, Санхүүгийн зохицуулагч байгууллага, Сангийн яам зэрэг байгууллагуудын хамтын ажиллагаа хамгаас чухал тул улс орнууд ихэвчлэн санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах чиг үүрэг бүхий зөвлөл ажиллуулах, байгууллагуудын шийдвэр гаргах түвшинд бусад байгууллагуудын төлөөллүүдийг гишүүнээр ажиллуулах зэрэг байдлаар хамтын ажиллагааг үр дүнтэй байлгах чиглэлд ажиллаж байна.

ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын хувьд санхүүгийн зохицуулалтыг Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хороо хариуцан гүйцэтгэдэг бөгөөд институционал хэлбэр давамгайлсан санхүүгийн хяналт, зохицуулалтыг аргачлалыг ашигладаг. Монголбанк буюу төв банк нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхээс гадна арилжааны банкуудын үйл ажиллагааг хянаж, зохицуулан төлбөрийн системийг хянах үүргийг гүйцэтгэдэг бөгөөд одоогоор манай улсад 13 арилжааны банк үйл ажиллагаа явуулдаг.

Харин Санхүүгийн зохицуулах хороо нь банкнаас бусад санхүүгийн зах зээл болох хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчид, дэд бүтцийн байгууллагууд, даатгалын компаниуд, төлөөлөгч, зуучлагч, хохирол үнэлэгчид, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоод зэрэг нийт 2,433 санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй этгээдүүдийг хянаж зохицуулдаг.

Харин санхүүгийн зах зээлийн бодлого боловсруулалтад Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон Сангийн яам гэсэн төрийн эрх бүхий гурван байгууллага оролцдог. Эдгээр гурван байгууллага нь санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, дэд бүтэц бий болгох зэрэг асуудлаар бодлогын түвшинд ажлын хэсэг байгуулах, харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах эсвэл дундын бодлогын баримт бичиг батлах замаар хамтран ажилладаг.

Зураг 2. 1. Монгол Улсын санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалт



Санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах чиг үүрэг нь СЗХ болон Монголбанк аль алинд нь харьяалагддаг. Мөн Монголбанк, СЗХ, Сангийн яам, Хадгаламжийн даатгалын корпорацын гишүүнчлэлтэй Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл улирал тутам хуралдан, хамтарсан шийдвэр гаргах замаар санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хамгаалах чиглэлд хамтран ажилладаг.

Манай улсад 2013 оноос эхлэн Өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн ба СЗХ-ны хувьд мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааны гарын үсэг зурж, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэн ажиллаж байна. Өөрийгөө зохицуулах байгууллага нь зах зээлийн зуучлагчид буюу гишүүдийнхээ ёс зүйг сайжруулах, сургалт зохион байгуулах үндсэн үүрэгтэйгээр зохицуулалтын үйл ажиллагаанд оролцдог. СЗХ нь банкнаас бусад санхүүгийн зах зээл, үүн дээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон төлбөр тооцоог мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх үйл ажиллагааг хянан зохицуулах үүргийг шинээр хариуцдаг болсон.

Түүнчлэн санхүүгийн бус бизнесийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэгчид буюу үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийг СЗХ зохицуулахаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар СЗХ зохицуулж эхлээд байна.

Зохицуулалт, хяналт шалгалтын асуудлууд

Монгол Улсад санхүүгийн зах зээлийн банкны салбарыг Монголбанк, банкнаас бусад санхүүгийн зах зээлийг СЗХ зохицуулан, хяналт шалгалт хийдэг. 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр шинэчлэн батлагдсан Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтад банк, түүний хараат болон охин компани банкнаас бусад санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа эрхлэх эрхзүйн орчныг нэмж оруулснаар манай улсад санхүүгийн нэгдэл (financial conglomerates)-үүд үүсэж эхэлсэн.

Банкны салбар санхүүгийн зах зээлийн бусад салбарт үйл ажиллагаа явуулж эхэлснээр банк давамгайлсан санхүүгийн зах зээлээс олон тулгуурт тогтолцоо руу шилжих давуу талтай. Харин санхүүгийн нэгдлүүдийг зохицуулах, хяналт шалгалт хийх орчныг бий болгоогүй нөхцөлд санхүүгийн тогтвортой байдлыг ганхуулах сул тал үүснэ.


Санхүүгийн нэгдлүүд үүссэнээр тэдгээрийг удирддаг толгой компани нь зохицуулалтад ороогүй, түүнчлэн хөрөнгийн төвлөрөл нэмэгдэн, байгууллага хоорондын холбоо хамаарал гүнзгийрдэг. Ингэснээр санхүүгийн групп дэх охин, хараат компаниудын хоорондын хөрөнгийн шилжүүлгийн улмаас халдварлах эрсдэл үүсэж болдог. Санхүүгийн зохицуулагч байгууллагуудын тусдаа хяналт шалгалтын улмаас шинээр үүсэж буй уг зохицуулалтын хэлбэрийг хянах сул орон зай үүсээд байна.

Зохицуулалтын сул орон зайн улмаас үүсэж болох халдварлах эрсдэлийн хэмжээг санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийг ДНБ-д харьцуулсан байдлаар тооцоход 142.4 хувь буюу даруй ДНБ-ээс 1.5 дахин их тул эдийн засагт үзүүлэх нөлөө өндөртэйг илтгэж байна. Уг харьцааг салбар тус бүрээр харуулбал, арилжааны банк 133.7 хувь буюу хамгийн өндөр, банк бус санхүүгийн байгууллагууд 6.2 хувь, даатгалын салбар 1.4 хувь, хадгаламж зээлийн хоршоод 0.8 хувь, үнэт цаасны компаниуд 0.3 хувьтай байна.

Нөгөө талаас системийн эрсдэл нь оролцогчдын санхүүгийн зах зээлд итгэх итгэлийг алдагдуулдаг сөрөг талтай байдаг ба 2019 оны байдлаар санхүүгийн зах зээлийн банкны салбарт 2.4 сая хадгаламж эзэмшигч, үнэт цаасны 1,827,724 данс эзэмшигчид, ХЗХ-ны 70 мянган гишүүд, ББСБ-ын 419.9 мянган зээлдэгчид, 1,153,392 даатгуулагч иргэн санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлжээ.

Санхүүгийн нэгдлүүдийн хөрөнгийн төвлөрлийн хэмжээг мөн тооцоход 18 санхүүгийн нэгдлийн нийт хөрөнгө зах зээлийн 83 хувийг бүрдүүлж байна. Уг төвлөрлийг салбар тус бүр дэх нийт хөрөнгөд эзлэх хувиар харвал арилжааны банк 87 хувь, үнэт цаасны компаниуд 65 хувь, даатгалын компаниуд 59 хувь, хадгаламж, зээлийн хоршоо 42 хувь, банк бус санхүүгийн байгууллага 7 хувьтай гарлаа.

Зураг 2. 2. Санхүүгийн нэгдлүүдийн санхүүгийн зах зээлд эзлэх хувь, салбар тус бүрээр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн нэгдлүүдийн хөрөнгийн төвлөрөл ийнхүү өндөр байгаа тул системийг хамарсан эрсдэл тохиолдох үед санхүүгийн байгууллагууд бие биенийгээ татан унагах магадлал өндөртэйг илтгэж байна.

Зураг 2-т салбар бүрт эзэлж буй санхүүгийн нэгдлүүдийн хөрөнгийн төвлөрлийг харуулсан бол хүснэгт 10-т санхүүгийн нэгдэл тус бүрийн охин компаниудаараа дамжуулан үйл ажиллагаа явуулдаг салбарыг харуулав.

Хүснэгт 2. 10. Санхүүгийн нэгдлүүд

№	Санхүүгийн нэгдэл	Үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн салбар								
		Төлбөр, тооцоо	Агентлагийн үйлчилгээ	ХОМ	ҮЦК	Үнэт цаас итгэмжлэн удирдах	Арилжааны банк	Даатгал	ББСБ	ХЗХ
1	Худалдаа хөгжлийн банк	*	*		*		*			
2	Голомт фэйненшл групп	*	*	*	*		*	*	*	
3	Үндэсний хөрөнгө оруулалтын банк			*	*	*	*			
4	Тэнгэр санхүүгийн нэгдэл	*		*	*		*	*	*	
5	Ард санхүүгийн нэгдэл				*			*	*	*

6	Стандарт капитал				*				*	
7	Бодь групп			*			*	*	*	
8	Таванбогд групп	*	*				*		*	
9	“Миллениум секьюритис менежмент лимитед” ХХК						*	*		
10	Mongolian investment holding group /“Эф Эс Си Өү” ХХК/			*	*			*		
11	Улаанбаатар хотын банк						*			
12	Бишрэлт холдинг				*			*	*	
13	“Би ди сек” ХК				*				*	
14	“Кей Эйч Кей” ХХК							*	*	
15	Номин Холдинг							*	*	*
16	Мобиком Корпорац								*	

Дээрх хүснэгтээс харахад манай улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй 14 санхүүгийн нэгдэл охин компаниудаа удирддаг ба нэгдлийн толгой компани нь Хороо болон Монголбанкны аль ч зохицуулалтад хамаарагддаггүй нь асуудалтай. Үүнээс 4 санхүүгийн нэгдэл бие даасан толгой компанигүй, харин үлдсэн 10 нь арилжааны банк эсвэл үнэт цаасны компанийн охин компани хэлбэрээр ажиллаж байна.

Санхүүгийн нэгдэл нь дараах төрлийн эрсдэлүүдийг үүсгэснээр системийг доргиох хүндрэлд оруулдаг. Үүнд:

1. Зохицуулалтын сул орон зай /Regulatory consistency/ үүсэх;
2. Халдварлах нөлөө /Contagion or reputation effects/ үүсэх буюу санхүүгийн нэгдэл дэх аль нэг салбарын санхүүгийн хүндрэл нь бусад салбар луугаа халдварлах;
3. Санхүүгийн нэгдлийн хэмжээ ба төвлөрөл /Size and complexity of financial conglomerates/ нэмэгдэх. Санхүүгийн нэгдлийн хөрөнгийн хэмжээ томорч, төвлөрөл нэмэгдэх тусам ёс зүйн гажуудал нэмэгдэж, “Унахад хэтэрхий том” буюу үйл ажиллагааг зогсооход санхүүгийн зах зээлд томоохон сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл үүсэх зэрэг болно.

1990–ээд оноос Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага болон Олон улсын төлбөр тооцооны банкаас гаргасан зарчим, Японы санхүүгийн үйлчилгээний агентлагаас санхүүгийн нэгдлийг хянахад мөрдлөг болгодог гарын авлагад нийтлэг байдлаар толгой компани нь нэгдлийг хянах

засаглал, эрсдэлийн удирдлагын систем болон дотоод хяналтын тогтолцоотой байх, зохицуулалт, хяналт шалгалт хариуцсан байгууллага тухайн санхүүгийн нэгдлийн толгой компанийг хянадаг зохицуулалттай байхыг оруулсан.

Харин Монгол Улсад санхүүгийн нэгдлүүд 2011 оноос үүссэн ба одоогийн байдлаар Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо аль аль нь санхүүгийн нэгдлийг, түүний толгой компанид зохицуулалт хийгээгүй, цөөхөн тохиолдолд хамтран нэгдсэн хяналт шалгалтыг удирдамжийн дагуу хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, 2013 онд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Тэнгэр санхүүгийн нэгдлийн охин компани “Тэнгэр капитал ҮЦК” ХХК–д хамтарсан шалгалт, Монгол Улс Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улсуудын “саарал” жагсаалтад орсонтой холбоотой 2019 онд 46 санхүүгийн болон санхүүгийн бус нэгдлийн толгой, охин, хараат, зэргэлдээ компанид шалгалт хийж байсан.

Банкны тухай хуулийн 44 дүгээр зүйлд Банкны нэгдэлд хийх нэгдсэн хяналт шалгалтын харилцааг тусгасан байдаг. Үүнд банкны нэгдэлд хяналт шалгалт хийхэд тусгайлан баталсан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам хамтран хийх тухай зохицуулсан. Монголбанк банкны нэгдэлд хийх “Нэгдсэн хяналт шалгалтын журам”-ын төслийг 2018 онд боловсруулж, цахим хуудсаараа дамжуулан олон нийтээс санал авахаар байршуулсан ба уг журам батлагдаагүй.

Банкны тухай хуульд зөвхөн банкны нэгдлийн зохицуулалтыг тусгасан бол Даатгалын тухай хуулийн 61, 62 дугаар зүйлд даатгалын компанийн холбогдох этгээдэд шалгалт хийх тухай харилцааг тусгасан. Дээрх хоёр хуулийн зохицуулалтад арилжааны банк тухайн нэгдлийн охин, хараат компани биш тохиолдолд буюу банк багтаагүй санхүүгийн нэгдэл, санхүүгийн бус нэгдэлд хяналт шалгалт хийх хууль эрх зүйн орчин үүсээгүй байна.

Санхүүгийн зах зээлийн хувьд банкны, даатгалын салбарын хувьд нэгдлийн хэмжээний шалгалтыг хийх харилцаа тусгагдсан ба үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид, банк бус санхүүгийн байгууллагын салбар, хадгаламж, зээлийн хоршооны салбарын нэгдэлд багтах охин, хараат, зэргэлдээ компаниудын зохицуулалт, хяналт шалгалтын харилцаа хууль, эрх зүйн орчны гадна байна.

Түүнчлэн, манай улсад сүүлийн жилүүдэд финтек буюу санхүүгийн технологи хөгжиж эхэлж буйтай холбоотой зохицуулалтыг хэрхэн хийх тухай яригдах болсон. Үүн дээр СЗХ чиг үүргийн дагуу тусгай зөвшөөрөл олгож, хяналт тавих үүрэгтэй ч төлбөр тооцооны хяналтыг Монголбанкнаас хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нь зохицуулалтын давхардал бий болох эрсдэлийг үүсгэж байгаа юм.

Санхүүгийн хяналт, зохицуулалтын явцад үүсдэг өөр нэгэн асуудал нь газар дээрх шалгалтын үеэр тухайн санхүүгийн байгууллагын хөрөнгө (харилцах, хадгаламж, нөөц сан гэх мэт) бусад санхүүгийн байгууллагуудын дансанд байршдаг ба уг хөрөнгүүдийг хянах эрх СЗХ–нд хууль эрхзүйн орчны хувьд олгогдоогүй. Ингэснээр санхүүгийн зах зээл дээрх хөрөнгүүдийн хоорондын холбоо хамаарлыг тодорхойлж, хоорондоо хамаарал бүхий санхүүгийн байгууллагуудын эрсдэлийг эрт илрүүлэх боломж хязгаарлагдаж байгаа юм.

Нэгдсэн хяналт, зохицуулалтын тогтолцоонд шилжих эсхүл нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж эхлэх хэрэгцээ, шаардлага

Санхүүгийн нэгдлүүдийн хөрөнгийн хэт их төвлөрөл болон холбоо хамаарлын улмаас аливаа нэг нэгдэл дэх санхүүгийн компанийн үйл ажиллагаа доголдоход халдварлах нөлөөгөөр нэгдэл дэх бусад байгууллагууд болон зах зээл дээр үүсгэсэн гинжин хэлхээгээр дамжуулан санхүүгийн салбарыг бүхэлд нь унагах аюулыг дагуулдаг.

Уг системийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд санхүүгийн нэгдлүүдийг зохицуулах, хянан шалгах шинэ хувилбарыг боловсруулах шаардлага зайлшгүй үүсэж байна. Санхүүгийн нэгдлийг зохицуулах зорилго нь тэдгээрийн хэвийн үйл ажиллагааг хангуулснаар зах зээлийн хэвийн буюу тогтвортой байдлыг хамгаалах юм.

BIS, IOSCO, IAIS хамтран 1999 онд санхүүгийн нэгдлийг хянах зарчмыг баталж, 2012 онд дахин шинэчилснээр дараах байдалтай байна. Үүнд:

Санхүүгийн нэгдлийн үйл ажиллагааг хянах: Санхүүгийн нэгдэл дэх зохицуулалтад багтдаггүй байгууллагуудаас үүсэж болох эрсдэлийг тодорхойлохын тулд санхүүгийн үйл ажиллагааны болон үйл ажиллагааны бус холдинг компаниуд, зохицуулалтгүй толгой компани болон тэдгээрийн салбарууд, тусгай зориулалтын компанийг хянадаг болох.

Санхүүгийн нэгдлийн үүсгэж болох эрсдэлийг дараах хүрээнд авч үздэг. Үүнд:

- Шууд болон шууд бус оролцоо;
- Холбоо хамаарал;
- Эрсдэлийн төвлөрөл;
- Эрсдэлийн шилжилт;
- Сул эрсдэлийн удирдлага;
- Нэгдэл хоорондын хэлцэл;
- Стратегийн эрсдэл;
- Нэр хүндийн эрсдэл зэрэг болно.

Санхүүгийн нэгдлийг дараах байдлаар зохицуулж, хянан шалгадаг. Үүнд:

- Санхүүгийн зохицуулагч нь санхүүгийн нэгдлийн эрсдэлд суурилсан зохистой стандартыг хэрэгжүүлэх;
- Санхүүгийн нэгдэл дэх зохицуулалттай болон зохицуулалтгүй этгээдүүдийг хамарсан компанийн засаглалыг хэрэгжүүлэх;
- Тохиромжтой этгээдийг сонгох;
- Санхүүгийн нэгдлийг группийг хамарсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхийг шаардах;
- Нэгдлийг бүхэлд нь хамарсан хөрвөх чадварын, эрсдэл даах чадварын бодлоготой байхыг шаардах;
- Шинэ бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд эрсдэлээ үнэлэхийг шаардах;
- Стресс тест болон сценарь шинжилгээ хийхийг шаардах;
- Балансын гадуурх данс хөтлөхийг тус тус шаардах шаардлагатай.

Монгол Улсын санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн болон санхүүгийн бус нэгдлүүдийн үүсгэж болох эрсдэлүүд нь системийн хэмжээнд нөлөөлөх аюултай тул тэдгээрийг зохицуулж, хяналт шалгалт хийх нэгдсэн тогтолцоог бий болгох шаардлага үүсээд байна.

Иймд нэгдүгээрт СЗХ санхүүгийн болон санхүүгийн бус нэгдлийг хянаж, зохицуулах эрх зүйн орчныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд шинээр тусгаж, үүний хүрээнд нэгдлийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих журам баталж, гарын авлага боловсруулах мөн зохицуулалтын нэгдсэн эсвэл хосолсон хэлбэр рүү шилжих ажлыг эхлүүлэх шаардлагатай юм. Улс

орнууд 2008 оны хямралаас хойш мөнгөний болон сангийн бодлого, микро зохистой бодлого дээр нэмээд макро зохистой бодлогыг хэрэгжүүлснээр системийн эрсдэлийг удирдах нөхцөл бүрдэж санхүүгийн тогтвортой байдлыг хадгалах бодлогын хэрэгслүүд цогцоороо бий болно гэж үзэх болсон бөгөөд санхүүгийн зохицуулалтын хосолмол хэлбэрийг илүүд үзэж байна. Тус хэлбэрийн хүрээнд санхүүгийн зохицуулалтын байгууллага нь санхүүгийн зах зээлийн үйл ажиллагааг, төв банк нь системийн эрсдэлийг удирдах макро зохистой бодлогыг хариуцах юм.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Сүүлийн гуч орчим жилийн туршид санхүүгийн зах зээлд томоохон хэмжээний өөрчлөлтүүд явагдаж байна. Техник, технологийн дэвшил, санхүүгийн зах зээлд шинээр гарч буй инновацийн нөлөөгөөр олон төрлийн санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтэрч, санхүүгийн үндсэн 3 салбар болох хөрөнгө, даатгал, банкны салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд өөр хоорондоо уялдаа холбоо өндөртэй болж тэдгээрийг ангилж, зааглах улам бүр төвөгтэй болж байна. Түүнчлэн зах зээлийн өөрчлөлт, өсөлтийг даган санхүүгийн нэгдэл компаниуд олноор бий болон зөвхөн дотоодын зах зээлд нэг төрлийн үйлчилгээ үзүүлэх биш газар нутгийн хязгаарлалтгүйгээр бүхий л салбарыг дагнасан үйл ажиллагааг явуулж байна. Зах зээлийн энэхүү хэв маягийг даган санхүүгийн зах зээлийн зохицуулалтын хэлбэр ч мөн өөрчлөгдөж, банк, хөрөнгө, даатгалын салбарыг тус тусын мэргэшсэн зохицуулалтын байгууллага хянаж, зохицуулдаг байсан уламжлалт хэлбэрээс бүхий л салбарын үйл ажиллагааг нэг дор зохицуулдаг хяналтын нэгдсэн загварт шилжих хандлага ажиглагдаж байна.

Энэхүү судалгааны ажил нь санхүүгийн зах зээлийн зохицуулалтын үндсэн дөрвөн хэлбэр, тэдгээрийн давуу, сул тал болон санхүүгийн зах зээлийн зохицуулалтын орчин үеийн чиг хандлага, олон улсын туршлагыг судлах байсан бөгөөд судалгааны ажлаас гарсан дүгнэлтүүдийг товч дурдъя. Үүнд:

- Одоогоор улс орнуудын ашиглаж буй санхүүгийн зохицуулалт, хяналтын хэлбэрийг институционал, функционал, нэгдсэн болон хосолмол гэсэн 4 үндсэн хэлбэрт ангилж байна. Улс орон бүрийн онцлог болон зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан эдгээр 4 хэлбэрийн аль нэгийг нь хамгийн сайн хувилбар гэж дүгнэж чадахгүй байгаа хэдий ч сүүлийн 30 орчим жилийн туршид зах зээлийн зохицуулалт, хяналтын тогтолцоо уламжлалт хэлбэрээс нэгдсэн хэлбэрт шилжих хандлага ажиглагдаж байна.
- Санхүүгийн тогтвортой байдлын байгууллага /Financial Stability Institute/-аас санхүүгийн зах зээлийн хямралын дараагаар санхүүгийн зохицуулалтын хэлбэр хэрхэн өөрчлөгдөж буйг судалсан бөгөөд 2017 оны байдлаар судалгаанд хамрагдсан 79 улсын 39 нь уламжлалт буюу институционал болон функционал зохицуулалтын тогтолцоотой бол үлдсэн 40 нь санхүүгийн бүхий л байгууллагуудыг нэгдсэн байдлаар зохицуулдаг, нэгдсэн болон хосолмол хэлбэрийн тогтолцоотой байна. Мөн нэгдсэн зохицуулалтын загварыг ашигладаг улс орнуудын хувьд дийлэнх нь бие даасан бүтэц бүхий санхүүгийн зохицуулагч байгууллагатай байгаа бол үлдсэнийх нь хувьд төв банк нь санхүүгийн салбарын хяналтын үүргийг давхар хэрэгжүүлж байна.
- Зах зээлийн шинж чанар, эдийн засгийн нөхцөл байдлаар нь ангилан харвал харьцангуй жижиг эдийн засагтай, санхүүгийн салбарт нь банкны салбар давамгайлсан, мөн банк болон даатгалын компанийн нэгдэл ихтэй улс орнууд нэгдсэн зохицуулалтын хэлбэрийг ашиглах хандлагатай байна. Банкны салбарын санхүүгийн салбарт эзлэх хувь өндөр байснаар бусад санхүүгийн зах зээлд оролцох оролцоо нэмэгдэх, төвлөрөл үүсэх эрсдэлтэй байдаг тул нэгдсэн зохицуулалтын тогтолцоо нь системийн эрсдэлийг хянах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх давуу талтай юм.
- Уламжлалт зохицуулалтаас нэгдсэн зохицуулалтын хэлбэр рүү шилжиж байгаа улс орнуудын хувьд дараах үндсэн шалтгаануудын улмаас зохицуулалт, хяналтын хэлбэрээ өөрчлөх болсон байна. Үүнд: (1) универсал банк буюу банкны салбарын үйл ажиллагаа хөрөнгө, даатгалын зах зээлд орох, санхүүгийн байгууллагууд өөр хоорондоо ижил, уялдаа хамаарал өндөртэй үйлчилгээ эрхлэх болсон; (2) зах зээл өсөж, өргөжихийн хэрээр олон тооны санхүүгийн нэгдлүүд үүсэн

системийн эрсдэлийг нэмэгдүүлэх болсон; (3) технологийн дэвшил, зах зээлд гарч буй инновацын нөлөөгөөр олон төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ санхүүгийн зах зээлд нэвтэрч тэдгээрийг ангилж, зааглах боломжгүй болж ирсэн. Эдгээр үндсэн шалтгаануудын улмаас улс орнууд тус тусдаа зохицуулалтын байгууллага бүхий хяналтын тогтолцоог халан нэгдсэн зохицуулалтын хэлбэрт шилжих болжээ.

- Санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалтын хэлбэрт шилжих үед үүсдэг өөр нэгэн томоохон асуудал нь санхүүгийн салбарын хяналт, зохицуулалтын үүргийг төв банканд олгох эсхүл тусдаа бие даасан байгууллагад хариуцуулах юм. Энэхүү аргумент нь мөн л маргаан дагуулдаг хэдий ч мөнгөний бодлогын бие даасан байдлыг хангах зорилгоор төв банкнаас санхүүгийн зохицуулалтын чиг үүргийг салгах хандлага нь илүү түгээмэл ажиглагдаж байна. Түүнчлэн сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн зохистой бодлого, салбарын тогтвортой байдлыг хангах үүднээс зохицуулалт, хяналтын үйл ажиллагаанд төв банкиг оролцуулах хандлага мөн нэмэгдэж байна.
- Санхүүгийн зах зээл нь зохицуулалтын аль ч хэлбэрт харьяалагддаг байсан салбарын болон эдийн засгийн тогтвортой байдлыг хангах хүрээнд санхүүгийн зохицуулагч байгууллага, төв банк, сангийн яам зэрэг бодлого гаргагчдын хамтын ажиллагаа ихээхэн чухал гэдэг дээр судлаачид болон бодлого гаргагчдын байр суурь нэгдэж байна. Улс орнууд эдгээр байгууллагуудын хамтарсан зөвлөл байгуулах, шийдвэр гаргах түвшинд нь бусад байгууллагуудын төлөөллөөс оролцуулах зэрэг арга хэлбэрийг нийтлэг ашиглаж байна.
- Монгол Улсын хувьд санхүүгийн салбар бүр өөр өөрийн хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулан зохицуулагддаг тул институционал хэлбэрийн зохицуулалтын тогтолцоотой илүү төстэй байна. Мөн банкны салбарыг Монголбанк, хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээлийг Санхүүгийн зохицуулах хороо зохицуулан хянаж Сангийн яамтай хамтран Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийг байгуулан ажиллаж байгаа хэдий ч санхүүгийн нэгдэл компаниудын төвлөрөл болон шинээр зах зээлд нэвтэрч буй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс шалтгаалан нэгдсэн зохицуулалт, хяналтыг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх шаардлага зайлшгүй гарч байна. Тухайлбал 2019 оны 3 дугаар улирлын байдлаар санхүүгийн нэгдэл компаниудын банкны салбарт эзлэх хувь 87, үнэт цаасны зах зээлд эзлэх хувь 65, даатгалын салбарт эзлэх хувь 59 байна.

Санал:

- 2011 оноос хойш нэмэгдэж буй санхүүгийн нэгдлүүдийг хянах тогтолцоог бий болгох. Үүний тулд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд СЗХ–г тусгайлсан журмын дагуу санхүүгийн нэгдлийг зохицуулж, хянан шалгадаг байх харилцааг нэмж оруулах. Санхүүгийн нэгдлийг зохицуулах үйл ажиллагааны журам, хяналт шалгалтын журам (удирдамж) зэргийг шинээр боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулах. Үүнд:
 - Санхүүгийн нэгдлүүд мэдээллээ зохицуулагч байгууллагад тайлагнадаг болох;
 - Олон улсад нийтлэг мөрдөгддөг зарчим, стандартуудыг судлан дотоодод нэвтрүүлэх;
 - Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтыг үр ашигтай хийх процедурыг тодорхой болгох / хөрөнгийн шалгуурууд, тайлан мэдээнүүдийн төрөл, хяналт шалгалтын шалгах хуудас гэх мэт/;
- Санхүүгийн нэгдлийн хяналт шалгалтыг бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран хийдэг механизмыг бий болгох;

- Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)–ийн ажлын алба нь зах зээлд тулгараад буй системийг хамарсан эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авах, гишүүн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлд илүү анхааран ажиллах, үйл ажиллагаагаа эрчимжүүлэх;
- Нэгдсэн хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх зорилго нь санхүүгийн төвлөрөл болон байгууллагууд хоорондын хөрөнгө, өр төлбөр, авлагаар холбогдсон холбоо хамаарлын улмаас системийг хамарсан эрсдэлээс урьдчилан сэргийлдэг. Системийн эрсдэл нь дээрх хоёр эх үүсвэрээс гадна эдийн засгийн мөчлөгийн уналтын үе болон бусад хүчин зүйлсээс хамаардаг. Үүнийг удирдах бодлогын хэрэгсэл нь макро болон микро зохистой бодлого тул СТБЗ, Монголбанк, Сангийн яам, СЗХ хариуцсан чиг үүргийнхээ дагуу макро зохистой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- Санхүүгийн зохицуулалтын байгууллагуудын дундын мэдээллийн сан бий болгох ажлыг эрчимжүүлэх;
- Санхүүгийн нэгдлийг хянах гарын авлага боловсруулах зэрэг болно.

ЗУРГАА. ЭХ СУРВАЛЖ

- Acharya, Viral V. “Measuring systemic risk”, *The Review of Financial Studies*, 30.1: 2–47. 2017
- Acharya, Viral V., Thomas Philippon, and Matthew Richardson. “Measuring systemic risk for insurance companies”, *The economics regulation, and systemic risk of insurance markets*. 2016.
- Adams, Zeno, Roland Füss, and Reint Gropp. “Spillover effects among financial institutions: A state-dependent sensitivity value-at-risk approach”, *Journal of Financial and Quantitative Analysis* 49.3: 575–598. 2014.
- Bank of Japan. “Financial system report”. 2019.
- Bernardi, Mauro, Antonello Maruotti, and Lea Petrella. “Multivariate Markov–Switching models and tail risk interdependence”, arXiv preprint arXiv:1312.6407. 2013.
- Bernardi, Mauro, Ghislaine Gayraud, and Lea Petrella. “Bayesian inference for CoVaR”, arXiv preprint arXiv:1306.2834. 2013.
- Brownlees, Christian, and Robert F. Engle. “SRISK: A conditional capital shortfall measure of systemic risk”, *The Review of Financial Studies*, 30.1: 48–79. 2016.
- Calomiris, Charles. “Banking Crises and the Rules of the Game”, *National Bureau of Economic Research*, No. w15403. 2009.
- Dirk Schoenmaker and Nicolas Vignon. “Twin Peaks”, Vision for Europe. 2017.
- Daniel Calvo and others. “Financial supervisory architecture: what has changed after the crisis?”, FSI. 2018.
- Drehmann, Mathias, and Nikola Tarashev. “Measuring the systemic importance of interconnected banks”, *Journal of Financial Intermediation*, 22.4: 586–607. 2013.
- Elisabetta Montanaro. “Central banks and financial supervision: New tendencies”, FESSUD. 2015.
- Engle, Robert F., and Simone Manganelli. “CAViaR: Conditional autoregressive value at risk by regression quantiles”, *Journal of Business & Economic Statistics*, 22.4: 367–381. 2004.
- Financial Regulatory Commission of Mongolia. “Rule of capital adequacy in non-bank financial institutions”. 2016.
- FSA. “Guideline for Financial conglomerates supervision”. 2007.
- Galati, Gabriele, and Richhild Moessner. “Macroprudential policy—a literature review”, *Journal of Economic Surveys*, 27.5: 846–878. 2013.
- Garry, J. Schinasi, and G. Schinasi. “Defining financial stability”, *IMF Working Paper*: 128–190. 2004.
- Hanson, Samuel G., Anil K. Kashyap, and Jeremy C. Stein. “A macroprudential approach to financial regulation”, *Journal of economic Perspectives*, 25.1: 3–28. 2011.
- Huang, Xin, Hao Zhou, and Haibin Zhu. “Systemic risk contributions”, *Journal of financial services research*, 42.1–2: 55–83. 2012.
- IOSCO. “Principles for the supervision of financial conglomerates”. 1992.
- IOSCO, BIS, IAIS. “Principles for the supervision of financial conglomerates”. 2012.
- Kemp, Malcolm HD. “Systemic Risk: A Practitioner’s Guide to Measurement, Management and Analysis”, Springer. 2017.

- Martin Čihák and Richard Podpiera. “Is one Watchdog Better Than Three? International Experience with Integrated Financial Sector Supervision”, IMF Working Paper. 2006.
- Mayes, David, and Geoffrey E. Wood. “The structure of financial regulation”, Mongolia: Financial regulation and Governance program of ADB, Vol. 37. Routledge. 2011.
- Mishkin, Frederic S. “Financial instability and monetary policy”, Remarks delivered at the Risk USA 2007 Conference, New York City, November. Vol. 5. 2007.
- Mishkin, Frederic S. “The causes and propagation of financial instability: Lessons for policymakers”, Maintaining financial stability in a global economy: 55–96. 1997.
- Moussa, Amal. “Contagion and systemic risk in financial networks”, Columbia University. 2011.
- Schinasi, Garry J. “Defining financial stability and a framework for safeguarding it”, Documentos de Trabajo (Banco Central de Chile) 550: 1. 2009.
- Schinasi, Garry J. “Safeguarding Financial Stability: Theory and Practice”, Washington, DC: International Monetary Fund. ISBN 1–8906–440–2, 2006.
- Tatsu Katayama, Takaharu Totsuka and Keisuke Hatano, Anderson Mori & Tomotsune. “Financial regulation in Japan”. 2019.
- Zhou, Chen. “Are banks too big to fail? Measuring systemic importance of financial institutions”, Measuring Systemic Importance of Financial Institutions. 2009.





ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТИЙН НИЙТЛЭГ ЗАРЧИМ, ШИЛДЭГ ТУРШЛАГА

2020 он

Гүйцэтгэсэн: А.Бадамсүрэн¹

¹ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, badamsuren@frc.mn

ХУРААНГУЙ

Монголын үнэт цаасны зах зээлд олон улсад мөрдөгдөж буй тогтвортой санхүүжилтийн нийтлэг зарчим, шилдэг туршлагыг нэвтрүүлэх зорилгоор энэхүү судалгааг хийсэн. Тогтвортой санхүүжилтийг хөгжүүлж буй олон улсын туршлагыг судлахдаа улс орнуудын үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллагууд тогтвортой хөгжлийг хангах хүрээнд хөрөнгө оруулалтыг дэмжих, ил тод байдлыг нэмэгдүүлэх, үүрэг хариуцлагыг тодорхой болгох, засаглал болон чадавхыг бэхжүүлэх чиглэлүүдэд хэрхэн арга хэмжээнүүдийг авч ажилласан талаар бичсэн. Олон улсад мөрдөгдөж буй тогтвортой санхүүжилтийн шилдэг туршлага, тогтвортой санхүүжилтийг дэмжих үүднээс улс орнуудын зохицуулагч байгууллагуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, баримталж буй зарчмуудад үндэслэн мөн Монголын үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс авч хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагаануудын жагсаалтыг гаргаж дүгнэлт хэсэгт орууллаа.

Түлхүүр үгс: тогтвортой санхүүжилт, хөрөнгийн зах зээл, үнэт цаасны зах зээл, хөрөнгө оруулалт, зохицуулагч байгууллага

JEL ангилал: G38, O16, P43

НЭГ. УДИРТГАЛ

Байгаль орчин, экосистемд учирч буй дарамт, хохирол, дэлхийн уур амьсгалын өөрчлөлт зэрэг нь дэлхий нийтийн анхаарах чухал асуудлуудын нэг болоод байгаа билээ. Нэгдсэн үндэстний байгууллагын¹ /НҮБ/ таамаглаж буйгаар, 2050 он гэхэд 2.5 тэрбум хүн хөдөө орон нутгаас хот суурин газарт шилжих бөгөөд, энэхүү шилжилтийн 90 хувь нь хөгжиж буй эдийн засагт төвлөрөх юм байна. Үүнтэй зэрэгцэн хот суурийн газрууд эдийн засгийг хөгжүүлэх чухал боломжуудыг эрэлхийлэх ч уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлд улам эмзгээр өртөх юм.

Дэлхийн тогтвортой хөгжлийн хэрэгцээ, урт хугацаат уян хатан өсөлтийг хангахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байгааг орон орны судлаач, мэргэжилтнүүд онцолсоор ирсэн бөгөөд салбар салбарын төлөөлөгч, эрх баригчид уг асуудалд анхаарлаа хандуулсаар ирсэн. Тэр дундаа хөрөнгийн зах зээлийн оролцогчид, бодлого боловсруулагчид тогтвортой эдийн засаг, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд зохих бодлогын арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна.

Дэлхийн хэмжээнд, ногоон бонд, нийгэмд эерэг нөлөөтэй бонд, сэргээгдэх эрчим хүчинд оруулах хөрөнгө оруулалт зэрэг тогтвортой хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний цар хүрээ нэмэгдсээр байгаа бол хөрөнгийн зах зээлийг зохицуулагч байгууллагуудын зүгээс тогтвортой хөгжлийн гүйцэтгэлийг хэмжих, зах зээлд оролцогчдыг Байгаль орчин, нийгэм, засаглалын /Environmental, social and governance (ESG)/ эрсдэлийн талаар тайлагнахыг дэмжих, санхүүгийн тайлагналыг боловсронгуй болгох удирдамж, зарчмыг боловсруулах, мөн тогтвортой санхүүжилтийн дата, мэдээллийн ил тод, чанартай байдлыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Арилжаа эрхлэх байгууллагууд мөн адил сайн дурын болон албадлагын зарчмаар дамжуулан тогтвортой байдлын тайланг гаргах талаас компаниудыг дэмжих, ESG-ийн индексийг боловсруулах, ESG-ийн тайлагналын удирдамжийг гаргах зэрэг урт хугацаат тогтвортой зах зээлийг дэмжих санаачилгуудыг эхлүүлэн ажиллаж байна.

¹ United Nations, <https://www.un.org/development/desa/en/news/population/2018-revision-of-world-urbanization-prospects.html>

ХОЁР. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

Нэгдсэн үндэстний байгууллагын ерөнхий ассемблээс 2015 онд тогтвортой хөгжлийг дэмжих хүрээнд дэлхийн хэмжээнд мөрдлөг болгох 17 зорилтуудыг баталсан байдаг. Тогтвортой хөгжлийн зорилтууд /Sustainable development goals (SDG)/ нь байгаль орчин, нийгэм, эдийн засаг болон засаглалын асуудлууд зэрэг дэлхийн тогтвортой байдлын хамгийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн юм.

SDG–г баталснаар НҮБ–ын гишүүн орнуудын санхүүгийн систем, зах зээлд оролцогчид, зохицуулагч байгууллагууд болон өргөн хүрээний оролцогч талууд үйл ажиллагаагаа явуулж буй бодлогын орчинд өөрчлөлт хийхийг зорьж байна.

SDG–д тодорхойлогдсон тогтвортой байдлын асуудлууд болон тэдгээрийн эсрэг авах хариу бодлогын арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулагчдад материаллаг эрсдэлүүд болоод боломжуудыг бий болгож, мөн цаашлаад санхүүгийн системийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй юм. Тэдгээр нөлөөлөл, үр дагавар нь үнэт цаасны зохицуулагч байгууллагуудын гурван үндсэн зорилтуудад шууд хамааралтай. Тэдгээр нь:

- a) Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах
- b) Зах зээлийн шударга, ил тод, үр ашигтай байдлыг бэхжүүлэх
- c) Системийн эрсдэлийг бууруулах

Зураг 3. 1. НҮБ–ын Тогтвортой Хөгжлийн Зорилтууд



Эх сурвалж: SSE


ГУРАВ. ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ БА ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА ESG-Г ДЭМЖИХ НЬ

SDG-г хангахад чиглэн хэрэгжүүлж буй арилжаа эрхлэх байгууллагын үйл ажиллагаа, мөн үнэт цаасны зах зээлд баримтлах бодлого зохицуулалтууд нь тогтвортой хөрөнгө оруулалтын талбарыг бий болгоход чухал байр суурийг эзэлж байна.

НҮБ-аас гаргадаг Дэлхийн хөрөнгө оруулалтын тайлан 2018-д дэлхийн 54 арилжаа эрхлэх байгууллага Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмыг анхааралдаа аван холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа талаар онцолжээ.


Зураг 3. 2. Тогтвортой санхүүжилтийг хэрэгжүүлж буй арилжаа эрхлэх байгууллагын тойм



2009 онд НҮБ-аас Тогтвортой хөгжилд чиглэсэн биржүүдийн холбоо /Sustainable Stock Exchanges (SSE)/ санаачилгыг хэрэгжүүлсэн бөгөөд, биржүүд SSE-ийн олон талуудыг холбосон платформоор дамжуулан хөрөнгө оруулагчид, бүртгэлтэй компаниуд, хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд болон бодлого боловсруулагчидтай зөвшилцөж, чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаанд оролцож, мэдээлэл солилцдог байна.

2018 оны 3 дугаар улирлын байдлаар 81 их наяд ам.долларын зах зээлийн үнэлгээ бүхий 45,700 бүртгэлтэй компанитай 5 тивийн 78 бирж SSE-д нэгдсэн байна.

Зураг 3. 3. SSE-д бүртгэлтэй гишүүд



Эх сурвалж: SSE database


НОГООН САНХҮҮ БОЛОН ESG ИНДЕКС

Арилжаа эрхлэх байгууллагууд болон хөрөнгийн зах зээлийн бусад оролцогчид ногоон бүтээгдэхүүнийг дэмжих, мөн уламжлалт санхүүгийн зах зээлийг “ногоонжуулах” нь дэлхийн дулаарлаас үүдсэн уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд маш чухал ач холбогдолтой.

Дэлхийн дундаж дулаарлыг цельсийн 2 градусын хэмээр бага байлгахад эрчим хүчний салбарт 2012–2050 он хүртэл жил бүр 1 их наяд ам.долларын хөрөнгө оруулалтыг хийх шаардлагатай байгаа талаар Олон улсын эрчим хүчний агентлагаас тооцоолон гаргасан.²

Сүүлийн жилүүдэд Ногоон бонд гаргах нь эрчимтэйгээр өсөж, нийт ногоон бондод оруулах хөрөнгө оруулалтын дүн 2017 оны эцсийн байдлаар 163 тэрбум ам. долларт хүрчээ. Энэ нь 2016 оноос 167 хувиар өссөн үзүүлэлт юм. Америкийн санхүүгийн үйлчилгээний салбарын Мүүди байгууллагаас 2019 онд ногоон бондод оруулах хөрөнгө оруулалт 200 их наяд ам. доллар давах хандлагатай талаар таамаглал гаргаж байв.

Зураг 3. 4. Ногоон бондод оруулсан хөрөнгө оруулалт /их наяд ам.доллар/




Эх сурвалж: UN Environment and Bloomberg

ESG индекс нь арилжаа эрхлэх байгууллагуудын хувьд тогтвортой санхүүжилтийн хамгийн түгээмэл арга хэрэгсэл бөгөөд SSE дата баазад бүртгэлтэй 87 биржийн 40 нь тус индексийг тооцож гаргадаг байна. Мөн биржүүдээс гадна FTSE–Russel, Standard & Poor’s, Dow Jones, Stoxx, Thomson Reuters, MSCI зэрэг байгууллагууд ESG индексийг тооцож байна.

Тухайлбал, 1990 оноос тооцож эхэлсэн Байгаль орчин, нийгэм, засаглалын өндөр үнэлгээтэй 400 америк компанийн зах зээлийн үнэлгээнд суурилсан MSCI KLD 400 Social Index нь 2013–2017 онуудын 4 жилд нь S&P 500 индексийг давсан үзүүлэлттэй байжээ.

Зураг 3. 5. ESG индекс болон уламжлалт зах зээлийн индексийн өгөөж /хувиар/



Эх сурвалж: SSE database

2 Олон улсын эрчим хүчний агентлаг, Global Energy Transformation: A Roadmap to 2050 (2018 edition)

ДӨРӨВ. МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Монголын үнэт цаасны зах зээлд тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх, дэмжих санал санаачилгууд ойрын жилүүдэд эрчимжиж байна. 2020 оны 5 дугаар сард Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын санхүүгийн корпорацитай Ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх төслүүдийг хамтран хэрэгжүүлэхээр Харилцан ойлголцлын санамж бичгийг байгууллаа.

Ногоон санхүүжилтийг хөгжүүлэх санамж бичгийн хүрээнд Монгол Улсад ногоон санхүүжилтийг хөгжүүлэх, ялангуяа ногоон бонд гаргахад чиглэсэн заавар, зөвлөмжийг боловсруулах, банк бус санхүүгийн байгууллага болон хөрөнгийн биржийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон засаглалын шаардлагыг нэвтрүүлэх, байгаль орчинд ээлтэй төсөл, бизнесийн үйл ажиллагааг дэмжих санхүүжилтийг нэмэгдүүлэх, уур амьсгалтай холбоотой эрсдэлийг үнэлэх, бодлого боловсруулах үйл ажиллагаанд техникийн туслалцаа үзүүлэх юм.

Нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх санамж бичгийн хүрээнд Монгол Улсад өртгийн буюу нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх, факторингийн бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний санхүүжилтийн талаар мэдлэг, мэдээллийг түгээн дэлгэрүүлэх, нийлүүлэлтийн сүлжээнд оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл авах боломжийг нэмэгдүүлэх юм.

Эдгээр төслүүдийг хэрэгжүүлсний үр дүнд Монгол Улсын санхүүгийн салбарт байгаль орчинд ээлтэй ногоон санхүүжилтийн зах зээлийг хөгжүүлэх, банк бус санхүүгийн байгууллагууд хөдлөх хөрөнгө барьцаалсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх чадавх дээшилж, тэдгээрийн зээлийн багц төрөлжих, жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох санхүүжилт нэмэгдэх, санхүүгийн хүртээмж сайжирч, нийлүүлэлтийн сүлжээний үйл ажиллагаа хөгжих боломж бүрдэх ач холбогдолтой.³

2019 оны 12 дугаар сард Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын хамтарсан тушаалаар “Ногоон таксономи”-ийг баталсан. Үүнийг баталснаар банк санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон бодлого боловсруулагчид байгальд ээлтэй бүтээгдэхүүн, ногоон зээл, үнэт цаас, бусад ногоон санхүүжилтийг дэмжсэн төсөл хөтөлбөрүүдийг тодорхойлохдоо ашиглах гарын авлагатай болсон.

Санхүүгийн зохицуулах хороо нь 80 гаруй эрчимтэй хөгжиж буй болон хөгжиж буй улс орнуудын Төв банк болон санхүүгийн зохицуулагч байгууллагуудын гишүүнчлэлтэй Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (Alliance for Financial Inclusion)-т гишүүнчлэлтэй бөгөөд нийт 7 ажлын хэсэгт ажилладаг. Түүний нэг нь Хүртээмжтэй ногоон санхүү бөгөөд уг ажлын хэсэг нь 2019 оны 4 дүгээр сард байгуулагдаж, СЗХ нь 2019 оны 6 дугаар сард гишүүнээр элссэн. Ажлын хэсгийн хүрээнд ногоон санхүүжилтийг дэмжих олон санал санаачилгуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2018 онд ОУСК, Тогтвортой санхүүжилтийн холбоо болон НҮБ-аас “Монголд тогтвортой санхүүжилтийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан байдаг. Энэхүү хөтөлбөрт банк, хөрөнгийн зах зээл, банкаас бус санхүүгийн байгууллагууд болон даатгалын зах зээлд чиглэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр тусгасан. Хөрөнгийн зах зээлийн хувьд ESG-ийн бүртгэлийн шаардлагуудыг

3 Санхүүгийн Зохицуулах Хороо, <http://www.frc.mn/a/3220>

нэвтрүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах, хэрэгцээг үнэлэх судалгаа хийх, чадавхыг бэхжүүлэх санаачилгуудыг хэрэгжүүлэх, бүртгэлтэй компаниудад заавал тавигдах шаардлагуудыг гаргах, ногоон санхүүжилтийг дэмжих ажлын хэсэгт орж ажиллах, гарын авлагыг гаргах зэрэг ажлуудыг төлөвлөжээ. 2017 онд “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК нь 2017 оны 9 дүгээр сард SSE-д гишүүнээр элсэж, хариуцлагатай хөрөнгө оруулалт тогтвортой бизнесийн ажиллагааг дэмжин хамтран ажиллаж иржээ. Гишүүнээр элсэх хүрээнд МХБ нь шинэчлэн найруулсан “Бүртгэлийн журам”-даа НҮБ-аас тодорхойлсон Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаатай компанид Биржийн I, II ангиллын шалгууруудаас чөлөөлөх, үнэт цаасны бүртгэлийн үйлчилгээний хөлсийг 20 хүртэл хувиар хөнгөлөх зэрэг давуу талуудыг тусгасан билээ.⁴

4 Монголын хөрөнгийн бирж, http://mse.mn/uploads/images/annual_report_mn.pdf

ТАВ. ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ БА ЗОХИЦУУЛАГЧ БАЙГУУЛЛАГУУД

SSE-ээс Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад Үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагуудын зүгээс хэрхэн дэмжлэг үзүүлдэг талаар товхимол гаргасан байдаг. Тус товхимолд SDG-ийг илүү сайн дэмжих тогтвортой, уян хатан санхүүгийн системийг бий болгоход хувь нэмрээ оруулах 5 гол хэрэгжүүлэх арга хэмжээ болон 5 нэмэлт арга хэмжээг тодорхойлсон.

5 үндсэн арга хэмжээ:

- 1. Хөрөнгө оруулалтыг дэмжих:** Санхүүгийн хэрэгслээр дамжуулан тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх
- 2. Ил тод байдлыг нэмэгдүүлэх:** Нийгэм, эдийн засгийн талаарх дата өгөгдлийн ил тод байдлын чанар, тоог сайжруулах
- 3. Үүрэг хариуцлагыг тодорхой болгох:** Шийдвэр гаргахдаа тогтвортой байдлыг харгалзан үзэх талаар хөрөнгө оруулагчдад чиглэл өгөх
- 4. Засаглалыг бэхжүүлэх:** Нийгэм болон байгаль орчны хүчин зүйлстэй холбогдолтой үүрэг хариуцлагыг төлөөлөн удирдах зөвлөлд таниулах
- 5. Чадавхыг бэхжүүлэх:** Тогтвортой байдлын сэдвээр зах зээлд оролцогчдод сургалт явуулах

Зураг 3. 6. SDG-ийг дэмжих арга хэмжээ



Эх сурвалж: SSE

5 туслах арга хэмжээ:

1. **Анализ:** Тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжихэд нөлөөлөх зах зээлийн хүчин зүйлсэд анализ хийх
2. **Замын зураглал:** Тогтвортой санхүүжилтийг бий болгох бүс нутгийн эсхүл үндэсний хэмжээний төлөвлөгөөг боловсруулах
3. **Хуваалцах:** Бусад үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагуудтай туршлага солилцох
4. **Стандарт:** Стандартчилгдсан заавар, удирдамжийг хэрэгжүүлэх тал дээр бүс нутгийн эсхүл олон улсын холбогдох байгууллагуудтай хамтрах
5. **Хамтын ажиллагаа:** Тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэмжихэд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

1. Хөрөнгө оруулалтыг дэмжих

НҮБ-ын худалдаа хөгжлийн бага хурал /United Nations Conference on Trade and Development (UNCTAD)/-ын таамаглаж буйгаар 2030 он хүртэлх SDG-ийг хангахад жилд 5–7 их наяд ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай гэж үзэж байна. Энэхүү хөрөнгө оруулалтад Засгийн газрын санхүүжилт чухал байр суурь эзлэх хэдий ч хувийн хэвшлийн хувь нэмэр, оролцоо ихээхэн шаардлагатай.

Хөрөнгө оруулагчдын SDG-уудтай холбоотой боломжуудад хөрөнгө оруулах сонирхолд нөлөөлөх олон хүчин зүйлс байдаг. Олонх шалтгаанууд хөрөнгө оруулалтын санхүүгийн шинж чанартай холбоотой байдаг. Тухайлбал, тэдгээрийн татварын болон нягтлан бодох бүртгэлийн журам, хөрөнгө оруулалт хийхэд гарах зардал, хөрөнгө оруулалтын эрсдэл өгөөжийн харьцаа зэрэг байна. Бусад чухал хүчин зүйлсээс дурдвал, SDG-г хангахад оруулах хөрөнгө оруулалтын боломжийн талаарх ойлголт дутмаг, мөн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгслийг хөгжүүлэх, туршлага хуваалцах боломж хангагдаагүй зэрэг юм.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагууд, арилжаа эрхлэх байгууллагууд, хөрөнгө оруулагчид болон үнэт цаас гаргагчид тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг билээ. Тухайлбал, арилжаа эрхлэх байгууллагын зүгээс тогтвортой бондын арилжааны самбарыг хөгжүүлэх мөн бүртгүүлэх удирдамжийг гарган ажиллаж байна.

Харин, үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагуудын зүгээс SDG-г хангах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үүднээс дараах нийтлэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна:

- 1) SDG-г хангах санхүүжилтийн шинэлэг шийдэл болох ногоон бонд, ногоон үнэт цаас, нийгмийн бонд зэргүүдийг хөгжүүлэх төсөл хөтөлбөр, хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж дэмжин ажиллах;
- 2) SDG-ийн хөрөнгө оруулалтын боломжуудыг хэрхэн ашиглах талаар удирдамж, кэйс судалгаануудыг боловсруулах;
- 3) Тогтвортой санхүүжилтэд хувь нэмрээ оруулахад зах зээлд оролцогчдын үүрэг оролцоог тодорхой болгох;
- 4) Тогтвортой хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний баталгаа, индекс зэргийг шошголох үйл явцыг хөгжүүлэх.

Хүснэгт 3. 1. Хөрөнгө оруулалтыг дэмжсэн олон улсын туршлага

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
БНХАУ	<p>– 2016 онд БНХАУ–ын Төв банк, Үнэт цаасны зохицуулах хороо зэргийг багтаасан 6 засгийн газрын харьяа агентлагууд нэгдэн Ногоон Санхүүгийн Системийг Хөгжүүлэх Удирдамжийг гаргасан. Тус удирдамж нь ногоон хөрөнгө оруулалтыг дэмжихэд үнэт цаасны зах зээлийн үүрэг оролцоог тодорхой зааж өгсөн.</p> <p>Ногоон бондтой холбогдолтой дүрэм, журмыг сайжруулах, ногоон бондын санхүүжилтийн өртгийг бууруулах, ногоон бондын зэрэглэл тогтоох болон баталгаажуулах үүрэг гүйцэтгэх гуравдагч этгээдийн үйл ажиллагааны стандартыг боловсруулах, ногоон бонд болон хувьцааны индексийг хөгжүүлэх, тэтгэврийн сан болон даатгалын сан зэрэг мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг ногоон хөрөнгө оруулалт хийхэд дэмжих зэрэг зөвлөмжүүдийг удирдамждаа тусгажээ.</p> <p>– 2017 оны 12 дугаар сард БНХАУ–ын Төв банк болон Үнэт цаасны зохицуулах хорооноос Ногоон бондыг сертификатжуулах удирдамжийг гаргасан. Тус удирдамжийн зорилго нь баталгаажуулалтын үйл явцын чанар, найдвартай байдлыг хангах, баталгаажуулалтын үйл явцын стандартыг зохицуулах, зах зээлд гарсан ногоон бонд холбогдох дүрэм журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавих замаар ногоон бондын найдвартай байдлыг хангах юм.</p> <p>– 2018 онд Шанхайн Хөрөнгийн Биржээс Ногоон Санхүү, Ногоон хөгжлийг дэмжих төлөвлөгөөг боловсруулан гаргасан.</p>
Хонконг	<p>2016 онд Хонконгийн санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэх зөвлөл /Financial Services Development Council/ нь Хонконгийг хэрхэн ногоон санхүүгийн төв болгон хөгжүүлэх зөвлөмжийг боловсруулсан. Зөвлөмжид төрийн салбарын жишиг бондыг гаргах, мөн хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчдыг татах зорилгоор үнэт цаас, төслүүдийн ногоон шошгоны схемийг бий болгох талаар тусгасан.</p>
Бразил	<p>Бразилийн Үнэт цаасны хороо, Бразилийн хөгжлийн хороо болон Америк хоорондын хөгжлийн банкууд нэгдэн Санхүүгийн Инновацын Лабораторийг байгуулсан. Тус лаборатори нь ногоон бонд, ногоон санхүү, нийгэмд нөлөөлөх санхүүгийн хэрэгсэл болон финтек гэсэн 4 үндсэн сэдвээр ажлын хэсгүүдийг байгуулсан.</p>

Эх сурвалж: SSE

2. Ил тод байдлыг нэмэгдүүлэх

IOSCO–ийн Үнэт цаасны зохицуулалтын зорилт, зарчмуудын 16 дахь зарчимд “Хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад нөлөөлөх санхүүгийн тайлан, эрсдэл болон бусад мэдээллүүдийг бүрэн дүүрэн, үнэн зөв, цаг алдалгүй байдлаар ил тод тайлагнаж байх” гэж заасан байдаг. Тогтвортой байдлын асуудлуудад авах хариу бодлого зохицуулалалтын арга хэмжээнүүд нь хөрөнгө оруулагчдад санхүүгийн эрсдэл болон боломжуудыг олгох, мөн санхүүгийн системийн уян хатан байдалд бүхэлд нь нөлөөлөх боломжтой.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагуудын зүгээс хөрөнгө оруулагчдад санхүүгийн зах зээлийн эрсдэл болон боломжуудын талаарх бүрэн ойлголтыг өгөх үүднээс ил тод байдлыг сайжруулахад ихээхэн ач холбогдол өгч ажиллаж байна. Ил тод байдал нь компанийн гаргасан алдаа болон тэдгээр алдаанууд нь системийн эрсдэлд хэрхэн нөлөөлөх талаар илүү сайн мэдээллийг үнэт цаасны зохицуулагчид болон бодлого боловсруулагчдад олгодог.

Үнэт цаасны зохицуулагчид нь өөрийн зах зээлийн дүрэм журмыг баталж ажиллах нөлөө бүхий байгууллагынхаа хувьд ил тод байдлын мэдээллийн чанар, тоог нэмэгдүүлэх үүднээс дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

1. Сайн дурын тайлагналын удирдамжийг боловсруулах. Найдвартай стандарт аль хэдийн хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа тохиолдолд, Үнэт цаасны зах зээлийн зохицуулагчид шинэ стандарт

гаргахаас илүүтэйгээр өмнөх стандартаа сайжруулах тал дээр ажиллах нь зүйтэй;

2. Бүртгэлийн журамд хэн тайлагнах, юуг тайлагнах, болон хэрхэн тайлагнах талаарх тогтвортой байдлын удирдамжийг тодорхойлж өгөх;
3. Олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц, харьцуулж болохуйц тогтвортой байдлын ил тод байдлын тайлагналыг боловсруулах хүрээнд бусад улс орнуудын ижил төстэй эрх бүхий байгууллагууд болон IOSCO зэрэг олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

Тогтвортой байдлын тайланг гаргадаг компаниудын тоо өссөөр байна. Тухайлбал, 2017 онд явуулсан компанийн хариуцлагын тайлагналын талаарх дэлхийн хэмжээний судалгаагаар дэлхийн томоохон аж ахуйн нэгжүүдийн дийлэнх буюу 78 хувь нь жилийн санхүүгийн тайландаа санхүүгийн болон санхүүгийн бус мэдээллийг нэгтгэх болсон хэмээн KPMG компаниас онцолжээ. Компанийн хариуцлага эсхүл тогтвортой байдлын талаар тайлагнах нь дэлхийн дунд болон томоохон компаниудын хувьд жишиг стандарт болоод байна.

Хүснэгт 3. 2. Ил тод байдлыг нэмэгдүүлсэн олон улсын туршлага

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Индонез	Индонезийн санхүүгийн үйлчилгээг зохицуулах байгууллага 2017 онд шинээр гаргасан журамдаа тогтвортой байдлын тайланг жилийн эцсийн тайландаа тусгаж байхыг бүртгэлтэй бүх санхүүгийн байгууллага, үнэт цаас гаргагч болон хувьцаат компаниудад шаардлага болгосон.
Энэтхэг	2012 оноос Энэтхэгийн үнэт цаасны зохицуулах хорооноос Энэтхэгийн гол 2 арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй зах зээлийн үнэлгээгээрээ эхний 100–д багтах компаниудад Бизнесийн хариуцлагын тайланг жилийн эцсийн тайландаа тусгаж байхыг шаардлага болгожээ. 2015 онд 100 компанийг 500 болгон нэмэгдүүлсэн.
Япон	Японы Санхүүгийн үйлчилгээг зохицуулах байгууллагын дор байгуулагдсан Санхүүгийн системийн зөвлөлийн ил тод байдлын ажлын хэсгийн зүгээс хөрөнгө оруулагчдын бизнесийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах үүднээс бизнесийн стратегийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл өгөх, удирдлагын дүн шинжилгээний дэлгэрэнгүйг жилийн тайландаа тусгаж байх талаар Японы компаниудад санал болгожээ. Ажлын хэсгийн зүгээс мөн SDG–ийн хүчин зүйлсийн талаарх нэмэлт мэдээллийг сайн дураар тайлагнаж байхыг Японы компаниудад санал болгосон.

Эх сурвалж: SSE

3. Хөрөнгө оруулагчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгох

Хариуцлагатай хөрөнгө оруулалт нь ESG–ийн хүчин зүйлсийг хөрөнгө оруулалтын шийдвэртээ тусгах зорилготой арга барил бөгөөд ингэснээрээ эрсдэлийн удирдлагыг сайжруулж, тогтвортой, урт хугацааны өгөөжийг бий болгож байгаа юм. Өнгөрсөн 10 жилийн хугацаанд хариуцлагатай хөрөнгө оруулалт ихээхэн өссөн бөгөөд өнөөдрийн байдлаар шийдвэр гаргах үйл явцдаа ESG–ийн хүчин зүйлсийг тусгасан олон тооны хөрөнгө оруулагчид байгаа юм. Тухайлбал, 2018 оны байдлаар 2000 гаруй хөрөнгө оруулагч, 80 их наяд ам.доллар бүхий хөрөнгийн удирдагчид НҮБ–аас санаачилсан Хариуцлагатай хөрөнгө оруулалтын /Responsible Investment Initiative/ санаачилгын хүрээнд хүлээсэн үүрэг амлалтынхаа хүрээнд ESG–ийн хүчин зүйлсийг анхаарч үзэх болсон.

Дэлхийн тогтвортой хөрөнгө оруулалтын нийгэмлэгийн таамаглаж буйгаар дэлхийн мэргэжлийн хэмжээнд удирдаж буй хөрөнгийн дөрөвний нэгийг хариуцлагатай хөрөнгө оруулалт эзэлж байгаа юм.

20 гаруй улс орон хөрөнгө оруулалтын хариуцлагын тухай журам эсхүл төсөөтэй баримт бичгийг батлан ажиллаж байна. Тэдгээрийн ихэнхийг үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллагууд эсхүл бусад зохицуулагчид боловсруулж, хэрэгжүүлэн идэвхтэй дэмжих ажиллаж байна.

Хүснэгт 3.3. Хөрөнгө оруулагчдын үүрэг хариуцлагыг тодорхой болгосон олон улсын туршлага

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Франц	Францын эрчим хүчний шилжилтийн хуулийн 173-ын 4 дүгээр зүйлд заасны дагуу мэргэжлийн хөрөнгө оруулагчид санал өгөх болон хөрөнгө оруулах шийдвэр гаргахдаа ESG хүчин зүйлсийг хэрхэн харгалзан үзсэн талаар, хөрөнгө оруулалтын багц нь бага нүүрс төрөгч ялгаруулах орчныг бүрдүүлэхэд хэрхэн хувь нэмэр оруулж байгаа болон уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн талаар мэдээлэл өгөх үүрэгтэй.
Өмнөд Солонгос	2015 онд Солонгосын үндэсний тэтгэврийн үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулсан. Тус өөрчлөлт нь Үндэсний тэтгэврийн сан хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахдаа ESG хүчин зүйлсийг харгалзан үзэхийг шаардаж байгаа бөгөөд харгалзан үзээгүй тохиолдолд яагаад үзээгүй талаараа тайлбарлах тухай заажээ.
Хонконг	2016 оны 3 дугаар сард Хонконгийн үнэт цаасны зохицуулах хорооноос Хариуцлагатай өмчлөлийн зарчмыг боловсруулжээ. Энэхүү зарчмууд нь өмчлөлийн үүрэг хариуцлагыг хэрхэн сайн биелүүлэх талаар хөрөнгө оруулагчдад сайн дураар мөрдөх зааварчилгааг өгдөг. Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулж буй компани ESG-ийн асуудлаарх бодлогыг баримталж ажиллахыг хөхүүлэн дэмжих ёстой талаар заажээ.

Эх сурвалж: SSE

4. Засаглалыг бэхжүүлэх

Компанийн тогтвортой байдлын гүйцэтгэлийг хангахад компанийн засаглал чухал үүрэг гүйцэтгэдэг. Удирдлагын бүтэц, эрсдэлийн менежмент, удирдлагын цалин хөлс, тайлан, аудит болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зэрэг нь чухал хэвээр байгаа ч ойрын жилүүдэд компанийн засаглалын асуудал нь ихээхэн анхаарал хандуулах зүйл болсон.

Үнэт цаасны зохицуулагчид нь өөрийн зах зээлийн дүрэм журмыг баталж ажиллах нөлөө бүхий байгууллагынхаа хувьд компанийн засаглалын тогтвортой байдлын цар хүрээг бэхжүүлэх үүднээс дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Үүнд:

1. Тогтвортой байдлын хүчин зүйлсийг компанийн засаглалын кодекст тусгах.
 - Тогтвортой байдлын эрсдэл болон боломжийг удирдах зохих систем, төлөвлөгөөтэй байлгахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлүүдэд шаардлага болгох;
 - Тогтвортой байдлын талаарх чухал асуудлуудаар сургалт, мэдээлэл авсан байхыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд шаардлага болгох;
 - ESG асуудлыг хянах тогтолцоотой байхыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд шаардлага болгох;
 - Тогтвортой байдлын гүйцэтгэл болон удирдлагын цалин хөлсний тогтолцоо хоорондоо уялдаатай байлгахыг компаниудад шаардлага болгох;
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтцийн төрөлжсөн байдлыг дэмжих, тэр дундаа жендерийн ялгаатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогыг баримтлах.
2. Компанийн хувьд гүйцэтгэх өөрсдийн чиг үүргийг тодорхойлсон мэдэгдлийг боловсруулж, түүнийгээ компанийн урт хугацааны эрх ашигт нийцүүлэхийг байгууллагын төлөөлөн удирдах

зөвлөлийн гишүүдэд зөвлөх.

3. SDG болон тогтвортой байдалтай холбоотой асуудлуудын хүрээнд компаниудтай хамтран ажиллах боломжийг хөрөнгө оруулагчдад олгох.

Хүснэгт 3. 4. Засаглалыг бэхжүүлсэн олон улсын туршлага

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Япон	Японы санхүүгийн үйлчилгээг зохицуулах байгууллага болон Токиогийн хөрөнгийн биржийн хамтын ажиллагааны хүрээнд байгуулагдсан хорооноос баталсан Японы компанийн засаглалын Кодекс "Компаниудын зүгээс нийгэм болон хүрээлэн буй орчныг хамарсан тогтвортой байдлын асуудлыг шийдвэрлэхэд зохих арга хэмжээг авч ажиллах шаардлагатай" хэмээн заажээ.
Их Британи	Их Британийн Санхүүгийн тайлагналын зөвлөлийн зүгээс боловсруулсан Их Британийн компанийн засаглалын кодекс "Цалин хөлс, урамшууллын бодлого нь урт хугацааны тогтвортой амжилтыг болон стратегийг дэмжихэд чиглэсэн байх шаардлагатай. Удирдлагын цалин урамшууллын систем нь компанийн үнэ цэнэ, зорилтуудтай нийцэхийн зэрэгцээ компанийн урт хугацааны стратегийг амжилттай хэрэгжүүлэхтэй нягт уялдаатай байх ёстой" хэмээн заасан байдаг.
Кени	2015 онд батлагдсан Кенийн компанийн тухай хуульд компанийн бизнесийн орчны талаарх тоймыг бэлтгэн удирдлагын тайланд тусгаж байхыг бүртгэлтэй компаниудад шаардлага болгожээ. Энэхүү тойм нь бизнесийн ирээдүйн байр суурь, гүйцэтгэл болон хөгжилд нөлөөлөх хүчин зүйлс, гол чиг хандлагыг тодорхойлох шаардлагатай. Мөн нийгэм, ажиллах боловсон хүчин, болон байгаль орчны талаарх мэдээллийг агуулах шаардлагатай. Үүний зэрэгцээ, Кенийн үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын хүрээнд Үнэт цаас гаргагчдын компанийн засаглалын кодексыг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар Кенийн үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллага болон бусад оролцогч талуудад жил бүр мэдээлж байхыг үнэт цаас гаргагчдад үүрэг болгосон.

Эх сурвалж: SSE

5. Чадавхыг бэхжүүлэх

Санхүүгийн систем тогтвортой хөгжлийг дэмжихэд урт хугацааны үнэ цэнэ, тогтвортой байдлыг бий болгох чадавх, боловсон хүчин дутмаг байгаа нь анхаарах ёстой асуудлуудын нэг болсон.

2015 онд SDG батлагдсанаас хойш, тэдгээр зорилтууд хөрөнгө оруулагчдад танигдаж эхлэн, SDG–д оруулах хөрөнгө оруулалтын гарцуудыг эрэлхийлж эхэлсэн. SDG–д хөрөнгө оруулахад учрах саад бэрхшээлийг тодорхойлж, мөн санхүүгийн систем дэх төрөл бүрийн оролцогчдын үүрэг хариуцлага улам бүр ойлгомжтой болж байна. Гэсэн хэдий ч, маш олон институцүүд өөрсдийн үйл ажиллагааны тогтвортой хөгжил болон SDG–уудтай хэрхэн уялдуулах тал дээр туршлага дутмаг байдаг.

Үнэт цаасны зах зээлийн зохицуулагч байгууллагууд ерөнхийдөө дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлснээр SDG–д хувь нэмрээ оруулдаг:

1. Тогтвортой байдалтай холбоотойгоор зах зээлд дутагдаж буй тодорхой чадавх, мэдлэг, мэдээллийн шаардлагад дүн шинжилгээ хийж, тэдгээр шаардлагуудад үндэслэн үнэт цаас гаргагчид, хөрөнгө оруулагчид, болон бусад зах зээлд оролцогчдод зориулан чадавхыг бэхжүүлэх сургалтыг явуулах;
2. Тогтвортой байдлын талаарх хүлээн зөвшөөрөгдсөн түвшний мэдлэг, чадварыг олгоход дэмжлэг үзүүлэх (Тухайлбал, компанийн удирдах түвшний менежерүүд, төлөөлөн удирдах зөвлөл зэрэг гол шийдвэр гаргагчид, ахлах мэргэжилтнүүдэд зориулсан тогтвортой байдлын талаарх мэргэшүүлэх сургалт явуулах);

3. SDG–уудтай холбоотой шилдэг туршлагуудыг хуваалцах пийр тү пийр платформыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх мөн SDG–уудад оруулсан шилдэг хөрөнгө оруулалтын талаарх жишээ, туршлагыг онцлох;
4. Санхүүгийн тогтвортой, уян хатан байдалд нөлөөлөх, компанийг дампууруулахад хүргэх тогтвортой байдлын асуудлуудыг хянах, үнэлэх чадавхыг бий болгох.

Хүснэгт 3. 5. Чадавхыг бэхжүүлсэн олон улсын туршлага

Улс	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Олон улсын байгууллага	2018 оны 7 дугаар сард Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/ нь тогтвортой хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжихэд үнэт цаасны зохицуулагчдын үүрэг оролцоог хэлэлцэх үүднээс зохицуулагчид, арилжаа эрхлэх байгууллагууд, хөрөнгө оруулагчид, үнэт цаас гаргагчид, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчид болон олон улсын байгууллагуудыг хамарсан хурлыг зохион байгуулсан. IOSCO Өсөлт, Хөгжиж буй Орнуудын Хорооноос зохион байгуулсан тус уулзалтаар тогтвортой байдлыг хангах болон хөрөнгө босгоход үнэт цаасны зах зээлийн үүрэг оролцоог судлах ажлын хүрээнд Хорооноос гүйцэтгэх ажил үүргийг тодорхой болгох үүднээс хэлэлцүүлгийг өрнүүлсэн.
Турк Улс	2013 онд Туркийн тогтвортой байдлын платформ байгуулагдсан бөгөөд гишүүдээр Хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага, Арилжаа эрхлэх байгууллага, салбарын холбоод болон төрийн бус байгууллагууд багтаж байна. Энэхүү платформын зорилго нь тогтвортой байдлыг хөгжүүлэх хүрээнд хийгдэх үйл ажиллагааг дэмжих, тогтвортой хөгжлийн чиглэлээр цаашид хийх алхмуудын талаар хэлэлцэх боломжийг хангахын тулд олон талт оролцогчдын сүлжээг бий болгох явдал юм. Тус платформ нь тогтвортой байдлын талаар холбогдох дүрэм, журамд тусгах асуудлыг дэмжих, мөн бусад холбогдох олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг олгож байгаа юм.
Малайз	Малайз Улсын Үнэт цаасны хороо нь тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс төрөл бүрийн чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр болон олон улсын хурал зөвлөгөөнүүдийг зохион байгуулж байсан. Ногоон төслүүдийг санхүүжүүлэх ногоон үнэт цаас гаргагчдын холбоо, ногоон санхүүгийн экосистемийг бэхжүүлэх хүрээнд Дэлхийн банк, Малайзын төв банк, Малайзын үнэт цаасны хорооны бүрэлдэхүүн бүхий ажлын хэсэг байгуулагдсан.

Эх сурвалж: SSE

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Олон улсад мөрдөгдөж буй тогтвортой санхүүжилтийн шилдэг туршлага, тогтвортой санхүүжилтийг дэмжих үүднээс улс орнуудын зохицуулагч байгууллагуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, баримталж буй зарчмуудад үндэслэн мөн Монголын үнэт цаасны зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр Санхүүгийн Зохицуулах Хорооны зүгээс авч хэрэгжүүлж болохуйц үйл ажиллагаануудын жагсаалтыг гаргав. Үйл ажиллагаа бүрийг SSE-ээс боловсруулсан Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад зохицуулагч байгууллагын зүгээс авч хэрэгжүүлбэл зохих 5 чиглэлийн хүрээнд ангилан гаргав.

Хөрөнгө оруулалтыг дэмжих

- Ногоон үнэт цаас, ногоон бондыг хөгжүүлэх төсөл хөтөлбөрийг бусад холбогдох байгууллагуудтай хамтран санаачилж, хэрэгжүүлж ажиллах;
- Үнэт цаасны бүртгэлийн журамд ногоон бондыг бүртгэхтэй холбоотой тусгай заалтууд тусгах, ногоон бондын санхүүжилтийн өртгийг бууруулах талаас арга хэмжээ авах.

Ил тод байдлыг нэмэгдүүлэх

- Монголын арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэйгээр үнэт цаасаа арилжиж буй компаниудыг нийгэм, байгаль орчин, засаглалын хариуцлагын талаар тайлагнахыг шаардах. /Уул уурхай болон аж үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудад тэргүүн ээлжид тайлагнахыг шаардлага болгох/;
- Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын ил тод байдлын тайлагналыг журмыг батлах эсхүл одоогийн мөрдөгдөж буй холбогдох дүрэм журамд ил тод байдлын тайлагналын талаарх заалтуудыг тусгаж өгөх.

Үүрэг хариуцлагыг тодорхой болгох

- Хөрөнгө оруулахдаа үнэт цаас гаргагчийн нийгэм, хүрээлэн буй орчин, засаглалын хариуцлагыг харгалзан үзэх, хэрхэн харгалзах талаарх заавар зөвлөмжийг хөрөнгө оруулагчдад өгөх.

Засаглалыг бэхжүүлэх

- Үнэт цаас гаргагчдын удирдлагын баг, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд зориулж тогтвортой байдал, нийгэм, хүрээлэн буй орчин, засаглалын хариуцлагын талаар сургалт явуулах, тус сургалтад заавал хамрагдсан байхыг шаардлага болгох;
- Бүртгэлтэй компаниуд тогтвортой байдлын хүчин зүйлсийг компанийн засаглалын кодекст тусгахыг шаардлага болгох.

Чадавхыг бэхжүүлэх

- Тогтвортой санхүүжилтийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх үүднээс чадавхыг бэхжүүлэх хурал, зөвлөгөөн, нээлттэй өдөрлөгийг зохион байгуулах, компанийн удирдах түвшний ажилтнуудад зориулж тогтвортой байдлын талаар мэргэшүүлэх сургалтыг явуулах

ДОЛОО. ЭХ СУРВАЛЖ

DESA, UN. "68% of the world population projected to live in urban areas by 2050, says UN." *United Nations Department of Economic and Social Affairs*. 2018.

IOSCO. "Sustainable finance in emerging market and the role of securities regulators". 2019.

Maimbo, Samuel Munzele, and Simon Zadek. "Roadmap for a sustainable financial system." 2017.

Sustainable Stock Exchanges Initiative. "How securities regulators can Support the Sustainable Development Goals: A sharing of experiences." *Nueva York* (2018).


Sustainable Stock Exchanges Initiative. "2018 Report on Progress: A paper prepared for Sustainable Stock Exchanges, 2018 Global Dialogue". 2018.

Waygood, Steve. "A Roadmap for Sustainable Capital Markets: How Can the UN Sustainable Development Goals Harness the Global Capital Markets?." *Aviva White Paper*. 2014.

Монголын хөрөнгийн бирж. Жилийн тайлан, Улаанбаатар. 2017

Санхүүгийн зохицуулах хороо. "Санхүүгийн зохицуулах хороо олон улсын санхүүгийн корпорацитай хамтран ажиллана". 2020





МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ: ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ

2020 он

Гүйцэтгэсэн: Н.Нарантуяа¹, Б.Батчимэг², Л.Дөлгөөн³,
Б.Мөнх-Эрдэнэ⁴

¹ Санхүүгийн зохицуулах хороо, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, narantuya@frc.mn

² Санхүүгийн зохицуулах хороо, Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

³ Монголбанк, Судалгаа, статистикийн газрын эдийн засагч, dulguun.l@mongolbank.mn

⁴ Монголбанк, Судалгаа, статистикийн газрын эдийн засагч, bmunkherdene@mongolbank.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар макро зохистой бодлогын хүрээнд Монголбанкнаас хэрэгжүүлж буй арилжааны банкуудын хэрэглээний зээлд хязгаарлалт тавих бодлогын банк бус санхүүгийн байгууллагуудад (ББСБ) үзүүлэх нөлөө болон макро зохистой бодлогыг ББСБ-уудад хэрэгжүүлэх боломж, үүсэж болзошгүй эрсдэлийн талаар судалсан. Уг бодлогын нөлөөний шинжилгээнд ББСБ-уудын улирлын панель өгөгдлийг ашиглан ББСБ-уудын зээлийн эрэлт, нийлүүлэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсүүдийг тодорхойлсон. Судалгааны үр дүнгээр сүүлийн жилүүд дэх ББСБ-уудын зээлийн өндөр өсөлтөд голлон ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттайгаар нэмэгдүүлсэн бодлого, мэдээллийн технологийн дэвшлийг ашигласан финтекийн салбарын огцом өсөлт болон арилжааны банкуудын хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын нөлөөгөөр тайлбарлагдаж байна.

Тухайлбал зээлийн эрэлт, нийлүүлэлтийн загварын үнэлгээгээр хэрэглээний зээлд хязгаарлалт тавьсантай холбоотойгоор банкууд зээлийн шалгуураа чангаруулах нь ББСБ-уудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээл нь мөчлөг сөрсөн шинжтэй буюу банкны зээлийг тодорхой хэмжээнд орлож иргэдийн шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг нөхдөг бөгөөд үйл ажиллагаа нь “сүүдрийн банк”-ны шинжтэй байна. Мөн өөрийн хөрөнгийн өсөлт нь ББСБ-уудын зээл олгох эх үүсвэрийн хүрэлцээг сайжруулж улмаар зээлийн нийлүүлэлт нэмэгдэх гол хүчин зүйл болж байгаа нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Түлхүүр үгс: макро зохистой бодлого, ББСБ, сүүдрийн банк, эрэлт-нийлүүлэлтийн загвар;

JEL ангилал: E58, G23, C26 C36

НЭГ. УДИРТГАЛ

Дэлхийн санхүүгийн хямрал 2008 онд тохиолдсоноос хойш макро зохистой бодлого нь хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудад санхүүгийн тогтвортой байдлыг хангах чухал бодлогын арга хэрэгсэл болсон. Уг хямралаар санхүүгийн секторын аль нэг институцийн үйл ажиллагаа хэвийн, эрүүл явагдаж байгаа хэдий ч санхүүгийн систем бүхлээрээ системийн эрсдэлд эмзэг, өртөмтгий байх боломжтойг харуулсан (Shin, 2010). Иймээс улс орнууд макро эдийн засаг болон санхүүгийн тогтвортой байдлаа хангахын тулд макро зохистой бодлогыг микро зохистой бодлого, валютын ханшийн бодлого болон мөнгөний бодлоготой хавсарган хэрэгжүүлсээр ирсэн.

Түүнчлэн Төв банкууд үнийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах хос зорилтдоо хүрэхийн тулд дан ганц мөнгөний бодлогын арга хэрэгслүүдээр зохицуулах нь хангалтгүй бөгөөд үр дүн багатай гэдгийг олон улсад хийгдсэн судалгааны ажлууд нотлон харуулдаг (BIS, 2017). Иймд макро зохистой бодлогыг хариуцан хэрэгжүүлж буй Төв банкууд өөрсдийн орны эдийн засгийн онцлог болон тухайн үүссэн нөхцөл байдал, эрсдэлээс хамааран макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг харилцан ялгаатайгаар ашиглаж байна. Макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх эцсийн зорилго нь хямралын удирдлагаас илүүтэйгээр санхүүгийн системийн эрсдэл даах чадварыг дээшлүүлэх болон эдийн засаг, санхүүгийн сектор дах хэт халалтыг хязгаарлахад чиглэгддэг. Хоёрдугаар зорилгын хувьд макро зохистой бодлого нь дангаараа үр дүнд хүрэх боломж хомс бөгөөд бусад макро эдийн засгийн бодлогуудтай хэр уялдаатай хэрэгжихээс ихээхэн хамаардаг.

Манай улсын хувьд эдийн засгийн бүтэц төрөлжөөгүй, дотоод хуримтлал хангалттай бүрэлдээгүй, хөрөнгийн дотогшлох урсгал болон гадаад зах зээл дээрх түүхий эдийн үнийн хэлбэлзлээс өндөр хамааралтай, банкны салбар давамгайлсан санхүүгийн системтэй зэрэг нь санхүүгийн секторын эмзэг байдлыг нэмэгдүүлэх гол хүчин зүйлс болдог. Иймд Монголбанкнаас санхүүгийн секторын үйл ажиллагаа доголдож системийн хямралд өртөх, түүний бодит эдийн засагт хүчтэй сөрөг үр дагавар авчрахаас урьдчилан сэргийлэх, системийн эрсдэлийг бууруулж санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд макро зохистой бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна.

Тухайлбал сүүлийн жилүүдэд банкнаас иргэдэд олгосон хэрэглээний зээлийн жилийн өсөлт дунджаар 30 орчим хувьд хүрч хурдацтай өссөнөөр өрхийн өрийн түвшинг нэмэгдүүлэх хандлагатай болсон. Энэ нь богино хугацаанд санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг эрчимжүүлэх, гүнзгийрлийг дээшлүүлэх, банкны салбарын ашигт ажиллагааг нэмэгдүүлэх хэдий ч дунд, урт хугацаанд өрхийн өрийн дарамтыг нэмэгдүүлэх, санхүүгийн чадавхыг муутгах болон дотоод хуримтлалыг бууруулах нөлөөтэй юм.

Мөн хэрэглээний зээлийн хэт өсөлт нь импортын хэрэглээг өдөөж гадаад худалдааны алдагдлыг нэмэгдүүлэх, валютын ханшийн сулралтыг даамжруулах, гадаад өрийн дарамтыг ихэсгэх зэрэг макро эдийн засаг болон санхүүгийн секторын эмзэг байдлыг нэмэгдүүлж санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Иймд иргэдийн өрийн дарамтыг бууруулах, банк санхүүгийн байгууллагын тогтвортой байдлыг хангах, хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлтийг хязгаарлаж зээлийн эх үүсвэрийг бусад өндөр үр ашигтай салбаруудад шилжүүлэх зорилгоор Монголбанкнаас арилжааны банкуудын хэрэглээний зээлд өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 70%-д болон хугацааны дээд хязгаарыг 30 сар байхаар хязгаарлалт тавьсан. Энэхүү макро зохистой бодлогыг хэрэгжүүлснээр 2019 онд банкууд дахь хэрэглээний зээлийн өсөлт саарч дунджаар жилийн 8%, зээлийн дундаж хугацаа багасаж дунджаар 15 сар болсон нь уг бодлогын арга хэмжээ үр дүнгээ өгч байгааг харуулж байна.

Гэвч арилжааны банкууд зээлийн шалгуураа чангаруулсан үед уг шалгууруудыг хангаагүй иргэдийн эрэлт ББСБ, ломбард зэрэг бусад санхүүгийн байгууллагууд руу шилжиж харьцангуй хатуу нөхцөлтэйгөөр зээл авахад хүргэж болзошгүй. Энэ нь иргэдийг өндөр хүүний дарамтад оруулах, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх, улмаар зээлийн чанарыг муутгаж зээлийн эрсдэлийг нэмэгдүүлнэ. Ингэснээр банкны системд хуримтлагдаж байсан эрсдэл банкны бус санхүүгийн сектор руу шилжих, урт хугацаанд өрхийн өрийг бууруулахад чиглэсэн бодлогын үр нөлөөг сулруулах эрсдэлтэй юм. Иймд энэхүү судалгааны ажлаар Монголбанкнаас банкууд дахь иргэдийн хэрэглээний зээлд хязгаарлалтууд тогтоосонтой холбоотой банкнаас бусад санхүүгийн салбарын зээлийн өсөлтөд гарсан өөрчлөлт, тус салбарт макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх боломжийн талаар судлахыг зорьсон.

Гадаад болон дотоод шокоос үүдэлтэй макро эдийн засгийн тааламжгүй нөхцөл байдал үүсэж санхүүгийн секторын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй болсон үед төрөөс (ихэвчлэн Төв банк) санхүүгийн систем дэх хяналт, шалгалтын үйл ажиллагаагаа эрчимжүүлэх, арилжааны банкууд зээлийн нөхцөл, шалгуураа чангаруулах зэргээс шалтгаалан эдийн засаг дахь банкны зээлийн нийлүүлэлт хумигддаг. Энэ үед ББСБ-ууд буюу сүүдрийн банкны үйл ажиллагаа эрчимжин банкны зээлийг орлож иргэдийн шаардлагатай санхүүжилтийг нөхөх тодорхой хэмжээний эх үүсвэр болдог байна (Meeks, Nelson , & Alessandri , 2014).


Түүнчлэн сүүдрийн банкны үйл ажиллагаа эрчимжих нь бодит эдийн засаг дахь санхүүжилтийн зөрүүг нөхөх ба зах зээлийн үр ашигт байдлыг нэмэгдүүлэх давуу талтай ч зээлийн хөшүүргийг ихэсгэх, мөчлөгийн далайцыг нэмэгдүүлэх болон системийн эрсдэлийн тархалтыг эрчимжүүлэх зэрэг сөрөг нөлөөтэй байдаг. Иймд зохицуулагч байгууллагын зүгээс бодлогын арга хэрэгслүүдээр дамжуулан “сүүдрийн банкны” үйл ажиллагаанд зохицуулалтуудыг хийх, системийн эрсдэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй гэж үздэг (Ghosh 2012; Schwarcz, 2016).

Энэхүү судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Судалгааны хоёрдугаар бүлэгт хэрэглээний зээлийн хязгаарлалт нь арилжааны банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын зээлд хэрхэн нөлөөлснийг авч үзсэн. Гуравдугаар бүлэгт уг макро зохистой бодлогын хязгаарлалт нь ББСБ-уудын зээлийн эрэлт нэмэгдэхэд нөлөөлсөн эсэхийг тогтоохын тулд эрэлт, нийлүүлэлтийн загварыг ашиглан эконометрик шинжилгээг гүйцэтгэв. Харин дөрөвдүгээр бүлэгт макро зохистой бодлогыг ББСБ-д хэрэгжүүлэх боломж, үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлсон бол тавдугаар бүлэгт олон улсад ББСБ-д хэрэглээний зээлийн хязгаарлалт тавьж байсан туршлагын талаар судалсан. Түүнчлэн судалгаанаас гарсан үр дүнд тулгуурлан дүгнэлт болон санал зөвлөмжийг энэхүү судалгааны ажлын зургаадугаар бүлэгт тусгалаа.


ХОЁР. ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛИЙН ХЯЗГААРЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ

Гадаад орчны нөхцөл байдал 2017 оноос сайжирч эдийн засагт сэргэлт ажиглагдаж эхэлснээр иргэдийн зээлийн эрэлт идэвхжиж улмаар шинээр олгож буй зээлийн өсөлт эрчимтэй нэмэгдэх хандлагатай болсон. Тухайлбал иргэдийн зээл түүн дотроо хэрэглээний зээлийн өсөлт эрчимжиж 2017–2018 онд 30%-д хүрсэн бөгөөд иргэдийн зээлийн өсөлтийн дийлэнхийг тайлбарлаж байна (Зураг 1). Иргэдийн зээл өсөхийн хэрээр өрхийн өр, орлогын харьцаа нэмэгдэж иргэд орлогынхоо дийлэнх хэсгийг зээлийн эргэн төлөлтөд зарцуулахад хүргэж байна. Түүнчлэн өрхийн нийт зээлд эзлэх хэрэглээний зээлийн хувь өсөх хандлагатай буюу иргэд зээлээ ирээдүйд өгөөж авчрах бизнест зориулахаас илүүтэйгээр хэрэглээ болон орон сууц худалдан авахад зарцуулж байгаа нь өрхийн өрийн түвшнийг нэмэгдүүлж өрийн дарамтад оруулах эрсдэлтэй юм (Зураг 2).

Зураг 4. 1. Банкуудаас иргэдэд олгосон зээлийн жилийн өсөлт



Зураг 4. 2. Өрхийн өр, орлогын харьцаа



Эх сурвалж: Монголбанк


Улмаар Монголбанк нь иргэдийн хэрэглээний зээлийн өрийн дарамтыг бууруулах, санхүүгийн салбарт хэрэглээний зээлээс хамааралтай эрсдэл үүсэхээс сэргийлэх, банкны эх үүсвэрийг бизнесийн салбарын хөрөнгө оруулалтад чиглүүлэх зорилгоор банкуудаас иргэдэд олгох хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогыг 2019 оны 01 дүгээр сарын 01–ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Тухайлбал, мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр 2019 оноос эхлэн банкуудаас иргэдэд шинээр олгох хэрэглээний зээлийн хугацааны дээд хязгаарыг 30 сараар, зээлдэгчдийн өр, орлогын харьцааны дээд хязгаарыг 60–70%¹ байхаар тус тус тогтоосон. Ингэснээр тус бодлогын арга хэмжээ хэрэгжиж эхэлсэн буюу 2019 оноос эхлэн хэрэглээний зээлийн өсөлт саарсан бөгөөд эсрэгээрээ бизнесийн зээлийн өсөлт нэмэгдэх хандлагатай болсон. Мөн шинээр олгосон хэрэглээний зээлийн хугацаа богино болсон (Зураг 3) ба хэрэглээний зээлтэй иргэдийн өр, орлогын харьцаа буурч хязгаарлалтаас доогуур түвшинд хадгалагдаж байна (Зураг 4).

¹ 2019.01.01–ний өдрөөс эхлэн 70%; 2019.04.01–ний өдрөөс тэтгэврийн зээлээс бусад хэрэглээний зээлд 60%–иар тогтоох шийдвэр гарсан

Зураг 4.3. Банкуудаас олгосон хэрэглээний зээлийн жигнэсэн дундаж хугацаа




Зураг 4.4. Хэрэглээний зээлийн үлдэгдэлтэй иргэдийн өр, орлогын харьцаа



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү макро зохистой бодлогын нөлөө нь банкуудаас иргэдэд шинээр олгох хэрэглээний зээлийн дүн болон бүтцэд томоохон өөрчлөлтийг бий болоход нөлөөлжээ. Тухайлбал банкуудаас иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээл сард дунджаар 600 тэрбум төгрөг байсан бол бодлогын хэрэгжилтийн дараагаар 400 орчим тэрбум төгрөг болж буурсан байна. Түүнчлэн шинээр олгосон цалингийн зээл 2018 оны эцэст огцом өсөх хандлагатай болсноос харахад бодлого хэрэгжиж эхлэхээс өмнө иргэд урьтаж зээлийн эрэлтээ огцом нэмэгдүүлсэн байх талтай.

Зураг 4.5. Банкуудаас иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээл



Зураг 4.6. Банкны зээлийн шалгуурын индекс, хэрэглээний зээлийн өсөлт




Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас улирал тутам гүйцэтгэдэг банкны зээлийн төлөвийн түүвэр судалгаагаар арилжааны банкуудаас зээл олгох үйл ажиллагааны шалгуурын индексийг тооцоолдог. Уг индекс өсөх нь зээл олголтын шалгуур чанга, буурах нь шалгуур суларч байгааг илтгэдэг. Иргэдэд олгох зээлийн шалгуурын индекс буурах үед банкуудаас олгосон хэрэглээний зээл өсөлттэй, тус индекс өсөх үед хэрэглээний зээл бууралттай байна (Зураг 6).


Иргэдийн хэрэглээний зээл хязгаарлах бодлогыг зөвхөн банкууд дээр хэрэгжүүлснээр уг зээл нь

ББСБ-ууд руу шилжиж, макро зохистой бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэл бий. Өөрөөр хэлбэл банкны шаардлага хангаагүй иргэд ББСБ-аас зээл авч, банкны системд байсан эрсдэл банк бус санхүүгийн салбарт шилжих боломжтой бөгөөд энэ нь урт хугацаанд өрхийн өрийн дарамтыг бууруулах зорилготой бодлогын нөлөөг сулруулж болзошгүй юм.

Зураг 4. 7. Иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээл



Зураг 4. 8. Зээлийн дансны тоо



Эх сурвалж: Монголбанк, СЗХ

Манай улсын хувьд ББСБ-аас иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл нь дунджаар банкуудаас иргэдэд олгосон зээлийн 10 хувьтай тэнцүү байдаг (Зураг 7). Хэдийгээр санхүүгийн системийн ихэнх зээлийг банкны салбар олгож байгаа ч ББСБ-аас иргэдэд шинээр олгож буй зээлийн дүн, зээлдэгчдийн тоо улирал тутам өсөх хандлагатай байна² (Зураг 7, 8). Тухайлбал, 2018 онд ББСБ-аас иргэдэд олгосон зээлийн жилийн өсөлт дунджаар 70 хувь, харин 2019 оны эхний гурван улиралд олгосон зээлийн дүн 400 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад дунджаар 62 хувиар өсжээ (Зураг 9). Түүнчлэн иргэдэд шинээр олгосон зээлийн 40 орчим хувийг технологийн дэвшилд суурилсан буюу гар утсаар олгосон зээл эзэлж байна (Зураг 10).

Зураг 4. 9. Иргэдэд шинээр олгосон зээл, өсөлт



Зураг 4. 10. ББСБ-аас иргэдэд шинээр олгосон хэрэглээний зээлийн бүтэц



Эх сурвалж: СЗХ

² Хадгаламж, зээлийн хоршоодын нийт зээлийн үлдэгдэл 163 тэрбум төгрөг буюу санхүүгийн системд злэх хувь харьцангуй бага тул шинжилгээнд авч үзээгүй болно.

Харин ББСБ–ын эх үүсвэрийн бүтцийг авч үзвэл дунджаар 75 хувь нь хувь нийлүүлсэн хөрөнгө (ХНХ) буюу өөрийн хөрөнгөөс бүрдэж байгаа бол дотоод, гадаадын банк санхүүгийн байгууллагаас авсан зээл дунджаар 12 орчим хувийг эзэлж байна (Зураг 11). Эндээс ББСБ–ын хувьд өөрийн хөрөнгийн өсөлт нь зээлийн өсөлтөд хамгийн чухал нөлөөтэйг харж болохоор байна. ББСБ–ын зээлийн өсөлт нь 2011–2016 оны хооронд ХНХ–ийн өсөлтөөр тодорхойлогдож байсан бол 2018 оноос эхлэн зээлийн өсөлт харьцангуй эрчимжсэн нь ХНХ–ийн өсөлтөөс гаднах бусад хүчин зүйлсийн нөлөөг харуулж байна (Зураг 12).

Зураг 4. 11. ББСБ–ын пассивын бүтэц




Зураг 4. 12. ББСБ–ын ХНХ болон зээлийн үлдэгдлийн өсөлт




Эх сурвалж: СЗХ

ББСБ–ын зээлийн үлдэгдлийг хугацааны ангиллаар үзвэл нийт дүнгийн 94.6 хувь нь 30 сар буюу 2.5 жилээс бага (24.9 хувь нь 1 жилээс бага, 69.7 хувь нь 1 – 2.5 жил, 5.1 хувь нь 2.5 – 5 жил, 0.3 хувь нь 5–аас дээш жил) хугацаатай олгогджээ (Зураг 11). Харин өр, орлогын харьцаа нь 70 хувиас давсан зээлдэгчдийн дийлэнх нь шуурхай, автомашины зээлтэй иргэд байгаа бол бусад хэрэглээний зээлтэй иргэдийн 99.5 хувь нь өр, орлогын харьцаа 70 хувиас бага байна (Зураг 12).

Зураг 4. 13. ББСБ–уудын нийт зээлийн үлдэгдэл, хугацааны ангиллаар



Зураг 4. 14. ББСБ–ын зээлдэгчдийн өр, орлогын харьцаа




Эх сурвалж: СЗХ

Түүнчлэн энэхүү судалгааны сэдэвтэй холбоотой боломжит бүх тоон мэдээллийн эх үүсвэрийг ашиглах зорилгоор Монголбанк, СЗХ-ны банк, ББСБ-ын албан статистикаас гадна Зээлийн мэдээллийн сан дахь өгөгдлийг ашиглав. Монголбанкны Зээлийн мэдээллийн сан нь санхүүгийн байгууллагуудаас авсан зээлдэгчдийн мэдээллийг бүртгэдэг нэгдсэн сан юм. Уг санд байгаа нийт мэдээллээс банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагаас 2018–2019 оны хооронд иргэдэд шинээр олгосон зээлийн мэдээллийн дүнг нэгтгэн шинжиллээ.

Зураг 4. 15. Зээлдэгчдийн тоо (ББСБ, давхардсан тоогоор)



Зураг 4. 16. Зээлийн дүн, ББСБ



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн мэдээллийн сангийн тооноос харахад хэрэглээний зээлд хязгаарлалт тавьснаар ББСБ-аас шинээр олгосон зээлийн дүн болон зээлдэгчдийн тоо нь 2019 оны 1-р сард буюу хязгаарлалт хэрэгжиж эхэлсэн үед огцом өсөжээ. Иймд ББСБ-аас олгосон зээлийн дүн болон зээлдэгчдийн тоо нь банктай харьцуулахад бага хэмжээтэй хэдий ч банкуудын хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалт нь ББСБ-уудын зээлдэгчдийн тоог өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байх талтай байна.

Энэхүү бүлэгт авч үзсэн дээрх тоон мэдээллүүдээс харахад ББСБ-ын зээлийн өндөр өсөлт нь дараах хүчин зүйлсүүдээр голлон тайлбарлагдаж болохоор байна.

- Нэгдүгээрт, Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны шийдвэрээр ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх шийдвэр гарсан. Уг шийдвэрээр ББСБ тус бүрийн ХНХ-ийн доод хэмжээг байршлаас нь хамааран 2018, 2019, 2020, 2021 онд харгалзан Улаанбаатар хотод 1.0, 1.4, 1.9, 2.5 тэрбум төгрөг, Орхон, Дархан-Уул аймгуудад 250, 350, 474, 600 сая төгрөг, бусад аймгуудад 70–200 сая төгрөг хүртэл нэмэгдүүлэхээр болсон. ББСБ-ууд нь хадгаламж татдаггүй бөгөөд голчлон өөрийн хөрөнгөөр зээлийн бүтээгдэхүүнээ санхүүжүүлдэг тул энэхүү хөрөнгийн өсөлт нь зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чухал хүчин зүйлс юм.
- Хоёрдугаарт гар утасны программ, техник, технологийн дэвшлийн дагуу Финтекийн салбарын огцом өсөлт нь 2018 оноос хойш ББСБ дахь хэрэглэгчдийн тоо, шинээр олгох зээлийн тоо, дүнг огцом өсгөх гол хүчин зүйлсийн нэг болсон.
- Гуравдугаарт, банкуудаас иргэдэд олгох хэрэглээний зээлийн хязгаарлалт бүхий макро зохистой бодлогын нөлөөгөөр зарим иргэдийн хэрэглээний зээл нь ББСБ-уудын зах зээл рүү шилжсэн байх магадлалтай. Гэвч ББСБ-уудын иргэдэд шинээр олгож буй зээлийн дүн нь банкны салбартай харьцуулахад харьцангуй бага бөгөөд 2017–2019 оны хооронд банкны салбарын зээлтэй харьцуулахад дунджаар 10 хувийг олгож байна.

ГУРАВ. ЭКОНОМЕТРИК ШИНЖИЛГЭЭ

Зээлийн зах дээр иргэд, аж ахуйн нэгжүүдийн эрэлт болон санхүүгийн зуучлагч байгууллагуудын нийлүүлэлтээр тэнцвэрт хүү (үнэ) болон хэмжээ тодорхойлогдож байдаг. Зах зээлийн тэнцвэр өөрчлөгдөхөд эрэлтийн эсвэл нийлүүлэлтийн талын аль хүчин зүйлс давамгайлсныг шинжилж тогтоох нь бодлогын хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх, дамжих сувгийг тодорхойлох зэрэгт чухал ач холбогдолтой юм.

Эрэлт, нийлүүлэлтийн загвар

Энэ хэсэгт Mauricio, Pablo, ба Daniel (2010) болон Behrendt (2016) нарын ажилд тулгуурлан ББСБ–ын зээлийн эрэлт, нийлүүлэлтийн функцийг загварчлах, тэдгээрт нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох эмпирик шинжилгээг гүйцэтгэсэн. Зээлийн эрэлт (L_t^D) болон нийлүүлэлтийн (L_t^S) функц нь зээлийн хүү болон бусад экзоген хувьсагчдаас хамаарсан систем тэгшитгэл байна.

$$L_t^S = \alpha_1 + \alpha_2 r_t + \alpha_3 z + \epsilon_t^S \quad (1)$$

$$L_t^D = \beta_1 + \beta_2 r_t + \epsilon_t^D \quad (2)$$

Зээлийн зах дээр тэнцвэрийн нөхцөл үргэлж хангагддаг гэж таамагласан бөгөөд эрэлт болон нийлүүлэлтийн шокууд ($\epsilon_t^D, \epsilon_t^S \sim i.i.d$) нь уг тэнцвэрийн нөхцөлд нөлөөлнө. Мэдрэмжийн коэффициентууд болох $\alpha_2 > 0, \beta_2 < 0$ байвал нийлүүлэлт болон эрэлтийн муруй нь харгалзан эерэг болон сөрөг налалттай байна. Хэрэв зээлийн нийлүүлэлтэд ямар нэг хязгаарлалттай тохиолдолд $\alpha_3 < 0$ утга авна. (1) болон (2) дахь систем тэгшитгэлүүдийн хураангуйлсан хэлбэрийг бичвэл дараах байдалтай болно.

$$r_t = \frac{1}{1 - \alpha_2/\beta_2} \left[\frac{\alpha_1 - \beta_1}{\beta_2} + \frac{\alpha_3}{\beta_2} z + \frac{1}{\beta_2} (\epsilon_t^S - \epsilon_t^D) \right] \quad (3)$$

$$L_t = \frac{1}{1 - \alpha_2/\beta_2} \left[\alpha_1 - \frac{\alpha_2 \beta_1}{\beta_2} + \alpha_3 z - \frac{\alpha_2}{\beta_2} \epsilon_t^D + \epsilon_t^S \right] \quad (4)$$

Тэгшитгэл (3) болон (4)–ээс харахад зээлийн хүү болон зээлийн нийлүүлэлтийн хэмжээ нь эрэлт болон нийлүүлэлтийн бүтцийн шокуудаас зэрэг хамаарч байна. Иймд зээлийн хүү болон хэмжээний хоорондох хамаарлыг үнэлэх нь ($L_t = \gamma_0 + \gamma_1 r_t + \eta_t$) эрэлт, нийлүүлэлтийн мэдрэмжүүдийн (γ_1) талаар нарийн мэдээлэл өгч чадахгүй байх талтай. Тухайлбал мэдрэмжийн коэффициент γ_1 нь эрэлт, нийлүүлэлтийн мэдрэмжүүдийн жигнэсэн дундаж болохыг дараах тэгшитгэлээс харж болно.

$$\mathbb{E}(\hat{\gamma}_1) = \beta_2(1 - \omega) + \alpha_2 \omega \quad (5)$$

$$\omega = \frac{\sigma_{\epsilon^D}^2}{\alpha_3^2 \sigma_z^2 + \sigma_{\epsilon^S}^2 + \sigma_{\epsilon^D}^2} \quad (6)$$

Тиймээс зээлийн эрэлт, нийлүүлэлтийн муруйн налалтыг тодорхойлоход нэг тэгшитгэлт загвараас илүүтэйгээр ялгаварлах хязгаарлалт (*exclusion restriction*) бүхий инструмент хувьсагчийн (*instrumental variable-IV*) аргачлалд тулгуурлан үнэлэх нь илүү үр дүнтэй бөгөөд бодит мэдээллээр хангах боломжтой байдаг (Mauricio, Pablo, & Daniel, 2010). Тэгшитгэл (7) болон (8)–д зээлийн эрэлт, нийлүүлэлтийн функцийг зээлийн хүү болон бусад экзоген хувьсагчдаас хамаардаг гэж үзье.

$$L_t^D = \alpha r_t + Z^D \Gamma + \epsilon_t^D \quad (7)$$

$$L_t^S = \beta r_t + Z^S \Upsilon + \epsilon_t^S \quad (8)$$

$$L_t^* = L_t^D = L_t^S \quad (9)$$

Энд Z^D болон Z^S нь систем дэхь экзоген хувьсагчдын векторыг илэрхийлэх бол Γ болон Υ нь харгалзах параметруудийн вектор байна. L_t^D болон L_t^S -ийн тэнцвэрээр (9) зах зээлийн тэнцвэр тодорхойлогдоно.

$$\mathbb{E}[(Z^{S,D})'(\epsilon^{S,D})] = \mathbb{E}[(\epsilon^S)'(\epsilon^D)] = 0 \quad (10)$$

$$\mathbb{E}[(Z^{S,D})'(r_t)] \neq 0 \quad (11)$$

Инструмент хувьсагчийн үнэлгээ нь инструмент хувьсагч болон шокуудын хоорондох ковариацийг тэгтэй тэнцүү (9) буюу экзоген байх мөн тус хувьсагч нь эндоген хувьсагчтай хамааралтай (10) гэсэн үндсэн хоёр нөхцөл хангагдахыг шаардана.

Тоон өгөгдөл

Энэхүү шинжилгээнд нийт 187 ББСБ–уудын 2016 оны 3 дугаар улирлаас 2019 оны 2 дугаар улирал хүртэлх панель өгөгдлийг ашиглан банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын хувьд зээлийн эрэлт, нийлүүлэлтийн хоёр тэгшитгэлт загварыг үнэлсэн³. Тайлбарлагдагч хувьсагчийн хувьд тухайн улиралд олгосон зээлийн логарифм утгын улирлын өөрчлөлт буюу өсөлтийг ($dlnloan_{it}$) авч үзсэн. Харин тайлбарлагч хувьсагчуудын хувьд эрэлт, нийлүүлэлтийн талын хүчин зүйлсээс хамаарч тэгшитгэл тус бүрд ялгаатай сонгогдсон. ББСБ–ын сарын зээлийн хүү (lr_{it}) нь зах зээл дээрх зээлийн эрэлт, нийлүүлэлтийн аль ч талд нөлөөлөх боломжтой бөгөөд нийлүүлэлт талаас орлогын нөлөөг, эрэлт талд зардлын нөлөөг харуулна.

Нийлүүлэлтийн талын бусад экзоген хувьсагчдад төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт ($liqratio_{it}$), зээлийн харьцаа ($loanratio_{it}$), өөрийн хөрөнгийн логарифм ($lncap_{it}$) зэрэг ББСБ–уудын балансын үзүүлэлтүүдийг тусгасан. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг үнэт цаас болон бэлэн мөнгөний нийлбэрийн нийт активд эзлэх харьцаагаар авч үзсэн (Gambacorta & Marques-Ibanez, 2011). ББСБ–уудын хувьд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайтай буюу мөнгөн хөрөнгө сайтай байх нь харилцагчдын санхүүгийн хэрэгцээг богино хугацаанд хангах, улмаар зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөөтэй.

Мөн өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай өндөр байснаар зах зээлийн эрэлтийг хангахуйц зээлийн нийлүүлэлт хийгдэх, цаашлаад зээлийн тэлэлт бий болох боломжийг бүрдүүлнэ (Gambacorta &

³ ХЗХ–ны тоон мэдээлэл нь үнэлгээнд ашиглахад бүрэн бус мөн олгосон зээлийн хэмжээ төдийлэн өндөр биш тул эконометрик үнэлгээнд оруулаагүй болно.

Shin , 2016). Зээлийн багцын эрсдэлийг тодорхойлох хувьсагчийн хувьд тухайн ББСБ–ын зээлийн үлдэгдлийн нийт активд эзлэх хувиар авч үзсэн. Зээлийн харьцаа өндөр байх нь ББСБ–уудын балансын эмзэг байдлыг нэмэгдүүлснээр зээлийн нийлүүлэлтэд сөрөг нөлөөтэй гэсэн таамаглал дэвшүүлсэн. Түүнчлэн хөшүүргийн харьцаа өндөр байх нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан зээлийн эрэлтийг эрчимжүүлэх улмаар өндөр эрэлтийг хангахын тулд санхүүгийн байгууллагууд зээлийн нийлүүлэлтээ дахин нэмэгдүүлэх зэргээр гинжин нөлөө үзүүлэх талтай юм.

Эрэлтийн талын хүчин зүйлсд эдийн засгийн өсөлт ($rgdpg_t$), инфляци (inf_t), ажилгүйдэл (ur_t), бодит цалингийн өсөлт ($wage_t$), өрхийн дундаж зарлага (hh_exp_t) болон банкуудын зээлийн шалгуурын өөрчлөлтийн чиглэлийн индекс (BLS_t)⁴, банкуудад авч хэрэгжүүлсэн макро зохистой бодлогын хэрэгжилтийг илэрхийлэх дамми хувьсагч (d_t) зэрэг зээлийн эрэлтэд нөлөөлөх макро эдийн засгийн болон бодлогын үзүүлэлтүүдийг тусгасан.

Эдийн засгийн үйл ажиллагааны өнгөрсөн болон ирээдүйн төлөв байдал нь хувийн сектор дахь бизнесийн болон өрхийн санхүүгийн төлөвлөлтөд чухал нөлөөтэй буюу зээлийн эрэлтийг тодорхойлох гол үзүүлэлт болдог (Behrendt, 2016). Эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтээр эдийн засгийн өсөлт болон хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийг авч үзсэн. Инфляцийн түвшин өндөр байх нь зээлдэгчдийн өрийн ирээдүйн үнэ цэнийг бууруулах тул энэ нь иргэд, ААН–ийн зээл авах хандлагыг өдөөснөөр зээлийн эрэлтийг нэмэгдүүлнэ. Мөн ажилгүйдэл нэмэгдэх, өрхийн орлого тасалдах, бодит цалин буурах зэрэг нь өрхийн амьжиргаа, орлогын хүрэлцээнд хүндрэл учруулж улмаар иргэд тогтмол хэрэглээгээ богино хугацаанд зээлээр санхүүжүүлснээр эрэлтийг өсгөх боломжтой.

Олон улсад хийгдсэн судалгааны ажлуудад (Eugenio et al. 2015, Pinar et al. 2017, Ozge & Jane , 2018) макро зохистой бодлогын нөлөөг судлахдаа ихэвчлэн ОУВС–гаас эрхлэн гаргадаг Макро зохистой бодлогын тоймд⁵ тооцоологдсон макро зохистой бодлогын индексийг ашиглах хандлагатай байдаг. Гэвч Манай орны хувьд макро зохистой бодлогын нэгдсэн болон дэд индексийн үзүүлэлтүүд нь хугацааны давтамжийн хувьд төдийлөн нарийвчлалтай бус бөгөөд сүүлийн үеийн тоон мэдээллүүд шинэчлэгдэн тооцоологдоогүй байгаа тул уг хэрэгжилтийг нөлөөг дараах хоёр хувьсагчдаар орлуулав.

Нэгдүгээрт Монголбанкнаас улирал тутам эрхлэн гаргадаг “Банкны зээлийн төлөв”–ийн судалгааны үр дүнг ашиглав. Банкнаас зээлдэгчдэд тавьж буй шалгуур болон зээлийн нөхцөлд өөрчлөлт орох нь иргэдийн зээлийн эрэлтийг ББСБ–руу шилжихэд нөлөөлөх магадлалтай юм. Иймээс тус түүвэр судалгаанд тулгуурлан, банкууд зээлийн шалгуур, нөхцөлөө өнгөрсөн 3 сарын хугацаанд хэрхэн өөрчилсөн талаарх чиглэлийн индексийг зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүүний бус хүчин зүйлсээр авч үзлээ.

Хоёрдугаарт хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалтыг дамми хувьсагчийн нөлөөгөөр төлөөлүүлэн авч уг хувьсагчийг эрэлтийн тэгшитгэлд оруулсан. Тус дамми хувьсагч нь хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалтаас өмнөх үеүдэд 0 гэсэн утга авах бол хэрэгжилтийн хугацаанд 1 гэсэн утгыг авна. Дээрх эрэлт болон нийлүүлэлтийн талын хувьсагчдын тайлбар болон тоон мэдээллийн эх үүсвэрийг Хавсралт 2–д дэлгэрэнгүй үзүүлэв.

4 Индексийн утга нь [-1; +1] завсарт утга авах бөгөөд индекс өсөх нь банкны шалгуур чангарахыг илтгэнэ.

5 IMF's GMPI survey

Панель үнэлгээ

Банкууд дах иргэдийн хэрэглээний зээлд тодорхой хязгаарлалтууд тавьсантай холбоотойгоор ББСБ–уудын иргэдийн зээлийн эрэлт нэмэгдсэн эсэхийг судлахдаа панель өгөгдөл ашиглан хэд хэдэн аргачлалуудаар үнэлгээг гүйцэтгэж үр дүнг харьцуулсан болно.

Зээлийн эрэлт

Өмнөх бүлэгт тодорхойлогдсон эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээнээс харахад аль ч аргачлалын хувьд ББСБ–уудын олгосон зээл нь хүүнээс сөрөг хамааралтай буюу эрэлтийн муруйн шинж чанарыг харуулах бөгөөд онолын хүрээний таамаглалын дагуу байна (Хүснэгт 1). Үнэлгээ (1)–д зээлийн хүү болон олгосон зээлийн хоорондын хамаарлыг нэгтгэсэн Хамгийн Бага Квадратын Аргаар (ХБКА, Pooled OLS) үнэлсэн. Тус үнэлгээнд зээлийн эрэлтэд нөлөөлөгч бусад хүчин зүйлс нарийн тусгагдаагүй ба тайлбарлагч хувьсагч нь үлдэгдэлтэй корреляцтай үед үнэлгээний үр дүн гажуудалтай бөгөөд коэффициентийн утга нь хэт эсвэл дутуу үнэлэгдсэн байх магадлалтай юм. Иймд бусад удирдлагын хувьсагчдын нөлөөг авч үзсэнээр зээлийн хүүний нөлөөллийг бодитоор илрүүлэх боломжтой тул үнэлгээ (2)–т макро эдийн засгийн үзүүлэлтүүд болон банкны зээлийн шалгуурын өөрчлөлтийг үнэлгээнд нэмж оруулсан.

Харин үнэлгээ (3) болон (4)–т тогтмол ба санамсаргүй нөлөөний (Fixed effects and Random effects) загварын үр дүнг харуулсан бөгөөд тус 2 үнэлгээний аргачлалын аль нь илүү тохиромжтойг Хаусмэны шалгуураар тодорхойлсон. Тус шалгуурын үр дүнгээр $\chi^2(7)$ –ын утга нь 7.64, магадлалын утга буюу p -value=0.3652 гарсан. Энэ нь 5 хувийн ач холбогдлын түвшин бүхий $\chi^2(7)$ тархалтын критик утгаас давснаар H_0 таамаглал болох санамсаргүй нөлөөний арга гажуудалгүй бөгөөд илүү үр дүнтэй гэдгийг няцааж чадахгүй байна. Тус шалгуурын үр дүнгээр үнэлгээний алдаанууд нь тайлбарлагч хувьсагчуудтай хамааралгүй гэдгийг харуулах юм.

Үнэлгээ (5) болон (6)–д хоёр шатат инструмент хувьсагчийн үнэлгээний (2SLS–IV) үр дүнг харуулав. Уг үнэлгээний тусламжтайгаар нийлүүлэлтийн талын нөлөөг хассанаар зөвхөн зээлийн эрэлтийн мэдрэмжийг ялган тооцох боломжтой байдгаараа онцлогтой юм. Эрэлтийн талын нөлөөг ялгахын тулд нийлүүлэлтэд нөлөөлөгч хувьсагчдыг сонгож инструмент хувьсагчаар үнэлгээнд ашигладаг. Иймд инструмент хувьсагчаар ТТГЧ–ын харьцаа болон өөрийн хөрөнгийн хэмжээний логарифм утгыг авч үзсэн. Тус аргачлалын хувьд үнэлгээний үр дүн нь гажуудалгүй бөгөөд учир шалтгааныг нарийн тайлбарлаж буйг шалгахын тулд дараах тестүүдийг шалгах шаардлагатай байдаг.

Инструмент хувьсагчийн үнэлгээ нь зөв тодорхойлогдсон эсэхийг LM статистик (Kleibergen–Paark) шалгуураар тогтоох боломжтой. Үнэлгээ (5)–н хувьд тус статистик нь 0.741–тай тэнцүү буюу 1 чөлөөний зэрэгтэй 5 хувийн ач холбогдлын түвшин бүхий $\chi^2(1)$ тархалтын критик утга болох 3.84–өөс бага, магадлалын утга тэгээс их (p -value=0.3893) гарсан нь H_0 таамаглалыг няцааж чадахгүй байна. Энэ нь тус тэгшитгэл зөв тодорхойлогдоогүй буюу сонгосон инструмент хувьсагч эндоген хувьсагчтай хүчтэй хамааралгүйг илтгэнэ. Мөн сонгосон инструмент хувьсагч нь сул эсэхийг тогтоодог F статистик (Cragg–Donald Wald F statistic) 0.644–тэй тэнцүү буюу 10 хувийн ач холбогдлын түвшин бүхий критик утга болох 16.38–аас (Stock & Yogo, 2005) бага байгаа нь төлбөрийн чадварын үзүүлэлт нь инструмент хувьсагчийн нөлөөг бүрэн харуулж чадахгүй байна. Мөн инструмент хувьсагчийг сул эсэхийг тогтоохдоо F статистикийн утга 10–аас бага үед уг сонгосон хувьсагчийг сул инструмент гэж үздэг (Sanderson & Windmeijerabc, 2016).

Хүснэгт 4. 1. Зээлийн эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээ

Тайлбарлагч хувьсагчид	$\Delta \ln(\text{Олгосон зээл})$						
	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)
	Pooled OLS	Pooled OLS	Fixed effects	Random effects	IV	IV	3SLS
Зээлийн хүү	-0.078* [0.0431]	-0.0816* [0.0445]	-0.230* [0.122]	-0.0816** [0.0389]	-3.817 [4.635]	-0.0177 [0.106]	-0.0231 [0.126]
BLS (Зээлийн шалгуур)		1.372*** [0.321]	1.309*** [0.332]	1.372*** [0.289]	0.774 [1.112]	1.382*** [0.320]	0.545*** [0.193]
БДНБ-ий өсөлт (-3)		-0.093*** [0.0204]	-0.099*** [0.0213]	-0.093*** [0.0176]	-0.254 [0.206]	-0.0904*** [0.0208]	-0.055*** [0.0145]
Инфляци		0.0510* [0.0272]	0.0485 [0.0297]	0.0510* [0.0273]	0.0310 [0.0939]	0.0514* [0.0271]	0.0198 [0.0203]
Бодит цалингийн өсөлт		-0.052*** [0.00931]	-0.051*** [0.0100]	-0.052*** [0.00885]	-0.0506* [0.0291]	-0.0526*** [0.00930]	-0.023*** [0.00631]
Ажилгүйдэл		-0.304*** [0.0611]	-0.308*** [0.0613]	-0.304*** [0.0574]	-0.0339 [0.366]	-0.309*** [0.0615]	-0.122*** [0.0359]
Өрхийн зарлагын өсөлт		-0.0323 [0.0562]	-0.0338 [0.0561]	-0.0323 [0.0532]	-0.237 [0.285]	-0.0288 [0.0565]	-0.0257 [0.0306]
Тогтмол	0.2874** [0.155]	3.540*** [0.309]	4.090*** [0.464]	3.540*** [0.286]	15.00 [14.25]	3.344*** [0.430]	1.606*** [0.429]
Hausmen test (p-value)				0.3652			
Sargen-Hansen					0.000	0.000	
F-statistics †					0.741	111.5***	
LM statistic ††					0.644	57.4***	
Инструмент хувьсагч					ТТГЧ-ын харьцаа	$\ln(\Theta \cdot X_{\theta})$	
Observations	1,712	1,112	1,112	1,112	1,112	1,112	1,112
R ²	0.0025	0.193	0.252			0.191	0.138

Хаалтанд стандарт алдгаар (robust s.e) харуулав.

*** p<0.01, ** p<0.05, * p<0.1

† - Cragg-Donald Wald F statistic

†† - Kleibergen-Paap rk LM statistic

Харин өөрийн хөрөнгийн логарифм утгыг инструмент хувьсагчаар сонгосон үнэлгээний (6) хувьд LM статистик нь 57.4 гарсан бөгөөд 1 чөлөөний зэрэгтэй 5 хувийн ач холбогдлын түвшин бүхий $\chi^2(1)$ тархалтын критик утгаас их ба харгалзах магадлалын утга 0.000 байгаа нь H_0 таамаглалыг няцааж байна. Мөн F статистикийн утга 111.5 буюу критик утгаас (Stock & Yogo-16.38 болон Sanderson-Windmeijer-10) өндөр гарсан нь өөрийн хөрөнгийн үзүүлэлтийг инструмент хувьсагчаар сонгох нь илүү тохиромжтойг харуулсан. Энэ нь тус инструмент хувьсагчийн хувьд IV үнэлгээний гол хоёр нөхцөлийн нэг болох эндоген хувьсагчтай хамааралтай (relevant condition) бөгөөд корреляц нь сул биш гэсэн нөхцөлийг хангаж байгааг илтгэх юм. Түүнчлэн инструмент хувьсагчийн үнэлгээ тус бүрд

нэг инструмент хувьсагч авч үзсэн тул инструмент хувьсагчийн хэтэрч тодорхойлогдсон эсэхийг тогтоох боломжгүй. Энэ үед Sargan–Hansen шалгуурын утга тэгтэй тэнцүү буюу тэгшитгэлүүд яг тодорхойлогдсон байна гэж үзнэ.

Банкууд зээлийн шалгуураа чангаруулах нь ББСБ–уудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлнэ гэсэн таамаглалыг шалгахад үнэлгээ (2), (3), (4) болон (6)–н хувьд уг таамаглал статистикийн 5 хувийн ач холбогдлын түвшинд няцаагдахгүй байна. Энэ нь банк хэрэглээний зээлд хязгаарлалт тавьж зээлийн шалгуураа чангаруулсан нь ББСБ–уудын олгосон зээлийн хэмжээг өсгөх нөлөө үзүүлдгийг илтгэнэ. Мөн иргэдийн хэрэглээний зээлд тавьсан хязгаарлалтыг дамми хувьсагчаар төлөөлүүлсэн үнэлгээний хувьд коэффициент нь статистикийн хувьд ач холбогдолтой бөгөөд эерэг хамааралтай байна (Хавсралт 1). Иймд банкуудад тавьсан хэрэглээний зээлийн хязгаарлалтын нөлөөг хоёр хувьсагчаар төлөөлүүлэн шинжлэхэд үр дүн хоорондоо нийцтэй гарлаа. Эндээс банкууд зээлийн шалгуураа чангаруулж зээлийн нийлүүлэлтэд тодорхой хязгаарлалт тавих нь ББСБ–ын дундаж зээлийн өсөлтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлдэг гэсэн үр дүнг харж болохоор байна. Тухайлбал банкны зээлийн шалгуур чангарах буюу индексийн утга нэг нэгж хувиар өсөхөд ББСБ–уудын зээлийн улирлын дундаж өсөлт 1.4 нэгж хувиар нэмэгдэхээр байна.

ББСБ–ын зээлийн эрэлтэд нөлөөлөгч бусад хүчин зүйлсийн нөлөөг авч үзвэл эдийн засгийн өсөлт болон ББСБ–уудын зээлийн хооронд сөрөг хамаарал ажиглагдсан бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Энэ нь банкны салбарт суурилсан санхүүгийн системтэй манай орны хувьд банкны зээл макро эдийн засгийн мөчлөг дагасан шинжтэй байдаг (Doojav & Batmunkh, 2018) бол банкаас бусад санхүүгийн байгууллагууд нь сүүдрийн банкны үйл ажиллагаа явуулах буюу банкны зээлийг тодорхой хэмжээнд орлодгоороо илүү мөчлөг сөрсөн шинжтэй байгааг харуулж байна.

Мөн инфляцийн түвшин нь ББСБ–уудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлд харин бодит цалингийн өсөлт бууруулах чиглэлд нөлөө үзүүлдэг байна. Инфляци өндөр үед өрхийн хэрэглээний зардал нэмэгдэж, орлогын хүрэлцээ муу болох тул иргэд орлогоос давсан зардлаа богино хугацаат зээлийн санхүүжилтээр нөхдөг байх талтай. Нөгөөтэйгүүр өндөр инфляцийн түвшин нь зээлийн нэрлэсэн үнэ цэнийг хурдан бууруулах тул ирээдүйд зээлдэгчдэд учрах санхүүгийн дарамтыг сааруулж зээлийн эргэн төлөлтийг сайжруулна. Энэ нь иргэдийн хувьд зээлийн эрэлтээ нэмэгдүүлэхэд нөлөөлдөг байж болох юм. Харин бодит цалингийн өсөлт өндөр үед иргэдийн орлогын хүрэлцээ харьцангуй сайжирч худалдан авах чадвар дээшилснээр зээлийн шаардлага багасах, улмаар зээлийн эрэлтийг бууруулах нөлөө үзүүлж байна.

Зээлийн нийлүүлэлт

Энэ хэсэгт ББСБ–уудын зээлийн нийлүүлэлтэд нөлөөлөгч дотоод хүчин зүйлсүүдийн талаарх үнэлгээг авч үзсэн. Үнэлгээний үр дүнгээс харахад нэгтгэсэн ЭХБК арга болон тогтмол, санамсаргүй нөлөөний загваруудын хувьд зээлийн нийлүүлэлтэд үзүүлж буй зээлийн хүүний нөлөө сөрөг гарсан. Харин хоёр шатат инструмент хувьсагчийн болон гурван шатат ХБК–ын аргуудын хувьд зээлийн хүүний коэффициентийн утга эерэг бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан нь онолын таамаглалтай нийцтэй буюу нийлүүлэлтийн муруйн шинжийг харуулж байна (Хүснэгт 2).

Хүснэгт 4. 2. Зээлийн нийлүүлэлтийн тэгшитгэлийн үнэлгээ

Тайлбарлагч хувьсагчид	$\Delta \ln(\text{Олгосон зээл})$					
	(1)	(2)	(3)	(4)	(5)	(6)
	Pooled OLS	Fixed effects	Random effects	IV	IV	3SLS
Зээлийн хүү	-0.0692 [0.0444]	-0.151* [0.0810]	-0.0859* [0.0456]	2.601*** [0.843]	2.603* [1.436]	0.983** [0.478]
ТТГЧ-ын харьцаа	-0.141 [0.260]	-0.724 [0.727]	-0.177 [0.188]	-0.411 [0.567]	-0.208 [0.471]	-0.0125 [0.222]
Зээлийн харьцаа	0.0415 [0.246]	-0.241 [0.700]	0.0530 [0.171]	0.474 [0.522]	0.389 [0.466]	0.155 [0.215]
$\ln(\text{Өөрийн хөрөнгө})$	0.0197 [0.0319]	0.101 [0.127]	0.0188 [0.0253]	0.658*** [0.235]	0.692* [0.361]	0.240* [0.132]
Тогтмол	-0.0213 [0.542]	-0.554 [1.882]	0.0437 [0.430]	-17.94*** [6.115]	-18.66* [9.975]	-6.580* [3.447]
Hausmen test (p-value)			0.1889			
Sargen-Hansen				0.000	0.000	
F-statistics †				0.741	11.260***	
LM statistic ††				0.644	10.272***	
Инструмент хувьсагч				Инфляци	БДНБ өсөлт	
Observations	1,712	1,712	1,712	1,112	1,712	1,112
R ²	0.004	0.067	0.0035			

Хаалтанд стандарт алдгаг (robust s.e) харуулав.

*** p<0.01, ** p<0.05, * p<0.1

†- Cragg-Donald Wald F statistic

††- Kleibergen-Paap rk LM statistic

Хоёр шатат инструмент хувьсагчийн үнэлгээнүүдэд нийлүүлэлтийн хүчин зүйлсээр өдөөгдсөн зээлийн өөрчлөлтийг ялган авахын тулд эрэлтэд нөлөөлөгч хувьсагчид болох инфляци болон бодит ДНБ-ий өсөлтийн гурван улирлын хоцрогдолтой утгыг инструмент хувьсагчдаар сонгосон. Үнэлгээ (4)-ийн хувьд инфляци нь сайн инструмент болж чадахгүй буюу F, LM статистик шалгууруудыг хангахгүй байгаа бол бодит ДНБ-ий өсөлт нь эдгээр статистик шалгууруудыг давснаар инструмент хувьсагчаар сонгоход тохиромжтойг илэрхийлнэ. Энэ нь үнэлгээ (5)-ийн хувьд гажуудалгүй бөгөөд тууштай үнэлгээний үр дүн болохыг харуулж байна.

Зээлийн харьцаа болон мөнгөн хөрөнгийн активд эзлэх хувь статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан. Харин ББСБ-уудын зээлийн нийлүүлэлтэд хүүнээс гадна өөрийн хөрөнгийн өсөлт чухал нөлөөтэй буюу коэффициентийн утга эерэг бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой байна.

Тухайлбал өөрийн хөрөнгө нэг хувиар өсөхөд зээлийн нийлүүлэлтийн өсөлтийг 0.7 нэгж хувиар нэмэгдүүлдэг гэсэн үр дүнд хүрлээ.

СЗХ–ноос бичил санхүүгийн зах зээлийг бэхжүүлэх, чадавхжуулах, ирээдүйд үүсэж болох болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зах зээл дэх мэргэжлийн оролцогчдыг нэмэгдүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, үр ашгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилгоор ББСБ–уудын өөрийн хөрөнгийн доод хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ авсан. Энэхүү өөрийн хөрөнгийн өсөлт нь ББСБ–уудын зээл олгох эх үүсвэрийн хүрэлцээг сайжруулж улмаар зээлийн нийлүүлэлт нэмэгдэх гол хүчин зүйл болж байгаа нь судалгаагаар харагдлаа.

Систем тэгшитгэлт загвар: Тэгшитгэл (7), (8) болон (9)–д тодорхойлогдсоноор зээлийн эрэлт болон нийлүүлэлтийн тэнцвэрээр зах зээлийн тэнцвэрт хэмжээ болон хүү тогтох тул нэгэн зэрэг тодорхойлогдсон систем загварын үнэлгээг гурван шатат ХБК аргаар (3SLS) үнэлсэн⁶. Энэ тохиолдолд зээлийн хүү нь эндоген хувьсагчийн шинж чанарыг илэрхийлэх тул эндоген хувьсагчийн тоо нь тэгшитгэлийн тоотой тэнцүү буюу систем яг тодорхойлогдсон гэж үзнэ.

Уг аргачлал нь тэгшитгэлүүдийн үлдэгдэл хоорондын ковариацийг авч үздэгээрээ бусад нэг тэгшитгэлт загварын үнэлгээний аргачлалуудаас онцлог бөгөөд хоёр шатат ХБК аргатай харьцуулахад илүү үр ашигтай, тууштай үр дүн өгөх боломжтой юм. Гурван шатат үнэлгээний үр дүнг зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэгшитгэлүүдийг тус тусд нь үнэлсэн үнэлгээтэй харьцуулахад коэффициентийн утгыг бага зэрэг зөрүүтэй ч зээлийн эрэлтийн тэгшитгэлийн хувьд зээлийн хүү статистик ач холбогдолгүй байна.

6 Zellner & Theil, (1962) ажлаас дэлгэрэнгүйлэн харах боломжтой.

ДӨРӨВ. МАКРО ЗОХИСТОЙ БОДЛОГЫГ ББСБ–Д ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖ, ҮҮСЭЖ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛ

Арилжааны банкуудын хэрэглээний зээлд хязгаарлалт тавьсан хэдий ч уг зээлийн эрэлт бусад санхүүгийн байгууллагууд тэр дундаа ББСБ–д шилжих улмаар тус бодлогын үр нөлөөг бууруулах эрсдэл үүсэж болзошгүй юм. Иймд хэрэглээний зээлийн тус хязгаарлалтыг банк бус санхүүгийн байгууллагуудад мөн адил мөрдүүлснээр эдийн засаг, санхүүгийн зах зээлд үүсэх үр нөлөөг гадаад, дотоод орчны шинжилгээгээр (SWOT) уг бүлэгт тодорхойллоо.

Хүснэгт 4.3. SWOT шинжилгээ

S: Давуу тал	W: Сул тал	O: Боломж	T: Эрсдэл
<ul style="list-style-type: none"> * Зээлийн эх үүсвэрийн үр ашигтай хуваарилалт; * Зээлийн эргэн төлөлт сайжрах; * Санхүүгийн байгууллагуудын эрсдэл буурах; 	<ul style="list-style-type: none"> * Бизнесийн үйл ажиллагааг хязгаарлах; * Бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, хангуулж ажиллахад хүндрэл үүсэх; * Технологийн дэвшлээр зээлийн эрсдэлийг үнэлж буй үед тус бодлого үр ашиг багатай; 	<ul style="list-style-type: none"> * Өрхийн өрийн дарамтыг бууруулах, төлбөрийн чадавхыг хамгаалах; * Үнийн хөөсрөл, эдийн засгийн халалтаас сэргийлэх; * Хэрэглэгчдийн санхүүгийн сахилга бат сайжрах; 	<ul style="list-style-type: none"> * Хангагдаагүй эрэлт үүсэх; * Хэрэглэгчид албан бус сектор руу шилжих; * Сүүдрийн банкны үйл ажиллагаа нэмэгдэх;

Давуу тал:

- Хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлт буурах, зээлийн эх үүсвэрийг илүү үр өгөөжтэй салбар, төслүүдэд хуваарилах боломж үүснэ.

Сүүлийн жилүүдэд банк, санхүүгийн байгууллагуудын зээлийн багцад эзлэх хэрэглээний зээлийн хувь хэмжээ нэмэгдэн илүү үр ашигтай төслүүдэд хуваарилагдах боломжтой байсан эх үүсвэр хэрэглээний зээлийг санхүүжүүлж байгаа нь өр, орлогын хязгаарлалтыг зээлдэгчдэд тавих нэг үндсэн шалтгаан байсан.

2019 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ–ын нийт зээлийн багцын 85.2 хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байгаа бол 14.8 хувийг хуулийн этгээдэд олгосон зээл бүрдүүлж байна. Мөн тайлант хугацаанд шинээр олгосон зээлийн 72.7 хувь нь хэрэглээний зориулалттай зээлд олгосон байна. Өөрөөр хэлбэл ББСБ–уудаас зах зээлд нийлүүлж буй зээлийн бүтээгдэхүүний дийлэнх хувь нь хэрэглээний зээлд зориулагдаж байна.

Гэхдээ ББСБ–уудын зээлийн бүтээгдэхүүний онцлог нь харьцангуй богино хугацаатай, бага дүнтэй зээл байдаг тул хэрэглээний зээлийг голчлон санхүүжүүлдэг. Мөн сүүлийн жилүүдэд ББСБ–ууд онлайн зээл, гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж эхлээд байна. Эдгээр зээл нь 1 сарын хугацаатайгаар хамгийн ихдээ 2 сая төгрөг хүртэлх дүнтэйгээр олгогдож байгаа бөгөөд уг төрлийн зээл нь тайлант хугацаанд шинээр олгосон хэрэглээний зээлийн 41.3 хувийг бүрдүүлж байгаа юм.

- Хэрэглэгчид очих өрийн дарамтыг бууруулснаар, зээлийн эргэн төлөлт сайжирч, чанаргүй зээлийн хэмжээ буурна.


2019 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ–уудын нийт зээлийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ 9.0 хувьтай байна. 2017 оны 3 дугаар улиралд 14.3 хувьд хүрээд байсан чанаргүй зээлийн хувь хэмжээ буурч байгаад эдийн засгийн нөхцөл байдал сайжирснаас гадна, зээлийн бүтээгдэхүүний үнэ буурсан мөн технологийн дэвшил банк бус санхүүгийн үйл ажиллагаанд нэвтэрч эхэлсэн зэрэг нь нөлөөлсөн байх боломжтой юм.

Уул уурхай, эрдэс баялгийн бүтээгдэхүүнээс өндөр хамааралтай манай улсын хувьд эдийн засаг өсөлттэй үед иргэд хэрэглээгээ ихээр тэлэн түүнийгээ зээлээр санхүүжүүлэх эргээд эдийн засгийн уналтын үед зээлийн эргэн төлөлт саарч санхүүгийн системд нөлөөлөх эрсдэлтэй байдаг. Олон улсын туршлагаас харахад хэрэглээний зээлд өр, орлогын хязгаарлалтыг тавин хэрэгжүүлж буй нэг шалтгаан нь өрхийн орлогын дарамтыг бууруулах байдаг бөгөөд ингэснээр зээлийн эргэн төлөлт сайжирч санхүүгийн зах зээл дэх чанаргүй зээлийн хувь хэмжээ буурах нөлөөтэй юм.

Зураг 4. 17. ББСБ чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь



Зураг 4. 18. ББСБ–ын зээлийн эрсдэлийн сан



Эх сурвалж: СЗХ

– Санхүүгийн байгууллагын эрсдэл буурна.

ББСБ–уудын зээлийн багцын дийлэнх хувийг хэрэглээний зээл бүрдүүлж байгаа тул иргэдийн зээлийн эргэн төлөлт сайжрах нь тухайн байгууллагуудад учрах зээлийн эрсдэлийг бууруулах нөлөөтэй юм.

Гэхдээ банк бус санхүүгийн байгууллагууд нь зээлийн бүтээгдэхүүнээ өөрсдийн хөрөнгөөр санхүүжүүлэх ба бусдаас хадгаламж татан төвлөрүүлдэггүй. Өөрөөр хэлбэл банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгчид нь цэвэр ХНХ–өөрөө өөрөө эрсдэлээ бүрэн даана гэсэн шийдвэрийн дагуу тус зах зээлд нэвтэрдэг. Мөн СЗХ–ноос банк бус санхүүгийн байгууллагуудыг зээлийн чанарын дагуу зээлийн эрсдэлийн санг байгуулан ажиллахыг шаарддаг бөгөөд уг санг зохих хэмжээнд тогтмол бүрдүүлдэг.

Сул тал:

– Зээлийн бүтээгдэхүүнийг хязгаарласнаар бизнесийн үйл ажиллагаанд саад учруулах

ББСБ–ууд нь өөрийн хөрөнгөөр уг үйл ажиллагаагаа явуулан богино хугацаатай, бага дүнтэй зээлийн зах зээл дээр голчлон үйл ажиллагаа явуулдаг тул хэрэглээний зээл нь ББСБ–уудын голлох үйлчилгээ байдаг. Мөн санхүүгийн зах зээл дэх зохицуулалтын орчныг чангаруулах нь тухайн бизнесийн үйл ажиллагаанд хязгаарлалт үүсгэх нөлөөтэй юм. Зах зээл дэх бага дүнтэй зээлийн эрэлтийг даган бичил санхүүгийн байгууллагууд болон ББСБ–ууд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тус эрэлт зах


зээлд байгаа нөхцөлд ББСБ–уудын үйл ажиллагаанд хязгаарлалт учруулах нь тус байгууллагууд албан сектороос албан бус сектор руу шилжин үйл ажиллагаа явуулах эрсдэлтэй юм.

– Бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, хангуулж ажиллахад хүндрэл учрах
2019 оны 3 дугаар улирлын байдлаар улсын хэмжээнд нийт 539 банк бус санхүүгийн байгууллага 245 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ББСБ–уудын хэрэглээний зээлд өр, орлогын хязгаарлалт тавин хэрэгжилтэд хяналт тавихад хүндрэл үүсэх эрсдэл байгаа юм.


– Технологийн дэвшлийг ашиглан зээлийн эрсдэлийг үнэлж эхлээд буй өнөө үед уг бодлого нь төдийлөн үр ашигтай биш

Сүүлийн жилүүдэд ББСБ–ууд үйл ажиллагаандаа технологийн дэвшлийг нэвтрүүлэн хэрэглэгчдийн зээлийн эрсдэлийг алсаас үнэлэн цахим эсхүл вебд суурилсан зээл, гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж эхлээд байгаа билээ.

Зураг 4. 19. Гар утсаар зээл авч буй иргэдийн нийт зээлдэгчдэд эзлэх хувь



Зураг 4. 20. Гар утсаар олгосон зээлийн эзлэх хувь



Эх сурвалж: СЗХ

2019 оны 3 дугаар улирлын байдлаар 2 ББСБ зөвхөн гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг эрхэлж байгаа бол 6 ББСБ онлайн болон гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг уламжлалт зээлийн үйлчилгээтэй хослуулан зах зээлд нийлүүлж байна. Тайлант хугацаанд салбарын нийт зээлдэгчдийн 46.1 хувь нь зөвхөн гар утсаараа зээлийн үйлчилгээ авч байгаа бөгөөд нийт шинээр олгосон хэрэглээний зээлийн 41.3 хувийг гар утсаар олгосон зээл эзэлж байна. Тус зээлийн бүтээгдэхүүний хувьд чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь нь 3.7 хувь буюу салбарын дүнгээс 2.5 дахин бага байгаа юм. Өөрөөр хэлбэл санхүүгийн байгууллагууд технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн зээлийн эрсдэлийг үнэлж байгаа өнөө үед өр, орлогын хязгаарлалтыг заавал хэрэгжүүлэхийг шаардах нь төдийлөн үр ашигтай хувилбар биш юм.

Боломж:

– Арилжааны банкуудад хэрэгжүүлж буй бодлогын хэрэгжилтийг дэмжин өрхийн өрийн дарамтыг бууруулах, зээлийн хэт өндөр өсөлтийг хязгаарлан, эдийн засгийн халалт бий болохоос сэргийлэх
Хэрэглээний зээлд өр, орлогын хязгаарлалтыг тавьснаар хэрэглэгчдийн төлбөрийн чадварыг нийцтэй байлгаж, хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлтийг сааруулан эдийн засгийн халалт бий болохоос

сэргийлэх боломжтой бөгөөд арилжааны банкуудад уг хязгаарлалтыг тавин хэрэгжүүлж байна. Харин уг хязгаарлалтыг ББСБ–уудад тавиагүйн улмаас хэрэглээний зээлийн эрэлт тус салбар руу шилжин Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын үр нөлөө багасах эрсдэл үүсээд байгаа билээ. Сүүлийн жилүүдэд ББСБ–уудын зээлийн өсөлт 30–аас дээш хувь, иргэдэд шинээр олгосон зээлийн өсөлт 60 орчим хувьтай байгаа нь арилжааны банкуудад хэрэгжүүлж буй уг бодлогоос шалтгаалан зээлийн эрэлт тус салбар руу шилжиж байх боломжтойг харуулж байгаа юм. Гэхдээ ББСБ–уудын зээлийн уг өндөр өсөлтөд Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын нөлөөнөөс гадна 2017 оноос эхлэн хэрэгжүүлж буй ХНХ–ийн хэмжээг нэмэгдүүлэх шийдвэр, технологид суурилсан бичил зээлийн үйлчилгээ зах зээлд нэвтэрсэн зэрэг нь мөн нөлөөлсөн байх боломжтой.

– Хэрэглэгчдийн санхүүгийн сахилга бат сайжрах

Хэрэглээний зээлийн хэт өндөр өсөлт нь нэг талаас иргэдийн санхүүгийн сахилга бат сул буйг харуулдаг. Тус бодлого нь хэрэглээний зардлын өсөлт нь орлогын өсөлтөөс өндөр байдаг, өр, орлогын харьцаа өндөртэй, зээлийн бүтээгдэхүүнээс хамааралтай хэрэглэгчдийн хувьд хэрэглээний зээлийн өсөлтийг аажмаар сааруулах замаар өрийн дарамтыг бууруулан, санхүүгийн сахилга батад нөлөөлөх боломжтой юм.

– Үнийн хөөсрөлтөөс сэргийлэх

Эдийн засгийн өсөлтийн үед хэрэглээ нэмэгдэн зах зээл дэх бараа бүтээгдэхүүний эрэлт өсөж улмаар үнийн хөөс бий болох эрсдэл үүсдэг нь үл хөдлөх хөрөнгийн салбарт илүү хүчтэй ажиглагддаг. Үл хөдлөх хөрөнгийн үнийн хөөсрөлтөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон улсад өр, орлогын хязгаарлалтыг ашигладаг бөгөөд тус бодлогыг хэрэгжүүлэх нь эдийн засгийн хэт халалтаас хамгаалах боломжийг үүсгэдэг.

Эрсдэл:

- Нэгэнт зах зээлд зээлийн эрэлт өндөр байгаа нөхцөлд нийлүүлэлтийг хязгаарлах нь бүтээгдэхүүн, үйлчилгээний хомсдолд хүргэх, үнийн түвшнийг өсгөх сөрөг нөлөөтэй


Зах зээл дээр ББСБ–ын үйл ажиллагаа эрхлэгчид олон тоогоор үйл ажиллагаа явуулж байгаа нь нэг талаас бага хэмжээтэй бичил зээлийн эрэлт өндөр байгааг харуулж байна. Зээлийн компаниуд, бичил санхүүгийн байгууллагууд, ломбард зэрэг ихэвчлэн хэрэглээний санхүүжилтэд зориулагдсан бичил зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд зах зээлд их байх нь тухайн улсын иргэдийн амьжиргааны түвшин доогуур, өрхийн орлого нь хэрэглээг бүрэн санхүүжүүлж чадахгүй байгааг харуулдаг. Тийм учраас зээлийн бүтээгдэхүүний нийлүүлэлтэд нөлөөлөх нь эргээд хангагдаагүй эрэлтийг нэмэгдүүлэх улмаар зээлийн бүтээгдэхүүний үнийг өсгөх эрсдэлийг дагуулж болзошгүй.

- Хэрэглэгчид зээлийн хэрэгцээгээ хангахын тулд албан бус сектороор үйлчлүүлэх улмаар илүү их өрийн дарамтад орох

СЗХ “Үндэсний судалгаа, шинжилгээний төв” ХХК–тэй хамтран улирал тутам санхүүгийн зах зээл дэх хэрэглэгчдийн итгэлийг үнэлэх түүвэр судалгааг гүйцэтгэдэг бөгөөд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 1000 гаруй иргэнийг судалгаанд хамруулдаг. Тус судалгаанд иргэдийн санхүүгийн зах зээлийн оролцоог тандах зорилгоор өнгөрсөн 6 сарын хугацаанд зээл авсан эсэх, зээл авахдаа санхүүгийн аль байгууллагаас авсан эсэхийг тодорхойлдог бөгөөд 2019 оны 3 дугаар улирлын

байдлаар судалгаанд хамрагдсан иргэдийн 41.5 хувь нь зээл авсан байна. Эдгээр иргэдийн 56 хувь нь арилжааны банкнаас, 14 хувь нь банк бус санхүүгийн байгууллагаас, 1 хувь нь хадгаламж зээлийн хоршоогоор үйлчлүүлсэн бол үлдсэн 29 хувь нь албан бус сектор болох хувь хүн, ломбардаас зээл авчээ. Өөрөөр хэлбэл манай улсын зээлийн зах зээлд албан бус секторын эзлэх хувь бага биш болох нь уг түүвэр судалгааны үр дүнгээс харагдаж байгаа юм.

Зураг 4. 21. Иргэдийн зээлийн санхүүжилтийн төрлүүд



Иймд хэрэглэгчид зээлийн хэрэгцээгээ хангах, санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэхийн тулд арилжааны банкнаас, ББСБ-ууд руу шилжихээс гадна ББСБ-уудаас албан бус сектор луу буюу илүү өндөр үнэтэй, хатуу нөхцөлтэй зээлийн үйлчилгээг хүртэж, өрийн дарамтаа нэмэгдүүлэх эрсдэл байна.

Эх сурвалж: “Санхүүгийн зах зээлийн хэрэглэгчдийн итгэлийг тандах судалгаа” III улирлын үр дүн

- Зохицуулалтын бодлогыг зээлийн хязгаарлалт тавьж чангаруулснаар сүүдрийн банкны үйл ажиллагаа нэмэгдэнэ.

Зах зээл дэх зохицуулалтын орчин чангарснаар тухайн бизнесийн байгууллага үйл ажиллагаагаа далд хэлбэрээр явуулах, зохицуулалтаас зугтах эрсдэл үүсдэг бөгөөд ББСБ-ууд зохицуулалтын уг шаардлагаас зугтах зорилгоор зээл олгох хуулиар зохицуулагдаагүй боломжийг хайхад хүрнэ. Тухайлбал, Хятад Улс 2010 онд зээлийн хатуу бодлого баримталснаар сүүдрийн банкны тоо огцом өссөн байдаг (Sun, 2019).

ТАВ. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

Олон улсад ББСБ–д хэрэглээний зээлийн хязгаарлалт тавьж байсан туршлага

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй ББСБ–ууд нь голчлон богино хугацаатай, бага дүнтэй зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлдэг хэдий ч хадгаламжийн үйлчилгээ эрхлэлгүйгээр өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа санхүүжүүлдгээрээ олон улс дахь бичил санхүүгийн байгууллагуудаас ялгаатай юм. Өөрөөр хэлбэл, ББСБ–уудын үйл ажиллагааг олон улсынхтай харьцуулаад үзвэл бичил санхүүгийн байгууллагаас илүүтэйгээр зээлийн байгууллага, зээлийн компанийн үйл ажиллагаатай илүү төстэй.

Олон Улсын Валютын Сангаас жил бүр гаргадаг “Макро зохистой бодлогын түүвэр судалгаа”–ны 2018 оны үр дүнгээс үзэхэд 42 улс өрхийн секторын эрсдэлийг хязгаарлах зорилгоор өр, орлогын хязгаарлалтыг хэрэгжүүлж байгаа бөгөөд өрхийн секторт хэрэгжүүлж буй уг макро зохистой бодлогыг арилжааны банкууд баримтлан ажиллаж байна. Харин манай улсын ББСБ–тай төстэй үйл ажиллагаа бүхий зээлийн байгууллагуудад уг хязгаарлалтыг хэрэгжүүлсэн тухай судалгаа, мэдээлэл олдоц багатай байна.

Банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгддөг макро зохистой бодлого

2008 оны Санхүүгийн хямралаас үүдэлтэй макро зохистой бодлогыг банкны салбар төдийгүй хөрөнгийн зах зээл, даатгалын салбар, бичил санхүүгийн салбарт хэрэгжүүлэхийг зорин улс орнууд, стандарт тогтоогч олон улсын байгууллагууд ажиллаж байна. Хөгжингүй орнууд болон санхүүгийн зах зээлийн олон улсын стандарт тогтоогч байгууллагуудын хувьд уг бодлогыг нэвтрүүлэх алхмыг хэрэгжүүлээд аль хэдийн 10 жил өнгөрсөн тул өдгөө хэрэгжилтийн үнэлгээг хийж байна.

Даатгалын хяналт шалгалтын олон улсын холбооноос 2017 онд “Даатгалын гол зарчмууд” стандартынхаа 24 дүгээр зарчимд макро зохистой бодлогын стандартыг оруулсан. Уг стандартад системийн эрсдэлийг стресс тестийн аргаар үнэлэхийг тусгасан байдаг.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллагаас 2010 онд системийн эрсдэлийг бууруулах, удирдах 6 болон 7 дугаар зарчмуудыг хөрөнгийн зах зээлийн стандартад нэмж оруулсан. Мөн 2008 оны санхүүгийн хямралыг судлаачид шинжлэн үзээд системийн эрсдэлд брокер, дилерүүд хамгийн их нөлөө бүхий байсныг тогтоосон тул хөгжингүй улс орнууд хөрөнгийн зах зээлд макро зохистой бодлогыг хэрэгжүүлэхийг ихэд анхаарах болсон. Манай улсын хувьд хөрөнгийн зах зээл дэх мэргэжлийн оролцогчдын үйл ажиллагаа системд нөлөөлөхүйц биш хэдий ч олон жижиг байгууллагуудын эрсдэлийн бөөгнөрөл нийлэн системд эрсдэл учруулдаг тул мөн хэрэгжүүлэх нь зохистой гэж үзэн СЗХ–ноос эрсдэлд суурилсан хяналт шалгалт, стресс тестийг үнэлэхээр ажиллаж байна.

Олон улсын санхүүгийн зах зээлийн хяналт шалгалтын стандарт тогтоогч байгууллагууд болох Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл, Базелийн хороо, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага, Даатгалын хяналт, шалгалтын олон улсын холбоо зэрэг нь системийн эрсдэлийн тохиолдох магадлалыг бууруулахын тулд хоорондын хамтын ажиллагаагаа нэмэгдүүлж зохицуулалтын зөрүү үүсэхээс сэргийлэн бодлого зохицуулалтаа уялдуулан ажилладаг болсон.

Харин бичил санхүүгийн салбарт үүсэж болох системийн эрсдэл нь сүүдрийн банкны нөлөө юм. Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс сүүдрийн банкиг арилжааны банкны системээс гадуурх зээлийн зуучлалын байгууллага болон үйл ажиллагаа гэж тодорхойлжээ. Энэ нь арилжааны банк

Төв банкны өндөр зохицуулалтын улмаас бичил санхүүгийн салбарт үйл ажиллагаа эрхлэхийг хэлнэ. Арилжааны банк зээлийн хатуу зохицуулалтын улмаас хөрөнгөө зах зээлийн зохицуулалт багатай хэсэг рүү шилжүүлэх ба тус хөрөнгө нь арилжааны банкны санхүүгийн байдлын тайланд хөрөнгө оруулалт эсвэл балансын гадуурх дансанд тохируулга хийгдэх боловч сүүдрийн банк гэж нэрлэж буй тэдгээрийн охин компаниуд уг хөрөнгө оруулалтыг зээлийн санхүүжилтэд шилжүүлдэг.

Сүүдрийн банк системийн эрсдэлийн цаг хугацааны болон хөндлөнгийн эрсдэлүүдийг үүсгэх боломжтой. Үүнээс гурван гол эрсдэл нь мөнгөний зах зээлийн сангийн эрхлэх эрсдэл, үнэт цаасны санхүүжилтийн хэлцлийн мөчлөг, арилжааны банк болон сүүдрийн банк хоорондын холбоо хамаарал. Үүний хамгийн эхний зохицуулагчийн байр суурь нь ХНХ-ийн шаардлага болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудад олгож буй зээлийн үйл ажиллагаанд хяналт тавих байдаг (Gebauer & Mazelis, 2019).

Манай улсын хувьд арилжааны банканд тавигдах хяналт, зохицуулалт чангарсны улмаас санхүүгийн групп компаниудын тоо нэмэгдэх эрсдэл байгаа юм. Тухайлбал, ХНХ-ийн эзэмшлээр харвал 13 санхүүгийн группүүд үүсээд байгаа бөгөөд арилжааны банкууд санхүүгийн группэд харьяалагдаж, даатгал, үнэт цаас, хөрөнгө оруулалт, бичил санхүүгийн салбаруудад үйл ажиллагаа нь өргөжжээ. Иймд санхүүгийн группийн төвлөрлийн, мөн санхүүгийн нийт байгууллагуудын өр, авлагын гинжин хэлхээгээр холбогдсон холбоо хамаарлыг удирдах макро зохистой бодлогыг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ ЗӨВЛӨМЖ

Энэхүү судалгааны ажлаар Монголбанкнаас банкуудын хэрэглээний зээлд хязгаарлалт тавьсантай холбоотойгоор ББСБ–уудын зээлийн өсөлт эрчимжсэн эсэх мөн макро зохистой бодлогын арга хэрэгслүүдийг ББСБ–уудад хэрэгжүүлэх боломжийн талаар судаллаа. Бодлогын нөлөөний шинжилгээнд нийт 187 ББСБ–уудын 2016.III–2019.II улирлын хоорондох панель тоон мэдээллүүдийг ашигласан бөгөөд эрэлт, нийлүүлэлтийн загварт тулгуурлан эконометрик үнэлгээг ялгаатай аргачлалуудын хувьд гүйцэтгэж үр дүнг харьцуулав.

Иймд банкуудын хэрэглээний зээлд тавьсан макро зохистой бодлогын нөлөө, түүний үр дүнгийн шинжилгээнүүдэд үндэслэн дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна.

- ББСБ–уудаас иргэдэд олгох хэрэглээний зээлийн дүн сүүлийн 3 жилд эрчимтэй өсөх хандлагатай болсон. Энэхүү өсөлт нь голлох 3 хүчин зүйлсээр тайлбарлагдаж байгаа нь ББСБ–уудын ХНХ–ийг үе шаттайгаар нэмэгдүүлсэн бодлого, мэдээллийн технологийн дэвшлийг ашигласан финтекийн салбарын огцом өсөлт, арилжааны банкуудын хэрэглээний зээлийг хязгаарлах макро зохистой бодлогын нөлөө юм.
- Зээлийн эрэлтэд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээнээс харахад хэрэглээний зээлд хязгаарлалт тавьсантай холбоотойгоор банкууд зээлийн шалгуураа чангаруулах нь ББСБ–уудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлж байна. Загварын үнэлгээний үр дүнгээр банкны зээлийн шалгуур чангарах буюу индексийн утга нэг нэгж хувиар өсөхөд дунджаар ББСБ–уудын зээлийн улирлын өсөлт 1.4 нэгж хувиар нэмэгдэхээр байна.
- ББСБ–ын зээлийн эрэлтэд нөлөөлөгч бусад хүчин зүйлсийн нөлөөг авч үзвэл эдийн засгийн өсөлт болон ББСБ–уудын зээлийн хооронд сөрөг хамаарал ажиглагдсан. Энэ нь банкнаас бусад санхүүгийн байгууллагууд нь сүүдрийн банкны шинжтэй буюу банкны зээлийг тодорхой хэмжээнд орлож иргэдийн шаардлагатай санхүүжилтийг нөхдөг бөгөөд мөчлөг сөрсөн шинжтэй байгааг харуулж байна. Мөн инфляцийн түвшин нь ББСБ–уудын зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх чиглэлд харин бодит цалингийн өсөлт бууруулах чиглэлд нөлөө үзүүлдэг гэсэн үр дүн гарлаа.
- Зээлийн эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээнээс харахад ББСБ–уудын зээлийн эрэлтэд зээлийн хүүний мэдрэмж сул бөгөөд иргэд хүүний түвшингээс илүүтэйгээр бусад нөхцөл, шалгууруудыг голчлон үзэх талтай байна. Харин ББСБ–уудын зээлийн хүү өндөр байх нь ББСБ–уудын ашигт ажиллагааг сайжруулах тул зээлийн нийлүүлэлтэд эерэгээр нөлөөлж байна.
- Түүнчлэн өөрийн хөрөнгийн өсөлт нь ББСБ–уудын зээл олгох эх үүсвэрийн хүрэлцээг сайжруулж улмаар зээлийн нийлүүлэлт нэмэгдэх гол хүчин зүйл болж байгаа нь судалгааны үр дүнгээр харагдлаа.

Цаашид ББСБ–уудад иргэдийн зээлийг хязгаарлах зохицуулалтын бодлогыг авч хэрэгжүүлэх тохиолдолд дараах асуудлуудыг анхаарах нь зүйтэй гэж үзлээ:

- Манай улсад 2011 оноос эхлэн арилжааны банкууд болон бусад цөөн тооны санхүүгийн байгууллагууд нь санхүүгийн групп болж, санхүүгийн зах зээлд брокер, дилер, хөрөнгө оруулалтын менежмент, сан, даатгал, хадгаламж, зээлийн хоршоо болон банк бус санхүүгийн байгууллагуудад охин компаниа байгуулах замаар үйл ажиллагаа эрхлэх болсон. Эдгээр групп компаниудын 6 нь арилжааны банкны охин болон холбоотой талууд байгаа тул эдгээрийн төвлөрөл, хоорондын холбоо хамаарал нь системийн эрсдэлийг үүсгэх аюултай. Иймд уг эрсдэлд тохирсон макро

зохистой бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай.

- ББСБ–уудын хэрэглээний зээлд хязгаарлалт тавих нь уг зээлээр амьжиргаагаа залгуулах сонирхолтой иргэдийг шаардлага бага, зардал өндөр бусад эх үүсвэрийг хайхад хүргэж болзошгүй. Ингэснээр сүүдрийн банкны нөлөө, бүртгэлгүй санхүүгийн үйлчилгээ, далд эдийн засгийн цар хүрээг ихэсгэж, хэрэглэгчдийн хүүгийн дарамтыг нэмэгдүүлэх эрсдэлтэй.
- Иймд хязгаарлалтын бодлогоос гадна олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлыг төрийн, мэргэжлийн, төрийн бус гэх мэт бусад байгууллагатай хамтран тууштай бөгөөд эрчимтэйгээр хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Ингэснээр иргэдийг хувийн санхүүгээ зөв удирдах, хэрэглээний зээл авах шийдвэрийг ухаалгаар гаргах хөшүүргийг бий болгох юм.

Албан ёсны ББСБ–уудын үйл ажиллагаа, мэдээ, тайлангийн бүртгэлийг сайжруулах, мөн ББСБ–ын хүрээнд (*ломбард, хувь хүн зэрэг*) албан бус үйл ажиллагаа эрхлэгчдийг зохицуулах шаардлагаар Банк бус санхүүгийн байгууллагын тухай хууль эрх зүйн орчныг сайжруулах хэрэгтэй байна.

ДОЛОО. ХАВСРАЛТ

Хүснэгт 4. 4. Зээлийн эрэлтийн тэгшитгэлийн үнэлгээ (Дамми)

Тайлбарлагч хувьсагчид	$\Delta \ln(\text{Олгосон зээл})$					
	(2)	(3)	(4)	(5)	(6)	(7)
	Pooled OLS	Fixed effects	Random effects	IV	IV	3SLS
Зээлийн хүү	-0.0707* [0.0422]	-0.198* [0.119]	-0.0707* [0.0400]	-3.400 [4.478]	0.0711 [0.0993]	0.0416 [0.122]
Дамми (2019q1–2019q2)	1.848*** [0.147]	1.828*** [0.160]	1.848*** [0.151]	1.364* [0.796]	1.868*** [0.149]	1.673*** [0.148]
БДНБ-ий өсөлт (-3)	-0.174*** [0.0176]	-0.178*** [0.0191]	-0.174*** [0.0164]	-0.304* [0.180]	-0.168*** [0.0180]	-0.153*** [0.0173]
Инфляци	0.0603** [0.0269]	0.0578** [0.0292]	0.0603** [0.0271]	0.0439 [0.0838]	0.0610** [0.0270]	0.0478* [0.0266]
Бодит цалингийн өсөлт	-0.0790*** [0.00859]	-0.0776*** [0.00935]	-0.0790*** [0.00880]	-0.0721*** [0.0273]	-0.0793*** [0.00863]	-0.0859*** [0.00863]
Ажилгүйдэл	-0.487*** [0.0542]	-0.491*** [0.0564]	-0.487*** [0.0487]	-0.185 [0.429]	-0.500*** [0.0549]	-0.439*** [0.0427]
Өрхийн зарлагын өсөлт	-0.140*** [0.0442]	-0.139*** [0.0455]	-0.140*** [0.0406]	-0.312 [0.255]	-0.132*** [0.0448]	-0.109*** [0.0360]
Тогтмол	5.430*** [0.348]	5.908*** [0.462]	5.430*** [0.348]	15.13 [13.05]	5.017*** [0.444]	4.500*** [0.450]
Hausmen test (p-value)		0.4193				
Sargen-Hansen				0.000	0.000	
F-statistics †				0.563	110.32***	
LM statistic ††				0.649	56.567***	
Инструмент хувьсагч				ТГГЧ-ын харьцаа	$\ln(\Theta \cdot X_{\Theta})$	
Observations	1,112	1,112	1,112	1,112	1,112	1,112
R ²	0.269	0.324	0.2689	-5.085	0.259	0.253

Хаалтанд стандарт алдгаар (robust s.e) харуулав.

*** p<0.01, ** p<0.05, * p<0.1

† - Cragg-Donald Wald F statistic

†† - Kleibergen-Paap rk LM statistic

Хүснэгт 4. 5. Хувьсагчдын дэлгэрэнгүй тайлбар, тоон мэдээллийн эх үүсвэр

Хувьсагчид	Тайлбар	Эх сурвалж
Банк бус санхүүгийн байгууллагын үзүүлэлтүүд		
$dl\lnloan_{it}$	ББСБ–ын тухайн улиралд олгсон зээлийн логарифмын өөрчлөлт	СЗХ
lr_{it}	ББСБ–ын сарын зээлийн хүү	СЗХ
$liqratio_{it}$	ББСБ–ын мөнгөн хөрөнгө, активын харьцаа	
$loanratio_{it}$	ББСБ–ын зээл, активын харьцаа	СЗХ
$ln\text{cap}_{it}$	ББСБ–ын өөрийн хөрөнгийн логарифм	СЗХ
Макро эдийн засгийн үзүүлэлтүүд		
$rgdpg_t$	Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	ҮСХ
inf_t	Хэрэглээний үний индексээр илэрхийлэгдсэн инфляци	ҮСХ
ur_t	Ажилгүйдлийн түвшин	ҮСХ
$wage$	Бодит цалингийн өсөлт	ҮСХ
hh_exp_t	Өрхийн зарлагын өсөлт	ҮСХ
Бусад хувьсагчид		
BLS_t	Банкны зээлийн шалгуурын өөрчлөлтийн индекс	Монголбанк
d_t	Дамми хувьсагч (Бодлогын хэрэгжилттэй үед 1, бусад үед 0 гэсэн утга авна)	–

НАЙМ. ЭХ СУРВАЛЖ

- Schwarcz , S. L. Shadow Banking and Regulation in China and Other Developing Countries. <https://ssrn.com/abstract=2871297>. 2016.
- Behrendt, S. Determinants of lending activity in the Euro area. Jena Economic Research Papers, 2016–2017.
- BIS. Macroprudential frameworks, implementation and relationship with other policies. BIS Papers No 94, Monetary and Economic Department. 2017.
- Doojav, G.–O., & Batmunkh, U. Monetary and macroprudential policy in a commodity exporting economy: A structural model analysis. *Central Bank Review*, 18(3), 107–128. 2018.
- Eugenio , C., Stijn , C., & Luc , L. The Use and Effectiveness of Macroprudential Policies: New Evidence. IMF Working Paper. 2015.
- Gambacorta , L., & Marques–Ibanez, D. The bank lending channel: lessons from the crisis. European Central Bank. 2011.
- Gambacorta , L., & Shin , H. S. Why bank capital matters for monetary policy. BIS. 2016.
- Gebauer , S., & Mazelis, F. Macroprudential Regulation and Leakage to the Shadow Banking Sector. German Institute for Economic Research. DIW Berlin. 2019.
- Ghosh, S., Mazo, I. G., & Ötoker-Robe, İ. Chasing the Shadows: How Significant Is Shadow Banking in Emerging Markets? POVERTY REDUCTION AND ECONOMIC MANAGEMENT NETWORK, THE WORLD BANK, POVERTY REDUCTION AND ECONOMIC MANAGEMENT NETWORK. 2012.
- Mauricio, C., Pablo , G., & Daniel, O. Supply and Demand identification in the credit market. Central bank of Chile. 2010.
- Mauricio, C., Pablo, G. S., & Daniel , O. Z. Supply and Demand Identification in The Credit Market. Central Bank of Chile. 2010.
- Meeks, R., Nelson , B. D., & Alessandri , P. Shadow banks and macroeconomic instability. Bank of England. 2014.
- Ozge , A., & Jane , O.–R. How effective are macroprudential policies? An empirical investigation. *Journal of Financial Intermediation*, 33, 33–57. doi:<https://doi.org/10.1016/j.jfi.2017.04.001>. 2018.
- Pınar, E., Etkin, Ö., & İbrahim, Ü. Are Macroprudential Policies Effective Tools to Reduce Credit Growth in Emerging Markets? Central Bank of the Republic of Turkey. 2017.
- Sanderson, E., & Windmeijerabc, F. A weak instrument F–test in linear IV models with multiple endogenous variables. *Journal of Econometrics*, 190(2), 212–221. 2016.
- Shin, H. S. Macroprudential policies beyond Basel III. Princeton University. 2010.
- Stock, J., & Yogo, M. Testing for weak instruments in linear IV regression, in DWK Andrews and JH Stock, eds., *Identification and Inference for Econometric Models: Essays in Honor of Thomas J. Rothenberg*. Cambridge University Press, Cambridge, UK. 2005.
- Sun, G. China’s Shadow Banking: Bank’s Shadow and Traditional Shadow Banking. Working Papers No 822, BIS, Monetary and Economic Department. 2019.
- Zellner , A., & Theil, H. Three–Stage Least Squares: Simultaneous Estimation of Simultaneous Equations. *Econometrica*, 30(1), 54–78. 1962.





САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ТЕХНОЛОГИ, ТЭДГЭЭРИЙН ТӨРӨЛ, ЗОХИЦУУЛАЛТ

2019 он

Гүйцэтгэсэн: Б.Батболд¹, А.Мөнгөнсаран², Б.Наранжаргал³,
Б.Батчимэг⁴

¹ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын мэргэжилтэн, batbold_b@frc.mn

² Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, mungunsaran@frc.mn

³ Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн, naranjargal_b@frc.mn

⁴ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлын зорилго нь санхүүгийн салбарт шинээр үүсэж амжилттай хэрэгжиж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний олон улсын жишээ болон тэдгээрийг хэрхэн өөрийн улсын зах зээлд аюулгүй нэвтрүүлэх, үр дүнтэй зохицуулах талаар судлахад оршино.

Судалгааны ажилд бичил санхүүгийн байгууллага, даатгалын салбарт гарч буй шинэ технологиуд, тэдгээрийг нэвтрүүлэхэд анхаарах зүйлс зэрэг чухал агуулгуудыг багтаасан ба цаг тутамд шинээр бий болж хөгжиж буй технологи нь зөвхөн санхүүгийн салбартаа төдийгүй тогтвортой хөгжилд хэрхэн нөлөөлдгийг улс орнуудын туршлагад үндэслэн танилцуулсан.

Судалгааны үр дүнд, манай улсын хувьд санхүүгийн салбарт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч эхэлсэн хэдий ч эдгээртэй холбоотой зохицуулалт, хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг байна. Иймд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхийн тулд холбогдох хууль, дүрэм, журмын сайн туршлагуудыг өөрийн улсынхаа хөрсөнд буулган суурьшуулах хэрэгтэй байгаа юм.

Түлхүүр үгс: технологийн дэвшил, финтек, регтек, иншүртек, блокчейн;

JEL ангилал: G2, O3

НЭГ. УДИРТГАЛ

Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлд технологийн дэвшил хурдацтай нэвтэрч санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанаас эхлэн хэрэглэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх хандлагад нөлөөлөх, цаашлаад эдийн засгийн хөгжил, тэгш бус байдал, ядуурлын асуудлуудыг шийдвэрлэхэд тус болохуйц томоохон өөрчлөлтийг авчирч, салбарыг бүхэлд нь өөрчилж байна. Санхүүгийн салбарт гарч буй энэхүү инновацыг бид “Финтек” гэж нэрийдэж байна. Финтек нь санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхээс гадна төлбөр тооцооны үйлчилгээ, хөрөнгө оруулалт, менежментийн үйл ажиллагаа, даатгал, зээлийн бүтээгдэхүүн зэрэг санхүүгийн олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд нэвтэрч байна.

Энэхүү инновацын үр дүнд бий болж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийн дэвшил нь зах зээл дэх өрсөлдөөнийг дэмжиж, зардлыг бууруулан, үр ашгийг нэмэгдүүлж байна. Түүгээр ч барахгүй зах зээлийн хөгжлөөс алслагдсан иргэдэд гар утас, интернетийн сүлжээг нэвтрүүлснээр хөгжлийн наад захын амин чухал хэрэгцээ болох эрүүл мэнд, боловсрол, банк санхүүгийн үйлчилгээг хүргэх боломж нээгдэж байна.


Энэ дундаа санхүүгийн зах зээлд гарч буй инновац нь зах зээлийн хэмжээг нэмэгдүүлж, гүнзгийрүүлж, төрөлжүүлж, глобалчилж, тэр ч бүү хэл санхүүгийн зах зээлийн бүтцийг өөрчилж, санхүүгийн системийг улам боловсронгуй болгон хүртээмжтэй өсөлтийг бий болгож байна. Технологийн дэвшилд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээ буюу Финтек нь албан ёсны санхүүгийн зах зээлийн гадна орхигдсон маш олон хүмүүст санхүүгийн үйлчилгээг хүргэж, хүртээмжийг нэвтрүүлж байгаа сайн жишээнүүд дэлхий нийтэд маш олон бий.

ХОЁР. САНХҮҮГИЙН ТЕХНОЛОГИ БУЮУ ФИНТЕК

Технологийн дэвшилд тулгуурласан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх болсноор бидний өдөр тутмын амьдралын хэв маяг өөрчлөгдөөд зогсохгүй, түргэн шуурхай хямд өртөг бүхий, нийгмийн аль ч бүлэгт хүрч үйлчлэх санхүүгийн бүтээгдэхүүнийг авч хэрэглэх боломж бүрдэж, цаашлаад энэ нь нийт эдийн засагт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх томоохон гарц болоод байна. Нөгөө талдаа финтек компаниуд санхүүгийн зах зээлд орж ирснээр уламжлалт санхүүгийн байгууллагуудын бүтцийн зардал буурах, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар сайжрах, бизнесийн үр ашигтай шинэ загвар бүрэлдүүлэх зэрэг олон эерэг хандлагууд гарч ирсээр байгаа билээ.

2018 онд финтек компаниудын хувьд өөрсдийн чадамжийг харуулж, санхүүгийн байгууллагуудтай харилцан тохиролцож, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, олон гэрээ хэлэлцээр хийгдсэн чухал жил болж өнгөрсөн. 2018 онд финтекийн салбарт оруулсан гарааны бизнесийн хөрөнгө /venture capital/ оруулалт 2017 оноос 2 дахин өсөж 23 тэрбум ам.долларт хүрсэн бол рэгтект оруулсан хөрөнгө оруулалт 2017 оноос 3 дахин өсөж 3.7 тэрбум ам.долларт хүрчээ. Харин блокчейн болон криптовалютад оруулсан хөрөнгө оруулалт 4.5 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна. Түүнчлэн дата анализ, мобайл, хиймэл оюун ухаан, кибер нууцлал, робот автоматжуулалт, биометрик технологи, блокчейн, үүлэн системд оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх жилүүдээс огцом нэмэгдсэн. Мэдээлэл технологи асар хурдацтай хөгжиж буй өнөө үед хөрөнгө оруулагчид уламжлалт банк, банк бус, үнэт цаас, даатгалын системд хөрөнгө оруулахаас илүүтэйгээр технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээ санал болгож буй гарааны бизнес, банкууд болон бусад санхүүгийн институцид хөрөнгө оруулах хандлага ихээр нэмэгдэх болов. 2018 оны байдлаар дэлхийн хэмжээнд финтекийн үйл ажиллагаа явуулдаг компаниудад оруулсан хөрөнгө оруулалт гэхэд өмнөх оны 4-р улиралтай харьцуулахад 2 дахин нэмэгдэж 29.8 тэрбум ам.долларт хүрсэн. Хэдий нийт хэлцлийн тоо 200 орчмоор буурсан боловч нэг хэлцэлд хийгдэж буй хөрөнгө оруулалтын тоо бусад онуудтай харьцуулахад нэмэгдсэн байна.

Зураг 5.1. Финтект оруулсан капитал хөрөнгө оруулалт ба нийт хэлцлийн тоо



Эх сурвалж: *The pulse of fintech 2018, KPMG*

Технологийн хурдац хором бүрээр хэмжигдэж буй энэ үед дэлхийн өнцөг булан бүрд технологийн дэвшлийг санхүүгийн зах зээл дээр нэвтрүүлж, хөрөнгө оруулагчид болон хэрэглэгчдээ татах гэсэн улс орноос эхлээд жижиг санхүүгийн байгууллагуудын хооронд идэвхтэй өрсөлдөөн өрнөх болов. Финтекийг санхүүгийн зах зээлдээ тогтмол нэвтрүүлж, нутагшуулж буй улс орнуудыг Хятад, Энэтхэг, Их Британи зэрэг улсууд тэргүүлж байна. 2018 оны судалгаанаас харахад хэрэглэгчдэд хүртээмжтэй, цаг хэмнэсэн, үр ашигтай бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж буй салбаруудыг банк болон даатгалын салбар тэргүүлж байна. Банкны хувьд уламжлалт үйлчилгээг финтекийн тусламжтайгаар сайжруулан үр ашигтай бүтээгдэхүүнийг зах зээлд танилцуулж байгаа нь банкны салбарын дэд бүтцийн зардлыг 30 орчим хувьд бууруулж байгаа гэсэн судалгаа гарчээ.

Түүнчлэн, өнөө үед гар утас, электрон хэрэгсэл, компьютер бидний өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болохын хэрээр технологид суурилсан санхүүгийн олон талт үйлчилгээний хүрээ нэмэгдэж, нөгөө талдаа түүний хэрэглээ хором тутамд өсөж байна. 2018 оны байдлаар нийт төлбөр тооцооны 84 хувь, сан хоорондын гүйлгээний 68 хувь, хувийн санхүү болон хувийн зээл тус бүр 60 хувь, 50 хувь, даатгал болон хөрөнгийн удирдлагын 38 хувь нь технологийн дэвшлийг ашиглан гүйцэтгэгдсэн байна. Монгол Улсын хувьд ч мөн адил технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ зах зээлд нэвтрээд багагүй хугацаа өнгөрч байна. Тэр дундаа банк, санхүүгийн байгууллагуудын технологид суурилсан үйлчилгээ улам сайжирч, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хямд өртгөөр хэрэглэгчдэд хүргэх боломж нэмэгдэн, өргөн цар хүрээг хамрах болсон нь санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа юм. Монголбанкнаас гаргасан судалгаанаас харахад л 2018 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын интернет орчноор дамжуулан санхүүгийн үйлчилгээ авч буй хэрэглэгчид өмнөх оноос 29.9 хувиар нэмэгдсэн дүнтэй байна. Харин СЗХ-ны зохицуулалтын салбаруудын хувьд уламжлалт санхүүгийн зах зээлийг өөрчилсөн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд нэвтэрч, санхүүгийн зах зээлийн бүтцийг өөрчлөх хандлагатай байна. Тухайлбал банк бус санхүүгийн байгууллагууд гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ, цахим мөнгө, цахим хэтэвчний үйлчилгээг зах зээлд нийлүүлж эхэлсэн нь хэрэглэгчид гар утсаараа дамжуулан зөвхөн санхүүжилтийн асуудлаа шийдвэрлэхээс гадна хэрэглээний төлбөр тооцоогоо төлөх, онлайнаар худалдан авалт хийж цагаа хэмнэх зэрэг олон боломжийг олгож байна. 2018 оны байдлаар банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хэрэглэгчдийн 40 гаруй хувь нь гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээг хүртэж байгаа нь финтекийн бүтээгдэхүүн үйлчилгээ зах зээлд хурдтай нэвтэрч буйг харуулж байна. Үүнээс гадна финтек компаниуд блокчейн технологид суурилсан арилжааны платформыг хөгжүүлж хөрөнгийн зах зээлд танилцуулж эхлээд байгаа бол даатгалын салбарын хувьд ч мөн адил технологийн дэвшил хурдтай нэвтэрч даатгалын компаниуд цахим даатгалын үйлчилгээг санал болгож эхлээд байна.

Финтекийн хандлагууд:


Олон улсын хэмжээнд финтекийн салбарын хөгжлийг гар утасны технологи, дижитал банк, биометрик технологи, блокчейн технологи, хиймэл оюун ухаантай холбоотой гарсан өөрчлөлт, дэвшилтүүд эрчимжүүлэх хандлагатай байна. Эдгээр технологиудын хүрээнд өнгөрсөн жилүүдэд гарсан чиг хандлагуудыг авч үзвэл:

1. Гар утасны технологи: Хүмүүс гар утсыг илүү их ашиглахын хэрээр санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ гар утсанд суурилах болсон. PWC-ийн 2018 оны “Дижитал банкны хэрэглэгчдийн судалгаа”-ны үр дүнгээс харахад өөрийн гар утсаар банкны үйлчилгээг авах сонирхолтой иргэдийн тоо нэмэгдсэн байсан бөгөөд энэ нь тэдэнд өөрийн биеэр банкны салбарт очихгүйгээр


банкны үйлчилгээг авах том давуу тал болж байгаа тухай мөн дурджээ. Мөн хөгжил буурай орнуудын хувьд, нэн ялангуяа Африкийн орнуудын хувь гар утасны технологид суурилсан мобайл мөнгөний хэрэглээ өндөр байгаа бөгөөд энэ нь эмэгтэйчүүд, хөдөө орон нутгийн иргэд зэрэг нийгмийн хамгийн эмзэг бүлгүүдийн санхүүгийн зах зээл дэх оролцоог нэмэгдүүлж байгаа тухай Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэгээс 2018 онд гаргасан “Санхүүгийн хүртээмж дэх финтек тайлан”-д тусгасан байна.

2. Дижитал банк: Дижитал банкны үйлчилгээ нь маш өндөр түвшний автомат үйл ажиллагаа бүхий веб суурьтай үйлчилгээ бөгөөд түүнчлэн банкны үйлчилгээг хүргэх, төлбөр тооцоог гүйцэтгэх хүрээнд санхүүгийн байгууллага хоорондын үйл ажиллагааг холбох зорилгоор API-ийг ч ашигладаг. Тус үйлчилгээ нь санхүүгийн хэрэглэгчдэд гар утас, компьютер, АТМ зэрэг төхөөрөмжөөр дамжуулан санхүүгийн хэрэглээгээ түргэн шуурхай хангах боломж олгодог тул эрэлтээ дагаад гар утсаар дамжуулан хийгдэж буй санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын тоо ч мөн адил нэмэгдэх хандлага ажиглагдах болсон.
3. Биометрик технологи: Өнөөгийн дижитал эрин үед цахим халдлага нь эмзэг асуудлуудын нэг болоод байгаа тул финтекийн салбарын хувьд цахим аюулгүй байдлыг нэн тэргүүнд шийдвэрлэх нь чухал. Тус асуудлыг шийдвэрлэх нэг арга зам нь биометрик технологи юм. Хэдий хамгаалалт нь зөвхөн биометрик баталгаажуулалтыг шаарддаг боловч, энэхүү технологи нь аппликэйшнд нэвтрэх үйл явцыг илүү хялбар бөгөөд түргэн шуурхай болгох давуу талыг олгож байгаа юм.
4. Блокчейн технологи: Блокчейн технологи нь мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд маш нээлттэй суурь болж байгаа тул финтекийн шинэ гарааны бизнес эрхлэгчид тус технологийг өргөн ашиглах хандлагатай байна. Санхүүгийн үйл ажиллагааг автоматжуулах ухаалаг гэрээ хэлэлцээрийг хийх боломжийг тус технологи олгож байгаа нь түүний өөр нэгэн давуу тал болж байна.
5. Хиймэл оюун ухаан: Хиймэл оюун ухааныг финтекийн салбарт ашиглах хэд хэдэн шалтгааныг энд дурдаж болно. Нэн тэргүүнд ухаалаг оюун ухаан нь маш өргөн цар хүрээг хамарсан өгөгдлийн шинжилгээг автоматжуулах боломжийг олгож байгаа нь цаг хугацааг хэмнэх болсон. Түүнчлэн тус технологи нь чатбот, робот зөвлөгчийн хөгжүүлэлтэд ашиглагдах гол суурь болж байгаагаас гадна хэрэглэгчдийн зан төлөв, дадал хэвшлийг хянах замаар ямарваа нэгэн залилан хууран мэхлэлтийг илрүүлэх боломж олгож байгаа юм.

Зураг 5. 2. Финтекийн хэрэглээний түвшин



Зураг 5. 3. Санхүүгийн зах зээл дээрх финтек ашиглалтын хувь



Эх сурвалж: www.finsmes.com

ГУРАВ. БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Хамгийн амжилттай нэвтэрч эдийн засаг, иргэдийн аж амьдралд мэдэгдэхүйц эерэг нөлөөг үзүүлж байгаа нэг төрлийн бүтээгдэхүүн бол технологид суурилсан зээлийн үйлчилгээ юм. Технологийн дэвшлийг зээлийн үйл ажиллагаанд ашигласнаар санхүүгийн байгууллагуудын зардал буурах, санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжрах, уламжлалт банкны зээлийн үйлчилгээнээс хасагдсан иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүжилтийн олон төрлийн боломж нээгдэх зэрэг олон давуу тал үүсэж байна.


Статистик дүнгээс харахад технологид суурилсан зээлийн үйлчилгээ хамгийн өргөн хүрээнд нэвтэрсэн улс нь Хятад, үүний дараагаар АНУ, Их Британи зэрэг улсууд байна. Эдгээр улсуудын хувьд нэг хүнд ногдох финтек зээлийн дүн нь 60–110 ам.доллар байна. Мөн АНУ, Герман, Солонгос, Шинэ Зеланд зэрэг улсуудын хувьд технологид суурилсан зээлийн үйлчилгээний дийлэнх буюу 80 гаруй хувийг иргэдэд олгосон зээл бүрдүүлж байгаа бол Австрали, Япон, Нидерланд улсуудын хувьд аж ахуйн нэгжүүд нь технологид суурилсан зээлийн үйлчилгээг бусад улс орнуудаас илүү их ашиглаж байна. Дараах төрлийн финтек зээлийн загварууд санхүүгийн зах зээлд түгээмэл ашиглагдаж байна. Үүнд:

Уламжлалт P2P зээлийн загвар:

P2P зээлийн загвар нь зээл олгогч, зээл хүсэгч, тэднийг холбох үүрэг бүхий платформуос бүрдэнэ. Зээл хүсэгч иргэн нь платформд өөрийн мэдээллээ оруулж, бүртгүүлснээр платформын үйл ажиллагаа эхэлдэг. Платформ нь зээлдэгчийн мэдээллийг шинжлэн баталгаажуулах бөгөөд зээл олгогч буюу хөрөнгө оруулагч нар зээлийн хэмжээ, хугацаа, зориулалт болон зээл хүсэгчийн орлого зэрэг мэдээлэлд суурилан санхүүжүүлэх зээлээ сонгоно. Дундын платформ нь зээлдэгчийн эрсдэлийг үнэлэх, зээлдэгчтэй холбоотой тоон мэдээллийн санг үүсгэх зэрэг үүргийг гүйцэтгэн ажилладаг.

Энэтхэг, Хятад улсуудад ашиглагдаж буй P2P зээлийн платформууд нь арилжааны банкны тоон мэдээллийн сангаас илүү том, илүү нарийвчлал сайтай тоон мэдээллийн сан үүсгэж, олон төрлийн шинжилгээг хийх бүрэн чадвартай болж хөгжсөн байна. Одоогоор үйл ажиллагаа явуулж буй ихэнх P2P платформууд нь хөрөнгө оруулагчдыг хэд хэдэн зээлийн төслүүдийг давхар сонгож, эрсдэлээ тархаахыг санал болгодог бөгөөд хөрөнгө оруулагчийн хүссэн шаардлагын дагуу автоматаар хөрөнгийг нь олон төрлийн зээлийн төслүүдэд хуваарилдаг үйлчилгээ мөн ашиглагдаж байна. Тухайлбал 2016 онд хийгдсэн нэгэн судалгааны үр дүнгээс харахад Европын P2P платформуор хийгдэж буй иргэдийн зээлийн 80 хувь, бизнесийн зээлийн 40 хувь нь уг автоматаар сонгох механизмыг ашиглаж байна. Мөн Австрали, Хятад, Итали, Өмнөд Африк, Их Британи зэрэг улсуудад үйл ажиллагаа явуулж буй P2P платформууд нь хөрөнгө оруулагч оруулсан хөрөнгөө буцаан авахыг хүссэн тохиолдолд тодорхой хэмжээний шимтгэл аван зээлийн дүнг өөр хөрөнгө оруулагчид шилжүүлдэг үйлчилгээг санал болгож байна.


Зураг 5. 4. Уламжлалт P2P зээлийн загвар



Нотари зээлийн загвар:

Нотари зээлийн загвар нь мөн хөрөнгө оруулагч, зээлийн төслийг холбох үүрэг бүхий платформын хүрээнд ажилладаг хэдий ч зээлийг дундын банк нийлүүлдэг онцлогтой. Энэ төрлийн финтек зээлийн платформууд нь Герман, Солонгос, АНУ–д өргөн ашиглагдаж байна. Зээл хүсэгч, хөрөнгө оруулагчийг холбосон мэргэжлийн санхүүгийн байгууллага зээлийн платформтой хамтран ажиллах нь илүү эрсдэл багатайд тооцогдож байгаа тул энэ төрлийн загвар илүү өргөн хүрээнд ашиглагдаж байна.


Зураг 5. 5. Нотари зээлийн загвар



Баталгаат зээлийн загвар:

Баталгаат зээлийн загвараар дундын платформ нь зээлийн эргэн төлөлтийг батлан дааж хөрөнгө оруулагчдад зээлийн эрсдэлээс үл хамааран зээлийн дүнг тодорхой хэмжээний өгөөжийн хамт буцаан олгодог онцлогтой. Энэ төрлийн зээлийн загвар нь Хятад Улсад өргөн ашиглагдаж байна. 2015 онд мэргэшсэн нягтлан бодогчдын холбооноос хийсэн судалгаанаас харахад Хятадын томоохон зээлийн баталгаат платформууд нь хөрөнгө оруулагчийн хөрөнгийг олон төрлийн зээлийн төслүүдэд хуваарилж дунджаар 12 хувийн өгөөжийг санал болгож байна.

Зураг 5. 6. Зээлийн баталгаат загвар



Балансын загвар:

Балансын загварт зээлийн платформ нь банк бус санхүүгийн байгууллагын үүргийг гүйцэтгэх бөгөөд хөрөнгө оруулагчдын хөрөнгийг өөрийн балансын бүтцэд оруулан, зээлийн төслийг санхүүжүүлэхээс гадна бусад төрлийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг явуулах замаар ажилладаг. Энэ төрлийн загвар нь Австрали, Канад улсуудад түгээмэл ашиглагдаж байна.

Зураг 5. 7. Балансын загвар



Төлбөрийн даалгаврын загвар:

Бизнесийн байгууллагууд төлбөрийн даалгавраа гуравдагч этгээдэд худалдаалах замаар хөрвөх чадварын асуудлаа түргэн шуурхай шийдвэрлэдэг. Энэ төрлийн санхүүгийн үйлчилгээг факторинг гэж нэрлэдэг. Финтек компаниуд гарааны бизнес эрхлэгчид, жижиг дунд үйлдвэрлэлд зориулсан төлбөрийн даалгавраа арилжаалах боломж бүхий платформыг хөгжүүлж эхлээд байгаа ба энэ төрлийн платформ нь уламжлалт факторингийн үйлчилгээнээс илүү үр ашигтай ажиллаж байна.

Дараах хүснэгтэд дээрх төрлийн зээлийн платформын үйл ажиллагааг амжилттай явуулж буй финтек компаниудыг харууллаа.

Хүснэгт 5. 1. Зээлийн платформын үйл ажиллагаа явуулж буй финтек компаниудын жишээ


		Уламжлалт P2P загвар	Нотари загвар	Баталгаат зээлийн загвар	Балансын загвар	Төлбөрийн даалгаврын загвар
Зээлийн төрөл	Хэрэглээний зээл	Funding Secure Zopa RateSetter Lending Works Lendable	Lending Club Auxmoney	Dianrong PPDai	SoFi	
	Бизнесийн зээл	Funding Circle ThinCats LendInvest Assetz Capital Saving Stream		Dianrong PPDai		Market Invoice Investly Finexkap Demica CRX Markets
	Үл хөдлөх хөрөнгийн зээл	Wellesley LendInvest			Wellesley LendInvest	

Төлбөр тооцооны загвар:

Пэйтек /PayTech/ нь төлбөр, тооцооны үйл ажиллагаанд ашиглагддаг технологид суурилсан санхүүгийн үйлчилгээний нэг хэлбэр юм. Одоогоор дэлхийн томоохон төлбөр тооцооны үйл ажиллагаа явуулагч байгууллагууд гар утасны аппликэйшн, электрон түрийвч зэрэг пэйтекийн шийдлүүдийг ашиглаж байна. 2018 онд дэлхийн нийт пэйтек компаниудад оруулсан хөрөнгө оруулалт хамгийн их хэмжээндээ буюу 18.0 тэрбум ам.доллар хүрсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын 77.8 хувь буюу 14.0 тэрбум нь зөвхөн БНХАУ-ын “Айнт Фаянэйншл” /Ant Financial/ финтекийн нэгдэлд оруулсан хөрөнгө оруулалт байсан бөгөөд тус байгууллага нь одоогоор дэлхийн хамгийн том гар утасны болон цахим төлбөр тооцооны систем болох Алипэй /Alipay/-г эзэмшдэг.

Харин Сиэ /Sea/ группийн хувьцаагаа анхдагч зах зээлд олон нийтэд санал болгож (IPO) татан төвлөрүүлсэн 575.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт нь 2018 оны хоёр дахь том хөрөнгө оруулалт нь байв. Тус компанийн эзэмшдэг Эйрпэй /AirPay/ нь Индонез, Тайван, Тайланд, Малайз зэрэг Зүүн өмнөд Азийн улсуудын хэрэглэгчдийн ашигладаг электрон түрийвчийн платформ юм.

Зураг 5. 8. Дэлхийн хэмжээнд нийт ПэйТек компанийн хөрөнгө оруулалт /сая ам.доллараар/



Эх сурвалж: FinTech Global

1. Интернет дэх төлбөр тооцоо:

Олон улсын судалгааны байгууллага болох Гартнер /gartner/–ийн судалгаагаар 2016 онд 6.4 тэрбум байсан интернетед холбогдсон төхөөрөмжийн тоо 2020 он гэхэд 20.8 тэрбум хүртэл нэмэгдэнэ гэжээ. Хэрэглэгчид эдгээр төхөөрөмжүүдийг төлбөр тооцоог хялбарчлах зориулалтаар ашиглах хандлагатай байна. Жишээ нь: “Smart refrigerator” буюу ухаалаг хөргөгчийг хэрэглэгчид ухаалаг системийг зөвхөн “хүнснийг дуусаж байгаа” талаарх мэдээллийг өгөхөөс илүүтэй “тухайн бүтээгдэхүүнийг автоматаар хүргүүлэн, тооцоо хийгддэг байх”–аар өөрчлөн, шинэчлэх хүсэлтийг тавьсаар байгаа аж. “Visa” болон “Honda” компаниуд хамтарч машины шатахуун дуусах дөхөж байвал машины дэлгэцтэй холбогдсон утасны аппликэйшнийг ашиглан шатахуун худалдан авах аргыг боловсруулж байна.

2. P2P төлбөр тооцоо:

Сүүлийн жилүүдэд P2P буюу хүмүүсийн хоорондын төлбөр, тооцоо, мөнгөн шилжүүлгийн талбар улам хөгжсөөр байна. Энэтхэгт гэхэд WhatsApp–ийн хэрэглэгчид цахим чатаар бие биедээ мөнгө шилжүүлэх боломжтой болсон. Apple компанийн хувьд энэхүү үйлчилгээг Apple Pay Cash аппликэйшнээр дамжуулж нэвтрүүлж байна. Цаашдаа Alexa, Siri, Cortana зэрэг дуу хоолой таних программыг ашиглан P2P төлбөр тооцоо болон банкны шилжүүлгийг хийх ч боломжтой болно гэж үзэж байна.

3. Бодит цагийн горимын төлбөр тооцоо:

Real–Time буюу бодит цагийн төлбөр тооцоо, шилжүүлэг нь ирэх жилүүдэд зах зээлд нэвтрэх төлөвтэй байна. Бодит цагийн төлбөр тооцооны хувьд дараах хэд хэдэн онцлогтой. Маш шуурхай, бараг л хормын төдийд буюу шилжүүлэгч этгээд үйлдлээ хиймэгц хүлээн авагчид очих; шилжүүлэгчийн шилжүүлэг амжилттай хийгдсэн эсэхийг тэр дор нь мэдэх боломжтой байх; Хэрэглэгчид бодит цагийн төлбөр тооцооны системийг шөнө оройн цагаар, амралтын өдрүүдэд, мөн түүнчлэн олон нийтийн баяр ёслолын үеэр ч ашиглах боломжтой болно гэсэн үг юм. Үйлдвэрлэгчдийн талаас бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ хөлсийг тэр дор нь авах сонирхолтой байдгаас энэхүү системийн шаардлага нэмэгдэж байна.


4. Электрон түрийвчийн хэрэглээ:

Финдексийн судалгаагаар 2017 оны байдлаар дэлхий даяар 1.7 тэрбум хүн санхүүгийн хүртээмжгүй эсвэл маш бага хүртээмжтэй байдаг гэсэн үр дүн гарсан байна. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж багатай улсын иргэдийн хувьд электрон түрийвчийг ашиглан (гар утасны түрийвч) өдөр тутмын төлбөр тооцооны хэрэгцээгээ хангаж байна. Цахим арилжаа, үйлчилгээний салбар өсөхтэй зэрэгцэн электрон түрийвчийг ашиглахдаа P2P буюу хүмүүс хоорондын биш харин B2C (business to customer) буюу үйлдвэрлэгч, хэрэглэгчийн хоорондын төлбөр тооцоо өсөх хандлага Ази, Африк, Латин Америкийн улсуудад харагдаж эхэлсэн.

5. Гар утсаар хийх төлбөр тооцоо:

Пэйтек компаниудын харилцагчдын хувьд гол төлөв гар утсыг ашигладаг ба гар утаснаас хийх төлбөр тооцооны дүн өсөх хандлагатай байгаа юм. Санхүүгийн зах зээлийн судалгааны байгууллага болох шэйрпостын 2018 онд гаргасан “Төлбөр тооцоо: Финтек дэх тэргүүлэгчид” салбарын тайланд гар утсаар хийх төлбөр тооцооны дүн өссөн үзүүлэлттэй ба цаашид өсөх төлөвтэй байгааг харуулжээ.

Зураг 5. 9. Гар утсаар хийгдэж буй төлбөр тооцооны хэмжээ /сая ам.доллараар/



Эх сурвалж: *Sharespost, Payments: Star of the Fintech World, 2018*

Төлбөр тооцооны финтекийн зохицуулалт:

Кибер халдлагууд өсөж байгаатай холбоотойгоор өгөгдлийн комплаенсын тал дээрх хяналт, зохицуулалт ихэссэн байна. Зах зээлд эзлэх байр сууриа болон харилцагчдаа хадгалж үлдэхийн тулд банкууд төлбөр тооцооны компаниудтай хамтарч ажиллах хэрэгтэй байгаа хэдий ч энэ нь цахим халдлагад өртөх магадлалыг ихэсгэж байгаа юм. Target, Yahoo, Equifax компаниудад гарсан цахим халдлагаас хойш зохицуулагч байгууллагууд харилцагчдын мэдээллийг хамгаалах асуудалд анхаарал хандуулж, комплаенсын асуудалд өндөр торгууль тогтоож ажиллаж байна.

Төлбөрийн үйлчилгээний удирдамж (PSD2 буюу Payment Service Directive): Европын холбооноос PSD2-ийг харилцагчдын мэдээллийн хувьд банкны монополийг байдлыг багасгах зорилготойгоор нэвтрүүлсэн байна. Энэхүү зохицуулалтаар компаниуд болон худалдаачдад PayPal, Visa гэх мэт гуравдагч этгээдийн оролцоогүйгээр төлбөр тооцоог гүйцэтгэх боломжийг олгож өгсөн байна. Зөвшөөрөл олгогдсон тохиолдолд санхүүгийн байгууллагаас бусад худалдааны байгууллагууд ч гэсэн банкны дансны мэдээллийн санд шууд нэвтрэх боломжтой болдог. Банкууд мөн өөрсдийн API (аппликэйшн программчлалын интерфейс)-ийг нээлттэй болгож өгөх ёстой ба ингэснээр хэрэглэгчдийн мэдээлэл гуравдагч үйлчилгээний байгууллагуудад нээлттэй болно гэсэн үг юм.

Мэдээлэл хамгааллын ерөнхий зохицуулалт (GDPR буюу general Data Protection Regulation): Европын холбооны гаргасан энэхүү зохицуулалт нь компаниудыг хувийн мэдээллийг буруу зорилгоор ашиглахаас сэргийлэх зорилготой. Энэхүү хуулийн хүрээнд банк болон төлбөр тооцооны байгууллагуудын мэдээллийг ашиглах, боловсруулах аргууд хязгаарлагдах ба мэдээлэл ашигласантай холбоотойгоор харьяа зохицуулалтын байгууллагадаа тайлагнах ёстой болдог. Хэрвээ зөрчил гаргасан тохиолдолд торгууль нь хэдэн сая ам.доллартай тэнцэхүйц байдаг.

Шигтгээ 1. Сая сая хүмүүст санхүүгийн хүртээмжийг хүргэх гар утасны технологи /Африк тив/

Африк тив бол дэлхийн гар утасны хамгийн хурдацтай хөгжиж буй санхүүгийн зах зээлийн талбар юм. Уг тивд уламжлалт банкны салбар болон АТМ-ны тоо багатай тул гар утас нь хэдэн зуун сая африкчуудад санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх боломжийг олгодог байна. Үүний зэрэгцээ, ирэх 25 жилийн дотор хоёр дахин нэмэгдэх гэж байгаа Африкийн залуу хүн ам нь бусад улс орны хүмүүстэй харьцуулахад гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээг илүү ихээр ашиглах хандлага ажиглагдаж байна.

Гар утсанд суурилсан зээлийн үйлчилгээ үзүүлдэг гар утасны Польш Улсаас гаралтай “Zenka Finance” компани нь Африкт өөрсдийн брэндээ гаргахаар хичээн ажиллаж байгаа юм. Zenka Finance нь 2018 оны 12 дугаар сараас Кени Улсад үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба жижиг бизнес эрхлэгчид болон энгийн хэрэглэгчдэд чиглэсэн 5 ам.доллараас 200 ам.доллар хүртэлх хэмжээтэй гар утасны бичил зээлийг санал болгосон.

2018 оны FinAccess судалгаагаар дижитал зээлийг хамгийн ихээр бизнесийн хэрэгцээнд ашигладаг болохыг харуулсан ба Zenka Finance нь уг хэрэгцээг тодорхойлж, бизнесийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн үйлчилгээг бий болгох, хүртээмжтэй хүргэх арга замыг эрэлхийлсэн байна. Юуны өмнө, Zenka Finance-ийн зээлийн бүтээгдэхүүн нь маш уян хатан бөгөөд үйлчлүүлэгч нь өөрийн хэрэгцээ шаардлагаасаа хамааран нэгээс 30 хоногоор төлөх хугацаагаа уртасган, зээлийн хязгаартаа багтаан нэмэлт мөнгө авах хүсэлт гаргах боломжтой.

Zenka Finance-ийн Кенийн зах зээлд хэрэгжүүлсэн бас нэг өвөрмөц онцлог зүйл бол анх удаа зээл авч буй зээлдэгчдэд анхны зээлээ ямар ч шимтгэлгүйгээр авах боломжийг олгосон явдал юм. Мөн зээлүүд нь хэрэглэгч бүрт хялбар байдаг. Android болон IOS үйлдлийн системтэй утасны Google Play Store болон App Store дээрээс бүрэн татаж авч ашиглах боломжтой, түүнчлэн USSD *841# кодоор дамжуулан үйлчилгээгээ авах боломжтой юм. Энэхүү кодоор дамжуулах арга нь хөдөө орон нутгийн гар утасны аппликейшн ашиглах боломжгүй, ухаалаг гар утасгүй бичил болон жижиг бизнес эрхлэгчдэд тохиромжтой.

Үүнээс гадна Zenka Finance нь харилцагчдадаа анхаарал халамж тавих, туршлага хуримтлуулах зэрэгт ихээхэн хөрөнгө оруулалт хийжээ. Энэ ажлын хүрээнд үйлчлүүлэгчийн лавлагааг тусгай мэргэжилтний багаар бүрдүүлсэн ба AI-ийн хүчирхэг CC системээр шуурхай удирддаг байна.

Үйлчлүүлэгчдийн санхүүгийн аюулгүй байдлыг хангахын тулд Zenka нь машин тооцооллын алгоритм, зээлийн мэдээллийн сангийн хэрэглээ, хуурамч гэмт хэрэгтэй тэмцэх аргачлал, эдийн засагт суурилсан онооны загвараар хэрэглэгчдийг тодорхойлох, зээлийн чадварыг үнэлэх нарийн төвөгтэй хэрэгсэл зэргийг боловсруулж, хэрэгжүүлсэн.

Дээрх бүхэн нь Zenka Finance-ийн динамик өсөлтөд нөлөөлсөн бөгөөд 7 сарын хугацаанд 700,000 гаруй үйлчлүүлэгчдийн мэдээллийн баазыг бий болгосон юм.

Эх сурвалж: www.fintechfutures.com

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ТЕХНОЛОГИЙН ДЭВШИЛ

Шинэ технологийн шийдлүүд даатгалын зах зээлд нэвтрэхийн хэрээр урьд өмнө нь байгаагүй их хэмжээний мэдээлэл, дата сан, шинэ системүүд, гарааны бизнесүүд, хэрэглэгчдийн хувийн өвөрмөц онцлогт нийцсэн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ шинээр бий болж байна. Дижитал технологийн дараагийн давлагаа болох “Юмсын интернет” буюу “Internet of Things (IoT)”, хиймэл оюун ухаанд суурилсан платформ зэрэг нь даатгалын байгууллагын мөн чанарыг өөрчилж байгаагаас гадна эдгээр дижитал трендүүд нь даатгалын компаниудыг уламжлалт хэв маягаасаа давсан, илүү өргөн цар хүрээг хамарсан бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгох болжээ.

Зөвхөн түүхэн өгөгдөл ашиглан үнийн тооцоолол, эрсдэлийн үнэлгээг хийдэг байсан бол дижитал технологи нь хэрэглэгч тус бүрээр, бодит цагийн горимоор эрсдэлийг шууд буюу автоматаар үнэлэх боломжийг олгохоос гадна хэрэглэгчдэд гарч болох эрсдэлээс зайлсхийхэд дэмжлэг үзүүлэх болсон. Гэвч даатгагчид эдгээр давуу талыг бий болгохын тулд ажиллах хүч болон байгууллагын соёлыг эрс өөрчлөх шаардлагатай тулгарч байгаа юм. Хэдий дижитал технологиуд нь олон давуу талыг зах зээлд бий болгож байгаа ч сөрөг үр дагаврыг мөн дагуулж байна. 2013 оны Оксфорд Мартины судалгаагаар даатгалын салбарын ажлын байрыг автомат системээр орлуулагдах нь хамгийн өндөр эрсдэлтэй болох нь харагджээ.

Түүнчлэн салбарт шинэ үүрэг нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, даатгагчдад авто төхөөрөмж үйлдвэрлэгчид, технологийн компаниуд зэрэг гуравдагч талтай хамтын ажиллагааг өргөжүүлэх боломжийг бий болгож буй экосистем нь үүний нэг жишээ бөгөөд энэ нь одоо байгаа ажил үүргийн хуваарилалтад өөрчлөлтүүд оруулах төлөвтэй байна. Хувьсан өөрчлөгдөж буй технологийн эрин үед технологийн чадвар, мэдлэг боловсрол эзэмшсэн ажиллах хүчин нь даатгагчдын хувьд чухал шаардлагатай хүчин зүйл болж байна. Иймд уламжлалт хэв маягаар ажиллаж дадлагажсан ажилтнууд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд зах зээлд гарч буй өөрчлөлттэй зэрэгцэн өөрсдийгөө хөгжүүлэх хэрэгцээ үүсэж байгаагаас гадна тус чиглэлд мэргэшсэн боловсон хүчнийг бэлдэх асуудал гарч ирж байгаа юм.

Дижитал технологи нь байгууллагын стратеги, зохион байгуулалтын бүтцээс эхлээд өдөр тутмын үйл ажиллагаа, ажлын байрны соёлд ч нөлөөллөө үзүүлж эхлээд байна. Олон улсын даатгалын зах зээлд гарсан технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ болон технологийн дэвшлийн жишээг дор дурдав.

1. Дотоод ажиллах хүчний урсгалыг автоматжуулах:

Автоматжуулалт нь өдөр тутмын ажилд зарцуулагдах зардлыг бууруулах боломжтой бөгөөд ажилчдыг өөрийн цагаа илүү үр бүтээлтэй ажил үүрэгт анхаарал хандуулах боломжийг олгоно. Зардал хэмнэсэн нэг жишээ бол “Fukoku Mutual life Insurance”-ийн даатгуулагчдад олгох нөхөн төлбөр тооцоолох автоматжуулалтын систем юм. Тус компани нь 34 ажилтныг хиймэл оюун ухааны системээр орлуулсан ба энэ нь бүтээмжийг 30 хувиар нэмэгдүүлж, эхний жилдээ 1.25 сая долларыг хэмнэн, өгөөжөө 2-оос бага жилийн хугацаанд өгнө хэмээн үзэж байгаа аж. Тухайлбал гадаад болон дотоод баримт, албан бичгийн урсгалыг автоматжуулах боломжтой юм. Санхүүгийн байгууллагууд өдөр тутмын үйл ажиллагаандаа мянга мянган файлыг цуглуулж, архивладаг. Энэ нь мэдээлэл хадгалах, боловсруулах, солилцох хамгийн сайн арга биш бөгөөд байгаль орчинд ч сөрөг нөлөөтэй. Хэрэв эдгээр файлууд нь цахим хэлбэрт шилжиж, үүлэн системд хадгалагдвал албан бичиг нь

автомат хэлбэрээр хянагдаж, алдаатай мэдээллийг үл зөвшөөрч, улмаар даатгалын ажилчид үнэн зөв мэдээлэлтэй ажиллах боломжийг бүрдүүлэх юм. Архивлагдаж, тоос буртагт дарагдах мэдээллийг илүү үнэ цэнэтэй болгох үүднээс, зураг болон текст таних алгоритмыг хөгжүүлэх нь өөр нэг гарцыг нээж өгч байна.

2. Нөхөн төлбөр тооцоолох ухаалаг машин:

AI insurance software нь даатгалын нөхөн төлбөр олгох үйл ажиллагааны явцад өөр нэгэн өөрчлөлтийг хийжээ. Тухайлбал газар нутагт ган гачиг тохиоход даатгалын хохирлыг үнэлэхтэй холбоотой шаардлагатай мэдээллийг цуглуулахад маш их цаг хугацаа, зардал шаардагдана. Харин AI-ийн хөгжүүлсэн тус төхөөрөмжийн алгоритм нь хиймэл дагуул, эсвэл дронд тусгасан зургийг ашиглан гантай газар нутгийн хэмжээ, учирсан хохирлыг тооцоолох боломжийг олгож байгаа юм. Улмаар энэ нь хүний хүчин зүйлсийг бууруулж, цаг болон зардлыг бууруулна. Түүнчлэн даатгалын нөхөн төлбөрийн нэхэмжлэл гаргах процесс нь мэдээлэл цуглуулагч ухаалаг төхөөрөмж болон гар утасны технологиудыг хослуулах замаар өөрчлөгдөн хөгжиж байна. Тухайлбал State Farm нь хэрэглэгчдэд зориулан Pocket Agent app-ийг нэвтрүүлээд байна. Үйлчлүүлэгч тээврийн хэрэгслийн зургийг илгээснээр нөхөн төлбөрийн нэхэмжлэх процесс нь цаасан баримт бичиг эсвэл нүсэр веб хувилбар ашиглаж, цаг гарздахгүйгээр хийгдэх юм.



3. Нэхэмжлэл болон гэрээний удирдлагын шинэчлэлт:

Нэхэмжлэлийн менежмент нь даатгалын компанийн бизнесийн чухал үйл явц бөгөөд энэ нь нэхэмжлэлийн бүртгэлээс эхэлж, даатгуулагчид төлөх нөхөн олголтоор дуусгавар болдог. Нэхэмжлэлийн менежментийн программ хангамж нь гар ажиллагаа болон хүн хоорондын харилцааны үйл явцыг багасгаж, улмаар нэхэмжлэх шийдвэрлэгдэх явцыг илүү хялбаршуулж, түүнд зарцуулагдах хугацааг богиносгох давуу талыг үүсгэдэг. Түүнчлэн даатгалын компаниудын зүгээс үзэхэд автоматжуулалтаар дамжуулан хөдөлмөрийн зардлыг бууруулах боломжийг бүрдүүлдэг байна. Гэрээний менежментийн программ хангамж нь холбогдох тохиргоо, өөрчлөлтүүдийг хийх, гэрээний нөхцөлийг удирдах зэрэг үйлдэл хийхэд шаардагдах хэрэгслээр хангах үүрэг бүхий нийт системийн дэд хэсэг юм. SAP, Oracle, Patra Corp, guideWire, Claim Kit, Insly зэрэг байгууллагуудын гаргасан программ хангамж нь даатгалын салбар дахь нэхэмжлэл болон гэрээний удирдлагын хэрэгслийн нийтлэг хэрэгцээг хангаж байгаа юм. Гэвч AI, Блокчейн, IoT зэрэг технологид суурилсан даатгалын технологийн гарааны бизнес эрхлэгчид болон технологийн зөвлөх компаниуд салбарт гарч буй голлох инновацыг бий болгож байна.

4. IoT болон олон нийтийн сүлжээн дэх мэдээлэл ба шинэ бүтээгдэхүүн:

Суурин болон хөдөлгөөнт төхөөрөмжүүдээр дамжуулан цусны даралт, халуун, судасны цохилт зэрэг хэрэглэгчдийн бие физиологийн нөхцөлийн талаарх мэдээлэл, мөн хэрэглэгчийн өдөр тутмын амьдралын хэв маягийн талаарх мэдээллийг цуглуулж, даатгуулагчийн өвөрмөц онцлог, шинж чанарыг агуулсан өргөн хэмжээний дата баазыг үүсгэх боломжтой юм. Тухайлбал өдрийн алхалтын тоо, шүд угаахад зарцуулах хугацаа гэх мэт. Түүнчлэн Фейсбүүк, Твиттер болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслийн өгөгдлүүд тус дата баазыг баяжуулах өөр нэгэн эх үүсвэр болж байна. Энэ нь мэдээлэл цуглуулагч төхөөрөмж эсвэл ямар нэгэн урьдчилан таамаглагч анализ хийгч аппликэйшн ашиглан хэрэглэгчийн эрсдэлийн хандлагыг тодорхойлох замаар хийгддэг бөгөөд бүх өгөгдөл, мэдээлэл нь бодит цагийн горимоор ашиглагдах боломжтой юм.

Beam бол үүнтэй холбоотой өөр нэгэн жишээ юм. Тус компани нь шүдний даатгалын бүтээгдэхүүн санал болгохдоо IoT технологийг ашиглажээ. Ухаалаг шүдний сойз нь хэрэглэгчдийн шүдээ хэрхэн арчилж байгаа өдөр тутмын бичлэгийг хийх ба даатгалын компани шүдний сойзонд тэмдэглэгдсэн дата ашиглан тухайн үйлчлүүлэгчдэд зориулсан даатгалын төлөвлөгөөг гаргах юм. Beam нь бусад өрсөлдөгч байгууллагуудтай харьцуулахад 25 хувиар доогуур үнийн түвшнийг санал болгож байгаа аж.

5. Телематик даатгал:

Телематик даатгал нь хар хайрцагтай ижил зарчмаар ажилладаг машины даатгалын шинэлэг бүтээгдэхүүн юм. Телематик хайрцгийг машинд суурилуулах ба тус төхөөрөмжид GPS систем, хөдөлгөөн мэдрэгч, сим карт болон шинжилгээ хийгч программ хангамжид суурилуулагдсан байдаг. Телематик хайрцаг нь хурд, байршил, цаг, авто машины осол, жолоодлого хоорондын зай, эвдрэл болон бусад жолоодлоготой холбоотой мэдээллийн бичлэгийг хийдэг. Уг систем нь цугласан мэдээллийг боловсруулж, гар утасны интернетээр дамжуулан даатгалын компани руу цаашдын шинжилгээнд зориулан мэдээллийг илгээнэ. Түүний дараагаар жолоодлогын шинжилгээний тайлан нь хэрэглэгчийн хувийн мэдээллийн данс руу нэмэгдэнэ. Жолоочийн жолооны зан үйлдлийн талаар бичлэг хийгдсэнээр даатгалын компаниуд хэрэглэгчдэд тусгайлан зориулсан даатгалын төлөвлөгөөг гаргаж, эрсдэлийн удирдлагаа сайжруулж чадах юм. Тухайлбал компани хариуцлагагүй жолооч нарын хураамжийг нэмэгдүүлж, аюулгүй жолооддог харилцагч нарыг урамшуулж, мөн авто тээврийн хэрэгслийн ослын талаар цагдаагийн байгууллагад мэдээлэх боломжийг бүрдүүлнэ.

6. P2P даатгал:

Пийр тү пийр (P2P) даатгал нь боломжит технологи дээрээ суурилан хөгжих боломжтой гэдгээрээ хурдацтай нэрд гарч буй хамгийн амжилттай бизнесүүдийн нэг юм. Ижил төстэй эрсдэлээ даатгах зорилготой хэрэглэгчид өөрсдийн хураамжийн орлогоор сан бүрдүүлэх замаар зөвшилцөлд хүрэх бөгөөд тус загвар нь уламжлалт даатгалын дундын зуучлал шаардлагагүй гэдгээрээ онцлог юм. Даатгалын тохиолдол гарах бүр боломжит шаардлагатай мөнгөн хөрөнгийн дахин санхүүжилт хийгддэг. Ингэснээр хэрэглэгчид зардлаа хамгийн бага байлгаж, нэхэмжлэхтэй холбогдох зөрчлөө бууруулдаг.

7. Блокчейн ба давхар даатгал:

PWC-ийн 2016 онд хийгдсэн “Давхар даатгагчдад зориулсан блокчейн” хэмээх судалгаанд блокчейн

технологийн даатгалын салбар дахь хэрэглээ нь дэлхий даяар давхар даатгалын компаниудад 5–10 тэрбум ам.долларын хэмнэлтийг бий болгохоор хүлээгдэж байгаа тухай дурджээ. Давхар даатгалын мөн чанар нь сүлжээний бүтэцтэй ойролцоо бөгөөд төлбөр тооцооны дараа орох финтек дэх хоёр дахь том мөнгөн гүйлгээний бүртгэлийн сүлжээ / distributed ledger/ юм. Тус технологи нь баталгаажуулах хугацааг богиносгох, алдааг арилгах, нэр хүнд алдах эрсдэлийг бууруулах зэрэг томоохон давуу талуудыг бий болгодог. Блокчейн технологийг ашигласнаар давхар даатгагч компаниуд үйлчлүүлэгчийн талаарх мэдээллийг хүлээн авахын тулд даатгалын компанитай харьцах шаардлагагүй болох юм. Тухайлбал, эрүүл мэндийн эрсдэлийн давхар даатгалын гэрээг хийхэд хэд хэдэн даатгалын тохиолдлыг шалгах шаардлага гардаг. Хэрэв талууд ухаалаг гэрээгээр холбогдвол давхар даатгалын компани нь даатгуулагчийн эрүүл мэндийн мэдээлэл рүү шууд хандах боломжтой болох юм. Түүнчлэн тус технологи нь давхар даатгагчдад үүсэж болох хохирлоос урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлдэг. Бичиг баримт боловсруулах нарийн төвөгтэй байдлын улмаас нэхэмжлэл шийдвэрлэх үе шатуудад алдагдал үүсэх боломжтой байдаг бол Блокчейн технологи нь гэрээ тус бүрээр богино хугацаанд, гар ажиллагаагүйгээр хохирлын үнэлгээний түүхийг хөтлөх замаар тус эрсдэлийг шийдвэрлэдэг. Улмаар энэ нь илүү хариуцлага тогтоох, зөрчлийг шийдвэрлэх боломжийг олгодог.

8. Чатбот:

Жил бүр даатгалын компаниуд эрэлт талын мэдээлэл цуглуулах, түүний тайлагналын стандартыг бий болгох, улмаар хэрэглэгчдийн шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлэх зэрэгт маш их цаг хугацааг зарцуулдаг. Чатбот, гар утасны технологиуд болон дуу хоолой таних алгоритм нь эдгээр төвөгтэй үйл ажиллагааг автомат болгон, хялбарчилж өгдөг. Эдгээрээс чатбот нь томоохон хэрэглэгчийн үйлчилгээний төвтэй ижил хэмжээнд үр ашигтай ажиллаж, харилцагчдыг дэмжих болон борлуулалттай холбоотой зардлыг эрс бууруулж байна.

Америк дахь зарим нэг даатгалын компаниуд эдгээр технологийг ашиглаж эхлээд байна. Канадын Онтариод байрлах Excalibur Insurance хэмээх байгууллага үйлчлүүлэгчидтэй харьцах автомат AI роботыг ашиглалтад оруулжээ. Тус робот нь 7 хоногт 24 цаг веб хуудас болон Фейсбүүкээр дамжуулан идэвхтэй байгаад зогсохгүй систем өөрөө шинэ харилцагчдыг татаж, нэхэмжлэл болон үйлчилгээний хүсэлтийг шийдвэрлэдэг. Үйлчлүүлэгчтэй харилцах төвийн дуудлагын 70 хувь нь л хариулт авч чаддаг байсан бол тус систем энэхүү асуудлыг шийдвэрлэх нэгэн гарц болж чаджээ. Түүнчлэн ухаалаг систем нь шинэчлэгдсэн мэдээлэл илгээх, агентуудад үүрэг даалгавар өгөх, үйлчлүүлэгчдээ хадгалж үлдэх үүднээс нөхөрсөг мэндчилгээ болон тусгай санал илгээх замаар тэдэнтэй халуун дулаан харилцаа үүсгэх зэрэг үйлдлүүдийг хийдэг байна.

9. Даатгалын API:

Хэт өндөр, хатуу зохицуулалт, уламжлалт маягийн бизнес загвар, технологийн хүчин чадал дутмаг байдал нь салбарын инновацийн хөгжлийг удаашруулдаг. Гэтэл бодит байдал дээр хэрэглэгчид уян хатан, инновацлаг зүйлийг хүсэж байдаг. IBM-ийн судалгаанд даатгуулагчдын 41 хувь нь даатгалын компаниуд хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад гарч буй өөрчлөлтийг хангах үйлчилгээ үзүүлдэггүй учир өөр байгууллагыг сонгоход хүргэдэг тухай дурдсан байна.

Даатгалын API (application programming interfaces) нь даатгагчдад гуравдагч этгээдтэй мэдээлэл хуваалцах, үйлчилгээ үзүүлэх боломжоор хангаж өгснөөр дээрх асуудлыг шийдвэрлэсэн байна. Тус технологи нь компаниуд хэрэглэгчдэдээ илүү сайн, цоо шинэ дижитал бүтээгдэхүүн үйлчилгээ санал

болгох, цаашлаад борлуулалтаа нэмэгдүүлж, бизнесийн загвараа хөгжүүлэх боломжийг олгож байгаа юм. Жишээлбэл, нэгэн даатгалын компани API-ийг ашигласнаар цахим аяллын агентлагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэн аяллын даатгалын цахим зах зээлд нэвтрэх боломжтой болжээ. Тус компани booking.com, Travelcity зэрэг онлайн аяллын агентлагуудын веб хуудсаар дамжуулан аялагчдад даатгалын бүтээгдэхүүнийг шууд худалдах болсон нь тухайн байгууллагын борлуулалтыг огцом өсгөсөн байна.

10. Даатгалын залиланг илрүүлэх программ хангамж:

Даатгалын салбарын хувьд залилан нь томоохон асуудлуудын нэг билээ. Америкийн “Даатгалын Залилангийн Эсрэг Эвсэл”-ээс мэдээлснээр АНУ-д жилд хамгийн багадаа л залилангаас үүдэлтэй 80 тэрбум долларын алдагдал хүлээдэг бөгөөд энэ нь Хойд Америкийн даатгалын компаниудын хувьд нийт нөхөн төлбөрийн зардлын 5–10 хувийг эзэлж байгаа юм. Үүлэн болон үүрэн телефонд суурилсан технологиуд нь даатгалын агентлагуудад давхардсан нэхэмжлэл, хэт өндөр үнэлгээ, хуурамч онош, хуурамч гэр бүл болон хамааралтай этгээд үүсгэх зэрэг эрсдэлээс сэргийлэх хүрээнд бодит цагийн мэдээллээр хангах, мөн даатгалын тоон өгөгдлийн тасралтгүй байдлыг хангах, ажилчдаас үүдэлтэй алдааг бууруулах зэрэгт дэмжлэг үзүүлдэг байна. Тухайлбал, үйлчлүүлэгч өөр өөр огноотой боловч ижил даатгалын тохиолдол дээр хуурамч бичиг баримт бүрдүүлэн нөхөн төлбөр нэхэмжилсэн тохиолдолд систем нэхэмжлэлийн өгөгдлийг дата бааз дахь өгөгдөлтэй харьцуулан, залилангийн хэргийг илрүүлэх юм. Энэ нь үйл ажиллагааны хурдыг нэмэгдүүлэх, илүү нарийвчлалтай боловсруулалт хийх, мөн талуудын ашиг сонирхлын зөрчлийг арилгах замаар даатгалын үйл ажиллагаатай холбогдох зардлыг бууруулах давуу талтай.

11. Даатгалын цахим зах зээлийн орчин:

Даатгалын гэрээ байгуулахын тулд даатгалын агентлаг руу биеэр очих, утсаар ярьдаг өдрүүд ард хоцорчээ. Веб хуудас нь хэрэглэгчдэд зах зээл болон бүтээгдэхүүн, үйлчилгээний талаарх мэдээлэл авах боломжийг олгохоос гадна, даатгалын компаниуд тухайн хувь хүний шаардлага хэрэгцээнд тохирсон тусгай төлөвлөгөөг санал болгох болжээ. Insurfy, CoverHood, Friendsurance зэрэг даатгалын бүтээгдэхүүний худалдааны платформууд нь даатгалын бүтээгдэхүүний түгээлтийн сувгийн загварыг шинээр тодорхойлох болов. Үйлчлүүлэгчид өөрсдийн хүссэн бүтээгдэхүүний талаарх нарийн мэдээлэл авахын зэрэгцээ, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хувьд ч мөн хэрэглэгчийн эрэлтэд нийцэх бүтээгдэхүүн санал болгож чадвал олон нийтэд илүү танигдах боломжтой болж байна. Даатгалын салбарт шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэгч, хөгжүүлэгч, шинийг эрэлхийлэгч оролцогчид нэн шаардлагатай байгаагаас гадна хурдацтай хөгжиж буй технологийн дэвшлүүдтэй зэрэгцэн даатгалын салбарын хувьд ч өнөөгийн уламжлалт бизнесийн загвараас шинэ инновацлаг загварт шилжих шаардлагатай байна.

Телематик даатгал нь хэрэглэгчдийн зан байдлыг тодорхойлох, түүнд тохирох эрсдэлийн хамгаалалтыг бий болгох, цаашлаад бизнесийн шинэ загварт хүрэх замыг илүү нээлттэй болгож байгаа бол AI даатгалын шийдэл нь хэрэглэгчийн хувийн онцлогт тохирсон бүтээгдэхүүнийг санал болгох, робот зөвлөхийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мөн залилан, хууран мэхлэлтийг илрүүлэх үйл ажиллагааг сайжруулах боломжоор хангаж байна. Түүнчлэн даатгал гэлтгүй бүх салбарт тренд болоод байгаа блокчейн технологи нь байгууллагын үйл ажиллагааны засаглалыг сайжруулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх эерэг нөлөөлөлтэй байгаа бол даатгалын API нь мэдээлэл солилцох үйл явцыг илүү хялбаршуулж, бүтээгдэхүүн хүргэлтийн сувгийг цахим сувгаар дамжуулан илүү өргөн хүрээг


хамруулах, улмаар даатгуулагчид илүү уян хатан бүтээгдэхүүнийг санал болгох боломжоор хангаж байна.

Салбарт гарсан технологи, инновацын дэвшлийн нөлөөллийг өргөн хүрээнд авч үзвэл шинэ инновацын дэвшлүүд салбарт нэвтэрснээр зарим зардал өндөртэй үйл ажиллагааг автоматжуулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хүргэлтийн сувгийг хөнгөвчлөх, мөн удирдлагын программ хангамжуудаар дамжуулан илүү үр ашигтай үйл ажиллагааг хэрэгжүүлснээр үйл ажиллагааны зардлыг хэмнэн, цаашлаад технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ нэмэгдэж, салбарт төрөлжилт үүссэнээр ашигт ажиллагаанд эерэг нөлөөллийг бий болгож байна. Түүнчлэн хэрэглэгчийг таньж мэдэх, хуурамч даатгалын тохиолдол үүсгэн залилан, хууран мэхлэлт хийх үйл ажиллагаатай холбоотой алдагдлыг эрс бууруулж байгаа нь салбарын ашигт ажиллагаанд тодорхой нөлөөллийг үзүүлж байгаа юм.

Даатгалын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн талаарх маш олон тооны хүчин зүйлсийн тоон өгөгдөл болон статистик дээр суурилан хийгддэг бизнес юм. Гэвч салбарын хувьд бодит цагийн өгөгдөл бус түүхэн өгөгдөл дээр суурилсан шинжилгээ хийгдсээр байна. Харин дижитал технологи нь асар том хэмжээний бодит цагийн өгөгдлийн урсгалыг бий болгож, үйлчлүүлэгч тус бүрийн хувийн мэдээллийн сан бүрдүүлэх боломжийг бий болгож байна. Улмаар хэрэглэгчийн талаарх хувийн, нарийвчилсан мэдээлэл дээр суурилан тухайн хэрэглэгчийн эрсдэлийн аппетитад нийцсэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, үнэ өртгийг санал болгож байгаа нь илүү хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн хөгжүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Иншүртек (Insurtech) бол финтекийн нэг төрөл бөгөөд шинэ технологиудыг даатгалын салбарт ашигладаг. Уламжлалт даатгалын компаниуд өдрөөс өдөрт нэмэгдэж буй даатгалын технологийн стартапуудын өрсөлдөөнтэй нүүр тулж байна. Олон шинжээчид тус салбарыг шинэ технологийн хэрэгцээ хамгийн ихтэй байгаа гэж үзэж байна. "Иншүртек" гэдэг нь шинэ технологиудыг даатгалын салбарт нэвтрүүлэх шинэлэг санаачилгыг бий болгох, даатгалын зах зээлийн зохицуулалтын үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой нэр томъёо юм. Шинэ технологийг нэвтрүүлэх нь санхүүгийн салбарын өөрчлөлтийн гол хөдөлгөгч хүч бөгөөд энэ нь хэрэгжүүлж эхлэхэд эргэлзээтэй байх хэдий ч хэмжигдэхүйц үр ашгийг бий болгодог.

Зураг 5. 10. Иншүртек хөрөнгө оруулалтын хандлага (2012–2018)



Эх сурвалж: CB Insights (2019a) Даатгалын Техникийн Шинжилгээ

Дэлхий хэмжээнд Иншүртекийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт 2012 онд 348 сая ам.доллар байсан бол 2018 онд 4.15 тэрбум ам.долларт хүрч огцом өсөлтийг үзүүлээд байна. 2015 онд "Alibaba

Group Holding” групп нь өөрийн нийт хөрөнгө оруулалтын 1/3–ийг буюу 931 сая ам.долларыг 2013 онд байгуулагдсан “Zhong An” гэх зөвхөн интернет даатгалын үйлчилгээ үзүүлдэг компанид хөрөнгө оруулсан. Иншүртекд оруулах санхүүжилт, хөрөнгө оруулалт зэргээс харахад энэхүү салбарын ирээдүй маш хурдан хөгжих нь гарцаагүй байгаа юм. Мөн санхүүгийн салбарын технологиуд нь энэ мэтчилэн түргэн хөгжиж буй нь нөгөөтээгүүр хяналт шалгалт, зохицуулалтууд мөн шаардагдаж байна.

Иншүртек–ийн бодлого зохицуулалтын үүрэг:

Инновац нь ерөнхийдөө эерэг хөгжлийг бий болгодог ч бизнесийн хөгжилд зарим тодорхой бус байдал болон хязгаарыг тогтоодог хэд хэдэн бодлого, зохицуулалт байдаг. Өрсөлдөөний бодлогын үүднээс авч үзвэл шинэ санаа болон шинэ технологийг нэвтрүүлэх замаар зах зээлд шинээр орж ирэгсэд нь хэрэглэгчдэд ашиг тустай байдлыг нэмэгдүүлж чаддаг. Өрсөлдөөний тухай хууль болон бодлогын үндэс нь хэрэглэгчдийн сэтгэл хангамжийг дээшлүүлээд зогсохгүй, үйлдвэрлэл болон нийлүүлэлтийн үр ашгийг дээшлүүлснээр үнийг бууруулж, өргөн сонголтыг бий болгоход оршино. Инновац, шинэ технологийг нэвтрүүлэх замаар бизнесийн гараагаа эхэлж, зах зээлд шинээр орж ирэх нь даатгалын зах зээлийн өрсөлдөөнд хэд хэдэн эерэг өөрчлөлтийг авчирч болох юм.

Гарааны бизнес эрхлэгчид даатгалын зах зээлд даатгагч болон даатгалын төлөөлөгч, зуучлагчаар үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авахын тулд зайлшгүй байх хэмжээний хөрөнгөтэй байх ба зохих ёсны шаардлагуудыг хангасан байх ёстой. Иймд даатгалын иншүртек–гарааны бизнес эрхлэгчдийн ихэнх нь зуучлагчийн тусгай зөвшөөрөл авдаг. Эдгээр шаардлагууд нь бодлого боловсруулагчдын хамгаалалтыг баталгаажуулахад маш чухал боловч зах зээлд шинээр орж ирэгсдийн хувьд нэлээд саад тотгор болж байдаг. Санхүүгийн салбарын хувьд санхүүгийн зохицуулалт ба өрсөлдөөний хоорондын зохистой тэнцвэрийг хангах тал дээр байнгын дарамт байдаг бөгөөд энэ нь ихэнхдээ шинэлэг технологитой холбоотой юм.

Үүнийг шийдвэрлэхийн тулд зарим санхүүгийн зохицуулагчид Финтекийн гарааны бизнес эрхлэгчдэд өөрсдийн технологийг турших боломжийг олгох бодлогыг боловсруулж, зохицуулалтын зарим шаардлагыг зөөлрүүлсэн байна. Их Британийн Санхүүгийн Зохицуулах Хорооны (FCA) Инновацын төв нь "зохицуулалтын хамгаалагдсан хязгаарлагдмал орчин" арга барилыг анх хэрэгжүүлж байгаа юм. Сингапурын Мөнгөний Бодлого Зохицуулалтын Газар (MAS) нь "зохицуулалтын хамгаалагдсан хязгаарлагдмал орчин" аргыг мөн хэрэгжүүлсэн. Австралийн Үнэт цаас ба Хөрөнгө оруулалтын Комисс (ASIC) нь финтек шинийг санаачлагчидтай хамтарч, гарааны бизнес эрхлэгчдэд зах зээлд нэвтрэх зохицуулалтын шаардлагад нийцүүлэн эрсдэлийг бууруулах Инновацын төвийг байгуулсан. Хонконгийн Мөнгөний Зохицуулалтын Газар болон Канадын Онтарио Корпорацийн Үнэт Цаасны Комисс нь мөн ижил төстэй бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн байна. Эдгээр бодлогууд нь зах зээлд дэх шинэ өрсөлдөөн, инновацыг илүү их дэмжиж, зах зээлд шинээр орж ирж буй гарааны бизнес эрхлэгчдэд туслах зорилготой бөгөөд энэ нь хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилготой хэрэгжүүлж буй бодлого юм.

Шигтгээ 2. Сингапурын мөнгөний бодлого

Сингапурын мөнгөний зохицуулалтын газар (СМЗГ) нь Сингапурын санхүүгийн салбарт финтекийн сэндрокс аргачлалыг баталсан. СМЗГ–ын авч хэрэгжүүлж буй энэ арга нь шинэ технологиуд нь үр ашгийг дээшлүүлж чадах ба эрсдэлийн менежментийг сайжруулах, шинэ боломжуудыг бий болгох, хүмүүсийн аж амьдралыг дээшлүүлэхэд оршино гэдгийг хүлээн зөвшөөрөх явдал юм.

Сэндрокс нь санхүүгийн байгууллагууд болон финтекийн хэрэглэгчид финтекийн шийдлүүдийг турших аюулгүй, тохиромжтой орон зайг олж авах зорилготой боловч мөн алдаатай үр дагаврыг агуулсан байдаг. Гэсэн хэдий ч, санхүүгийн байгууллагууд нь СМЗГ–ын удирдамжгүйгээр шинэ шийдлүүдийг хэрэгжүүлэх боломжтой бөгөөд ингэснээр хууль эрх зүйн шаардлагыг зөрчихгүй юм. СМЗГ нь 2016 оны 6, 7–р сард олон нийтийн хэлэлцүүлэг явуулж, 2016 оны 11 дүгээр сард финтекийн сэндрокс орчны арга зүйг эцэслэн боловсруулсан байна.

Сэндрокс арга нь СМЗГ–ын тогтоосон хууль эрхзүйн болон зохицуулалтын шаардлагыг зөөлрүүлэхэд финтек шийдлүүдийн хувьд СМЗГ–ын дэмжлэгийг дараах тохиолдлуудад авах боломжгүй юм:

- Сингапурт аль хэдийн санал болгосон технологитой адил бол дэмжлэг авах боломжгүй. Гэхдээ өргөдөл гаргагч нь өөр технологи ашиглаж байгаа эсвэл ижил технологийг өөрөөр ашиглаж байгаа гэдгээ баталж чадвал дэмжлэг авч болно.
- Өргөдөл гаргагч нь санал болгож буй санхүүгийн үйлчилгээг лабораторийн орчинд туршсан, мөн санал болгож буй санхүүгийн үйлчилгээг хэрэглэх хууль эрх зүйн шаардлагыг хангаж байгааг харуулаагүй бол дэмжлэг авахгүй.

Мөн түүнчлэн сэндрокс орчноос гарсны дараа финтек шийдлийг Сингапурт хэрэглэх зорилготой байх ёстой.

СМЗГ нь хамгаалалтад өргөдөл гаргагчид цаашид хэрэгжүүлж байх ёстой шаардлагуудыг тодорхойлсноос гадна зөөлрүүлсэн шаардлагуудыг ч мөн адил тавьдаг. Харин тавигдаж буй хатуу шаардлагуудад хэрэглэгчийн мэдээллийн нууцлал, үнэнч шударга байдал, зуучлагчаар дамжиж байгаа харилцагчдын мөнгө, эд хөрөнгөтэй харьцаж байгаа байдал, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс хэрхэн сэргийлж байгаа зэрэг шаардлагууд орно.

Эх сурвалж: СМЗГ, FinTech Зохицуулалтын Хамгаалалтын удирдамж

ТАВ. САНХҮҮГИЙН ШИНЭ ТЕХНОЛОГИЙГ АЮУЛГҮЙ НЭВТРҮҮЛЭХ БОЛОМЖ

Блокчейн тэргүүтэй тархалттай бүртгэлийн технологиуд нь бидний амьдран буй нийгмийг хурдацтайгаар өөрчилж байгаа билээ. Эдгээр технологиуд дээр суурилсан шинэ аппликэйшнуудын хэрэглээ болон хамрах цар хүрээ нь байнга өргөжин тэлж шинэ салбаруудад эргэлт буцалтгүйгээр нэвтэрсээр байна. Энэхүү хурдацтайгаар өсөж, бизнесийн цоо шинэ боломжуудыг бий болгож буй дэвшилтэт технологийн секторыг зөвөөр бойжуулан үр ашгийг нь хүртэхийн тулд түүнд тохирсон таатай орчныг бий болгох нь зайлшгүй хэрэг юм. Хэрэв улс орон зохистой бөгөөд “ухаалаг” бодлогыг бий болгон хэрэгжүүлж чадвал энэхүү шинэ технологи дээр бий болж буй хүчирхэг эдийн засаг, бизнесийг төвлөрүүлэн татсан төв цэг болон хөгжих боломж нээлттэй хэвээр байна.

Энэхүү шинэ технологийг харин хэр хэмжээнд төрийн зүгээс зохицуулан оролцох хэрэгтэй вэ? ICO буюу Initial Coin Offering санхүүгийн шинэ хэрэгсэл болон гарч ирснээс хойш чухам яаж зохицуулах, ямар хууль дүрэмд захирагдах нь тодорхойгүй байв. Учир нь ICO нэг бол зөвхөн төлбөр тооцооны хэрэглээний токен эсвэл хөрөнгийн зах зээлийн бүтээгдэхүүн (security буюу хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас)–тай дүйх шинж чанарыг агуулсан байдаг. Хэрэв тухайн токен буюу шинэ крипто мөнгө нь security–н шинжийг агуулсан байвал одоо байгаа санхүүгийн түүнд хамаарах хуулиар зохицуулагдах нь зайлшгүй хэрэг бөгөөд энэ нь тухайн токент хөрөнгө оруулагчдыг гарч болох залилангаас болон бусад санхүүгийн аюулаас хамгаалж буй хэрэг юм. Гэвч нөгөө талаараа тухайн технологийн үндсэн мөн чанарыг алдагдуулан хэт зохицуулалт хийгдсэнээс шинэ боломжуудыг үгүй хийх талтай. Хэдийгээр уг шинэ дижитал технологийн салбарын өгч болох өгөөж нь өндөр ч, нөгөө талаар өндөр эрсдэл дагуулж буй тул хурдан бөгөөд бас аюулгүйгээр нэвтрүүлэх тэр алтан тэнцвэрийг хэрхэн яаж олох нь чухал юм.

Дэлхийн хамгийн криптод ээлтэй орон болохоо зарлан түүнийгээ ажил хэрэг болгож буй орон бол Малта юм. Тэд гурван хууль санаачлан гаргасан бөгөөд ICO–д хянан зохицуулах агентлаг байгуулан үүнтэй хамааралтай хууль бий болгосон хамгийн анхны орон болсон. Мөн крипто ертөнцийн томчууд болох Binance, OKEx болон BitBay тэргүүтэй бизнесүүд салбараа нээн үйл ажиллагаагаа эрчимтэйгээр явуулж эхлээд буй. Малтагийн батлан гаргасан гурван хууль нь Virtual Financial Assessts Act (“VFA”) буюу Цахим санхүүгийн хөрөнгийн тухай акт, The Malta Digital Innovation Authority Act (“MDIA”) буюу Малтагийн дижитал инновацын газрын тухай акт, мөн The Innovative Technology Arrangements and Services Act (“TAS”) Дэвшилтэт технологи болон түүн дээр суурилсан үйлчилгээний тухай акт) зэрэг болно. Эдгээр хууль актууд нь ICO, хөрөнгийн менежмент, crypto exchange болон түрийвч нь мөн түүнчлэн хөрөнгө оруулагчдыг хамгаалах талаар дэлгэрэнгүй заасан болно.

Бусад ICO–д таатай ханддаг бөгөөд хөхүүлэн дэмждэг орнууд гэвэл мэдээж хэрэг Сингапур болон Швейцар улсууд юм. Тэд аль хэдийн маш өндөр төвшинд хөгжсөн хөрөнгө санхүүгийн зах зээлтэйн дээр тэдгээрийг зохицуулах жишиг хууль, заалттай байдаг. Тэд блокчейн болон бусад шинэ технологийг шинээр нэвтрүүлэхдээ “Fintech Regulatory Sandbox”–г ашигладаг бөгөөд энэхүү бодлогын хэрэглэгдэхүүн нь “Эдийн засагт өндөр үр нөлөө бүхий санхүүгийн дэвшилтэт технологиудыг туршин хөгжүүлэх таатай орчныг төрөөс бүрдүүлэн өгч бизнесийн эрсдэлийг нь багасгах мөн тухайн шинэ технологид тохирсон бодлогын загварыг шинээр бий болгох” гэсэн үндсэн зорилготой байна. Мөн Швейцар Улс нь Crypto Valley буюу Крипто Хөндийг үүсгэн байгуулж “Ухаалаг бодлого” мөн санхүүгийн таатай орчныг бий болгон Европын болоод дэлхийн крипто инновацын төв болохоор ажиллаж байгаа билээ.

Эдгээр жишээнээс харахад ICO–д хамааралтай одоогоор хэрэгжиж буй болон шинээр бий болох хууль, тэдгээрийн зохицуулалтыг анхнаас нь оновчтойгоор зөв чиглэлд нь залах төрийн агентлаг байх нь зайлшгүй хэрэгцээтэй болж байна. Мэдээж төрийн зүгээс мөнгө угаалтын эсрэг мөн терроризмын санхүүжилтийн эсрэг олон улсын хууль, тогтоомжуудад нийцүүлэн хамгийн аюулгүй бөгөөд ард иргэддээ массыг хамарсан крипто нэр барьсан залилангуудаас сэргийлэх нь зүй ёсны хэрэг юм. ICO болон блокчейнийг зохицуулах тодорхой, оновчтой хуульгүйгээс олон дэвшилтэт санаанууд ажил хэрэг болж чадалгүй үлдсэн байдгийн нэг жишээ нь Black Cell Technology Limited (Black Cell) бөгөөд Хонконгийн security–н хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулах боломжгүй гэсэн шалтгаанаар хаалга барьсан билээ. АНУ ч бас Jumpstart Our Business Startup Act–г санаачлан шинэ дэвшилтэт санаа болон бизнесүүдийн хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулахад нь төрийн зүгээс дэмжлэг үзүүлэн зарим тохиолдолд хуулиас чөлөөлөгдөх практик бий.

10 сая доллароос дээш хөрөнгө босгосон, тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж буй бөгөөд ямарваа нэгэн хууль зөрчөөгүй гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэсэн бөгөөд аль оронд үйл ажиллагаа явуулж байгааг нь жагсаавал:

1. Сингапур: 11
2. Швейцар: 10
3. Кайманы арлууд: 7
4. АНУ: 6
5. Их Британи: 3

Сингапур болон Швейцарь улсууд нь чанартай ICO–н тоогоороо тэргүүлж байгаа бөгөөд зөв ухаалаг бодлоготой нь салшгүй холбоотой. Зөв ICO–г сонгон жишиг болгон “Sandbox”–т шалгаруулан оруулснаар эдийн засаг болоод эрх зүйн өндөр хариуцлагатай бодлого явуулж чаддаг бөгөөд блокчейн болон бусад дэвшилтэт технологийг чухлаар авч үзэн ач холбогдлыг нь үнэлж буй хэрэг юм.

ЗУРГАА. ФИНТЕК БА ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ

Финтек нь гүйлгээний зардлыг бууруулж, капиталын үр ашигтай байдлыг нэмэгдүүлдэг.

Шинэ технологийн тусламжтайгаар гүйлгээний зардал болон хугацааг багасгаж, хөрөнгийн зарцуулалтыг хянах боломжтой болсноор үйл ажиллагааны үр ашигтай байдал ерөнхийдөө нэмэгддэг. Газар тариаланд big data буюу том датаг ашиглан температур, чийг, хур тунадас зэрэг ургацын ургах орчныг хянах боломжтой болно. Цаашлаад энэ нь зээл, даатгал зэрэг санхүүгийн салбарт ашиглагдах боломжтой болдог.

Жишээ. Big data ашиглалт

Хөдөө аж ахуйн хувьд үр ашиггүй нийлүүлэлтийн гинжин хэлхээ, зах зээлийн хүртээмжид тулгарах саад, бэрхшээлүүдээс болоод олон тооны жижиг үйлдвэрлэл эрхлэгч, фермерүүд эдийн засгийн болон нийгмийн хожоогоо алдаж байдаг. Вьетнам Улсад VanQu корпорац блокчейнийг ХАА–д нэвтрүүлснээр фермерүүд гар утсаа ашиглан өөрсдийн болон газрынхаа мэдээллийг агуулсан хувийн хэргийг үүсгэснээр VanQu сүлжээнд нэвтрэн үйл ажиллагаагаа хялбараар явуулах боломжтой болж байна. Ингэснээр фермерүүдийн хувьд газар болон бүтээгдэхүүнийхээ үнэлгээг бодитоор үнэлүүлж, даатгалд хамрагдаж, ургацын хэмжээг таамаглах боломжтой болж байгаа юм.

Блокчейний нөлөө

Финтек компаниуд блокчейнийг ашиглан байгалийн нөөц баялгийг дижитал хэлбэрт оруулж байна. Ил тод байдлыг нэмэгдүүлдэг учир блокчейнийг ашигласнаар бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгож тэгш бус мэдээллийн эрсдэлийг бууруулж байна.

Жишээ 1. Нийлүүлэлтийн гинжин хэлхээний ил тод байдал:

Нийлүүлэлтийн гинжин хэлхээний ил тод байдал нь тогтвортой хөгжилд нөлөө үзүүлдэг финтекийн хамгийн түгээмэл жишээ байдаг. Блокчейнийг ашиглан хөрөнгийн урсгалыг ил тод болгосноор энэ нь цаашлаад ой мод, загас ан агнуураас эхлээд нүүрсхүчлийн хий болон эрчим хүч ашиглалт зэрэг байгалийн нөөц баялгийн хэрэглээ, ашиглалтыг хянах боломжтой болгодог. Индонезид нийлүүлэлтийн тогтвортой гинжин хэлхээг үүсгэх зорилготой блокчейний төслийг хэрэгжүүлж эхлээд байгаа нь орон нутгийн загасчдын барьсан үсэрдэг загас болон шар судалт тунаны гарал үүслийг тодорхой болгож, комплаенсийг нэвтрүүлэн одоогийн гарал үүслийн бичигт тогтолцоог халах боломжтой болгож байгаа юм. Үүнээс гадна энэхүү төсөл амжилттай хэрэгжвэл загас их хэмжээгээр барих (overfishing), залилан, хууль бус загасчлал буурна гэж үзээд байна.

Жишээ 2. Нүүрсхүчлийн хийн ялгарлын зөвшөөрөл:

Зарим улс орнууд компаниудын ялгаруулдаг нүүрсхүчлийн хий болон бусад хүлэмжийн хийг багасгах үүднээс carbon credit буюу нүүрсхүчлийн хийн ялгарлын зөвшөөрлийг олгодог байна. Энэхүү хөтөлбөр нь илүү хэмжээний зөвшөөрлөө наймаалцах буюу худалдах боломжийг олгодог буюу cap-and-trade нэрээр алдаршсан. Компаниуд нүүрсхүчлийн ялгарлын дээд хязгаарт тохируулан үйлдвэрлэлээ явуулж, тэрнээс давж ялгарах тохиолдолд зөвшөөрлийг засгийн газраас эсвэл бусад компаниудаас худалдаж авдаг. Гэхдээ нүүрсхүчлийн хийн ялгарлыг тооцох болон зөвшөөрлийг солилцох нь цаг их шаардсан, өртөг өндөртэй үйл ажиллагаа учраас энэхүү тогтолцоог илүү боловсронгуй болгох үүднээс блокчейнийг нэвтрүүлж эхэлсэн. Блокчейний тусламжтайгаар компанийн ялгаруулж байгаа хэмжээг тодорхойлоод зогсохгүй цаашлаад зөвшөөрлийн илүү эсвэл дутууг биржийн бус аргаар наймаалцах боломжтой болж байна.

Финтек нь ногоон санхүүжилтийг өргөн хүрээтэй болгодог.

Том датаны тусламжтайгаар зөвхөн тухайн хүнд зориулсан маркетинг явуулж чаддагаараа финтек компаниуд бага зардлаар илүү олон хэрэглэгчийг ногоон санхүүжилтэд нэгтгэж чаддаг.

Жишээ 1. P2P буюу пийр тү пийр эрчим хүчний “гүйлгээ”:

Prosumers (Producer + consumer) буюу хэрэглэгч–үйлдвэрлэгчид нь өөрсдөө эрчим хүчийг ашиглаад зогсохгүй нар, салхины буюу сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг ашиглан үүсгэсэн эрчим хүчийг блокчейн технологийг ашиглан “хөрш”–дөө худалдах боломжтой болж байна. Үр дүнд нь блокчейнд суурилснаар эрчим хүчний хэрэглээ банк, эрчим хүчний компаниудаас хамааралгүй болж байна. Оронд нь нэг төвтэй биш эрчим хүчний гүйлгээ болон нийлүүлэлтийн систем хөгжиж хэрэглэгчид өөрсдийн хэрэглэж буй болон худалдаж буй эрчим хүчээ хянах боломжтой блокчейнд суурилсан ухаалаг гэрээний тоо нэмэгдэнэ. P2P эрчим хүчний гүйлгээ нэмэгдсэнээр байгальд ээлтэй буюу сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ өснө гэж үзэж байна.

Жишээ 2. БНХАУ дахь ногоон финтек буюу “Ant Forest”:

БНХАУ–д тэргүүлэх финтек компани болох ANT санхүүгийн нэгдэл нь хэрэглэгчдэд ногоон санхүүжилтийг сурталчлах зорилгоор өргөн хүрээний төслийг хэрэгжүүлээд байна. Компаниас интернет, санхүү болон “low-carbon lifestyle” буюу нүүрсхүчлийн хийн бага ялгаралтай амьдралын хэв маягийг нэгтгэн гаргасан “Ant Forest” аппликэйшн нь Ant–ийн хэрэглэгчдэд өөрсдийн ялгаруулсан нүүрсхүчлийн хийг багасгах боломжийг олгож байна. Ингэхдээ (a) хэрэглэгчид ухаалаг гар утаснаасаа нүүрсхүчлийн хийг багасгахад оруулсан хувь нэмрээ харах боломж, (b) виртуал хаягийг нь “ногоон эрчим хүч”–ээр орлоготой болгох, (c) тухайн орлогоор нь мод тарьж урамшуулах гэсэн гурван алхамт хөтөлбөрийг нэвтрүүлэн ажиллаж байна. Хэрэглэгчид алхах, эсвэл олон нийтийн унаагаар зорчих мөн хэрэглээний зардал, торгууль, эмнэлгийн зардлаа цахимаар төлөх зэрэг нүүрсхүчлийн хийн ялгарал багатай үйл ажиллагааг хийсэн нь тооцоологдож, “ногоон эрчим хүч”–ийг дансандаа нэмнэ. Ногоон эрчим хүч нь виртуал дансандаа виртуал мод тарих хангалттай хэмжээнд хүрэхэд Ant санхүүгийн нэгдэл болон хамтран ажиллагч байгууллагуудын зүгээс бодитоор мод тарьдаг байна.

Гайхалтай нь уг хөтөлбөр төсөөлж байснаас хамаагүй олон хэрэглэгчийг хамарч богино хугацаанд хамарч чадсан байна. 2016 оны 8 дугаар сараас 2017 оны 1 дүгээр сар хүртэлх 6 сарын хугацаанд БНХАУ–ын 200 гаруй сая иргэн сайн дураараа аянд нэгдсэн нь Ant–ийн хэрэглэгчдийн 44%, БНХАУ–ын насанд хүрсэн хүн амын 20% буюу дэлхийн хүн амын 3%–тай тэнцэж байна. Энэхүү амьдралын хэв маягийн өөрчлөлт нь үүсэж болох байсан 150,000 тонн нүүрсхүчлийн хийн ялгарлаас сэргийлж, Ant санхүүгийн нэгдэл 2017 оны 1 дүгээр сар гэхэд 1 сая мод, 2019 он гэхэд 100 сая модыг 933 км² буюу 130,000 хөл бөмбөгийн талбайтай тэнцэх талбайд суулгажээ.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дэлхий нийтээрээ эрчимтэй даяаршиж эдийн засаг, санхүүгийн салбар техник, технологийн үсрэнгүй дэвшилттэй хоршин асар хурдацтай хөгжиж байгаа нь дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлт шинэчлэлтийг бий болгож байна. Сүүлийн жилүүдэд финтекийн салбар дахь хөгжүүлэлт, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалт нэмэгдэхийн хэрээр санхүүгийн салбарын хөгжилд томоохон ахиц дэвшил авчирч байгааг энэхүү олон улсын бүтээгдэхүүн, үйлчилгээний судалгаанаас харж болно.

Технологийн дэвшилд суурилсан блокчейн, рэгтек, хэрэглэгчдийг таних дижитал систем, үүлэн систем, хил дамнасан мөнгөн гуйвуулгын платформ, мобайл мөнгө, цахим хэтэвч зэрэг нь хэрэглэгчдэд санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг илүү хямд зардлаар, богино хугацаанд, чирэгдэл багатайгаар хүртэх боломжийг нээж өгч байна. Монгол Улсын хувьд Пийр тү Пийр, цахим хэтэвч, бичил даатгал зэрэг финтекийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлснээр хөдөө, орон нутгийн иргэдийн санхүүгийн хүртээмж сайжрах боломжтой байна.

Хэдийгээр нэг талаас санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл нэмэгдэж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх шинэ гарц, шийдлүүдийг олсоор байгаа боловч нөгөө талаас хэрэглэгчийн эрх ашиг, мэдээллийн аюулгүй байдал, цахим гэмт хэргээс хамгаалахын тулд технологид суурилсан эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээг зохицуулах хууль, эрх зүйн орчин үүссэн байх шаардлагатай.

Манай улсын хувьд санхүүгийн салбарт технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрч эхэлсэн хэдий ч эдгээртэй холбоотой зохицуулалт, хууль эрх зүйн орчин бүрдээгүй байгаа нь тулгамдаж буй асуудлын нэг болоод байна. Иймд технологид суурилсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэхтэй зэрэгцэн холбогдох хууль, дүрэм, журмын сайн туршлагуудыг Монгол Улсад тохируулан суурьшуулах хэрэгтэй байна.

НАЙМ. ЭХ СУРВАЛЖ

CB Insights. Даатгалын Техникийн Шинжилгээ, <https://www.cbinsights.com/research/report/insurance-tech-q3-2019/>. 2019.

Fintech futures. Финтекийн салбарт гарч буй нийтлэлүүд, <https://www.fintechfutures.com/subject/fintech/>

Sharespost. Payments: Star of the Fintech World, https://avestix.com/eZ1lvwYnQ2WGcEj34KZP/Payments_Star_Of_The_FinTech_World.pdf. 2018.

KPMG. The pulse of fintech 2018, <https://assets.kpmg/content/dam/kpmg/rs/pdf/2018/07/h1-2018-pulse-of-fintech.pdf>. 2018.

KPMG. The pulse of fintech 2019, <https://assets.kpmg/content/dam/kpmg/xx/pdf/2019/07/pulse-of-fintech-h1-2019.pdf>. 2019.

Finsmes. Fintech – The Evolution of Financial Technology, <http://www.finsmes.com/2019/01/fintech-the-evolution-of-financial-technology.html>. 2019.

Wikipedia. Ant financial, https://en.wikipedia.org/wiki/Ant_Financial. 2019.





ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ БА ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

2019 он

Гүйцэтгэсэн: Б.Батчимэг¹, А.Мөнгөнсаран²

¹ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

² Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, mingunsaran@frc.mn

ХУРААНГУЙ

Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ), гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж эдийн засаг, нийгмийн хөгжлийнх нь томоохон асуудал байдаг. Иймд энэхүү судалгаагаар Монгол Улсын ЖДҮ-ийн өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын туршлагыг харьцуулан судлахыг зорьсон.

Судалгаа нь нийт 6 бүлэгтэй. Энэ хүрээнд ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлж, тэдгээр санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг судласан ба ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлогын арга хэмжээг томъёолохоор ЖДҮ-ээр тэргүүлдэг улс орнуудын туршлагыг дэлгэрүүлэн судалж дүгнэлт боловсруулсан.

Судалгааны үр дүнд манай улсын ЖДҮ эрхлэгчид голчлон арилжааны банкны үйлчилгээг ашиглан санхүүжилтийн асуудлаа шийддэг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд санхүүгийн үйлчилгээний өндөр хүү, хураамж, шимтгэл хамгийн том бэрхшээлийн нэг болдог байна. Эдийн засгийн өндөр хөгжил, зах зээлийн таатай нөхцөлөөс гадна ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүй, зохицуулалтын орчин чухал нөлөөтэй бөгөөд энэ нь бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагуудын анхааралдаа авах асуудал юм.

Түлхүүр үгс: жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ), санхүүжилт, туршлага

JEL ангилал: G18, G32, M13

НЭГ. УДИРТГАЛ

“Жижиг, дунд үйлдвэрүүд нь хөгжиж буй орнуудын хөдөлмөр эрхлэлтийн хамгийн их хувийг эзэлж байна. Тэдгээр бизнесүүд нь зах зээл дээр эргэлтийн хөрөнгөө удирдах, өсгөх, өрсөлдүүлэх чадамжтай байх шаардлагатай учраас том байгууллагуудаас илүү зээлийн хэрэгцээ тулгардаг байна. Иймд санхүүгийн хүртээмж нь тэдний амжилтад нэн чухал асуудал юм.”

Дэлхийн банк, Бизнес эрхлэх нь 2015.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж өсөн нэмэгдэж байгаа хэдий ч уг үйлчилгээг хүртэж чаддаггүй иргэд, аж ахуйн нэгжийн тоо өндөр байсаар байна. Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд ЖДҮ, гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон асуудал байдаг.

ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалт, ажилгүйдлийг бууруулах, нийгмийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг.

Судалгааны үндэслэл

ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудал нь үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийн эдийн засгийн байдал, банк, санхүүгийн салбарын зохицуулалтын чадавхаас ихээхэн хамаардаг. Жишээ нь, буурай хөгжилтэй орнуудын ЖДҮ нь хөгжингүй орнуудын ЖДҮ-тэй харьцуулахад санхүүжилт авах илүү хэцүү байдаг.

Хөгжингүй орнууд нь буурай хөгжилтэй болон хөгжиж буй эдийн засагтай орнуудтай харьцуулахад ЖДҮ-д зээл олгох эрсдэл ба зардлыг багасгахад чиглэсэн зохицуулалтын бүтэцтэй байдаг тул тухайн улсын зах зээл нь илүү үр ашигтай санхүүжилтийн үйлчилгээг ЖДҮ-үүдэд санал болгодог. Мөн бүх байгууллагын зээлийн түүхийг хадгалдаг хувийн зээлийн газруудыг олноор нь байгуулж, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг байна. Харин зээлийн өгөгдөл байхгүй, эсвэл дутуу, олон нийтэд хуваалцах боломжгүй улсын хувьд ЖДҮ-ийн эрсдэлийг багасгахад ихээхэн хүчин чармайлт, зардлыг шаарддаг байна.

Иймд хөгжиж буй манай улсын хувьд ЖДҮ-ийн санхүүжилтийн байдал, зохицуулалт зэрэг асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар олон улсын туршлага болон өөрийн орны өнөөгийн нөхцөл байдалд харьцуулсан судалгааг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны зорилго, зорилт

Тус судалгааны зорилго нь манай улсын ЖДҮ-ийн өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын туршлагыг харьцуулан судалж, дүгнэлт гаргахад оршино. Тус зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ:


- ЖДҮ-ийн санхүүжилтэд тулгардаг саад бэрхшээлүүдийг тодорхойлох;
- ЖДҮ-ийн санхүүжилтийн арга хэрэгслүүд, өргөн ашиглагддаг загваруудыг судлах;
- ЖДҮ эрхлэгчдийг дэмжих бодлогын арга хэмжээг томъёолох;
- Монгол Улсын ЖДҮ-ийн өнөөгийн байдлыг судлах;
- ЖДҮ-ээр тэргүүлдэг улс орнуудын туршлагыг судлах;
- Судалгааны дүгнэлт боловсруулах.

ХОЁР. ЖДҮ-ИЙН САНХҮҮЖИЛТЭД ТУЛГАРДАГ СААД БЭРХШЭЭЛ

Санхүүгийн хүртээмж нь бизнес эрхлэгч, аж ахуйн нэгж, иргэдэд бүтээгдэхүүн, үйлчилгээ шинээр нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэх, зах зээлд өрсөлдөх зэрэг олон тооны боломжийг олгодог. ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагааны эхэн үедээ ихэвчлэн албан бус санхүүгийн хэрэгсэл ашигладаг бол үйл ажиллагааны цар хүрээ нь өргөжихийн хэрээр албан ёсны санхүүгийн хэрэгслүүд шаардлагатай болж эхэлдэг ба албан ёсны санхүүгийн эх үүсвэрийг ашиглах нь цаашдын өсөлт, хөгжилд нь чухал хувь нэмэр оруулдаг.

Жижиг, дунд үйлдвэрлэлийн санхүүжилтэд түгээмэл ашиглагдаж буй санхүүжилтийн арга хэрэгслүүдийг зураг 1-т харууллаа. Томоохон аж ахуйн нэгжүүдийн хувьд хөрөнгийн зах зээлд оролцох, хувьцаагаа олон нийтэд арилжаалж хөрөнгө босгох, арилжааны банкны үйлчилгээ авах зэргээр санхүүжилтээ шийдэж байна. Мөн өндөр хөгжсөн улсуудын арилжааны банкуудын хувьд ЖДҮ-д зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж харьцангуй сайн байгаа бол дийлэнх хөгжиж буй орнуудад арилжааны банк нь ЖДҮ-д зориулсан үйлчилгээ нэвтрүүлж чадахгүй байна. Бичил санхүүгийн байгууллагууд нь ЖДҮ-д тохирсон бага хэмжээний зээлийн бизнес загварыг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байгаа хэдий ч хэрэглэгч аж ахуйн нэгжүүдээ илүү томруулах, цаашдын хөгжлийг нь дэмжих тал дээр хязгаарлагдмал нөөцтэй байна. Улс орнуудад бага хэмжээний бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн гол эх үүсвэр нь бичил санхүүгийн байгууллагуудаас олгож буй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд байна.

Зураг 6. 1. ЖДҮ-ийн санхүүжилтэд ашиглагддаг санхүүгийн арга хэрэгслүүд



ЖДҮ–ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тулгардаг гол бэрхшээлүүд нь санхүүгийн зах зээлийн дэд бүтэц болон хууль, эрх зүй, зохицуулалтын орчинтой холбогдож байдаг.

Хууль, эрх зүйн оновчтой шийдэл, үр ашигтай зохицуулалт нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хадгалахын сацуу, санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж байдаг. Хөгжиж буй олон улс орнуудад ЖДҮ–ийн санхүүжилтийн үр ашигт хэрэгсэл болох санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээнүүд нь хууль, эрх зүй, зохицуулалтын орчин сулаас шалтгаалан төдийлөн сайн хөгжиж чадахгүй байна. Зөвхөн арилжааны банкаар тогтохгүй санхүүгийн зах зээлд оролцогч бүхий л байгууллагуудыг оновчтой зохицуулалт дэмждэг бөгөөд санхүүгийн зах зээлийн хөгжилд түлхэц болох, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх замаар байгууллагуудын үр ашгийг өсгөж ЖДҮ–д зориулсан санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Эсрэгээрээ зарим улс орнуудад хийгдэж буй зээлийн хүүгийн түвшинд тааз хэмжээ тогтоох зэрэг үр ашиггүй зохицуулалт нь ЖДҮ–ийн санхүүжилтийн эх үүсвэрийг хорогдуулж байна.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд нягтлан бодох бүртгэл болон аудитын стандарт, зээлийн мэдээллийн систем, барьцаа хөрөнгө болон төлбөрийн чадварын зохицуулалт, төлбөр, тооцооны систем гэх мэт ойлголтууд хамардаг. Дэд бүтэц сайн хөгжсөнөөр санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлтийг хязгаарладаг мэдээллийн тэгш бус байдал, зохицуулалтын орчны тодорхой бус байдлыг бууруулдаг.

Нягтлан бодох бүртгэл, аудитын стандарт сайн байснаар мэдээллийн тодорхой бус байдлыг бууруулж, зээл олгогчдод санхүүгийн тайланд үндэслэн шийдвэр гаргах боломжийг олгосноор санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлдэг. Гэхдээ улс орнуудын зохицуулагчид, бодлого гаргагчдад ЖДҮ эрхлэгчдийн үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, тэдэнд учруулах зохицуулалтын дарамтыг бууруулах гэсэн хоёр чухал үүргийг зэрэг биелүүлэхэд хүндрэл учирдаг. Дэлхий нийтэд ойролцоогоор 60 гаруй улс “Олон улсын санхүүгийн тайлагналын стандарт” (IFRS)–ын ЖДҮ–д зориулсан хувилбарыг ашигладаг бол Герман, Европын холбооны улсууд уг стандартыг ЖДҮ–д зардал өндөртэй тусна гэж үздэг тул ижил төстэй боловсруулагдсан өөрсдийн стандартыг ашигладаг.

Төрийн болон хувийн зээлийн мэдээллийн сан нь зээлдэгчийн зээлжих чадварыг тодорхой болгосноор ЖДҮ–ийн зээлийн нийлүүлэлтэд эерэг нөлөө үзүүлдэг. Зээлийн мэдээллийн сан сайн байснаар сөрөг сонголт (adverse selection), ёс суртахууны гажуудал (moral hazard)–аас үүсэх эрсдэлийг багасган зээлийн үйлчилгээний зардлыг бууруулж, нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Love, Mylenko нарын 2003 онд гүйцэтгэсэн 51 улсын 5000 гаруй ЖДҮ эрхлэгчдийг хамруулсан судалгааны үр дүнд зээлийн мэдээллийн сан, бүртгэлийн систем сайтар хөгжсөн орнуудын ЖДҮ эрхлэгчдийн банк, санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээнд хамрагдалтын түвшин өндөр гарсан байна.

Мөн барьцаа хөрөнгийн зохицуулалтыг оновчтой болгосноор барьцаа хөрөнгийг төрөлжүүлж (хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө), зээлээ эргэн төлж чадаагүй нөхцөлд үүсэх алдагдлыг бууруулдаг тул зээлдэгчдийн хохирол амсах магадлалыг бууруулж, зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг.

ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлогын интервенц

Тогтвортой макро эдийн засгийн орчин, үр ашигт санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, хууль эрх зүйн оновчтой зохицуулалт нь ЖДҮ–ийн хөгжилд зайлшгүй чухал зүйл бөгөөд энэхүү ЖДҮ–д ээлтэй орчныг бүрдүүлэхэд засгийн газрын оролцоо чухал үүрэгтэй юм.

Дан ганц нийгэм эдийн засгийн орчин сайн байснаар ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй юм. Жижиг болон шинэ бизнес эрхлэгчид нь бизнесийн сайн төлөвлөгөө, өсөлт, хөгжлийн хангалттай чадавхтай байсан ч зээлийн түүхгүй, барьцаа хөрөнгийн баталгаа байхгүйн улмаас зээлийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй бөгөөд санхүүжилтийн асуудал том бэрхшээл болдог. Засгийн газар нь ЖДҮ-ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хөгжлийг дэмжих зорилгоор дараах интервенцийг хийх боломжтой байдаг.

Хүснэгт 6. 1. ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын интервенц

Санхүүжилтэд учрах бэрхшээл	Боломжит интервенц	Интервенц хийснээр гарах үр дүн
Мэдээллийн тэгш бус байдал	Бизнес регистр	Бизнес регистр, бүртгэлийн процессыг сайжруулснаар мэдээллийн ил тод байдал сайжирна
	Зээлийн хороо	Зээлийн үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ, муу зээлдэгчийн мэдээлэл сайжирна
	Нягтлан бодох бүртгэлийн стандарт	Зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд ЖДҮ-ийн санхүүгийн тайланд үндэслэн зээлийн шийдвэр гаргахад амар болно
	Барьцаа хөрөнгийн бүртгэл	Барьцаа хөрөнгийн үнэ цэнэ, төрлийн талаар мэдээллийн эх үүсвэр нэмэгдэнэ
Санхүүгийн зуучлагч байгууллагуудын чадавх	Техникийн туслалцаа	Зээлийн эрсдэлийг тооцох, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэхэд зээлдэгчийн чадавхыг нэмэгдүүлнэ
		Барьцаа хөрөнгийн менежмент, бүрдүүлэлт, бүтээгдэхүүний загвар гаргах зэрэгт зээл олгогчийн чадавхыг нэмэгдүүлнэ
ЖДҮ-ийн санхүүгийн зах зээлд оролцох чадвар	Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөр	Санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх хөтөлбөрөөр дамжуулан санхүүгийн зах зээл, бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх
	Бизнесийн зөвлөхүүдийн сүлжээ	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад нь мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах
Хууль эрх зүйн орчин	Зээл олгогчийн эрх	Төлбөрийн чадвар, хөрвөх чадварын эрсдэл болон дампуурлын үед үүсэх алдагдлыг бууруулах боломжтой
	Компани дампуурах үед хийгдэх эрх зүйн зохицуулалт	Дампуурлын үед хэрэгжих хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулснаар зах зээлд оролцогчдын алдагдлыг бууруулна
	Өмчийн эрх	Барьцаа хөрөнгө, өмчийн бүртгэлийг сайжруулна
Төрийн бодлогын дэмжлэг	Баталгааны схем	ЖДҮ-ийн зээлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ
Арилжааны өндөр зардал	Техникийн туслалцаа	Улс орнуудад хэрэгжүүлдэг сайн туршлагаудыг нэвтрүүлнэ
Тогтмол зардлын өндөр суурь	Зах зээлийн дэд бүтэц	Өрсөлдөөнд нөлөөлөхгүй байдлаар зарим төрлийн платформыг дундаа ашиглаж, зардлаа хэмнэж, үр ашгаа нэмэгдүүлэх
Хөрөнгийн зах зээлийн сул хөгжил	Банкны санхүүжилтийн схем	Зээлдэгчээс ЖДҮ-дэд шууд хүрэх бага зардалтай эх үүсвэрээр хангах

Мөн дээрх интервенцээс гадна зарим улс орнуудад засгийн газар нь арилжааны банкнаас ЖДҮ-д олгох зээлд квот тогтоох, ЖДҮ-ийг дэмжих зорилгоор төсөл хөтөлбөр болон засгийн газрын зээлд

хамрагдаж эх үүсвэрийг ЖДҮ–ийн агентлаг болон орон нутгийн банкуудаар дамжуулан олгох, ЗГ–аас ЖДҮ–ийг дэмжих дүрмийн сан байгуулж өндөр өсөлттэй, технологийн компаниудад санхүүжилт хийх зэрэг бодлогын арга хэрэгслийг ашигладаг.

Дээрх төрлийн төрөөс шууд байдлаар орсон зохицуулалт нь зарим тохиолдолд амжилттай хэрэгждэг хэдий ч зарим тохиолдолд үр ашиггүй байдаг байна. Дэлхийн банкнаас гаргасан судалгаанаас харахад ЖДҮ–ийг дэмжих зорилготой төрийн өмчийн санхүүгийн байгууллага нь нэлээд хэдэн улс оронд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийтлэг зүйл ажиглагдсан нь хөгжиж буй орнуудын хувьд төрийн өмчийн уг байгууллагууд нь нэлээд үр ашиггүй ажиллаж санхүү, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг байна. Энэ төрлийн байгууллагууд нь ихэвчлэн улс төрийн зорилгоор үйл ажиллагаа явуулж, сонгуулийн мөчлөгийг даган үр ашиггүй зардал гаргаж, улсын төсөв цаашлаад татвар төлөгчдийн хөрөнгийг үргүүдүүлсэн өндөр зардлыг зах зээлд үүсгэдэг байна.

ГУРАВ. ЖДҮ–ИЙН САНХҮҮЖИЛТИЙН АРГА ХЭРЭГСЛҮҮД, ӨРГӨН АШИГЛАГДДАГ ЗАГВАРУУД

Санхүүгийн хүртээмжийн экспертүүдийн групп (FEIG) нь ЖДҮ–ийн тогтвортой санхүүжилтийг дэмжих зориулалтаар амжилттай хэрэгжсэн бодлогын загваруудыг судалсан ба эдгээр загварууд нь дараах хүрээг хамарсан байна. Үүнд:

- ЖДҮ–ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүй, зохицуулалтын интервенц
- Мэдээллийн тэгш бус байдал, арилжааны зардлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн зах зээлийн дэд бүтэц
- ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төрийн оролцооны загвар
- ЖДҮ–ийг тогтвортой санхүүжилтээр хангах хувийн хэвшлийн загвар

Мөн уг байгууллагаас ЖДҮ–ийн хөгжлийг хангах чиглэлээр улс орнууд ямар бодлого баримталж буйг судалсан ба дундаж орлоготой улсуудын хувьд ЖДҮ–ийг хөгжүүлэх арга хэмжээг хамгийн их хэрэгжүүлдэг байна. Нийт судалгаанд хамрагдсан дундаж орлоготой улсуудын 88 хувь нь ЖДҮ–ийг дэмжих дээрх 4 загварыг бүгдийг нь ашигладаг ба дийлэнх нь буюу 60 орчим хувь нь төрийн оролцооны загварыг ашигладаг байна. Харин бага орлоготой улсуудын 11 хувь нь төрийн оролцооны загвар, 5 хувь нь хувийн хэвшлийн загвар, 1 хувь нь хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг сайжруулах арга хэмжээг авч ажилладаг байна.

ЖДҮ–ийг тогтвортой санхүүжилтээр хангах хувийн хэвшлийн загвар

ЖДҮ–ийг хөгжүүлэхэд санхүүгийн зах зээлд хувийн хэвшлээс дараах байдлаар оролцож болдог. Үүнд:

- Арилжааны банкуудаас ЖДҮ–ийн санхүүжилтийг хангах доош чиглэсэн загвар
- Бичил санхүүгийн байгууллагуудаас ЖДҮ–ийн санхүүжилтийг хангах дээш чиглэсэн загвар
- Хувь нийлүүлэгч, хувьцаа эзэмшигчид нь ЖДҮ–ийг дэмжих, эдийн засгийн хөгжлийг дэмжих сонирхлоор нийгмийн хариуцлагаар хэрэгжүүлж буй коммунити банкуудын үйл ажиллагаа
- Хувийн хөрөнгө оруулалтын сангууд

Арилжааны банкуудын загвар

Өндөр хөгжсөн улсуудад арилжааны банкууд нь мэдээллийн технологи, тоон мэдээллийн санг ашиглан ЖДҮ–ийн зээлийн эрсдэлийг зардал багатай аргаар судалж, бага дүнтэй зээлийг үр ашигт байдлаар гаргадаг байна.

Харин хөгжиж буй улсуудын хувьд уламжлалт банкны системийн дагуу, харьцангуй сул дэд бүтэц ашиглаж, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн санхүүжилт, сангуудыг ашиглан ЖДҮ–д зориулсан зээлийн үйлчилгээ гаргадаг.

ЖДҮ–ийн зээлийн үйлчилгээг амжилттай шийдэж буй банкуудын туршлагаас харахад технологийн дэвшил, мэдээллийн сан, үнэлгээний систем боловсруулан зардлаа хэмнэх замаар үр ашигтай ажиллаж чаддаг байна. Эдгээр банкуудын жишээ гэвэл АНУ–ын “Wells Fargo”, Энэтхэгийн “ICICI Bank”, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг “Standard Chartered” банк зэрэг юм.

Бичил санхүүгийн байгууллагуудын загвар

Бичил санхүүгийн байгууллагууд нь зах зээлийн мэдээлэл, хэрэглэгчдийн сүлжээгээрээ дамжуулан ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг. ЖДҮ-д зориулсан үйлчилгээг амжилттай хэрэгжүүлсэн бичил санхүүгийн байгууллагуудын нэг жишээ нь Латин Америкийн ПроКредит, Бангладешийн Брак банк зэрэг юм. Брак банк нь хэрэглэгчдийн тоон мэдээллийн сан дээрээ суурилан барьцаа хөрөнгийн шаардлагагүй ЖДҮ-ийн зээл, орон нутаг, алслагдмал газар байршдаг байгууллагуудад зориулсан зээл зэрэг бүтээгдэхүүнийг гарган хэрэглэгчдэдээ амжилттай хүргэдэг.

Коммунити банк

Бусад банк санхүүгийн байгууллагуудаас ялгаатай нь коммунити банк нь тухайн үйл ажиллагаа явуулж буй бүс нутаг эсхүл санхүүгийн үйлчилгээ хүргэхийг зорьж буй тухайн зорилтот бүлгийн хэрэглэгчидтэй илүү ойр ажилладаг тул хэрэглэгчдийн мэдээллийн сан сайн бүрдсэн, эрсдэлийн үнэлгээг илүү үр дүнтэй гүйцэтгэх боломж өндөр байдаг. Мөн коммунити банк нь хэд хэдэн банк, санхүүгийн байгууллагуудын нэгдэл хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг тул зарим төрлийн зардлаа хуваалцаж, үр ашгаа нэмэгдүүлдэг. Герман Улсын “Хадгаламжийн банкны санхүүгийн групп” / Sparkassen Finanzgruppe/ нь нэлээд үр ашигтай ажилладаг коммунити банк бөгөөд Германы гарааны бизнесийн зээлийн 50 орчим хувийг дангаар хангадаг.

Сүүлийн жилүүдэд технологийн дэвшлийг коммунити банкны үйлчилгээнд ашиглаж нэлээд амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд банкны хэрэглэгчид өөрсдийн дансаар нэвтэрч зээлээ төлөх, хадгаламж хийх, бизнесийн үйл ажиллагааны эрсдэлээ үнэлэх зэрэг давуу талуудыг олгож байна.

Хувийн хөрөнгө оруулалтын сан

Ихэвчлэн өндөр хөгжсөн орнууд хувийн хөрөнгө оруулалтын санг ЖДҮ-ийн санхүүжилтэд ашигладаг. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг шийдээд зогсохгүй хүний нөөцийг чадавхжуулах, засаглалыг сайжруулах, инновацыг дэмжих зэрэг олон хөгжлийн асуудлуудад эерэг нөлөө үзүүлдэг. Бусад төрлийн ЖДҮ-ийн санхүүжилтийн арга хэрэгслээс ялгаатай нь хувийн хөрөнгө оруулалтын сан нь ихэвчлэн өндөр өсөлттэй бизнес эрхлэгчдэд үйлчилгээ үзүүлдэг учраас хүртээмжийн хувьд бага байдаг. Сүүлийн жилүүдэд хөрөнгө оруулалтын сангууд нь технологи, инновацийн шийдлийг ашигласан ЖДҮ, гарааны бизнесүүдэд түлхүү санхүүжилт олгох хандлагатай байна.

Хувийн хөрөнгө оруулалтын санг Засгийн газраас санхүүжүүлдэг хэлбэр байдаг бөгөөд Шинэ Зеланд болон Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нэлээд амжилттай явагддаг. Солонгосын Венчур Капитал Хөрөнгө оруулалтын корпорац (KVIC) нь 1.5 тэрбум долларын хөрөнгөтэйгөөр зөвхөн ЖДҮ-ийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байна.

ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүй, зохицуулалтын интервенц

ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжихээр төрөөс баримталж буй бодлого нь ихэвчлэн зах зээлийн орчныг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүй, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох байдлаар хэрэгждэг. Хууль, эрх зүй, зохицуулалтын бодлогод өөрчлөлт оруулан хэрэгжүүлсний дараагаар ЖДҮ-ийн санхүүжилт нэмэгдэх үр дүн гардаг хэдий ч тоон мэдээний дутмаг байдлаас шалтгаалан олон улс оронд уг бодлогын үр дүнг хэмжиж чаддаггүй. Мөн ЖДҮ-ийг дэмжих чиглэлээр

зохицуулалтын орчинд чиглэсэн бодлогыг дангаар баримтлах нь хангалтгүй байдаг бөгөөд бусад төрлийн бодлогуудтай хавсран хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байдаг байна.

ЖДҮ–ийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тэдний хөгжлийн түвшнийг дээшлүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн цогц бодлого баримтлан амжилттай хэрэгжүүлж буй улсын жишээ нь Франц, Малайз, Солонгос Улс юм. Эдгээр гурван улс нь дан ганц хууль, эрх зүйн орчныг сайжруулахаас гадна дараах бодлогын хэрэгслүүдийг ашиглажээ.

Хүснэгт 6. 2. ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн цогц бодлогыг амжилттай хэрэгжүүлж буй улсууд

Улс	Бодлогын төрөл	Хэрэгжүүлж буй бодлого
Франц	Хууль, эрх зүйн зохицуулалт	ЖДҮ болон бага дүнтэй зээлийн хувьд банканд тавигдах хөрөнгийн болон зохицуулалтын бусад шаардлагууд, Базелийн стандартын дагуу
	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц	Байгууллагуудын тоон мэдээллийн сан (FIBEN) ЖДҮ эрхлэгчдийн мэдээллийн сан
	Төрийн дэмжлэгийн механизм	OSEO инновацыг дэмжих бодлого OSEO санхүүгийн байгууллагуудаар дамжуулан ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлого OSEO ЖДҮ–д зориулсан санхүүгийн баталгааны бодлого
Солонгос	Төрийн дэмжлэгийн механизм	ЖДҮ–д олгох зээлийн дээд хэмжээг тогтоох зохицуулалт
		Идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ–ийн шууд санхүүжилтэд зориулсан сан байгуулах
		Солонгосын зээлийн баталгааны сан (KODIT)
		Хөрөнгө оруулалтын сан (KVIC) Аж үйлдвэрийн банкаар дамжуулан зээлийн сүлжээ тогтоох зохицуулалт ЖДҮ–д зориулсан зээлийн баталгааны хөтөлбөр
Малайз	Хууль, эрх зүйн зохицуулалт	ЖДҮ–ийн хөгжлийг дэмжсэн цогц бодлогын арга хэмжээ
	Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц	ЖДҮ–ийн өрсөлдөх чадварын үнэлгээ
		Зээлийн мэдээллийн систем
	Төрийн дэмжлэгийн механизм	Бага дүнтэй зээлийн схем
		Гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын хөтөлбөр
		Хөрөнгө оруулалтын сан
		Мэдээллийн технологи болон био технологийн компаниудад зориулсан төслийн санхүүжилт
		Зээлийн баталгааны корпорац
		ЖДҮ–д туслах баталгааны схем
Бичил санхүүгийн тогтвортой хөгжлийг дэмжих бодлого ЖДҮ–д зориулсан бизнесийн зөвлөхийн үйлчилгээ		

Мэдээллийн тэгш бус байдал, арилжааны зардлыг бууруулахад чиглэсэн санхүүгийн зах зээлийн дэд бүтэц

Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах нь ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих гол түлхүүр гэж зах зээлд оролцогчид үздэг. Зах зээлийн дэд бүтэц сайжирснаар тодорхой бус байдлыг бууруулж, мэдээллийн тэгш байдлыг нэмэгдүүлснээр санхүүгийн үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг. Зүүн өмнөд Ази, Латин Америк, Хойд Африкийн хөгжиж буй орнуудын 75 гаруй хувь нь зах зээлийн дэд бүтцийг сайжруулах бодлогын арга хэрэгслийг ашиглаж байна.

Технологийн дэвшлийг ашиглан зээлийн мэдээллээр харьцангуй хомс ЖДҮ-ийн зээлийн шийдвэр гаргалтыг хурдасгаж, зардлыг хэмнэх боломжийг сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд гарч буй томоохон өөрчлөлтүүд олгож байгаа ба зээлийн мэдээллийн сан, зээлийн үнэлгээний болон барьцаа хөрөнгийн систем нь санхүүгийн зах зээлийн дэд бүтцэд хамгийн түгээмэл хийгдэж байна.

ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх төрийн оролцооны загвар

Засгийн газраас банк, санхүүгийн байгууллагуудаар дамжуулан шууд санхүүжилт олгох, зээлийн баталгаа гаргах сан байгуулах зэрэг түгээмэл арга хэрэгслээр ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлдэг.

Зээлийн үйлчилгээгээр дамжуулан ЖДҮ-ийг санхүүжүүлэх арга хэрэгсэл нь хөгжиж буй улсуудад хамгийн түгээмэл ашиглагдаж байна. Энэ төрлийн санхүүжилтийн арга хэрэгсэл нь зорилгоосоо хамааран 2 төрлөөр ашиглагддаг. Эхнийх нь санхүүгийн үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих дунд болон урт хугацааны арга ба үүний нэг жишээ нь зах зээлд инновацыг нэвтрүүлж буй ЖДҮ-дийг дэмжих зорилготой Инновацыг дэмжих Францын Агентлаг (OSEO) юм. Харин хоёр дахь нь эдийн засгийн хямралын үед ЖДҮ эрхлэгчдийг хамгаалах богино хугацааны бодлогын арга хэрэгсэл бөгөөд Турк Улс ЖДҮ эрхлэгчдэдээ хямралын үед хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох аргыг ашиглаж байсан.

Харин зээлийн батлан даалтын арга хэрэгслийг хөгжиж буй болон өндөр хөгжсөн улс орнуудад бүгдэд нь ижил түгээмэл ашигладаг. Уг бодлогын хэрэгсэл амжилттай хэрэгждэг орнуудад Солонгос, Нидерланд, Малайз, АНУ зэрэг орно.

ДӨРӨВ. ЖДҮ ЭРХЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн үйлчилгээ нь иргэд аж ахуйн нэгжид хэрэглээгээ тогтмол хангах, нөөцөө зохистой хуваарилах, өдөр тутмын орлогоо зөв хянаж, зарцуулах, тулгарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг олон давуу талыг бий болгодог. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж өсөн нэмэгдэж байгаа хэдий ч уг үйлчилгээг хүртэж чаддаггүй иргэд, аж ахуйн нэгжийн тоо өндөр байсаар байна. Өндөр хөгжсөн болон хөгжиж буй бүхий л улс орнуудын хувьд ЖДҮ, гарааны бизнест зориулсан санхүүгийн үйлчилгээний хүртээмж эдийн засаг, нийгмийн хөгжлийн томоохон асуудал байдаг.

Бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагуудын хувьд зах зээлийн гажуудлыг багасгах, тэгш бус байдлыг бууруулах зорилгоор зарим бодлогын интервенцийг хийх, ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудлыг амжилттай шийдэж буй бусад улс орнуудын туршлагыг судалж, нэвтрүүлэх зэргээр зах зээлээ дэмжих олон арга хэмжээг авч ажилладаг. Энэ бүлэгт эдгээр зохицуулалтын арга хэрэгслүүдийн талаар товч авч үзнэ.

ЖДҮ-ийг хөгжүүлэх стратеги боловсруулах

ЖДҮ-ийг хөгжүүлэх стратегийг боловсруулахдаа нэн тэргүүнд санхүүгийн зах зээл, үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх шаардлагатай. Уг үнэлгээнд эрэлт болон нийлүүлэлт талын тоон мэдээлэлд суурилсан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, хууль эрх зүй, зохицуулалтын орчны чанарын судалгаа зэрэг судалгаанууд багтана. Үнэлгээг хийснээр зах зээлийн дутагдалтай талыг тодорхойлох, бодлого, хяналтын уялдаа холбоотой байдал зэргийг үнэлэхээс гадна бодлогын интервенцийн үр нөлөөг тооцох боломжтой болох юм.

Зах зээлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг бий болгох

Зардал, үр ашиг, эрсдэлээ нарийн тодорхойлж, тэнцвэржүүлж чаддаг банк, санхүүгийн зах зээлтэй байснаар санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалттай түвшинд байж чадах ба бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагууд зах зээлийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэгтэй юм.

Хууль, эрх зүйн оновчтой зохицуулалт нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх нөлөөтэй бөгөөд үүний нэг жишээ нь ЖДҮ-д зориулсан санхүүгийн үйлчилгээгээр тэргүүлдэг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудыг зах зээлд нэвтрүүлэх, санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээг хөгжүүлэх зэрэг юм. Мөн хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг сайжруулж үнэт цаасны зах зээл, институционал хөрөнгө оруулагчдыг дэмжсэнээр ЖДҮ-д зориулсан зээлийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой. Шинэ техник, технологийн дэвшлийг зах зээлд нэвтрэхийг дэмжсэн, үүнээс үүдэх эрсдэлээс урьдчилан сэргийлж чадахуйц зохицуулалтын орчныг бий болгох нь мөн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй.

Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц

Ихэнх хөгжиж буй улс орнуудын хувьд санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах нь хөгжлийн нэн тэргүүний зорилт байх учиртай. Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц сайтар хөгжсөнөөр мэдээллийн тэгш бус байдлыг бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар ЖДҮ эрхлэгчдэд зээлийн түүх үүсгэхэд тусалж, үйл ажиллагааны зардлыг бууруулна.

Нягтлан бодох бүртгэл болон аудитын стандарт: ЖДҮ эрхлэгчид нь харьцангуй энгийн санхүүгийн гүйлгээтэй, олон нийтэд хаалттай хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг учраас зарим тохиолдолд

нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг дагаж мөрдүүлэх нь хэтэрхий зардал өндөртэй, үр ашиг багатай байдаг. Уг шалтгаанаар олон улс орон 50–аас доош ажилтантай ЖДҮ эрхлэгчдийн хувьд олон улсын стандартыг илүү энгийн болгосон Европын холбооны улсуудын баримталдаг бодлого, стандартад суурилан өөрийн улсад тохирсон стандартыг ашиглаж байна.

Зээлийн хороо/зээлийн мэдээллийн сан: Засгийн газар, зохицуулагч байгууллагууд нь зээлийн мэдээллийн санг үүсгэн байгуулах шаардлагатай юм. Хувийн болон арилжааны зээлийн мэдээллээс бүрдэх санг бүрдүүлснээр зээлийн шийдвэр гаргалтын үйл явц түргэсэх, санхүүгийн байгууллагуудын зардал болон эрсдэл буурах, улмаар санхүүгийн үйлчилгээг хүргэх хугацаа богиносх, хүртээмж нэмэгдэх зэрэг давуу талуудтай. Мөн бодлого гаргагчдын зүгээс тоон мэдээллийн сангийн ашиглалт, аюулгүй байдлын талаар сайтар анхаарч ажиллах шаардлагатайгаас гадна мэдээллийн сан нь хугацааны хоцрогдолгүй бодит цагийн горимоор шинэчлэгдэж, ашиглагддаг, цахимаар нэвтрэх боломжтой байх шаардлагатай.

ЖДҮ эрхлэгчдэд үнэлгээ өгөх агентлаг: Зарим улс орнуудад ЖДҮ эрхлэгчдэд үнэлгээ өгөх агентлагууд ажилладаг ба зээл олгогчдод тухайн этгээдийн талаар мэдээлэл өгснөөр зээлийн шийдвэр гаргалтад туслах, хөрөнгийн эх үүсвэрийг үр ашигтай хуваарилахад дэмжлэг үзүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг. Гэхдээ энэ төрлийн үнэлгээний механизмд ашиг сонирхлын зөрчил үүсэх магадлал өндөр, мөн харилцагч байгууллагуудаас албан ёсны орлогоос давсан эх үүсвэр авах зэрэг эрсдэл байх тул төрөөс энэ төрлийн байгууллагуудыг хянаж, зохицуулах шаардлагатай юм.

Зээл чанаргүйдэх тохиолдолд хийгдэх зохицуулалт: Банк, санхүүгийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээ, гүйлгээ нь оролцогчид талуудыг хохироохгүй байхаар найдвартай байх шаардлагатай бөгөөд уг асуудалд төрийн зохицуулалт оролцох шаардлагатай байдаг. Тухайлбал барьцаа хөрөнгийн бүртгэлийг сайжруулснаар хөрөнгийг ангилах, үнэлэх үйл ажиллагаа сайжрах бөгөөд зөвхөн үл хөдлөх хөрөнгөөс гадна хөдлөх хөрөнгө зээлийн барьцаанд ашиглагдах боломжтой болох юм. Мөн зээлдэгч үүргээ гүйцэтгээгүй тохиолдолд барьцаа хөрөнгийг хураах, шилжүүлэх харилцааг үр ашигтай зохицуулах нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд ихээхэн чухал юм.

Үр ашигт төрийн оролцоо

Төрөөс гаргаж буй бүхий л зохицуулалт, интервенц нь зах зээлийн хэрэгцээнд нийцсэн, цаг хугацааны хувьд тохиромжтой, зардал, үр ашгийг сайтар тооцсон, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд уян хатан хариу үзүүлэхүйц байх шаардлагатай юм.

Төрөөс зээлийн батлан даалтын сан байгуулах, төрийн зээмшлийн банкаараа дамжуулан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, шууд санхүүжилт ашиглах зэргээр ЖДҮ–ийг дэмждэг ба бодлогын аль ч арга хэрэгслийг ашигласан бай тухайн үйл ажиллагаанд улс төрийн нөлөө бага, авлигал хээл, хахуулийн хяналт хүчтэй, үйл ажиллагааны үр дүнг дүгнэх үнэлгээний систем чухал байдаг.

ЖДҮ–ийн санхүүжилтэд зориулсан тоон мэдээллийн сан үүсгэх

Нийлүүлэлт болон эрэлт талын тоон мэдээллийн санг үүсгэж, ЖДҮ–ийн зах зээлийг үнэлэх түүвэр судалгааг тогтмол гүйцэтгэх, ЖДҮ–ийг газар зүйн байршил, ажилчдын тоо, хөрөнгө, ашгийн хэмжээ зэргээр нь ангилан мэдээллийн сан үүсгэх нь ЖДҮ–ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд чухал зүйл юм. Түүнчлэн цахим сүлжээг ашиглан бүртгэл хийх, мэдээлэл цуглуулдаг болсноор тоон мэдээллийн сан үүсгэх нь илүү амар хялбар, зардал бага, үр ашигтай болдог байна.

ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЖДҮ-ИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь дэлхийн улс орнуудын эдийн засгийн нэн тэргүүний зорилтуудын нэг билээ. ЖДҮ-ийг хөгжүүлэх нь ядуурал, ажилгүйдлийг бууруулахын зэрэгцээ эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг гүйцэтгэдэг. ЖДҮ-ийг хөгжүүлснээр орлогын тэгш бус хуваарилалтыг бууруулах, нийгмийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлэх, хувийн секторын хөгжлийг хангахад чухал хувь нэмэр үзүүлдэг.

Монгол Улсын Засгийн газраас ЖДҮ-ийн талаар баримтлах бодлого, үндсэн чиглэлийг тогтоож 2007 онд “Жижиг, дунд үйлдвэрийн тухай” хуулийг батлан гаргаж, 2008 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Жижиг, дунд үйлдвэрийн газар, 2009 онд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх санг байгуулсан. Төрөөс ЖДҮ-ийг хөгжүүлэх, бизнесийн орчныг сайжруулахад анхаарч 2009 оныг “Үйлдвэрлэлийг дэмжих жил”, 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил”, 2011 оныг “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”, 2012 оныг “Өрхийн хөгжлийг дэмжих жил” –ээр тус тус зарласан бөгөөд 2014 онд Засгийн газраас “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр (2014–2016)” –ийг баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд 2016 оныг “Дотоодын үйлдвэрлэл, борлуулалтыг дэмжих жил” –ээр зарлан ЖДҮ-ийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлж иржээ. Түүнчлэн Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр 2019–2022” –ыг баталсан байна.

2019 оны байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 187,126 аж ахуйн нэгжээс 93,858 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд үүний 77% буюу 64,571 аж ахуйн нэгж ЖДҮ-ийн салбарт хамаарч байна. Статистикийн үзүүлэлтээс харахад жижиг, дунд үйлдвэрийн салбарт 842,728 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 72%–ийг эзэлж байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний 17.8 хувь, экспортын 2.3 хувийг ЖДҮ-ийн салбарт үйлдвэрлэж байна.

Монголбанкнаас Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй ЖДҮ-ийн өнөөгийн хөгжил, тулгарч буй саад бэрхшээл болон санхүүжилтийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилгоор түүвэр судалгааг жил бүр, Улаанбаатар хот болон 21 аймаг дахь бизнес эрхлэгч нарын дунд явуулдаг. Энэхүү судалгааны 2018 оны тайланд нийт ЖДҮ эрхлэгчдийн 64.9 хувь нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа бол 11.1 хувь нь төвийн бүсэд, 8.8 хувь нь баруун бүсэд, 11.0 хувь нь хангайн бүсэд, 4.1 хувь нь зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна.


Зураг 6.2. ЖДҮ эрхлэгчдийн тоо



Эх үүсвэр: “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”, Монголбанк, 2018

ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй биш, олдоц бага бөгөөд арилжааны банкуудаас ихэвчлэн санхүүжилт авдаг байна. Санхүүжилтийн эх үүсвэр олдох боломжийг аймгаар ангилан харахад бусад аймагтай харьцуулахад Ховд болон Баянхонгор аймагт олдоц илүү доогуур түвшинд байна.

Зураг 6. 3. Санхүүжилтийн орчин



Эх үүсвэр: “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”, Монголбанк, 2018

Голчлон, ЖДҮ эрхлэгчид 1–5 жилийн хугацаатай 10–50 сая төгрөгийн санхүүжилт авах сонирхолтой байдаг байна. Мөн ЖДҮ эрхлэгчдэд макро эдийн засгийн орчны зүгээс валютын ханш болон инфляци, нийгэм орчны зүгээс ядуурал болон ажилгүйдэл, хуулийн орчны зүгээс хуулийн сул хэрэгжилт болон төрийн байгууллагын үйлчилгээ хамгийн их хүндрэл учруулдаг гэсэн хариултыг өгчээ.

Тулгарч буй асуудлууд

Гадаад орчны таагүй нөхцөл байдал, түүнээс үүдэлтэй дотоод эдийн засгийн хүндрэл, банкаас бусад санхүүгийн байгууллагуудын хөгжил сул байгаа нь ЖДҮ эрхлэгчид үйл ажиллагаагаа явуулахад бэрхшээл учруулж байна. Эдийн засгийн хүндрэлтэй байдал тэр дундаа төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн сулралт үргэлжилж түүхий эд, тоног төхөөрөмжийн зардлыг өсгөх, нөгөө талаас ажилгүйдэл нэмэгдэж хэрэглэгчдийн худалдан авах чадвар муудсанаар бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Бизнесийн орлого муудсанаар ААН-үүд эргэлтийн хөрөнгөөр дутагдах, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхэд хүндрэл учирч байна. Түүнчлэн үйлдвэрлэлээ өргөтгөх, хэвийн

үргэлжлүүлэхэд санхүүжилтийн бэрхшээл хамгийн ихээр тулгарч байна. ЖДҮ эрхлэгчдэд Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас олгож буй хөнгөлөлттэй зээл төдийлөн хүртээмжтэй биш, олдоц бага бөгөөд арилжааны банкуудын зээлийн нөхцөл хатуу, шалгуур өндөр байгаа нь санхүүжилтийн орчны гол бэрхшээл болж байна. Түүнчлэн банкны зээлийн хүү өндөр, хэмжээ бага, олгосон хугацаа нь бизнесийн үйл ажиллагаатай уялдахгүй байгаа нь найдваргүй зээлдэгч болох эрсдэлийг нэмэгдүүлэх, улмаар дахин зээл авахад хүндрэлтэй байгааг судалгаанд оролцогчид онцолж байна.

УИХ, Засгийн газрын зүгээс татварын таатай орчин бүрдүүлэх, санхүүжилтийн хүртээмжийг өсгөх, төрийн үйлчилгээг чирэгдэлгүй болгох, хуулийн орчныг сайжруулах болон авилгыг бууруулах шаардлага тулгарч байна. Тухайлбал:

- Төр, хувийн хэвшлийн харилцааг хууль, журмын хүрээнд явуулж, хүнд суртлыг бууруулах, авилгыг арилгах;
- Төсөл, хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах тэгш байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олгох үйл явцыг нээлттэй ил тод болгох, ажлын байрыг ихээр бий болгох, эдийн засгийг салбаруудад төрөлжүүлэх;
- Шинээр бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагааны эхний үе шатанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлж үйл ажиллагаа нь тогтворжсон үед татвар ногдуулах;
- Дотоодод үйлдвэрлэх бүрэн боломжтой хэдий ч импортоор авч хэрэглэдэг бараа, бүтээгдэхүүнүүдийн хувьд татварын болон бусад зохицуулалт арга хэмжээг авч хэрэгжүүлэн дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, дэмжих;
- Валютын ханшийн хэлбэлзлийг бууруулахад төрийн бодлого чиглэх шаардлагатай байна.

Түүхээс харахад, засгийн газрууд зээлийн схемийг ашиглан зээлийн эх үүсвэрийг тодорхой зорилтот хүн амд чиглүүлж ажилладаг байна. Гэвч энэ хандлага нь үргэлж хүссэн үр дүнд хүргэдэггүй. Засгийн газрын зарим хөтөлбөрүүд нь бичил санхүүгийн зах зээлийг улам доройтуулдаг. Гэсэн хэдий ч засгийн газрууд орлого багатай иргэдэд чиглэсэн санхүүгийн тогтолцоог бий болгоход чухал үүрэг гүйцэтгэдэг хэвээр байна. Туршлагатай донорууд нь санхүүгийн үйлчилгээг шууд үзүүлэхээс илүүтэйгээр бодлогын оновчтой бүтцийг бий болгох, бичил санхүүгийн орчинд өрсөлдөх чадвартай бичил санхүүгийн үйлчилгээг хөгжүүлэхэд анхаарлаа хандуулж байдаг.

ЗУРГАА. ЖДҮ–ЭЭР ТЭРГҮҮЛДЭГ УЛС ОРНУУДЫН ТУРШЛАГА

Сингапур Улс

Ажилгүйдлийн түвшин 2.1 хувь, нэг хүнд ногдох ДНБ нь ойролцоогоор 53,000 ам.доллартай тэнцэх Сингапурын эдийн засаг дэлхийн хамгийн хүчтэй эдийн засгуудын нэг болжээ. Энэ эдийн засаг нь нийт аж ахуйн нэгжүүдийнхээ 99 хувийг нь ЖДҮ–үүдээр бүрдүүлж, тэдгээрийн ажиллах хүч нь улсын нийт ажиллах хүчний гуравны хоёрыг буюу 65 хувийг эзэлдэг байна.

Сингапурын ЖДҮ–ийн танилцуулга

ЖДҮ–үүд нь Сингапурын эдийн засгийн маш чухал хэсэг юм. Ойролцоогоор 219,000 ЖДҮ 196.8 тэрбум сингапур долларын нэмүү өртгийг эдийн засагт оруулдаг. Үүнээс гадна сүүлийн 5 жилд тэдгээр нь ДНБ–ий тэн хагасыг бүрдүүлсэн юм. Дунджаар Сингапурын ЖДҮ эрхлэгчид тус бүр 10 ажилтантай байх бөгөөд эдийн засагтаа 900,000 Сингапур долларын нэмүү өртөг оруулж байна.

ЖДҮ–т тулгарч буй сорилтууд

Сингапурын эдийн засгийн гол тоглогчдын хувьд ЖДҮ нь сүүлийн жилүүдэд бэрхшээлтэй тулгарч байсан. Жишээлбэл, ЖДҮ–дэд ногдох дундаж үйлдвэрлэлийн хэмжээ 2013 оноос хойш 1 хувиар буурч, ЖДҮ–ийн дундаж хэмжээ 12 хувиар буурсан байна. Эдгээр тоон үзүүлэлтүүд нь сүүлийн жилүүдэд ЖДҮ эрхлэгчдийн дунд өрсөлдөөн их байгааг харуулж байна.

Том корпорацуудын хүч: Том бизнесүүд Сингапурын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг. Сингапурын бүх аж ахуйн нэгжүүдийн зөвхөн 1 хувийг бүрдүүлдэг эдгээр компаниуд нийт ажилчдын 35 хувийг эзэлж, эдийн засгийн нийт нэмүү өртгийн хагасыг бий болгодог. Эдгээр том, хүчирхэг корпорацууд жижиг бизнес эрхлэгчдийг оршин тогтноход хэцүү болгодог. Эдийн засгийн өсөлт удааширч, ЖДҮ–үүд эдийн засагт бага хувь нэмэр оруулж байгаа ч том корпорацууд өсөн нэмэгдсээр байгаа юм. Том компани бүрээс нэмэгдсэн өртгийн хэмжээ 2013 оноос хойш 8 хувиар өссөн байна.

Зардлын өсөлт: 2017 онд Сингапурын ЖДҮ–ийн 42 хувь нь зардлаа нэмэгдүүлсэн ба энэ нь тэдгээрийн бизнест ихээхэн хохирол учруулсан байна. Эдгээр зардлын өсөлт нь тэдгээрийн ажиллах хүчний зардлын өсөлтөөс хамаарсан юм. Инфляциас болж цалингийн түвшин тогтмол өссөөр байгаа юм. Энэ нь нэг үйлдвэрлэгчийн нэмүү өртгийг бууруулж, цаашлаад ашигтай ажиллахад илүү төвөгтэй болгож байна.

Санхүүгийн хүртээмжийн хязгаарлагдмал байдал: Саяхан хийгдсэн судалгаагаар Сингапурын ЖДҮ–ийн 5–аас 4 нь бизнесийн санхүүжилтийг авахад тэнцэхгүй гэж дүгнэгджээ. Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд Сингапурын ЖДҮ нь санхүүжилт олоход илүү бэрхшээлтэй байсан. 2017 онд ЖДҮ–ийн 18 хувь нь санхүүжилт авахад хялбар "олох боломжтой" (2014 оноос 30.9 хувиар буурсан) гэсэн бол, 2018 онд ЖДҮ–ийн 12.4 хувь нь санхүүжилт авахад хялбар "олох боломжтой" (2014 оноос 24.4 хувиар буурсан) гэжээ. Гэсэн хэдий ч Сингапурт олон нийтийг хамарсан сангуудыг бий болгосны улмаас санхүүжилтийн хүртээмж сайжирч байна. Crowdfunding платформ нь бизнес эрхлэгчид хөрөнгө оруулагчдын томоохон бүлгээс хөрөнгө босгох боломжийг олгодог.

ЖДҮ эрхлэгчдээ хэрхэн дэмждэг вэ?

ЖДҮ-ийн нэг цэгийн төвүүд: Эдгээр төвүүд нь ЖДҮ-дэд бизнесийн зөвлөгөө өгч, Засгийн газраас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл өгдөг. ЖДҮ-ийн төвүүдийг интернетийн сүлжээнд холбосон ба бизнесийн янз бүрийн үе шатанд ЖДҮ-д тохиромжтой, хэрэгцээтэй мэдээлэл, үйлчилгээг цахим хэлбэрээр мөн хүргэдэг байна.

Шинэ нэг цэгийн /Tech Depot/ төв нь ЖДҮ-ийн порталд 2017 оны хоёрдугаар улиралд нэмэгдсэн. Tech Depot нь A*STAR-ийн бэлэн болгох (RTG) технологи, мөн IMDA-ийн урьдчилан мэдэгдэх Infocomm and Media (ICM) шийдлүүдийг багтаасан хэрэглэхэд хялбар технологийн шийдэл юм. Уг төв нь бараа материалын бүртгэл, хөрөнгө хянах үйл явцыг сайжруулах, нийлүүлэлтийн гинжин хэлхээний менежмент, төлөвлөлтийн үйл явцыг сайжруулах асуудлаар компаниудад тусалдаг.

Чадавхыг нэмэгдүүлэх тусламж: SPRING's Capability Development Grant (CDG) нь ЖДҮ-ийг дэмжих, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бүтээмж, брэнд, маркетинг гэх мэт бизнесийн үйл ажиллагаан дахь 10 гол салбарын төслүүдийг шинэчлэн сайжруулахад дэмжлэг үзүүлдэг.

Компанийн чадварыг хөгжүүлэхэд хялбар болгох үүднээс 2017 онд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хөгжлийг бэхжүүлж, бага хэмжээний багцын үйлдвэрлэлд буцалтгүй тусламжийг нэмэгдүүлэх замаар үйлдвэрлэлийн эрт үе шаттай холбоотой эрсдэлийг бууруулах, ЖДҮ-ийн цар хүрээг нэмэгдүүлэхэд тусалж эхэлсэн.

Түншлэлийг бэхжүүлэх: Сингапурын эдийн засгийн идэвхтэй ЖДҮ-ийн тоо олон байгаа тул Засгийн газар зөвхөн бүх бизнесийг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэхгүй, ЖДҮ-д амжилттай ажиллахад нь түншлэл, хамтын ажиллагааг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагатай байдаг.

Сингапурын Худалдааны Ассоциацид чухал үүрэг гүйцэтгэж байгааг хүлээн зөвшөөрч, 40 орчим хөтөлбөрийг Орон нутгийн Үйлдвэрлэл, Холбоо Хөгжил (LEAD) хөтөлбөрөөр дамжуулан идэвхтэй явуулж байна. Тэд өөрсдийн гишүүдийг чадавхжуулах, олон улсын түвшинд дэмжих чиглэлийн төсөл дээр ажиллаж байна.

LEAD хөтөлбөр нь гишүүдээ илүү ихийг сургах, гишүүдийнхээ төлөө илүү ихийг хийхэд нь туслах чиглэлээр 2016–2020 оны төсвийг нийт 100 сая доллар хүртэл нэмэгдүүлсэн. Засгийн газар нь ЖДҮ-үүдийг дэмжиж, тэдний дотоод систем, үйл ажиллагааны процессыг сайжруулах, гишүүддээ дэмжлэг үзүүлэх төслүүдийг эхлүүлэхэд тусалдаг.

Загвар үйлдвэр: Үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, ЖДҮ-ийг дэвшилтэт үйлдвэрлэлийн шийдлүүдийг нутагшуулахын тулд Засгийн газар 2 "Загвар үйлдвэр"-ийг бий болгосон.

Загвар үйлдвэрүүд нь ЖДҮ-ийн орчинд шинэ технологиудыг сурах орчинд нь туршиж, бизнесийн үйл ажиллагаа, туршилтад нөлөөлөхгүйгээр үйлдвэрлэлийн процесст шинэлэг шийдлийг хөгжүүлэх боломжийг олгодог. Эхний загвар болох @SIMTech нь ЖДҮ-үүдэд дэвшилтэт технологийг гар аргаар ашиглах боломжийг олгодог.

Хоёр дахь загвар үйлдвэр @ARTC нь компаниуд өөрсдийн бүтээмжийг сайжруулахын тулд одоо байгаа үйлдвэрлэлийн процессуудтай ухаалаг, дижитал, дэвшилтэт технологийг нэгтгэх боломжийг олгодог.

Их Британи Улс

ЖДҮ нь Их Британийн эдийн засгийн чухал элемент юм. Их Британид 5.4 сая ЖДҮ үйл ажиллагаа явуулдаг ба тэдгээрт нийт 24.3 сая хүн ажилладаг. Мөн Их Британийн үйл ажиллагаа эрхлэгч

байгууллагуудын 99 хувийг ЖДҮ бүрдүүлдэг. Энэ үзүүлэлт нь нийт улсын ажиллах хүчний 60 хувь, улсын нийт бизнесийн орлогын 50 хувийг бүрдүүлж байна. Их Британийн Банкны зохицуулах байгууллага (the British Banking Authority)–ын мэдээлж байгаагаар тус улсын банкны бизнес жилд 2 тэрбум паундын орлого олдог ба ЖДҮ эрхлэгчдэд олгож байгаа зээл нь 90 тэрбум паунд орчимд байдаг байна.

Гэсэн хэдий ч ЖДҮ эрхлэгчдэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж маш том бэрхшээл болсон хэвээр байна. Тус улсад, дэлхийн санхүүгийн хямралаас болж ЖДҮ эрхлэгчдийн зээлийн үнэлгээг хийдэг банкуудын шийдвэр гаргах тогтолцоог устгаж илүү том байгууллагуудын үйл ажиллагааг дэмждэг болсноор энэхүү ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн асуудал хурцаар тавигдах болсон. Үндэсний эдийн засагт хувь нэмрээ оруулж байгаа пүүсүүдэд санхүүгийн тусламж үзүүлж, зээлийнхээ үр шимийг гаргахгүй байгаа пүүсүүдэд нэмэлт хөрөнгө олгохгүй байгаа нь ЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг хумиж байна.

Дэлхийн санхүүгийн хямрал нь жижиг бизнесийн зах зээлийн санхүүжилтийг маш ихээр өөрчилсөн. 2008 оноос хойш Их Британийн санхүүгийн зах зээл дэх уламжлалт хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкуудын ЖДҮ–дэд олгох зээлийн хэмжээ эрс буурсан байна. Дэлхийн санхүүгийн хямралын нөлөөгөөр ихэнх банкууд тайлангийн үзүүлэлтүүдээ шинэчилж, эрсдэл өндөртэй зээлийг багасгаж эхэлснээр жижиг пүүсүүдэд олгогдох зээлийн хэмжээ багассан юм. Гэхдээ 2008 оноос жижиг пүүсүүдийн санхүүжилтийн зах зээлд томоохон өөрчлөлт гарсан юм. Тэр нь жижиг бизнес эрхлэгчид олноор зах зээлд нэмэгдсэнээр peer-to-peer болон crowdfunding зэрэг зээлийн олон хувилбарыг бий болгоход хүргэсэн. Эдгээр санхүүгийн шинэ бүтээгдэхүүнийг шинэ пүүсүүдэд санал болгосноор ЖДҮ–ийн салбарт өрсөлдөөнийг нэмэгдүүлж, харьцангуй богинохон хугацаанд жижиг бизнесийн зээлийн зах зээлд бүтцийн өөрчлөлтийг хийсэн.

Хүснэгт 6.3. ЖДҮ–ийн санхүүжилтийн уламжлалт хэлбэр ба шинэ үеийн хэлбэрийн харьцуулалт

ААН–ийн хэлбэр	Санхүүжилтийн уламжлалт хэлбэр	Санхүүжилтийн шинэ үеийн хэлбэр
Старт–ап ба микро ААН /10–аас бага ажилтантай/	Найз нөхөд, гэр бүл, үүсгэн байгуулагч, кредит карт, хөрөнгө оруулалт	Өөрийн хөрөнгийн crowdfunding
Жижиг ААН /10–49 ажилтантай/	Банк, хөрөнгө оруулалт	Өөрийн хөрөнгийн crowdfunding, peer-to-peer зээлдэгчид
Дунд хэмжээний ААН /50–249 ажилтантай/	Банк, хөрөнгө оруулалт, өөрийн хөрөнгө, IPO	Өрсөлдөгч банкууд, өөрийн хөрөнгийн crowdfunding, peer-to-peer зээлдэгчид

Хүснэгт 3–т, Их Британи дахь ЖДҮ–ийн санхүүжилтийн шинэ түвшний хэлбэрүүдийг уламжлалт хэлбэртэй нь харьцуулан харуулж байна. ЖДҮ–ийн санхүүгийн зах зээл дэх шинэ санхүүжилтийн хэлбэрүүд нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, зарим зээл авах зардлыг бууруулж байна.

Санхүүжилтийн орчинд технологийн өөрчлөлтийн үр нөлөөг үнэлэхэд төвөгтэй хэдий ч технологийн дэвшил нь ЖДҮ–ийн санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх нь эргэлзээгүй. Технологийн өөрчлөлт нь ЖДҮ–ийн зах зээлд урт хугацааны бүтцийн нөлөөг үзүүлэх ба зах зээлд илүү оролцож буй финтек компаниудын тоо улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Одоогийн байдлаар Их Британид хамгийн хурдацтай хөгжиж байгаа бизнесүүд нь Crowdcube, Lending Circle гэх мэт шинэ финтек үйлчилгээ

үзүүлэгчид байгаа юм.

Одоогийн байдлаар Их Британийн олон томоохон банкууд нь нэлээд эртний IT системийг үйл ажиллагаандаа ашигладаг байна. Цаг хугацаа өнгөрөх тусам банкууд өөрсдийн технологийн дэд бүтцийг өөрчилснөөр тэдний шинэ системүүд хэрэглэгчдэдээ илүү хурдан үйлчилгээг үзүүлэх боломжтой болно.

Засгийн газрын дэмжлэг

Их Британид бизнес эрхлэлтийг дэмжих үндэсний стратеги гэж байхгүй хэдий ч эдийн засгийн гол салбаруудыг дэмжихийн тулд үндэсний болон бүс нутгийн санаачилгуудыг хэрэгжүүлдэг. Эдгээр санаачилгуудын зарим нь ЖДҮ (зөвхөн start-up-уудад ч биш)-д чиглэсэн байдаг ба хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бичил санхүүгийн байгууллагуудын үүрэг, оролцоо чухал байдаг. Тухайлбал,

Их Британийн бизнесийн банк (British business bank-BBB)

BBB нь 2012 онд ЖДҮ-ийн санхүүжилтийн асуудалд зөвлөгөө өгөх "Нэг цэгийн дэлгүүр"-ийг бий болгох зорилгоор байгуулагдсан төрийн өмчит хөгжлийн банк юм. BBB нь анх 2008 оны санхүүгийн их хямралын дараах асуудлуудыг арилгахын тулд 1.25 тэрбум паундын хөрөнгөтэйгөөр байгуулагдаж байсан. Энэхүү байгууллага нь ЖДҮ-д хэсэгчилсэн зээлийн баталгааг гаргаж өгөх зуучлагчийн үүргийг гүйцэтгэдэг. BBB нь жил бүр бизнесийн санхүүгийн гарын авлага хэвлэн нийлүүлдэг ба энэ нь бизнес эрхлэхэд зээл авах, олон нийтэд хувьцаагаа худалдах болон бусад дэмжлэгийн талаар мэдээллийг оруулдаг. 2016 онд BBB нь ЖДҮ-д тохирсон "Олон талт" санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн платформыг танилцуулсан. Их Британийн томоохон банкууд нь энэхүү платформд хандан зээл хүсэж буй ЖДҮ-д хандах боломжтой болсон.

Аж ахуйн нэгжийн санхүүгийн баталгааны сан (EFG)

Аж ахуйн нэгжийн санхүүгийн баталгааны сан (EFG)-г BBB үүсгэсэн ба энэ нь засгийн газраас бизнесийн үйл ажиллагаанд зориулан олгосон зээлийн 75%-г аюулгүй байлгах үүднээс батлан даасан баталгааны сан юм. EFG-д банкууд болон Их Британийн бичил санхүүгийн байгууллагуудаас зээл авсан бөөний худалдааны байгууллага болон EFG-ээр зөвшөөрөгдсөн зээлүүд хамардаг. Хамгийн сүүлийн үеийн байдлаар BBB нь бүс нутгийн санхүүжилтийн дараах сангуудыг гаргасан. Тухайлбал, Умардын эрчим хүчний хөрөнгө оруулалтын сан, Европын холбооны хуваарилалтыг зохицуулах бүтцийн сан зэрэг орно. Эдгээр сангууд нь бичил санхүүгийн байгууллага гэх мэт зуучлагчдаар дамжуулж жижиг бизнес эрхлэгчдийг хүрээгээ тэлэхэд нь зориулагдсан.

Start-up зээлийн компани (Start-up loans company-SULCO)

SULCO нь BBB-ийн эзэмшдэг хөтөлбөр бөгөөд 18 сар ба түүнээс доош хугацаагаар сургалтад хамрагдсан бизнесүүдэд зээл олгох хөтөлбөр юм. Start-up компаниуд нь арилжааны банкнаас санхүүжилт авахад маш их бэрхшээлтэй тулгардаг. Иймд эдгээр компаниудад бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан зээл олгох хөтөлбөр юм. Бичил бизнес эрхлэгчдэд 5 жил хүртэлх хугацаанд 25,000 паундыг жилийн 6%-ийн хүүтэйгээр олгох юм. Бизнес эрхлэгчдэд зээл олгох явцад зээлийн өмнөх дэмжлэг болон зөвлөгөөг өгдөг. 2012 онд нээгдсэнээс хойш 46,508 бизнес эрхлэгчдэд 301 сая паундын зээлийг олгожээ. Энэхүү засгийн газрын санхүүжүүлсэн хөтөлбөрийн хувьд 26 зуучлагч түнш, 15 бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулж санхүүгийн үйлчилгээг хүртэхгүй байгаа зах зээлийн сегментүүдэд энэхүү хөтөлбөрөө хүргэхийг эрмэлздэг.

Орон нутгийн үйлдвэрлэгчдийн түншлэл эдийн засгийн бүсүүд (Local enterprise partnerships–LEPs and economic zones)

LEPs нь томоохон хэмжээний газар нутгийг хамарсан эдийн засгийн төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлдэг орон нутгийн зөвлөлүүдийг багтаасан орон нутгийн эрх мэдэл бүхий байгууллагаар удирдуулдаг. LEPs нь орон нутгийн удирдлагуудад эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг нь тогтооход тусалдаг бизнесийг удирдсан санаачилгууд юм. Энэхүү түншлэл нь Европын бүтцийн хөрөнгө оруулалтын сан, бизнес эрчим хүч аж үйлдвэрийн хөгжлийн агентлагийн орон нутгийн өсөлтийн сангаас санхүүжигддэг. LPEs нь орон нутгийнхаа эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, орон нутгийн хөгжлийн сангаас төвлөрсөн санхүүжилт авах, тендерт оролцох боломжтой. LPEs нь ЖДҮ–ийг бичил санхүүгийн байгууллагуудаар дамжуулан санхүүжүүлэх зорилготой.

Бүс нутгийн өсөлтийн сан (The regional growth fund–RGF)

RGF нь 2010 онд бүс нутгийн эдийн засаг, төрийн секторыг ажил эрхлэлтийг дэмжих чиглэлээр 3.2 тэрбум паундын хөрөнгөтэйгөөр байгуулагдсан. 60 сая паундыг нь бичил санхүүгийн байгууллагын салбарт хуваарилсан. Энэхүү 60 сая паундын бичил санхүүгийн байгууллагын RGF төсөл амжилттай хэрэгжиж байна. 2016 оны эцэс гэхэд бичил санхүүгийн байгууллагууд нийтдээ 60 сая паундыг 2000 гаруй бизнес эрхлэгчдэд олгож 8000 ажлын байрыг бий болгожээ. Одоогоор бичил санхүүгийн байгууллагууд RGF сандаа эргүүлэн төлж байна. RGF хөтөлбөрийг зөвхөн Англи Улсад ашиглах боломжтой.

Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгсэл (Labour market instruments)

The New Enterprise Allowance (NIA) хөтөлбөр нь SULCO–той хамтран хэрэгжүүлдэг хувиараа бизнес эрхлэхийг хүссэн хүмүүст зөвлөгөө өгөх хөтөлбөр юм. Энэхүү хөтөлбөр нь Sulco–ын түншүүдэд зөвлөгөө өгч, санхүүгийн шууд дэмжлэг үзүүлж, 2500 паунд хүртэлх зээл олгодог.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, САНАЛ

Улс орнуудын эдийн засаг, нийгмийн хөгжилд ЖДҮ-ийн оруулах хувь нэмэр ямагт өндөр байсаар ирсэн. Гэсэн хэдий ч ЖДҮ-ийн санхүүжилтийн эх үүсвэр дутмаг, санхүүгийн хүртээмж хангалтгүй түвшинд хэвээр байна.

Эдийн засгийн өндөр хөгжил, зах зээлийн таатай нөхцөлөөс гадна ЖДҮ-ийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүй, зохицуулалтын орчин чухал нөлөөтэй бөгөөд бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагуудын анхааралдаа авах асуудал юм.

Дэлхийн ЖДҮ эрхлэгчдийн дунд хийгдсэн судалгаанаас үзэхэд ихэнх улс орнуудын хувьд ЖДҮ-ийн гол санхүүжилт нь бичил санхүүгийн байгууллагуудаас олгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээ байна. Харин манай улсын хувьд ЖДҮ эрхлэгчдэд голчлон арилжааны банкны үйлчилгээг ашиглан санхүүжилтийн асуудлаа шийддэг бөгөөд бизнесийн үйл ажиллагаа эрхлэхэд санхүүгийн үйлчилгээний өндөр хүү, хураамж, шимтгэл хамгийн том бэрхшээлийн нэг болдог байна.

ЖДҮ нь өндөр хөгжсөн улс орнуудын туршлагаас харахад санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх нь бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн асуудлыг шийдэхэд хамгийн үр дүнтэй бодлого юм. Мөн төрөөс шууд оролцох байдлаар ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжих бодлогыг олон улс орон хэрэгжүүлдэг ч хөгжиж буй орнуудын хувьд төдийлөн үр ашиг үзүүлж чаддаггүй байна.

Тоон мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн технологийг ашиглан зээлийн эрсдэлийг зардал багатайгаар үнэлэх, ЖДҮ эрхлэгчдэд зориулсан зээлийн батлан даалтын сан байгуулах, зээлийн үйлчилгээнээс гадна хөрөнгийн зах зээл, факторинг, санхүүгийн түрээсийн үйлчилгээ зэргийг бодлого, зохицуулалтаар дэмжих, иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг мэргэжлийн зөвлөгөөгөөр тогтмол хангаж байх зэрэг нь хамгийн түгээмэл бөгөөд амжилттай хэрэгждэг зохицуулалтын аргууд юм. Санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ өндөртэй манай улсын хувьд мөн мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан санхүүгийн зах зээлийн дэд бүтцээ хөгжүүлэх, мэдээллийн сан үүсгэх, альтернатив санхүүжилтийн хэрэгсэл болох банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хөгжлөө дэмжих зэрэг нь зайлшгүй хэрэгжүүлэх ёстой зорилтууд юм.

НАЙМ. ЭХ СУРВАЛЖ

IFC. “Scaling–Up SME Access To Financial Services in the Developing World”. 2010

IFC. “SME Finance Policy Guide”, 2011 CGAP, “Donor Brief The Role of Governments in Microfinance”. June 2004

ITIF. “International Benchmarking of Countries’ Policies and Programs Supporting SME Manufacturers”. 2011

Finnish Ministry of Trade and Industry. “High–Growth SME Support: Initiatives in Nine Countries: Analysis, Categorization, and Recommendations”. 2007

OECD. “Financing SME access to diversified financing instruments”. 2018

Zhanh Ziyu. “Financing Problems and Solutions of SMEs”. 2014

ADB. “Solutions for Small and Medium sized Enterprises’ Difficulties in Accessing Finance: Asian Experiences”. 2017


Thorsten Beck, Asli Demirguc Kunt, Maria Soledad Martinez Peria. “Banking SMEs around the world: Lending practices, business models, drivers and obstacles”. 2008

OECD. “New Approaches to SME and Entrepreneurship Financing: Broadening the Range of Instruments”. 2015

Монголбанк. “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”. 2016

Монголбанк. “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”. 2017

Монголбанк. “Жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал”. 2018





АВСТРАЛИ УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН РЕФОРМ

2018 он

Гүйцэтгэсэн: Б.Наранжаргал¹, А.Бадамсүрэн², Б.Батчимэг³,
А.Мөнгөнсаран⁴, Ц.Анударь⁵, Б.Дөлгөөн⁶

¹ Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн, naranjargal_b@frc.mn

² Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, badamsuren@frc.mn

³ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

⁴ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын ахлах мэргэжилтэн, mungunsaran@frc.mn

⁵ Хяналт шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгагч, anudari@frc.mn

⁶ Үнэт цаасны газрын мэргэжилтэн, dulguun_b@frc.mn

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 1980 оныг хүртэл чөлөөт бус, хаалттай, социалист дэглэмтэй эдийн засгийн тогтолцоотой байсан Австрали Улс хэрхэн эдийн засгийн тэргүүлэх чиглэл бүхий салбаруудад 1980, 1990, 2000–аад онуудад реформуудыг үе шаттайгаар хийснээр бүтээмжээ нэмэгдүүлж, 1991 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй 26 жил эдийн засгаа хөгжүүлж ирсэн түүхэн туршлагыг судаллаа.

Судалгаа дараах бүтэцтэй. Нэгдүгээр бүлэгт удиртгал, хоёрдугаар бүлэгт 1980 оноос өмнөх Австрали Улсын эдийн засгийн нөхцөл байдал, гуравдугаар бүлгээс арван нэгдүгээр бүлэг хүртэл төрийн салбар, төрийн өмчийн хувьчлал, зах зээлийн өрсөлдөөн, хөдөлмөрийн зах зээл, мөнгөний бодлого, сангийн бодлого, санхүүгийн зах зээл, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарын хүрээнд хийгдсэн реформууд, арван хоёрдугаар бүлэгт дүгнэлт бичигдсэн болно.

Түлхүүр үгс: Австрали Улс, реформ, хувьчлал, зохицуулалт

JEL ангилал: E4, E5, E6, N1, N2, N3, N4, N5, P3

НЭГ. 1980 ОНООС ӨМНӨХ АВСТРАЛИЙН ЭДИЙН ЗАСАГ

1980–аад оныг хүртэл Австрали Улсад чөлөөт зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй, социалист эдийн засгийн дэглэм ноёрхож байсан ба эрүүл мэнд, банк, боловсрол, харилцаа холбоо, тээвэр зэрэг гол салбаруудыг төр эзэмшиж, ажилчдын цалинг төрийн зохицуулалтаар тогтоож, гадаад худалдаа хангалттай нээлттэй бус, валютын тогтмол ханшийн дэглэмтэй байв.

1970–аад онд газрын тосны үнийн өсөлтөөс үүдэн дэлхийн эдийн засаг хямарч, Австрали Улсад эдийн засгийн уналт, экспортын бууралтын нөлөөтэй нийлүүлэлтийн шок, цалин болон засгийн газрын өндөр зардлын нөлөөтэй эрэлтийн шок үүссэн. Эдгээр шокуудын нөлөөгөөр Австралид стагфляци үүсэж, инфляци, болон ажилгүйдэл түүхэндээ хамгийн өндөр түвшинд хүрсэн бөгөөд Австралийн засгийн газар 1980–аад оноос эхлэн эдийн засгийн реформуудыг хийж эхэлжээ.

Тухайлбал, газрын тосны үнийн шок нь санхүүгийн салбарыг зохицуулахад тогтворгүй орчныг үүсгэж эхэлсэн бөгөөд 1983 онд Австрали Улс хөвөгч ханшийн дэглэмд шилжсэн. Хөвөгч ханшийн дэглэмд шилжсэнээр Австралийн эдийн засаг илүү уян хатан бодлогыг баримтлах суурь нөхцөл бүрдэж, гаднын банкныг нэвтрүүлэх, зээлийн хязгаарлалтуудаа сулруулах, тарифаа бууруулах, цалингийн зохицуулалтыг орхих зэрэг дараа дараагийн эдийн засгийн өөрчлөлтүүдийг хийх болсон. 1890–ээд онд үл хөдлөх хөрөнгийн хөөсрөлт бий болж, Австрали Улсын 11 арилжааны банк дампуурч, эдийн засгийн гүн хямралд орж байсан түүхтэй. Энэхүү хямралын улмаас засгийн газар нь гаднын банкуудыг зах зээлд нэвтрэхийг 100 жилийн туршид хориглож, засгийн газраас хяналт тавин хүүгийн түвшнийг тогтоож байв. Харин 1980 оноос эхлэн засгийн газар гаднын банкуудыг зах зээлд нэвтрэхийг зөвшөөрч, хүүгийн түвшний хязгаарлалтыг цуцлан банкуудаа хувьчилсан. Улмаар 1996 онд нөөцийн банканд мөнгөний бие даасан бодлого баримтлах эрхийг олгосноор өрсөлдөөнийг нэмэгдүүлж, санхүүгийн зах зээлийг илүү үр ашигтай ажиллахад түлхэц болсон.

1988 оноос эхлэн Австралийн Засгийн газар үйлдвэрлэгчдээ хамгаалах бодлогоо бууруулснаар аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчид зах зээлд үлдэхийн тулд үйл ажиллагаагаа сайжруулж, үнийн түвшнээ бууруулж эхэлснээр инфляци буурах болов.

1989 онд их сургуулиудын үнэ хэт өндөр байсан бөгөөд нийгмийн давхаргын ялгаа үүсэх эрсдэлээс сэргийлж Австралийн Засгийн газраас оюутны зээл олгох тогтолцоог хөгжүүлсэн. Ингэснээр оюутан суралцагчид сургалтын төлбөрийн хүүгүй зээл авч, ажилд орсны дараагаар цалингаас зээлийн эргэн төлөлтийг суутгуулах систем бий болов.

Дээрх үйл ажиллагаануудаас гадна төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг хувьчилж, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг сулруулан, татварын бодлогоо өөрчилсөн зэрэг эдийн засгийн реформуудыг хийж эхэлсэн.

Австралийн ДНБ–ий бүтцийг харьцуулан харвал 1977 оноос хойш уул уурхай, мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ, санхүү, үл хөдлөх хөрөнгийн бизнесийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаан зэрэг салбаруудын ДНБ–д эзлэх хувь өссөн бол аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь буурч байжээ.

Хүснэгт 7.1 Австралийн ДНБ, салбараар

	1977	1987	1997	2017
Хөдөө аж ахуй, загас барилт	4.8%	3.9%	3.7%	3.3%
Уул уурхай	4.4%	4.3%	5.5%	6.9%
Аж үйлдвэр	17.1%	14.5%	12.2%	6.9%
Цахилгаан, цэвэр, бохир усны үйлчилгээ	4.1%	4.7%	4.2%	2.9%
Барилга	9.3%	7.8%	7.0%	8.7%
Бөөний болон жижиглэн худалдаа	11.3%	9.7%	9.7%	10.3%
Байр сууц, хүнсний үйлчилгээ	3.5%	3.2%	3.2%	2.9%
Тээвэр, агуулахын үйлчилгээ	5.2%	5.7%	5.9%	5.7%
Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээ	1.1%	1.6%	2.6%	3.2%
Санхүү, үл хөдлөх хөрөнгийн бизнесийн үйлчилгээ	8.0%	10.6%	11.8%	14.0%
Төрийн удирдлага	11.2%	11.5%	11.2%	10.2%
Боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны үйлчилгээ	16.3%	18.9%	19.5%	22.1%
Бусад	3.9%	3.7%	3.6%	3.0%

Эх сурвалж: Австралийн статистикийн хороо


Австралийн эдийн засаг 1961 оноос хойш 1983, 1991 онд уналттай байсан бөгөөд эдгээр үеүдэд эдийн засаг 2.2 болон 0.4 хувиар тус тус буурч байсан. 1970–аад онд бүтээмж өсөөгүй хэдий ч бодит цалингийн түвшин өссөнөөр инфляци болон ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байв. Үүний үр дүнд ДНБ–ий өсөлт удааширсан.

1960, 1970, 1980–аад оны эхэн үеүдэд Австралийн эдийн засаг нь чанга зохицуулалттай, төрийн өмчит монополь салбарууд ноёрхсон, бүтээмж, өсөлтийн түвшин доогуур эдийн засагтай байсан гэж судлаачид үздэг. 1980, 1990–ээд оноос хэрэгжүүлж эхэлсэн реформуудын үр дүнд Австралийн эдийн засаг илүү нээлттэй, уян хатан, өндөр бүтээмжтэй болсоор иржээ.

Эдийн засагт хийгдсэн реформуудын үр дүнд Австралийн бүтээмж нэмэгдэн улсын эдийн засаг 1991 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй 26 жил өсөлттэй байна. 1960 оноос хойш эдийн засгийн өсөлтийн динамикийг 10 жилийн интервалаар харвал дундаж өсөлт буурах хандлагатай байгаа хэдий ч, өсөлтийн хэлбэлзэл буурсан. Өөрөөр хэлбэл Австралийн эдийн засаг илүү тогтворжиж эхэлсэн. 2000 оноос хойш сүүлийн 16 жилийн өсөлтийн түвшин нь өмнөх жилүүдтэй харьцуулахад илүү тогтвортой байгаа юм.

Нэг хүнд ногдох ДНБ–ий өсөлтийг бүтээмжийн өсөлттэй холбож тайлбарладаг бөгөөд 1980–аад оны үед Австралийн бүтээмжийн үзүүлэлт Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ОЕСД)–ын гишүүн орнуудтай харьцуулахад нэлээд доогуур байсан бол 1990–ээд оноос эхлэн бүтээмжийн үзүүлэлтээрээ дээгүүрт жагсаж, 1990–ээд оны 2 дугаар хагас гэхэд Австрали Улсын нэг хүнд ногдох орлогын түвшин өсөж эхэлжээ.

Зураг 7. 1. ДНБ-ий өсөлт




Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

1950 онд Австрали Улс нэг хүнд ногдох ДНБ-ий үзүүлэлтээр дэлхийд 4-т жагсаж байсан бол 1983 онд ухарч 14-т орсон. Харин 2008 онд 5 дугаар байр хүртэл урагшилж, улмаар 2016 оны байдлаар 10 дугаар байранд бичигдэж байв.

Австрали Улсын нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 1960 онд 1,809 доллар байсан бол 1980 онд 10,202 доллар, 2000 онд 21,691 доллар, 2013 онд хамгийн өндөр буюу 67,792 доллар байсан. 2016 оны байдлаар уг үзүүлэлт хэмжээ 49,927 доллар байна.

Зураг 7. 2. Нэг хүнд ногдох ДНБ



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

ХОЁР. ТӨРИЙН САЛБАР

1980–аад оноос 2010–аад он хүртэлх Австралийн төрийн реформ нь менежериализм, төрийн шинэ менежмент, төр төвтэй засаглал гэсэн үе шатуудад хуваагдана.

Хүснэгт 7. 2. Төрийн салбарын реформ

Реформын хамрах хүрээ	Менежериализм (1980–аад)	Төрийн шинэ менежмент (1990–ээд)	Төр төвтэй засаглал (2000–аад)
Үндсэн ойлголт	Хувийн хэвшилд тулгуурласан менежмент	Зах зээл	Уялдааг хангах/ coordination/
Төрийн үндсэн үйлчилгээнд төвлөрсөн реформ	Санхүүгийн удирдлагыг сайжруулах	Аутсорсинг хийх	Нэгдсэн Засгийн газрыг байгуулах ¹
Төрийн сектороос бусад салбарт төвлөрсөн реформ	Төрийн өмчит болон бусад компаниудын Корпорацчилал ²	Хувьчлал	Компанийн засаглалыг оновчтой болгох
Ерөнхий хандлага	Үр дүнгийн менежментийн чиг хандлагыг өөрчлөх	Шилжүүлэх, хуваах	Нэгтгэх, бэхжүүлэх
Төр–хувийн хэвшлийн хандлага	Хувийн хэвшлийн арга барилыг оруулж ирэх	Хөрөнгө болон чиг үүргийг экспортлох	Төрийн салбарыг засаглалын төв болгон шинэчлэх
Олон нийтийн оролцоо	Төрийн үйлчилгээний зардал болон уялдаа холбоог дахин үнэлэх	Хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээ	Иргэнд төвлөрсөн бодлого, үйлчилгээ

Менежериализм

1980–аад онд хийгдсэн реформын эхэн үед уламжлалт удирдлагын тогтолцоог шинэчилж төрийн салбарт тулгуурласан менежментийг хэрэгжүүлж эхлэв. Энэхүү менежментийн тогтолцоо нь аливаа ажлын орц болон гол үйл ажиллагаанд бус үр дүн, гүйцэтгэлд ач холбогдол өгөх, мөн санхүүгийн менежментийг сайжруулахад чиглэж байв. Тухайн үед Санхүүгийн менежментийг сайжруулах хөтөлбөр хэрэгжиж, үндсэндээ ашигт ажиллагааг нэмэгдүүлэх¹, төвлөрлийг бууруулах, мөн дээд түвшин дэх төрийн үйлчилгээ, санхүүгийн удирдлагыг сайжруулахад эхний ээлжинд анхаарч, түүний дараагаар төрийн өмчийг олон нийтийн оролцоотой болгох, мөн хувьчлалын асуудалд төвлөрч байв. Реформын гол элемент нь төрийн хэвшлийн үйл ажиллагааг илүү бизнес төвтэй болгох байсан.

Төрийн шинэ менежмент (NPM²)

1990–ээд оны Нео–либерал эдийн засгийн реформын амлалтууд төрийн үйлчилгээг илүү төвлөрсөн бус, зах зээлжсэн, гэрээ хэлэлцээрт тулгуурласан, мөн хувьчлагдсан хэлбэр лүү хөтөлсөн. 1980–аад оны дунд үед хамтын нөхөрлөлийн нийгэмлэг болон мужууд зах зээл дэх өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор төр болон бизнесийн секторын өрсөлдөөнийг саармагжуулан, төрийн эзэмшлийн монополь аж ахуйн нэгжүүдэд бүтцийн өөрчлөлтийг хийхээр тохиролцож байв. Улмаар 1990–ээд оны дунд үе гэхэд Австралийн төрийн үйлчилгээнд дахин шилжилт хийгдсэн нь цаашид реформыг

1 commercialization

2 New public management

улам эрчимжүүлэх хүч болсон юм. Хоёр дахь шинэчлэлт нь өрсөлдөөн, өрсөлдөх чадвар, төр хувийн хэвшлийн гэрээ хэлцэл, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах, үндсэн бизнесийн чиглэлүүд зэрэг асуудлуудад чиглэсэн юм.

Төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлж, хувийн хэвшил дэх бизнесийн арга барилыг төрийн үйлчилгээнд нэвтрүүлснээр төр болон хувийн хэвшлийн хамтын хариуцлагын тогтолцоог бий болгож, төвлөрлийг сааруулан, төрийн үйлчилгээний өрсөлдөх чадварыг сайжруулсан. Төр болон хувийн хэвшлийн түншлэл улсын түвшинд, ялангуяа хурдны зам зэрэг дэд бүтцийн болон цэвэршүүлэх үйлдвэр, сургууль зэрэг бусад салбарт мөн хүчээ авах болсон.

Түүнчлэн эдгээрээс гадна төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг олон нийтэд нээлттэй болгох, хувьчлах үйл ажиллагааг өрнүүлсэн нь хамгийн томоохон өөрчлөлт, шинэчлэлийг бий болгоод зогсохгүй, цаашлаад өрсөлдөөнийг нэмэгдүүлэх, төсвийн зардлыг бууруулах, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үндэс суурийг тавьсан. Нийт хувьчлалын хүрээнд банкны, агаарын болон харилцаа холбооны салбарын хувьчлал томоохон хувийг эзэлж байсан ба олон улстай харьцуулахад улс төрийн болон эдийн засгийн хувьд амжилттай хэрэгжсэн.

1999–2000 онд нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурийг төсвийн тооцоололд бүрэн нэвтрүүлж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнаж, мөн салбар агентлагууд төсвийн тайлагнах процессыг хэрэгжүүлж эхэлсэн. Ийнхүү төв агентлагийн хариуцлагыг түүний салбар нэгжүүдэд шилжүүлсэн нь төв агентлагийн үүргийг бууруулах, үр ашигтай тайлагнах хэлбэрийг бүрдүүлэхэд өндөр ач холбогдолтой байсан юм.

Төр төвтэй засаглал

Энэхүү үе шат нь 2000–аад оноос эхэлсэн бөгөөд засаглалын үндсэн асуудлуудыг нэгтгэсэн дөрвөн арга хэмжээг зохион байгуулсан: төв агентлагийн яамдад шууд нөлөөлөх голлох үүргийг сэргээсэн; Засгийн газрын байгууллагуудын хамтын ажиллагаа, холбоо хамаарлыг сайжруулан Нэгдсэн засгийн газрыг байгуулсан; агентлагийн хэрэгжилт, үйлчилгээг хянах төв байгууллагыг байгуулсан; мөн агентлагийн бүтэц зохион байгуулалтыг нэгтгэж, цомхотгосон. Commonwealth буюу Хамтын нөхөрлөл систем дэх төвлөрсөн чиг хандлага нь тодорхой бодлогын салбаруудад мөн ажиглагдаж байв. Эдгээр нь улмаар нэгдмэл засаглалын суурийг бий болгосон.

Улс төрийн хяналтыг сайжруулах хүрээнд сайд нарын санхүүгийн мэдээллийг сайжруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх; Засгийн газрын стратегийн уялдаа холбоог илүү анхаарах; бодлогын гол асуудлуудыг хянах; агентлаг, байгууллагуудыг оновчтой болгох, интеграцчилах; төрийн бодлогыг хүргэх, хэрэгжүүлэхэд хяналт тавих зэрэг арга хэмжээнүүдийг мөн хэрэгжүүлж ажиллажээ.

1980–аад онд яамдыг удирдлагыг хэрэгжүүлэх болон бодлогын зөвлөгөө өгөхийг шаарддаг байсан бол 2000–аад оны дунд үеэс үр ашигтай бодлогын биелэлтийг хангах, түүнийг хүргэх, үр дүнг хэмжихийг шаарддаг болов. Яамдын засаглалыг тодорхойлохдоо хууль эрхзүйн хүрээнд салангид байсан зарим яамдын үйл ажиллагааг нэгтгэх, хосолсон удирдлагыг бий болгох арга хэмжээг авч байв.

Төрийн секторын засаглал

Системийн засаглал гэдэг нь засгийн газарт төвлөрсөн төрийн секторын засаглалд хамаарах бөгөөд яамдын болон захиргааны засаглалд үндэслэдэг. Энэ нь ихэвчлэн төрийн секторууд хоорондын үйл ажиллагааг хамарсан систем бөгөөд засгийн газрын үндсэн гол цөмийг бүрдүүлэгч мэргэжлийн

агентлагуудад чухал нөлөөтэй байдаг. Төрийн секторт босоо хэлбэрийн шатлалт харилцааны систем үйлчилдэг ч, хэвтээ шатлалт харилцааны системийг ч мөн дагаж мөрдөх шаардлагатай байдаг. Гэвч энэхүү хэвтээ болон босоо хэлбэрийн шатлалт харилцааг зохицуулах систем нь төрийн бусад секторуудын хувьд үйлчлэхдээ хэт төвөгтэй болж ирдэг. Эдгээр харилцаа нь улс төрийн гүйцэтгэх засаглалын хэв маяг, хувьсан өөрчлөгдөж буй орчинд тавих шаардлага, хариу үйлчлэлээс хамаарч өөр өөр байдаг. Төрийн захиргааны системийн засаглал нь төв агентлагууд, мөн мэдээж улс төрийн гүйцэтгэх засаглал дээр төвлөрдөг.

Системийн засаглалын арга хэрэгсэл удаан хугацааны туршид засгийн газрын бүтэц зохион байгуулалтын нэгэн хэсэг байсаар ирсэн. Улс төрийн гүйцэтгэх засаглал нь ерөнхий сайд болон ерөнхий сайдын хувийн алба, засгийн газар, засгийн газрын хорооны тогтолцоо, сайдууд болон тэдний зөвлөхүүдээс бүрддэг. Төрийн үйлчилгээний хувьд гол байгууллагууд нь төв агентлагууд (Ерөнхий сайдын тэнхим болон засгийн газар, Сангийн яам, Санхүүгийн тэнхим болон Австралийн төрийн үйлчилгээний хороо) болон төрийн үйлчилгээний газрууд юм.

Төрийн үйлчилгээнд гол үүрэг гүйцэтгэх байгууллагуудын хувьд, төв агентлагууд засгийн газрын бүхий л үйл ажиллагаа болон системийн үүргийг гүйцэтгэдэг. Үүнд, Ерөнхий сайдын алба болон засгийн газар нь бодлого баримтлах чиглэлээр, Сангийн яам эдийн засгийн бодлогын чиглэлээр, Санхүү зохицуулалтын алба нь санхүүгийн удирдлагын чиглэлээр, мөн Австралийн Төрийн Үйлчилгээний Хороо нь хүмүүн капиталын удирдлагын чиглэлээр тус тус хариуцан үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр нь бүгд өвөрмөц, бие даасан байгууллагууд бөгөөд засгийн газрын бүтцийн байгууллагууд, ерөнхий сайдын алба, болон засгийн газрын удирдлага дор байна. Мөн системийн хувьд үүрэг хариуцлагаараа чухал ач холбогдолтой бас нэгэн байгууллага нь Өмгөөлөгчийн ерөнхий газар юм.

Засгийн газрын механизмын хамгийн чухал бүтцийн өөрчлөлт нь 1987 онд тэр үеийн Засгийн газрын эдийн засгийн бичил шинэчлэлийн хөтөлбөрийн гол элемент болж байсан юм. Бүтцийн өөрчлөлт нь Гадаад Харилцаа, Худалдаа зэрэг эдийн засгийн чухал ач холбогдолтой онцгой салбаруудыг нэгтгэн "мега" газрыг (mega – department) бий болгох юм.

Улс төрийн гүйцэтгэх засаглал болон төрийн үйлчилгээ хоорондын харилцаа хамаарал

Сайд нарын зөвлөхийг томилох замаар сайдуудын нөлөө, нөөцийг улам бэхжүүлж мөн төрийн удирдах албан тушаалтнуудын томилгоо, томилогдох хугацаанд өөрчлөлт оруулсан. 1980 оноос өмнө Бюрокраси ноёрхож байсан бол, 1983 – 1996 оны засгийн үед шинэчлэл хийгдэж, улмаар 1996 – 2007 онд Ховардын засгийн газрын үед засгийн газрын нөлөө улам багасаж хувийн секторын нөлөө улам бэхжиж эхэлж байв. Харин 2007–2010 оны хоорондын Рудын засгийн үед гүйцэтгэлийн шаардлагыг эрчимжүүлж, харилцааны асуудлуудыг шийдвэрлэхийг эрэлхийлсэн.

1984 онд төрийн нарийн бичгийн даргыг тодорхой заасан хугацаагаар томилох шийдвэр гарч 1994 оноос хэрэгжиж эхэлсэн. Дараагийн шатанд 1996 оноос төрийн нарийн бичгийн дарга нарт гүйцэтгэлийн хяналтыг тавьж үнэлгээ хийж байхаар тогтсон ч Рудын засгийн газар гүйцэтгэлд суурилсан нэмэлт бонус нь төрийн нарийн бичгийн даргын зан төлөвт нөлөө үзүүлэх төлөвтэй гэж үзэн нэмэлт урамшуулал олгохыг болиулсан байна.

Төв удирдлага ба зохицуулалт

Засгийн удирдлага илүү нарийн төвөгтэй, бэрхшээлтэй, олон нөлөөнд автах болсноор төвийн удирдлага, зохицуулалт ноёрхох болов. Төвийн удирдлага нь хэд хэдэн үүрэг, механизмтай байх

бөгөөд манлайллын хэв маяг, байгаль орчны тулгамдсан асуудлууд, болон нөхцөл байдалд тулгуурлан үүрэг хариуцлагыг тодорхойлдог байсан. Австрали нь ерөнхий сайдын албыг чухалчлан авч үздэг бөгөөд улс төрийн гүйцэтгэх албан тушаалтнуудын нөөцийг нэмэгдүүлэх ажиллах тал дээр анхаарлаа хандуулдаг байв. Реформ хийгдэх үеэр хэд хэдэн загварын хандлага ажиглагдаж байсан бөгөөд тэдгээр загваруудын урт хугацааны чиг хандлага нь төвийн удирдлагыг бэхжүүлэх, цаашлаад улс төрийн манлайлал нь илүү стратегийн, засгийн газар хоорондын, гүйцэтгэлд суурилсан төлөвтэй болж байлаа.

Харилцаа холбоо нь төв засгийн газарт төвлөрсөн, эсхүл мужуудын засгийн газар болон төрийн бус байгууллага зэрэг гуравдагч байгууллагуудыг хамарсан, эсхүл улс төрийн болон захиргааны механизмыг ашигласан эсэхэд үндэслэж төвийн зохицуулалтын стратегийг тодорхойлох 4 загварыг ялган авч үзжээ.

Шаталсан загвар (hierarchical model) нь хууль тогтоомж, дүрэм журам, шатлал, санхүүгийн болон боловсон хүчний гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг хянах замаар уламжлалт төрийн удирдлагад тулгуурладаг. Шилжих загвар (devolved model) нь менежментийн эсвэл зах зээлд тулгуурласан бүтээгдэхүүн гэж тооцогддог бөгөөд төвлөрлийг сааруулах зорилготой загвар юм. Гурав дахь загвар болох төр төвтэй засаглал нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй яамдын удирдлагад тулгуурладаг байна. Дөрөв дэх загвар нь стратегийн төлөвлөлт, тэргүүлэх чиглэлийг тогтоож, ерөнхий сайд болон түүний алба гол удирдлагын түвшинд үйл ажиллагаагаа явуулах бөгөөд гол салбаруудад чадварлаг тохирсон сайдуудыг томилох замаар хэрэгжинэ.

Төвийн удирдлагын зарчим нь 20 жилийн туршид эдгээр 4 загварын хэв шинжийг агуулсаар иржээ.

Гүйцэтгэлийг удирдах систем

Австралийн гүйцэтгэлийн удирдлагын систем нь хэд хэдэн үе шатлалыг дамжсан. Эхэн үед төвлөрсөн хандлагын хүрээнд Сангийн яамтай хамтарсан хүрээнд хөгжиж байсан бол хоёрдугаар шатанд гүйцэтгэлийн мэдээлэл болон албан ёсны шаардлагуудад бус зарчим, үр дүнгийн тогтолцоонд суурилж байв. Засгийн газрын харьяа үйл ажиллагаа явуулах албууд мөн агентлагууд өөрсдийн хүрэх үр дүнг тодорхойлж, түүний хүрээнд хариуцлага хүлээх тогтолцоонд шилжсэн.

Шинэ тогтолцооны бий болсноор мэдээллийн бааз болон урамшууллын тогтолцоо илүү сайжирч, байгууллагуудын нийгэмд оруулах хувь нэмрийн үнэ цэнэ илүү нэмэгдэж, мөн анх удаа үр дүнг гарцтай холбосон нь ашиг тусаа өгсөн юм.

Сангийн яам засгийн газрын хэрэгцээ шаардлагыг хангахад уг тогтолцооны үр ашигтай байдалд үнэлгээ хийж, мөн системийн санхүүгийн менежмент болон мэдээллийг хянах үүрэг, чадавхаа бэхжүүлэн ажиллаж байв.

Засгийн газрын багц / Government portfolio /

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд нь хараат бус, ил тод бус засаглалтай байсан тул засаглалыг сайжруулах хүрээнд ерөнхий сайдын шууд удирдлага дор орж, гүйцэтгэлээ ил тод тайлагнах болж, улмаар үр дүнтэй үйл ажиллагаа явуулахад яамдын сайдууд, төрийн албан хаагчид, удирдах зөвлөл хоорондын харилцаа хамаарал, зорилго, эрх мэдэл, үүрэг хариуцлагыг маш тодорхой зааж өгсөн. Сайн засаглал нь эрх мэдлийн ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, тайлагнал зэргээс хамаардаг. Эдгээрийг хэрэгжүүлэх нэг гол үндэс нь departmentalization буюу тогтолцоог өөрчлөх үйл явц байсан. Үүний хүрээнд үйл ажиллагаанаас хараат бус удирдах зөвлөлийг үүсгэн байгуулж, хяналтыг

нэмэгдүүлсэн юм.

Цаашлаад илүү иж бүрэн Засгийн газрын департамент³ –ийг нэвтрүүлж эхэлсэн бөгөөд энэ нь багцын менежмент гэгддэг байв. Үүний нэгэн жишээ нь төрийн сангийн багц бөгөөд үүнд Австралийн статистикийн хороо, Австралийн татварын алба, Үнэт цаасны хороо зэрэг багтаж байв.

2017 оны байдлаар засгийн газрын агентлагууд чиг үүргийнхээ хүрээнд 19 багцад хуваагдана. Засгийн газрын харьяалалд 18 department буюу алба байдаг бөгөөд алба бүр нэг багцад харьяалагдаж, мөн агентлагууд бүр чиг үүргийнхээ хүрээнд багцуудад харьяалагдана. Cabinet буюу сайдуудын зөвлөл гэж байдаг бөгөөд сайдууд чиг үүргийнхээ хүрээнд багцуудыг хариуцаж ажилладаг.

Бүтээмжийн хороо

Бүтээмжийн хороо нь Тарифын зөвлөл (Tariff board)–ийн чиг үүрэг дээр Аж үйлдвэрийн хороо (the Industry Commission), Аж үйлдвэрийн эдийн засгийн товчоо (Bureau of Industry Economics), Эдийн засгийн төлөвлөлтийн зөвлөлх хороо (the Economic Planning Advisory Commission) зэрэг агентлагуудын чиг үүргийг нэгтгэн, 1998 онд Парламентын тогтоолоор бие даасан эрх мэдэл бүхий байгууллага болж байгуулагдсан.

Бүтээмжийн хороо нь зөвлөлх чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд засгийн газрын хөтөлбөрүүдийг удирдах, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэггүй, харин өөрийн дүн шинжилгээ, саналд үндэслэн чанартай, бие даасан зөвлөгөөг өгдөг Сангийн яамны харьяа Засгийн газрын агентлаг юм. Түүний үйл ажиллагаа нь засгийн газрын бүх түвшин, эдийн засгийн бүх салбар болон нийгэм байгаль орчны бүхий л асуудлыг хамардаг.

Түүхэн замнал:

Одоогийн Бүтээмжийн хороо нь өмнөх агентлагуудын чухал шинж чанаруудыг агуулсан байдаг боловч чиг үүрэг, хамрах асуудал зэрэг нь бусдаасаа ихээхэн ялгаатай. Хороо нь өмнөх үеэс илүү нээлттэй, өрсөлдөөнийг дэмжсэн бодлого хэрэгжүүлж эхэлсэн. Дээр дурдсан байгууллагуудын хэрэгжүүлж байсан чиг үүргийг авч үзвэл:

Тарифын зөвлөл (Tariff board)–1921

Тарифын зөвлөл нь 1921 оны Тарифын зөвлөлийн тухай хуулийн дагуу Хамтын нөхөрлөлийн засгийн газарт импортыг орлох дотоодын салбаруудад зөвлөгөө өгөх зорилгоор байгуулагдсан. Энэ байгууллага нь олон улсын хэмжээнд худалдаалагдах бараа, ажил үйлчилгээний татвар, татаасын талаар зөвлөгөө өгөхөөс гадна, худалдаанд тулгарах зарим саад бэрхшээлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд зөвлөгөө өгдөг байв. Зөвлөлийн анхны гишүүд нь үйлдвэрлэгч, импортлогч, төрийн албан хаагчид байсан ба хагас цагаар ажилладаг байв.

Аж үйлдвэрийн тусламжийн хороо (the Industries assistance commission)–1974

1973 оны 12 дугаар сарын 11–нд Аж үйлдвэрийн тусламжийн хороо /IAC/–ны тухай хууль батлагдаж 1974 оны 1 дүгээр сарын 1–ний өдрөөс Аж үйлдвэрийн тусламжийн хороо үйл ажиллагаагаа явуулж эхэлжээ. Тус байгууллагын чиг үүрэг нь Засгийн газрын зүгээс аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд үзүүлэх туслалцааны талаарх мэдээллийг судлах байв.

Аж үйлдвэрийн тусламжийн хорооны зохион байгуулалтын бүтэц нь хэд хэдэн салбар, хэлтсүүдээс бүрддэг. Жишээлбэл, Салбарын эдийн засгийн хэлтэс /Industry Economics Division/ нь эдийн засгийн

3 Ministerial department

болон эмпирик шинжилгээг дагнан хийдэг. Тусламжийн үнэлгээ, хөгжлийн хэлтэс /The Assistance Evaluation and Development Division/ нь үйл ажиллагааны бүтэц, түүний үр нөлөөний талаар өргөн хүрээтэй судалгаа хийж жилийн тайланг гаргадаг. IAC-ын төв оффис нь Канберрад байрладаг ч Сидней, Мельбурнд салбар, хэлтсүүд нь байрладаг байна.

Зураг 7.3. Аж үйлдвэрийн тусламжийн хорооны бүтэц



Аж үйлдвэрийн хороо (the Industry Commission)–1990

Аж үйлдвэрийн хороо нь 1990 оны 1 дүгээр сарын 17–ны өдөр Аж үйлдвэрийн хорооны тухай хууль батлагдсанаар албан ёсоор үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Ингэхдээ муж хоорондын хороо (the Inter-State Commission) болон Бизнесийн зохицуулалтын нэгж (the Business Regulation Review Unit)–ийн үүргийг өөрийн үйл ажиллагаандаа шингээсэн. Тус хороо нь аливаа асуудлын нийгэм болон байгаль орчны үр дагаврын талаар судалдаг байсан тул Аж үйлдвэрийн тусламжийн хорооноос илүү өргөн хүрээтэй асуудлуудыг авч үздэг байв. Мөн зөвхөн аж үйлдвэрийн салбар төдийгүй Төрийн маркетингийн корпорац, хот төлөвлөлт, тээвэр, нийтийн орон сууц, ажилчдын нөхөн олговор, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, буяны байгууллага, батлан хамгаалахын үйл ажиллагааг ч мөн судалдаг байсны зэрэгцээ, 1995 онд батлагдсан Үндэсний өрсөлдөөний бодлого (National competition policy)–ыг боловсруулахад холбогдох судалгааг хийж байжээ. Аж үйлдвэрийн хорооны бүтцийг доорх зураглалд харууллаа.

Зураг 7. 4. Аж үйлдвэрийн хорооны бүтэц, 1995 он



Бүтээмжийн хороо (Productivity commission)–1998

Бүтээмжийн хороо нь 1998 оноос өмнө үйл ажиллагаа явуулж байсан байгууллагуудын чиг үүргийг нэгтгэж, мөн илүү өргөн хүрээтэй асуудлуудыг чухалчлах болов. Хороо нь илүү үр ашигтай, өндөр бүтээмжтэй эдийн засгийг бий болгохын тулд амьжиргааны түвшин буюу микро эдийн засгийн үзүүлэлтэд илүү анхаарч эхлэв. Түүнчлэн, эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахаас гадна нийгэм, байгаль орчин, эдийн засгийн харилцан хамаарлын асуудлыг хамарсан судалгаа, зөвлөмжийг гаргаж байлаа. Австралийн эдийн засаг нь бүтээмжийн өсөлтийг нэмэгдүүлж, микро эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлж, төсөв, мөнгөний бодлогын оновчтой тогтолцоог бий болгоход чиглэн эдийн засгийн бүхий л салбарын харилцаа холбоог сайжруулж, холбогдох судалгааг илүү өргөн хүрээтэй хийхэд анхаарлаа хандуулж ажиллаж байсан.

Хорооны үндсэн чиг үүрэг нь:

- Эдийн засаг, нийгэмд чиглэсэн дунд болон урт хугацааны бодлоготой холбоотой гарах асуудлыг судлах, судалгаа хийхтэй холбоотой туслалцаа үзүүлэх, эдгээр асуудлаар сайд нарт мэдээлэл, зөвлөгөө өгөх;
- Эдийн засаг, нийгмийн асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, дэмжих;
- Сайд нарын хүсэлтээр эдийн засаг, нийгмийн асуудлаар тусгай төсөл хэрэгжүүлэх;
- Хамтын нөхөрлөлийн жилийн төсвийг бэлтгэхтэй холбогдуулан аж үйлдвэрийн салбарын оролцогчид, үйлдвэрчний эвлэл, орон нутгийн иргэдийн үзэл бодлыг сайд нарт мэдээлэх;
- Сайдын хүсэлтээр эдийн засаг, нийгмийн дунд, урт хугацааны бодлогын асуудлаар хуралдаан зохион байгуулах;
- Өөрийн чиг үүрэгтэй холбоотой эдийн засаг, нийгмийн дунд болон урт хугацааны бодлогын асуудлаар санал асуулга явуулж байгаа аливаа байгууллага, бүлэгт мэдээлэх;
- Чиг үүрэгтэй холбоотой асуудлаар хурал семинар зохион байгуулах;

Үйл ажиллагааны онцлог:

- Хараат бус байдал: Хороо нь өөрийн хууль тогтоомжийн бүрэн эрх, удирдамжийн дагуу үйл

ажиллагаагаа явуулдаг. Улсын төсвөөс санхүүждэг бөгөөд Засгийн газрын тогтоосон хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, гаргасан дүгнэлт, зөвлөмж нь өөрсдийн дүн шинжилгээнд үндэслэн гардаг байна. Хороо нь Сангийн ямаар дамжуулан Засгийн газарт албан ёсоор үйл ажиллагаагаа тайлагнадаг.

- Ил тод байдал: Хорооны зүгээс Засгийн газарт өгч буй зөвлөмж нь мэдээлэл, дүн шинжилгээний хамт олон нийтэд нээлттэй байдаг.
- Олон нийтийг хамарсан өргөн цар хүрээ: Хороо нь шийдвэр гаргахдаа зөвхөн тодорхой салбар буюу бүлгээс илүүтэй олон нийтийн ашиг сонирхлыг дээдлэхийг эрмэлздэг.


Хорооны үйл ажиллагааны зорилт:

- Эдийн засгийн гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэх
- Шаардлагагүй зохицуулалтыг багасгах
- Аж үйлдвэрийн салбарыг үр ашигтай, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадвартай болгоход дэмжлэг үзүүлэх
- Бүтцийн өөрчлөлтөд зохицуулалт хийхэд дэмжлэг үзүүлэх
- Нийгмийн ашиг сонирхлыг тодорхойлох
- Бүс нутгийн хөдөлмөр эрхлэлт, хөгжлийг дэмжих
- Австралийн олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалт болон бусад орнуудын худалдааны бодлогыг харгалзах
- Австралийн аж үйлдвэрийг экологийн хувьд тогтвортой хөгжүүлэх

Зохион байгуулалтын бүтэц:

1975 онд ажилчдын тоо 500 давсан нь түүхэн дэх хамгийн их ажилтантай үе байсан ба одоогийн Бүтээмжийн хороо нь 200 ажилтантай.


Зураг 7.5. Ажилчдын тоо



Бүтээмжийн хороо нь дараах бүтэцтэй үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Аж үйлдвэрийн хорооноос ялгаатай нь судалгааны багийг судалгаа авах баг, судалгааны нэгтгэл, шинжилгээ хийх баг гэж 2 задалсан. Мөн хэрэгжилтийг хянах багийг тусдаа алба болгосон байна. Нэмэлтээр хэвлэл, цахим

мэдээллийн алба /Media, Publication and Web/ болон өргөдөл гомдол хүлээн авах оффис /Australian Government Competitive Neutrality Complaints office/–ийг үүсгэн байгуулсан.

Зураг 7. 6. Бүтээмжийн хорооны зохион байгуулалтын бүтэц



Эх сурвалж: pc.gov.au

ГУРАВ. ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЧЛАЛ

Хувьчлал хийх болсон шалтгаан

1980–аад оны сүүл үе хүртэл төрийн өмчит байгууллагууд нь Австралийн эдийн засгийн хөгжлийн эх үүсвэр байсан ба ДНБ–ий 10 хувь, цэвэр капиталын хөрөнгийн 16 хувийг тус тус бүрдүүлдэг байв. Улсын хэмжээнд засгийн газар нь банк, санхүү, тээврийн салбарт оролцоотой байсан.

Австралийн урсгал дансны алдагдал нь арав гаруй жилийн хугацаанд ДНБ–ий 4.5 хувьтай тэнцэж, гадаад өр төлбөр огцом өсөж байсан нь 1980–аад онд Австралийн эдийн засагт тулгарч байсан томоохон асуудал байсан юм. Энэ асуудал нь 1990–ээд он хүртэл үргэлжилсэн ба санхүүгийн зах зээл, хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг бууруулах, сангийн болон мөнгөний зохистой бодлогыг баримтлах, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зэрэг шаардлагууд үүсэж эхэлсэн. Төрийн өмчийн хувьчлал нь 1990–ээд оноос эхлэлтэй бөгөөд тухайн үед 85 тэрбум гаруй долларын үнэлгээ бүхий төрийн өмчийг хувьчилж байжээ.

Австрали Улс нь бүтээмжийн үзүүлэлт, өрсөлдөх чадвар муудсан, мөн төсөвт санхүүжилт хэрэгтэй болсон гэсэн 2 үндсэн шалтгаанаар төрийн өмчийн хувьчлалыг эхлүүлсэн. Төрийн өмчит байгууллагууддаа реформ хийх болсон шалтгаануудыг нарийвчлан дурдвал:

- 1987 онд дэлхий даяар хөрөнгийн зах зээл богино хугацаанд огцом унаж, томоохон хямрал үүсэхэд хүргэсэн. Уг хямрал нь хувьцааны хэт өндөр үнэлгээ, программчлагдсан арилжааны системийн хэт их ашиглалтаас шалтгаалсан бөгөөд Япон, ХБНГУ, АНУ зэрэг улсууд бодлогын хүүгээ өсгөж, зээл хумих бодлого явуулснаар зах зээлд сөрөг хүлээлт үүсэж, дэлхий дахин АНУ–ын хувьцааг зарж эхэлсэн. Хувьцааны хөрвөх чадвар муудсанаар олон улсын хөрөнгийн зах зээл дунджаар 25 хувиар унаж, тэр дундаа Австрали Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 40 хувиар унасан юм. Энэхүү хямрал тохиосноор Австрали Улс макро болон микро эдийн засгийн түвшинд бодлогын шинэчлэлүүд хийх шаардлагатай болов;
- Австралийн эдийн засгийн үзүүлэлтүүд суларч эхэлсэн бөгөөд 1980–аад оны сүүлчээр Австралийн бүтээмжийн өсөлт Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /OECD/–ын гишүүн орнуудтай харьцуулахад доогуур байсан;
- Мужуудын дунд хөрөнгө оруулалт татахтай холбоотой өрсөлдөөн үүсэж эхэлсэн;
- Шинэ Өмнөд Вэльсийн усжуулалтын системийн үйл ажиллагаа эрхлэгч томоохон аж ахуйн нэгж, салбарууд алдагдалтай ажиллаж эхэлсэн;
- Викториа, Өмнөд Австрали дахь төв банк, бусад санхүүгийн байгууллагуудын уналт нь улсын өрийг нэмэгдүүлж, дарамт үүсгэсэн;
- Банкны салбарт хийгдсэн зохицуулалт нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, гаднын банкуудыг зах зээлд нэвтрэхийг зөвшөөрснөөр төрийн өмчит банкуудын зах зээлд эзлэх хувийг бууруулж, ашигт ажиллагаанд нөлөөлж эхэлсэн;
- Австралийн засгийн газарт зээлжих зэрэглэлээ AAA хэвээр хадгалахын тулд өр төлбөрөө бууруулах шаардлага тулгарсан.

Хувьчлал хэрхэн хийгдсэн бэ?


Австралид хийгдсэн хувьчлал нь ерөнхий 2 төрөлд хуваагддаг. Нэгдүгээрт, өрсөлдөөн өндөртэй салбарт

үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагуудыг хувьчилсан бөгөөд ийм төрлийн байгууллагуудыг хувьчлах нь харьцангуй амар байдаг байна. Хамтын нөхөрлөлийн банк, Шинэ өмнөд Вэльсийн төрийн банк, Өмнөд Австралийн төрийн банк, BankWest зэргүүд нь хувьчлагдахаасаа өмнө хувийн банкууд болон арилжааны компаниудтай хүчтэй өрсөлддөг байв. Харин өрсөлдөөн багатай салбарт үйл ажиллагаа явуулдаг буюу монополь шинжтэй байгууллагыг хувьчилснаар монополийн хүчийг сөргөөр ашиглаж болзошгүй байдаг тул зохицуулалтын орчныг маш сайн бүрдүүлэх шаардлагатай байсан. Өмнөд Австрали болон Викториа дахь эрчим хүчний компанийн хувьчлал үүний нэг жишээ бөгөөд хувьчлалтай холбоотойгоор эрчим хүчний үүсгүүр, шилжүүлэг, түгээлт, болон борлуулалт зэргийг зохицуулах шаардлагатай болов.

Австрали Улсын хувьчлал нь санхүү, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, эрүүл мэнд, бизнесийн салбаруудад явагдаж эхэлсэн бөгөөд OECD–н бусад улс орнуудын адилаар өрсөлдөөн өндөртэй салбарт үйл ажиллагаа явуулж байсан аж ахуйн нэгжүүдээс эхлэн хувьчлалыг явуулсан.

Австрали Улс нь санхүүгийн зохицуулалтыг бууруулах бодлого хэрэгжүүлж байсан учраас санхүүгийн үйлчилгээний салбараас төрийн өмчийн хувьчлалыг эхлүүлж, Хамтын нөхөрлөлийн банкиг 1991, 1993, 1996 онуудад тус тус үе шаттайгаар хувьчилж, мөн төрийн эзэмшлийн 3 банк, мужийн даатгалын компаниудыг тус тус хувьчилжээ.

Зураг 7.7. Австралийн төрийн өмчийн хувьчлал салбараар



Австралийн Засгийн газар төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ корпорацчилал, хувьчлал гэсэн 2 ерөнхий алхмаар хувьчилсан.

• **Корпорацчилал**

Суурь нөхцөл: Австралийн төрийн өмчит байгууллагууд нь хуулиар тогтоогдсон эрх мэдлийн дагуу эсвэл үйл ажиллагааг нь зохицуулсан тусгай хуулийн хүрээнд корпорац хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байв. 1988 оноос эхлэн Аудитын хороо болон бусад шинжээчдийн зүгээс төрийн өмчит байгууллагуудын менежмент болон үр ашигт байдал маш муу байна гэж дүгнэсэн бөгөөд төрийн өмчит байгууллагуудад хувийн байгууллагуудаас илүү давуу тал олголгүй, өрсөлдөөнт орчинд үйл ажиллагаа явуулахыг зөвлөх болсон.

Корпорацчилалын суурь зарчмууд: Корпорацжуулах ажлын хүрээнд төрийн өмчит байгууллагуудыг нөөцөө үр ашигтай зарцуулахын тулд дараах 5 нөхцөлийг баримтлах хэрэгтэй хэмээн тодорхойлсон.

Хүснэгт 7.3. Корпорацчилалын баримтлах нөхцөл

Нөхцөл	Тайлбар
Тодорхой зорилго	Төрийн өмчит байгууллагууд зорилгоо нийгмийн, зохицуулалтын, эсвэл арилжааны эсэхийг нь тодорхойлон, зорилгодоо төвлөрсөн менежментийн бодлого баримтлах
Менежериад удирдлага	Байгууллагын үнэт зүйлсээ максимум байлгаж чадах боловсон хүчнээр байгууллагын гол дотоод шийдвэрүүдийг гаргуулах
Үйл ажиллагааны хяналт	Хараат бус үнэлгээ, хяналтыг хэрэгжүүлэх
Урамшуулал болон хариуцлагын тогтолцоо	Урамшуулал болон хариуцлагын тогтолцоогоор үр ашгийг нэмэгдүүлэх
Өрсөлдөөнд давуу тал олгохгүй байх	Төрийн өмчит үйл ажиллагаанд ямар нэгэн давуу тал олгох нь бүтээгдэхүүн, үйлчилгээний стандартыг бууруулах, хэрэглэгчдийг хохироох нөлөөтэй тул өрсөлдөөний давуу талыг олгохгүй байх

Төрийн болон хувийн байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт суурилан төрийн өмчит байгууллагуудыг корпорацчилахын тулд дараах үйл ажиллагааны зохицуулалтыг гаргаж ирсэн.

- Төрийн секторт үйл ажиллагаа явуулж буй байгууллагууд нь засгийн газрын нийгэм, эдийн засгийн зорилгоос хараат бусаар хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хүргэн, өмчийн эзэмшлийг сайд хариуцдаг арилжааны хэлбэрээр байгуулагдан, зах зээлд оролцох;
- Зохицуулалтын болон бодлогын зөвлөгөө өгөх байгууллагууд нь төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээс тусдаа байх;
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулж, томилгоог тухайн салбарын сайд нар хариуцах эзэмшиж буй сайд, ерөнхий сайд нар хариуцах;
- Төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн байгууллагын хөрөнгийн өгөөжийг хамгийн өндөр түвшинд хүргэх зорилго тавин ажиллах бөгөөд сайд нь урамшуулал болон хариуцлагыг тооцдог байх;
- Төлөөлөн удирдах зөвлөл нь байгууллагын гүйцэтгэх удирдлагыг томилох, халах, цалин урамшууллыг тогтоох шийдвэрт оролцдоггүй байх;
- Сайд болон төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд албаны бус харилцаа үүсэхгүй байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх;
- Төлөөлөн удирдах зөвлөл нь жил бүр сайдад үйл ажиллагааны хүрээ, зорилго, зорилт, санхүүгийн харьцаа, ногдол ашиг зэргийг тооцон танилцуулдаг байх;
- Хувийн байгууллагуудын адилаар үйл ажиллагаа, санхүүгийн тайлангаа ил тод мэдээлдэг, хариуцлага хүлээдэг байх;
- Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хувийн байгууллагуудын мэргэжилтэн, шинжээчид хяналт тавин, үнэлгээ өгдөг байх.

Корпорацчилалын үр дүн: 1994 оныг хүртэл 6 жилийн хугацаанд /Грейнерийн засгийн газрын үед/ Шинэ Өмнөд Вэльсэд 5 төрийн өмчит байгууллагыг корпорацчилж, 3 байгууллагыг хувьчилсан бөгөөд уг үйл ажиллагааны үр дүнд:

- Мужийн эрчим хүч, усан хангамж, тээврийн салбаруудад хөдөлмөрийн бүтээмж 78 хувиар өссөн;

- Цэвэр өр төлбөр 1990–1994 оны хооронд 27 хувиар буурсан;
- Төрийн өмчит байгууллагуудын ногдол ашгийн хэмжээ 1 тэрбум доллараар нэмэгдэж 1993–1994 онд жилийн орлого 22.4 тэрбум долларт хүрч, 5 хувиар өссөн;
- Бодит үнийн түвшин буурсан.

Хувьчлал

Австрали Улсад төрийн өмчит байгууллагуудын хувьчлал ихэвчлэн мужуудын хэмжээнд хийгдэж байсан ба ихэнхдээ худалдан борлуулах замаар хувьчилж байв. Хамтын нөхөрлөлийн хувьчлалын талаас их хувь нь хувьцаа гаргах замаар хийгдэж байсан бол Викториагийн хувьчлалын 80–аас их хувь нь худалдан борлуулах замаар хийгдсэн бөгөөд борлуулалтын үнэ нь ихэвчлэн анхны хүлээлтээсээ давж байв.

Хувьчлалын үйл ажиллагаа болон арга хэрэгсэл: Австралийн эдийн засаг нь хувьцаа гаргах, худалдах, менежментийн аутсорсинг хийх зэрэг хувьчлалын бүхий л арга хэрэгслийг ашиглаж байжээ. Хувьчлалын аргуудыг ихэвчлэн дараах байдлаар сонгон ашигласан.

- Өрсөлдөөнт зах зээлд үйл ажиллагаа явуулдаг, нэр хүндтэй төрийн өмчит байгууллагуудыг хувьцаа гаргах замаар хувьчилсан. Жишээлбэл Хамтын нөхөрлөлийн банк, TABCORP, Telstra зэргийг хувьцаа гарган хувьчилсан бөгөөд ихэнх хувьцааг нь ажилчид нь худалдаж авсан.
- Хувьцаа гаргах, мөн шууд худалдах аргуудыг хослуулан хэрэглэж болдог бөгөөд Күинланд болон Баруун Австралийн Засгийн газар төрийн банкуудын хувьцааг олон нийтэд санал болгон худалдаалснаар бусад банкуудын сүлжээнд орж, уусах боломжтой, мөн дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлж, үйл ажиллагааг нь хамгаална гэж үзэн уг 2 аргыг хамтад нь ашиглаж байсан.
- Монополь шинж чанартай байгууллагуудыг шууд худалдан борлуулж байсан.
- Лаборатори, инженер зэрэг илүү техникийн салбаруудад менежментийнх нь хувьд хувьчлал хийж байсан.

Санхүүгийн онолын хүрээнд компаниудыг хувьчлахдаа шууд худалдахын оронд хувьцаа гаргах замаар хувьчилснаар илүү орлого олно гэж үздэг хэдий ч дараах шалтгаануудын улмаас худалдах аргыг илүү хэрэгжүүлж байв.

- Зохицуулалт болон зах зээлийн орчин нь харьцангуй шинэ, тодорхой бус, санхүүгийн тайлан нь асуудалтай байгууллагуудын хувьд худалдан авагч нь үнэ цэнэ, эрсдэлийг нь үнэлэх илүү чадвартай учраас худалдан борлуулдаг
- Корпорацийн хуульд заасны дагуу хувьцаа гаргахдаа үнэ, өгөөжийн таамаглалыг судалж мэдээллээр хангах шаардлагатай байдаг тул хувьцаа гаргах арга нь өртөг өндөртэй, цаг хугацаа их шаарддаг
- Хувьцаа гаргахтай адилаар худалдах үнэ нь илүү өндрөөр үнэлэгдэх боломж байдаг

Үр дүн: Үр ашгийг нэмэгдүүлэх нь төрийн өмчийн хувьчлалын үндсэн зорилго байсан ба хувьчлалыг хэрэгжүүлснээр засгийн газрын өрийн хэмжээг бууруулж, эдийн засгийн хөгжлийн нэг хөдөлгөөр болсон. Үүнээс гадна дэлхийн санхүүгийн зах зээлийн даяарчлал явагдаж гаднын хөрөнгө оруулалт их хэмжээгээр орж ирж хямралаас гарахад түлхэц үзүүлсэн байна.

ДӨРӨВ. ЗАХ ЗЭЭЛИЙН ӨРСӨЛДӨӨН

Дэлхий нийтээр глобалчлал явагдаж байсан цаг үед Австрали Улсын хөгжил бусад улсынхаас хоцрогдож байв. Австрали Улс нь 1950–аад онд нэг хүнд ногдох ДНБ–ий хэмжээгээр дэлхийд 4–т жагсаж байсан бол 1980–аад он гэхэд 14–т орж, нийт хүчин зүйлийн бүтээмжийн өсөлтөөр OECD–ийн орнуудтай харьцуулахад дунджаас доогуур түвшинд орсон нь зах зээлийн өрсөлдөөнийг нэмэгдүүлэх реформ хийх шаардлагыг бий болгов.

Иймд Австралийн Засгийн газар дотоодын өрсөлдөөнийг идэвхжүүлэх бус, олон улсын түвшинд өсөж буй бизнесийг дэмжих чиглэлийг баримтлан, тэдгээрийн зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн ба улмаар нээлттэй, уян хатан, өндөр бүтээмжтэй эдийн засгийг бүрдүүлэх хүрээнд Австралийн Үндэсний Өрсөлдөөний Бодлого (NCP)–ыг хэрэгжүүлж эхэлсэн. 1980–аад оны эхэн үед тарифын квотыг цуцалж, зарим өндөр тарифыг бууруулах замаар худалдааны реформыг эхлүүлсэн.

Хамгийн томоохон өөрчлөлт нь санхүүгийн салбар дахь өөрчлөлт байв. 1981 онд хүүгийн түвшний тааз болон зарим банкуудын зээлийн хязгаарлалтыг цуцалж, 1983 онд хөвөгч ханшийн системийг нэвтрүүлэн, банкуудад шинээр зөвшөөрөл олгож эхэлсэн үйл явдал нь зах зээл дэх өрсөлдөөнийг идэвхжүүлэх үндэс болов. Мөн 1980–аад оны дунд үеэс ашгийн татварыг бууруулж, татварын суурийг өргөтгөсөн нь аж ахуйн нэгжүүдийг дэмжих, тэдний олон улсын зах зээлд өрсөлдөх чадварыг дэмжих зорилготой байв. Түүнчлэн 1988, 1991 онуудад Засгийн газар тарифыг үе шаттайгаар бууруулах тухай мэдэгдэл гаргасан ба 1992 он гэхэд бүх татварыг 15 хувь, 1996 он гэхэд 5 хувь хүртэл бууруулах зорилт тавин ажиллажээ.

1980–аад оны үед Австрали Улсын Засгийн газраас зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх чиглэлд дараах бодлогуудыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөний эсрэг үйлдлийг хязгаарлах: Австралийн өрсөлдөөний тухай хуульд өөрчлөлт оруулах;
- Өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх шинэчилсэн зохицуулалт: Дотоодын нисэх онгоцны болон өндөгний зах зээлийг зохицуулахгүй байх;
- Өрсөлдөөнийг хөнгөвчлөх хүрээнд монополь байгууллагуудын бүтцийн шинэчлэлт хийх: Өрсөлдөөнт зах зээлд үйл ажиллагаа явуулах боломжтой төрийн хэвшлийн монополь аж ахуйн нэгжийг хувьчлах, бие даасан бизнесийн нэгжүүдэд хуваах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн;
- Өрсөлдөөнд зайлшгүй шаардлагатай тодорхой арга хэрэгсэлд гуравдагч талын оролцоог хангах: Харилцаа холбооны сүлжээ, цахилгааны утас, шугам хоолой, төмөр зам, боомт зэрэг дэд бүтцийн асуудлуудыг шийдвэрлэхэд гуравдагч талын оролцоог хангах, өрсөлдөөнийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлсэн;
- Монопольт үнэ тогтоох үйл ажиллагааг зогсоох: Үнийн хяналтын газар (ACCC–ийн харьяа Price Surveillance Authority) байгуулсан;
- Төр болон хувийн хэвшлийн хооронд "өрсөлдөөнт төвийг сахисан байдал"–ийг бий болгох: Төр болон хувийн өмчит байгууллагад адил татвар ногдуулах арга хэмжээг авсан.

Харилцаа холбоо, төмөр зам, цахилгаан гэх мэт салбаруудад дэд бүтцийн шинэчлэлт хийсэн ба 1980–аад болон 1990–ээд онд дараах дэд бүтцийн өөрчлөлтүүд, арга хэмжээг хэрэгжүүлсэн.

Хүснэгт 7. 4. 1980 болон 1990–ээд оны бүтцийн өөрчлөлтүүд


1980–аад он	1990–ээд он
<p>Цахилгаан холбоо Төр харилцаа холбооны салбарыг бүхэлд нь босоо, нэгдсэн хэлбэрээр эзэмшиж байсан, өрсөлдөөнгүй, өөрийгөө зохицуулагч хэлбэртэй байв.</p>	Өрсөлдөөнийг дэмжсэн дэглэм болон шинэ зөвшөөрөл тус салбарт олгогдож эхэлснээр Telstra зэрэг хувийн өмчлөл бүхий олон өрсөлдөгчдийг бий болгосон.
<p>Цахилгаан Мужийн түвшинд өрсөлдөгчгүй, босоо интеграцлагдсан өмчлөлийн хэлбэртэй байсан ба улсын хэмжээнд холбогдоогүй байв.</p>	Олон тооны цахилгаан эрчим хүч үйлдвэрлэгч компаниуд /жижиглэнгийн худалдаачид зүүн эрэг орчимд үндэсний хэмжээнд өрсөлдөх болж, монополь сүлжээг бий болгосон.
<p>Хий Улсын хил дотор худалдаалах, худалдаа хийхэд тулгардаг олон бэрхшээлтэй байсан.</p>	Улс доторх хийн чөлөөт худалдаа; хийн дамжуулах хоолойд гуравдагч талын оролцоог хангах.
<p>Төмөр замын ачаа тээвэрлэлт Муж бүр босоо интеграцчилал бүхий, өөрийн ачаа тээврийн монополь эрхтэй бөгөөд алдагдалд ордог; Ачааны галт тэрэг нь ихэвчлэн хилийн боомт дээр буулгадаг, муж хоорондын ачилтад ямар нэгэн хариуцлага хүлээлгэдэггүй.</p>	Үндэсний хэмжээнд хувийн хэвшлийн 2 компани хувьчлагдсан. Төмөр замын тээврийн компани нь өнөөг хүртэл төрийн эзэмшилд байгаа.
<p>Зам тээвэр Ялгаатай дүрмүүд нь ачааны машинууд хил хязгаарыг байнга чөлөөтэй давах боломжийг хязгаарласан; авто замын ашиглалтын хураамжийг доогуур түвшинд, ялгаатай байдлаар тогтоосон.</p>	Үндэсний зам тээврийн дүрэмтэй болсон ба зам ашиглалтын хураамжийг авч байв.
<p>Нисэх онгоц Нийтийн эзэмшлийн дотоодын болон олон улсын агаарын тээврийн компанийг тусгаарлаж, өрсөлдөөнөөс хамгаалж байв.</p>	Дотоод болон гадаадын нислэг хийдэг Qantas хэмээх хувийн эзэмшлийн байгууллага байгуулагдсан.
<p>Хөдөөгийн усны хэрэглээ Худалдааны бус, үнэгүй усаар тогтмол хангах болж, ялангуяа өртөг багатай үйл ажиллагаанд энэ бодлого чиглэсэн, усны өмчлөлийн эрхийн асуудал</p>	Усыг газрын нэрээр хязгаарладаг бөгөөд усалгааны бүсэд түр болон байнгын худалдаа эрхлэх боломжийг олгодог Усны арилжааны дэглэм хэрэгжиж эхэлсэн.
<p>Хотын усны хэрэглээ Зардалд суурьлаагүй үнэ тогтоосон.</p>	Зардал, хэрэглээнд суурилсан үнийг тогтоосон.

Бусад шинэчлэл

1. Жижиглэнгийн худалдааны ажиллах цагт хяналт тавихаа больсон.
2. Архи, дарсны зөвшөөрөлд хяналт тавихаа зогсоосон.
3. Бизнесийн тусгай зөвшөөрлийг 72 хүртэл бууруулсан.
4. Томоохон дэд бүтцийн болон бусад чухал төслүүд хэрэгжиж эхэлсэн.
5. Хуулийн чиглэлийн зөвлөгөө өгөх, түүнийг сурталчлах, хамтын ажиллагаа зэрэг үйлчилгээнд хяналт тавихаа зогсоон, тус зах зээлийн монополь байдлыг өөрчилсөн.
6. Сувилахуйн мэргэжилтнүүдийг ангилан, эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа явуулах, мөн эрүүл мэндийн салбартай холбоотой өмчлөлийн асуудлыг чөлөөтэй болгон, эрүүл мэндийн салбар дахь хязгаарлалтыг зогсоосон.
7. Үр тарианы зах зээлийг чөлөөлсөн. Тухайлбал, будааны экспортын болон дотоодын монополь зах зээлийг чөлөөт өрсөлдөөнт болгосон.

8. Өндөг болон шувууны аж ахуйн тогтмол үнийн хязгаарлалт, гэрээний баталгаажуулалт, нийлүүлэлтийн хязгаарлалт зэрэг төвлөрсөн зохицуулалтыг халсан.
9. Бөөний болон жижиглэнгийн худалдааны үнийн хяналт, нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгасан.
10. Загасны аж ахуйн удирдлагын хяналтыг шинэчилсэн. Тухайлбал, шилжүүлэгдэхгүй лицензийг үе шаттайгаар гаргах, зардлыг бүрэн нөхөн төлөх, илүү уян хатан байдлыг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээг авч ажилласан.

Зураг 7. 8. Нийт хүчин зүйлсийн бүтээмжийн өсөлт, 1980–1990 ба 1990–2000 он



Эх сурвалж: OECD дата, Giuseppe Nicoletti and Stefano Scarpetta, "Regulation, Productivity and Growth: OECD evidence", *Economic Policy* Vol. 18 No. 36 (april 2003), pp. 9–72.

2005 он гэхэд NCP реформын үр дүнд эдийн засгийн өсөлт 13 жилийн хугацаанд тасралтгүй өсөж бүтээмж илүү өндөр болсон. 1980–1990 онд Австрали Улс бүтээмжийн үзүүлэлтээр OECD-ийн орнуудын дунд сүүл мушгиж байсан бол 1990–2000 онд тэргүүлэгчдийн нэг болсон байна.

ТАВ. ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалт

1970–аад оны дунд үед дайны дараа бодлого боловсруулагчдын Австралийн эдийн засгийг сэргээх гол арга хэрэгсэл нь аж үйлдвэрийн харилцааны бүтцийг өөрчлөх, төрийн идэвхтэй оролцоог хангах явдал байв. Фрейзерийн засгийн газар (1975–1983) болон Хавкийн засгийн газрын (1983–1987 онуудад) эхэн үед төвлөрсөн цалингийн зохицуулалтын байгууллагуудын эрх мэдлийг нэмэгдүүлэх замаар цалингийн зохицуулалтыг хэрэгжүүлж, ажил хаялтыг бууруулах зорилго тавьж байв. 1980–аад оны дунд үе буюу Хөдөлмөрийн намын Засгийн газрын "Микро эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхлэх хүртэл хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг бууруулах, зогсоох ажил төдийлөн амжилт олоогүй юм. Харин 1980–аад оны эхээр төвлөрсөн бус хэлэлцээр⁴-ийн зохицуулалтыг оруулж ирсэн нь хөдөлмөрийн зах зээлийн зохицуулалтыг бууруулах, зогсоох үйл ажиллагаанд чухал нөлөөг үзүүлсэн.

Тогтмол цалингийн системийн үед ажилласан цаг, бүтээмжээс үл хамааран бүх ажилчид ижил цалин авч байсан нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж, түүнчлэн цалингийн асуудлаас болж ажилчид болон эвлэлийн хооронд байнга мөргөлдөөн үүсэж байв. Түүнчлэн энэ систем нь баялгийг бий болгох боломжийг хаагаад зогсохгүй, тогтмол ханшийн системтэй хавсарснаар хөдөлмөрийн нийт зах зээлийн шок, нөлөөллийг шингээх чадварыг бууруулж байв. Цалингийн түвшин бодит цалин эсвэл ажилласан цагаар тогтох бус нийт ажилчдын тоонд суурилан тогтоогддог байсан нь нийгмийн зардлыг нэмэгдүүлэн, удаан хугацааны ажилгүйдлийг бий болгож байжээ.

Улмаар Хөдөлмөрийн зах зээлд цалингийн төвлөрсөн тогтолцоог хэрэгжүүлэх нь эдийн засаг дахь нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хязгаарлан, эдийн засаг дахь хөдөлмөрийн эрэлт өндөр салбар дахь хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахгүй байсан тул 1981 оны 7 дугаар сард Эвслийн ЗГ–аас тус системийг халж, төвлөрсөн бус хэлэлцээрийг нэвтрүүлэх шийдвэр гаргасан. Гэвч 1981–1982 оны хооронд хөдөлмөрийн зах зээлд цалингийн хөөрөгдөл үүсэж, ЗГ–аас тодорхой хэмжээний интервенц хийхийг оролдсон боловч үнийн хөөрөгдөл цаашид улам даамжирсаар байсан тул буцаад цалингийн төвлөрсөн индексжүүлсэн систем рүү шилжсэн.

Австралийн эдийн засаг нь боловсруулаагүй түүхий эдээс хэт хамааралтай, аж үйлдвэрийн салбар нь өрсөлдөх чадваргүй байсан тул түүхий эдийн үнийн уналтаас шалтгаалан урсгал тэнцэл алдагдалтай гарах болов. Мөн 1983 онд валютын ханшийн чөлөөт хөвөгч системтэй болж, 1985–1986 оны хооронд ханш 40 хувиар суларч, инфляци хөөрөгдсөнөөс үүдэн бодит цалин буурсан. Үүний дараагаар цалингийн дарамт, үр ашиггүй нөөцийн хуваарилалт зэрэг асуудлуудаас үүдэн ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлээс ирэх шүүмжлэл газар авч, мөн эдийн засаг болон улс төрийн хүчин задарч эхэлсэнтэй холбоотойгоор өөрчлөлт хийх шаардлага гарсан.

Ийнхүү 1986 онд Хөдөлмөрийн зах зээл нь бусад зах зээлийн адил зах зээлийн тэнцвэр эрэлт нийлүүлэлтээр тодорхойлогдож, өрсөлдөөн нь бүрэн ажил эрхлэлтийг дэмжин, хөдөлмөрийн нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хангана гэсэн утга агуулга бүхий Нео–либерализмийн үзэл баримтлалд суурилсан зохицуулалтыг бууруулах, зогсоох чиглэл бүхий “Шинэ эрх” хэмээх зохицуулалт гарч ирсэн. Тус зохицуулалтын хандлагыг мөн өөрөөр “managed decentralist” буюу “зохицуулалттай төвлөрсөн бус хандлага” гэдэг.

4 Decentralized bargaining


Үүний дараагаар 1987 онд Австралийн бизнесийн консулаас хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, технологийн өөрчлөлт, чадварын шаардлагад суурилсан, илүү өрсөлдөөнд бүтээмжтэй ажлын орчныг бүрдүүлэхүйц “enterprise approach” буюу “аж ахуйн нэгжийн хандлага”-ыг гаргаж ирсэн. Өөрөөр хэлбэл ажлын байранд ажил олгогч болон ажилчдын хооронд цалин хөлсний талаарх хэлцэл хийгдэх боломжтой болсон гэсэн үг юм.

1993 онд “Салбарын харилцааны реформын тухай хууль” батлагдсанаар цаашдын зохицуулалтыг бууруулах, зогсоох үйл ажиллагааны дараагийн алхам болсон юм. Ингээд 1990–ээд оны дунд үеэс үйлдвэрчний эвлэлд нэгдэн гэрээ хэлэлцээр хийгддэг харилцааны хэлбэрээс “хувийн гэрээт ажилтан” – ны хэлбэр буюу ажил олгогч болон тухайн ажилтан гэрээний нөхцөлийг харилцан тохиролцох хэлбэрт шилжсэн. Энэ нь ялангуяа уул уурхайн салбарт эрчимжиж байжээ.

Хэрэгжүүлсэн арга хэмжээ ба үр дүн

Эхний хамгийн энгийн нөлөө нь төвлөрсөн бус хэлэлцээрийг албан ёсны болгож, өргөтгөх явдал байв. Зарим үйлдвэрүүд болон ажлын байруудад төвлөрсөн бус хэлэлцээр нь албан бус байдлаар хийгдэж байсан бөгөөд эдгээр гэрээ хэлэлцээр нь албан ёсоор бүртгэгдэх боломжтой болсон. Гэсэн хэдий ч эдийн засгийн томоохон хэсэг нь тодорхой хэмжээний эсвэл огт туршлагагүй байсан тул “аж ахуйн нэгжийн хэлэлцээр”-ийн талаарх ойлголт авч, үүнд оролцох шаардлагатай байв.


Зураг 7. 9. Аж ахуйн нэгжийн хэлцэлд хамрагдсан ажилчдын нийт ажилчдад эзлэх хувь



Хөдөлмөрийн зах зээлд 2000–аад оны байдлаар 3 ялгаатай цалингийн зохицуулалт явагдаж байна. Ойролцоогоор 30–40 хувьд ажилчид ажил олгогчтой ажлын байрны зарим болон бүх нөхцөлийг тохиролцсон “аж ахуйн нэгжийн хэлцэл” хийж байна, мөн 30 хувьд ажилчид ямар нэгэн байдлаар гэрээнд саналаа тусгах боломжгүй байдаг бол үлдсэн гуравны нэг хэсэг нь ажил олгогчтой “хувийн гэрээт ажилтан”-ы харилцаатай байна.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээл дэх зохицуулалтыг бууруулах хууль, дүрэм гарснаар Хөдөлмөрийн зах зээлийг илүү чөлөөт зах зээл рүү шилжүүлж, хөдөлмөрийн зах зээл дэх бүтээмжийн үзүүлэлт улам сайжрахад эерэг нөлөөг үзүүлсэн. 1970–аас 1993 он хүртэл Австралийн ажлын нэг цагт ногдох ДНБ–ий хэмжээ дунджаар 32 ам.доллар байсан бол 1994 оноос 2016 оны хооронд дунджаар 45 доллар болж өссөн байна.

Зураг 7. 10. Австралийн хөдөлмөрийн бүтээмж ба ажилгүйдлийн түвшин



Эх сурвалж: OECD data


Хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөнийг дэмжсэнээр хөдөлмөрийн илүүдэл эрэлтийг хангах нөхцөлийг бүрдүүлснээс гадна, ажилчид хийснээрээ цалинжиж эхэлсэн нь нийт бүтээмжийг нэмэгдүүлэн, үйлдвэрлэлийн үр ашиг, орлогыг нэмэгдүүлж, улмаар нийт эдийн засаг дахь ажилгүйдлийн түвшинг бууруулах нөлөөг үзүүлсэн.

1970–аад оны үеэр Австрали Улсын эдийн засагт нийлүүлэлт болон эрэлтийн талын шок үүссэн ба цалин болон засгийн газрын зардлын огцом өсөлт нь эрэлтийг нэмэгдүүлж, 1973 онд тохиосон Газрын тосны үнийн өсөлт олон улсын хямралыг бий болгож Австрали Улсын экспортын эрэлтийг бууруулсан. Нийлүүлэлт болон эрэлтийн шокийн нөлөөгөөр инфляцийн түвшин өсөж, мөн цалингийн зардлын өсөлт нь хөдөлмөрийн зах зээлийн өртгийг нэмэгдүүлж, улмаар ажилгүйдлийн түвшинг нэмэгдүүлсэн. Ийнхүү 1983 онд нийт ажилгүйдлийн түвшин 9.7 хувьд хүрч байжээ. Үүний дараагаар дэлхийн санхүүгийн хямрал тохиож, Засгийн газрын бодит цалинг нэмэгдүүлэх шийдвэрийн үр дүнд буурч байсан ажилгүйдлийн түвшин 1992 онд түүхэн дээд цэг болох 11.2 хувьд хүрсэн боловч уян хатан цалингийн системийг нэвтрүүлснээр 2000–аад оны эхэнд 6.1 хувьд хүрч буурчээ.

Одоогийн хөдөлмөрийн зах зээл

Ажиллах хүчний бүтэц: 1999–2003 оны хооронд хувьчлалтай холбоотойгоор төрийн ба дэд бүтцийн сектор дахь ажилчдын тоо 31,000–аар буурсан. Гэвч 1990–ээд оны эхний хагаст энэхүү бууралт тохиосон бөгөөд дараагийн жилүүдэд өсөлттэй байсан юм. 1990–1995 онд нийт ажлын байрны тоо 50,000–аар буурсан бол дараагийн 8 жилийн хугацаанд 19,000–аар нэмэгджээ.


Зураг 7. 11. 1990–2003 он хоорондын дэд бүтцийн салбарууд дахь ажилчдын тоо /мянган ажилчин/



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо, “Ажилчдын орлого, ашгийн судалгаа”

Ажиллах хүчний оролцоо: Нийт ажиллах хүчинд эзлэх ажиллаж байгаа болон идэвхтэй ажил хайж буй иргэдийн тоог ажиллах хүчний оролцоо гэсэн үзүүлэлтээр илэрхийлдэг билээ. 1970 оноос 1994 оныг хүртэл OECD орнуудын ажиллах хүчний оролцоо дунджаар 63.7 хувь байсан бол Австралийн хувьд 2 хувиар доогуур түвшинд буюу 61.7 хувь байв. Харин 1995 оноос эхлэн Австралийн ажиллах хүчний оролцоо OECD орнуудаас дээгүүр болж 2016 оны байдлаар 64.8 хувьд хүрээд байна.

Зураг 7. 12. Австрали болон OECD-ийн орнуудын ажиллах хүчний оролцоо



Эх сурвалж: OECD дата

Хөдөлмөрийн бүтээмж: Хөдөлмөрийн бүтээмжийг илэрхийлдэг олон үзүүлэлт байдгийн нэг нь KLEMS MFP⁵ буюу олон хүчин зүйлсийн бүтээмжийн үзүүлэлт юм. Уг үзүүлэлтийг тооцохдоо нийт үйлдвэрлэлийн индексийг үйлдвэрлэлийн орцын одоогийн үнээр жигнэсэн үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн индексэд харьцуулдаг. 2014–2015 оны хооронд Австрали Улсын олон хүчин зүйлийн бүтээмжийн өсөлтийг салбараар ангилан үзвэл, уул уурхайн салбарт хамгийн өндөр байгаа юм. Түүний дараагаар санхүү болон даатгалын үйлчилгээ, мөн цахилгаан хий ус хог хаягдлын үйлчилгээний салбарын бүтээмжийн өсөлт өндөр гарчээ.

Зураг 7. 13. KLEMS Олон хүчин зүйлийн бүтээмжийн өсөлт



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

5


KLEMS Multifactor productivity	
Definition	$\frac{\text{Quantity index of gross output}}{\text{Quantity index of combined inputs}}$ <p>Quantity index of combined inputs = Quantity index of (different types of) labour, capital, energy, services, each weighted with its current-price share in total gross output.</p>

ЗУРГАА. МӨНГӨНИЙ БОДЛОГО

Мөнгөний зах зээлийн нөхцөл байдал

1970–аад оныг хүртэл Австрали Улсын инфляцийн түвшин бага байсан. 1970–аад оноос эхлэн бодит цалингийн, засгийн газрын зардлын болон газрын тосны үнийн өсөлтүүд, мөн нийлүүлэлтийн шок зэргээс шалтгаалан үнийн түвшин өсөж 1974 онд 15.1 хувьд хүрсэн. Хямралаас шалтгаалан эрэлт буурч, цалингийн өсөлт зогссоноор инфляцийн түвшин 1984 онд 4 хувь хүртэл буурсан. 2000 оноос хойш Австрали Улсын инфляцийн түвшин дунджаар 2.8 хувьтай байна.


Зураг 7. 14. Инфляцийн түвшин



Эх сурвалж: Дэлхийн банк

1970–аад оныг хүртэл 5 орчим хувьтай байсан зээлийн хүүгийн түвшин 1970 оноос эхлэн өссөөр 1989 онд хамгийн өндөр буюу 16.46 хувьд хүрсэн бөгөөд үүнээс хойш буурсаар 2016 оны байдлаар жилийн 5.42 хувьтай байна.


Зураг 7. 15. Хүүгийн түвшин



Эх сурвалж: Дэлхийн банк

Мөнгөний нийлүүлэлтийг илэрхийлдэг үзүүлэлт болох Broad Money-г ДНБ-д харьцуулсан харьцаа 1980 оныг хүртэл 40 гаруй хувьтай байсан бол 1982 онд мөнгөний нийлүүлэлт бууран хамгийн бага түвшиндээ буюу 37.7 хувьд хүрсэн. Мөнгөний нийлүүлэлт өссөөр 2016 оны байдлаар ДНБ-ээс 1.2 дахин их буюу 118.5 хувьтай байна.

Зураг 7. 16. Мөнгөний нийлүүлэлтийн ДНБ-д эзлэх хувь



Эх сурвалж: Дэлхийн банк

Мөнгөний бодлогын үе шат

Дайны дараах Австралийн мөнгөний бодлогыг ерөнхийд нь дөрвөн хэсэгт хувааж болно.

1. 1970–аад оны эхэн хүртэл үргэлжилсэн тогтмол валютын ханшийн тогтолцоотой үе;
2. 1976–1985 оны хоорондох мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогын үе;
3. 1990 оны эхэн хүртэл үргэлжилсэн мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогын шилжилтийн үе;
4. 1993 оны инфляцийг онилсон бодлогын үе.

• Тогтмол валютын ханшийн тогтолцоотой үе

Дайны дараа үеэс буюу 1931 оноос хойш Австрали доллар нь Их Британийн фунт стерлингтэй уягдсан валютын ханшийн системтэй байв. 1970–аад он хүртэл валютын ханшийн системд томоохон хоёр өөрчлөлт гарсан. Нэгдүгээрт, 1949 онд Их Британи Улс фунт стерлингийн алт болон Америк доллартай уясан ханшийн түвшнээ сулруулахад Австрали Улс ханшаа дагаж сулруулсан. Хоёрдугаарт, 1967 онд Их Британи Улс ханшаа дахин сулруулахад Австрали үүнийг дагаагүй байна. Өөрөөр хэлбэл Австрали долларын фунт стерлингтэй харьцуулсан валютын ханш 1931–1967 он хүртэл өөрчлөгдөөгүй бол, 1949–1971 онд Америк доллар илүү чухалд тооцогдож байсан тул ам.доллартай харьцах харьцааг хэвээр хадгалан, стерлингийн ам.доллартай харьцах ханшийн сулруулалтыг дагаагүй байна. Тогтмол ханшийн түвшин нь Австрали Улсын хувьд мөнгөний бодлогын гол тулгуур байв.

1971 онд Австрали долларын ханшийг дахин тохируулсан бөгөөд үүнээс хойш энэ давтамж нь нэмэгдсэн. 1971 оноос хойш 1976 онд тогтмол болон хөвөгч ханшийн холимог систем /peg system/-г хэрэгжүүлэх хүртэл 6 удаагийн тохиргоо хийгдсэн бөгөөд улмаар 1983 онд хөвөгч ханшийн системд шилжих шийдвэрт хүргэв. Бреттон Вудсийн системийн үед ихэнх валютууд Америк доллартай уягдсан байсан. Тийм ч учраас тухайн улсуудын макро эдийн засгийн бодлогод Америк доллар чухал үүрэг гүйцэтгэдэг байв. АНУ нь төсвийг тэнцвэржүүлэх, инфляцийн түвшинг бууруулах сангийн болон мөнгөний бодлого баримталж байсан нь бусад улсууд болон Австралийн хувьд инфляцийн түвшин нь бага байхад нөлөөлжээ.

Гэвч энэ нөхцөл 1960–аад оны дунд үеэс өөрчлөгдөж эхэлсэн бөгөөд Вьетнамын дайнтай холбоотойгоор батлан хамгаалах салбарын зардал нэмэгдэж, 1964, 1965 онд цэрэг армитай холбоотой татварын хөнгөлөлт үзүүлсэн нь АНУ–ын сангийн бодлогыг тэлэхэд хүргэв. Энэ нь АНУ–ын инфляцийн түвшинг нэмэгдүүлсэн бөгөөд үүнээс үүдэн бусад улсууд долларын нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах болсон нь дотоодын макро эдийн засгийн бодлогыг сулруулж, инфляцийн түвшинг өсгөсөн байна. Ийнхүү Бреттэн Вудсийн систем үр дүнгүй болж, тогтмол ханшийн систем хэрэгжүүлж байсан улс орнуудын эдийн засгийг муудаж, инфляцийн түвшин нь дагаж хөөрөгдүүлэх үр нөлөөтэй байсан тул хэрэгжиж байсан ханшийн систем нуран унасан. Харин Австрали Улсын эдийн засаг нь түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай байсан тул дээрх нөхцөл байдал экспортод сөргөөр нөлөөлж, төлбөрийн тэнцлийн хязгаарлалт болон дотоодын бодлогын үр нөлөөг сулруулж, үр дүнд нь 1970 оны эхээр АНУ–г давсан өндөр инфляцитай болжээ.

Филлипсийн муруйн өсөлт, бууралт

1970 оноос өмнөх бодлого ихээхэн амжилттай хэрэгжсэн бөгөөд хэт өндөр инфляци бий болох нь ховор байв. Гэвч 1970–аад оны үед инфляци болон ажилгүйдлийн түвшин нэгэн зэрэг ихээр нэмэгдсэн. Энэ нь онолын хувьд инфляци нь хэт их эрэлтээс үүддэг бол ажилгүйдэл нь эрэлт хангалтгүй байгаа дохио өгдөгтэй зөрчилдөж байна. Үүнийг тайлбарлах нэг хүчин зүйл нь үйлдвэрлэлийн хэмжээ болон тогтвортой инфляцийн үеийн ажил эрхлэлтийг бууруулсан нийлүүлэлтийн шок юм. Нийлүүлэлт талаас 1970–аад оны газрын тосны үнийн өсөлт, харин эрэлт талаас бодит цалингийн шок байсан. Зарим бодлого боловсруулагчид, эдийн засагчдын хувьд тогтвортой Филлипсийн муруйг чухалчилдаг бөгөөд, өндөр инфляцитай байх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлнэ гэж үздэг байна. Гэвч энэ нь богино хугацааны хувьд ашигтай боловч урт хугацаандаа эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг.

- **Мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогын үе**

Мөнгөний нийлүүлэлтийн тогтвортой өсөлт нь эдийн засгийн хэвийн өсөлтийг хангах, инфляцийг бууруулахад хүргэдэг гэж Фридман үзэж байв. 1970–аад оны эхэн үеэс эхлэн АНУ, Герман, Их Британи, Швейцар гэх зэрэг улсууд мөнгөний нийлүүлэлтийг онилсон мөнгөний бодлогыг баримталж эхэлсэн байна. Австрали Улс ч мөн энэ жишгийг дагаж эхэлсэн ба 1976–1985 оныг хүртэл жил бүр М3 мөнгөний өсөлтийн таамаглалыг гаргадаг байжээ.

Мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогын хүрээнд Австрали Улс урт хугацааны зорилт болох инфляцийг бууруулах зорилтдоо амжилттай хүрч чадсан. 1975–1985 оны хооронд Австрали Улсын инфляцийн түвшин буурч байсан хэдий ч 1980–аад оны дунд үед OECD–н гишүүн орнуудтай харьцуулахад нэлээд өндөр байжээ.

Хүснэгт 7. 5. Инфляцийн түвшин, 1975–1996

Улс	Үе	Зорилтот түвшнээсээ хазайх дундаж хазайлт	Зорилтот түвшнээ хангасан жилийн бодлого хэрэгжүүлэх хугацаанд эзлэх хувь
Австрали	1977–85	2.6	33.3
Канад	1976–82	1.3	71.4
Франц	1977–96	2.5	50.0
Герман	1975–96	1.8	54.5
Итали	1975–96	2.7	31.8

Швейцар	1975–96	2.6	47.6
Их Британи	1976–96	2.7	52.4
АНУ М2	1975–96	1.5	63.6
АНУ М3	1975–96	1.8	40.9

Эх сурвалж: Edey (1997)

Мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогыг баримтлахад хоёр нийтлэг асуудал тулгардаг бөгөөд Австрали Улсад ч мөн уг асуудлууд тулгарсан. Эхнийх нь хяналтын асуудал юм. Мөнгөний бодлогын зорилтот түвшнээ тогтмол хадгалахын тулд хяналт сайн тавих шаардлага үүсдэг хэдий ч ихэнх тохиолдолд мөнгөний нийлүүлэлтийг хянаж чаддаггүйн улмаас зорилтот түвшиндээ хүрч чадахгүй байх асуудал үүсдэг. Дараагийн нэг асуудал нь мөнгөний нийлүүлэлт болон мөнгөний бодлогын урт хугацааны зорилт болох инфляци, нэрлэсэн ДНБ зэргийн хоорондын хамаарал тогтвортой бус байдаг. Уг хоёр асуудлаас шалтгаалан ихэнх улс орнууд мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлого баримтлахаа зогсоож байв.

1983 оны үед мөнгөний бодлого нь бусад макро түвшний цалин хөлсний болон төсвийн бодлоготой нягт уялдаатай байсан. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн хямралыг даван туулахын тулд Засгийн газар зардлаа танаж, мөнгөний хатуу бодлого болон бусад хавсрах бодлогуудыг хэрэгжүүлэн хямралыг зогсоох шийдвэрт хүрсэн. Энэ хугацаанд бодит цалинг хэт өндөр тогтоосон байсан бөгөөд бодит цалин хөлсийг бууруулах Цалингийн түр зогсолт (1982 онд Фрастерийн Засгийн газрын сүүлийн жилд хэрэгжсэн) хийж байв. Цалингийн түвшин хэт өндрөөр тогтсон байсан нь нийт эрэлтийг нэмэгдүүлэн, инфляцийг цаашид улам хөөрөгдүүлэх нөлөөтэй байсан юм. Иймд мөнгөний бодлого нь цалингийн бодлогыг дэмжихийн тулд нэрлэсэн орлогын зохистой өсөлтийг хангахад чиглэсэн.

1983 оны 12 дугаар сард ханшийн чөлөөт хөвөгч системд шилжсэн нь бодлогын арга хэмжээг өөрчлөх, санхүүгийн зах зээл дэх хязгаарлалтуудыг бууруулах шаардлагыг бий болгосон. Зохицуулалтыг бууруулж, эдийн засгийг илүү чөлөөтэй болгож байсан нь тухайн үеийн мөнгөний бодлоготой харшилж байв. Иймд Австрали Улсын засгийн газар холимог зохицуулалтын аргыг хэрэгжүүлэхээр болсон.

1985–аас 1986 оны хооронд бодит цалин болон төсвийн алдагдлыг бууруулах нь эдийн засгийн хувьд гол асуудал болсон тул үүнийг мөнгөний бодлогоор дамжуулан хэрэгжүүлэх болсон. Тухайн үед урсгал тэнцлийн алдагдал их хэмжээнд байсан нь валютын ханшид, цаашлаад инфляцид дарамт учруулж байв.

1985 оны эхэн гэхэд дотоодын валютын ханш 35 хувиар суларч, урсгал тэнцэл алдагдалтай гарсан бөгөөд үнийг тогтворжуулах бодлогын хүрээнд инфляцийн эхэн үед нөлөөллийг хүлээж авах, дараагийн үеэс сөрөг нөлөөллөөс хамгаалах бодлогын арга хэрэгслийг хэрэгжүүлсэн. Энэ үед цалинг тодорхой хэмжээгээр бууруулах арга хэмжээг авч байжээ.

1985 оны 11 сард хүүгийн түвшин сүүлийн 10 жилд хамгийн дээд цэгтээ хүрсэн. Энэ үед валютын ханшийг тогтворжуулах нь үндсэн асуудал байсан бөгөөд хүүгийн түвшнийг байх ёстой зохистой хэмжээнд хүртэл тохируулж чадахгүй байв. Гадаад валютын интервенцийг стерилизаци хэлбэрээр хийж байсан. Харин хүүгийн түвшин нь суурь мөнгийг өөрчилсний үр дүнд бус, тогтоосон түвшнээр тодорхойлогдож байв.

1980–аад оны дунд үеэс Австрали Улс санхүүгийн зах зээлийн зохицуулалтаа сулруулснаар банк, санхүүгийн байгууллагын зах зээлд эзлэх хувь хурдацтайгаар өсөж эхэлсэн. Үүний үр дүнд мөнгөний

нийлүүлэлт, инфляци болон нэрлэсэн орлого хоорондын хамаарал багасаж эхэлсэн бөгөөд 1985 онд МЗ мөнгөний өсөлт 17.5 хувьд хүрсэн хэдий ч инфляцийн түвшин буурч эхэлснээр мөнгөний нийлүүлэлтийг онилсон мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх нь үр ашиггүй болсон.

- **Мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогын шилжилтийн үе**

Хөвөгч ханшийн тогтолцоотой олон улс орнууд мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлогыг баримтлахаа больж, инфляцийн түвшнийг бууруулан эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтворжуулах бодлого баримталж эхэлсэн.

Австрали Улсын хувьд мөнгөний нийлүүлэлтийг онилох бодлого баримтлахаа больсны дараагаар тохирох бодлогыг олохоор хэдэн жилийн туршид эдийн засгийн нөхцөл байдлыг судалж, бодлогын шийдвэр гаргахаар зэхэж байв. Хүүгийн түвшин, валютын ханш, мөнгөний нийлүүлэлт, инфляци, хөрөнгийн үнэ, богино, дунд болон урт хугацааны бодлогын зорилт, ерөнхий эдийн засгийн үзүүлэлт зэргийг харгалзан үзэж бодлогын судалгааг хийж байжээ.

1987–1989 он нь бодлогын шилжилтийн үе байсан ба дараагийн үе хүртэл боловсруулагдах шатандаа байсан. Мөн үед инфляцийн түвшин 10–аас доош хувьтай байсан ба бодлого боловсруулагчид үнийн түвшинг тогтвортой хадгалахын тулд цаашид ч бууруулах шаардлагатай гэж үзэж байв. 1989 оны сүүл гэхэд хөрөнгийн үнийн инфляци бий болж, улмаар бодлогын шийдвэр гаргах шаардлагатай болсон. Бодлогыг хэрэгжүүлэхдээ богино хугацаанд үнийн тогтвортой байдлыг хангах, олон улсад өрсөлдөх чадвараа бууруулахгүйгээр валютын ханшаар дамжуулан инфляцийг хянах, мөн цалингийн түвшинг бууруулах зэрэг арга хэмжээнүүдийг авч байв. Төв банкны хувьд инфляцийн түвшинг бууруулах зорилтоо хадгалсаар байсан бөгөөд түүний хэрэгжүүлж байсан мөнгөний хатуу бодлогын реформын нөлөө өндөр үүрэгтэй байв.

Бодлого гаргагчид мөнгөний бодлогын зорилтыг инфляцийн түвшнээр дамжуулан ажилгүйдэл, эдийн засгийн өсөлт, төлбөрийн тэнцэл зэрэг эдийн засгийн бодит хувьсагчдад нөлөөлнө хэмээн тодорхойлж, инфляцийг онилсон мөнгөний бодлогод шилжсэн.

- **Инфляцийг онилсон мөнгөний бодлогын үе**

Их Британи, Шинэ Зеланд зэрэг улсууд шиг мөнгөний бодлогын дэглэмээ огцом өөрчилсөн улсуудаас ялгаатай нь Австрали Улс инфляцийг онилсон мөнгөний бодлогод аажмаар шилжсэн. Австрали Улс нь Шинэ Зеланд, Канад зэрэг улсуудын мөнгөний бодлогын загварыг дуурайсан бөгөөд уг загварыг өөрийн улсад тохирсон, илүү уян хатан болгох, олон нийт, улс төрийн дэмжлэгийг авах зэрэг шалтгааны улмаас бодлогын шилжилт нь бусад улс оронтой харьцуулахад удаан байсан.

Австрали Улс нь 1993 оноос эхлэн инфляцийг онилсон мөнгөний бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн ба инфляцийг 2–3 хувьд байлгах зорилтыг тавьсан.

Хүснэгт 7. 6. Инфляцийн түвшин, 1990–1994

Улс	Инфляцийг онилсон бодлого шилжсэн хугацаа	Зорилтот түвшин
Шинэ Зеланд	1990.03	0–3
Канад	1991.02	1–3

Их Британи	1992.10	2.5
Швед	1993.01	1–3
Финланд	1993.02	2
Австрали	1993	2–3
Испани	1994, зун	0–3

Эх сурвалж: BIS 1996 оны жилийн тайлан

Бусад улс орнуудын туршлагаас харахад өмнөх бодлогын нөлөөгөөр хямрал тохиосны улмаас бодлогын хэлбэрээ өөрчилж байсан бол Австрали Улсын хувьд эдийн засгийн хямралаас үүдэн бодлогын хэлбэрээ өөрчлөөгүй. Өмнөх бодлогын үед Австрали Улсын инфляцийн түвшин аль хэдийн буурчихсан байсан ба мөнгөний нийлүүлэлтийг онилсон бодлого хэрэгжүүлэх нь үр ашиггүй болж эхэлсэн учраас инфляцийг онилсон мөнгөний бодлогод шилжсэн.

Өмнөх 20 жилийн түүхэнд хамгийн өндөр түвшинд хүрээд байсан инфляци 1990 оны үед дунджаар 2–3 орчим хувьтай болж буурав. Австрали Улс нь 1980–аад оны сүүл үеэр инфляцийн өндөр түвшнээс хамгаалах зорилгоор мөнгөний хатуу бодлого баримталж байсан. 1990, 1991 оноос эдийн засгийн хямралын нөлөө Австрали Улсад ажиглагдаж эхэлсэн бөгөөд 1980–аад оноос хэрэгжүүлж эхэлсэн реформын үр дүнд 1990–ээд оны хямрал эдийн засагт хүчтэй нөлөөллийг үзүүлээгүй, харин бусад улс оронтой харьцуулахад богино хугацаанд эдийн засгаа эргэн сэргээж чадсан юм. Гэхдээ хямралын үед мөчлөгийн дагуу инфляцийн түвшин буурсан хэдий ч, энэ нь өөрөө хэвийн үзэгдэл биш тул бодлого гаргагчид инфляцийн түвшинд анхаарлаа хандуулж эхэлсэн.

Мөн 1990 оны эхэн үеэс хөвөгч ханшийн тогтолцоонд шилжсэнээс шалтгаалан Австралийн мөнгөн тэмдэгтийн ханш суларч эхэлсэн бөгөөд үүнээс шалтгаалан гадаад худалдааны нөхцөл муудаж улмаар инфляцийн түвшинд нөлөө үзүүлж эхэлжээ. 1992 он гэхэд ханш 15 хувиар суларч байв. Уг нөхцөл байдлын тухайд Австрали Улсын төв банкнаас эрхлэн гаргадаг жилийн тайланд “Гадаад валютын арилжааны зах зээлд хямрал нүүрлээгүй учраас ханш 20 хувиар сулрах нь Австралийн ирээдүйн өрсөлдөх чадварт чухал нөлөө үзүүлнэ” хэмээн дурдсан байдаг.

Одоогийн мөнгөний бодлого

Хөвөгч ханшийн системтэй Австралийн хувьд ихэнх хөгжсөн улсуудын адилаар богино хугацааны зээлийн хүүг удирдах замаар мөнгөний бодлогын зорилтуудаа хэрэгжүүлдэг. Инфляцийг онилсон мөнгөний бодлого нь дотоодын мөнгөн тэмдэгтийн тогтвортой байдлыг хангах, бүрэн ажил эрхлэлтийг хадгалах, иргэдийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх гэсэн үндсэн 3 зорилттой байдаг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хэрэглээний үнийн инфляцийг дундаж түвшин буюу 2–3 хувьд барихыг зорьдог байна. Төв банкнаас бодлогын хүүг өөрчлөх замаар зээлийн хүүд нөлөөлдөг бөгөөд энэ нь зээлдэгч, зээлдүүлэгчийн үйл хөдлөл болон эдийн засаг дахь үйл ажиллагаа, цаашлаад инфляцийн түвшинд нөлөөлдөг байна.

ДОЛОО. САНГИЙН БОДЛОГО

1980 болон 1990–ээд оны эхэн үеийн хямралын үед Австрали Улсын төсвийн алдагдал нь түүхэн дэх хамгийн доод хэмжээнд хүрч ДНБ–ий 3–5 хувьтай тэнцэж байв. Иймд, тухайн онуудад дунд хугацааны төсвийн тэнцлийг тогтворжуулах бодлогыг хэрэгжүүлсэн юм. Энэхүү бодлогын стратеги нь эдийн засгийн мөчлөгийн туршид төсвийн илүүдлийг бий болгохыг зорьдог ба дараах элементүүдээс бүрддэг:

1. Төсвийн алдагдлыг бууруулж, төсвийн тэнцлийг сайжруулах
 - a. Засгийн газрын зарим зардлыг танах
 - b. Засгийн газрын өрийг бууруулах
 - c. Татварын системийн зохистой бодлого хэрэгжүүлэх
2. Үндэсний хуримтлалыг нэмэгдүүлэх

Төсвийн тэнцлийг сайжруулах:

Австралийн Засгийн газар нь 1980–аад оны дундуур дунд хугацааны төсвийн дүрэм буюу fiscal rules–ийг хэрэгжүүлж эхэлсэн ба тус дүрэмтэй холбогдуулан 1985–1986 оны төсөвт гурван амлалт өгсөн. Үүнд:

- Парламентын бүрэн эрхийн хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлэхгүй байх /татварын дарамтыг бууруулах/;
- Парламентын бүрэн эрхийн хугацаанд засгийн газрын зардлыг бууруулах;
- Парламентын бүрэн эрхийн хугацаанд төсвийн алдагдлыг бууруулах байв.

Өөрөөр хэлбэл, Засгийн газар өрийн үлдэгдэл болон татварын дарамтыг нэмэгдүүлэлгүйгээр зардлаа танах замаар төсвийн алдагдлаа бууруулахыг зорьсон.

Нэн тэргүүнд төрийн хуримтлалыг нэмэгдүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр 1984 онд ДНБ–ий 3х хувьтай тэнцэж байсан төсвийн алдагдал нь 5 жилийн дараа буюу 1988 онд ашигтай гарч ДНБ–ий 1¼ хувьд хүрсэн юм. Энэ бодлого нь 1988 оноос 1990 оны эхэн үе хүртэл төсвийн тэнцлийг ашигтай гаргасан ч 1992 онд төсвийн алдагдал нь ДНБ–ий 5 хувьтай тэнцэж түүхэн дэх хамгийн муу үзүүлэлт болов. Энэ үед 1980 онд хэрэгжүүлсэн бодлогоо дахин хэрэгжүүлснээр 1998 он гэхэд төсвийн тэнцэл нь ДНБ–ий 2 хувьтай тэнцэж ашигтай гарч чадсан юм.

Зураг 7. 17. Австралийн засгийн газрын төсвийн тэнцэл, ДНБ-д эзлэх хувиар, 1980–2005 он




Эх сурвалж: Австралийн сангийн яам

■ Засгийн газрын зардлыг бууруулах

Төсвийн тэнцлийг сайжруулах хүрээнд, нэн тэргүүнд засгийн газрын зардлыг бүх түвшинд бууруулах арга хэмжээ авахыг зорьсон. ДНБ-д эзлэх засгийн газрын зардлын хэмжээ 1990-ээд оноос 2007 он хүртэл хурдацтай буурсан. Үүнд, төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг корпорацчилах, хувьчлах замаар төрийн нийт албан хаагчдын орон тоог бууруулан, засгийн газрын зардлыг бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэ тухай төрийн секторын реформ болон хувьчлал бүлэгт тодорхой авч үзсэн билээ.

Зураг 7. 18. ДНБ-д эзлэх засгийн газрын зардлын хувь, 1998–2015 он




Эх сурвалж: www.tradingeconomics.com

Засгийн газрын оновчтой хөрөнгө оруулалт: Ихэнх хөгжиж буй орнуудын нэгэн адил Австралид хүн амын нас баралтын түвшин буурч, насжилт удааширсаар байсан бөгөөд 1990-ээд онд нийт хүн амд

эзлэх 65 ба түүнээс дээш насныхан дараагийн арван жилд хоёр дахин өсөх төлөвтэй байлаа. 1996 онд Австралийн засгийн газрын санхүүжилтээр зохион байгуулсан Аудитын үндэсний хорооны илтгэлд насжилт ба нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээний зардал нь засгийн газрын зардалд ихээхэн нөлөөтэй талаар болоод Засгийн газар насжилттай холбоотой урт хугацааны сангуудыг нэмэгдүүлэх хэрэгтэйг дурдсан. Тиймээс 1996 оноос төсвийн илүүдлийг Засгийн газрын ирээдүйд үүсэх өр төлбөрийг санхүүжүүлэх, хойч үед үүсэх санхүүгийн дарамтыг бууруулах зорилготой ирээдүйн санг байгуулахаар ашиглаж эхэлсэн.

Зураг 21–т 1972–2005 оны хоорондох Засгийн газрын нийт зардалд эзлэх батлан хамгаалах, эрүүл мэнд, нийгмийн халамж болон бусад салбарт зориулж буй зардлын хэмжээг харуулав. Үүнээс харахад, 1970 онд засгийн газрын нийт зардлын 20–оод хувийг нийгмийн халамжийн зардал эзэлдэг байсан бол 1990 оноос нийгмийн халамж, эрүүл мэндэд зориулах зардал нь 50–аас дээш хувийг эзлэх болжээ.

Зураг 7. 19. Засгийн газрын зардалд салбаруудын зардлын эзлэх хувь, 1972–2005 он



Эх сурвалж: *Intergenerational report 2002*

Хүснэгт 5 –д, 2017 оны 9 сарын байдлаар хэрэгжиж байгаа засгийн газрын сангуудыг харууллаа.

Хүснэгт 7. 7. Засгийн газрын санхүүжилттэй сангууд


Сангууд	Байгуулагдсан огноо	2017.9.30-ны байдлаарх төсөв (тэрбум \$)	Зорилго
Ирээдүйн сан	2006.4.3	134.5	Тэтгэвэрт гарах хүмүүст тэтгэврийг нь бүрэн өгөх зорилготой. (Засгийн газрын ирээдүйд үүсэж болох өр)
Эрүүл мэндийн судалгааны ирээдүйн сан	2015.8.26	6.9	Анагаах ухааны судалгаа, шинэчлэлийг дэмжихэд зориулсан
Хөдөлмөрийн чадвараа алдагсдад зориулсан Австралийн сан	2014.7.1	10.5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний даатгалын тогтолцоонд хамаарах засгийн газрын зардлыг санхүүжүүлэх зорилготой.
Үндэсний барилгын сан	2009.1.1	7.6	Дэд бүтцийн чухал салбаруудад санхүүжилт олгох зорилготой. (the Building Australia fund, the Education investment fund)

Эх сурвалж: finance.gov.au

• Засгийн газрын өрийг бууруулах

Дэлхийн хоёрдугаар дайны дараахан Австрали Улсын засгийн газрын өрийн үлдэгдэл нь нийт дүнгээр ДНБ-ий 100-аас дээш хувийг эзэлж байв. 1970-аад оны дунд үе хүртэл төсвийн хатуу бодлогыг хэрэгжүүлснээр ДНБ-д эзлэх өрийн харьцаа дараагийн арван жилд хурдацтай буурч 1980 он гэхэд 10 орчим хувь болсон.


Зураг 7. 20. ДНБ-д эзлэх Засгийн газрын нийт өр, 1908–2008 он



Эх сурвалж: *Barnard Source Papers in Economic History 1986*

Харин 1980 оны дунд үед 30 хувьтай тэнцэж байсан эдийн засаг дахь гадаад цэвэр өр төлбөрийн ДНБ-д эзлэх дүн 2004 он гэхэд 60 орчим хувь болж 2 дахин өсжээ. Гэхдээ энэ үед нийт цэвэр гадаад өр нь бүгд хувийн секторын өр байсан бөгөөд төрийн секторын гадаад цэвэр өр тэглэгдсэн байлаа.


Зураг 7. 21. Гадаадын цэвэр өр төлбөр ба төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Австралийн статистикийн газар ба Австралийн төв банк

1980-аад онд Австралийн урсгал дансны алдагдал ДНБ-ий 2 хувьтай тэнцэж байлаа. Харин дараагийн 20 жил буюу 2005 он хүртэл, урсгал дансны алдагдал нь ДНБ-ий 2-оос 7 хувьтай тэнцэж байсан ба энэ нь дунджаар 4 хувь орчимд байлаа.

Зураг 7. 22. Австралийн төрийн сектор дахь гадаад цэвэр өр төлбөр



Эх сурвалж: Австралийн статистикийн газар

• Татварын системийн зохистой бодлого

19-р зууны сүүл үед Австралийн 6 колони тус бүр гаалийн болон онцгой татвараас бүрэн хамааралтай татварын тогтолцоотой байсан. Эдгээр татварын тогтолцоо нь үр ашигтай байдлыг хангахаас илүүтэйгээр захиргаадгалтын шинж чанартай байв.

Австралийн хамгийн анхны татвар нь гааль болон онцгой татвар юм. Гаалийн татвар нь колони улсууд хоорондын худалдаанд хязгаарлалт тавих зорилготой байсан боловч колони улсууд нэгдсэний дараагаар худалдааны чөлөөт байдлыг хангах зорилгоор тус татваруудыг халсан.


Австралийн Татварын Алба нь 1910 оны Газрын татварын тухай хуульд /Land Tax Act 1910/ үндэслэн, Газрын татварын Комиссар /Commissioner of Land Taxation/-ын удирдлага дор, Сангийн яамны салбар хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Засгийн газрын хэрэгжүүлж буй татварын бодлого нь татварын тогтолцооны тэгш шударга байдал, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн. 1980 онд хөрөнгө борлуулсны татвар, цалингийн урамшууллын татвар, мөн 2000 онд бараа үйлчилгээний татвар зэргийг бий болгох замаар татварыг төрөлжүүлсэн.

Өнөөгийн байдлаар Австрали Улсын татварын орлого нь 125 төрлийн татварын орлогоос бүрддэг ба үүнээс 99 нь засгийн газрын, 25 нь мужийн, 1 нь орон нутгийн засаг захиргаанаас ногдуулдаг байна.

Татварын нийт орлогын дийлэнх хувийг аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын татвар, бараа үйлчилгээний татвар, цалингийн татвар, үл хөдлөх хөрөнгийн татварын орлого нь тус тус бүрдүүлдэг.

Зураг 7. 23. Татварын орлогын задаргаа /1980–2015/




Эх сурвалж. OECD statistics

Нийт татварын орлогын хэмжээ 1980 оноос эхлэн өссөн дүнтэй байгаа ба засгийн газраас 1996–1997 онд татварын ачааллыг нэмэгдүүлэхгүй байх сангийн бодлогыг хэрэгжүүлсэн ба татварын орлогын хэмжээ өссөн нь аж ахуйн нэгж байгууллагын орлогын болон хувь хүний орлогын албан татварын орлого өссөнтэй холбоотой юм.

1. Company income tax– Аж ахуйн нэгжийн орлогын татвар

Австралийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын түвшин 1980 оноос эхлэн буурч эхэлсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээг бууруулахдаа татвар ногдуулах орлогын дээд хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 1980–1986 оны хооронд 46 хувьтай байсан бол 2017 оныг хүртэл татварын хувь хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 7. 24. Аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь /1980–2017/



Эх сурвалж: *The Treasury, Australian government*

1980 оноос хойш Австрали Улсын аж ахуйн нэгжийн орлогын татварын хувь хэмжээ буурсан дүнтэй ба доорх шалтгаануудыг үндэслэж татварын хэмжээг бууруулсан байна.

Хүснэгт 7. 8. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын өөрчлөлт


№	Он	Тайлбар
1	1986	Хувь хүний орлогын албан татвар ногдуулах дээд хязгаар өссөнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг өсгөх шаардлага үүссэн. Татвар ногдох орлогын интервал өөрчлөгдсөнөөс гадна ногдол ашгийн татвар, хөрөнгө орлогын татвар, шуудангийн татварыг шинээр нэвтрүүлсэн.
2	1988	Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг сайжруулахын тулд хүүгийн хэмжээг бууруулсан. Татвар ногдуулах орлогын суурь нэмэгдсэн ба алт олборлолтын үйл ажиллагааг чөлөөлж, зарим салбар дахь элэгдлийн зардлыг давхар бууруулах аргыг халсан, хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг хассан.
3	1993	Эдийн засгийн хямралын үед сангийн тэлэх бодлого буюу татварыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хүүг бууруулж, элэгдлийн зардлыг давхар бууруулах аргачлалаар байгуулж, татвар ногдох орлогыг бууруулсан.
4	1995	Эдийн засгийн сэргэлтийн үед сангийн хумих бодлого хэрэгжүүлсэн. Татвар ногдуулах хүүгийн хэмжээг нэмэгдүүлсэн, татвар ногдох орлогын суурь тогтмол байсан.
5	2002	Олон улсын хэмжээнд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хүүгийн хэмжээг бууруулсан. Элэгдлийн зардлыг давхар бууруулах аргачлалыг халж, хөрөнгө борлуулсны татварыг зогсоосон, мөн хувийн үйлчилгээний татвар болон арилжааны бус алдагдлын шинэ зохицуулалтыг оруулж, улмаар татвар ногдуулах орлогын суурийг нэмэгдүүлсэн.

2. Personal income tax –Хувь хүний орлогын албан татвар

1915 онд орлогын албан татвар нь шаталсан хувь хэмжээний дагуу өсдөг байсан ба 3 хувиас 25 хувь хүртэл хэлбэлздэг байв. Татвар ногдуулах орлогын доод хэмжээг өндрөөр тогтоож өгдөг байсан ба нийт хүн амын хамгийн өндөр орлоготой 20 хувь нь хувь хүний орлогын албан татварын дийлэнх хувийг бүрдүүлж байжээ.

1942 оны эдийн засгийн хямралын үеэр өмнөд Австралийн засгийн газар олсон орлогынхоо хэмжээгээр татвар төлөх системийг /Pay-As-You-Earn (PAYE) / бий болгосон. PAYE систем нь татвар төлөгчдөд илүү таатай орчныг бүрдүүлсэн ба засгийн газрын татварын орлогыг нэмэгдүүлж байжээ.

Зураг 7. 25. Татвар ногдуулах орлого ба татварын хувь /1980–2008/



Эх сурвалж: OECD

1980 онд 4,042–17,239 долларын татвар ногдох орлогод 32 хувийн татварыг ногдуулдаг байсан бол орлогын доод интервал 2008 онд 6,001–34,000 доллар болж өссөн ба тус орлогод 15 хувийн татварыг ногдуулдаг болсон. Дээрх графикаас харахад хувь хүний татвар ногдох орлогын интервалыг нэмэгдүүлэхэд хүүгийн хэмжээг бууруулсан төлөв ажиглагдаж байна.

3. Goods and service tax– Бараа үйлчилгээний татвар

2000 оны 7–р сард, татварын шинэ систем буюу өргөн хэрэглээний бараа үйлчилгээнд суурилсан бараа үйлчилгээний татвар /Австралийн нутаг дэвсгэрт худалдагдаж борлуулагдсан ихэнх бараа үйлчилгээнд ногдуулах татвар/–ыг ногдуулж эхэлсэн. Энэ нь 1998 оны гол сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгагдсан ажил бөгөөд Австралийн татварын системийн хамгийн том шинэчлэл байлаа.


Ховард нь 1998 оны 10–р сард сонгуульд ялалт байгуулсныхаа дараагаар Сангийн яам, Австралийн татварын алба, Нийгмийн даатгалын хэлтэс, Ерөнхий сайдын ажлын албанаас нийт 30 мэргэжилтнийг татварын багцыг хөгжүүлэхээр ажиллуулсан. Энэхүү татварын хуулийг Засгийн газрын дээд танхим /The Senate/–аар батлуулахаар тохирч, татварын түвшнийг бүх газар нутагт 10%–аар тогтоосон ба энэ нь одоог хүртэл тогтмол үйлчилж байна.

Уг шинэчлэлийн гол зорилго нь Засгийн газрын төсвийн орлого дахь орлогын татварын суурийг

өргөтгөхөд оршиж байсан. Энэхүү татвар нь орон нутгийн шууд бус татвар, түүний дотор борлуулалтын татвар, банкны дансны татвар зэргийг орлож, мөн хүн амын орлогын албан татвар, компанийн албан татварын хэмжээг бууруулах нөлөөтэй байсан юм. Тиймээс орлогын татваруудын бууралт нь энэхүү шинэчлэлийн салшгүй нэг хэсэг байсан.

Бараа үйлчилгээний татварыг бүх бүтээгдэхүүн, үйлчилгээнд тэгш ногдуулдгаараа давуу. Тус татварыг эцсийн хэрэглэгчээс бусад бүх талуудад буцаан олгодог. Австралид бизнес эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн нийт орлого нь 75,000 ам.доллараас дээш бол бараа үйлчилгээний татвар төлөгчөөр бүртгүүлэх шаардлагатай. Харин босгоос доогуур байгаа аж ахуйн нэгжүүд сайн дураараа бүртгүүлдэг.

Зураг 7. 26. Бараа үйлчилгээний татварын нийт орлогод эзэлж буй хэмжээ



Эх сурвалж: OECD

2015 оны байдлаар бараа үйлчилгээний татвар нийт татварын орлогын 27.53 хувийг бүрдүүлж байгаа ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 0.4 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм.


4. Capital gain tax– Хөрөнгө зарж борлуулсны татвар

Австрали Улс нь 1985 оноос өмнө хөрөнгө зарж борлуулсан орлогын татварыг ногдуулдаггүй байсан. 1985 онд Засгийн газраас “Хөрөнгийн үнийн өсөлт нь бодит цалин, цалин хөлс, хүү, ногдол ашгийн бодит өсөлттэй адил худалдан авах чадварын өсөлтийг илэрхийлж байгаа тул орлогын дэлгэрэнгүй тодорхойлолтод хамрагдах ёстой” гэж үзэн хөрөнгө зарж борлуулсны татварыг бий болгосон.

Үндэсний хуримтлалыг нэмэгдүүлэх

Австрали Улсын хувьд хадгаламж, хөрөнгө оруулалтын аль аль нь ДНБ–д эзлэх хувиар бусад улс орнуудтай харьцуулахад өндөр байх хандлагатай байдаг. Гэвч хөрөнгө оруулалт нь хадгаламжийн хэмжээнээс давсан тул урсгал дансны алдагдал ихтэй байв. Гэсэн хэдий ч үндэсний хадгаламжийн хүү өндөр байгаа нь урсгал дансны алдагдлыг сүүлийн жилүүдэд бууруулж байгаа юм.


Зураг 7. 27. Хадгаламж, хөрөнгө оруулалт, ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: ABS

1970–аас 1980–аад оны дунд үе хүртэл өрх болон засгийн газрын үндэсний хуримтлалын ДНБ-д эзлэх хувь буурч байсан. 1990–ээд оноос Австралийн Засгийн газраас албан журмаар тэтгэврийн сан (Superannuation system)–д хамруулж, түүгээрээ дамжуулан үндэсний хадгаламжийг өсгөх бодлого хэрэгжүүлсэн.

Зураг 7. 28. Үндэсний нийт хадгаламж, сектороор



Эх сурвалж: Австралийн статистикийн хороо

Супераннуэшн систем

1973 онд Витламын засгийн газар “National Superannuation Committee of Inquiry”–ийг байгуулсан ба 1974 онд Австралийн Статистикийн газрын хийсэн үндэсний анхны тэтгэврийн судалгаагаар нийт ажиллах хүчний 32 хувь нь тэтгэврийн санд хамрагдсан гэсэн үр дүн гарсан байна.

Үүний дараа 1990 оноос тэтгэврийн сангийн тогтолцоог боловсронгуй болгож, тэтгэврийн орлогын зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн юм. Тэтгэврийн сангийн гол зорилго нь үндэсний хадгаламжийг өсгөхөд чиглэсэн ба 1992 онд Superannuation Guarantee (SG)–г байгуулснаар үндэсний хадгаламж их

хэмжээгээр өссөн. Мөн 1993 онд Австрали Улс тэтгэврийн орлогын зохицуулалтын 3 тулгуурт бодлого /Age pension, The superannuation guarantee, voluntary saving for retirement/-ыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн юм. Дээрх 3 бодлогын талаар авч үзвэл:

- 1. Age pension:** Амьжиргааны доод түвшнийг хангаж чадахуйц тэтгэврийн орлогыг олгох хэлбэр юм. Бага болон дунд орлоготой ажилчдын тэтгэврийн орлого нь өндөр орлоготой ажилчдынхаас бага байдаг ба тэдгээрийн төлөвлөсөн хадгаламж нь амьдралд хүрэлцдэггүй, огт хөдөлмөр эрхлээгүй, эмзэг бүлгийн, гадаадад урт хугацаанд ажилласан хүмүүст тус тэтгэврийг олгодог. Татвар төлөгчдийн татвараар санхүүжигддэг Age pension нь мөн хөрөнгө оруулалт, инфляци болон урт хугацааны эрсдэлээс хамгаалахад зориулагддаг.
- 2. The superannuation guarantee:** Энэ нь хувийн хадгаламж буюу хөрөнгө хуримтлуулах хэрэгсэл бөгөөд тэтгэвэрт гарсан ажилчдын эрүүл мэндийг сайжруулахад хувь нэмэр оруулдаг. Хувийн нэрийн дансанд хуримтлал үүсдэг тул орлогын дахин хуваарилалт, төрийн хөрөнгө оруулалт зэргийг энэ сангаас гаргах боломжгүй юм. Албан журмаар орлогоос суутгадаг.
- 3. Voluntary saving for retirement:** Энэ нь тэтгэврийн орлогын тогтолцооны гурав дахь тулгуур бөгөөд superannuation системийн сайн дурын хэсэг буюу албан шаардлагаар бус сайн дурын үндсэн дээр тэтгэврийн хадгаламж нээхийг хэлнэ.

1990 оноос 2007 он хүртэл тэтгэврийн тогтолцоог хамгийн уян хатан болгох хүрээнд хууль эрх зүйн шинэчлэлтийг эрчимтэй хийсэн. Дээрх бодлого, шийдвэрийн үр дүнд, нийт ажиллагсдын 90% нь тэтгэврийн санд хамрагдаж, тэтгэврийн сангийн нийт хөрөнгө нь 1 их наяд ам.доллар давсан. Доорх хүснэгтэд 1986 оноос 2007 он хүртэлх тэтгэврийн системд хийгдсэн голлох үйл явдлыг харууллаа.

Хүснэгт 7. 9. Голлох үйл явдал 1986–2007 он

№	Он	Голлох үйл явдал
1	1990 он	Тэтгэврийн сангийн нийт хөрөнгө 123 тэрбум ам.доллар байсан ба нийт ажил эрхлэгчдийн 64% нь тэтгэврийн сантай болсон.
2	1991 он	Сангийн сайд John Kerin SG тэтгэврийн хадгаламжийн шинэ системийг төсөвт оруулсан.
3	1992 он	SG-г хэрэгжүүлснээр нийт ажил эрхлэгчдийн 72% нь тэтгэврийн хадгаламжтай болсон.
4	1993 он	The Superannuation Industry (Supervision) Act 1993 (SIS Act)-ыг баталсан. Энэ нь тэтгэврийн сангийн чухал зохицуулалтуудыг тусгасан байдаг.
5	1994 он	Эмэгтэй хүний тэтгэврийн насыг өсгөж 65 болгосон.
6	1995 он	Нийт ажил эрхлэгчдийн 80.5% нь тэтгэврийн сантай болсон.
7	1996 он	Тэтгэврийн сангийн нийт хөрөнгө 245.3 тэрбум ам.доллар байсан ба энэ нь ДНБ-ий 37.9% байв.
8	1997 он	Ховардын засгийн газар тэтгэврийн бодлогод шинэ өөрчлөлт шинэчлэлтийг хийсэн. Retirement savings accounts (RSA)/ Тэтгэврийн хадгаламжийн дансыг нээсэн. Тэтгэвэрт гарах насыг 65-аас 70 болгож өсгөсөн.
9	1998 он	Australian Prudential Regulation Authority (APRA) нь 1998 оны 7-р сарын 1-нд байгуулагдсанаар тэтгэврийн зохицуулалтыг хэрэгжүүлэх болсон. Гэхдээ Австралийн татварын алба тэтгэврийн татвартай холбоотой асуудлыг шийдвэрлэдэг хэвээр үлдсэн.
10	1999 он	SIS Act-д тэтгэврийн сантай холбоотой жижиг хэсэг нэмж оруулсан. Үүнд, Австралийн татварын алба нь тэтгэврийн хадгаламжтай холбоотой харилцааг зохицуулах Self managed superannuation fund гэсэн сантай байна гэж заасан.

11	2000 он	Тэтгэврийн сангийн нийт хөрөнгө 484.2 тэрбум ам.доллар ба нийт ДНБ-ий 63%-ийг эзэлж байлаа. Мөн нийт хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 87% нь тэтгэврийн санд хамрагдсан байв.
12	2002 он	Гэр бүлийн гишүүд салахдаа тэтгэврийн сангийн хөрөнгөө хувааж авч болох зохицуулалт хийсэн.
13	2003 он	Тэтгэврийн сангийн нийт хөрөнгө 546.8 тэрбум ам.доллар ба нийт ДНБ-ий 65.2%-ийг эзэлж байлаа. Мөн нийт хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн 90% нь тэтгэврийн санд хамрагдсан байв.
14	2004 он	Тэтгэврийн орлогын системийг илүү уян хатан, дасан зохицох боломжтой болгосон. Энэ нь 65 нас хүрэхээсээ өмнө өөрийн хүсэлтээр тэтгэвэрт гарах бүрэн боломжтой гэсэн зохицуулалт юм. 2 өөр тэтгэврийн данс хооронд мөнгөн хөрөнгийг шилжүүлэх боломжтой болгосон.
15	2006 он	Сангийн сайд Costello-ын шийдвэр: - 60-аас дээш настай Австралийн иргэд татвараас чөлөөлөгдөх - Тэтгэмжийн орлогыг татваргүй болгох - Тэтгэврийн сангийн орлогыг татваргүй болгох - Сангуудын хооронд шилжүүлэг хийхэд амар болгох
26	2007 он	Тэтгэврийн сангийн нийт хөрөнгө 1,153.3 тэрбум ам.доллар ба ДНБ-ий 119% болсон.

НАЙМ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

1970 –аад оны санхүүгийн зах зээл

- Зохицуулалтын орчин

Австралийн санхүүгийн зах зээлийн зохицуулалтыг сулруулах үйл ажиллагаа 1970–аад оны эхэн үеэс эхэлсэн. Тухайн үед санхүүгийн систем дэх хяналт маш хатуу байсан бөгөөд дараах зорилгын хүрээнд хэрэгжиж байсан. Үүнд:

- Эдийн засаг дахь мөнгөний зах зээлийг хянах механизмыг бүрдүүлэх;
- Засгийн газрыг санхүүжүүлэх Засгийн газрын үнэт цаасны хаалттай зах зээлийг бий болгох;
- Банкны салбарт учирч болох эрсдэлийг бууруулах;
- Эрх баригчдын тэргүүлэх гэж үзэж буй салбарт зээлийг хуваарилах боломжийг бүрдүүлэх;
- Валютын ханшийг тогтвортой хадгалж, дотоодын хадгаламжийн урсгалыг хамгаалах.


Дээрх зорилгын хүрээнд дараах хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн:

- Банкны зээлийн болон хадгаламжийн хүүд харилцан адилгүй хяналтыг тавьж байсан. Энэ нь банкны тэлэлт, өөрөөр хэлбэл хөрөнгөө нэмэгдүүлэх үйл ажиллагаанаас хамгаалах зорилготой байв.
- Банкны нөөцийн болон хөрвөх чадварын харьцааг тодорхойлж өгдөг байсан бөгөөд энэ нь төлбөрийн тэнцлийн болон сангийн бодлогоос нийт хөрөнгөд үзүүлж буй хоёр дахь үеийн нөлөөллийг хянах хэрэгсэл болдог байсан.
- Банкны зээлийн хэмжээ болон салбаруудад оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг хянадаг байсан.
- Санхүүгийн байгууллагууд нь ихэвчлэн төрөлжсөн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байв. Худалдааны банк нь бизнесийн зээл, хадгаламжийн банк нь өрхийн болон орон сууцны зээл, санхүүгийн компаниуд нь эрсдэл өндөртэй хөрөнгийн зээл болон иргэдийн зээл олгодог байсан.
- Бүх гадаад валютаарх шилжүүлэг нарийн хянагддаг байсан ба гүйлгээ бүрийг нэг бүрчлэн шалгадаг байв. Мөн хилийн чанадад хөрөнгө оруулалт хийхийг хориглодог байсан. Учир нь эрх баригчид ихэвчлэн дотоодын хадгаламжийг дотоодын хөрөнгө оруулалтад зарцуулахыг зорьж байв.
- Валютын ханшийг маш хатуу зохицуулдаг байсан. 1970–аад оны эхэн үед Бреттон Вүүдс нурах үед бусад хөгжсөн орнуудын адил хөвөгч ханшийн систем рүү шилжээгүй юм.

1960 болон 1970–аад оны үеүдэд Австралид ихээхэн хэмжээний мөнгөн хөрөнгийн дотогшлох урсгал бий болсон ба энэ нь эрх баригчдыг дотоодын мөнгөн хөрөнгийг удирдахад хүндрэл учруулж байсан юм. Ялангуяа тогтмол валютын ханшийн системтэй үед хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдсэнээр нийт эдийн засаг дахь санхүүжилтийн хэмжээ өсөж, дотоодын хөрвөх чадварыг нэмэгдүүлж байсан нь бусад эдийн засгийн үзүүлэлтүүдийг зохистой хэмжээнд удирдахад бэрхшээлтэй болгосон. Иймд хөрвөх чадварыг бууруулах үүднээс банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээнд өөрчлөлт оруулсан боловч төдийлөн амжилттай хэрэгжээгүй ба банкны нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь буурч банк бус санхүүгийн байгууллагуудын зах зээлд эзлэх хувь хэмжээ ихэссэн. Мөн нээлттэй эдийн засгийн үйл ажиллагааны тусламжтайгаар хөрвөх чадварыг бууруулах арга хэмжээг авч байсан боловч энэ нь улмаар хүүгийн түвшнийг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлж хөрөнгийн дотогшлох урсгалыг улам дэмжиж байв.

Банкны зохицуулалтыг сулруулж эхэлсэн нь дотоодын эдийн засгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болж байв. Тухайлбал, 1971 онд банкны зээлийн хэмжээнд тавьж байсан хяналтыг хэрэгсэхгүй болгож, 1972 онд их хэмжээний зээлийн хүүгийн таазыг арилгаснаар банкуудад хөрөнгөө улам ашигтайгаар зээлдүүлэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн юм. Цаашлаад 1973 онд хадгаламжийн сертификатад төлөгдөх хүүгийн түвшний таазыг зогсоосноор банкуудад нэмэлт хөрөнгөө үр ашигтайгаар зарцуулах боломжийг олгосон. Эдгээр хүчин зүйлс банкны зээлийн хэмжээг өсөхөд түлхэц болсон бөгөөд зээлийн өсөлт 1973 онд 30 хувиас дээш өсөлттэй байв.

Зураг 7. 29. Австралийн дотоодын зээлийн өсөлт



Эх сурвалж: Австралийн нөөцийн банк, Authors' calculations, Foster 1996

- Бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Их хэмжээний мөнгөний дотогшлох урсгал, тэр дундаа дотоодын хөрвөх чадвар болон зээлийн өсөлтөд нөлөөлөх нөлөөллийн эсрэг эрх баригчдын авсан хариу арга хэмжээний нэг нь 1972 оны сүүлчээр Австрали долларын ам.доллартай харьцах ханшийг 7 хувиар өсгөсөн явдал байв.

Түүнчлэн 2 жилээс богино хугацаатай гаднаас авсан зээлд хориг тавьж, 2 жилээс дээш хугацаатай гаднаас авсан зээлд “Variable deposit requirement (VDR)” гэх шаардлагыг тавьж өгсөн. VDR-ийн хүрээнд зээлийн эргэн төлөлт хийгдэх хүртэл гаднаас авсан зээлийн тодорхой хувийг Австралийн Төв Банкны хүүгүй дансанд байршуулахыг шаарддаг байсан ба VDR нь гаднаас авах зээлд татварын үүргийг гүйцэтгэх зарчмаар зээлийн өртгийг ихэсгэж байв. Иймд тус шаардлагыг нь 1977 оны 7 дугаар сард хэрэгсэхгүй болгосон бөгөөд энэхүү зарчмыг дахин нэвтрүүлээгүй юм.

Банкны маш өндөр хяналтаас шалтгаалан банкнаас бусад санхүүгийн салбар хөгжиж эхэлж, банкуудын зах зээлд эзлэх хувь буурч эхэлсэн тул эрх баригчид банкны салбарын зохицуулалтыг сулруулж эхэлсэн ба энэ нь дараах шалтгаанаас үүдэлтэй байв.

- Нэгдүгээрт, хатуу хяналт нь банкуудын байр суурийг ганхуулж, тэдгээр нь хэрэглэгчдийнхээ хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахгүйд хүрсэн. Улмаар банкны нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь эрс буурч, 1950–аад оны эхээр 70 хувьтай байсан банкны зах зээлийн хувь хэмжээ 1980–аад оны эхээр 40–өөд хувь хүртлээ буурсан.

- Хоёрдугаарт, хяналт, зохицуулалтгүй шинэ санхүүгийн зуучлагчдад санхүүжилт олгож эхэлснээр хяналтын систем үр дүнгүй болсон.
- Гуравдугаарт, Бреттон Вүүдсийн тохиролцооны дараа олон улсын хөрөнгийн урсгал нэмэгдсэн нь Австрали долларын ам.доллартай харьцах ханшийн дарамтыг нэмэгдүүлсэн. Эрх баригчид гадаад валютын их хэмжээний гүйлгээ хийх замаар валютын ханшийг тогтворжуулахыг хичээж байсан боловч энэ нь дотоодын хөрвөх чадвар, ерөнхийдөө дотоодын санхүүгийн зах зээлийг зохицуулахад төвөгтэй болгосон.
- Дөрөвдүгээрт, санхүүгийн систем нь үр ашиггүй байсан ба өөрөөр хэлбэл хүүгийн ашгийн зөрүү өндөр, шинэ санаачилга тун бага мөн зээл авах чадвартай боловч зээлийн үйлчилгээгээр хангагдаж чадахгүй иргэдийн тоо их байв.

Улмаар банкны зохицуулалтыг сулруулах хүрээнд 1973 онд хадгаламжийн сертификатын хүүд тогтоосон таазыг хэрэгсэхгүй болгосон. Энэ нь банкуудад хөрөнгө оруулалт татах мөн банкны удирдах боломжтой өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн.

• Зах зээлд гарсан үр дүн

1976 онд хөрөнгө оруулагчид валютын ханшийг улам сулруулахад хүргэсэн бөгөөд энэ нь тодорхой тогтоож өгсөн хязгаарын хүрээнд хэлбэлзэх тогтмол ханшийн системд шилжихэд хүргэсэн. Ханшийг Нөөцийн банк, Эрдэнэсийн сан болон Ерөнхий сайд, Засгийн газрын танхим хамтран тогтоодог байсан. Энэ үед компаниудын гаднаас авах хөрөнгө оруулалт нэмэгдэж, улмаар валютын ханш өндөр хэлбэлзэлтэй болж ханшийн эрсдэл нэмэгдсэн юм.

Зураг 7. 30. Австралийн нэрлэсэн болон бодит валютын ханшийн түвшин



Эх сурвалж: Австралийн нөөцийн банк

Үүний үр дүнд, хувийн хэвшлийнхэн гадаад валютын ханшийн эрсдэлийн эсрэг албан бус зах зээлийг Non-deliverable forward market⁶ болгон хөгжүүлсэн нь одоо ч Австралийн аж ахуйн нэгжүүдийг ханшийн эрсдэлээс хамгаалах арга хэмжээний нэг хэвээр үлдсэн.

6 Non-delivery forward market – богино хугацаанд өөрийн валютыг урьдчилж тогтсон ханшаар чөлөөтэй хөрвөх валюттай ирээдүйд солих үйл явцыг хэлнэ

1980–аад оны санхүүгийн зах зээл

- **Зохицуулалтын орчин**

Зохицуулалтыг сулруулсны үр дүнд санхүүгийн зах зээл дэх инновац, интеграцчилалыг нэмэгдүүлсэн боловч, Австралийн валютын хяналтын системийг үр ашиггүй болгосон. Тухайлбал, Non-deliverable forward зах зээл нь их хэмжээний урьдчилсан төлбөр гүйцэтгэлгүйгээр валютын ханшид нөлөөлөх боломжийг зах зээлд оролцогчдод олгосон бол банкуудын хадгаламжийн хүүд тогтоосон таазын хязгаарлалтыг бүрэн арилгасан нь банкуудад гаднын хөрөнгө оруулалт татахад таатай нөхцөлийг бүрдүүлж өгсөн.


Түүнчлэн ирээдүйн валютын ханшийн өөрчлөлтийг хянах эсвэл Нөөцийн банкнаас мөнгөний бодлогыг хатууруулах оролдлого хийх бүрд хөрөнгийн урсгал их хэмжээгээр өөрчлөгдөж, хяналт хийхэд хүндрэлтэй болсон. Улмаар 1983 оны 12 дугаар сард Австрали долларын ханшийн системийг хөвөгч болгосон ба ихэнх хөрөнгийн хязгаарлалтуудыг зогсоосон. Харин гаднын Засгийн газар болон Төв банкны бонд, хадгаламжийн сертификат, хадгаламж гэх мэт хүү тооцдог хөрөнгийн худалдан авалтад хориг тавьсан хэвээр үлдсэн юм.

Ханшийг чөлөөт хөвөгч болгох үед банкны бүх хяналтыг арилгаагүй юм. Бүх хадгаламжийн хүүгийн таазыг арилгасан боловч зөвхөн 100,000 Австрали доллараас дээших дүнтэй зээлийн хүүгийн хязгаарлалт үйлчлэхгүй байхаар заасан. Жижиг зээлийн хувьд хязгаарлалт 1980–аад оны сүүл хүртэл үргэлжилсэн.

- **Зах зээлд гарсан үр дүн**

Австрали долларыг чөлөөт хөвөгч болгож, хязгаарлалтыг зогсоосон нь хүлээж байснаар маш том нөлөөг үзүүлсэн. Тухайлбал, Австрали иргэдийн гаднын улс орон руу хийх хөрөнгө оруулалтын хоригийг арилгаснаар хөрөнгийн гадагшлах урсгал нэлээд их хэмжээгээр нэмэгдсэн. Харин хөрөнгийн дотогшлох урсгалын хэмжээ илүү их хэмжээгээр өссөн ба хатуу зохицуулалттай байх үеийн түвшнээс ч өндөр хэмжээнд хүрсэн байна.


Зураг 7. 31. Австралийн албан бус секторт эзлэх нийт болон цэвэр мөнгөн хөрөнгийн урсгал, ДНБ–д эзлэх хувиар



Эх сурвалж: Австралийн нөөцийн банк

Валютын ханшийн систем хөвөгч болсноор валютын ханш илүү савлагаатай болсон тул Нөөцийн банкаас бага дүнгээр, илүү тогтмол байдлаар интервенц хийснээр хүүгийн түвшний хэлбэлзлийг тогтворжуулж эхэлсэн нь эрх баригчид санхүүгийн зах зээлд үүссэн нөхцөл байдлыг хянахад илүү хялбар болгосон. Улмаар 1990 оноос инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлэх болсон.

Зураг 7. 32. Хүүгийн түвшин ба валютын ханшийн хэлбэлзэл, 6 сарын гулгасан дундаж, сарын абсолют өөрчлөлтөөр



Ийнхүү хөвөгч ханшийн системд шилжсэнээр Австралийн эдийн засагт нэлээд ач холбогдолтой байсан. Гадаад валютын хэлбэлзэл нь мөнгөний бодлогын хараат бус байдалд эерэг нөлөө үзүүлэхээс гадна, түүхий эдийн нээлттэй экспортлогч улсын хувьд эдийн засгийн гадаад шоконд дасан зохицож, уян хатан тохируулга хийгдэх боломжоор хангасан. Мөн валютын ханшийн систем нь 1997–98 оны Азийн хямрал, 2000–аад оны технологийн хөөсрөлт болон 2008–09 оны дэлхийн санхүүгийн хямралын үеүдийн сөрөг нөлөөллийг саармагжуулах нөлөөтэй байсан юм.


Банкны зах зээл

1970 онд банкны зохицуулалтыг халах алхмуудыг хийснээс хойш Австралийн банкууд болон зохицуулагч байгууллагууд эрсдэлийг үнэлэх тал дээр туршлагагүй байснаас үүдэн банкууд өндөр эрсдэлтэй зээлдэгч нарт зээл олгож эхэлсэн байна. Мөн 1980 онд зах зээлд гаднын банкууд орж ирэх болсноор банкуудын өрсөлдөөн улам эрчимжсэн.

Зээлийн эрэлт нэмэгдэж, эрсдэлийг хянах тогтолцоо харьцангуй хөгжөөгүй мөн хөрөнгийн дотогшлох урсгал чөлөөтэй байсан нь өрсөлдөөнийг нэмэгдүүлж, зээлийн хэмжээг эрчимтэй өсгөж, улмаар

хөөсрөлт үүсгэж арилжааны зориулалттай үл хөдлөх хөрөнгийн зах зээл уналтад орж, банкууд их хэмжээний алдагдалд орсон. Энэхүү туршлага нь банкуудыг эрсдэлийн удирдлагадаа шинэчлэл хийж, зохицуулалтын тогтолцоогоо улам чадваржуулах шаардлагыг үүсгэсэн.

Зураг 7. 33. Австралийн зээлийн нэрлэсэн ДНБ-д эзлэх хувиар



Эх сурвалж: Австралийн нөөцийн банк

Хеджинг зах зээл

Хөвөгч ханшийн тогтолцооноос өмнө зах зээлд оролцогчид харьцангуй жижиг гадаад валютын үүсмэл санхүүгийн хэрэгслийн зах зээлийг хөгжүүлээд байв. Харин ханшийн систем солигдсоноос хойш жилийн дотор л Австралийн хеджинг зах зээл болон гадаад валютын зах зээл гурав дахин өсжээ.


Ямартаа ч хеджинг зах зээл хөгжихөд тодорхой цаг хугацаа, туршлага хуримтлуулах шаардлагатай байсан. Зарим аж ахуйн нэгжүүдийн хувьд чөлөөт хөвөгч ханшийн систем нэвтрэхээс өмнө тус зах зээлд арилжаа хийн гадаад валютын хэлбэлзлийг удирдах туршлага хуримтлуулж байсан бол зарим байгууллагын хувьд огт тус зах зээлийн талаар мэдлэггүй байв. Тухайлбал, 1980-аад оны дунд үед Швейцар франкаар зээл авсан зээлдэгчдийн тоо давамгайлах болсон ба 1985–86 оны хооронд Австрали долларын ханш огцом суларсны улмаас эдгээр зээлдэгчид урьдчилан таамаглагдаагүй өндөр зээлийн эргэн төлөлтийг хийх шаардлагатай болсон. Австралийн хеджинг зах зээл нь өнөөгийн өндөр түвшинд хүрч хөгжихөд хөвөгч ханшийн хэлбэлзэлтэй үеийн зах зээлд оролцогчдын хуримтлуулсан туршлага, тэдний өндөр оролцоо чухал нөлөөтэй байв.

1990 оны санхүүгийн зах зээл

- Зах зээлийн нөхцөл байдал

Банкууд маш өндөр алдагдалтай байсан бөгөөд 1990 онд 9 тэрбум долларын алдагдалтай байсан нь ДНБ-ийх нь 2.25 хувьтай тэнцэж байсан юм.

Зураг 7. 34. Банкны ашигт ажиллагаа, хувьцаа эзэмшигчийн хөрөнгө оруулалтын өгөөж



Note: Profit figures are adjusted to exclude the government assistance provided to the State Bank Victoria (SBV) and State Bank South Australia (SBSA). Adjusted after-tax figures for 1990 and 1991 are unavailable due to the large transfers between SBV, SBSA and their state government owners.

Source: Banks' financial statements

1980–аад онд банкны зохицуулалтыг халснаас хойш өрсөлдөөн нэмэгдэж банкууд хөрөнгөө ихэсгэх эрмэлзэлтэй байв. Энэ нь арилжааны үл хөдлөх хөрөнгийн үнийг эрчимтэйгээр нэмэгдүүлэхэд хүргэсэн. Үүний үр дүнд хэт өндөр үнэлгээтэй арилжааны үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан зээл өсөж эхэлсэн юм. 1989 онд бий болсон хүүгийн түвшин болон арилжааны үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт зэрэг нь зээлийн чанарыг муудуулснаар эдийн засаг уналтад орж, хөрөнгийн үнэ буурч эхэлсэн ба зээлийн чанарын үзүүлэлтүүд улам муудаж эхэлжээ. Үүний дараа 1992 оны дунд үед чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хэмжээ 6 хувьд хүрэн өссөн байв.

Иргэдийн санхүүгийн зах зээлд итгэх итгэл буурч эхэлсэн бөгөөд итгэлийг буцаан сэргээх үүднээс банкуудын хүүгийн марж өссөнөөр өрхүүдийн зээлийн хэмжээ нэмэгджээ. 1992 онд өрхийн өрийн хэмжээ дор хаяж 10 хувиар нэмэгдсээр 1994 онд 17 хувьтай тэнцэж байв. Улмаар өрхийн өрийн болон орлогын харьцаа 2 дахин өсөж, 1994 онд өрийн орлогод эзлэх хувь 54 хувь байсан бол 1999 онд 100 хувьд хүрсэн.

- **Бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Компаниудын нэгдэл ба өрсөлдөөнийг дэмжих: Томоохон 4 банк болон 2 даатгалын компанийг нэгтгэх “6 тулгуурт” бодлогыг баримталсан боловч эрх баригчид энэ бодлого өрсөлдөөнийг бууруулна хэмээн үзсэн. Хэдий энэхүү бодлогын үзэл баримтлалыг эсэргүүцэх сөрөг хандлага байсан боловч эцэстээ хүлээн зөвшөөрөгдсөн ба үүний дараагаар хэд хэдэн банк болон даатгалын компаниуд хоорондоо нэгдсэн байна. 1990 онд банкны системийн хөрөнгийн 1/3 нь төрийн өмчит 5 том банкны хөрөнгөөс бүрдэж байсан бөгөөд 10 жилийн хугацаанд 5 банкыг олон нийтэд эсвэл бусад банкуудад худалдах үйл явц явагдсан.

Зах зээлийн өсөлтийг хангах: Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, тэр дундаа ипотекийн зээлийн үйл ажиллагаа хөгжиж эхэлсэн. Түүнчлэн хөрөнгийн зах зээл хөгжиж эхэлсэн бөгөөд Австралийн


хөрөнгийн бирж хувьцааны арилжааг газар дээр бус цахимаар арилжаалдаг болсон.

Санхүүгийн үйлчилгээний хяналт шалгалт, зохицуулалтыг сайжруулах:

- Төв банкнаас эрсдэлд суурилсан болон газар дээрх хяналт шалгалтын системийг нэвтрүүлсэн.
- Бичил зээлийн байгууллагууд болон даатгалын компаниудын нэгдсэн, зохистой байдлыг хангахын тулд Австралийн Санхүүгийн Институтийн Хороог байгуулсан.
- 1995 онд Амьдралын даатгалын тухай хуулийг баталсан ба үүгээрээ төлбөрийн чадварын стандарт болон санхүүгийн тайлангийн шаардлагыг шинэчилж, амьдралын даатгалын компаниудын захирал, аудиторуд болон актуарчдын хариуцлагыг нэмэгдүүлсэн.

2000–аад оны санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал

• Зах зээлийн нөхцөл байдал



Эх сурвалж: Австралийн нөөцийн банк

Гадаад валютын зах зээл: Австралийн гадаад валютын зах зээл 1980 оноос хойш хоёр үе шаттай маш хурдацтай өсөж эхэлсэн. 1985–аас 1990 онд нэг өдрийн арилжаа дунджаар \$A5 тэрбумаас \$A44 тэрбум болтлоо өссөн бөгөөд жилд дунджаар 50 хувиар өссөн юм. 1990 онд хэсэг хугацаанд санхүүгийн салбарт компаниудын нэгдэл явагдаж зах зээлийн өсөлт удааширч байсан бол 1992 оноос буцаад хурдацтай өсөж 1995 он гэхэд өдрийн дундаж арилжаа \$A50 тэрбумд хүрч зах зээлийн өсөлт тогтворжсон.

Энэхүү өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл бол санхүүгийн зах зээлийн зохицуулалтын сулруулалт байсан бөгөөд тэр дундаа тогтмол ханшийн тогтолцооноос хөвөгч ханшийн тогтолцоонд шилжсэн үйл явдал нь Австралийн гадаад валютын зах зээлийг олон улсад нээлттэй болгож, эрчимтэй өсөлтийг бий болгосон юм.

Өрийн зах зээл: Гадаад валютын зах зээлтэй адил Австралийн өрийн зах зээл нь 1980–аад оноос өсөж эхэлсэн. Австралийн өрийн зах зээл нь урт ба богино хугацаат өрийн зах зээлээс бүрддэг. Урт хугацаат өрийн зах зээл нь хамтын нөхөрлөлийн үнэт цаас, засгийн газрын үнэт цаас /ЗГҮЦ/, компанийн бонд, ипотекийн зээл зэргээс бүрддэг бол богино хугацаат өрийн зах зээл нь богино хугацаат банкны үнэт цаас, компанийн үнэт цааснаас бүрддэг.

Урт хугацаат өрийн зах зээл нь хамгийн идэвхтэй бөгөөд нийт арилжааны хэмжээ, улсын нийт өртэй уялдаатай байдаг. Хамтын нөхөрлөл бондын зах зээлийг хөгжүүлэх үүднээс зах зээлд гаргаж буй бондын бүтэц, төрлүүдээ шинэчилж арилжааг идэвхжүүлсэн. 1985 онд Хамтын нөхөрлөл 300 сая долларын дундаж хэмжээтэй 153 төрлийн бонд санал болгож байсан бол одоогоор 51 төрөл болгон

бууруулаад байна. Үүнээс 4–5 тэрбум долларын дүнтэй 20 төрлийн жишиг бондууд дийлэнх хувийг эзэлдэг. Эдгээр бондууд нь 1980 онд зах зээлийн 30 хувийг эзэлдэг байсан бол өнөөдрийн байдлаар нийт бондын зах зээлийн 97 хувийг эзэлж зах зээлийн хөрвөх чадварыг сайжруулж байна.

Австралийн урт хугацаат өрийн зах зээлийн нэг онцлог нь компанийн бонд сайн хөгжөөгүй явдал юм. 1970–80 оны өндөр инфляцитай үед зээлдэгч нар урт хугацааны зээлийн гэрээнд орох хүсэлгүй байсан. Компаниуд ихэвчлэн бондоо гадаадын хөрөнгийн зах зээлд гаргадаг бөгөөд 1993 оноос хойш Австралийн бондын зах зээл дэх нийт компанийн бондын хэмжээ буурсаар байна.

1980–аад онд банкуудад заавал байлгах нөөцийн шаардлага тавьж эхэлснээс хойш мөнгөн тэмдэгтийн арилжаа огцом өссөн. Заавал байлгах нөөцийн шаардлага нь мөнгөн тэмдэгттэй холбоотой санхүүгийн хэрэгсэлд нөлөөлдөггүй байсан тул энэхүү шаардлагаас зугтахын тулд банкууд богино хугацаат өрийн хэрэгслүүдээ мөнгөн тэмдэгттэй холбож эхэлсэн байна.

Хувьцааны зах зээл: Бусад санхүүгийн зах зээлийн адил Австралийн хөрөнгийн бирж /АХБ/-ийн нийт арилжааны хэмжээ өнгөрсөн 10 жилийн туршид хүчтэй өссөн. Санхүүгийн зохицуулалтыг бууруулсны дараагаар 1995 онд АХБ-ийн арилжааны хэмжээ 133 тэрбум доллар хүрч дээд амжилтаа тогтоож байсан. Энэ нь гурван жилийн өмнөх үетэй харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлт юм. Мөн зах зээлийн үнэлгээ 10 жилийн өмнөхөөс тав дахин өсөж 546 тэрбум доллар хүрсэн нь бүртгэлтэй компаниудын үнэлгээ өссөнтэй холбоотой юм.

Санхүүгийн зах зээлийн даяарчлал Австралийн хувьцааны зах зээлийн өсөлтөд өндөр нөлөөтэй. 1985 онд нийт 15 тэрбум долларын зах зээлийн үнэлгээтэй 18 компани байсан бол 10 жилийн дотор бүртгэлтэй гадаад компанийн тоо 49 болж зах зээлийн үнэлгээ нь 217 тэрбум доллар болсон байна. Харин 2017 оны 11 дүгээр сарын байдлаар АХБ дээр бүртгэлтэй гадаад компанийн тоо 136 байна. Австралийн хөрөнгийн зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь 2000–2007 онд 47 пунктээр өссөн бөгөөд энэ нь бүртгэлтэй компанийн тооны өсөлтөөс бус, хувьцааны үнэлгээ эрчимтэй өссөнтэй холбоотой байв.

Эдгээр дэвшлээс үүдэн Австралийн хувьцааны зах зээл 1995 он гэхэд нийт арилжааны хэмжээгээр OECD-ын улсуудаас ес дэх хамгийн идэвхтэй зах зээлд бичигдсэн. Азийн зах зээлтэй харьцуулахад зах зээлийн үнэлгээгээр Япон, Хонконгийн араас гуравт бичигдэж эхэлсэн юм. Харин нийт арилжааны хэмжээгээр авч үзэхэд тавт жагссан. Үүнээс харахад Австралийн зах зээл Азийн зарим зах зээлийг бодвол хувьцаа эзэмшилт харьцангуй тогтвортой түвшинд хүрсэн юм.

Банкны зах зээл: 2007 оны байдлаар банкны хадгаламж болон нийт хөрөнгийн ДНБ-д эзлэх хувь харгалзан 0.85, 1.14 хувь байв. Банканд байршуулсан хадгаламж болон нийт хөрөнгийн ДНБ-д харьцуулсан харьцаа харьцангуй бага байгаа нь хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй. Эдгээр шалтгаануудын нэг нь өрхүүд хөрөнгийнхөө дийлэнх хувийг буюу ДНБ-ий 70 хувьтай тэнцэх хөрөнгийг тэтгэврийн санд байршуулах сонирхолтой байгаа бөгөөд үүний үр дүнд хөрөнгө удирдлагын салбар эрчтэй хөгжих болсон. Харин 2 дахь шалтгаан нь сүүдрийн банкны хөгжилтэй холбоотой юм.

Хүснэгт 7. 10. Австралийн санхүүгийн системийн үзүүлэлтүүд (ДНБ–д харьцуулсан харьцаа)


	2000		2007	
	OECD	Австрали	OECD	Австрали
Банкны хадгаламж	0.82	0.62	1.00	0.85
Банкны хөрөнгө	1.00	0.87	1.31	1.14
Гадаадын банкаас авсан зээл	0.76	0.14	1.08	0.17
Хувийн бондын зах зээлийн үнэлгээ	0.35	0.27	0.54	0.57
Нээлттэй бондын зах зээлийн үнэлгээ	0.43	0.20	0.44	0.13
Зах зээлийн үнэлгээ	1.00	1.00	1.04	1.47

Эх сурвалж: Дэлхийн банк

Гаднын банкаас авсан зээлийн хэмжээний хувьд OECD–ийн орнуудтай харьцуулахад төдийлөн өсөлттэй биш байсан ба өөрөөр хэлбэл 2007 онд OECD–ийн орнуудын хувьд гаднын банкаас авсан зээлийн ДНБ–д эзлэх хувь 32 пунктээр өссөн бол Австралийн хувьд 3 пунктээр өссөн байгаа юм.

Зээлийн үзүүлэлтийг авч үзвэл банк санхүүгийн зах зээл дэх нийт зээлийн хэмжээ 2017 оны 3 дугаар улирлын байдлаар 2,683.4 тэрбум долларт хүрээд байгаа бөгөөд үүнээс банкны салбарын олгосон зээлийн хэмжээ 2,494.8 тэрбум ам.доллар, банк бус санхүүгийн байгууллагын олгосон зээлийн хэмжээ 145.8 тэрбум ам.доллар, бусад зээлийн хэмжээ 43.8 тэрбум ам.доллар байна.

Зураг 7. 35. Австралийн нийт зээлийн бүтэц, санхүүжилт олгож буй байгууллагаар, тэрбум ам.доллар



Банкны зах зээлийн зохицуулалтын хязгаарлалтыг зогсоосонтой холбоотойгоор, банкны зээлийн нийт санхүүгийн зах зээлд эзлэх хувь хэмжээ өндөр байгаа бол банк бус санхүүгийн байгууллагын хувьд бууралттай байна. Тухайлбал 1980 онд банк болон банк бус санхүүгийн зах зээлийн нийт зээлд эзлэх хувь хэмжээ ижил 46 хувь байсан бол 2017 оны 3 дугаар улирлын байдлаар банкны зах зээлийн эзлэх хувь 93 хувь, банк бус санхүүгийн байгууллагын эзлэх хувь 3 хувь байна.

- **Бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

Тэтгэврийн санг байгуулснаар хөрөнгийн хуримтлал болоод урт хугацааны хадгаламжийг нэмэгдүүлж, бондын зах зээлийн хөгжлийг дэмжих үндэс болсон. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжсөнөөр санхүүгийн зах зээл дэх өрсөлдөөн нэмэгдэж эхэлсэн. Мөн 2 тулгуурт зохицуулалтын

тогтолцоо ашиглаж эхэлснээр үр дүнтэй, уялдаа холбоотой зохицуулалтын загвар бий болсон. Тус загварын хүрээнд Австралийн зохистой байдлын зохицуулах хороо (Australian Prudential Regulatory Commission) нь зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харин нөгөө талд Австралийн үнэт цаас болон хөрөнгө оруулалтын хороо (Australian Securities and Investment Commission) нь зах зээлийн зохистой үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн эрхийг хамгаалах үүрэгтэйгээр үүсгэн байгуулагдсан.

Мөн зохицуулалтын хүрээнд хийгдсэн бас нэгэн чухал шинэчлэл нь Компанийн хууль болон эдийн засгийн шинэчлэлийн программыг хэрэгжүүлж эхэлсэн явдал байв. Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг сайжруулах хүрээнд хэд хэдэн хуулийн өөрчлөлтийг хийсэн бөгөөд тэдгээр нь нягтлан бодох бүртгэлийн стандартад өөрчлөлт оруулж, аудиторуудын бие даасан байдлыг дэмжих бодлого, захирлын үүрэг, компанийн засаглалын шаардлага, хувьцаа эзэмшигчийн эрх үүрэг гэх зэрэгт өөрчлөлтүүдийг оруулж өгсөн.

Банкны салбарт 2008 онд Базел II-ийг нэвтрүүлж, 2000-аад оны эцэс үед Базел III-ыг нэвтрүүлсэн.

ЕС. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР

Салбарын ерөнхий байдал

Хөдөө аж ахуй нь Австралийн эдийн засгийн жижиг боловч чухал хэсэг юм. 1980–аад онд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 14 тэрбум ам.доллар байсан бол 2016–17 онд 60 тэрбум ам.доллар болсон. Уг салбар нь зах зээлд тулгуурласан, экспортод чиглэсэн байдаг бөгөөд үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийхээ 77 гаруй хувийг экспортолдог. Хөдөө аж ахуйн экспортын орлого нь 2010–2011 онд 32.5 тэрбум ам доллар байсан бол 2016–17 онд 44.8 тэрбум ам.доллар болж өссөн байна.

Австралийн фермерүүд нь нийт газар нутгийн 48 хувийг эзэмшин үйл ажиллагаагаа явуулж байна. 2016–17 оны байдлаар ойролцоогоор 85,681 фермерийн аж ахуйд 304,200 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллах хүчний 3 хувийг хамарч байна. Мөн тээвэр, хоол хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл зэрэг холбогдох салбарууддаа шууд бусаар ажлын байр үүсгэн, нийт эдийн засагт 1.6 сая ажлын байрыг бий болгожээ.

Австралийн эдийн засгийн реформтой холбогдон уг салбарын бодлогын орчин өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд ихээхэн өөрчлөгдөн ирсэн.

Салбарын гол онцлог:

- Экспортод тулгуурласан салбар: Фермерүүд дэлхийн хөдөө аж ахуйн бараа бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэлд ихээхэн мэдрэмтгий байдаг.
- Төсвийн хязгаарлагдмал байдал: Хүн ам багатай улсын хувьд төсвөөс уг салбар дахь төсөл, хөтөлбөрт дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хэмжээний мөнгийг гаргах боломж бага байдаг. Энэхүү хязгаарлагдмал байдал нь банкнаас санхүүжилт авах боломж олгох зорилготой зээлийн хүүгийн татаас зэрэг зарим бодлогын хөгжилд хувь нэмэр оруулсан байна.
- Цаг уур, байгалийн онцгой үзэгдлийн нөлөө их: 2006–07 онд болсон ган гачиг нь Австрали Улсын эдийн засгийн өсөлтийг ойролцоогоор 0.75 пунктээр бууруулсан байна.

Канола, арвай, улаан буудай, ноос зэрэг салбарын зарим бүтээгдэхүүнүүд биржээр дамжуулан худалдаалагддаг. 1960–аад онд анхны хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний биржийн худалдаа Сиднейн Ноосны Фьючерсийн Бирж дээр явагдаж байсан бөгөөд уг бирж нь 2006 онд Австралийн хөрөнгийн биржтэй нэгдэж Австралийн үнэт цаасны бирж гэх зах зээлийн үнэлгээгээр дэлхий хэмжээнд эхний 10–т ордог томоохон биржийн үндэс болсон байна. Мөн 1990–ээд оны сүүлээс цаг агаарын таамаглалд үндэслэсэн шинжтэй дериватив /weather derivatives/–ыг ашиглаж эхэлсэн бөгөөд тухайн үед зах зээлийн үнэлгээ 500 сая доллар байсан бол 2004 он гэхэд нь энэ нь 5 тэрбум доллар болж өсжээ.

Эдийн засгийн шинэчлэл хийхээс өмнөх үеийн хөдөө аж ахуйн салбар

Хөдөө аж ахуйн салбар дахь засгийн газрын оролцоо нь фермерүүдийн сайн сайхан байдлыг өсгөх болон үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх замаар гадаад валютын нөөцтэй болоход чиглэж байсан. 1950–аад онд хөгжлийн зорилтуудыг санхүүжүүлэхэд шаардлагатай гадаад валютыг төвлөрүүлэх зорилгоор хөдөө аж ахуй (уул уурхай)–н экспортод ихээхэн анхаарал хандуулж байсан бөгөөд тогтмол ханштай үеийн эдийн засгийг өсгөхөөр төлбөрийн тэнцлийн хязгаарлалт хийсэн. Австралийн импортыг орлуулах замаар аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх бодлого нь орон нутгийн үйлдвэрүүд дотоодын зах зээлд төвлөрөхөд хүргэн, цаашлаад экспортод тулгуурлах байдлыг нэмэгдүүлсэн.

Мөн засгийн газрын өөр нэгэн оролцоо нь фермерүүдийн орлогыг тогтворжуулах байсан. Тухайлбал, дэлхийн үнийн хэлбэлзлийн эсрэг үнэ болон орлогыг тогтворжуулах, экспортын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын үнийн зохицуулалтыг ашигладаг. Татаас нь импортын өрсөлдөөнөөс аж үйлдвэрийн салбарыг хамгаалах зорилгоор фермийн нөөцийн зардалд нөхөн олговор хэлбэрээр олгогддог байсан. Жишээлбэл, фермерүүд материал, тоног төхөөрөмжид татвар төлдөг бөгөөд илүү өндөр цалин, их зардалтай байдаг. Мөн үйлдвэрлэгчдэд уг нөхөн олговрыг төрөл бүрийн хэлбэрээр олгодог байсан. Үүнд:

- Цитрус, дарсны хатаасан жимс, хүнсний ногоо болон тамхины татвар;
- Орлогын татварыг бууруулах;
- Бордооны татаас, хөнгөлөлттэй зээл, хөдөө аж ахуйн тракторын өглөг гэх мэт орцуудын татаас;
- Ган гачгийн тусламж;
- Усжуулалтын үйлчилгээ зэрэг хямд үнэтэй дэд бүтцийн үйлчилгээнээс үүдэлтэй татаас.

Гэвч эдгээр олгож байгаа татаасын үр өгөөж юу вэ гэсэн асуулт гарч ирсэн:

- Газар тариаланчдад газрынхаа үр өгөөжийг сайжруулахад туслах зорилгоор өгдөг байсан боловч нөөцийн татааснаас томоохон үйлдвэрлэгчид ихээхэн ашиг олж байсан.
- Янз бүрийн хэмжээгээр татаас олгодог байсан нь нөөцийн хуваарилалтыг гажуудуулж байсан. Өөрөөр хэлбэл бага татаастай, ач холбогдолтой салбараас их татаас олгогддог салбарт нөөц шилжиж байсан.
- Хөдөө аж ахуйн бодлого нь фермерүүдийн эрсдэлээс хамгаалах, илүү үр бүтээмжтэй ажиллах, шинэ бүтээгдэхүүн, зах зээл хайх идэвхийг бууруулж байсан.

Хөдөө аж ахуйн салбар дахь реформ

Австралийн хөдөө аж ахуйн салбар дахь бодлогын шинэчлэл 1970–аад оны эхэн үеэс засгийн газар татаасны хэмжээг хязгаарлах замаар эхэлсэн. Хэдийгээр бусад салбараас бага хэмжээгээр татаас олгогддог байсан боловч татаасны зардал нь дотоодын хэрэглэгчид болон татвар төлөгчдөд ачаалал өгдөг байсан. Тиймээс шинэчлэлийн явцад татаасны түвшин болон салбар хоорондын татаасны дүнгийн ялгааг аажмаар багасгасаар 1995 он гэхэд арвай, хөвөн, шинэ ургамлын гаралтай бүтээгдэхүүн, үр тарианы буурцагт ургамал, эрдэнэ шиш, тамхи, мах, овьёос, тосны үр, будаа, улаан буурцаг, улаан буудай, ноос зэрэгт олгогдож байсан татаасыг байхгүй болгосон. Мөн сүү, сүүн бүтээгдэхүүн, дарсны хатаасан жимс, элсэн чихэр, дарс зэрэг бусад салбарын татвар мөн буурч байсан ба 1988 онд бордооны хэрэглээний татаасыг хассан.

1990–ээд оноос 2000–аад оны үед маркетингийн эрх бүхий байгууллага болон тэдгээрээс гаргаж буй хууль тогтоомжууд нь Үндэсний өрсөлдөөний бодлого (ҮӨБ)-ын хүрээнд гарч байсан. Хууль тогтоомжийг хянах хөтөлбөрийн хүрээнд Хамтын нөхөрлөл, муж, орон нутгийн засаг захиргаа өрсөлдөөнийг хязгаарласан, МЭББ–д дараах монополь эрх өгсөн хууль тогтоомжийг хянан үзэхээр зөвшөөрсөн бөгөөд үүнд:

- Газар тариаланг албадан худалдаж авах;
- Бараа таваарын чанар болон үнийг зохицуулах;

Хүснэгт 7. 11. Хөдөө аж ахуйн маркетингийн зохицуулалтын шинэчлэлүүд

1970–аад оноос эхлэн хөдөө аж ахуйн маркетингийн зохицуулалт нь дотоодын болон экспортын зах зээлийн (аль аль эсвэл хоёуланд нь) фермерүүдийн хоорондын харилцааг зохицуулсан байсан өрсөлдөөнийг хөдөө аж ахуйн ихэнх салбаруудад аажмаар нэвтрүүлсэн бөгөөд дараахаар шинэчлэлийн үед хийгдсэн гол өөрчлөлтүүдийг харуулав.

Он	Бараа	Өөрчлөлт
1970–аад	Улаан буудай	<ul style="list-style-type: none"> Баталгаажсан үнээс тогтворжсон үнэд шилжүүлэх; Дотоодын хэрэглээний үнэ улаан буудайгаар хязгаарлагдана.
1980–аад	Дарсны хатаасан жимс	Үнийн тогтворжуулалтын зохицуулалтыг 1980 онд дуусгавар болгосон.
	Цитрус	<ul style="list-style-type: none"> 1986 оноос эхлэн татварыг 30–аас 5 хувь хүртэл бууруулсан; Улсын маркетингийн зөвлөлүүдийг нэгтгэсэн, өрсөлдөөнд газарзүйн саад тотгорыг багасгах.
	Өндөг	1989 оноос үнийн хяналтыг аажмаар алга болгосон.
	Элсэн чихэр	1980–аад оны сүүлээр Хамтын нөхөрлөл дотоодын үнийн зохицуулалт болон экспортын хяналт, удирдлагыг цуцалсан.
1990–ээд	Улаан буудай	<ul style="list-style-type: none"> 1989 онд дотоодын зах зээлийн зохицуулалтыг бууруулсан; Австралийн улаан буудайн зээллэгийн хамтын нөхөрлөлийн баталгааг орлох тариаланчдад татвар ногдуулах сан үүссэн.
	Арвай	1998 оноос эхлэн Өмнөд Австрали болон Викториа мужид дотоодын тэжээл болон арвайн маркетинг өрсөлдөөн нэвтэрсэн.
	Сүү, сүүн бүтээгдэхүүн	Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын төлбөрийн дэмжлэгийг бууруулсан.
	Тамхи	Тамхины салбарын тогтворжуулах төлөвлөгөөг 1995 онд зогсоосон.
	Элсэн чихэр	1997 оны дундуур импортын татвар болон дотоодын зах зээлийн үнийн дэмжлэгийг арилгасан.
	Улаан буудай	1999 онд Австралийн улаан буудайн зөвлөл нь хууль ёсны эрх барих байгууллагаас тариаланчдын эзэмшлийн компани болсон.
Ноос	Нөөц үнийн төлөвлөгөө 1991 онд зогссон.	
2000–аад	Арвай	<ul style="list-style-type: none"> Өмнөд Австралийн нэг–ширээний зохицуулалт 2007 онд дуусгавар болсон; 2009 онд баруун Австралийн зах зээлийн зохицуулалтыг бууруулсан (ямар ч лицензтэй аж ахуйн нэгжид арвай экспортлохыг зөвшөөрсөн).
	Элсэн чихэр	Queensland Sugar Limited нь 2006 онд заавал эзэмших эрхээ алдсан.
	Улаан буудай	2008 онд их хэмжээний экспортод дахин зохицуулалт хийсэн. (их хэмжээгээр экспортлоход Австралийн улаан буудайн зөвлөлөөс зөвшөөрөл авах шаардлагагүй болсон).

Ган гачгийн үндэсний бодлого

1990–ээд онд Австралийн ган гачгийн бодлогын зорилт нь ихээхэн өөрчлөгдсөн байна. 1992 онд Австралийн засгийн газар, мужуудын болон орон нутгийн засаг захиргаа ган гачгийн менежментийг сайжруулах шинэ арга барилыг баримталсан “Ган гачгийн үндэсний шинэ бодлого” боловсруулсан. Өмнө нь ган гачгийг байгалийн гамшиг гэж үзсэн бодлогын нөлөөгөөр фермерүүдийн ган гачигт бэлдэх идэвх суларсан байв. Тиймээс ч шинэ бодлогод ган гачгийг фермерүүдийн үйл ажиллагааны хэвийн үйл ажиллагааны нэг хэсэг гэж үзсэн байна.

1990–ээд оны эхэнд “Хөдөө орон нутгийн тохируулах төлөвлөгөө” хэрэгжиж байсан. Уг төлөвлөгөө нь үр ашигтай ирээдүйтэй фермерүүдийг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадваргүй фермерүүдийг салбараас

гаргах зорилготой бүтцийн зохицуулалтын бодлого байсан. Энэхүү төлөвлөгөөний гол онцлогууд нь:

- Хөнгөлөлттэй зээл авах боломж (Онц аюултай гангийн үеийн зээлийн хүүгийн татаас);
- Гүйлгээнд суурилсан татаас (жишээ нь: тэжээлийн татаас);
- Гэр бүлийн мөнгөн тэтгэмж, онц аюултай гангийн үеийн нөхөн төлбөр;
- Дахин байгуулалтын буцалтгүй тусламж.

1992 онд боловсруулсан Ган гачгийн үндэсний шинэ бодлогын зорилтууд нь:

- Австралийн хөдөө орон нутгийн үйлдвэрлэгч болон бусад хэсгүүдийг цаг уурын өөрчлөлтийг удирдахад бие даасан хандлагыг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- Цаг агаар эрс тэс уур амьсгалтай үед Австралийн хөдөө аж ахуй, байгаль орчны нөөцийн баазыг хамгаалах;
- Хөдөө аж ахуйн салбарыг урт хугацааны, тогтвортой түвшинд хүргэх, сэргээх.

Энэ бодлого нь ган гачгийг байгалийн гамшиг гэж үзэхээ больсон хэдий ч онц аюултай ховор ган гачгийн үед хамгийн туршлагатай фермер ч урьдчилан бэлтгэх боломжгүй гэдэг үндэслэл дээр тулгуурлан явагдаж байна. Зөвхөн ган гачгийн онц аюул үүссэн тохиолдолд фермерүүдэд нөхөн олговор өгөхөөр зохицуулалт оруулсан. Онц аюул учруулсан ган гачиг гэдэгт:

- Ховор, ноцтой байх – 20–25 жил тутам нэгээс олон удаа тохиолдох ёсгүй бөгөөд том хэмжээг хамарсан;
- Үр дүнд нь урт хугацаагаар буюу 12 сараас дээш хугацаанд орлогогүй байх хэмжээнд хохирол учруулсан;
- Урьдчилан таамаглах боломжгүй.

2008 он гэхэд онц аюултай ган гачгийн зохицуулалтыг эдийн засаг, нийгэм, цаг уурын талаас нь судлан үзээд Австралийн засгийн газраас цаашид хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн. Тухайлбал, эдийн засгийн үнэлгээгээр онц аюултай ган гачгийн үеийн хүүгийн татаас нь үр дүн муутай, гэр бүлийн тусламжийн хөтөлбөрийг зөвхөн ган гачиг болсон бүсээр хязгаарладаг (өөр газарт байж болох хүндрэл бэрхшээлийг авч үзээгүй) зэрэг уг бодлого нь фермерүүдэд бие даасан байдал, ган гачигт бэлэн байх, уур амьсгалын өөрчлөлтийн менежментийг сайжруулахад тусалж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүрсэн.

2008–09 онд явагдсан уг үнэлгээг даган 2014 оны 7 дугаар сарын 1–ний өдрөөс хэрэгжих ган гачгийн үндэсний шинэ хөтөлбөрийг зарласан. Уг хөтөлбөр нь:

- Фермерийн өрхийн дэмжлэгийн төлбөр;
- Татварын хөнгөлөлтийн арга хэмжээг үргэлжлүүлэн авах;
- Фермерийн аж ахуйн сургалтад чиглэсэн үндэсний хандлага;
- Фермерүүдийн шийдвэр гаргахад ашиглах багаж, технологи.

Одоогийн хөдөө аж ахуйн салбарын бодлого

Хөдөө аж ахуйн салбар дахь үйлдвэрлэлийн эрсдэлийг удирдах үйлдвэрлэгчдийн чадавхыг сайжруулах зорилготой хөтөлбөрүүдийг засгийн газраас хэрэгжүүлдэг. Эдгээр нь ихэвчлэн үйлдвэрлэгчдэд бүтээмж, үр ашгаа дээшлүүлэх, бүтцийн зохицуулалт хийх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, байгалийн нөөцийн менежментийг сайжруулахад туслах зорилготой буцалтгүй тусламжийн хэлбэртэй

байдаг. Үүнд:

- *Хөдөө орон нутаг дахь судалгаа, хөгжилд зориулсан санхүүжилт*

Австралийн засгийн газар нь өөрийн агентлагуудаар дамжуулан өргөн хүрээг хамарсан судалгаа шинжилгээ, хөгжилд зориулсан санхүүжилт явуулдаг бөгөөд үүний нэг нь хөдөө аж ахуй, загасны аж ахуй, ойн аж ахуй зэргийг хамруулсан хөдөө орон нутгийн судалгаа, хөгжлийн хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн санхүүжилтэд жилд дунджаар 715 сая ам доллар зарцуулдаг.

- *Гантай холбоотой хөтөлбөрүүд*

Уг хөтөлбөрийн хүрээнд фермерүүдэд үзүүлж буй тусламж нь ган гачиг, бусад сорилтуудыг даван туулахад бэлтгэж, үүнээс үүдэх нөлөөг зохицуулахад нь туслах зорилготой.

- *Орон нутгийн санхүүгийн зөвлөгөө өгөх үйлчилгээ*

Санхүүгийн хүндрэлд орсон анхан шатны үйлдвэрлэгчид, загасчид, хөдөө орон нутагт жижиг бизнес эрхлэгчдэд санхүүгийн үнэгүй зөвлөгөө өгөх

- *Татварын хөнгөлөлт*

Үйлдвэрлэгчдэд зориулсан хэд хэдэн татварын хөнгөлөлт үзүүлдэг. Үүнд, хөдөө аж ахуйн менежментийн хадгаламж; орлогыг бууруулах нөлөөтэй хасалт хийх, хөнгөлөлт үзүүлэх зэрэг бусад олон төрлийн үйлчилгээг авах чадвартай байх зэрэг орно.

- *Нүүрстөрөгчийн фьючерс*

Уг хөтөлбөр нь фермерүүдэд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах замаар нүүрстөрөгчийн кредит авах боломжийг олгодог. Үүнийгээ нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулахыг зорьж буй хүмүүст эсвэл аж ахуйн нэгжүүдэд зарах боломжтой байдаг. Мөн судалгаа шинжилгээ, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаануудыг санхүүжүүлэх боломжтой.

- *Байгаль орчинд ээлтэй фермерийн үйл ажиллагааг санхүүжүүлэх*

Австралийн байгаль орчин, тогтвортой байдлыг хамгаалах зорилготой бөгөөд фермерүүд биологийн олон янз байдал, фермийн тогтвортой үйл ажиллагааг сайжруулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд санхүүжилт хүсч болдог.

- *Гамшгийн орлогын нөхөн олговрын татаас*

Бороо, үер зэрэг байгалийн гамшгийн үр дүнд орлогоо алдсан фермерүүд болон бусад бизнесүүдэд туслалцаа үзүүлэх.

Бодлогын үр дүн

Австралийн хөдөө аж ахуйн бодлогын шинэчлэлийн үр дүнд фермерүүд өөрчлөгдөж буй зах зээлд дасан зохицоход аливаа саад тотгоргүй болсон. Үнийн дэмжлэг /output price support/-ийг арилгасан нь хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдэд олгогдож байсан татаасын хэмжээний ялгааг бууруулсан. Энэ нь нөөцийн буруу хуваарилалт хийгдэх үндэс болж өгсөн бөгөөд үүнээс үүдэлтэй татаасын хэмжээний стандарт хазайлт 1970–аад он болон 1980–аад онуудад маш өндөр байсан. Харин шинэчлэл хийснээр татаас авна гэсэн хүлээлтийг байхгүй болгосон бөгөөд энэ нь фермерүүд бага татаастай боловч үр ашигтай бүтээгдэхүүний зах зээлд ферм худалдан авч үйл ажиллагаагаа өргөжүүлэх боломжтой болсон.

Мөн хөдөө аж ахуйн маркетингийн зохицуулалтад тавьсан хязгаарлалтаас үүдэж фермерүүд бүтээгдэхүүнээ хэрхэн, хэзээ, ямар үнээр, хэнд зарахаа сонгох боломжгүй байсан нь инновацыг

нэмэгдүүлэх, маркетингийн шинэ арга замыг хайх үйл ажиллагааг бууруулж байсан. Хөдөө аж ахуйн маркетингийн зохицуулалтын дахин зохицуулалт нь фермерүүдэд шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, илүү өгөөж авчрах шинэ зах зээл олох замаар бүтээмжийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжийг олгосон.

Одоо байгаа болон шинээр орж ирж буй фермүүдийн хоорондын салбарын бүтэц болон нөөцийн дахин хуваарилалтын өөрчлөлт нь өргөн хэрэглээний болон сүү, сүүн бүтээгдэхүүний бүтээмжийн өсөлтөд чухал эх үүсвэр болсон. Жишээлбэл, Австралийн сүү, сүүний үйлдвэрлэл нь 1970–аад оноос шинэчлэлийн субъект байсан бол 2000–аад оноос бүх татаасыг арилгасан нь хөгжлийн дээд цэгт нь хүргэсэн. Үүний үр дүнд бүтцийн зохицуулалт нь сүүний аж үйлдвэрийг өөрчилж, аж үйлдвэрийн түвшний бүтээмжийн өсөлтөд хувь нэмэр оруулсан.

Одоо байгаа болон шинээр орж ирж буй фермүүд хоорондын салбарын бүтэц болон нөөцийн дахин хуваарилалтын өөрчлөлт нь өргөн хэрэглээний болон сүү, сүүн бүтээгдэхүүний бүтээмжийн өсөлтөд чухал эх үүсвэр болсон. Жишээлбэл, Австралийн сүү, сүүний үйлдвэрлэл нь 1970–аад оноос реформын субъект байсан бол 2000–аад оноос бүх татаасыг арилгасан нь бүтээмжийг ихээр нэмэгдүүлсэн. Үүний үр дүнд бүтцийн зохицуулалт нь сүүний аж үйлдвэрийг өөрчилж, аж үйлдвэрийн түвшний бүтээмжийн өсөлтөд хувь нэмэр оруулсан.

Түүхий эдийн деривативын зах зээлийг зохицуулах зарчмууд

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /ҮЦХОУБ/-ын түүхий эдийн фьючерсийн зах зээлийн ажлын хэсэг нь 2011 онд түүхий эдийн деривативын зах зээлийг зохицуулах зарчмуудыг боловсруулсан. Уг ажлын хэсгийн хүрээнд түүхий эдийн деривативын зах зээлд баримтлах 5 төрлийн зарчмын зөвлөмжийг боловсруулан гаргасан байна. Үүнд:

1. Түүхий эдийн деривативын гэрээнд баримтлах зарчмууд;
2. Түүхий эдийн деривативын зах зээлийн хяналтын зарчмууд;
3. Түүхий эдийн деривативын зах зээлд үүссэн зөрчлийг шийдвэрлэх зарчмууд;
4. Хууль сахиулах, мэдээлэл хуваалцах зарчмууд;
5. Түүхий эдийн деривативын зах зээлд үнийг тогтоох үйл явцыг эрчимжүүлэх зарчмууд.

ҮЦХОУБ–ын түүхий эдийн дериватив гэрээний загвар гаргах зарчмууд /Contract Design Principles/

■ *Хариуцлага хүлээх чадвар /Accountability/*

Зохицуулагч байгууллага нь түүхий эдийн деривативын гэрээний шалгуур нөхцөлүүдийг боловсруулах болон хянах тодорхой тогтолцоог бий болгох шаардлагатай. Мөн зохицуулагч байгууллага нь өөрийгөө зохицуулах стандарт болон дүрэм журмын хэрэгжилтийг тогтмол хангуулах мөн манипуляц болон зөрчил үүсгэж болохуйц гэрээний заалтуудыг илрүүлэн шийдвэрлэх эрх мэдэлтэй байх ёстой.

■ *Эдийн засгийн үр ашигтай байдал /Economic Utility/*

Түүхий эдийн деривативын гэрээ нь хэрэглэгчдийн эрсдэлийн удирдлагын хэрэгцээнд нийцсэн бөгөөд түүхий эдийн үнийг тодорхойлсон байна.

■ *Биет зах зээлтэй хамааралтай байдал /Correlation with Physical Market/*

Түүхий эдийн дериватив гэрээний нөхцөл нь түүхий эдийн зах зээлийн үйл ажиллагааг тусгасан, хүргэлт хийгдэхэд саад бэрхшээл учруулахгүй байх ёстой.

■ *Оролцогч талын саналыг тусгах /Responsiveness/*

Түүхий эдийн деривативын гэрээг боловсруулахад гэрээнд гэрээний байгуулсан талын саналыг тусгана.

▪ *Ил тод байдал /Transparency/*

Ил тод байдлыг сайжруулахын тулд зохицуулагч байгууллага нь дүрэм журамдаа дараах зүйлсийг тусгасан байна. Тухайлбал:

- i. Үнийн түвшний хэлбэлзэж болох хамгийн бага хэмжээ;
- ii. Үнийн түвшний хэлбэлзэж болох хамгийн их хэмжээ;
- iii. Арилжааны сүүлийн өдөр;
- iv. Төлбөр тооцоо болон хүргэлтийн үйл явц;
- v. Арилжаа хийгдэх сарууд;
- vi. Позцын хязгаар;
- vii. Арилжааны цаг.

Түүхий эдийн деривативын зах зээлийн хяналтын зарчмууд

▪ *Зах зээлийн хяналтын тогтолцоо /Framework for Undertaking Market Surveillance/*

Зохицуулагч байгууллага нь зах зээлд хяналт тавих, хууль, дүрэм журмыг сахиулах үйл ажиллагаа явуулах хүчирхэг тогтолцоотой байх ёстой. Зах зээлийг хянах хөтөлбөр нь арилжаа эрхлэгчийн дериватив, биет зах зээлийн гүйлгээ, хэлцлийг харгалзан үзэх ёстой. Зах зээлийн хяналтын хөтөлбөр нь хангалттай нөөц, биет зах зээлийн тоо мэдээ болон аналитик чадавхтай байх ёстой.

▪ *Хянах, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх /Monitoring, Collecting and Analyzing Information/*

Зохицуулагч байгууллага нь зохицуулалтад буй зах зээлийн арилжааны үйл ажиллагааг хянах үр дүнтэй аргачлалыг нэвтрүүлж хэрэгжүүлэх, хөгжүүлэх шаардлагатай бөгөөд зах зээлд тохирсон үр дүнтэй мэдээ мэдээллийг цуглуулж, цуглуулсан мэдээлэлдээ анализ хийх хэрэгтэй байдаг.

Захиалга болон цахим гүйлгээг үр дүнтэй хянахад, гүйлгээний явцад үүсэх гажуудлыг илрүүлэх автомат системийг нэвтрүүлэх зэрэг бодит цагийн хяналтын чадавх шаардлагатай болдог байна. Өдрийн арилжаанд ч мөн хяналт хийх, мэдээлэл цуглуулах, анализ хийх чухал шаардлагатай.

▪ *Мэдээлэл авах эрх /Authority to Access information/*

Зохицуулагч байгууллага биет түүхий эдийн зах зээл болон түүхий эдийн зах зээлийн биржийн бус арилжаанд оролцогчдын хэлцлийн талаарх мэдээллийг авах эрхтэй байх зэрэг түүхий эдийн деривативын зах зээлийн талаар байнгын болон шаардлагатай тохиолдолд мэдээлэл авах эрхтэй байна. Тухайлбал:

- i. Зохицуулалттай түүхий эдийн деривативын зах зээл дэх гүйлгээг сэргээх боломжийг бүрдүүлсэн мэдээллүүдийг авах;
- ii. Тухайн зах зээлийн бүтэц болон их хэмжээний хэлцлийг тодорхойлоход шаардлагатай мэдээлэл;
- iii. Хувийн эзэмшилд байгаа позицуудыг нэгтгэхийн тулд зах зээлд оролцогчийн эзэмшиж буй бенефициар өмчлөгчийн позицгийн хэмжээний талаарх мэдээллийг авах;
- iv. Түүхий эдийн деривативын болон биржийн бус зах зээлд оролцогчдын арилжаа, гүйлгээний талаарх мэдээллийг авах;

- v. Түүхий эдийн деривативын зах зээлд оролцогчид шаардлагатай мэдээллээр хангахгүй байгаа тохиолдолд зохих арга хэмжээг авах.

Зохицуулагч байгууллагууд нь дээр дурдсан мэдээллүүдээс гадна бусад хэрэгцээт мэдээллүүдийг холбогдох хуулийн байгууллага болон засгийн газрын харьяа байгууллагуудаас хүсэх ёстой.

- *Бирж дээрх арилжааны талаар мэдээллийн цуглуулга /Collection of Information on On-Exchange Transaction/*

Бирж дээрх бараа бүтээгдэхүүний деривативын арилжааны талаарх мэдээллийг тогтмол цуглуулах ёстой. Үүнд:

- i. Арилжаа явагдсан өдөр гэрээний үнийг бодит цаг (real time)-аар тогтоох;
- ii. Арилжаа явагдсан өдрийн арилжааны огноо, түүхий эдийн гэрээ, бүтээгдэхүүнийг хүргэсэн байх тов, гэрээ дуусах хугацаа, худалдан авах/худалдах тоо хэмжээ, гэрээнд заасан оролцогч талууд, гэрээний үнэ зэргийг агуулсан өдөр тутмын гүйлгээний мэдээлэл;
- iii. Арилжааны өдрийн эцэс дэх хэлцлийн хэмжээ, оролцогчдын мэдээлэл, гэрээний хугацаа зэрэг өдрийн арилжааны тайлан;
- iv. Зохистой үед, гэрээний хугацаа дуусах үед нийлүүлэх боломжтой түүхий эдийн хэмжээ.

- *Биржийн бус зах зээл дээрх арилжааны мэдээллийн цуглуулга /Collection of OTC Information/*

Зохицуулагч байгууллагаас тогтмол авах болон шаардлагатай тохиолдолд авах мэдээллүүдэд ямар мэдээлэл хамруулахыг шийдэх хэрэгтэй.

Тогтмол цуглуулах мэдээлэл:

- i. Хэлцэл хийгдсэн огноо, гэрээний нөхцөл, гэрээнд оролцогч талууд болон гэрээний үнэ зэрэг гүйлгээний мэдээлэл;
- ii. Хэлцлийн мэдээлэл.

Шаардлагатай тохиолдолд цуглуулах мэдээлэл:

- i. Хүргэх зорилго;
- ii. Бенефициар өмчлөгч;
- iii. Хувийн эзэмшил дэх хэлцлүүд;
- iv. Форвардаас бусад гэрээ хэлцлийн хувьд нэрлэсэн үнэ цэнэ, борлуулалтын өртөг, үнэлгээний аргачлал буюу гэрээний үргэлжлэх хугацаа зэрэг нэмэлт мэдээлэл.

- *Их хэмжээний хэлцэл /Large Position/*

Зохицуулагч байгууллага нь бирж дээрх түүхий эдийн деривативын гэрээнүүдийн их хэмжээний хэлцэл, бенефициар эзэмшигч эсвэл түүний нэрийн өмнөөс эзэмшигчдийн өмчлөл дэх нийт хэлцлийн талаарх мэдээлэл авах эрхтэй.

Түүхий эдийн деривативын зах зээлд үүссэн зөрчлийг шийдвэрлэх зарчмууд /Principles to Address Disorderly Commodity Derivatives Markets/

▪ *Зах зээлд интервенц хийх эрх мэдэл /Intervention Powers in the Market/*

Зохицуулагч байгууллага түүхий эдийн деривативын зах зээл дээрх асуудлыг олж илрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр ашигтай байдлыг хангах зорилгоор зах зээлд интервенц хийх эрх мэдэлтэй байх ёстой. Үүнд:

1) Хэлцлийн хэмжээнд хязгаарлалт тавих чадвар

- i. Арилжигчийн позиц нь зах зээлийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөхүйц хэмжээнд хүрэхэд арилжигчид зохицуулагч байгууллагын өгсөн үүрэг даалгаврыг заавал дагаж мөрдөнө. Өөрөөр хэлбэл тэд хэлцлийн хэмжээг ихэсгэж эсхүл багасгаж болохгүй гэсэн Зохицуулагч байгууллагын даалгаврыг дагаж мөрдөнө.
- ii. Зохицуулагч байгууллага нь зах зээлд оролцогчийн түүхий эдийн деривативын гэрээн дэх позицгийн хэмжээнд урьдчилсан байдлаар хязгаарлалт тогтоох.

2) Бусад эрх мэдэл – Зохицуулагч байгууллага нь зах зээлийн хямралыг илрүүлэх эсвэл тулгарч буй аюулыг арилгах зорилгоор дараах арга хэмжээг авах эрхтэй:

- i. Үнэ хэлбэлзэх хязгаарыг тогтоож өгөх;
- ii. Зах зээл дээрх арилжааг түр зогсоох эсвэл цуцлах;
- iii. Нээлттэй захиалгыг хаах эсвэл шилжүүлэх;
- iv. Хүргэлтийн нөхцөлүүдийг өөрчлөх;
- v. Арилжааг цуцлах;
- vi. Позицуудын өмчлөгчдөөс хүргэлтийн зорилгыг тодорхой болгохыг шаардах;
- vii. Арилжаанд оролцогчдыг биржийн бус зах зээл дээрх деривативын эсвэл ихээхэн хэмжээний позицын талаарх мэдээллийг нээлттэй байлгахыг шаардах.

▪ *Өөрчлөгдөн буй арилжааны үйл явцыг хянах /Review of Evolving Practices/*

Зохицуулагч байгууллага нь зохицуулалтын журмыг хянаж, өөрчлөгдөж буй зах зээлийн шинж чанарт нийцэж байгаа эсэх, зах зээлийг хямралд хүргэж болзошгүй арилжааны практикийг илрүүлэх чадвартай эсэхийг судлах ёстой. Энэхүү үйл ажиллагаанд биржүүд болон өөрийгөө зохицуулах байгууллагууд чухал үүрэгтэй оролцдог.

Хууль сахиулах, мэдээлэл хуваалцах зарчмууд /Principles for Enforcement and Information Sharing/

Уг зарчмын хүрээнд, зохицуулагч байгууллагуудын хоорондоо мэдээлэл солилцох шаардлага болон дотоод мэдээлэл эзэмшигчдээс болж хөрөнгө оруулагчид шууд болон шууд бусаар хохирох үйл явцын эсрэг хориг арга хэмжээ авах, мөрдөн шалгах, мөн хууль дүрэм журмыг сахиулахад шаардагдах хүчний талаар авч үзсэн.

- *Дүрэм журам дагаж мөрдөх хөтөлбөр /Rules and Compliance Programs/* – Зохицуулагч байгууллага нь зах зээлийг урвуулан ашиглах болон урвуулан ашиглах оролдлого хийх зэрэг зах зээлд үүсэж буй зөрчилтэй үйл ажиллагааг хориглох, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үүднээс тэдгээрт зориулсан тусгай дүрэм журам, бодлого, дагаж мөрдөх хөтөлбөртэй байх ёстой. Дүрэм журамдаа зах зээлийг урвуулан ашиглах, хориглосон үйл ажиллагаа зэрэгт юуг хамруулж байгааг тодорхой зааж өгөх ёстой ба дараах зүйлс багтана. Үүнд:

- i. Зах зээл дээр зохиомол үнийг үүсгэх буюу үүсгэхийг оролдох;
 - ii. Идэвхтэй арилжаа хийхэд төөрөгдлийг бий болгох;
 - iii. Аливаа барааны үнэд нөлөөлөх хуурамч мэдээллийг түгээх;
 - iv. Хэрэглэгчийн захиалгыг урвуулан ашиглах;
 - v. Хөрөнгө оруулагчдын эдийн засагт ач холбогдолгүй санхүүгийн хэрэгслийг нэгэн зэрэг авч зарах;
 - vi. Хэлцлийн заасан хэмжээнээс хэтрэхгүй байх;
 - vii. Хөрөнгө оруулагчийн хувийн мэдээллийг нуун дарагдуулах;
 - viii. Мэдээллийг буруугаар ашиглах.
- *Олон талт арилжааны асуудлыг шийдвэрлэх тогтолцоо /Framework for Addressing Multi-Market Abusive Trading /* – түүхий эдийн зах зээл болон олон бирж дээрх арилжаа, биржийн бус зах зээлийн арилжаа зэрэгт нөлөөлөхүйц зах зээлийг урвуулан ашиглах болон бусад сөрөг үр дүнтэй үйл ажиллагааг хуулийн хүрээнд зохицуулах дүрэм журмын цогц тогтолцоог бүрдүүлэх.
 - *Зах зээлийн эсрэг нөлөөтэй үйл ажиллагаанд хариу үйлдэл үзүүлэх чадавх /Powers and Capacity to Respond to Market Abuse/* – зохицуулагч байгууллагууд нь зах зээлийг урвуулан ашиглахыг оролдох, зах зээлд нөлөөлөхүйц болон сэжигтэй үйл ажиллагаа зэргийг мөрдөх болон яллах чадавх бүхий хүчин чадалтай байх. IOSCO–ийн зөвлөгөө, Хамтын ажиллагаа, Мэдээлэл солилцооны олон талт санамж бичгийн хүрээнд шаардагдах бүхий л эрх мэдэл нь түүхий эдийн деривативын зах зээлийг хянан зохицуулах IOSCO–ийн гишүүн байгууллагуудад байх.
 - *Зах зээлд оролцогчдын эсрэг сахилгын шийтгэл /Disciplinary Sanctions Against Market Members/* – хэрэв зах зээлд зөрчилтэй үйл ажиллагаа явагдвал, зах зээлд оролцогчид болон бүртгэлтэй гишүүдийгээ сахилгажуулах үр дүнтэй эрх мэдэлтэй байх ёстой. Шаардлагатай сахилгын арга хэмжээний төрлүүдийн талаар тодорхой ойлголттой байх хэрэгтэй. Сахилгын арга хэмжээнүүд нь дараах төрлүүдээс хэсэгчлэн эсвэл бүхэлд нь багтаах ёстой. Үүнд:
 - i. Анхааруулга (Нийтэд болон хувийн);
 - ii. Сануулга;
 - iii. Дахин сургах;
 - iv. Нөхөн төлүүлэх;
 - v. Торгууль;
 - vi. Арилжаа хийх нөхцөл;
 - vii. Арилжаанд хоригууд тавих;
 - viii. Гишүүнчлэлийг түдгэлзүүлэх;
 - ix. Гишүүнчлэлийг хасах;
 - x. Шаардлагатай тохиолдолд эрүүгийн хэрэг үүсгэх;
 - xi. Хууль бус орлогыг хураах.
 - *Гишүүн бус этгээдүүдийн эсрэг сахилгын шийтгэл ногдуулах /Disciplinary Sanctions Against Non-Members of the Market/*

Холбогдох эрх бүхий байгууллага нь зохицуулалттай түүхий эдийн деривативын зах зээлийн гишүүн

бус этгээдүүдийн болон бусад зах зээлд оролцогчид зах зээлийг урвуулан ашиглах, зөрчилтэй хэрэг үйлдэх эсвэл эдгээрт сэжиглэгдсэн тохиолдолд эсрэг арга хэмжээ авах эрхтэй байх ёстой. Зохицуулагч байгууллага нь гишүүд болон харилцагчид хоорондын гэрээг шаардаж болно. Төрийн байгууллага, прокурор болон шүүх байгууллагад хууль сахиулах эрх мэдэл нь байх бөгөөд эрх үүрэг нь хуульд тусгагдсан байдаг. Үүнээс гадна зохицуулагч байгууллага нь гишүүнчлэлгүй этгээдүүд зах зээлд хор хөнөөл учруулахаас сэргийлэх үүднээс зохих арга хэмжээ авах замаар зах зээлд оролцож болно. Мөн бирж хөндлөнгөөс оролцож болдог. Мөн гишүүдээрээ дамжуулан зах зээлд оролцож болох бөгөөд тухайлбал маржийн түвшнийг нэмэгдүүлэх, арилжаанд хязгаарлалт тавих, арилжааны давуу эрхүүдийг хүчингүй болгох зэрэг юм.

▪ *Мэдээлэл солилцох /Information Sharing/*

Зохицуулах эрх бүхий байгууллагууд хяналт, сахилгын арга хэмжээний талаарх мэдээллийг хуваалцахын тулд дотоод болон гаднын байгууллагуудтай нягт хамтран ажиллах ёстой байдаг. Тухайлбал, зохицуулагч байгууллагуудад зах зээлийн нийлүүлэлт болон их хэмжээний хэлцлийн талаар мэдээлэл хуваалцах боломжийг олгосон зохицуулалт хэрэгтэй байдаг. Эдгээр зохицуулалтууд нь (хэрэв хүчин төгөлдөр байдаг бол):

- i. Фирмүүдийн олон тооны зах зээлд сөргөөр нөлөөлж болзошгүй ихээхэн хэмжээний хэлцлийг тодорхойлох үүднээс Олон улсын мэдээлэл солилцооны харилцан ойлголцлын санамж бичиг болон хэлэлцээр, мөн олон улсын фьючерсийн бирж болон клирингийн байгууллагын хяналт болон хамтын ажиллагааны тунхаглал;
- ii. IOSCO-ийн зөвлөгөө, Хамтын ажиллагаа, Мэдээлэл солилцооны олон талт санамж бичиг;
- iii. Мэдээлэл солилцох талаар IOSCO-оос гаргасан заавар, тухайлбал хил дамнасан хяналт шалгалтын хамтын ажиллагааны тухай IOSCO-ийн зарчмууд, мэдээлэл хуваалцах удирдамж болон олон улсын хууль эрх зүйн хүрээнд зах зээлийн хяналтын талаар мэдээлэл солилцох тайлан.

Биет түүхий эдийн деривативын гэрээ өөр өөр биржүүд дээр арилжаалагдаж буй тохиолдолд гэрээний үнэ нөгөө гэрээний үнээсээ хамаарч тогтоогддог бөгөөд энэхүү тохиолдолд өндөр түвшний хяналтыг бууруулах үүднээс мэдээллийг солилцох нь зүйтэй байдаг.

Түүхий эдийн деривативын зах зээлд үнийг тогтоох үйл явцыг эрчимжүүлэх зарчмууд / Principles for Enhancing Price Discovery on Commodity Derivatives Markets/

▪ *Түүхий эдийн зах зээлийн ил тод байдлын зарчим /Commodity Derivatives Market Transparency/*

Арилжигчдын итгэлийг хадгалж үлдэх үүднээс зохицуулагч байгууллагууд нь томоохон арилжигчид, тэр тусмаа арилжааны болон арилжааны бус оролцогчдын арилжааны нийт өртгийн хэмжээг нийтлэх ёстой байдаг.

▪ *Биржийн бус арилжааны ил тод байдал /OTC Transparency/*

Ил тод байдлыг сайжруулах, системийн эрсдэлийг бууруулах, түүхий эдийн деривативын зах зээлд учирч болох зөрчлөөс хамгаалах үүднээс арилжааны репозиторт биржийн бус деривативын арилжааны гэрээнүүдийн талаар мэдээлж байхыг IOSCO-ийн гишүүн байгууллагууд дэмжих ёстой. Арилжааны репозиторуудыг дараах үйл ажиллагаануудыг гүйцэлдүүлэх үүднээс түүхий эдийн деривативын зах зээлийг зохицуулах төрийн байгууллага нь бусад зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллах ёстой байдаг. Үүнд:

- i. Арилжааны репозиторуудад мэдээлэх биржийн бус түүхий эдийн деривативын зах зээлийн датаг сайжруулах болон зохицуулагч байгууллагуудын нийтэд мэдээлэх, хүрч ажиллах зэргийг эрчимжүүлэхийн тулд ямар сайжруулалтуудыг хийх талаар дүгнэлт хийх;
- ii. Дээрх зорилтуудад хүрэхийн тулд салбарын байнгын ажиллагааг дэмжих, бодлого боловсруулах болон хууль эрх зүйн зохицуулалтад өөрчлөлт оруулахыг санал болгох зэрэг нааштай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх.

АРАВ. УУЛ УУРХАЙН САЛБАР

Салбарын ерөнхий байдал

Уул уурхайн салбар нь Австралийн эдийн засаг тэр дундаа гадаад худалдаанд чухал үүрэг гүйцэтгэгч салбар юм. 19–р зууны алтны олборлолт, 1960–аад оны төмрийн хүдэр, никель болон нүүрсний олборлолт зэрэг уул уурхайн салбарын өсөлт нь Австралийн эдийн засаг, орлогын түвшний өсөлт, ажилгүйдлийн түвшний бууралт зэрэгт ихээхэн хувь нэмрийг оруулсан.

Уг салбар нь Австралийн экспортын орлогын 50–60 хувийг бүрдүүлдэг бөгөөд Австрали Улс нь нүүрс, төмрийн хүдэр, мөнгө, зэс, ган төмөр, алт зэрэг ашигт малтмалуудын нөөцөөр дэлхийд тэргүүлдэг. Мөн Австрали Улс нь ашигт малтмалаа зөвхөн олборлох биш боловсруулан нэмүү өртөг шингээн худалдаалдаг ба уул уурхайн салбарын зах зээлийн үнэлгээ нь 2017 оны байдлаар 107 тэрбум доллар байсан.

Салбарын онцлог

Бусад салбараас ялгаатай нь Австралийн уул уурхайн салбар нь олон улсын зах зээлд голлох байр суурь эзэлдэг бөгөөд тус улсад үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниуд нь бага эрсдэлийн түвшин, өндөр ур чадвар бүхий ажиллах хүч, дэлхийд тэргүүлэх технологи, зохицуулалтын тогтвортой орчин, Ази номхон далайн зах зээлтэй ойр байршдаг зэргээрээ ялгардаг. Эдгээр зүйлс нь уг салбарыг бага зардалтай, инновацтай, бие даасан болгоход нөлөөлдөг байна.

Мөн Австралийн уул уурхайн салбарын бас нэгэн онцлог нь судалгаа, хөгжил болон ажилчдынхаа мэдлэг чадварыг дээшлүүлэхээр маш их хөрөнгө оруулалтыг хийдэг байна.

Уул уурхайн салбарт хийгдэж байсан бодлогын өөрчлөлт:

Австралийн уул уурхайн салбар нь бодлого, зохицуулалтын таатай орчноороо дэлхийд тэргүүлдэг бөгөөд 1991 онд хэрэгжүүлсэн “Хамгийн бага нөлөөлөл”-ийн бодлого нь Австралийн уул уурхайн салбар, цаашлаад нийгэм, эдийн засагт нь эерэг нөлөө үзүүлэн, амжилттай хэрэгжсэн бодлогод тооцогддог.

1991 онд Австралийн аж үйлдвэрийн хорооноос уул уурхайн салбарын үйл ажиллагаа, бодлого, зохицуулалтын орчинд үнэлгээ явуулсан бөгөөд уул уурхайн салбарт хэт олон тооны зохицуулалт байна гэсэн дүгнэлт өгсөн. Муж болон улсын хэмжээнд хуулийн давхардал, уялдаа холбоогүй байдал их байсан нь зохицуулалтын зардлыг нэмэгдүүлсэн ба засгийн газар оролцоогоо бууруулж, зах зээлд хэрэгжиж болохуйц, бодит, үр ашигтай зохицуулалтыг хийх шаардлагатай хэмээн Аж үйлдвэрийн хороо дүгнэсэн.

Аж үйлдвэрийн хорооноос дараах гол бодлогын зөвлөмжүүдийг гаргаж байсан. Үүнд:

- Орон нутгийн иргэд, газрын эзэн, ашигт малтмал хайх, олборлох хүсэлтэй этгээдүүдийн эрхийг тодорхойлох, ялгах;
- Ашигт малтмалын олборлолт, нөхөн сэргээлтийг бууруулах зэрэг сөрөг нөлөө үзүүлж буй татварын зохицуулалтыг өөрчлөх;
- Уул уурхайн үйл ажиллагаанд шууд оролцож, зохицуулах аргаас өмчийн эрхийг бий болгодог зах зээлд ээлтэй, эдийн засгийг эрчимжүүлдэг бодлогын аргачлалд шилжих;
- Ашигт малтмалын экспортын татварыг бууруулах, цуцлах.

1998 онд Аж үйлдвэрийн хорооноос 1991 оны зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу өөрчлөлтүүд хийгдэж байсан хэдий ч зарим төрлийн хатуу зохицуулалт /ихэвчлэн мужийн хэмжээнд/ хэвээр байсан. Уг шалгалтын дараагаар зохицуулалтын зардлыг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд дараах зөвлөмжүүдийг нэмж гаргасан байна. Үүнд:

- Засгийн газар уул уурхайн компаниудын менежментэд оролцохоо зогсоож, менежерүүдэд уг ажлыг даалгах;
- Уурхайн ажилчид ажил үүргээ гүйцэтгэж байхдаа аюулгүй ажиллагааг сахиж ажиллах үүргийг хуулиар олгох;
- Засгийн газар уул уурхайн салбарыг төмөр замаар хангах;
- Газрын гүний уурхайн олборлолтыг тусад нь зохицуулах, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны хууль, дүрэм, журам зэргийг ялгаатай боловсруулах.

Одоогийн байдлаар Австрали Улсыг уул уурхайн салбарын хууль, эрх зүй, зохицуулалтын орчны хувьд хамгийн таатай орон гэж олон улсын байгууллага, судлаачид үздэг бөгөөд энэ нь төрөөс уул уурхайн салбарт хэт их оролцолгүй, цөөн тооны оновчтой хэрэгжиж болохуйц, зах зээлийг дэмжсэн, тогтвортой, хууль, эрх зүйн бодлогыг баримталдагтай нь холбоотой юм.

Одоогийн бодлогын орчин

Хайгуул, олборлолт, боловсруулалт зэрэг уурхайн үйл ажиллагааны бүх шатанд уурхайчид болон тэдний ашиг сонирхлыг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтыг системчлэн боловсруулсан нь Австралийн уул уурхайн салбарын бодлогын нэг давуу тал юм. 2005 онд хийгдсэн Бехре Долбирийн судалгааны ажилд Австрали Улсыг уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт хийхэд хамгийн тохиромжтой газар гэж үзсэн байдаг.

Австрали Улсад байгалийн баялгийн нөөцийг ашиглахтай холбогдсон 2 шатны эрх зүйн зохицуулалт хэрэгждэг. Уул уурхайн салбартай холбоотой ихэнх хууль, дүрэм, журмуудыг харгалзах мужууд нь боловсруулж хэрэгжүүлдэг бол уул уурхайг хөгжүүлэх төсөл хөтөлбөр, бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэхдээ Хамтын нөхөрлөлийн тухай хуулийг баримталдаг.

Мөн Австрали Улсын гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан хууль, эрх зүйн системийн хөгжил нь уул уурхайн салбарын голлох том төслүүдэд их хэмжээний хөрөнгө оруулалт татах үндэс нь болж өгдөг.

Засгийн газрын оролцоо

Уул уурхайн нөөцийг олборлох, хуваарилах зэрэг үйл ажиллагаанд Австралийн засаг захиргааны шатлалууд нь өөр, өөр оролцоотой байдаг. Үүнд:

- Засгийн газар нь сангийн бодлого, мөнгөний бодлого, татварын бодлого, худалдааны бодлого болон олон улсын гэрээ хэлэлцээр байгуулах, хууль батлах зэрэг үндэсний бодлогыг боловсруулан, хэрэгжүүлдэг.
- Мужуудын засаг захиргаа нь ашигт малтмал, газрын тос ашиглах эрхийг зохицуулах, хуваарилах болон газар эзэмших, ашиглахтай холбогдсон бүхий л үйл ажиллагааг зохицуулах (байгаль орчин, мэргэжлийн аюулгүй байдлыг оролцуулан) ба ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг цуглуулах зэрэг нэн тэргүүний үүрэгтэй.
- Орон нутгийн засаг захиргаа нь хот, суурин, дүүргийн түвшинд үйл ажиллагаагаа явуулж, хог

хаягдал цуглуулах, нийтийн амралт цэнгээний байгууламж, хот төлөвлөлт зэрэг нийгмийн асуудлуудыг зохицуулах үүрэгтэй.

Эдгээр засаг захиргааны шатлалууд нь нийтлэг 4 үүрэг, хариуцлагыг хүлээдэг байна. Үүнд:

1. Макро эдийн засгийн орчныг бий болгох;
2. Үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулахад саад тотгор болж буй хүчин зүйлсийг арилгах, багасгах;
3. Хайгуулын салбар дахь арилжааны эрсдэлийг бууруулах зорилгоор геологийн мэдээллийг үнэ төлбөргүй эсвэл боломжит бага үнээр түгээх;
4. Хайгуул, боловсруулалт, аюулгүй байдал, байгаль орчны үнэлгээ хийх зохицуулалтын орчныг бүрдүүлэх, холбогдох төслийг батлах.

Уул уурхайн салбар дахь эрүүл, аюулгүй байдлын зохицуулалт

Уул уурхай нь аюул өндөртэй салбарт тооцогддог учир Засгийн газрын хувьд уурхайчдын эрүүл, аюулгүй байдал хамгийн чухал асуудал байдаг. Харин Австралийн уул уурхайн салбар нь “ямар ч эрсдэлгүй” буюу аливаа бэртэл гэмтэл, осол байхгүй гэдэг зорилтын хүрээнд хамгийн аюулгүй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд үүгээрээ дэлхийд тэргүүлдэг байна.

Муж бүр нь өөрсдийн эрх зүйн зохицуулалттай бөгөөд уул уурхайн үйл ажиллагааны бүх шатанд гарч болохуйц эрсдэлийг хамгийн бага байлгахаар зохицуулсан байдаг. Улсын хэмжээнд Засгийн газраас “Үндэсний уул уурхайн салбарын аюулгүй байдлын ажиллагаа” –г хөгжүүлэхэд оролцож байна.

Тоног төхөөрөмж, технологи, үйлчилгээ

Австрали Улсын уул уурхайн салбар нь технологийн хувьд маш өндөр түвшинд хөгжсөн байдаг. Эрдэс баялаг болон газрын тосны салбарууд нь экспортод түлхүү суурилсан, инновацтай салбар юм. Засгийн газраас уул уурхайн салбарыг илүү үр ашигтай, өрсөлдөөнтэй, инновац ихтэй болгох зорилгоор хэд хэдэн хөтөлбөр хэрэгжүүлдэг. Үүнд:

- Одоо байгаа болон шинээр хэрэгжүүлэх гэж буй үйлчилгээг амжилттай байлгах;
- Бизнес эрхлэгчдийн дэд бүтцэд чиглэсэн хөтөлбөр – Өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилгоор бизнес эрхлэгчдийг мэдлэг туршлага, мэргэшилтэй холбох;
- Салбарын өсөлтийг дэмжих төв – Австралийн өндөр өсөлттэй салбаруудын бүтээмж болон өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зорилготой төвийг ажиллуулдаг.

Татварын зохицуулалт

Уул уурхайн салбарт орж буй орлогоос татварын хувиар засгийн газар орлого олдог бөгөөд хэт өндөр татвар ногдуулах нь уул уурхайн салбарт дарамт учруулж, үйл ажиллагаа эрхлэгчдийн тоог бууруулдаг бол хэт бага татварын түвшин нь ашигт малтмал олборлолтыг нэмэгдүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бууруулах зэрэг сул талтай. Уул уурхайн салбарт ерөнхий 2 хэлбэрээр татвар ногдуулдаг ба эхнийх нь мөнгөн хэлбэрээр татвар авах, нөгөөх нь нийгэм, байгаль орчинд шаардлагатай дэд бүтцийг хөгжүүлэх /жишээ нь эмнэлэг, сургууль, зам тээвэр зэргийг хөгжүүлэх/ шаардлагыг тавьдаг.

Уул уурхайн салбар нь бусад салбаруудтай харьцуулахад онцлог ялгаатай татварын бодлогыг шаарддаг ба дараах хүснэгтэд уул уурхайн салбарт онцлог татварын бодлого баримтлах шалтгаан болон татварын бодлогод тусгах зүйлсийг харууллаа.

Онцгой татварын бодлого баримтлах шалтгаан	Татварын бодлогод баримтлах зүйлс
Уул уурхайн салбарт урт хугацаагаар, өндөр зардлаар үйл ажиллагаа явуулах шаардлага гардаг бөгөөд олборлолтын үйл явцад зардлаа нөхөх орлогыг олж чаддаггүй.	Үйл ажиллагаа явуулахад урьдчилж гарч буй нөхөн төлбөрийг ирээдүйн орлогод нь харьцуулж тооцно.
Уул уурхайн салбарын хөгжил нь капиталаас ихээхэн хамаардаг бөгөөд үйл ажиллагаа явуулахын тулд олон төрлийн тоног төхөөрөмж, экспертүүдийг импортлох шаардлага тулгардаг.	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлдвэрлэл эхэлсний дараагаар капиталын зардлыг нөхөхөд дэмжлэг үзүүлэх; ✓ Үйлдвэрлэл эхлэхээс өмнө гарсан үйл ажиллагааны зардлыг тодорхойлох; ✓ Импортын татварыг бууруулах, цуцлах; ✓ Импортын тоног төхөөрөмж, үйлчилгээнд тавигдсан нэмүү өртгийн татварыг (VAT) бууруулах, цуцлах эсвэл нөхөн төлбөр олгох.
Олборлосон бүтээгдэхүүн нь ихэвчлэн экспортлогддог.	<ul style="list-style-type: none"> ✓ Экспортын татварыг бууруулах; ✓ Экспортод тавигддаг НӨАТ-ыг бууруулах, цуцлах.
Ашигт малтмал тус бүр нь зарцуулагдах хөдөлмөр, зардал, үнэ, нэмүү өртөг, байгаль орчин болон нийгмийн нөлөөллөөрөө ялгаатай байдаг.	Ашигт малтмалыг бүлэглэж бүлэг тус бүрээр рояалти татвар ногдуулах.
Үйл ажиллагааны цар хүрээ нь жижиг, том янз бүр хэмжээтэй байдаг.	<ul style="list-style-type: none"> ✓ Үйлдвэрлэлийн хэмжээ бүрээр рояалти татварыг ялгаатай тогтоох; ✓ Жижиг үйл ажиллагаа эрхэлдэг олборлогчдыг зарим төрлийн татвараас чөлөөлөх.

Уул уурхайн салбарт улс оруудын хувьд ялгаатай олон төрлийн татварын бодлогыг баримталдаг ба доорх хүснэгтэд татварын төрөл, түүний зорилго, хэр түгээмэл ашиглагддаг зэргийг харууллаа.

Татварын төрөл	Зорилго	Тархалт
Нэгжид суурилсан рояалти	Тогтвортой орлогыг бүрдүүлэх зорилготой /үнийн хэлбэлзлээс хамаарахгүй/, эзэмшигч нь төлбөрийг шилжүүлдэг.	Түгээмэл ашиглагддаг.
Зарласан үнэд суурилсан рояалти	Өмчлөлийн эрхийг шилжүүлэх явцад ногдуулах төлбөр.	Түгээмэл ашиглагддаг.
Борлуулалтын онцгой татвар	Эдийн засгийн хэмжээнээс хамаарсан орлогыг бүрдүүлэх, орцод ноогдуулах татвар.	Ихэнх улсад НӨАТ нь борлуулалтын татварыг орлосон байдаг бол онцгой албан татварыг шатахуун зэрэг онцгой бараанд ногдуулдаг.
Өмчийн татвар	Үйлдвэрийн байгууллагын үнэ цэнэд тулгуурласан тогтвортой орлогыг бүрдүүлэх.	Түгээмэл ашиглагддаг.
Импортын татвар	Орлогыг бүрдүүлэх, дотоодын үйлдвэрлэгчдэд давуу байдал бий болгох, боомтын хөгжил болон гаалийн газрыг санхүүжүүлэх.	Ихэнх улсууд уул уурхайн тоног төхөөрөмжийг татвараас чөлөөлсөн байдаг.
Экспортын татвар	Орлогыг бүрдүүлэх, дотоодын эрэлт хэрэгцээг дэмжих.	Ихэнх улсад эрдэс баялгаас уг татварыг авдаггүй.
Withholding on remitted loan interest	Орлогыг бүрдүүлэх, тэгш байдлыг дэмжих, орон нутгийн санхүүжилтийг дэмжих.	Түгээмэл ашиглагддаг.

Импортын үйлчилгээнээс авах суутгал	Орлого бүрдүүлэх, дотоодын үйлчилгээний хэрэглээг дэмжих.	Түгээмэл ашиглагддаг.
Нэмэгдсэн өртгийн албан татвар	Орлого бүрдүүлэх, нэмэгдсэн өртгийг тодорхойлох.	Бараа, бүтээгдэхүүнийг экспортоор гаргасан бол ихэнх улсууд үүдэн гарах сөрөг үр дагаврыг татвараас чөлөөлдөг.
Бүртгэлийн хураамж	Захиргааны алба үйл ажиллагааны орлого бүрдүүлэх.	Түгээмэл ашиглагддаг.
Түрээсийн болон ашигласны хураамж	Тогтвортой орлогыг бүрдүүлэх, ихэвчлэн орон нутгийн засгийн газарт газар ашигласны төлбөр болгон төлдөг.	Түгээмэл ашиглагддаг.
Орлогын албан татвар	Төлбөр төлөх чадварт суурилсан орлогыг бүрдүүлэх.	Бүх улсад хэрэглэгддэг.
Хөрөнгө ашиглалтын татвар	Капиталын элэгдлийг тооцох.	Хөгжсөн улсуудад түгээмэл, харин хөгжингүй улсуудад бараг хэрэглэгддэггүй.
Нэмэлт орлогын татвар	Маш өндөр ашгийн хэмжээг тооцох.	Маш ховор
Илүүдэл ашгийн татвар	Маш өндөр ашгийн хэмжээг тооцох.	Маш ховор
Цэвэр ашгийн рояалти	Төлбөр төлөх чадварт суурилсан орлогыг бүрдүүлэх.	Татварын систем өндөр хөгжсөн улсуудад түгээмэл хэрэглэгддэг.
Ногдол ашгийн татвар	Төлбөр төлөх чадварт суурилсан орлогыг бүрдүүлэх.	Түгээмэл ашиглагддаг.

Рояалти

Ерөнхий мэдээлэл

Рояалти татвар нь уул уурхайн салбарт тавигддаг онцгой албан татварын төрөл бөгөөд ашгийн түвшинд нь суурилж эсвэл олборлосон ашигт малтмалын хэмжээ, түүний үнэ цэнэ дээр суурилан ногдуулдаг.

Олон улсад дараах шинж чанаруудыг нэгээс илүүгээр агуулж байвал рояалти татвар гэж үздэг.


- Баялаг эзэмшигчээс татвар төлөгчид өмчлөлийн эрхийг шилжүүлэх болон түүнийг зарж борлуулах эрхийг шилжүүлэх явцад үүсэх зардлыг баялаг эзэмшигчид нөхөн олгох зорилготой байх.
- Ашигт малтмал олборлогч олборлосон бүтээгдэхүүнийг боловсруулагчдаас татвар авах зорилготой байх.
- Зөвхөн уул уурхайн салбарт л ногдуулдаг онцгой төрлийн татвар байх.

Австрали Улс нь 1981 оноос өмнө рояалтийг 1904 оны Уул уурхайн хуулиар зохицуулдаг байсан бөгөөд анхандаа алт, нүүрсэнд энэхүү татварыг ногдуулдаг байв. Харин 1958 оноос Засгийн газраас ихэнх ашигт малтмалд ялгаатай хувь хэмжээгээр татвар ногдуулдаг болсон ба энэхүү тогтолцоог 1981 он хүртэл өөрчлөлгүй хэрэглэсээр байсан юм. Тиймээс Баруун Австралийн одоогийн рояалти татварын систем нь 1981 онд гаргасан зөвлөмж зарчмуудад үндэслэсэн байдаг.

Баруун Австралийн одоогийн рояалти татварын систем нь боловсруулалтын түвшнээс хамааран өөр өөр хувь хэмжээг ногдуулдаг бөгөөд доорх зурагт жишээгээр харуулж байна. Үүнд, олборлох, буталж шүүх, баяжуулах, хайлуулж цэвэршүүлэх гэсэн боловсруулалтын 4 үе шаттай ашигт малтмалын

хувьд жишээ авчээ. Зөвхөн олборлоод борлуулах үед 10%-ийн роялти татварыг, буталж шүүгээд борлуулбал 7.5%-ийг, баяжуулсны дараа борлуулбал 5%-ийг, хайлуулж, цэвэршүүлээд эцсийн бүтээгдэхүүн болгон борлуулах үед 2.5%-ийн роялти татварыг ногдуулдаг байна.

Зураг 7. 36. Баруун Австралийн роялти татварын хувь



Эх сурвалж: Department of mines and petroleum, Department of State development, "Mineral Royalty rate analysis", 2015

Роялти тооцох аргачлал

Нэгжид суурилсан роялти татвар: Энэ нь роялти татварын хамгийн эртний арга бөгөөд ашигт малтмалын хэмжээ, жинд суурилж тооцдог. Нэгжид суурилсан роялти татварыг ихэвчлэн аж үйлдвэрт ашиглагддаг элс, хайрга, шохойн чулуу, нүүрс, төмрийн хүдэр зэрэг ашигт малтмалуудад ногдуулдаг.

Үнэ цэнэд суурилсан роялти татвар: Энэ нь бүтээгдэхүүний үнэ цэнээс нь тооцон авдаг татвар бөгөөд нэгжид суурилсан татварын адилаар тухайн уурхайн ашиг, алдагдлаас хамааралгүйгээр ногдуулдаг. Гэхдээ түүхий эдийн үнийн хэлбэлзлээс шалтгаалан уг төрлийн татвар нь хэлбэлздэг байна.

Ашиг болон орлогод суурилсан татвар: Уурхайн ашигт ажиллагаанд суурилан тооцдог татвар бөгөөд хөрөнгө оруулагчдад ихэвчлэн таалагддаг.

Хайбрид татвар: Ашигт ажиллагаанд суурилсан татварыг нэгжид суурилсан эсвэл үнэ цэнэд суурилсан татвартай хослуулан ашигладаг татварын төрөл.

Харин экспортын хэмжээ бага, бүрэн боловсруулагдаагүй, никель, ховор элементийн исэл болон ванадийн пентоксид зэрэг ашигт малтмалд тогтмол ижил түвшинд 2.5 хувийн роялти татварыг ногдуулдаг.

1 тоннд төлөх роялти татварыг эцсийн бүтээгдэхүүнд агуулагдах концентрацын хэмжээ (концентрац, царцмаг, металл)-г 2.5%-аар үржүүлснийг 1 тонн металлын үнээр үржүүлж тооцдог:

$$R = \frac{U \times 2.5}{100} \times P$$

Энд, R= 1 тонн металлд төлөх рояалти татвар

U= металлын агууламж

P= 1 тонн металлын үнэ /австрали доллараар илэрхийлэгдсэн/

Бэнчмарк

Бэнчмарк нь тухайн рояалти татвар нийгэмд шударга үр өгөөж өгч байгаа эсэхийг хэмжих гол үзүүлэлт болдог. Өөрөөр хэлбэл бэнчмарк нь ашигт малтмал ашигласны төлбөрийг тооцоолоход ашиглагддаг механизм бөгөөд ашигт малтмал олборлосны дараах үнэ цэнийн 10%-тай ойролцоо байна. Баруун Австралийн Засгийн газар 1981 онд хүдрийн экспортын үнэ цэнийн 10%-д өгөөжийг хүртээхийн тулд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 7.5%, 5% ба 2.5% байхаар тогтоосон. Тус ялгаатай 3 татварын түвшин нь ашигт малтмалын олборлосны дараах үнэ цэнийн 10 хувьтай тэнцэх хэмжээний ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг бий болгосон. Баруун Австралид 10%-ийн бэнчмарк, зардлын үнэлгээний хувь хэмжээ нь тэгш шударга байдал, үр ашиг, нийгмийн шударга өгөөж, өрсөлдөх чадвар зэргийг тэнцвэржүүлсэн гэж үздэг.

Рояалтигийн тооцоолол

Бэнчмаркын 10% түвшинд ашигт малтмалыг олборлосны дараах үнэ цэнийн өгөөжийг тооцоолох замаар рояалтигийн хувь хэмжээг тогтоож өгсөн.

Рояалтигийн хувь хэмжээг дараах үе шатын дагуу тооцоолно. Үүнд:

1. Рояалтигийн суурийг тооцох

$$\text{Рояалтигийн суурь} = \left(\frac{\text{Үнэ (ам.доллар)}}{\text{Валют солиулах үнэ}} * \text{Хэмжээ} \right) - \text{Боломжит зардлууд} \quad (1)$$

Рояалтигийн суурь гэдэг нь рояалтигийн хувь хэмжээг ногдуулах суурь орлого бөгөөд үүнийг олохдоо тухайн ашигт малтмалыг борлуулсан орлогоос боломжит зардлуудыг хассан дүн юм. Боломжит зардал гэдэгт ачааны зардал, даатгалын зардал, ложистик зардал болон импортын татвар зэрэг ордог.

2. Ашигт малтмалын үнэ цэнийг тооцох

Ашигт малтмал олборлохоос өмнөх үнэ цэнэ= Рояалтигийн суурь- Netback зардлууд (2)

Ашигт малтмал олборлосны дараах үнэ цэнэ= Рояалтигийн суурь- Netback зардлууд (3)

Ашигт малтмал олборлохоос өмнөх үнэ цэнийг тооцохдоо рояалтигийн суурь хэмжээнээс Netback зардлыг хасаж тооцдог. Netback зардал гэдэг нь тухайн ашигт малтмалыг газрын гүнд, олборлох явцад болон олборлосны дараа гарах зардлыг хэлнэ. Ашигт малтмалыг олборлохоос өмнөх болон олборлосны дараа үнэ цэнээс хамаарч Netback зардал нь харилцан адилгүй байдаг. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 7. 12. Netback арга

		Зардал	Netback method				
			1	2	3	4	5
Mine head-ийн downstream зардал	Mine head, in-situ зардлууд	Тээвэрлэлтийн зардал					
		Тээрэмдэх зардал					
		Баяжуулах зардал					
		Хайлуулах зардал					
		Цэвэршүүлэх зардал					
		Эцсийн бүтээгдэхүүний тээвэрлэлт, боловсруулалтын зардал					
		Төслийн маркетингийн зардал					
		Гүний хөрөнгийн элэгдлийн зардал	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн
		Төслийн захиргааны зардал (үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн удирдлагын зардал)					
		Капиталын жигнэсэн дундаж зардал			Зээлдүүлэх зардал		
		Тогтворжуулалтын зардал. Үүнд, төслийн хайгуулын судалгаа, уурхайн амьдралын өргөтгөсөн судалгаа			Зөвхөн төсөл	Зөвхөн төсөл	
Компанийн зардал. Үүнд, legal, governance allocated to operation							
Гүйцэтгэлийн зардал. Үүнд, нөхөн сэргээх, татан буулгах							
Mine head-ийн upstream зардлууд	Зөвхөн in-situ зардлууд	Олборлох зардал					
		Уул уурхайн хөрөнгийн элэгдэл	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн	Цэвэр дүн
		Төслийн захиргааны зардал (үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн удирдлагын зардал)					
		Капиталын жигнэсэн дундаж зардал			Зээлдүүлэх зардал		
		Тогтворжуулалтын зардал. Үүнд, төслийн хайгуулын судалгаа, уурхайн амьдралын өргөтгөсөн судалгаа			Зөвхөн төсөл	Зөвхөн төсөл	
		Компанийн үйл ажиллагааны зардал					
Гүйцэтгэлийн зардал. Үүнд, нөхөн сэргээх, татан буулгах							

Netback зардлын 5 түвшин байх ба түвшин бүр бэнчмаркын 10 хувийн түвшинд байх ашигт малтмалын олборлохтой холбогдох зардлуудыг хасах замаар тохирох түвшнээр үнэ цэнийг тооцно.

3. Ашигт малтмалын өгөөжийг тооцох

$$\text{Ашигт малтмал олборлохны дараах өгөөж} = \frac{\text{Роялти}}{\text{Ашигт малтмал олборлохны дараах үнэ цэнэ}} \quad (4)$$

$$\text{Ашигт малтмал олборлохоос өмнөх өгөөж} = \frac{\text{Роялти}}{\text{Ашигт малтмал олборлохоос өмнөх үнэ цэнэ}} \quad (5)$$

Ашигт малтмалын өгөөж нь бэнчмаркын 10 хувийн түвшинтэй тэнцүү байх ба дээрх томъёоноос рояалтигийн хэмжээг тооцож гаргана.

4. Рояалтиг тооцох

$$\text{Рояалти} = \text{Рояалтигийн суурь} * \text{Рояалтигийн хувь} \quad (6)$$

Рояалтигийн хэмжээ (6) болон рояалтигийн суурь (1) нь тодорхой болсон учраас рояалти ногдуулах хувь хэмжээг дээрх томъёоны дагуу тооцдог.

Олон улсын харьцуулалт

Дараах хүснэгтэд Африк, Ази, Латин Америкийн улсууд болон Австрали Улсын уул уурхайн салбарт рояалти татварыг хэрхэн ногдуулдаг болохыг харууллаа.

	Гана	Өмнөд Африк	Хятад	Энэтхэг	Монгол	Баруун Австрали	Венесуэл
Хэлбэр	Үндэсний хууль	Аргачлалаар	Үндэсний хууль	Үндэсний хууль	Үндэсний хууль	Мужийн хууль	Үндэсний хууль
Рояалти татварын төрөл	Үнэ цэнэд суурилсан	Үнэ цэнэ, борлуулалтын орлогод суурилсан	Нэгж, болон үнэ цэнэд суурилсан	Нэгж, болон үнэ цэнэд суурилсан	Үнэ цэнэд суурилсан	Ихэвчлэн нэгж, үнэ цэнэд суурилсан, алмазны хувьд ашигт суурилсан болон хайбрид	Үнэ цэнэд суурилсан
Татварын түвшин	3–10%	3–12%	1–4%	0.4–20.0%	2.5% алтны хувьд 7.5%	2.5–7.5%	3–4%
Ашигт малтмал тус бүрээр ялгаатай эсэх	Үнэт чулуу: 10% Үнэт металл: 5% Бусад: 3%	Ялгаагүй	Ашигт малтмал тус бүрээр ялгаатай	Ашигт малтмал тус бүрээр ялгаатай	Ялгаагүй, зөвхөн алтны хувьд ялгаатай	Ялгаатай	Алт, мөнгө зэрэг металл: 3%, алмаз, үнэт чулуу: 4%, Бусад: 3%
Зэс	3%	3–12%	2%	3.2%	2.5%	Концентрац: 5% Метал: 2.5%	3%
Алт	5%	3–12%	4%	<2000 kg, US\$225/kg; >2000 kg, US\$235/kg	4–5%	2.5%	3%
Шохой чулуу	3%	3–12%	2%	55 рупи /тн	2.5%	0.30 Австрали доллар/тн	3%
Нүүрс	5%	3–12%	1%	65–250 рупи/тн	2.5%	7.5%	N/A

Уул уурхайн салбарт ногдуулсан татварын бодлого амжилттай хэрэгжсэн жишээ:

Австрали Улс: Хөрөнгө оруулалтын орчинд татварын бодлого, газар зүй, геологийн нөхцөл, улс төрийн тогтвортой байдал зэрэг олон хүчин зүйлс нөлөөлдөг. Австрали Улсын уул уурхайн салбар нь хөрөнгө оруулалтын таатай орчноороо дэлхийд тэргүүлдэг. Мөн рояалти татварыг муж тус бүр нь цуглуулдаг ба нэгжид суурилсан, үнэ цэнэд суурилсан, ашигт суурилсан рояалти татварыг ногдуулдаг.

1890 оноос хойш Баруун Австрали нь дэлхийд алтны үйлдвэрлэлээрээ тэргүүлж байгаа ба 1997 оноос эхлэн алтны үйлдвэрлэлд рояалти татвар ногдуулж эхэлсэн байна. Ингэснээр Австралийн уул уурхайн салбарт ямар нэг сөрөг нөлөө ажиглагдаагүй ба Баруун Австралийн алтны үйлдвэрлэлийн түвшин нь татвар ногдуулсны дараагаар ч өсөх хандлагатай байсан юм. Мөн хөрөнгө оруулалтын орчинд өөрчлөлт орсон эсэхийг илэрхийлэх Баруун Австралийн уул уурхайн салбарт гарсан зардлыг Австрали Улс болон дэлхийн зардлын хэмжээнд харьцуулан үзэхэд уг үзүүлэлт татвар ногдуулсны дараагаар ч өсөх хандлагатай байсан. 1996 онд Баруун Австралийн уул уурхайн салбарт гарсан зардлыг Австрали Улсын уг үзүүлэлттэй харьцуулахад 69.1 хувь байсан бол татвар ногдуулсны дараа 72.9 болж өссөн ба 2001 онд 74.5 хувь хүртэл өссөн байна.

Рояалти татвар Баруун Австралийн хөрөнгө оруулалтын орчинд сөрөг нөлөө үзүүлэлгүй амжилттай хэрэгжсэн гол шалтгаан нь татварын түвшнийг эдийн засгийн үзүүлэлтүүдтэй харьцуулан тооцож ногдуулж байсантай холбоотой. 1997 онд анх рояалти татварыг 2.5 хувиар ногдуулж байсан бол 1998 оны 6 дугаар сард алтны үнэ буурсан, зах зээлийн нөхцөл муудсан зэрэг шалтгаанаар 1.25 хувь болж бууруулсан. Харин 2000 онд татварыг 2.5 хувь болгож дахин өсгөсөн бол 2005 оныг хүртэл алтны үнийн бууралттай холбоотойгоор дахин 1.25 хувь болж бууруулсан. Өөрөөр хэлбэл Баруун Австрали рояалти татвар ногдуулахдаа тухайн үнийн түвшинд алт олборлож буй компани хангалттай хэмжээний ашигтай ажиллах боломжтойгоор алтны үнэ цэнэд суурилсан татварын бодлогыг хэрэгжүүлж байжээ.

Рояалти татварыг хэрэгжүүлснээр алтны үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын түвшинд сөрөг нөлөө үзүүлээгүй бөгөөд нутгийн иргэдэд алтны үйлдвэрлэлийн түвшин, зах зээлд эзлэх хувиа бууруулалгүйгээр орлогоо нэмэгдүүлэх зэрэг эерэг нөлөөг үзүүлсэн юм.

Уул уурхайн салбарт ногдуулсан татварын бодлого амжилтгүй хэрэгжсэн жишээ:

Ямаик Улс: 1960–аад оны үед Ямаик Улс хөнгөн цагааны хүдрийн экспортдоо 0.26/тн америк долларын татвар ногдуулсан бөгөөд тухайн үед хөнгөн цагааны хүдрийн олборлолтод ногдуулсан орлогын татвар 2.25/тн америк доллар байсан. 1974 онд засгийн газар рояалти татвараа 0.55/тн америк доллар болгож нэмэгдүүлсэн бөгөөд энэ нь хөнгөн цагааны дэлхийн зах зээл дээрх үнийн түвшний 7.5 хувьтай нь тэнцүү байсан.

Татварын уг бодлого нь Ямаик Улсын Засгийн газрын орлогыг нэмэгдүүлж байсан хэдий ч Ямаик Улсын хөнгөн цагаан үйлдвэрлэлийн түвшин дэлхийн зах зээлд эзлэх хувь буурч эхэлсэн ба хөрөнгө оруулалтын орчныг муутгаж эхэлсэн. Иймд Ямаик Улсын татварын бодлого амжилтгүй хэрэгжсэн бөгөөд олон улсын байгууллагууд, судлаачид татварын бодлогыг хэрэгжүүлэхдээ хөнгөн цагааны зах зээлийг сайн судлаагүйн улмаас уг бодлогыг амжилтгүй хэрэгжсэн гэж дүгнэсэн байна.

Өмнөд Африк: Өмнөд Африкийн уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын орчин Чили, Австрали зэрэг олон улс оронтой харьцуулахад төдийлөн таатай бус юм.

Халдварт өвчлөл, гэмт хэрэг, улс төрийн тодорхой бус байдал өндөртэй зэрэг нь Өмнөд Африкийн хөрөнгө оруулалтын орчныг таатай бус байхад нөлөөлдөг. Мөн Өмнөд Африкт хэрэгжүүлсэн рояалти

татвар нь харьцангуй өндөр байсан ба Баруун Австрали зэрэг татварын бодлого нь амжилттай хэрэгжиж байсан улсууд татварын хэмжээгээ зах зээлийн нөхцөл байдалд нийцүүлэн уян хатан өөрчилж байсан юм. Харин Өмнөд Африкийн татварын хувь хэмжээ тогтмол байсан нь татварын бодлого амжилттай хэрэгжээгүйн шалтгаан болсон байна.

Улс орнуудын уул уурхайн салбарт хийгдсэн татварын бодлогоос харахад зах зээлийн нөхцөл байдал, ашигт малтмалын төрөл зэрэгт нийцүүлсэн уян хатан татварын бодлого нь амжилттай хэрэгждэг ба ийм төрлийн татварын бодлогыг баримтлахад тухайн улсын татварын систем нь сайн хөгжсөн байх шаардлагатай байдаг ажээ.

	1980–аад он	1990–ээд он	2000–аад он
Төрийн салбар	<ul style="list-style-type: none"> Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн тодорхой хувийг олон нийтэд нээлттэй болгох үйл ажиллагааг эхлүүлсэн. Гэвч дийлэнх хэсэг нь төрийн өмч хэвээр үлдсэн. Хувийн хэвшлийн менежментийг арга барилыг төрийн секторт нэвтрүүлсэн Төрийн секторын санхүүгийн удирдлагыг сайжруулсан. Төрийн байгууллагын зардлыг бууруулж, цомхон бүтэцтэй болгож эхэлсэн. 	<ul style="list-style-type: none"> Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийг 100 хувь хувьчлах үйл ажиллагаа эхэлсэн. Төрийн байгууллагын зарим үйлчилгээг хувийн сектор гүйцэтгэх болсон. Төсвийн нягтлан бодох бүртгэлийн тооцоонд Аккруэл суурийг бүрэн нэвтрүүлсэн. Төв агентлаг болон түүний салбар яамдын тайлагнах хэлбэрт шилжин, хариуцлагыг өндөрсгөсөн. 	<ul style="list-style-type: none"> Төр төвтэй засаглалыг бий болгосон. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний арга барилыг нэвтрүүлсэн. Төв агентлагийн яамдад үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэн, голлох үүргийг оноож өгсөн. ЗГ–ын агентлагуудын хэрэгжилт болон үйлчилгээнд хяналт тавих үүрэг бүхий нэгжийг байгуулсан. Төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулсан. Төрийн байгууллагын цомхон бүтцийг бүрдүүлсэн. Засгийн газарт зөвлөх үйлчилгээ үзүүлэх Бүтээмжийн хороо үүсгэн байгуулагдсан.
	<ul style="list-style-type: none"> New South Wales муж нь 1988–1994 онд 5 төрийн өмчит байгууллагын корпорацжуулаад, 3 байгууллагын хувьчилсан 	<ul style="list-style-type: none"> 1990–ээд онд улсын төрийн өмчийн хувьчлал нь санхүүгийн салбараас эхэлсэн 1990–1993 оны хооронд ихэвчлэн банк, хөрөнгө оруулалт, санхүү, даатгалын байгууллагуудад 1994, 1995 онуудад агаарын тээврийн компаниудад, 	<ul style="list-style-type: none"> 2002 онд Сидней нисэх буудал 2014 онд Medibank хэмээх эрүүл мэндийн даатгалын компанийн Хамтын нөхөрлөлийн аж үйлдвэрийн Хий (Commonwealth Industrial Gases)
Төрийн өмчит байгууллагын хувьчлал	<ul style="list-style-type: none"> NSW Хөрөнгө оруулалтын корпорац 1989–1990 онд хувьчлагдсан. 	<ul style="list-style-type: none"> 1996 оноос эхлэн эрчим хүч, инженер, технологийн компаниудад голчлон хувьчлал явагдсан. Австрали Улс 1990 оноос хойш нийт 85 тэрбум долларын хувьчлал хийгдсэн ба үүний талаас илүү хувь нь шууд худалдаалах замаар хийгдсэн хувьчлал байжээ. 	<ul style="list-style-type: none"> Шинэ өмнөд Вэльс дэх Засгийн газрын цэвэрлэх үйлчилгээний байгууллага, Засгийн газрын даатгалын оффис, Засгийн газрын хэвлэх оффис Бүх ачаа тээвэр дамжуулах төмөр замын үйлчилгээ Дийлэнх төрийн өмчит банкнууд Хүн тээврийн төмөр замын үйлчилгээ

<p>Хөдөлмөрийн зах зээл</p>	<ul style="list-style-type: none"> • Нийлүүлэлт болон эрэлтийн шокийн нөлөөгөөр инфляцийн түвшин өссөнөөр цалингийн зардлын өсөж, энэ нь хөдөлмөрийн зах зээлийн өртгийг нэмэгдүүлж, улмаар ажилгүйдлийн түвшнийг нэмэгдүүлсэн. Ийнхүү 1983 онд нийт ажилгүйдлийн түвшин 9.7 хувьд хүрч өссөн. • Үүний дараагаар дэлхийн санхүүгийн хямрал тохиож, Засгийн газрын бодит цалинг нэмэгдүүлэх шийдвэрийн үр дүнд буурч байсан ажилгүйдлийн түвшин 1992 онд түүхэн дээд цэг болох 11.2 хувьд хүрсэн. • Хувьчлал, корпорацилалтай холбоотойгоор төрийн албан хаагчдын тоог цөөрүүлэх бодлого эхэлсэн. 	<ul style="list-style-type: none"> • 1993 онд уян хатан цалингийн системд шилжиж салбар болон пүүсүүдийн бодит эрэлт хэрэгцээ, хөдөлмөрийн нийлүүлэлтийн тэнцвэрээр цалин тогтох боломжийг олгосон. • Австралийн Ажлын Байрны Гэрээ³-нд ажилчдын эрх ашгийг хамгаалсан чухал нэмэлт заалтуудыг тусгасан. • Ховардын засгийн газрын үед Ашгийн Бус Төрийн Агентлагийг байгуулсан./ажилд зуучлах агентлаг/ • 1999–2003 оны хооронд хувьчлалтай холбоотойгоор төрийн ба дэд бүтцийн сектор дахь ажилчдын тоо 31000–аар буурсан. 1990–1995 онд нийт ажлын байрны тоо 50,000–аар буурсан бол дараагийн 8 жилийн хугацаанд 19,000–аар нэмэгджээ. 	<p>Өмнөх 10 жилийн бодлогыг үргэлжлүүлэн баримталж байна. 2000–аад онд Австралийн хөдөлмөрийн зах зээлд "чимээгүй арван жил" байлаа. Хөдөлмөрийн зах зээлд санаа зовоосон асуудлууд харьцангуй бага, ажил эрхлэлт, ажилгүйдэл зэрэг үзүүлэлтүүд бүгд эерэг гарсан.</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөлмөрийн зах зээл дэх мэдээллийн технологийн ашиглалт өссөн. • 2004–2008 оны хооронд ажил эрхлэлт нэмэгдсэн нь ДНБ–ий өсөлтийн хурдацтай өсөлттэй уялдаж байсантай холбоотой юм • Шинжлэх ухаан, техник, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн тусламжийн салбарт хөдөлмөр эрхлэлтийн өсөлт харьцангуй өндөр байгаа юм.
<p>Санхүүгийн зах зээл</p>	<ul style="list-style-type: none"> • Валютын ханшийн хөвөгч системд шилжсэн • Зөвхөн эрсдэл даах чадвартай иргэдэд зээл олгодог байсан бол өндөр эрсдэлтэй зээлдэгч нарт мөн зээл олгож эхэлсэн • Гаднын банкуудад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгож эхэлсэн. 	<ul style="list-style-type: none"> • Компани болон төрийн өмчит компаниудын хувьчлал • Тэтгэврийн санг байгуулсан • Банк болон даатгалын компаниудын нэгдэл • Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хөгжил • Хөрөнгийн зах зээл дэх хувьцааны цахим арилжааны систем • Банкуудын эрсдэлд суурилсан, газар дээрх хяналт шалгалтын систем • Life Insurance Act буюу амьдралын даатгалын хуулийг баталсан 	<ul style="list-style-type: none"> • Twin peaks систем буюу 2 тулгуурт зохицуулалтын тогтолцоо ашиглаж эхэлсэнээр үр дүнтэй, уялдаа холбоотой зохицуулалтын загвар бий болсон. • Компанийн хууль, эдийн засгийн шинэчлэлийн программ (Corporate Law Economic Reform Progm (CIERP)) • Базел II болон III–ыг нэвтрүүлсэн
<p>Хөдөө аж ахуйн бараанд</p>	<ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн бараанд олгож байсан нөхөн төлбөрийг багасгаж байсан. • Эрх зүйн зохицуулалтуудыг хянан шалгаж, цэгцлэх ажлууд хийгдсэн. 	<ul style="list-style-type: none"> • Шинээр гарч буй зохицуулалтууд нь Үндэсний Өрсөлдөөний Бодлогод нийцэж байсан. • Ган гачгийг фермерүүдийн үйл ажиллагааны хэвийн орчны хэсэг гэж “Ган гачгийн үндэсний шинэ бодлого” боловсруулсан. 	<ul style="list-style-type: none"> • “Ган гачгийн үндэсний шинэ бодлого”-оос онц аюултай ган гачгийн талаар зохицуулалтыг хасаж шинэчлэн танилцуулсан.
<p>Хөдөө аж ахуйн салбар</p>	<ul style="list-style-type: none"> • 1986 оноос хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болох цитрусын татварыг 30–аас 5 хувь хүртэл бууруулсан. • 1986 онд Ерөнхий сайд, Боб Хаух, үйлдвэрлэлийн сайд Жон Керин Эдийн засаг, орон нутгийн бодлогын мэдэгдэл гаргасан. 	<ul style="list-style-type: none"> • Сүү, сүүн бүтээгдэхүүний экспортын төлбөрийн дэмжлэгийг бууруулсан. • Тамхины салбарын тогтворжуулах төлөвлөгөөг зогсоосон. 	<ul style="list-style-type: none"> • Салбарын хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох төрийн хөтөлбөрүүд хэрэгжиж байна. • Баруун Австралид ямар ч лицензтэй аж ахуйн нэгжид арвай экспортлохыг зөвшөөрсөн. • Улаан буудайг их хэмжээгээр экспортлоход Австралийн улаан буудайн зөвлөлөөс зөвшөөрөл авах шаардлагагүй болсон.

<p>Сангийн бодлого</p>	<ul style="list-style-type: none"> • Дунд хугацааны төсвийн дүрмийг /fiscal rules/ 1980–аад оны дундуур хэрэгжүүлж эхэлсэн. • Австралийн Засгийн газар 1985–1986 оны төсөвт гурван амлалт өгсөн бөгөөд дараах үүргүүдийг хүлээсэн. Үүнд: • Парламентын бүрэн эрхийн хугацаанд татварын орлогыг нэмэгдүүлэхгүй байх; • Парламентын бүрэн эрхийн хугацаанд засгийн газрын зардлыг бууруулах; • Парламентын бүрэн эрхийн хугацаанд төсвийн алдагдлыг бууруулах байв. • Татварын дарамтыг нэмэгдүүлэлгүйгээр зардлаа танах замаар төсвийн алдагдлаа бууруулахыг зорьсон. 	<ul style="list-style-type: none"> • Өмнөх 10 жилийн бодлогыг үргэлжлүүлэх буюу үндэсний хадгаламжийг нэмэгдүүлж, урсгал дансны алдагдлыг бууруулах зорилготой байв. • Засгийн газрын төсвийн орлого дахь орлогын татварын суурийг өргөтгөж, татварын дарамтыг багасгах бодлого: 2000 оны 7–р сард, татварын шинэ систем буюу өргөн хэрэглээний бараа үйлчилгээнд суурилсан GST татварыг хэрэгжүүлсэн. • Үндэсний хадгаламжийг өсгөхөд чиглэсэн бодлого: 1990 оноос тэтгэврийн сангийн тогтолцоог боловсронгуй болгож, тэтгэврийн орлогын зохицуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн. 1992 онд Superannuation Guarantee (SG)–г байгуулсан. • 1993 онд Австрали Улс тэтгэврийн орлогын зохицуулалтын 3 тулгуурт бодлого /Age pension, The superannuation guarantee, voluntary saving for retirement/–ыг амжилттай хэрэгжүүлж эхэлсэн. 	<ul style="list-style-type: none"> • Тухайн үеийн Засгийн газар гадаадын өр төлбөрийг өсөлтөд үргэлжлүүлэн анхаарахаас илүүтэйгээр зөв зохистой сангийн бодлого, эдийн засгийн уян хатан шийдвэрийг амжилттай хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой үйл явдал гэж үзжээ. • 2002 оны 5–р сард Засгийн газрын нэгдсэн тайлан (IGR4) –г гаргаснаар олон нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлуудыг оновчтой хөндөх болсон. • IGR–ийн судалгаагаар олон нийтийн эрүүл мэндийн үйлчилгээ, ирээдүйн хадгаламжийн төсөвлөлт, тэтгэврийн зардал (Ирээдүйн сан) зэрэгт анхаарал хандуулах нь чухал хэмээн үзэж тэдгээрт чиглэсэн бодлогыг авч хэрэгжүүлэх болсон.
<p>Мөнгөний бодлого</p>	<ul style="list-style-type: none"> • 1980–аад онд инфляцийн түвшнийг бууруулах хүрээнд мөнгөний бодлого цалингийн бодлогод дэмжлэг үзүүлдэг байсан • Мөнгөний хатуу бодлого • Ханшийн чөлөөт хөвөгчийн системд шилжсэн. • Гадаад валютын интервенцийг стерилизаци хэлбэрээр хийж байсан • Харин хүүгийн түвшин нь суурь мөнгийг өөрчилсний үр дүнд бус, тогтоосон түвшнээр тодорхойлогдож байв. 	<ul style="list-style-type: none"> • Австралийн нөөцийн банк 1996 онд үйл ажиллагааны хувьд биеэ даасан хэлбэрт шилжсэн. • 1990 оны эхэн үеийн санхүүгийн хямралаас үүдэн инфляцийн түвшин огцом буурч, Нөөцийн банк инфляцийн түвшнийг 2–3 хувьд барих зорилт тавьж, хүүгийн түвшнийг бууруулснаар, 1994 он гэхэд 1980 оны түвшинд хүрсэн байна. 	<ul style="list-style-type: none"> • Үнийн тогтвортой байдлыг хангах асуудлаас гадна Төв банкны хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхийг зорьж байсан • 1990 оны 1 дүгээр сараас эхлэн бодлогын өөрчлөлтийг олон нийтэд нээлттэй мэдээлэх болсон. • Түүнчлэн тогтмол байдлаар статистикийн бюллетенийг олон нийтэд хүргэж, хагас жилд нэг удаа парламентад тайлагнадаг болсон.

АРВАН НЭГ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Австрали Улсад 1980 оныг хүртэл социалист эдийн засгийн дэглэм ноёрхож, эрүүл мэнд, санхүү, боловсрол, харилцаа холбоо, тээвэр зэрэг салбаруудыг төр эзэмшиж, гадаад худалдаа хаалттай, валютын тогтмол ханшийн систем үйлчилж байв. Үүний зэрэгцээ газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалан Австралийн эдийн засаг уналтад орж, экспортын бууралт болон засгийн газрын өндөр зардлын нөлөөтэйгөөр эрэлт, нийлүүлэлтийн шок үүсэж, улмаар стагфляци бий болж, инфляци түүхэн дээд түвшиндээ хүрснээр засгийн газрын зүгээс эдийн засгийн томоохон салбаруудад реформууд хийх болов. Австралийн засгийн газар 1980, 1990 болон 2000–аад онуудад төрийн салбар, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн зах зээл, хөдөө аж ахуй, уул уурхайн салбаруудад шинэчлэлүүдийг хийж эхэлсэн.

Төрийн салбарт менежерализм, төрийн шинэ менежмент, төр төвтэй засаглалыг хэрэгжүүлэх замаар иргэдийн хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэж, өндөр чадавхтай боловсон хүчнийг бүрдүүлж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлж, төрийн салбарт шинэ стандартуудыг нэвтрүүлсэн. Тухайлбал, Бүтээмжийн хороог байгуулснаар эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулахаас гадна нийгэм, байгаль орчин, эдийн засгийн харилцан хамаарлын асуудлыг хамарсан судалгаа, зөвлөмжийг гаргадаг болов. Мөн компаниудыг корпорацчилал, хувьчлал гэсэн 2 хэлбэрээр хувьчилж эхэлснээр засгийн газрын өрийг бууруулж, эдийн засгийн хөгжлийг дэмжих түлхэц болж өгчээ.

Реформын хүрээнд зах зээлийн өрсөлдөөнийг идэвхжүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Хөвөгч ханшийн системийг нэвтрүүлэх, хүүгийн түвшний таазыг цуцлах, банкуудад шинээр зөвшөөрөл олгох, мөн ашгийн татварыг бууруулах зэрэг санхүүгийн салбарт томоохон өөрчлөлтүүдийг хийж байсан бол аж ахуйн нэгжүүдийн хүрээнд монополийг байгууллагуудад бүтцийн өөрчлөлт хийх, харилцаа холбоо, төмөр зам, цахилгаан гэх мэт салбаруудад дэд бүтцийн шинэчлэлтүүдийг хийж байсан байна.

Түүнчлэн, реформ хийгдэж эхлэхээс өмнө тогтмол цалингийн систем буюу ажилласан цаг, бүтээмжээс үл хамааран бүх ажилчид ижил цалин авч, мөн цалингийн түвшин ажилласан цагаар бус нийт ажилчдын тоонд суурилан тогтоогддог байсан нь хөдөлмөрийн бүтээмжийг бууруулж байсан. Иймд хөдөлмөрийн зах зээл дэх реформыг эхлүүлж, илүү өрсөлдөөнийг дэмжсэн, хөдөлмөрийн нөөцийн үр ашигтай хуваарилалтыг хангасан зохицуулалтыг хэрэгжүүлж, мөн ажилтан ажил олгогчтой гэрээний нөхцөл, цалингийн хэмжээг харилцан тохиролцож болдог болов.

Санхүүгийн салбар дахь реформын хүрээнд тэтгэврийн санг байгуулснаар хөрөнгийн хуримтлал болон урт хугацаат хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх үндэс бий болж, мөн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг хөгжүүлснээр санхүүгийн зах зээлд өрсөлдөөн бий болж эхлэв. Үүнээс гадна санхүүгийн зохицуулалтын орчинд шинэчлэлт хийж, хоёр тулгуурт буюу “Twin Peaks” загварыг нэвтрүүлснээр зах зээлийн тогтвортой байдлыг хангах болон хөрөнгө оруулагч, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах эрх бүхий 2 тусдаа байгууллага үйл ажиллагаа явуулж санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжиж эхэлжээ.

Харин хөдөө аж ахуйн салбарт тус салбарыг дэмжих хүрээнд, байгаль хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох төрийн хөтөлбөрүүд хэрэгжиж эхэлсэн байна.

Австралийн уул уурхайн салбар нь бодлого зохицуулалтын таатай орчноороо дэлхийд тэргүүлдэг бөгөөд хайгуул, олборлолт, боловсруулалт зэрэг уул уурхайн үйл ажиллагааны бүх шатанд

уурхайчдын ашиг сонирхлыг хамгаалах хууль, эрх зүйн зохицуулалтыг системчлэн боловсруулсан байдгаараа маш онцлог.

Ийнхүү эдийн засгийн хөгжлийг дэмжигч томоохон салбаруудад реформыг хийсний үр дүнд Австралийн бүтээмж нэмэгдэн улсын эдийн засаг 1991 оноос хойш өнөөг хүртэл тасралтгүй 26 жил өсөлттэй байна.

АРВАН ХОЁР. ЭХ СУРВАЛЖ

- Asher, Allan. "Privatization of public enterprises and utilities and establishment of regulatory framework." International conference on competition policy and economic adjustment. Vol. 27, 1999.
- Asher, Allan. "Privatization of public enterprises and utilities and establishment of regulatory framework." International conference on competition policy and economic adjustment. Vol. 27, 1999.
- Australian Bureau of Statistics. Australian GDP classified by sectors. Retrieved from <http://www.abs.gov.au>
- Australian government. "Minerals And Petroleum In Australia". 2017
- Australian Rail Tram and Bus Industry Union. Australian Workplace Agreements. Retrieved from http://www.rtbu.com.au/_dbase_upl/52_2016-04-13_KDR.pdf
- Ballantyne, Alexander, et al. "Abstract for RDP 2014–10: Financial Reform in Australia and China." Reserve Bank of Australia Research Discussion Papers September. 2014.
- Bank of Australia, Reserve. "Privatisation in Australia." Reserve Bank of Australia Bulletin 79.2 (1997): 1–8.
- Banks, Gary. "Minimum effective regulation and the mining industry." Address to the Minerals Council of Australia's Annual Industry Seminar, Old Parliament House, Canberra. Vol. 2. 2003.
- Battellino, Ric. "Twenty years of economic growth." Structural Change in the Australian Economy 1 Durable Goods and the Business Cycle 11 Economic Change in India 19 Ownership of Australian Equities and Corporate Bonds 25 Interpreting Market Responses to Economic Data 35 (2010): 103.
- Chambers, R. "An Overview of the Australian Legal Framework for Mining Projects in Australia." 2015.
- Cockerell, Lynne, and Bill Russell. "Australian wage and price inflation: 1971–1994." Economic Research Department, Reserve Bank of Australia. 1995.
- Connolly, Ellis, and Christine Lewis. "Structural change in the Australian economy." RBA Bulletin, September (2010): 1–9.
- Connolly, Ellis, and David Orsmond. "Abstract for RDP 2011–08: The Mining Industry: From Bust to Boom." Reserve Bank of Australia Research Discussion Papers December. 2011.
- Davis, Kevin. "The Australian financial system in the 2000s: dodging the bullet." the Australian economy in the 2000s, Proceedings of a conference, Reserve Bank of Australia, Sydney. 2011.
- Department of Agriculture. Agricultural marketing regulatory reforms. Retrieved from <http://www.agriculture.gov.au>
- Department of Industry, Innovation and Science. "Resources". 2016.
- Gilmour, Brad, and Rajendra Kumar Gurung. Australia Agriculture Policy Review. No. 361–2016–18680. 2007.
- Gizycki, Marianne, and Philip Lowe. "The Australian financial system in the 1990s." The Australian Economy in the 1990s, Proceedings of a Conference, Reserve Bank of Australia, Sydney. 2000.
- Gizycki, Marianne, et al. "The Australian Economy in the 1990s." Economic Group, Reserve Bank of Australia. 2000.
- Gowland, David, and Max Aiken. "Privatisation In Australia In The 1990's: History And Social Conflicts Of Redistribution."

- Gray, Emily M., Max Oss–Emer, and Yu Sheng. "Australian agricultural productivity growth: past reforms and future opportunities." ABARES Research Report 14.02. 2014.
- Grenville, Stephen. "The evolution of monetary policy: from money targets to inflation targets□, in P Lowe (ed), Monetary policy and inflation targeting." Proceedings of a Conference, Reserve Bank of Australia, 1997.
- Gruen, David, and Amanda Sayegh. "The evolution of fiscal policy in Australia." *Oxford Review of Economic Policy* 21.4 (2005): 618–635.
- Hawke, Anne, and Mark Wooden. "Industrial relations reform in Australia: implications for the agricultural and mining sectors." *Australian Journal of Agricultural and Resource Economics* 42.3 (1998): 303–319.
- Henry, Ken. "Australia's Future Tax System–The Retirement Income System: Report on Strategic Issues." Commonwealth of Australia, Canberra. 2009.
- Kelly, Paul. *The Politics of Economic Change in Australia in the 1980s and 1990s*. Reserve Bank of Australia, 2000.
- King, S. "Why privatization? A review of the Australian experience." *Privatization: A Review of the Australian Experience*, CEDA. 2002.
- Macfarlane, I. "Monetary policy regimes: past and future." *Reserve Bank of Australia Bulletin* (1997): 20–31.
- Mah, Daniel CH. "A Legal Perspective on Privatization in Australia." Diss. Stanford University, 1999.
- Mark, Thoma. "The Australian Model." *Economist's view* (Online), 11 May 2006, https://economistsview.typepad.com/economistsview/2006/05/the_aus_australian_.html. Accessed 2018
- Marsden, John. "Reforming Public Enterprises: Case studies–Australia." Public Management Service, OECD. 1998.
- Murphy, Paul. *Australian Superannuation System Overview*. Vanguard Investments Australia, 2017.
- National Farmers Federation. "Food, Fibre & Forestry Facts." 2017.
- Nielson, Leslie, and Barbara Harris. "Chronology of superannuation and retirement income in Australia". Department of Parliamentary Services, 2010.
- OECD. "Privatisation in the 21st Century: Recent Experiences of OECD Countries." 2009.
- OECD. "Agricultural Policy Design and Implementation: A Synthesis, Organization for Economic Co-operation and Development (OECD)." 2008.
- Parkinson, Martin. "Reflections on Australia's era of economic reform." Address to the European Australian Business Council 5, 2014.
- Parliament of Australia. *Australian Labour Market Deregulation*. Retrieved from https://www.aph.gov.au/About_Parliament/Parliamentary_Departments/Parliamentary_Library/pubs/rp/rp9900/2000RP21
- Philip Maxwell, "Mineral Policy Lessons from Canada and Australia". 2002.
- Productivity Commission. "Potential Benefits of the National Reform Agenda." No. 0701. 2007.
- Quiggin, John. "Economic governance and microeconomic reform." *Economic governance and institutional dynamics* (2002): 158–177.
- Reserve Bank of Australia. *Net foreign debt and balance of payments*. Retrieved from <https://www.rba.gov.au>
- Reserve Bank of Australia. *The Australian Labour Market in the 1990s*. Retrieved from <https://www.rba.gov>

au/publications/confs/2000/dawkins.html

Russell, Bill, and Warren J. Tease. "Employment, output and real wages." Research Department, Reserve Bank of Australia, 1988.

Sims, Rod. "Australia's Experience Driving Economic Growth Through Competition Policy Reforms." World Bank Forum—Making Markets Work for Development: A Reform Agenda on Competition, 2013.

Stevens, Glenn. "The Australian economy: then and now." Reserve Bank Governor Address at University of Sydney, 2008.

The Australian council of Learned Academies. "Maintaining Australia's mining advantage." 2014.

"The Post-Socialist and Post-Capitalist Australian Economy". www.convictcreations.com/. Accessed 2018
Treasury, 'Statement 5: Revenue', Budget Paper no. 1: Budget strategy and outlook 2013–14. 2013, p. 42.

Warby, M. "From There to Back Again? Australian Inflation and Unemployment 1964 to 1993." Background Paper No. 9, 1994.

Wettenhall, Roger. "Privatization in Australia: How Much and What Impacts?" *Asian Review of Public Administration* 10.1–2 (1998): 144–158.

Wilkie, Joann, and Angelia Grant. "The importance of evidence for successful economic reform." *Economic Round-up* 1 (2009): 45.

World Bank. Global Financial Development Database. Australian financial system indicators (GDP ratios). Retrieved from <http://www.worldbank.org>





МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ ҮНЭЛЭХ ТҮҮВЭР СУДАЛГАА

2018 он

“Эн-Ар-Си-Си” ХХК

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь Монгол Улсын санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг үнэлэх зорилготой юм. Судалгааг Санхүүгийн зохицуулах хороо, “ЭН-АР-СИ-СИ” ХХК хамтран 2018 оны 6 дугаар сараас 8 дугаар сард хийж гүйцэтгэлээ.

Судалгааг энгийн санамсаргүй түүврийн аргаар хийсэн. Судалгаанд гар утастай иргэдийн жагсаалтаас 1600 насанд хүрэгчдийг санамсаргүй сонгон оролцуулсан бөгөөд оролцогчдоос асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Асуулга нь нийт 7 бүлэгтэй бөгөөд иргэдийн ерөнхий нийгэм эдийн засгийн шинж чанар, хуримтлал, санхүүгийн үйлчилгээ авч буй байдал, банкны данс, мобайл болон интернет банкны хэрэглээ, зээл болон даатгалын тухай асуултуудаас бүрдэнэ. Иргэдээс утсаар ярилцлага авах аргаар мэдээлэл цуглуулсан.

Тайлан дараах бүтэцтэй. Нэгдүгээрт бүлэгт Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн талаар, хоёрдугаарт бүлэгт санхүүгийн хүртээмж авахад учирч буй саад, гуравдугаарт бүлэгт банкны үйлчилгээний хэрэглээ ба орлогын эх үүсвэр, дөрөвдүгээр бүлэгт хэрэглэгчдийн хадгаламжийн хандлагын талаар, тавдугаар бүлэгт мобайл болон цахим банкны хэрэглээний байдал, зургаадугаар бүлэгт иргэдийн даатгалын үйлчилгээний хэрэглээний талаар, төгсгөлийн бүлэгт дүгнэлт бичигдсэн болно.

Судалгааны үр дүнд санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ Монгол Улс ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байсан ч бүс нутгаар бага зэрэг ялгаатай байна. Харин хүйс болон сууцны төрлөөр санхүүгийн хүртээмж ялгаагүй байсан бол хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж хөдөлмөр эрхэлдэг иргэдээс харьцангуй бага байна.

Түлхүүр үгс: санхүүгийн хүртээмж, санхүүгийн үйлчилгээ, цахим банк, хуримтлал

JEL ангилал: A20, E21, G5, G21, I22

НЭГ. УДИРТГАЛ

Энэхүү тайланд 2018 оны байдлаар Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг эрэлт талаас нь буюу түүврийн аргаар судалсан шинжилгээг нэгтгэн орууллаа. Шинжилгээг санамсаргүй байдлаар сонгосон 1600 иргэдээс нийт 7 бүлэг бүхий асуулга судалгааг авч хийлээ. Асуулга нь иргэдийн ерөнхий нийгэм эдийн засгийн шинж чанар, хуримтлал, санхүүгийн үйлчилгээ авч буй байдал, банкны данс, мобайл болон интернет банкны хэрэглээ, зээл болон даатгалын тухай асуулуудаас бүрдэнэ.

Санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ МУ ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, банканд данстай иргэдийн эзлэх хувь гэдэг үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна. МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Тухайлбал, иргэдийн 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг бөгөөд 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг. Судалгаанд оролцогсдын 5.2 хувь нь санхүүгийн секторын гадна буюу үйлчилгээ хүртэхгүй байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж бүсээр бага зэрэг ялгаатай байна. Хангай болон төвийн бүсэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж бусад орон нутгаас харьцангуй бага байна. Хүйс болон сууцны төрлөөр санхүүгийн хүртээмж ялгаагүй байна. Харин хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж хөдөлмөр эрхэлдэг иргэдээс харьцангуй бага байна.

Банкны үйлчилгээний хамрах хүрээ маш сайн байгаа хэдий ч банкны үйлчилгээ авдаг давтамж болон данс ашиглалтаар иргэд ялгаатай байна. Ялангуяа, байршил болон сууцны төрлөөс хамааран ялгаа их байна. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь өдөр бүр болон долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.5 пунктээр бага байна. Энэ хувь хотын иргэдийн хувьд 46.2% байхад хөдөөгийн иргэдийн хувьд 39.2%.

Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1350 төгрөг 16 минут зарцуулдаг байна. Энэхүү зардал болон хугацаа нь бүсээр ялгаатай. Тухайлбал, Хангайн бүсийн иргэд банкны салбарт очихдоо хамгийн их зардал болон хугацааг зарцуулж буй нь улсын дунджаас 723 төгрөг, 3 минутаар илүү байна.

Бүс нутгаас гадна, банкны салбар орох болон АТМ орох нь сууцны төрлөөс хамааран нэлээд ялгаатай байна. Орон сууцанд амьдардаг иргэд банкны салбар орохдоо 770 төгрөг зарцуулж буй нь гэр хорооллын иргэдтэй харьцуулахад 2.3 дахин бага, 12.4 минут зарцуулж буй нь гэр хорооллын иргэдийнхээс 1.6 дахин бага байна. АТМ орох зардал, хугацааны хувьд ялгаа бүр их.

Иргэдийн банкны үйлчилгээнд хамрагддаг байдал нь тийм ч их ялгаатай биш байхад энэ байдал мобайл болон интернет банкны хувьд арай өөр байгаа юм. Мобайл болон интернет банкны үйлчилгээ банкны дараа хамгийн өргөн авдаг үйлчилгээнүүд боловч банкны үйлчилгээнээс ялгаатай нь байршил, сууцны төрөл, хүйс, орлого болон ажил эрхлэлтийн байдлаас хамааран эрс ялгаатай байна. Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Энэ дүр зураг бүсээр нэлээд ялгаатай.

Сүүлийн 12 сарын хугацаанд нийт хэрэглэгчдийн 30.3 хувь хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд дийлэнх (94.8 хувь) нь банканд хадгалдаг гэжээ. Харин нийт хэрэглэгчдийн 35.4 хувь сүүлийн 6 сард зээл авсан бөгөөд нийт иргэдийн 23.1 хувь нь арилжааны банкнаас, 7.9 хувь нь ломбардаас, 6.5 хувь

нь ББСБ–аас, 4.9 хувь нь хувь хүнээс зээл авчээ. Хуримтлалдаа мөнгө хийсэн болон зээл авсан эсэх нь хэрэглэгчийн бүлгээр болон бүс нутгаар харилцан адилгүй байна.

Хэрэглэгчдийн 70 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаггүй бөгөөд тэдний 40 хувь нь даатгалын талаар мэдэхгүй учраас, 26 хувь нь хэрэгцээ, шаардлага байхгүй учраас даатгалд хамрагдаагүй гэж тус тус хариулжээ. Сайн дурын даатгалд хамрагдалт 18.9 хувьтай байгаа бол уг даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй иргэд 2 орчим хувь байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, сууцанд амьдардаг, зээл авсан, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг, хуримтлал хийдэг, ажил эрхэлдэг иргэдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдалт сайн байна. Даатгалын хэрэгцээ шаардлагын хувьд даатгалын төрлөөс хамааран иргэдийн таашаал өөр өөр байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН САНХҮҮГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖИЙН ХҮРЭЭ

Санхүүгийн хүртээмжийн хүрээг тодорхойлоходоо иргэд албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хэрхэн хамрагдаж байгааг харах нь чухал юм. Тухайлбал, иргэд хадгаламж, зээл, даатгал, төлбөр тооцоо хийх зэрэг өдөр тутмын санхүүгийн хэрэгцээндээ албан ёсны санхүүгийн үйлчилгээ хэр зэрэг ашиглаж байгаагаас санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг харах боломжтой. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн хүрээг арилжааны банк, бусад албан сектор, албан бус сектор болон гадна орхигдсон гэж ангилж үзье. Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг банканд идэвхтэй данстай эсэх болон санхүүгийн байгууллагын үйлчилгээ авдаг эсэхээр хэмжинэ.

Санхүүгийн хүртээмжийн хүрээ	
Банк	Оролцогч банканд ямар нэгэн данстай
Бусад албан сектор	Оролцогч ББСБ, ХЗХ, даатгал, хөрөнгө оруулалт, мобайл мөнгө зэрэг үйлчилгээнд хамрагддаг
Албан бус сектор	Оролцогч ломбард, хувь хүн зэрэг зохицуулалтгүй санхүүгийн хэрэгсэл ашигладаг
Эдгээрийн гадна	Дээрх санхүүгийн үйлчилгээний алийг ч хэрэглэдэггүй

Иргэдийн 95.6 хувь нь банканд өөрийн нэр дээр ядаж нэг данстай бөгөөд 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг байна. Санхүүгийн байгууллагуудаар үйлчлүүлдэг эсэхийг асуухад иргэдийн 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг гэж хариулсан. Эндээс үзвэл МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Харин 5.2 хувь нь санхүүгийн албан болон албан бус үйлчилгээ ашигладаггүй буюу санхүүгийн үйлчилгээний хүрээний гадна байна. Зураг 1-ээс үзэхэд, 0.3 хувь нь албан бус секторт хамрагдаж байна. Хотын иргэдийн 93.4 хувь, хөдөөгийн иргэдийн 90.0 хувь нь идэвхтэй данстай байна.


Зураг 8. 1. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж



Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг харьцуулах нь

Монгол Улс санхүүгийн хүртээмжийг бусад улсуудтай харьцуулж үзье. Зураг 2 нь ОУВС-гийн “Санхүүгийн хүртээмжийн судалгаа”-ны 1000 хүнд ногдох арилжааны банкны дансны тоог харуулж байна. Азийн улсуудтай харьцуулж үзвэл өндөр хөгжилтэй Япон, БНСУ-аас эрс бага, Энэтхэгтэй ойролцоо, харин Вьетнам, БНХАУ-аас эрс өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 8.2. 1000 хүнд ногдох арилжааны банкны данс




Эх сурвалж: Financial Access Survey Data, IMF

Санхүүгийн хүртээмжийг нийлүүлэлт талаас нь харуулдаг бас нэг үзүүлэлт бол 100,000 хүнд ногдох АТМ-ийн тоо юм. ОУВС-гийн судалгаагаар, 2016 оны байдлаар МУ-ын 100,000 иргэнд 88.6 АТМ ногдож байна. Энэ нь хөгжиж буй орны хувьд өндөр үзүүлэлт болно. Тухайлбал, энэ үзүүлэлтээр БНХАУ 81.4, Энэтхэг 21.4, Турк 78.1, Унгар 59.4 байна.

Дэлхийн банкны “Global Findex Data” сангийн санхүүгийн хүртээмжийн талаарх тоон өгөгдлийг Зураг 3 харуулж байна. Монгол Улсын иргэдийн 93 хувь нь данстай байгаа нь өндөр орлоготой орнуудтай харьцуулагдахуйц түвшинд байна. Түүнчлэн санхүүгийн байгууллагуудаас зээл авсан хувь өндөр байна. Харин санхүүгийн байгууллагад хадгаламжтай иргэдийн эзлэх хувь дэлхийн дунджаас бага байна.

Зураг 8.3. Санхүүгийн хүртээмжийн үзүүлэлтүүд, 2017




Эх сурвалж: Global Findex Data, World Bank

Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн ялгаа


Санхүүгийн үйлчилгээнд хамрагддаггүй иргэдийн эзлэх хувь бүсээр харилцан адилгүй байна. Тухайлбал, Хангайн бүсийн иргэдийн 8.3 хувь, төвийн бүсийн иргэдийн 6.8 хувь нь нь санхүүгийн үйлчилгээнд тус тус хамрагддаггүй байна. Харин зүүн бүсийн иргэдийн 3.5 хувь нь санхүүгийн үйлчилгээнд хамрагдахгүй байгаа нь хамгийн бага үзүүлэлт юм. Хүн амын талаас илүү нь амьдардаг УБ хотын хувьд санхүүгийн үйлчилгээний хүртээмж 95.4 хувь буюу улсын дунджаас өндөр байна.

Зураг 8. 4. Санхүүгийн хүртээмж, бүсээр




Орлогын бүлгээр харвал аль ч бүлгийн хувьд 90 гаруй хувь нь санхүүгийн албан секторт хамрагдсан байна. Гэхдээ санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр ялгаатай байна. Хамгийн бага орлоготой бүлгийн 92.6 хувь нь санхүүгийн албан секторын үйлчилгээ авдаг байхад хамгийн өндөр орлоготой бүлгийн 97.8 хувь нь албан сектороор үйлчлүүлдэг байна. Түүнчлэн, хамгийн бага орлоготой бүлгийн 87 хувь, хамгийн өндөр орлоготой бүлгийн 97 хувь нь тус тус банканд идэвхтэй данстай байна.

Зураг 8. 5. Санхүүгийн хүртээмж орлогын бүлгээр




Санхүүгийн хүртээмжийг хөдөлмөр эрхлэлттэй нь холбож авч үзье. Хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн 8.2 хувь, хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 3.7 хувь нь тус тус санхүүгийн албан секторын гадна байна. Харин хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн статусаасаа үл хамааран 96 хувь нь санхүүгийн албан сектороор үйлчлүүлж байна.

Зураг 8. 6. Санхүүгийн хүртээмж, ажил эрхлэлтээр (%)



Монголын нэг онцлог нь сууцны төрлөөр ялгаа ихтэй байдаг. Харин санхүүгийн хүртээмжийг сууцны төрлөөр ялгаагүй байна. Тухайлбал, гэр хороолол болон орон сууцанд амьдардаг иргэдийн 94 хувь нь санхүүгийн албан секторт хамрагдаж байхад 5.2 хувь нь санхүүгийн үйлчилгээнээс хүртэж чадахгүй орхигддог байна.


Зураг 8. 7. Санхүүгийн хүртээмж, сууцны төрлөөр



Санхүүгийн хүртээмж ба оролцогчдын шинж чанар


МУ-ын санхүүгийн хүртээмжийн байдалд хүйсээр ялгаа байхгүй байна. Эмэгтэйчүүдийн 92.1 хувь, эрэгтэйчүүдийн 91.5 хувь нь идэвхтэй данстай байна. Санхүүгийн албан сектороор эрэгтэй, эмэгтэй иргэдийн 94 хувь нь үйлчлүүлдэг бол 5 хувь нь санхүүгийн үйлчилгээнд хамрагддаггүй байна.

Зураг 8. 8. МУ-ын санхүүгийн хүртээмж, хүйсээр




Санхүүгийн хүртээмжид хүйсийн ялгаа байхгүй хэдий ч, хөдөлмөр эрхлэлт, орлого зэрэг үзүүлэлтүүд нь хүйсээр ялгаатай байна. Зураг 9 нь орлогын эх үүсвэрийг хүйсээр харуулж байна. Эрэгтэй хүмүүсийн 49.6 хувийн өнгөрсөн сарын орлого нь цалингийн орлого байсан бол эмэгтэй хүмүүсийн 43.2 хувийнх нь цалингийн орлого байсан. Харин эрэгтэйчүүдийн 15.2 хувь нь тэтгэвэр, тэтгэмжээс орлого олсон бол эмэгтэйчүүдийн 34.5 хувь нь тэтгэвэр тэтгэмжээс орлого олсон байна.

Зураг 8. 9. Орлогын эх үүсвэр, хүйсээр (%)



Амьжиргааны баталгаажих доод түвшнээс бага орлоготой иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж орлого өндөртэй иргэдээс бага байна. Тухайлбал, орлого багатай иргэдийн 7.3 хувь нь санхүүгийн албан болон албан бус үйлчилгээнд хамрагддаггүй байна.


Зураг 8. 10. Санхүүгийн хүртээмж, орлогоор



Насанд хүрэгсдийн санхүүгийн үйлчилгээнд хамрагдах магадлалд ямар хүчин зүйлс нөлөөлж буй талаар ойлголттой болох үүднээс логит загвар үнэлсэн.¹ Үнэлгээний үр дүнгээс харахад нас, орлого, боловсрол, шилжүүлэг болон ажил эрхлэлт банканд идэвхтэй данстай байх магадлалтай статистикийн хувьд найдвартай Корреляц хамааралтай байна. Зураг 11 нь хамаарлыг харуулж байна. Тэгийн баруун талд байрлаж байгаа хүчин зүйлс эерэг хамаарлыг, тэгийн зүүн талд байрлаж байгаа хүчин зүйлс сөрөг хамаарлыг харуулна.

1 Үнэлгээний үр дүнг Хавсралт А1-гийн 1-р баганаас харна уу.

Зураг 8. 11. Логистик загварын үнэлгээний үр дүн




Хүйс, гэрлэлтийн байдал, байршил зэрэг үзүүлэлтүүд насанд хүрэгсдийн банканд данстай байх магадлалд нөлөөгүй байна. Дээрх үр дүнгээс харахад хөдөлмөр эрхэлдэг хүн данс эзэмшдэг байх магадлал 3.5 хувь, шилжих төлбөр буюу тэтгэмж авдаг бол магадлал нь 3.9 хувиар өндөр байна. Түүнчлэн, 1 хувиар өндөр орлоготой бол данс эзэмших магадлал 2.1 хувиар өндөр байна.

Бид банкны үйлчилгээ авах давтамжийг дээрх хүчин зүйлсээс хамааруулан регрессийн үнэлгээ хийсэн. Үнэлгээний үр дүнг Хавсралт А1-ийн 4-р баганад үзүүлж байна. Нас, өрхийн тэргүүн, гэрлэлтийн байдал болон зүүн бүс гэсэн үзүүлэлтүүд давтамжтай хамааралтай бөгөөд өрхийн тэргүүнээс бусад хүчин зүйлс давтамжтай сөрөг хамааралтай байна. Тухайлбал, зүүн бүсэд амьдардаг хүмүүс банкны үйлчилгээг хангайн бүсийнхнээс арай цөөхөн авдаг байна.

ГУРАВ. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖ АВАХАД УЧИРЧ БҮЙ СААД


Дэлхийн банкны “Global Findex Database 2017” тайланд тооцооноор дэлхийн хэмжээнд нийт насанд хүрсэн иргэдийн 31 хувь нь банканд дансгүй байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт эрс бага буюу нийт иргэдийн 4.5 хувь нь банканд дансгүй байна. Эдгээр дансгүй иргэдийг нийгэм, эдийн засгийн шинж чанараар нь харвал хүйс, нас, сууцны төрөл, оршин суугаа газар, ажил эрхлэлтийн байдлаасаа хамааран ялгаатай байна. Дэлхийн жишигтэй харьцуулахад мөн ялгаатай зүйлс байна. Тухайлбал, дансгүй иргэдийн дийлэнх нь эмэгтэйчүүд, орлого багатай, эдийн засгийн идэвхгүй байгаа нь дэлхийн нийтэд түгээмэл байдаг нь манай улсын хувьд ч мөн адил байна. Харин дэлхийн бусад улсуудын хувьд насаар залуу, боловсрол багатай иргэд банканд дансгүй байх нь элбэг байдаг бол манай улсын хувьд эсрэг дүр зураг ажиглагдлаа.

Зураг 8. 12. Банканд дансгүй иргэд, хүйс болон орлогын бүлгээр



2017 оны байдлаар дансгүй байгаа иргэдийн 51 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь дэлхийн түвшнээс 5 пунктээр бага байна. Эдгээр хүмүүсийн 67 хувь нь орлогын хамгийн доод 2 бүлгийн иргэд байна². Зураг 13–д харуулснаар дансгүй иргэдийн бараг 22.8 хувь нь 17–24 настай байхад дийлэнх нь 24–өөс дээш настай байна.

Зураг 8. 13. Банканд дансгүй иргэд, нас болон эдийн засгийн идэвхээр (АХО)



2 Орлогоор хамгийн доод бүлэгт хамрагдсан иргэдийн өөрсдийнх нь мэдээлсэн сарын орлого нь 300 мянган төгрөгөөс бага.

Зураг 14–өөс ажиглахад, данс эзэмшихгүй шалтгааныг харахад дундын данстай байх нь зардал хэмнэдэг гэсэн шалтгааныг 20 шахам хувь нь сонгожээ. Орлого хангалттай биш шалтгаанаар данс эзэмшихгүй байгаа иргэдийн хувь 11.3 байна. Дэлхийн хэмжээнд банканд дансгүй иргэдийн 60 гаруй хувь нь орлого бага шалтгаан гэсэн шалтгаан дурдсан ажээ. Мөн түүнчлэн, шаардлагатай бичиг баримт байхгүй шалтгаанаар данс эзэмшихгүй байгаа хүмүүсийн хувь дэлхийн хэмжээтэй харьцуулахад эрс бага. Энэ нь дэлхийн хэмжээнд 2017 оны байдлаар 20 шахам хувь байхад манай улсын хувьд ердөө 1.4 хувь байна.


Зураг 8. 14. Данс эзэмшихгүй байгаа шалтгаан



Банк болон АТМ үйлчилгээний зардал, хугацаа

Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1,350 төгрөг 16 минут зарцуулдаг байна. Энэхүү зардал болон хугацаа нь бүсээр ялгаатай (Зураг 15). Тухайлбал, Хангайн бүсийн иргэд банкны салбарт очихдоо хамгийн их зардал (2,073 төгрөг) болон хугацааг (19 минут) зарцуулж буй нь улсын дунджаас 723 төгрөг, 3 минутаар илүү байна. Харин Улаанбаатар хотын иргэд хамгийн бага зардал (964 төгрөг) болон хугацааг (15 минут) банкны салбарт очиход зарцуулдаг бөгөөд энэ нь улсын дунджаас 386 төгрөг, 1 минутаар бага байна. Харин Хангайн бүсийн иргэдтэй харьцуулахад Улаанбаатар хотын иргэд банкны салбарт очихдоо 1,110 төгрөг, 4 минутаар бага цаг хугацааг зарцуулдаг.

Зураг 8. 15. Банкны салбарт очиход зарцуулдаг зардал болон хугацаа, бүсээр




АТМ үйлчилгээний хувьд банкны салбартай харьцуулахад харьцангуй бага зардал, хугацаа зарцуулж байгаа хэдий ч энэ нь хот, хөдөөгөөр эрс ялгаатай байна. Хөдөө амьдардаг иргэдийн хувьд (Төвийн бүсээс бусад газрын) бэлэн мөнгө авах гэж АТМ явах нь банкны салбар явахаас зардал өндөртэй, харин Улаанбаатар хотын иргэдийн хувьд АТМ явах нь банкны салбар явахаас зардлын хувьд бараг дөрөв дахин бага мөнгө, хугацааны хувьд 1.5 дахин бага минут зарцуулж байна.

Хүснэгт 8. 1. Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, хот хөдөөгөөр

	Дундаж зардал (төгрөгөөр)	Дундаж хугацаа (минутаар)
Хотод банкны салбар орох	964	15
Хотод АТМ орох	250	10
Хөдөө банкны салбар орох	1714	18
Хөдөө АТМ орох	1633	20


Зураг 15–ыг зураг 16–тай харьцуулахад АТМ явах зардал болон хугацаа нь банкны салбар явах зардал, хугацаатай харьцуулахад Баруун бүсийн хувьд 52 төгрөгөөр их, 0.1 минутаар бага, Хангайн бүсийн хувьд бараг 400 төгрөгөөр их, 9.1 минутаар их, Төвийн бүсийн хувьд 690 гаруй төгрөгөөр бага, 3.7 минутаар бага, Зүүн бүсийн хувьд 41 төгрөгөөр их, минутын хувьд ижил байна. Хангайн бүсийн иргэдийн хувьд банкны салбар орох болон АТМ орох нь аль аль бусад бүс нутгаас өндөр байна.

Зураг 8. 16. АТМ очиход зарцуулдаг зардал болон хугацаа, бүсээр



Бүс нутгаас гадна, банкны салбар орох болон АТМ орох нь сууцны төрлөөс хамааран нэлээд ялгаатай байна. Улсын хэмжээнд гэр хорооллын иргэд орон сууцанд амьдардаг иргэдтэй харьцуулахад банкны салбар болон АТМ орохдоо нэлээд өндөр зардал гаргадаг байна. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэд банкны салбар орохдоо 770 төгрөг зарцуулж буй нь гэр хорооллын иргэдтэй харьцуулахад 2.3 дахин бага, 12.4 минут зарцуулж буй нь гэр хорооллын иргэдийнхээс 1.6 дахин бага байна. АТМ орох зардал, хугацааны хувьд ялгаа бүр их.

Зураг 8. 17. Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, сууцны төрлөөр



Улсын хэмжээнд банк болон АТМ орох зардал болон хугацаа хүйсээс хамааран бага зэрэг ялгаатай байна. Эмэгтэйчүүд банкны салбар болон АТМ орохдоо эрэгтэйчүүдтэй харьцуулахад их мөнгө, цаг хугацаа зарцуулдаг байна. Гэхдээ энэ ялгаа нь банкны салбар ороход зарцуулдаг минутаас бусад хувьсагчийн хувьд статистикийн хувьд 10 хувийн түвшинд ач холбогдол бүхий ялгаа биш юм.


Хүснэгт 8. 2. Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа, хүйсээр

	Зардал (төгрөгөөр)	Хугацаа (минутаар)
Эрэгтэй хүмүүс банкны салбар орох	1487	15
Эмэгтэй хүмүүс банкны салбар орох	1255	17
Эрэгтэй хүмүүс банкны салбар орох	890	15
Эмэгтэй хүмүүс АТМ орох	1006	20

ДӨРӨВ. БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭ БА ОРЛОГЫН ЭХ ҮҮСВЭР


Өмнөх бүлгүүдээс үзэхэд санхүүгийн үйлчилгээний хүртээмжид орлогын эх үүсвэр нөлөөтэй байсан. Иймд энэ бүлэгт эдгээрийн хамаарлыг авч үзье. Хадгаламж болон банкны үйлчилгээ авдаг давтамжийг Зураг 18 харуулж байна. Хадгаламж хийдэг иргэдийн 68.8 хувь нь сард нэгээс доошгүй удаа хадгаламж хийдэг. Харин банканд данстай иргэдийн 43 хувь нь долоо хоногт ядаж нэг удаа банкаар үйлчлүүлдэг.

Зураг 8. 18. Хадгаламж хийх болон банкны үйлчилгээ авдаг давтамж




Орлогын эх үүсвэр хадгаламж хийдэг давтамжтай хамааралтай байна. Тухайлбал, цалингийн орлоготой хуримтлалтай хүмүүсийн 72.3 хувь нь сард ядаж нэг удаа хуримтлал хийдэг бол тэтгэвэр, тэтгэмж авдаг хуримтлалтай хүмүүсийн 50 гаруй хувь нь хуримтлал хийдэг байна.

Зураг 8. 19. Хадгаламж хийх давтамж орлогын эх үүсвэрээр



Банкны үйлчилгээ авдаг давтамжийг мөн орлогын эх үүсвэрээр нь харья. Цалингийн орлоготой хүмүүсийн 91.2 хувь нь сард нэгээс олон удаа банкны үйлчилгээ авч байхад, тэтгэмж болон тэтгэвэр авдаг хүмүүсийн 72–76 хувь нь сард нэгээс олон үйлчилгээ авдаг байна.


Зураг 8. 20. Банкны үйлчилгээ авах давтамж орлогын эх үүсвэрээр



Эндээс үзэхэд цалингийн орлоготой хүмүүсийн банкаар үйлчлүүлэх болон хадгаламж хийх давтамж тэтгэвэр, тэтгэмж авдаг хүмүүсийнхээс илүү өндөр байна.


Орлогын эх үүсвэр нь сууцны төрлөөс хамааран ялгаатай байна. Гэр эсвэл хашаа байшинтай иргэдийн 29.3 хувь нь тэтгэвэр тэтгэмж авч байхад орон сууцанд амьдардаг иргэдийн 20.8 хувь нь тэтгэвэр тэтгэмж авч байна. Түүнчлэн орон сууцанд амьдардаг иргэдийн 53.2 хувь нь байнгын ажлын цалинтай байхад гэр, хашаа байшинд амьдардаг иргэдийн 39.7 хувь нь байнгын ажлын цалинтай байна.

Зураг 8. 21. Орлогын эх үүсвэр ба сууцны нөхцөл



Нийт иргэдийн 90 гаруй хувь нь банкаар үйлчлүүлдэг бөгөөд энэ нь хаана амьдардаг, орлогын түвшин зэргээс хамааран тийм ч их ялгаатай биш хэдий ч банкны үйлчилгээ авдаг давтамж нь байршил, сууцны төрөл зэргээс хамааран өөр өөр байна. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь өдөр бүр болон долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.8 пунктээр бага байна. Энд нэг зүйлийг анхаарах хэрэгтэй нь иргэдийн ажил эрхлэлтийн байдлаас болж энэ хувь өөр өөр байж болно. Хөдөлмөр эрхэлдэг иргэд ажлын шаардлагаас болон банкаар их үйлчлүүлдэг байхад ажилгүй иргэд банкаар үйлчлүүлэх шаардлага бага гардгаас болж тэр бүр банк ордоггүй байж болно. Зураг 22-т хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 50.3 хувь нь банкаар өдөр бүр/долоо хоног тутам үйлчлүүлдэг байхад энэ нь ажилгүй иргэдийн хувьд 31.1 хувь байгааг харж болно. Тиймээс бид банкаар үйлчлүүлдэг давтамжийг зөвхөн хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд бас шинжилж үзэх нь зүйтэй.

Зураг 8. 22. Банкаар өдөр бүр/долоо хоногт 1–2 удаа үйлчлүүлдэг иргэдийн хувь



Банкны үйлчилгээ авдаг давтамжийг зөвхөн хөдөлмөр эрхэлдэг иргэдийн дунд бүлгээр нь ялган харахад хот, хөдөө болон сууцны төрлөөс хамаарсан ялгаа байсаар байгааг бид Зураг 23–аас харж болно. Мөн түүнчлэн, энэ давтамж нийт иргэдийн хувьд хүйсээр тийм ч их ялгаатай биш байсан бол одоо хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн хувьд ялгаа үүссэн байна. Тухайлбал, ажил эрхэлдэг эрэгтэйчүүд хөдөлмөр эрхэлдэг эмэгтэйчүүдийг бодвол банкны үйлчилгээ авдаг давтамж нь 6.9 пунктээр бага байна. Гэр хороолол болон орон сууцанд амьдардаг ажил эрхэлдэг иргэдийн хувьд үйлчилгээ авдаг давтамжийн ялгаа байсаар байна. Орон сууцанд амьдардаг иргэдийн 59.6 хувь нь хамгийн багадаа долоо хоног тутам банкаар үйлчлүүлдэг байхад хөдөлмөр эрхэлдэг иргэдийн бараг 60 хувь нь ижил байдалтай байна. Гэтэл гэр хорооллын хувьд нийт иргэдийнх 42.1 хувь нь ийм байсан бол хөдөлмөр эрхэлдэг иргэдийнх нь 42.1 хувь нь банкаар хамгийн холдоо долоо хоногтоо 1–2 удаа банкаар үйлчлүүлдэг. Тиймээс иргэд ажил эрхэлдэг үгүйгээс үл хамааран банкны үйлчилгээ авдаг давтамж нь сууцны төрлөөс хамааран ялгаатай байна. Өөрөөр хэлбэл гэр хорооллын иргэд орон сууцны иргэдийг бодвол банкнаас авдаг үйлчилгээ нь арай бага давтамжтай байна.

Мөн түүнчлэн, иргэд хаана амьдарч байгаагаас хамааран банкны үйлчилгээ авдаг давтамж ялгаатай байгаа нь хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд мөн байсаар байна. Цаашлаад хот болон хөдөөгийн ялгаа нэмэгдсэн байгааг зураг 23–аас харж болно. Банкаар багадаа долоо хоногт 1–2 удаа үйлчлүүлдэг хотын иргэдийн хувь хөдөөтэй харьцуулахад 7 пунктээр илүү байсан бол энэ нь хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд 7.7 пунктээр илүү байна.


Зураг 8. 23. Банкаар өдөр бүр/долоо хоног тутам үйлчлүүлдэг хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувь



Банкны данс ашиглалт

2017 оны байдлаар данс идэвхтэй ашиглаж буй нийт иргэдийн 86 хувь нь харилцах, 31 хувь нь хадгаламжийн, 12 хувь нь хугацаатай хадгаламжийн, 6 хувь нь зээлийн, 13 хувь нь дебит карт, 2 хувь нь гадаад валютын данстай, 2 хувь нь кредит карттай байна.

Зураг 8. 24. Дансны төрөл, хот хөдөө болон хүйсээр




Идэвхтэй эзэмшиж буй данснуудын төрлийг байршлаар нь харвал хотын иргэдийн 87 хувь хөдөө амьдардаг иргэдийн 85 хувь нь харилцах данс эзэмшиж байна. Эмэгтэйчүүд эрэгтэй хүмүүстэй харьцуулахад 7 пунктээр илүү харилцах данстай гэх мэтээр бага зэргийн ялгаа бүлгээс хамааран байна. Гэхдээ дансны төрлийн ялгаа тийм ч их биш байна. Харин кредит карт эзэмшдэг иргэд хөдөөд хоттой харьцуулахад бага байна.

Иргэдийн хувьд банканд данс нээлгэсэн шалтгаанууд дотроос хамгийн зонхилж буй нь цалин хөлсөө авах (44 хувь), үүний дараа мөнгөө найдвартай газар байлгах (35%), гуравдугаарт төлбөр хүлээн авах болон халамж тэтгэмжийн мөнгө авах (тус тус 24 хувь гэсэн шалтгаанууд оржээ. Гэвч энэ шалтгаан иргэдийн хаана оршин суудаг болон хүйсээс мөн хамааран өөр өөр байна. Жишээ нь эмэгтэйчүүдийн 33 хувь нь халамж тэтгэмжийн мөнгө авах зорилгоор данс нээлгэсэн гэсэн байхад эрэгтэйчүүдийн ердөө 10 хувь нь энэ шалтгаанаар дансаа нээлгэжээ. Энэ нь эмэгтэйчүүд хүүхдийн мөнгө, жирэмсний тэтгэмж гэх мэт олон төрлийн тэтгэмж авах эрхтэй байдагтай холбоотой байж болох юм. Өөр нэг сонирхолтой ялгаа нь хөдөө амьдардаг иргэдийн 31 хувь нь цалин авахын тулд данс нээлгэсэн байхад хотын иргэдийн бараг 60 шахам хувь нь цалингаа авахын тулд данс нээлгэсэн байна.


Нийт данстай иргэдийн 30 хувь нь данс хэзээ нээлгэсэнээ санахгүй, 32 хувь нь 2010 оноос өмнө нээлгэсэн, харин 36 хувь нь дансаа 2010–2018 оны хооронд нээлгэжээ. Хамгийн их данс нээлгэсэн он 2008 байна.

Зураг 8. 25. Данс нээлгэсэн шалтгаан, хот хөдөө, хүйсээр



Идэвхтэй данс ашиглаж буй иргэдийн 34.3 хувь нь нэг данстай байна. Мөн түүнчлэн, 36.7 хувь нь 2 данс, 16.7 хувь нь 3 харин үлдсэн нь 4 ба түүнээс дээш тооны данс эзэмшдэг аж. Хотод амьдардаг, хөдөлмөр эрхэлдэг, эдийн засгийн идэвхтэй, эмэгтэй, 25 ба түүнээс дээш настай, дээд боловсролтой иргэдийн хувьд 2 ба түүнээс дээш тооны данс эзэмшдэг байна. Тухайлбал, хотын иргэдийн 70 хувь, ажил эрхэлдэг иргэдийн 76 хувь, эдийн засгийн идэвхтэй иргэдийн 74 хувь, эмэгтэйчүүдийн 68 хувь, 25 ба түүнээс настай иргэдийн 67 хувь, дээд боловсролтой иргэдийн 67 хувь нь хоёр ба түүнээс дээш тооны данс эзэмшиж байгаа нь эсрэг бүлгийнхнээсээ 4–26 пунктээр их байна.

Зураг 8. 26. Хоёр ба түүнээс дээш тооны данс эзэмшиж буй байдал, бүлгээр



Хөдөлмөр эрхлэлтийн статусаар нь ангилан харвал ажил олгогчдын 86 хувь болон хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдийн 78 хувь нь нэгээс олон данс эзэмшиж байна. Өрхийн үйлдвэрлэл үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч иргэд бүгд нэг данс эзэмшдэг байна.

Зураг 8. 27. Эзэмшиж буй дансны тоо, хөдөлмөр эрхлэлтийн статусаар




ТАВ. ХЭРЭГЛЭГЧИД ХАДГАЛАМЖ ХИЙХЭД БАНК ХАМГИЙН НАЙДВАРТАЙ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА.

Энэ хэсэгт бид хэрэглэгчдийн хуримтлал хийх төлөв байдлыг авч үзнэ. Тухайлбал, сүүлийн 12 сарын хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн эсэх, хийсэн бол санхүүгийн ямар байгууллагаар үйлчлүүлсэн, тухайн байгууллагыг сонгож үйлчлүүлсэн шалтгаан, мөн хадгаламж хийдэг давтамжийн талаар асууж тодруулсан болно.

Мөнгөө хадгалах хамгийн аюулгүй, найдвартай арга нь банканд хадгалах гэж ихэнх хэрэглэгчид (80.7 хувь) үзэж байна. Биет хөрөнгө болгох нь аюулгүй гэж нийт хэрэглэгчдийн 13.5 хувь хариулсан бол хадгаламж зээлийн хоршоонд байршуулах нь найдвартай гэж 2.2 хувь хариулжээ. Харин хэрэглэгчдийн 3.7 хувь нь албан бус санхүүгийн арга хэрэгслийг сонгосон байна.

Энэхүү хариулт нь хэрэглэгчдийн хөрөнгө эзэмшдэг эсэх, орон байрны нөхцөл зэргээс бараг хамааралгүй байна. Харин зарим бүлгийн хувьд, тухайлбал, эрэгтэй, дээд боловсролтой, хотод амьдардаг, 35–аас дээш настай, бага орлоготой иргэд биет хөрөнгө болгох нь хамгийн найдвартай гэсэн хариултыг эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад илүү их (2.1–3.6 пунктээр) өгчээ. Бусад сонголтуудын хувьд хэрэглэгчдийн бүлгээр хариултууд маш ойрхон буюу бараг ялгаагүй байна.

Зураг 8. 28. Мөнгөө хадгалах хамгийн найдвартай, эрсдэл багатай арга




Сүүлийн 12 сарын хугацаанд нийт хэрэглэгчдийн 30.3 хувь хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд дийлэнх (94.8 хувь) нь банканд хадгалдаг гэжээ. Дөнгөж 2.3 хувь нь хадгаламж зээлийн хоршоо, бичил санхүүгийн байгууллага болон нөхөрлөлд хуримтлалаа байршуулсан байна. Мөн 1.7 хувь нь албан бус санхүүгийн хэрэгсэл буюу гэртээ, найз нөхөд эсвэл гэр бүлийн гишүүддээ өгч хадгалуулжээ.

Өнгөрсөн 1 жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн эсэх нь хэрэглэгчдийн бүлгээр харилцан адилгүй байна. Тухайлбал, боловсрол өндөртэй, орон сууцанд амьдардаг, ажилладаг, 35–аас доош настай, хотод амьдардаг, өндөр орлоготой, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг³ хүмүүс хуримтлалдаа мөнгө хийсэн гэж хариулах нь илүү их байна. Харин хүйс, гэрлэсэн байдал болон газар эзэмшдэг эсэхээр ялгаа байхгүй байна.


3 “Та өрхийн оршин суугаа орон сууц /гэр/ хашаа байшинг эзэмшдэг/өмчилдөг үү” гэсэн асуултад “Тийм” гэж хариулсан иргэдийг үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг гэж тэмдэглэв.

Зураг 8. 29. Өнгөрсөн 12 сарын хугацаанд хуримтлал хийсэн хэрэглэгчид, бүлгээр



Иргэдийн сүүлийн 12 сарын хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн эсэх нь орлогын бүлгээр эрс ялгаатай байна. Тухайлбал, хамгийн бага орлоготой бүлгээс бусад бүлгийг харвал орлого өндөр болох тусам тухайн орлогын бүлгийн хадгаламж хийсэн иргэдийн эзлэх хувь нэмэгдэж байна. Харин хамгийн орлого багатай бүлгийн иргэдийн 22.3 хувь хадгаламждаа мөнгө хийсэн гэж хариулсан нь орлогын дараагийн хоёр бүлгээс нэлээд өндөр байна.


Зураг 8. 30. Хуримтлал хийсэн эсэх, орлогын бүлгээр



Хэрэглэгч хуримтлалдаа мөнгө хийх магадлалд нөлөөлж буй хүчин зүйлсийг логит загвараар үнэлж, шинжилсэн⁴. Ингэхэд орлого (логарифм) болон боловсролд зарцуулсан жил өсөх тусам тухайн хэрэглэгчийн хуримтлалдаа мөнгө хийх магадлал өсөж байгаа бөгөөд энэхүү хамаарал нь статистикийн хувьд найдвартай байна. Мөн баруун бүсэд амьдардаг хэрэглэгч бусад бүсүүдэд амьдардаг иргэдтэй харьцуулахад хадгаламж хийх магадлал өндөр байна. Харин хүйс, нас, шилжүүлэг авдаг эсэх, гэрлэсэн, болон ажил эрхэлдэг байх нь хадгаламж хийх магадлалд нөлөөгүй байна.

4 Үнэлгээний үр дүнг Хавсралт А-гийн хүснэгт 4-ийн 2-р баганаас харна уу.

Зураг 8. 31. Хуримтлал хийсэн эсэх, бүсээр



Хэрэглэгчдийн хуримтлал хийсэн эсэхийг бүс нутгаар харвал, Улаанбаатар болон Баруун бүсэд амьдардаг иргэдийн хамгийн их хуримтлал хийдэг бол Хангайн бүсийн иргэд хамгийн бага хадгалдаг байна.

Банканд хуримтлал хийсэн хэрэглэгчдийн гуравны нэг орчим (31.1 хувь) нь сард нэгээс бага буюу хааяа нэг, харин талаас илүү (56.9 хувь) нь сар тутам, үлдсэн (12 хувь) нь сард нэгээс олон удаа хуримтлалдаа мөнгө хийдэг байна. Харин хуримтлалдаа мөнгө хийсэн сүүлийн хугацааг асуухад, 76.7 хувь нь сүүлийн 30 хоногт, үлдсэн 23.3 хувь нь сүүлийн 3 сар болон түүнээс дээш хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн гэжээ.

Банканд хадгаламж хийх давтамжийг үнэлгээ⁵ хийх замаар шинжлэхэд гэрлэсэн байх нь давтамжийг нэмэгдүүлдэг бол өрхийн тэргүүн байх нь хуримтлалдаа мөнгө хийх давтамжийг бууруулж байна. Харин бусад үзүүлэлтүүд, тухайлбал боловсрол, орлого, хүйс, ажил эрхлэлт, бүс нутаг зэрэг үзүүлэлтүүд хуримтлал хийх давтамжид нөлөөгүй байна.

Зураг 8. 32. Хуримтлалдаа мөнгө хийсэн сүүлийн хугацаа



Банканд хадгаламж хийсэн шалтгаанд банк хамгийн найдвартай, аюулгүй учраас гэсэн хариулт давамгайлж (56.6 хувь) байгаа бөгөөд үүний дараа амар, хялбар (13.5 хувь), хамгийн сайн хүү төлдөг (11.7 хувь), үргэлж хэрэглэсээр ирсэн (9.6 хувь) гэсэн хариултууд орж байна. Амар, хялбар гэсэн хариулт өгөх нь дээд боловсролтой, орон сууцанд амьдардаг хэрэглэгчдийн дунд арай илүү байна.

5 Үнэлгээний үр дүнг Хавсралт А-гийн хүснэгт 4-ийн 3-р баганаас харна уу.

Хадгаламж зээлийн хоршоо, бичил санхүүгийн байгууллагад хуримтлал хийсэн хэрэглэгчид хамгийн сайн хүү төлдөг учраас эдгээр байгууллагыг сонгосон гэсэн хариултыг илүү олон өгчээ. Харин албан бус санхүүгийн арга хэрэгсэл сонгосон хэрэглэгчид хамгийн найдвартай, зардал бага, амар хялбар бөгөөд хадгаламждаа хамгийн хурдан хүрнэ гэсэн хариултуудыг дурдсан байна.

Зураг 8. 33. Хуримтлал хийсэн шалтгаан



Хэрэглэгчид гэнэтийн зарлага гарвал (30.8 хувь) эсвэл өдөр тутмын зарлагадаа (13.8 хувь) хэрэглэх гэж хадгалахаас гадна орон сууц, байшин, газар гэх мэт үл хөдлөх хөрөнгө авах зорилгоор (11.4 хувь) хуримтлал хийдэг гэжээ.


Үл хөдлөх хөрөнгө авах, өндөр настай үедээ хэрэглэх болон бизнесийн зорилгоор хадгаламж хийж байгаа хэрэглэгчдийг урт хугацааны зорилготой хуримтлал хийдэг гэж үзвэл эдгээр нь нийт хэрэглэгчдийн дөрөвний нэг орчмыг эзэлж байна.

Хотод амьдардаг иргэд байр, байшин, газар авах зорилгоор, харин хөдөө амьдардаг иргэд өдөр тутмын зарлагадаа хэрэглэх зорилгоор гэж хариулах нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад арай илүү байна. Бизнесийн зорилгоор хадгалах нь орлого багатай хэрэглэгчдийн дунд арай бага байна. Дээд боловсролтой хэрэглэгчид гэнэтийн зарлагадаа хэрэглэх зорилгоор, харин бага болон дунд боловсролтой хэрэглэгчид өдөр тутмын хэрэгцээндээ зориулж хадгалдаг гэсэн хариултыг эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад илүү их өгчээ.

Судалгааны үр дүнгээс харахад хэрэглэгчид хуримтлал хийхдээ урт хугацааны зорилготой гэхээсээ илүү тодорхой бус байдал, эрсдэлээс болгоомжлох болон өдөр тутмын хэрэглээгээ тогтвортой байлгах зорилгоор хадгалах нь давамгайлж байна.

Нийт хэрэглэгчдийн 35.4 хувь сүүлийн 6 сард зээл авсан бөгөөд энэ нь сүүлийн нэг жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн хэрэглэгчидтэй харьцуулахад 5 пунктээр их байна. Нийт иргэдийн 23.1 хувь нь арилжааны банкнаас, 7.9 хувь нь ломбардаас, 6.5 хувь нь ББСБ-аас, 4.9 хувь нь хувь хүнээс зээл байдалтай байгааг Зураг 34-өөс харж байна.


Зураг 8. 34. Иргэдийн зээл авсан байдал



Зээл авсан иргэдийг зээл олгосон байгууллагаар нь харвал арилжааны банк 65.4%, ломбард 22.3%, хувь хүн 13.8%, ББСБ 18.3% эзэлж байна. Иргэдийн 36.1% албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авчээ. Зээл авсан иргэдийн 81.7 хувь нь нэг санхүүгийн байгууллагаас зээл авсан бол үлдсэн 18.3 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд хоёр болон түүнээс дээш байгууллагаас зээл авсан байна.


Иргэдийн авсан нийт зээлийн тоонд арилжааны банк 53%, ББСБ 15%, ломбард 18%, хувь хүн 11% эзэлж байна. Энэ нь 2018 оны 2 улирлын “Санхүүгийн зах зээлийн талаарх хэрэглэгчийн хүлээлт” судалгааны үр дүнтэй адилхан байна.

Зураг 8. 35. Иргэдийн авсан зээлийн бүтэц, олгосон байгууллагаар




Зураг 36 нь зээл олгосон байгууллагуудыг хот, хөдөөгөөр харуулж байна. Хотын иргэдийн 30 хувь, хөдөөгийн иргэдийн 28 хувь нь албан бус эх үүсвэрээс зээл авч байна. Үүнд, хотын иргэд ломбардаас илүү зээлдэг бол хөдөөгийн иргэд хувь хүнээс зээл авах нь арай их байна. Хотын иргэд ББСБ–аас зээл авах нь хөдөөгийн иргэдтэй харьцуулахад 10 пунктээр их байна.

Зураг 8. 36. Зээл олгосон байгууллагуудаар, хот хөдөөд




Хэрэглэгчдийн зээл авсан байдал нь хэрэглэгчийн зарим бүлгээр нэлээд ялгаатай байна. Тухайлбал, ажилладаг, өндөр орлоготой, 35-аас дээш настай, дээд боловсролтой, гэрлэсэн, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг иргэдийн зээл авсан байдал нь эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад эрс их буюу 5.3–14.7 пунктээр их байна. Харин хэрэглэгчийн хүйс, байршил, газар эзэмшдэг эсэх, болон орон сууцны төрлөөр зээл авсан байдал бараг ялгаагүй байна.

Зураг 8. 37. Зээл авсан байдал, бүлгээр




Хэрэглэгчдийн зээл авсан байдлыг бүс нутгаар харахад төвийн бүсийн иргэд хамгийн их буюу 39.6 хувь нь зээл авсан гэж хариулсан бөгөөд түүний дараа баруун бүс 36.4 хувиар орж байна. Харин хангайн бүсийн иргэд хамгийн бага хувьтай буюу 33.1% нь зээл авсан байгааг Зураг 38-аас харж байна.

Зураг 8. 38. Иргэдийн зээл авсан байдал, бүсээр



Зураг 39-т харагдаж байгаачлан, орлогын бүлгээр харвал, хамгийн орлого багатай бүлгийн хувьд зээл авсан байдал бусад бүлгүүдтэй харьцуулахад дор хаяж 16.4 пунктээр бага байна. Өөрөөр хэлбэл, тухайн хэрэглэгчийн орлого нь 70 мянгаас бага бол зээл авах магадлал эрс багасаж байна.

Зураг 8. 39. Иргэдийн зээл авсан байдал, орлогын бүлгээр



Хэрэглэгчид хадгаламж хийх болон зээл авахдаа хамгийн өргөнөөр үйлчлүүлдэг санхүүгийн байгууллага нь арилжааны банк байна. Хэрэглэгчид хуримтлал хийхдээ бараг дан ганц арилжааны банканд ханддаг бол зээл авахдаа илүү олон эх үүсвэрийг ашигладаг байна.

Хүснэгт 8. 3. Хадгаламж хийх, зээл авахад хамгийн өргөн үйлчлүүлдэг байгууллагууд


	Хадгаламж хийсэн байгууллага	Зээл авсан байгууллага
1-рт	Банк, 94.8%	Банк, 53%
2-рт	ХЗХ, нөхөрлөл 2.1%	Ломбард, 18%
3-рт	Гэртээ, эсвэл гэр бүлийн гишүүн, найздаа хадгалуулдаг, 1.45%	ББСБ, 15%
4-рт	Бонд хувьцаа худалдаж авсан, 0.4%	Хувь хүн, 11%
5-рт	Бичил санхүүгийн байгууллага, 0.2%	ХЗХ, 3%

ЗУРГАА. МОБАЙЛ БОЛОН ЦАХИМ БАНКНЫ ХЭРЭГЛЭЭ

Иргэдийн банкны үйлчилгээнд хамрагддаг байдал нь тийм ч их ялгаатай биш байхад энэ байдал мобайл болон интернет банкны хувьд арай өөр байгаа юм. Мобайл болон интернет банкны үйлчилгээ банкны дараа хамгийн өргөн авдаг үйлчилгээнүүд боловч банкны үйлчилгээнээс ялгаатай нь байршил, сууцны төрөл, хүйс, орлого болон ажил эрхлэлтийн байдлаас хамааран эрс ялгаатай байна.

Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Энэ дүр зураг бүсээр ялгаатай байгааг Зураг 40-өөс харж болно.


Зураг 8. 40. Мобайл болон интернет банкны хэрэглээ бүсээр



Улаанбаатар хотын иргэдийн 24.6 хувь нь мобайл болон интернет банк аль алиныг нь хэрэглэдэг байхад Баруун бүсийн иргэдийн ердөө 10.7 хувь нь аль алиныг нь хэрэглэдэг байна. Баруун бүсийн хувь энэ нь улсын түвшнээс бараг 2 дахин бага байна. Мобайл болон интернет банкны үйлчилгээ энэ бүсийн хувьд бусад бүстэй харьцуулахад хамгийн муу байна. Гэхдээ зөвхөн мобайл банктай иргэдийн хувь уг бүст хамгийн өндөр байна. Мобайл болон интернет банкны хэрэглээгээр Улаанбаатар хотын дараа Төвийн бүс орж байна.


Дээрх санхүүгийн үйлчилгээнүүд байршил, сууцны нөхцөл, хүйсээр хэр ялгаатай байгааг Зураг 41-өөс харж болно. Орон сууцанд амьдардаг иргэдийн 27.3 хувь нь мобайл болон интернет банк аль алиныг нь хэрэглэдэг бол гэр хорооллын иргэдийн хувьд энэ нь 14.4 пунктээр бага байна. Гэр хороололд амьдардаг иргэдийн талаас илүү хувь нь эдгээр үйлчилгээний алийг нь ч авдаггүй бол орон сууцны иргэдийн гуравны нэг нь л мобайл болон интернет банк алиныг нь ч ашигладаггүй байна. Мобайл болон интернет банкны хэрэглээ хүйсээр тийм ч их ялгаатай биш байна.

Зураг 8. 41. Мобайл болон интернет банкны хэрэглээ, хүйс, байршил, сууцны нөхцөлөөр



Сууцны төрлөөс хамааран эдгээр үйлчилгээ авдаг ялгаа их байгаа нь орлогын бүлгээр энэхүү үйлчилгээ авдаг байдлыг харах шаардлагатай гэсэн үг. Тиймээс иргэдийн өөрсдийн мэдээлсэн сарын орлогын мэдээнд үндэслэн таван бүлэгт хуваасан байдлаар Зураг 42–д мобайл болон интернет банкны хэрэглээг харууллаа. Хамгийн бага орлоготой иргэдийн тал нь мобайл болон интернет алиныг нь ч хэрэглэдэггүй бол хамгийн өндөр орлоготой иргэдийн ердөө 19.8 хувь нь алиныг нь ч хэрэглэдэггүй байна. Гэтэл хамгийн өндөр орлоготой иргэдийн 37.7 хувь нь аль алиныг нь хэрэглэдэг байхад хамгийн бага орлоготой бүлгийн 15.7 хувь нь мобайл, интернет банк хоёуланг нь хэрэглэдэг.

Зураг 8. 42. Мобайл болон интернет банкны хэрэглээ, орлогын бүлгээр




ДОЛОО. ХЭРЭГЛЭГЧДИЙН 70 ХУВЬ НЬ ЯМАР НЭГ САЙН ДУРЫН ДААТГАЛД ХАМРАГДДАГҮЙ БАЙНА

Хэрэглэгчдийн 70 хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаггүй бөгөөд тэдний 40 хувь нь даатгалын талаар мэдэхгүй учраас, 26 хувь нь хэрэгцээ, шаардлага байхгүй учраас даатгалд хамрагдаагүй гэж хариулжээ. Даатгалын талаар мэдэхгүй учраас даатгалд хамрагдаагүй иргэд (28 хувь) болон асуултад шууд мэдэхгүй (9.5 хувь) гэж хариулсан иргэдийг нэгтгэвэл, нийт хэрэглэгчдийн 37.5 хувь нь даатгалын талаар огт мэддэггүй гэж үзэж болохоор байгааг Зураг 43-аас харж болно.


Сайн дурын даатгалд хамрагдалт 18.9 хувьтай байгаа бол уг даатгалд хамрагдсан эсэхээ мэдэхгүй иргэд 2 орчим хувь байна.

Зураг 8. 43. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх



Сайн дурын даатгалд хамрагдалт нь иргэдийн боловсрол, орлого, хөрөнгө эзэмшдэг эсэх, зээл авсан эсэх, хуримтлал хийдэг эсэх болон сууцны нөхцөл зэргээс хамааран харилцан адилгүй байна. Өндөр орлоготой, дээгүүр боловсролтой, сууцанд амьдардаг, зээл авсан, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг, хуримтлал хийдэг, ажил эрхэлдэг иргэдийн хувьд сайн дурын даатгалд хамрагдалт сайн байна. Ялангуяа өнгөрсөн 12 сарын хугацаанд хуримтлал хийсэн иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт хамгийн өндөр буюу 29.3 хувь байна. Харин насны бүлэг, хот хөдөөгөөр сайн дурын даатгалд хамрагдалт бараг ялгаагүй байна.

Зураг 8. 44. Ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг эсэх, бүлгээр



Зураг 45–аас ажиглахад, даатгалын хэрэгцээ шаардлагын хувьд даатгалын төрлөөс хамааран иргэдийн таашаал өөр өөр байна. Тухайлбал эрүүл мэндийн даатгалыг иргэдийн 46.3 хувь нь хамгийн хэрэгцээтэй гэж үзэж байна. Дараагийн хамгийн хэрэгцээтэй даатгалаар гэнэтийн осол, эмчилгээний даатгал (22.8%)–ыг нэрлэжээ. Иргэдийн 3.1 хувь нь энэ асуултад мэдэхгүй гэж хариулсан.

Зураг 8. 45. Хамгийн хэрэгцээ шаардлагатай гэж үзсэн даатгалууд




Орлого, боловсролын түвшин болон байршлаас хамааран даатгалын хэрэгцээ шаардлага өөр өөр байна. Одоогоор ажил эрхэлдэггүй, 35–аас дээш настай, үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг хэрэглэгчид бусад бүлэгтэй харьцуулахад тэтгэврийн даатгал хамгийн хэрэгцээтэй гэж илүү их хариулжээ.

Гэнэтийн осол, эмчилгээний даатгалыг хэрэгтэй гэж 35–аас доош настай иргэд эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад 8.5 пунктээр илүү хариулсан бол хөрөнгө эзэмшдэггүй иргэд эсрэг бүлэгтэйгээ харьцуулахад 2.7 орчим пунктээр илүү их хариулсан. Өөрөөр хэлбэл, дээд боловсролтой, 35–аас доош настай, орон сууцанд амьдардаг, ажил эрхэлдэг, хотод амьдардаг, хөрөнгө эзэмшдэггүй иргэд гэнэтийн осол, эмчилгээний даатгал хамгийн хэрэгцээтэй гэсэн хариултыг бусад бүлэгтэйгээ харьцуулахад илүү их өгсөн байгааг Зураг 46–аас харж байна.


Харин эрүүл мэндийн даатгалыг нөгөө бүлгүүд нь харьцангуй их сонгосон. Тухайлбал, ажил эрхэлдэггүй иргэдийн 50.9 хувь нь эрүүл мэндийн даатгал хамгийн шаардлагатай гэж хариулсан нь ажил хийдэг иргэдтэй харьцуулахад 7.8 пунктээр өндөр, харин орлогын бүлгээр харахад орлого багатай бүлгийн иргэдийн 48.3 хувь нь эрүүл мэндийн даатгалыг хамгийн их шаардлагатай гэсэн байгаа нь орлого өндөр бүлгийн иргэдээс 2 пунктээр илүү байна.

Зураг 8. 46. Хамгийн хэрэгцээтэй даатгал, бүлгээр




Зураг 47-оос харахад даатгалд хамрагдаагүй иргэдээс хамрагдаагүй шалтгааныг тодруулахад 26 хувь нь хэрэгцээ шаардлагагүй гэж хариулсан. Энэ нь 2018 оны 2 улиралтай харьцуулахад 7 пунктээр бага, 2016 оны 3-р улиралтай харьцуулахад 14 пунктээр бага, 2018 оны 1 улирлын үр дүнтэй ойролцоо байна. Харин даатгалд итгэдэггүй гэсэн хариулт 10 хувь, даатгалын талаар мэдэхгүй учраас хамрагдаагүй гэсэн хариулт 40 хувь байна. Даатгалын хураамж өндөр учраас хамрагдаагүй гэж 15 хувь нь хариулсан.

Зураг 8. 47. Даатгалд хамрагддаггүй шалтгаан



Орон сууцанд амьдардаг, дээд боловсролтой, 35-с доош настай, хуримтлал хийдэг, зээл аваагүй иргэд хэрэгцээ шаардлага байхгүй учраас даатгалд хамрагдаагүй гэсэн хариултыг бусад бүлэгтэй харьцуулахад илүү их өгчээ. Харин гэр хороололд амьдардаг, бага болон дунд боловсролтой, ажил эрхэлдэггүй, зээл авсан, хуримтлал хийгээгүй иргэдийн дунд даатгалын талаар мэдэхгүй учраас гэсэн хариулт харьцангуй их байгааг Зураг 48-аас харж байна.

Зураг 8. 48. Сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгаан, бүлгээр



НАЙМ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Санхүүгийн хүртээмжийн үндсэн үзүүлэлтээрээ МУ ижил төстэй орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Тухайлбал, банканд данстай иргэдийн эзлэх хувь гэдэг үзүүлэлтээр өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна. МУ-ын иргэдийн 94.5 хувь нь ямар нэгэн байдлаар албан ёсны санхүүгийн үйлчилгээнд хамрагддаг байна. Тухайлбал, иргэдийн 92.1 хувь нь дансаа идэвхтэй ашигладаг бөгөөд 91.9 хувь нь банк, 9.3 хувь нь ББСБ, 3.4 хувь нь ХЗХ-гоор үйлчлүүлдэг. Судалгаанд оролцогсдын 5.2 хувь нь санхүүгийн секторын гадна буюу үйлчилгээ хүртэхгүй байна.

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж бүсээр бага зэрэг ялгаатай байна. Хангай болон төвийн бүсэд санхүүгийн үйлчилгээний хүртээмж бусад орон нутгаас харьцангуй бага байна. Хүйс болон сууцны төрлөөр санхүүгийн хүртээмж ялгаагүй байна. Харин хөдөлмөр эрхэлдэггүй иргэдийн хувьд санхүүгийн хүртээмж хөдөлмөр эрхэлдэг иргэдээс харьцангуй бага байна.

2017 оны байдлаар дэлхийн хэмжээнд нийт насанд хүрсэн иргэдийн 31 хувь нь банканд дансгүй байна. Манай улсын хувьд энэ үзүүлэлт эрс бага буюу нийт иргэдийн ердөө 4.5 хувь нь банканд дансгүй байна. Банканд дансгүй гэж өөрөө мэдээлсэн болон данстай хэдий ч түүнийгээ огт ашиглахгүй байгаа хүмүүсийг энд оруулж тооцсон. Энэхүү банкны дансгүй иргэд ажил эрхлэлтийн байдал, нас, боловсрол, байршил, орлого болон сууцны төрлөөс хамааран нэлээд ялгаатай байна. Гол төлөв ажилгүй, 25-аас дээш настай, орлого бага, гэр хорооллын иргэд дансгүй байх нь олон байна. Тухайлбал, дансгүй иргэдийн 36 хувь нь хамгийн бага орлоготой бүлгийн иргэд байхад 7 хувь нь хамгийн өндөр орлоготой бүлгийн иргэд байна. Мөн түүнчлэн, дансгүй иргэдийн 63.8 хувь нь эдийн засгийн идэвхтэй иргэд, 36.2 хувь нь идэвхгүй иргэд байна. Данс эзэмшихгүй шалтгаанууд дунд хамгийн өндөр хувь эзэлж буй нь дундаа данстай байх нь зардал багатай (20%) гэснээс үзвэл эдгээр иргэдийн 20 хувь нь данс огт хэрэглэдэггүй биш юм.

Монгол Улсын хэмжээнд иргэд тогтмол үйлчлүүлдэг банкны салбартаа очихын тулд дунджаар 1350 төгрөг 16 минут зарцуулдаг бол АТМ орохын тулд 960 төгрөг 15 минут зарцуулдаг байна. Банкны салбар болон АТМ орох зардал болон хугацаа нь хот хөдөөгөөр болон сууцны нөхцөлөөр нэлээд ялгаатай байна. Хөдөө амьдардаг бөгөөд гэр хороололд амьдардаг иргэд илүү их зардал, хугацаа зарцуулдаг. Хангайн бүсийн иргэд банкны үйлчилгээ авахдаа хамгийн их зардал, хугацааг зарцуулдаг Улаанбаатар хотын иргэд хамгийн бага зардал, хугацаа зарцуулж байна. Улаанбаатар хотод АТМ орох нь банкны салбар орохоос хэд дахин зардал багатай байхад хөдөөд эсрэгээрээ банкны салбар орох нь АТМ орохоос зардал багатай байна.

Банкны үйлчилгээний хамрах хүрээ нь манай улсын маш сайн бөгөөд энэ нь хаана амьдардаг, орлогын түвшин зэргээс хамааран тийм ч их ялгаатай биш хэдий ч банкны үйлчилгээ авдаг давтамж орон сууцанд амьдардаг, хөдөөгийн иргэдийн хувьд бага байгаа юм. Тухайлбал, орон сууцанд амьдардаг иргэдийн 52.5 хувь нь хамгийн багадаа л долоо хоног тутамд банкны үйлчилгээ авдаг бол гэр хороололд амьдардаг иргэдийн хувьд энэ нь 17.5 пунктээр бага. Иргэд ажил эрхлэлтийн байдлаас хамааран банкны үйлчилгээ авах нь өөр өөр байж болох хэдий ч хөдөлмөр эрхэлдэг иргэдийн хувьд мөн л хаана амьдардаг, сууцны нөхцөл зэргээс хамааран банкны үйлчилгээ авах давтамж ялгаатай байна.

2017 оны байдлаар данс идэвхтэй ашиглаж буй нийт иргэдийн 86 хувь нь харилцах, 31 хувь нь хадгаламжийн, 12 хувь нь хугацаатай хадгаламжийн, 6 хувь нь зээлийн, 13 хувь нь дебет карт, 2 хувь

нь гадаад валютын данстай, 2 хувь нь кредит карттай байна. Эзэмшиж буй дансны төрөл нь байршил, хүйс зэргээрээ тийм ч их ялгаатай биш байна. Иргэдийн 44 хувь нь цалингаа авахын тулд, 35 хувь нь мөнгөө найдвартай газар байлгах үүднээс, 24 хувь нь төлбөр авахын тулд мөн 24 хувь нь халамж тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд данстай болсон гэжээ. Нийт данстай иргэдийн 32 хувь нь 2010 оноос өмнө нээлгэсэн, харин 36 хувь нь дансаа 2010–2018 оны хооронд нээлгэжээ. Хамгийн их данс нээлгэсэн он 2008 он байна. Идэвхтэй данс ашиглаж буй иргэдийн 65.7 хувь нь нэгээс олон данстай байна.

Нийт иргэдийн 49.1 хувь нь мобайл банкны үйлчилгээ, 27 хувь нь интернет банкны үйлчилгээ авдаг бөгөөд үүн дотроо 19.8 хувь нь мобайл болон интернет аль алиныг нь ашигладаг, 29.3 хувь нь зөвхөн мобайл банк, 7.2 хувь нь зөвхөн интернет банк, 43.7 хувь нь алиныг нь ч ашигладаггүй байна. Мобайл болон интернет банкны үйлчилгээг хотод, орон сууцанд амьдардаг, орлого өндөртэй иргэд илүүтэй хэрэглэж байна.

Ихэнх хэрэглэгчид мөнгөө банканд хадгалах нь аюулгүй гэж үзэж байна. Хэрэглэгчдийн 30.3 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн бөгөөд тэдний 95 орчим хувь нь банканд хадгалсан гэжээ. Хэрэглэгчдийн ихэнх нь хуримтлалыг урт хугацааны зорилготой хийдэггүй, харин гэнэтийн зарлагадаа хэрэглэх болон өдөр тутмын хэрэглээгээ тогтвортой байлгах зорилготой хийдэг байна. Хадгаламж хийдэг хэрэглэгчдийн гуравны хоёр нь сард нэг буюу түүнээс олон удаа хуримтлалдаа мөнгө хийдэг гэжээ. Өөрөөр хэлбэл, хадгаламжтай иргэд хуримтлалаа давтамж ихтэй хийдэг байна. Хуримтлал хийсэн эсэх нь бүс нутаг болон орлогын бүлгээр эрс ялгаатай байна.

Нийт хэрэглэгчдийн 35.4 хувь нь өнгөрсөн 6 сарын хугацаанд санхүүгийн албан болон албан бус байгууллагуудаас зээл авсан бөгөөд хамгийн их үйлчлүүлсэн байгууллага нь арилжааны банк байна. Үүний дараагаар ломбард (18 хувь), ББСБ орж байна. Албан бус санхүүгийн үйлчилгээ буюу ломбард, хувь хүнээс авч байгаа зээл нэлээд их хувийг (30 орчим хувь) эзэлж байна. Хамгийн ядуу бүлгийн зээлд хамрагдалт хамгийн бага байна.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад иргэдийн хадгаламжийн зах зээлд арилжааны банк илт давамгайлж байна. Үүнтэй харьцуулахад иргэдийн зээлийн зах зээлд арилжааны банк харьцангуй бага хувь (53 хувь) эзэлж байна. Хэрэглэгчид зээл авахдаа бусад санхүүгийн байгууллагаар нэлээд үйлчлүүлдэг ажээ. Тухайлбал ББСБ-аас гадна, албан бус сектор буюу ломбард, хувь хүнээс зээл авдаг байна.

Хэрэглэгчдийн 70 хувь нь сайн дурын даатгалд хамрагддаггүй бол 20 орчим хувь нь ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг гэжээ. Бүлгээр харахад сүүлийн нэг жилийн хугацаанд хуримтлалдаа мөнгө хийсэн иргэдийн сайн дурын даатгалд хамрагдалт хамгийн өндөр байна. Хамгийн хэрэгцээ шаардлагатай даатгалаар эрүүл мэндийн даатгал, түүний дараа гэнэтийн осол, эмчилгээний даатгал болон тэтгэврийн даатгал орж байна. Сайн дурын даатгалд хамрагдаагүй шалтгаануудыг даатгалын талаар мэдэхгүй учраас гэсэн хариулт тэргүүлж байгаа бөгөөд дараагийн гол шалтгаан нь хэрэгцээ шаардлага байхгүй гэсэн шалтгаан байна.

ЕС. ХАВСРАЛТ

Хүснэгт 8. 4. Үнэлгээний үр дүн

	(1) Логит загвар	(2) Логит загвар	(3) Регресс	(4) Регресс
	Банканд идэвхтэй данстай	Банканд хадгаламжтай	Хадгаламжийн давтамж	Банкны үйлчилгээний давтамж
Нас	-0.002*** (0.00)	0.00 (0.00)	-0.01 (0.02)	0.01*** (0.00)
Насны квадрат	0.000* (0.00)	0.00 (0.00)	0.00 (0.00)	0.00** (0.00)
Эмэгтэй	0.016 (0.01)	0.05 (0.03)	0.07 (0.07)	-0.09* (0.05)
Өрхийн тэргүүн	0.018 (0.02)	0.00 (0.04)	-0.23 (0.09)	0.16** (0.07)
Орлогын логарифм	0.021*** (0.01)	0.11 (0.02)	0.09 (0.04)	-0.15*** (0.07)
Боловсрол	0.003** (0.00)	0.02 (0.00)	0.00 (0.00)	-0.01 (0.00)
Гэрлэсэн	0.022 (0.01)	-0.03 (0.04)	0.19 (0.09)	-0.17** (0.06)
Шилжих төлбөр	0.039*** (0.01)	-0.05 (0.06)	0.03 (0.19)	-0.02 (0.12)
Цалингийн орлого	0.024 (0.02)	-0.08 (0.05)	-0.04 (0.11)	-0.18* (0.09)
Хөдөлмөр эрхэлдэг	0.035** (0.02)	0.04 (0.04)	0.19 (0.12)	-0.12 (0.08)
Төв	-0.009 (0.02)	0.04 (0.05)	0.00 (0.12)	0.02 (0.08)
Баруун	0.016 (0.01)	0.18 (0.06)	0.06 (0.13)	0.02 (0.09)
Зүүн	0.020 (0.02)	0.11 (0.06)	0.03 (0.17)	-0.24** (0.12)
УБ	-0.010 (0.02)	-0.05 (0.06)	0.04 (0.15)	0.16 (0.11)
Тогтмол	-1.257	-5.23	1.41	3.51
Ажиглалтын тоо	1309.00	1309.00	400.00	1209.00
R²			0.06	0.13

Хүснэгт 8. 5. Хүртээмжийн индикатор

		%	95% итгэх интервал
Мобайл банк ашиглалт		49.1	[46.6, 51.5]
Интернет банк ашиглалт		27	[24.8, 29.2]
Хамгийн ойрын санхүүгийн үйлчилгээний цэгт очих дундаж зардал (төгрөгөөр)	ATM	958.6 ТӨГ	[748.7, 1168.5] ТӨГ
	Банк	1350.0 ТӨГ	[1086.6, 1613.4] ТӨГ
Хамгийн ойрын санхүүгийн үйлчилгээний цэгт очих дундаж хугацаа минутаар	ATM	14.9	[15.5, 17.3]
	Банк	16.4	[12.7, 17.1]

Хүснэгт 8. 6. Хүртээмжийн GPFI индикатор

GPFI Индикаторууд	%	95% Итгэх завсар
Банканд данстай: Албан ёсны санхүүгийн байгууллагад данстай иргэдийн %	92.0	[90.7, 93.4]
Зохицуулалттай байгууллагуудаас зээл авсан иргэд	23.9	[21.8, 21.0]
Даатгалтай иргэд	19.2	[17.3, 21.2]
Өнгөрсөн жилд санхүүгийн байгууллагад хадгаламж хийсэн	28.7	[26.5, 30.9]

Хүснэгт 8. 7. Хүртээмжийн ангилал

Санхүүгийн хүртээмжийн ангилал	%	95% Итгэх завсар
Банканд данстай (1467)	91.9	[90.5, 93.2]
Бусад албан сектор (41)	2.6	[1.8, 3.3]
Албан бус (5)	0.3	[0.04, 0.6]
Санхүүгийн үйлчилгээнээс гадуур (84)	5.3	[4.2, 6.4]
N=1597		

Хүснэгт 8. 8. Дансны төрөл, шалтгаан

Та банканд өөрийн данстай юу?	%	95% итгэх интервал
Тийм (n=1526)	95.6	[94.4, 96.5]
Урьд нь байсан, одоо байхгүй (n=18)	1.1	[0.7, 1.8]
Огт байгаагүй (n=33)	2.1	[1.5, 2.9]
Байхгүй, гэхдээ хамтын данстай (n=14)	0.9	[0.5, 1.5]
Байхгүй, гэхдээ өөр хүний нэр дээрх данс ашигладаг (n=6)	0.4	[0.2, 0.8]
N=1597		
Та хэдэн данстай вэ?		
1 (n=558)	36.6	[34.2, 39]
2 (n=541)	35.5	[33.1, 37.9]
3 (n=246)	16.1	[14.4, 18.1]
4+ (n=181)	11.9	[10.3, 13.6]
N=1526		
Ямар төрлийн данс вэ? (1 данстай)		

Харилцах данс (n=459)	82.3	[78.6, 85.2]
Хадгаламжийн данс (n=45)	8.1	[6.1, 10.6]
Хугацаатай хадгаламжийн данс (n=3)	0.5	[0.1, 1.6]
Зээлийн данс (n=4)	0.7	[0.2, 1.9]
АТМ/дебит карт (n=45)	8.1	[6.1, 10.6]
Кредит карт (n=2)	0.3	[0.0, 1.4]
N=558		
Ямар төрлийн данс вэ? (1–ээс олон данстай)		
Харилцах данс (n=915)	94.5	[92.9, 95.8]
Хадгаламжийн данс (n=453)	46.7	[43.7, 49.9]
Хугацаатай хадгаламжийн данс (n=183)	18.9	[16.6, 21.5]
Зээлийн данс (n=95)	9.8	[8.1, 11.9]
АТМ/дебит карт (n=167)	17.3	[14.9, 19.7]
Гадаад валютын данс (n=35)	3.6	[2.6, 4.9]
Кредит карт (n=33)	3.4	[2.4, 4.7]
N=968		
Та энэ дансыг нээлгэсэн хамгийн гол шалтгаанаа хэлнэ үү? (1 данстай?)		
Цалингаа авахын тулд (n=144)	25.8	[22.3, 29.6]
Төлбөр хүлээн авахын тулд (n=59)	10.6	[8.2, 13.4]
Мөнгөө найдвартай газар байлгах үүднээс (n=127)	22.8	[19.5, 26.4]
Халамж, тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд (n=117)	20.9	[17.8, 24.6]
Зээл авахын тулд (n=9)	1.6	[0.8, 3.1]
Бусад (n=95)	17.1	[14.1, 20.4]
Мэдэхгүй (n=7)	1.3	[0.6, 2.6]
N=558		
Та энэ дансыг нээлгэсэн хамгийн гол шалтгаанаа хэлнэ үү? (1–ээс олон данстай?)		
Цалингаа авахын тулд (n=558)	42.4	[39.3, 45.5]
Төлбөр хүлээн авахын тулд (n=318)	32.9	[29.9, 35.9]
Мөнгөө найдвартай газар байлгах үүднээс (n=428)	44.2	[41.4, 47.7]
Халамж, тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд (n=265)	27.4	[24.7, 30.2]
Зээл авахын тулд (n=127)	13.1	[11.1, 15.4]
Бусад (n=136)	14	[12.1, 16.4]
Мэдэхгүй (n=6)	1	[0.2, 1.4]
N=968		
Та энэ дансаа хэдэн онд нээлгэсэн бэ?		
2000 оноос өмнө (n=99)	6.5	[5.3, 7.8]
2001–2010 оны хооронд (n=478)	31.3	[29.0, 33.7]
2011 (n=48)	3.1	[2.4, 4.1]
2012 (n=84)	5.5	[4.5, 6.8]
2013 (n=80)	5.2	[4.2, 6.5]
2014 (n=66)	4.3	[3.4, 5.4]
2015 (n=86)	5.6	[4.6, 6.9]
2016 (n=55)	3.6	[2.8, 4.7]

2017 (n=49)	3.2	[2.4, 4.2]
2018 (n=28)	1.8	[1.3, 2.6]
Санахгүй байна (n=453)	29.7	[27.4, 32]
N=1597		

Хүснэгт 8. 9. Бичиг баримт

Бичиг баримт	%	95% Итгэх завсар
Иргэний үнэмлэх (n=1587)	99.4	[99.0, 99.8]
Оюутны үнэмлэх (n=127)	8.0	[6.6, 9.3]
Жолооны үнэмлэх (n=723)	45.3	[42.8, 47.7]
Гадаад паспорт (n=863)	54.0	[51.6, 56.5]
Ус/цахилгааны төлбөрийн нэхэмжлэх (n=383)	24.0	[21.9, 26.8]
Интернет, кабелийн сувгийн гэрээ (n=327)	20.5	[18.5, 22.5]
Утасны төлбөрийн нэхэмжлэх (n=480)	30.1	[27.8, 32.3]
Түрээсийн гэрээ (n=74)	4.6	[3.6, 5.7]
Татварын дэвтэр (n=243)	15.2	[13.5, 17.0]
Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ (n=447)	28.0	[25.8, 30.2]
Даатгалын дэвтэр (n=858)	53.7	[51.3, 56.2]
Ажил олгогчийн цалин олгосон баримт (n=204)	12.8	[11.1, 14.4]
N=1597		

Хүснэгт 8. 10. Дансны хэрэглээ

Данс нээсэн шалтгаан	%	95% Итгэх завсар
Цалингаа авахын тулд (n=702)	63.1	[60.3, 66.0]
Төлбөр хүлээн авахын тулд (n=377)	36.7	[33.8, 39.7]
Мөнгөө найдвартай газар байлгах (n=555)	50.7	[47.7, 53.7]
Халамж тэтгэмжийн мөнгө хүлээн авахын тулд (n=382)	35.2	[32.4, 38.1]
Зээл авахын тулд (n=136)	13.9	[11.7, 16.1]
Бусад (n=1)	21.7	[19.2, 24.2]
N=1526		
Сүүлийн 12 сард та банкнаас зээл авсан уу?	%	95% Итгэх завсар
Тийм (n=369)	23.1	[21.0, 25.2]
N=369		
Та хэр давтамжтай хуримтлал хийдэг вэ?	%	95% Итгэх завсар
Сард нэгээс бага (n=143)	8.6	[7.6, 10.4]
Сард нэг удаа (n=261)	16.3	[14.5, 18.2]
Сард нэгээс олон (n=55)	3.4	[2.5, 4.3]
N=459		

Хүснэгт 8. 11. Даатгал

Та ямар нэг сайн дурын даатгалд хамрагддаг уу?	
Тийм (n=301)	18.9
Үгүй (n=1,111)	69.7
Сайн дурын даатгалтай эсэхээ мэдэхгүй (n=31)	1.9
Даатгалын талаар мэдэхгүй (n=152)	9.5
N=1,595	
Та дараах даатгалуудаас алийг нь хамгийн хэрэгцээ, шаардлагатай гэж үзэж байна вэ?	
Хөрөнгийн даатгал (n=115)	7.2
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал (n=364)	22.8
Авто, тээврийн хэрэгслийн даатгал /сайн дурын/ (n=170)	10.7
Эрүүл мэндийн даатгал (n=739)	46.3
Тэтгэврийн даатгал (n=122)	7.7
Бусад (n=36)	2.3
Мэдэхгүй (n=49)	3.1
N=1,595	
Та яагаад даатгалд хамрагддаггүй вэ?	
Хэрэгцээ, шаардлага байхгүй (n=287)	25.8
Даатгалын хураамж, төлбөр өндөр (n=168)	15.1
Даатгалд итгэдэггүй (n=113)	10.2
Даатгалын талаар мэдэхгүй (n=448)	40.3
Бусад (n=95)	8.6
N=1,111	

Хүснэгт 8. 12. Орлогын эх үүсвэр


Орлогын эх үүсвэр	%	95% Итгэх завсар
Байнгын ажлын цалин	45.81	[43.2, 48.4]
Түр зуурын ажлын цалин	15.75	[13.8, 17.7]
эцэг эхээс авсан тусламж	1.95	[1.2, 2.7]
хүүхдийн тэтгэмж	5.13	[4.0, 6.3]
жирэмсний тэтгэмж	0.94	[0.4, 1.4]
групийн мөнгө	2.17	[1.4, 2.9]
бусад төрлийн нийгмийн халамж	1.45	[0.8, 2.1]
хөрөнгийн орлого	1.01	[0.5, 1.5]
Ээлжийн амралтын мөнгө	1.23	[0.6, 1.8]
тэтгэврийн орлого	15.75	[13.8, 17.7]
Бусад	8.82	[7.3, 10.3]
N=1384		

АРАВ. ЭХ СУРВАЛЖ

National Reserve Bank of Tonga. “Financial Services Demand Side Survey Tonga”. 2016.

World Bank Group. Asli Demirguc–Kunt, Leora Klapper, Dorther Singer, Saniya Ansar, Jake Hess “The Global Findex Database 2017: Measuring Financial Inclusion and the Fintech Revolution”. 2018.

IMF. IMF Database “Financial Access Survey, Tracking Access to Financial Services”. October 2017.



БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АШИГТ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛС

2017 он

Гүйцэтгэсэн: Б.Батчимэг¹

¹ Зах зээлийн судалгаа, хөгжлийн газрын референт, batchimeg_b@frc.mn

ХУРААНГУЙ

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд ямар хүчин зүйлс нөлөөлж байгааг тодорхойлоход тус судалгааны зорилго оршино.

Энэхүү судалгааг боловсруулахдаа 2006 оноос хойш өдийг хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж буй зээлийн үйл ажиллагааг дагнан болон хавсран эрхэлдэг нийт 72 ББСБ-ын 2007 оноос 2016 оныг хүртэлх тоон мэдээг ашиглан панел үнэлгээ хийсэн.

Судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Хоёрдугаар бүлэгт банк бус санхүүгийн байгууллагуудын өнөөгийн байдлыг товч дурдах бол, гуравдугаар бүлэгт уг сэдвээр хийгдсэн судалгааны ажлуудын талаар товчхон өгүүлнэ. Харин дөрөвдүгээр бүлэгт банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар онолын таамаглалуудыг дурдан, тавдугаар бүлэгт панел үнэлгээний үр дүнг тайлбарлана. Сүүлийн бүлэгт судалгааны үр дүнг нэгтгэсэн болно.

Судалгааны үр дүнд ББСБ-уудын ашигт ажиллагаанд хэд хэдэн хүчин зүйл нөлөөлдөг гэж гарсан ба үүнд чанаргүй зээлийн хувь, эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь, мөн макро хүчин зүйлс болох эдийн засгийн өсөлт, төв банкны бодлогын хүү зэрэг нь ач холбогдолтой байна. Олон улсын судалгааны нийтлэг үр дүнгээс ялгаатай нь эдийн засгийн өсөлт ББСБ-уудын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөө үзүүлж байна.

Түлхүүр үгс: банк бус санхүүгийн байгууллага, ашигт ажиллагаа, ашиг, өсөлт

JEL ангилал: C12, G23

НЭГ. УДИРТГАЛ

2017 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй ББСБ–ын тоо 535 байна. Энэ нь арван жилийн өмнөхөөс 3.8 дахин өссөн тоо юм. Зах зээл дээр үйл ажиллагаа явуулах ББСБ–уудын тоо өсөхийн хэрээр салбарын хөрөнгийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж 906 тэрбум төгрөгт хүрлээ. 2017 оны эцэс гэхэд банк бус санхүүгийн байгууллагуудын нийт хөрөнгийн хэмжээ 1 их наяд төгрөг давахаар хүлээгдэж байна. Мөн хөрөнгийн өсөлтийн дийлэнх хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байгаа буюу зах зээл дээрх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж, мөн хүүгийн түвшин буурч байгаа зэрэг таатай өөрчлөлтүүд явагдаж байна.


Гэсэн хэдий ч банк бус санхүүгийн байгууллагуудын ашгийн түвшин хэлбэлзэл өндөр хэвээр байна. Тухайлбал 2012 оны 3 дугаар улиралд 82.3 хувьтай байсан ББСБ–ын ашгийн өсөлт 2017 оны байдлаар –1.3 хувьтай байна. Ашгийн түвшнийг даган салбарын нийт хөрөнгийн болон өөрийн хөрөнгийн өгөөж ч мөн хэлбэлзэлтэй байгаа ба 2013 онд 11.1 хувьтай байсан нийт хөрөнгийн өгөөж 2017 оны байдлаар 7 хувь болж буурсан байна.

Банк бус санхүүгийн байгууллагын ашигт ажиллагаа хэт бага байх нь тухайн байгууллагын үр ашигт байдал, эрсдэлээ даах чадвар, хөрвөх чадвар зэрэг олон үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлдэг. Харин зарим банк бус санхүүгийн байгууллага хэт өндөр хүүгээр зээл олгон, мөнгө хүүлэлтийн шинжтэй үйл ажиллагаа явуулснаар өндөр ашигтай ажиллах боломжтой байдаг. Тийм учраас ББСБ–уудын ашгийн түвшинд ямар хүчин зүйлс нөлөөлж буйг олж судлах нь чухал зүйл юм.

ХОЁР. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


2017 оны 3 дугаар улирлын байдлаар зах зээлд үйл ажиллагаа явуулж буй ББСБ–уудын тоо 535–д хүрч өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар, өмнөх улирлаас 0.4 хувиар өслөө. Тайлант улиралд ББСБ–уудын харилцагчдын тоо 1.3 саяд хүрлээ. Харилцагчдын тоо огцом өссөн нь 2017 оноос эхлэн цахим мөнгөний харилцагчдын бүртгэлийг нэмж тооцсонтой холбоотой.

Зураг 9. 1. Банк бус санхүүгийн байгууллагуудын тоо




Тайлант улиралд ББСБ–уудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өсөж 906 тэрбум төгрөгт хүрлээ. ББСБ–уудын хөрөнгийн өсөлтийн дийлэнх хэсгийг буюу 80.0 хувийг зээлийн өсөлт бүрдүүлж байгаа ба зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдэж байна. Харин өөрийн хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35 хувиар өсөж 716.8 тэрбум төгрөгт хүрсэн ба өөрийн хөрөнгийн өсөлтийн 93.7 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгийн өсөлт бүрдүүлж байна.

Зураг 9. 2. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн өсөлт



Тайлант улиралд ББСБ–ын жигнэсэн дундаж сарын хүү 3.4 хувь болж өмнөх оны мөн үеэс 0.9 пункт, өмнөх улирлаас 0.2 пунктээр буурлаа. Зээлийн хүүгийн бууралтад зах зээл дэх зээлийн нийлүүлэлт нэмэгдсэн нөлөөлсөн байж болох бөгөөд арилжааны банкуудын хүүгийн түвшинтэй харьцуулахад ББСБ–уудын сарын хүүгийн түвшин 1.6 пунктээр өндөр байна.


Зураг 9.3. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн жигнэсэн дундаж хүү



2017 оны 3 дугаар улирлын байдлаар ББСБ–уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар буурч 138.6 тэрбум төгрөгт, нийт ашиг 1.3 хувиар буурч 43.7 тэрбум төгрөгт хүрлээ.


Тайлант улиралд салбарын хэмжээнд нийт 535 ББСБ үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаагаас 428 ББСБ нийт 52.3 тэрбум төгрөгийн ашигтай, 86 ББСБ нийт 8.7 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 21 ББСБ тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй байна.

Зураг 9.4. Банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаа




ББСБ–ын салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 5.4 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж 7.0 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.6 пункт, 1.4 пунктээр тус тус буурлаа. Өгөөжийн бууралтад ашгийн бууралтаас гадна хөрөнгийн өсөлт нөлөөлсөн.

Зураг 9. 5. Банк бус санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн өгөөж



Тайлант улиралд чанаргүй зээлийн хэмжээ 84.7 тэрбум төгрөгт хүрч чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 14.3 хувь болж өслөө. Энэ нь өмнөх оны мөн үеэс 1.8 пунктээр өссөн үзүүлэлт юм.

Зураг 9. 6. Банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн бүтэц



ГУРАВ. СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар хийгдсэн судалгааны ажил манай улсад төдийлөн хийгдэж байгаагүй бөгөөд олон улсад ч бас цөөн байдаг. Харин арилжааны банкны ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгаа цөөнгүй байдаг.

2011 онд Peter Muriu “Бичил санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаа: Санхүүжилтийн сонголт” судалгааны ажилдаа бичил санхүүгийн байгууллагуудын хөрөнгийн бүтэц тэдний ашигт ажиллагаанд хэрхэн нөлөөлж буйг судалсан байдаг. Modigliani, Miller нарын хийсэн хэд хэдэн судалгааны ажилд компанийн ашигт ажиллагаанд хөрөнгийн бүтэц нь нөлөөлдөг талаар дурдсан байдаг бөгөөд судалгааг уг санаан дээр суурилан хийжээ. Судалгаанд 31 улсын 210 бичил санхүүгийн байгууллагын 1997–2008 оны тоон мэдээг ашиглан баланслагдаагүй панел үнэлгээ хийсэн. Судалгааны үр дүнд бичил санхүүгийн байгууллагуудын олгосон зээлийн хэмжээ өндөр байх нь ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байсан. Мөн нийт хөрөнгөд хадгаламжийн эзлэх хувь өндөр байх нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэх үр нөлөөтэй байсан. Нэг сонирхолтой үр дүн гарсан нь бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулсан жил нь ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байсан. Олон жил үйл ажиллагаа явуулсан байгууллагуудын нийт хөрөнгөд эзлэх хадгаламжийн хувь хэмжээ өндөр байдаг бөгөөд энэ нь капиталын зардлыг бууруулж, ашгийн түвшнийг нэмэгдүүлдэг байна.

2015 онд хийгдсэн Sefa Awaworyi Churchill, Jeffrey Korankye Danso, Elikem Nyatefe нарын “Бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа: Макро эдийн засгийн нөлөө” судалгааны ажилд бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд макро эдийн засгийн хувьсагчид хэрхэн нөлөөлж буйг судалсан. Судалгаанд 84 улсын 563 бичил санхүүгийн байгууллагын 2005–2011 оны тоон мэдээг ашиглан панел үнэлгээ хийсэн. Панел үнэлгээг рандом эффе́кт аргачлалаар үнэлсэн. Судалгааны үр дүнд эдийн засгийн өсөлт нь бичил санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг. Харин эдийн засгийн хөгжлийг илэрхийлэгч бусад үзүүлэлтүүд болох ажил эрхлэлт, цалингийн өсөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт зэрэг нь бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан.

2016 онд Johan Borjesson, Adam Hulten нарын “Саб Сахарын Африк дахь бичил санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлс” судалгааны ажилдаа Са́б Са́харын Африкийн орнуудын бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд ямар хүчин зүйлс нөлөөлж буйг Са́б Са́харын Африкийн орнуудын бичил санхүүгийн байгууллагуудын 2005–2014 оны тоон мэдээг ашиглан судалсан. Судалгааны үр дүнд зээлийн эрсдэл, зардлын удирдлага, болон байгууллагын хэмжээ зэрэг нь бичил санхүүгийн байгууллагын ашигт ажиллагаанд нөлөө үзүүлж байсан.

ДӨРӨВ. ОНОЛЫН ТААМАГЛАЛ

Банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд нөлөөлөгч хүчин зүйлсийг судлахын тулд дараах регрессийн загварыг ашиглан панел үнэлгээ хийсэн.

$$P_{it} = C + \sum_{b=1}^B (\beta_b X_{it}^b) + \sum_{m=1}^M (\beta_m X_{it}^m) + \varepsilon_{it}$$

Энд:

- P_{it} – банк бус санхүүгийн байгууллагын ашигт ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт буюу ROA, ROE
- C – тогтмол тоо
- X_{it}^b – тухайн байгууллагын хувь дахь тайлбарлагч хувьсагчид
 - o Зээлийн эрсдэл–чанаргүй зээлийг нийт зээлд харьцуулсан харьцаа
 - o Диверсификацийн эрсдэл– хүүгийн орлогыг бусад үйл ажиллагаанаас олсон орлогод харьцуулсан харьцаа
 - o Санхүүгийн эрсдэл– эздийн өмчийг нийт хөрөнгөд харьцуулсан харьцаа
 - o Зардлын удирдлага– үйл ажиллагааны зардлаас логарифм авсан утга
 - o ББСБ–ын хэмжээ– нийт зээлийн үлдэгдлээс логарифм авсан утга
 - o Тухайн ББСБ–ын давхар үйлчилгээ эрхэлдэг эсэхийг илэрхийлсэн дамми хувьсагч
- X_{it}^m – макро эдийн засгийн хувьсагчид
 - o ДНБ–ий өсөлтийн түвшин
 - o Инфляцийн түвшин
 - o Төв банкны бодлогын хүү

Зээлийн эрсдэл: Чанаргүй зээлийн хэмжээг нийт зээлд харьцуулж тооцдог бөгөөд чанаргүй зээлийн хэмжээ их байх нь тухайн ББСБ–ын хүлээгдэж буй алдагдал өндөр байгааг харуулдаг учраас ашигт байдалд сөргөөр нөлөөлнө гэж таамагладаг.

Диверсификацийн эрсдэл: Хүүгийн орлогыг бусад үйл ажиллагаанаас олсон орлогод харьцуулсан харьцаа буюу үйл ажиллагааны төрөлжилтийг харуулдаг үзүүлэлт. Үйл ажиллагааны төрөлжилт сайн байснаар орлогын зөвхөн нэг үүсвэрээс хамааралгүйгээр илүү үр ашигтай ажиллах боломжтой юм. Мөн нөгөө талаасаа бусад үйл ажиллагааг үр ашигтай эрхэлж чадахгүй бол хөрөнгийн буруу хуваарилалтыг бий болгож ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх боломжтой юм.

Санхүүгийн эрсдэл: Эздийн өмчийг нийт хөрөнгөд харьцуулж тооцдог. Уг харьцаа нь тухайн байгууллагын төлбөрийн чадвар /leverage /буюу өр төлбөрөө барагдуулах чадварыг харуулдаг. Эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь өндөр байх нь тухайн байгууллагын өр төлбөрийн хэмжээ бага буйг харуулдаг ба санхүүгийн хувьд харьцангуй эрсдэл багатай гэсэн үг юм. Санхүүгийн эрсдэл бага байх нь ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж болох хэдий ч нөгөө талаасаа тухайн байгууллага үйл ажиллагаагаа зээлээр санхүүжүүлэн хүүгийн төлбөрөөс илүү орлого олж чадах тохиолдолд ашигт ажиллагааг бууруулах боломжтой.

Зардлын удирдлага: Үйл ажиллагааны зардал өндөр байх нь ашгийн хэмжээнд сөргөөр нөлөөлнө.

ББСБ–ын хэмжээ: ББСБ–ын хэмжээг тухайн байгууллагын зээлийн хэмжээгээр төлөөлүүлж авсан. ББСБ нь голлон зээлийн үйлчилгээ эрхэлдэг учраас олгосон зээлийн хэмжээ өндөр байх нь орлогын хэмжээнд голлон нөлөөлж ашгийн түвшинд эерэг нөлөө үзүүлнэ.

ДНБ–ий өсөлт: ДНБ–ий өсөлт нь бичил санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг. Эдийн засгийн өсөлт нэмэгдсэнээр зээлийн эрсдэл буурч, алдагдал багассанаар ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг. Мөн эдийн засгийн орчин, нөхцөл сайжирснаар бизнесийн орчин сайжирч жижиг дунд бизнес эрхлэгчдийн тоо нэмэгдэх, мөн хөрөнгө оруулалт өсөх эерэг нөлөө ажиглагддаг ба үүнийгээ даган бичил санхүүгийн байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт нэмэгддэг байна.

Инфляцийн түвшин: Инфляцийн өндөр түвшин нь хүүгийн түвшин өсөхөд нөлөөлдөг. Хүүгийн түвшний өсөлт нь банк санхүүгийн байгууллагуудын хүүгийн орлогыг нэмэгдүүлж ашгийн түвшинд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Мөн зээлийн бүтээгдэхүүний үнэ болох хүүгийн түвшин өссөнөөр зээлийн эрэлт буурах, цаашлаад орлогын түвшин буурах нөлөөтэй.

ТАВ. ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭСЭГ

Тоон мэдээ: Судалгаанд 2006 оноос хойш тусгай зөвшөөрөл эзэмшин, үйл ажиллагаа явуулж буй 72 банк бус санхүүгийн байгууллагын 2007–2016 оны тоон мэдээг ашигласан. Гадаад валют арилжаа дагнан эрхэлдэг ББСБ–уудыг оруулаагүй болно.

Хамааран хувьсагчаар банк бус санхүүгийн байгууллагын ашигт ажиллагааны үзүүлэлт болох өөрийн хөрөнгийн өгөөж болон нийт хөрөнгийн өгөөжийг авсан бол тайлбарлагч хувьсагчаар тухайн байгууллагын үйл ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт болох чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь, хүүгийн орлогыг бусад үйл ажиллагаанаас олсон орлогод харьцуулсан хэмжээ, эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь, үйл ажиллагааны зардлын логарифм утга, олгосон зээлийн хэмжээнээс логарифм авсан утга мөн тухайн байгууллагын эрхэлдэг үйлчилгээний тоог илэрхийлэх дамми хувьсагч, макро эдийн засгийн үзүүлэлт болох бодит ДНБ–ий өсөлт, инфляцийн түвшин, төв банкны бодлогын хүү зэргийг авсан.

Шинжилгээнд ашигласан тоо мэдээг банк бус санхүүгийн байгууллагуудын санхүүгийн тайлан, Монголбанкны сайтаас тус тус авсан болно.

Үнэлгээний аргачлал: Тоон мэдээнээс шалтгаалан шинжилгээг баланслагдаагүй панел загвараар үнэлсэн. Панел загварт Fixed Effect болон Hausman–ий шалгуурыг явуулахад шалгуурын үр дүнд загварыг Random Effect аргаар үнэлбэл үнэлгээний хазайлт хамгийн бага байхаар үр дүн гарсан.

Хураангуй статистик: Шинжилгээнд ашигласан 72 банк бус санхүүгийн байгууллагуудын 2007–2016 оны санхүүгийн үзүүлэлтүүдийн хувьд өөрийн хөрөнгийн өгөөж дунджаар 2.8 хувь, чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь дунджаар 10 хувь, хүүгийн орлогын хэмжээ нь бусад үйл ажиллагаанаас олох орлогоосоо дунджаар 447 дахин их, эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь дунджаар 86.9 хувь, үйл ажиллагааны зардал дунджаар 218 сая, нийт зээлийн хэмжээ дунджаар 1.4 тэрбум байна.

Харин эдийн засгийн өсөлт 2007–2016 оны хооронд 5.7 хувь, инфляцийн түвшин дунджаар 9.3 хувь, төв банкны бодлогын хүү 11.4 хувьтай байсан.

Хүснэгт 9. 1. Хувьсагчдын хураангуй статистик

Хувьсагч	Хувьсагчийн утга	Тэмдэглэгээ	А.утга	Дундаж	ХБУ	ХИУ	Хүлээгдэж буй нөлөө
Хамааран хувьсагч							
Ашигт ажиллагаа	Цэвэр ашиг/ Дундаж нийт хөрөнгө	ROA	720	0.028	-0.427	0.419	
	Цэвэр ашиг/ Дундаж өөрийн хөрөнгө	ROE	720	0.034	-0.018	0.634	
Тайлбарлагч хувьсагчид							
Зээлийн эрсдэл	Чанаргүй зээл/Нийт зээл	CRED	699	0.100	0.000	1.000	Сөрөг
Төрөлжилтийн эрсдэл	Хүүгийн орлого/ Бусад үйл ажиллагааны орлого	DIV	533	447.0	-1034.4	42499.3	Эерэг/ Сөрөг
Санхүүгийн эрсдэл	Эздийн өмч/ Нийт хөрөнгө	FIN	720	0.869	0.020	1.000	Эерэг/ Сөрөг
Зардал	Үйл ажиллагааны зардлаас логарифм авсан утга	COST	713	10.830	2.681	15.210	Сөрөг
Байгууллагын хэмжээ	Нийт зээлийн хэмжээнээс логарифм авсан утга	SIZE	699	12.930	8.006	16.800	Эерэг

Үйл ажиллагааны төрлийг	1 төрлийн үйлчилгээ эрхэлдэг бол	DUMMY1	720	0.542	0.000	1.000	
илэрхийлэх дамми хувьсагч	2 төрлийн үйлчилгээ эрхэлдэг бол	DUMMY2	720	0.250	0.000	1.000	
Бодлогын хүү		GROWTH	720	5.670	0.268	16.330	Эерэг
Инфляцийн түвшин		INF	720	9.329	1.128	15.960	Эерэг/ Сөрөг
Бодит ДНБ-ий өсөлт		RATE	720	11.420	8.400	14.000	Эерэг/ Сөрөг

Шинжилгээний үр дүн: 2006 оноос хойш үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй зээлийн үйл ажиллагаа голлон эрхэлдэг 72 ББСБ-ын 2007–2016 оны тоо мэдээг ашиглан тэдний ашигт ажиллагаанд буюу нийт хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтэд ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг судлах зорилгоор панел тоо мэдээг рандом эффекийн аргаар үнэлсэн. Үнэлгээний үр дүнг Хүснэгт 1–т харууллаа.

Банк бус санхүүгийн байгууллагуудын чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өндөр байх нь ашигт ажиллагааг бууруулах нөлөөтэй байдаг бол тухайн компанийн үйл ажиллагаа хэт төвлөрсөн байгаа эсэхийг илэрхийлэх төрөлжилтийн эрсдэл ашигт ажиллагаанд нөлөөгүй гарсан. Чанаргүй зээлийн хувь хэмжээ өндөр байх нь хүлээгдэж буй алдагдлыг харуулдаг бөгөөд банк бус санхүүгийн байгууллагууд уг алдагдлаас сэргийлэхийн тулд зээлийн эрсдэлийн сан байгуулах шаардлагатай тулгардаг. Харин эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь өндөр байх нь ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байсан. Тухайн байгууллагын үйл ажиллагааны зардал өндөр байх нь ашгийн түвшнийг бууруулах нөлөөтэй буюу нийт хөрөнгийн өгөөжид сөрөг нөлөө үзүүлж байсан бол өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтэд нөлөөгүй байсан. Банк бус санхүүгийн байгууллагын нийт зээлийн хэмжээгээр илэрхийлэгдсэн тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг илэрхийлсэн үзүүлэлт ашигт ажиллагаанд эерэг нөлөө үзүүлж байсан. Мөн зээлийн үйл ажиллагаатай давхар үйл ажиллагаа эрхлэх нь тухайн байгууллагын ашгийн түвшинд нөлөө үзүүлж буйг судлах зорилгоор зөвхөн зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг, хоёр төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг, хоёроос дээш төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг зэргээс нь хамааруулан дамми хувьсагч оруулан үнэлсэн хэдий ч ашигт ажиллагааны түвшинд огт нөлөөгүй буюу статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан учир үнэлгээнээс хассан. Өөрөөр хэлбэл тухайн ББСБ-ын эрхэлдэг үйл ажиллагааны тоо нь ашигт ажиллагааны түвшинд нөлөөгүй байдаг байна.

Хүснэгт 9. 2. Шинжилгээний үр дүн

Variable	ROA	ROE
CRED	-0.204*** (0.028)	-0.227*** (0.042)
DIV	-1.11E-06 (1.50E-06)	-1.14E-06 (2.24E-06)
FIN	0.099*** (0.031)	0.117** (0.046)
COST	-0.012** (0.006)	-0.017 (0.008)
SIZE	0.028*** (0.006)	0.038*** (0.008)
GROWTH	-0.003** (0.001)	-0.003 (0.002)
INF	0.013*** (0.001)	0.017*** (0.002)
RATE	0.044*** (0.004)	0.058*** (0.006)
F-statistic	37.574	28.409
Fixed effect test (prob)	0.000	0.000
Hausman test (prob)	0.110	0.105

“***”, “**”, “*” харгалзан 1,5,10 хувийн ач холбогдлын түвшнийг илэрхийлнэ

Банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд макро эдийн засгийн хүчин зүйлс нөлөө үзүүлж буй эсэхийг судлахаар үнэлгээнд эдийн засгийн өсөлт, инфляцийн түвшин, төв банкны бодлогын хүү зэргийг оруулсан. Судалгааны үр дүнд эдийн засгийн өсөлтийн түвшин банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг буюу статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Бусад улс орнуудад хийгдсэн ижил төрлийн судалгааны үр дүнгээс харахад эдийн засгийн өсөлт нь бичил санхүүгийн байгууллагуудын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний эрэлтийг өсгөх, зээлийн эрсдэлийг бууруулах эерэг нөлөөтэй бөгөөд ашигт ажиллагааг нэмэгдүүлдэг гэсэн байдаг. Харин манай улсын хувьд эсрэг үр дүн гарсан бөгөөд эдийн засгийн өсөлтийн үед ашигт ажиллагаа нь буурдаг байна. Эдийн засгийн өсөлт удааширсан үед иргэдийн худалдан авах чадвар муудах, банкны зээлийн нийлүүлэлт багасах, хөрөнгө оруулалт буурах, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн хэрэглээгээ санхүүжүүлэх чадвар сулрах зэрэг сөрөг нөлөөнүүдийн улмаас банк бус санхүүгийн байгууллагуудын зээлийн эрэлт нэмэгдэн ашигт ажиллагааг нэмэгдүүлдэг байж болох юм. Энэ нь нэг талаасаа банк бус санхүүгийн байгууллагын салбар эрүүл ажиллаж чадахгүй байгааг илтгэж байна.

Харин инфляцийн түвшний өсөлт нь банк бус санхүүгийн байгууллагуудын ашгийн түвшинд эерэг нөлөө үзүүлж байна. Инфляцийн түвшний өсөлт нь хүүгийн түвшний өсөлтийг дагуулдаг бөгөөд хүүгийн түвшин нэмэгдсэнээр зээлийн бүтээгдэхүүнээс олох орлого нэмэгдэж ашгийн түвшинд эерэг нөлөө үзүүлэх боломжтой. Мөн төв банкны бодлогын хүү нь банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд эерэг нөлөөтэй буюу статистикийн хувьд ач холбогдолтой гарсан.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Энэхүү судалгаагаар 2006 оноос хойш үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж буй зээлийн үйл ажиллагаа голлон эрхэлдэг 72 ББСБ-ын 2007–2016 оны панел тоо мэдээг ашиглан тэдний ашигт ажиллагаанд буюу нийт хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөжийн үзүүлэлтэд ямар хүчин зүйлс нөлөөлдөг болохыг судалсан. Тоо мэдээг рандом эффект аргаар үнэлсэн.

Үнэлгээний үр дүнд чанаргүй зээлийн хувь хэмжээ өндөр байх нь банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөөтэй, үйл ажиллагааны зардлын хэмжээ өндөр байх нь хөрөнгийн өгөөжийг бууруулах нөлөөтэй байсан бол эздийн өмчийн нийт хөрөнгөд эзлэх хувь өндөр байх нь ашигт ажиллагаанд эерэг нөлөөтэй, тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ том байх нь хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх нөлөөтэй байсан. Харин тухайн байгууллагын ашигт ажиллагаа нь эрхэлдэг үйл ажиллагааны төрөл, тоо хэмжээнээс хамаардаггүй байна.

Олон улсын судалгаанаас харахад эдийн засгийн өндөр өсөлт нь бичил санхүүгийн байгууллагуудын ашгийн түвшинд эерэг нөлөө үзүүлдэг гэсэн нийтлэг үр дүн байдаг бол манай улсын хувьд эдийн засгийн өсөлт нь банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлдэг, статистикийн хувьд ач холбогдолтой гарсан. Мөн инфляцийн түвшин, төв банкны бодлогын хүү зэрэг нь банк бус санхүүгийн байгууллагуудын ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж байсан.

Энэхүү судалгааны ажлыг 2011, 2015, 2016 онуудад олон улсад хийгдсэн судалгааны ажлуудад үндэслэн хийсэн бөгөөд цаашид өөрийн улсад тохирох загварыг боловсруулах, хувьсагчдыг сонгох, үнэлгээний аргачлалыг сайжруулах шаардлагатай болно.

ДОЛОО. ЭХ СУРВАЛЖ

Peter Muriu. “*Microfinance Profitability: Does financing choice matter?*”. 2011

Sefa Awaworyi Churchill. “*Microfinance Institution Performance: Does the Macro–economy matter?*”. 2015

Jonan Borjesson, Adam Hulten. “*Determinants of Profitability in Microfinance institutions in Sub–Saharan Africa*”. 2016

Microrate. “*Performance indicators for Microfinance institution: Technical Guide*”. 2003

Ahlin C., Lin J., Maio M.. “*Where does Microfinance flourish? Microfinance Institution performance in macroeconomic context*”. 2011

Athanasoglou P.P., Brissmis S.N., Delis M.D.. “*Bank–specific, industry–specific and macroeconomic determinants of bank profitability*”. 2008



Засгийн газрын IV байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-264444



press@frc.mn



www.frc.mn



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC_of_Mongolia